



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН

ПАРЛАМЕНТ



СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

БОТЬ
45

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

“ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



- Эрх зүй, төрийн байгуулалтын судалгааны хэсэг
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн судалгааны хэсэг

УЛААНБААТАР ХОТ, 2023

“Парламент” судалгааны эмхэтгэл (45 дугаар боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа,
сургалтын хүрээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Цогзолмаа
Ц.Норовдондог (Ph.D.)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Төгсзаяа

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ

- 1.1 Парламентын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалт: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага (СТ-23/204) 6
Ц.Норовдондог (Ph.D.), Г.Билгээ, Ц.Ариунаа, П.Уранчимэг
- 1.2 Парламентын сонгуулийн тойрог, мандатын тоог тогтоох эрх зүйн зохицуулалт ба шалгуур: парламентын засаглалтай (нэг танхимтай) орнуудын туршлага (СТ-23/206) 24
Ц.Норовдондог (Ph.D.), Г.Билгээ, Д.Халиун, О.Нарантуяа, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа
- 1.3 Үндсэн хуулийн цэц (шүүх)-ээр хүний эрхийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой бусад орнуудын туршлага (СТ-23/207) 64
Ц.Норовдондог (Ph.D.), Э.Дашзэвэг, Д.Аюуш, П.Уранчимэг, Ц.Ариунаа
- 1.4 Улсын Их Хурлын гишүүдийн тооны хувилбаруудад Улсын Их Хурлаас шийдвэр гаргах саналын тоог харьцуулсан лавлагаа (СТ-23/406) 103
Г.Билгээ, Д.Халиун, Э.Дашзэвэг, Л.Хурцбилэг
- 1.5 Гадаадын зарим орны парламентын сонгуулийн холимог тогтолцоо (СТ-23/407) 106
Ц.Норовдондог (Ph.D.), Г.Билгээ, Ц.Ариунаа, П.Уранчимэг
- 1.6 Парламентын сонгуулийн холимог тогтолцооны талаарх гадаадын зарим орны Үндсэн хуулийн зохицуулалт (СТ-23/408) 123
Г.Билгээ, О.Нарантуяа, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа
- 1.7 Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын тухай (СТ-23/409) 126
Д.Халиун, Р.Нургүл
- 1.8 Монгол Улс-БНЭУ-ын харилцаа болон БНЭУ-ын талаарх лавлагаа (СТ-23/410) 136
Г.Билгээ
- 1.9 Бодлогын намыг төлөвшүүлэх нь: гадаадын зарим орны улс төрийн намын үндсэн хөтөлбөр (СТ-23/412) 150
Д.Халиун, Э.Дашзэвэг, П.Уранчимэг

II БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 2.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар гадаадын зарим орны баримталж буй бодлого, эрх зүйн орчин ба практик туршлага (СТ-23/203) 190
Ц.Норовдондог (Ph.D.), Д.Халиун, Г.Алтан-Оч (Ph.D.), Р.Нургүл, О.Билеүүтэй, С.Золжаргал, И.Жаргалзаяабямба, Б.Баянмөнх, А.Номин-Эрдэнэ

- 2.2 Байгалийн хий, метан хий хайх, олборлох үйл ажиллагааны олон улсын туршлага: зохицуулалтын орчин ба стандарт (СТ-23/208) 247
Ц.Норовдондог (Ph.D.), Г.Алтан-Оч (Ph.D.), С.Золжаргал, Б.Баянмөнх, Б.Батцэцэг
- 2.3 Мах, махан бүтээгдэхүүн болон хүнсний ногооны дотоодын хэрэгцээ, хүнсний бүтээгдэхүүний зоорь агуулахын талаарх мэдээлэл, лавлагаа (СТ-23/405) 277
Ц.Норовдондог (Ph.D.), О.Билгүүтэй

БҮЛЭГ I

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ

**ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНААС ЗАВСАРЛАГА АВАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:
МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Ц.Ариунаа,
Г.Билгээ, П.Уранчимэг*

АГУУЛГА

УДИРТГАЛ

Нэг. Монгол Улсын Их Хурлын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалт

Хоёр. Парламентын хуралдаанаас завсарлага авах тухай гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль тогтоомжийн түүхчилсэн лавлагаа

Хүснэгт 2. Улсын Их Хурлын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалтын түүхчилсэн лавлагаа

Хүснэгт 3. Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны цагийн хуваарь

Хүснэгт 4. Судалгаанд авагдсан орнуудын парламентын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалт

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Парламентын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалт: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалт, 1990 оноос хойших Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалтад оруулсан өөрчлөлт болон гадаадын зарим орны парламентын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд Монгол Улсын Их Хурлын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалттай холбоотой зүйл, заалтуудыг холбогдох хууль тогтоомжуудаас түүвэрлэн авч хүснэгтээр боловсруулав. Мөн гадаадын дараах улсуудад парламентын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлав. Үүнд:

- Парламентын нэг танхимтай улс – Өмнөд Солонгос, Турк, Финланд, Эстони улсууд;
- Парламентын хоёр танхимтай улс – Австрали, Герман, Орос, Франц улсууд (доод танхим).

Судалгааны бүтэц:

Судалгааны тайлангийн *нэгдүгээр бүлэгт* Монгол Улсын Их Хурлын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалт, холбогдох хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх лавлагаа мэдээлэл, *хоёрдугаар бүлэгт* парламентын хуралдаанаас завсарлага авах тухай гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: завсарлага авах, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах, хойшлуулах.

Key words: adjournment, adjourn, recess, suspension, suspend, deferral.

Ключивые слова: перенос или прекращения обсуждений вопроса, перерыв, прерывание.

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНААС ЗАВСАРЛАГА АВАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдан чуулганы хуралдааны анхны дэгийг Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Бага Хурлаас 1990 оны 01 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг”¹ нэртэйгээр баталж байжээ.

Дараа нь Монгол Улсын шинэ Үндсэн хуульд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг 1992 оны 07 дугаар сард батлан гаргажээ. Энэ хуулиар Улсын Их Хурал (УИХ)-ын эрх зүйн байдлаас гадна УИХ-ын чуулганы хуралдааны дэгийг хамт зохицуулж байсан.

Түүнээс хойш цаг хугацааны хувьд авч үзвэл, чуулганы хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжид УИХ-ын сонгуулийн дараа шинээр бүрэлдсэн Парламент бүр тодорхой хэмжээнд өөрчлөлт оруулж ирсэн хандлага ажиглагдаж байна. Тодруулбал, 1997 онд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг бие даасан хууль болгон батлан гаргасан бол 2001, 2006 онуудад УИХ-ын тогтоолоор чуулганы хуралдааны дэгийг баталж байжээ. Харин 2007, 2020 онуудад чуулганы хуралдааны дэгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тус тус баталсан байна. (Хүснэгт 1.)

УИХ-ын чуулганы хуралдааны дэг нь 1992 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан дэгийн заалтуудаас уламжлан дараа дараагийн хуралдааны дэгд зохицуулалт болон тусгагдаж, мөн шинээр үүссэн асуудлуудыг нэмж журамлах замаар зохицуулалтыг илүү баяжуулан хөгжүүлж иржээ. Тухайлбал, нам, эвслийн бүлэг хуралдаанаас завсарлага авах хугацаа 1992, 1997 оны дэгийн хуулиудад тодорхой тусгагдаагүй байсан бол чуулганы хуралдааны дэг батлах тухай 2001 оны УИХ-ын тогтоолд хуралдааны завсарлагын хугацааг нэг цагаас илүүгүй байхаар, уг хугацаанд багтааж зөвшилцөхөөр тусгасан бол 2007 оны дэгийн тухай хуульд завсарлага авах хугацааг ажлын 5-аас илүүгүй өдөр байхаар, шаардлагатай бол ажлын 3 өдрөөр сунгаж болохоор заажээ. Харин 2020 онд батлагдан одоо хэрэгжиж байгаа дэгийн тухай хуульд илүү нарийвчилсан зохицуулалтуудыг тусгасан бөгөөд УИХ дахь нам, эвслийн бүлэг чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын болон дэд, түр хорооны хуралдаанаас завсарлага авч болохоор хуульчилсан байна.

*Хүснэгт 1. Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль
тогтоомжийн түүхчилсэн лавлагаа*

№	Баримт бичгийн нэр	Баталсан огноо (дугаар)	Хүчингүй болсон огноо (дугаар)
1.	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг	“Дэг батлах тухай” БНМАУ-ын Бага хурлын тогтоол, 1990.09.13, №01	
2.	Монгол Улсын Их Хурлын тухай	Монгол Улсын хууль, 1992.07.06	1997.02.06-ны хуулиар
3.	Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг	Монгол Улсын хууль, 1997.02.06	2001.06.21-ний хуулиар
4.	Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах	УИХ-ын тогтоол, 2006.01.27, №14

¹ БНМАУ-ын Бага Хурлын 1990 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн “Дэг батлах тухай” 1 дүгээр тогтоол. Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (1990-2017 он). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018. 208-214 дэх тал.

		тухай”, УИХ-ын тогтоол, 2001.06.21, №61	
5.	Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай”, УИХ-ын тогтоол, 2006.01.27, №14	УИХ-ын тогтоол, 2007.10.11, №67
6.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай ²	Монгол Улсын хууль, 2007.10.11	2020.05.13-ны хуулиар
7.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай	Монгол Улсын хууль, 2020.05.13	Хүчинтэй

Эх сурвалж:

- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он (Эх сурвалж, харьцуулсан судалгаа). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018.
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/additional/?lawid=356>

Анх 1990 онд батлагдсан “БНМАУ-ын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг”-д хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах талаар ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй байсан бол түүнээс хойш батлагдсан УИХ-ын тухай хууль, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн хууль тогтоомжид хэлэлцэж байгаа асуудлаар хуралдаанаас завсарлага авах асуудлыг дараах байдлаар зохицуулж иржээ. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Улсын Их Хурлын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалтын түүхчилсэн лавлагаа

№	Хууль, тогтоолын нэр	Хуулийн зохицуулалт
1.	Монгол Улсын Их Хурлын тухай хууль ³ (1992.07.06)	<p>18 дугаар зүйл. Намын бүлгийн эрх, үүрэг 18.1.Улсын Их Хурал дахь намын бүлэг дараах эрх, үүрэгтэй: 18.1.3.Улсын Их Хурлын <u>чуулганы хуралдааны үед завсарлага авах</u>;</p> <p>20 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний үндсэн эрх, үүрэг 20.2.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах үндсэн эрх, үүрэгтэй: 20.2.2.асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд <u>таслах эрхтэй оролцох</u>;</p> <p>24 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын чиг үүрэг 24.1.Улсын Их Хурлын дарга нь Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь уялдуулан зохицуулж, дараах ажлыг биечлэн эрхэлнэ: 24.1.4.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хурлын гишүүдэд туслах;</p> <p>31 дүгээр зүйл. Улсын Их Хурлын хуралдааны дэг 31.1. ...Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол <u>гишүүдийн олонхийн саналаар хуралдааныг түр завсарлах буюу хугацааг нь сунгаж болно.</u> 31.5.Чуулганы хуралдаанаар хэлэлцэх <u>тодорхой асуудлыг эрс эсэргүүцсэн шалтгаанаар улсын Их Хурлын гишүүн, намын бүлэг тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй гэдгээ уг асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө хуралдаан даргалагчид албан ёсоор мэдэгдэж болно.</u> Ийнхүү чуулганы хуралдаанд оролцоогүй нь хуралдааны хүчин төгөлдөр байхад</p>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawid=356>

³ Монгол Улсын Их Хурлын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11439>

		<p>нөлөөлөхөөр байвал хэрхэхийг Улсын Их Хурлын дарга шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл захирамж гаргаж болно.</p>
2.	<p>Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль⁴ (1997.02.06)</p>	<p>5 дугаар зүйл. Хуралдааны хэлэлцэх асуудал</p> <p>5.5.Чуулганы хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлыг эрс эсэргүүцсэн Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй гэдгээ уг асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө хуралдаан даргалагчид албан ёсоор мэдэгдэж болно.</p> <p>Энэ тохиолдолд нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд оролцохгүй тухай шалтгаан, хугацааг мэдэгдэж, хуралдаан даргалагчид бичгээр өгнө.</p> <p>Ийнхүү чуулганы хуралдаанд оролцохгүй нь хуралдааны хүчин төгөлдөр байхад нөлөөлөхөөр бол дэгийн дагуу хуралдаанд оролцохыг шаардах, эсхүл <u>хуралдаан завсарлах эсэхийг хуралдаан даргалагч шийдвэрлэнэ.</u></p> <p><u>Хуралдаан завсарласан хугацаанд нам, эвслийн бүлгийн ахлагч нар уг асуудлаар зөвшилцөнө.</u></p> <p><u>Зөвшилцөлд хүрч чадаагүй бол хуралдаанд оролцохгүй байх хугацаа дуусмагц тухайн гишүүн, нам, эвслийн бүлэг хуралдаандаа ирэх үүрэгтэй.</u> Хэрэв хуралдаанд ирэхгүй бүл Улсын Их Хурлын дарга хуралдаанд оролцохыг шаардсан захирамж гаргана.</p> <p>7 дугаар зүйл. Улсын Их Хурлын хуралдааны хуваарь</p> <p>7.6.Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол <u>гишүүдийн олонхын саналаар хуралдааныг түр завсарлах буюу хугацааг нь сунгаж болно.</u></p>
3.	<p>“Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг батлах тухай” УИХ-ын тогтоол⁵ (2001.06.21, №61)</p>	<p>Нэг. Нийтлэг үндэслэл</p> <p>1.9.Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол <u>гишүүдийн саналаар хуралдааныг түр завсарлуулах буюу хугацааг нь сунгаж болно.</u> Харин <u>түр завсарлах хугацаа нэг цагаас илүүгүй байна.</u></p> <p>1.10.Чуулганы хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлыг эрс эсэргүүцсэн Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй гэдгээ уг асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө хуралдаан даргалагчид албан ёсоор мэдэгдэж болно.</p> <p>Энэ тохиолдолд нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд оролцохгүй тухай шалтгаан, хугацааг мэдэгдэж, хуралдаан даргалагчид бичгээр өгнө.</p> <p>Ийнхүү чуулганы хуралдаанд оролцоогүй нь хуралдаан хүчин төгөлдөр байхад нөлөөлөхөөр бол дэгийн дагуу хуралдаанд оролцохыг шаардах, эсхүл <u>хуралдаан завсарлах эсэхийг хуралдаан даргалагч шийдвэрлэнэ.</u></p> <p><u>Хуралдаан завсарласан хугацаанд нам, эвслийн бүлгийн ахлагч нар уг асуудлаар зөвшилцөнө.</u></p> <p>Ийнхүү авсан <u>хуралдааны завсарлага нь нэг цагаас илүүгүй байна.</u> <u>Зөвшилцөлд хүрч чадаагүй бол хуралдаанд оролцохгүй байх хугацаа дуусмагц тухайн гишүүн, нам эвслийн бүлэг хуралдаанд ирэх үүрэгтэй.</u></p> <p>Хэрэв хуралдаанд ирэхгүй бол Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд оролцохыг шаардсан захирамж гаргах бөгөөд дээрх шалтгаанаар нэгдсэн хуралдаанд оролцохгүй байгаа Улсын Их Хурлын гишүүнийг хуралдаан тасалсанд тооцно.</p> <p>Зөвшилцөж чадаагүй асуудлыг нэгдсэн хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.</p>
4.	<p>“Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг</p>	<p>Хоёр. Хуралдааны тов, ирц</p>

⁴ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1997 оны 4 дугаарт нийтлэгдсэн. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=7104>

⁵ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 27 дугаарт нийтлэгдсэн. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203159&showType=1>

<p>батлах тухай” УИХ-ын 14 дүгээр тогтоол⁶ (2006.01.27)</p>	<p>2.6.Улсын Их Хурлын дарга <u>нэгдсэн хуралдааныг Байнгын хороо, нам эвслийн бүлгийн саналаар түр завсарлуулах буюу хугацааг нь сунгаж болно.</u></p> <p>2.9 Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн, эсхүл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэхээс бусад шалтгаанаар гишүүн, нам, эвслийн бүлэг хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно.</p> <p>2.10. Энэ дэгийн 2.9-д зааснаас бусад шалтгаанаар гишүүн хуралдаанд оролцоогүй буюу орхиж гарсан бол түүнийг хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.</p>
<p>5. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль⁷ (2007.10.11)</p>	<p>4 дүгээр зүйл. Хуралдааны тов, ирц</p> <p>4.6.Улсын Их Хурлын дарга <u>нэгдсэн хуралдааныг Байнгын хороо, нам эвслийн бүлгийн саналаар түр завсарлуулах буюу хугацааг нь сунгаж болно.</u></p> <p>4.6.Нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27.1.4-т⁸ заасны дагуу <u>завсарлага авах бол ийнхүү завсарлага авах хугацаа нь ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг нэг удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно.</u> Тухайн асуудлаар нам, эвслийн бүлэг дахин завсарлага авахыг хориглоно.⁹</p> <p><u>/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u></p> <p>Хуулиар шийдвэрлэх хугацааг тусгайлан заасан асуудлаар нам, эвслийн бүлэг завсарлага авах бол хуралдаан даргалагч тухайн асуудлыг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэхэд саад болохгүй байхаар завсарлагын хугацааг тогтооно.¹⁰</p> <p><u>/Энэ хэсэгт 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</u></p> <p>Завсарлагын хугацаанд нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдаанаар тухайн асуудлаар хэлэлцүүлэг явуулахгүй.¹¹</p> <p><u>/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u></p> <p>4.7.Нам, эвслийн бүлгийн дарга, эсхүл дэд дарга энэ хуулийн 4.6-д заасны дагуу завсарлага авахдаа завсарлага авах шалтгаан, хугацааг тодорхой хэлж, энэ талаар хуралдааны тэмдэглэлд тусгуулна.¹²</p> <p><u>/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u></p>
<p>6. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль¹³ (2020.05.13)</p>	<p>7 дугаар зүйл. Цахим хуралдааны дэг</p> <p>7.8.Хуралдааны үед <u>нам, эвслийн бүлэг тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авахаар бол хуралдаан даргалагч тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан завсарлагын хугацааг тогтооно.</u></p> <p>13 дугаар зүйл. Гишүүн хуралдаанд асуулт асуух, үг хэлэх журам</p>

⁶ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=203204&showType=1>

⁷ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 39 дугаарт нийтлэгдсэн. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=356>

⁸ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27.1.4-т зааснаар бүлэг “нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах” эрхтэй.

⁹ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=101571&showType=1>

¹⁰ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=102648&showType=1>

¹¹ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=103381&showType=1>

¹² Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=101571&showType=1>

¹³ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15412>

	<p>13.4. <u>Гишүүн</u> энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр <u>тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах</u> бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ.</p> <p>13.5. Хуралдаан даргалагч тухайн өдрийн хуралдааныг нээж, хэлэлцэх асуудалтай холбоотой гишүүнээс ирүүлсэн горимын саналыг танилцуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Энэ талаар хэлэлцүүлэг явуулахгүй.</p> <p>15 дугаар зүйл. Хуралдаанаас завсарлага авах</p> <p>15.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол <u>нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.4-т¹⁴ заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг 1 удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно.</u></p> <p>15.2. Нам, эвслийн бүлгийн дарга, эсхүл түүнийг албан ёсоор орлож байгаа гишүүн энэ хуулийн 15.1-д заасны дагуу завсарлага авахдаа завсарлага авах үндэслэл, хугацааг тодорхой хэлж, энэ талаар хуралдааны тэмдэглэлд тусгуулна.</p> <p>15.3. Завсарлага авсан нам, эвслийн бүлэг тухайн асуудлаар дахин завсарлага авахыг хориглоно.</p> <p>15.4. Шийдвэрлэх хугацааг нь хуулиар тусгайлан заасан асуудлаар нам, эвслийн бүлэг завсарлага авах бол хуралдаан даргалагч завсарлагын хугацааг тухайн асуудлыг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэх боломжтой байхаар тогтооно.</p> <p>15.5. Завсарлага авсан хугацаанд тухайн асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.</p>
--	--

¹⁴ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.4-т зааснаар бүлэг “нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах” эрхтэй.

Хоёр. ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНААС ЗАВСАРЛАГА АВАХ ТУХАЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаанаас үзэхэд, ихэнх улс орнуудад парламентын хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах, тэр дундаа завсарлага авахтай холбоотой харилцааг парламентын тухай хууль, эсхүл хуралдааны дэгээр зохицуулдаг байна. Энэ судалгаанд хамрагдсан гадаадын 7 орны хувьд парламентын хуралдааны дэгийг дэгийн тухай хууль, эсхүл регламентаар зохицуулж байгаа бол Бүгд Найрамдах Солонгос Улс (Өмнөд Солонгос)-д Парламентын буюу Үндэсний Ассамблейн тухай хуулиар зохицуулж байна. Тухайлбал:

1. Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг;¹⁵
2. Герман Улсын Бундестагийн хуралдааны дэг;¹⁶
3. Оросын Холбооны Улсын Төрийн Думын регламент;¹⁷
4. Өмнөд Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль;¹⁸
5. Турк Улсын Үндэсний Их Хурлын дэгийн тухай хууль;¹⁹
6. Финланд Улсын Парламентын хуралдааны дэг;²⁰
7. Франц Улсын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг;²¹
8. Эстони Улсын Рийгикогугийн хуралдааны дэг, дотоод журмын тухай хууль.²²

Эдгээр эрх зүйн баримт бичгүүдэд парламентын хуралдаанаас завсарлага авах гэдэгт хэлэлцэж байгаа асуудлаар парламентын хуралдаанаас завсарлага авах, хэлэлцүүлгийг завсарлуулах, эсхүл түр хойшлуулахаар зохицуулсан байна. Тухайлбал:

Хэлэлцэж байгаа асуудлаар хуралдаанаас завсарлага авах тухай зохицуулалтыг авч үзвэл, *Герман Улсын Бундестагт* дараах субъектүүдийн саналаар тухайн асуудлын хэлэлцүүлгийг завсарлуулна. Үүнд:

- 1) намын бүлгийн саналаар;
- 2) хуралдаанд оролцвол зохих гишүүдийн 5-аас доошгүй хувийн саналаар;
- 3) гишүүний саналаар.

Бундестагийн гишүүн нь хэлэлцүүлгийн явцад хийсэн мэдээлэлд няцаалт хийх, залруулах зорилгоор хэлэлцүүлгийг завсарлуулж болохоор хуульчилсан байна.

Оросын Холбооны Улс (Орос Улс)-ын Төрийн Думын хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулах (буюу зогсоох)-ыг санал хураалтад оролцсон

¹⁵ Австралийн Холбооны Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг (House of Representatives Standing and Sessional Orders, 2004)
https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_Orders

¹⁶ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэг (Rules of Procedure of the German Bundestag) - <https://www.bundestag.de/en/parliament/function/legal>

¹⁷ Оросын Холбооны Улсын Төрийн Думын Регламент (Регламент Государственной Думы, 1998)
<http://duma.gov.ru/duma/about/regulations/>

¹⁸ Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль (National Assembly Act, 2012)
https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=25732&lang=ENG

¹⁹ Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын хуралдааны дэг (Türkiye büyük millet meclisi içtüzüğü (Rules of Procedure of the Grand National Assembly of Turkey), 1973)
<https://www.mevzuat.gov.tr/anasayfa/MevzuatFihristDetayiframe?MevzuatTur=17&MevzuatNo=584&MevzuatTertip=5>

²⁰ Бүгд Найрамдах Финланд Улсын Парламентын хуралдааны дэг (Parliament's Rules of Procedure, 1999)
https://www.eduskunta.fi/FI/naineduskuntatoimii/julkaisut/Documents/ekj_3+2013.pdf

²¹ Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн Регламент (Rules of Procedure of National Assembly, 1958) <https://www2.assemblee-nationale.fr/langues/welcome-to-the-english-website-of-the-french-national-assembly#chap12>

²² Бүгд Найрамдах Эстони Улсын Рийгикогугийн хуралдааны дэг, дотоод журмын тухай хууль (Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act, 2003) - <https://www.riigiteataja.ee/en/eli/518112014003/consolide>

депутатуудын олонхын саналаар шийдвэрлэнэ. *Финланд Улсын Парламентад* хуралдаанд асуудлыг танилцуулах хэлэлцүүлгийн үед хэрэв хэн нэгэн гишүүн хүсэлт гаргасан бол уг хэлэлцүүлгийг ойрын нэгдсэн хуралдаан хүртэл нэг удаа хойшлуулж болно.

Франц Улсын Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч буюу хуралдаан даргалагч нь хуралдааныг хэдийд ч түр хойшлуулах (suspend) буюу завсарлуулах (adjourn) эрхтэй.

Мөн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар эсрэг байр суурьтай 2-оос доошгүй гишүүн үг хэлсэн бол уг хэлэлцүүлгийн тухайн үе шатыг Ерөнхийлөгч хааж болох (closure)-оос гадна Танхимын гишүүн хэлэлцүүлгийг хаах талаар санал гаргаж болно.

Ерөнхийдөө Үндэсний Ассамблейн хуралдааны дэгтэй холбоотой саналыг ямагт үндсэн асуудал (the main question)-аас нэн тэргүүнд хэлэлцэх буюу үндсэн асуудлаарх хэлэлцүүлгийг түр хойшлуулж болохоор Регламентад заасан байна. Гишүүн дэгтэй холбоотой санал гаргах үед өөр гишүүн үг хэлж байвал түүнийг үгээ хэлж дуусмагц санал гаргасан гишүүнд үг хэлэх эрх олгодог байна.

Хуралдааныг түр хойшлуулах хүсэлтийг Засгийн газар, холбогдох хорооны дарга буюу илтгэгч, эсхүл намын бүлгийн дарга, эсхүл түүнийг төлөөлөхөөр урьдчилан Ерөнхийлөгч буюу хуралдаан даргалагчид мэдэгдсэн бүлгийн гишүүн санал гаргасан бол хуралдаан даргалагч шийдвэрлэнэ, бусад тохиолдолд Үндэсний Ассамблейгаар шийдвэрлэнэ.

Эстони Улсын Рийгикогууд хуралдаан даргалагч нь 30 хүртэлх минутын завсарлага зарлаж болохоос гадна Байнгын хороо, эсхүл намын бүлгийн дарга, дэд дарга санал хураахаас өмнө 10 хүртэлх минутын завсарлага шаардах эрхтэй. Мөн Рийгикогугийн Зөвлөл, холбогдох хороо, эсхүл төсөл санаачлагчийн саналаар Рийгикогу төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн санал хураалтыг түр хойшлуулж болохоор зохицуулсан байна.

Судалгаанд хамрагдсан улсуудаас *Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын* хувьд хуралдаанаас завсарлага авах онцлог зохицуулалттай гэж хэлж болохоор байна. Төлөөлөгчдийн танхим нь “завсарлагааны хэлэлцүүлгийн цаг” буюу “adjournment” хэмээх тусгайлсан хэлэлцүүлэг явуулах цагтай байна. Энэхүү цагийг Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэгийн 29 дүгээр зүйлд тусгажээ. Хуваарийн дагуу Даваагаас Лхагва гарагт 19:30 цагт, Пүрэв гарагт 16.30 цагт спикер “Танхим одоо завсарлах уу” (“That the House do now adjourn?”) гэж асууснаар нэгэн төрлийн чөлөөт хэлэлцүүлэг буюу мэтгэлцээнийг эхлүүлдэг. Энэхүү хэлэлцүүлгийн онцлог нь танхимын хэлэлцүүлэгт хамаарах нийтлэг журмыг баримтлахгүйгээр гишүүдэд аливаа асуудлаар чөлөөтэй үг хэлэх боломж олгодогт оршино. (Хүснэгт 3.) Гэхдээ энэ үеэр танхимын хуралдаанаар хэлэлцээгүй аливаа шинэ асуудлыг хэлэлцэхгүй.

Хүснэгт 3. Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны цагийн хуваарь

1	2	3	4
Гараг	Хуралдаан эхлэх	Завсарлага санал болгох	Танхим завсарлах
Даваа	10:00	19:30	20:00
Мягмар	12:00	19:30	20:00
Лхагва	09:30	19:30	20:00
Пүрэв	09:30	16:30	17:00

Дэгийн 1 дүгээр зүйлд заасны дагуу уг хэлэлцүүлгийн үед гишүүн 5 хүртэлх минут үг хэлнэ, тэрээр 2 дахь удаагаа мөн 5 хүртэлх минут үг хэлэх боломжтой. Гэхдээ 2 дахь удаагийнх

нь танхимаас өөр гишүүн үг хэлэх хүсэлт гаргаагүй тохиолдолд боломжтой ажээ. Энэ үеэр гишүүн буруу ташаа мэдээллийг засахын тулд өмнөх мэтгэлцээний үеэр хөндөгдсөн асуудалд хувийн тайлбар, хариу өгч болно.

Төлөөлөгчдийн танхимын практикт уг чөлөөт хэлэлцүүлгийн үед сөрөг хүчний гишүүн хамгийн түрүүнд үг хэлэх саналыг хүлээж авдаг. Үүний дараа хэрэв гишүүд хуралдааны танхимын хоёр талаас үг хэлэх хүсэлтээ илэрхийлж боссон бол спикер ердийн журмаар хоёр талын гишүүдээс ээлжлэн дуудах ба спикер түрүүлж боссон гишүүнээс эхэлж дуудна.²³

Завсарлагааны хэлэлцүүлэг (adjournment) Даваагаас Лхагва гарагт 20:00 цаг хүртэл, Пүрэв гарагт 17:00 цаг хүртэл үргэлжилнэ. (Хүснэгт 3.)

Хэрэв танхимын тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд багтсан асуудлыг хэлэлцэж дуусаагүй байхад завсарлагааны хэлэлцүүлгийн цаг эхэлсэн бол уг асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулна.

Судалгаанд хамрагдсан орнуудын парламентад хуралдааны танхимд **эмх замбараагүй байдал үүссэний улмаас** хуралдааныг завсарлуулдаг зохицуулалт байна. Тухайлбал, *Турк Улсын Үндэсний Их Хуралд* хуралдаан даргалагч нь хуралдааны үеэр чимээ шуугиан гаргах, зодоон цохион хийх зэрэг эмх замбараагүй байдал үүсэж, хуралдааны дэгийг сахиулж чадахгүй бол чуулганы индэр дээрээс хуралдаанаас завсарлага авахыг сануулна, хэрэв эмх замбараагүй байдал үргэлжилбэл нэг хүртэлх цагийн завсарлага зарлах эрхтэй. Хуралдааныг дахин нээсэн ч эмх замбараагүй байдлыг зогсоож чадаагүй бол хуралдаан даргалагч хуралдааныг хаана. Мөн *Австрали, Герман, Өмнөд Солонгос* зэрэг улсын парламентад хуралдаан даргалагч ийм тохиолдолд хуралдааныг завсарлуулах эрхтэй.

Мөн дараах тохиолдлуудад хуралдааныг завсарлуулах, хэлэлцүүлгийг, эсхүл хуралдааныг хойшлуулах зохицуулалт байна. Тухайлбал:

Эстони Улсын Рийгигогуд шаардлагатай гэж үзвэл хуралдаан даргалагч хэлэлцэж буй асуудлаар **санал хураалтад бэлтгэх шаардлага гарсан тохиолдолд** хуралдааныг завсарлуулах ба саналын хуудас бэлтгэсний дараа хуралдаан даргалагч завсарлага дууссаныг зарлана.

Австрали, Герман, Турк зэрэг улсуудын парламентад **гишүүдийн ирц бүрдээгүйн улмаас** хэлэлцүүлгийг, эсхүл хуралдааныг хойшлуулж болдог. Тухайлбал, *Турк Улсын Үндэсний Их Хуралд* нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь ирээгүй бол хуралдааныг нэг цаг хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Хэрэв хуралдааны ирц бүрдээгүй бол уг хуралдааныг хааж болно.

Эстони Улсын Рийгигогуд хэлэлцүүлгийн үндэслэл болсон **баримт бичгийг гишүүдэд цаг тухайд нь тараагаагүй нь** хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болно.

Мөн **тухайн асуудлыг хэлэлцэхэд холбогдох субъект нь хуралдаанд хүрэлцэн ирээгүй нь** хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болдог. Тухайлбал, *Эстони Улсын Рийгигогуд* илтгэгч нь, *Орос Улсын Төрийн Думд* хуулийн төсөл өргөн мэдүүлсэн хууль санаачлагч, эсхүл түүний төлөөлөгч, холбогдох хороодын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь ирээгүй бол тухайн асуудлаарх хэлэлцүүлгийг хойшлуулна.

Судалгаанд авагдсан орнуудын парламентын хуралдаанаас завсарлага авах, хэлэлцүүлгийг завсарлуулах, түр хойшлуулахтай холбоотой парламентын хууль,

²³ Adjournment debate. Parliament of Australia
https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/H_TML/Chapter16/Adjournment_debate

хуралдааны дэг, регламентаар зохицуулсан харилцааны зүйл, заалтуудыг дэлгэрэнгүй байдлаар Хүснэгт 4-өөс үзнэ үү.

Хүснэгт 4. Судалгаанд авагдсан орнуудын парламентын хуралдаанаас завсарлага авах эрх зүйн зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт																																								
1.	<p>Австрали Улс Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг (2004 онд батлагдсан)</p>	<p>1 дүгээр зүйл. Үг хэлэх хугацааны дээд хязгаар Хэлэлцүүлэг, үг хэлэх, мэдэгдэл хийх хугацааны дээд хязгаар нь дараах байдалтай байна.</p> <table border="1" data-bbox="465 506 1159 938"> <thead> <tr> <th data-bbox="465 506 995 601">Хэлэлцүүлгийн дэг</th> <th data-bbox="995 506 1159 601">Хугацаа (дээд хязгаар)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td colspan="2" data-bbox="465 601 1159 639">Завсарлагааны хэлэлцүүлэг (adjournment)</td> </tr> <tr> <td data-bbox="465 639 995 677">Завсарлагааны нийт хэлэлцүүлэг</td> <td data-bbox="995 639 1159 677">30 минут</td> </tr> <tr> <td data-bbox="465 677 995 715">Холбооны танхим дахь нийт хэлэлцүүлэг</td> <td data-bbox="995 677 1159 715">Тодорхойгүй</td> </tr> <tr> <td data-bbox="465 715 995 773">Сунгасан хэлэлцүүлэг (Сайд хариулахын тулд түүний хүсэлтээр хэлэлцүүлгийг сунгах)</td> <td data-bbox="995 715 1159 773">10 минут</td> </tr> <tr> <td data-bbox="465 773 995 811">Гишүүн бүр (цаг сунгахгүйгээр)</td> <td data-bbox="995 773 1159 811">5 минут</td> </tr> <tr> <td data-bbox="465 811 995 906">Хэрэв өөр гишүүн босоогүй бол өмнө нь саналын талаар үг хэлсэн гишүүн дахин үг хэлэх</td> <td data-bbox="995 811 1159 906">5 минут</td> </tr> <tr> <td data-bbox="465 906 995 938">Сунгасан хэлэлцүүлэгт сайд үг хэлэх</td> <td data-bbox="995 906 1159 938">5 минут</td> </tr> </tbody> </table> <p data-bbox="817 944 1150 1020" style="text-align: right;"><i>(Дэгийн 31 дүгээр зүйл (Танхим), 191 дүгээр зүйл (Холбооны танхим))</i></p> <p>29 дүгээр зүйл. Танхимын хуралдаан болон завсарлагааны хэлэлцүүлгийн цагийн хуваарийг тогтоох б) Танхим нь дэгийн 30, 31, 32 дугаар зүйлд заасан асуудлаар дараах цагийн хуваарийн дагуу хуралдах ба завсарлана (adjourn).</p> <table border="1" data-bbox="465 1148 1159 1391"> <thead> <tr> <th data-bbox="465 1148 637 1239">1</th> <th data-bbox="637 1148 810 1239">2</th> <th data-bbox="810 1148 982 1239">3</th> <th data-bbox="982 1148 1159 1239">4</th> </tr> <tr> <th data-bbox="465 1239 637 1277">Гараг</th> <th data-bbox="637 1239 810 1277">Хуралдаан эхлэх</th> <th data-bbox="810 1239 982 1277">Завсарлага санал болгох</th> <th data-bbox="982 1239 1159 1277">Танхим завсарлах</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="465 1277 637 1315">Даваа</td> <td data-bbox="637 1277 810 1315">10:00</td> <td data-bbox="810 1277 982 1315">19:30</td> <td data-bbox="982 1277 1159 1315">20:00</td> </tr> <tr> <td data-bbox="465 1315 637 1353">Мягмар</td> <td data-bbox="637 1315 810 1353">12:00</td> <td data-bbox="810 1315 982 1353">19:30</td> <td data-bbox="982 1315 1159 1353">20:00</td> </tr> <tr> <td data-bbox="465 1353 637 1391">Лхагва</td> <td data-bbox="637 1353 810 1391">09:30</td> <td data-bbox="810 1353 982 1391">19:30</td> <td data-bbox="982 1353 1159 1391">20:00</td> </tr> <tr> <td data-bbox="465 1391 637 1429">Пүрэв</td> <td data-bbox="637 1391 810 1429">09:30</td> <td data-bbox="810 1391 982 1429">16:30</td> <td data-bbox="982 1391 1159 1429">17:00</td> </tr> </tbody> </table> <p>31 дүгээр зүйл. Танхимын хуралдааныг автоматаар завсарлуулах (adjournment) а) Дэгийн 29 дүгээр зүйлийн 3 дахь баганад заасан хугацаа болоход спикер хуралдаан завсарлуулах санал хураалт явуулна. Санал хураалтын талаар хэлэлцэж болох боловч өөрчлөлт оруулахгүй. в) Дор дурдсан шаардлагыг хангасан байна: Санал хураалт дуусгавар болох</p>	Хэлэлцүүлгийн дэг	Хугацаа (дээд хязгаар)	Завсарлагааны хэлэлцүүлэг (adjournment)		Завсарлагааны нийт хэлэлцүүлэг	30 минут	Холбооны танхим дахь нийт хэлэлцүүлэг	Тодорхойгүй	Сунгасан хэлэлцүүлэг (Сайд хариулахын тулд түүний хүсэлтээр хэлэлцүүлгийг сунгах)	10 минут	Гишүүн бүр (цаг сунгахгүйгээр)	5 минут	Хэрэв өөр гишүүн босоогүй бол өмнө нь саналын талаар үг хэлсэн гишүүн дахин үг хэлэх	5 минут	Сунгасан хэлэлцүүлэгт сайд үг хэлэх	5 минут	1	2	3	4	Гараг	Хуралдаан эхлэх	Завсарлага санал болгох	Танхим завсарлах	Даваа	10:00	19:30	20:00	Мягмар	12:00	19:30	20:00	Лхагва	09:30	19:30	20:00	Пүрэв	09:30	16:30	17:00
Хэлэлцүүлгийн дэг	Хугацаа (дээд хязгаар)																																									
Завсарлагааны хэлэлцүүлэг (adjournment)																																										
Завсарлагааны нийт хэлэлцүүлэг	30 минут																																									
Холбооны танхим дахь нийт хэлэлцүүлэг	Тодорхойгүй																																									
Сунгасан хэлэлцүүлэг (Сайд хариулахын тулд түүний хүсэлтээр хэлэлцүүлгийг сунгах)	10 минут																																									
Гишүүн бүр (цаг сунгахгүйгээр)	5 минут																																									
Хэрэв өөр гишүүн босоогүй бол өмнө нь саналын талаар үг хэлсэн гишүүн дахин үг хэлэх	5 минут																																									
Сунгасан хэлэлцүүлэгт сайд үг хэлэх	5 минут																																									
1	2	3	4																																							
Гараг	Хуралдаан эхлэх	Завсарлага санал болгох	Танхим завсарлах																																							
Даваа	10:00	19:30	20:00																																							
Мягмар	12:00	19:30	20:00																																							
Лхагва	09:30	19:30	20:00																																							
Пүрэв	09:30	16:30	17:00																																							

		<p>(i) Хэрэв дэгийн 31.а-д заасан Танхимыг завсарлуулах хугацаа болоход санал хураалт дуусаагүй байсан ч Танхимыг завсарлуулна.</p> <p>Хэлэлцэж дуусаагүй асуудал</p> <p>(vi) Хэрэв аливаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлээгүй байхад Танхимын хуралдааныг завсарлуулах цаг болсон бол тухайн асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулна.</p> <p>32 дугаар зүйл. Бусад завсарлага</p> <p>а) Сайд урьдчилан мэдэгдэлгүйгээр Танхимыг завсарлуулах санал гаргаж болно. Саналыг өөрчилж болохгүй.</p> <p>б) Дараах тохиолдолд спикер Танхимыг санал хуралт явуулахгүйгээр завсарлуулж болно:</p> <p>(i) гишүүдийн ирц бүрдээгүй болон дэгийн 57 дугаар зүйлд заасан ирц бүрдээгүй бол;</p> <p>(ii) дэгийн 95 дугаар зүйлд заасан эмх замбараагүй байдал үүссэн бол.</p> <p>33 дугаар зүйл. Ердийн завсарлагааны цагаас хойш үйл ажиллагаанд тавих хязгаарлалт</p> <p>Ердийн завсарлагааны цаг гэж дэгийн 29 дүгээр зүйлийн 4 дэх баганад заасан хамгийн сүүлийн цагийг ойлгоно. Танхимын захирамж гарснаас бусад тохиолдолд завсарлагааны хэлэлцүүлгийн хугацаанд аливаа шинэ асуудлыг хэлэлцэхгүй.</p> <p>34 дүгээр зүйл. Үйл ажиллагааны хуваарь</p> <p>Танхимын үйл ажиллагааны хуваарийг Зураг 2-т харуулав.</p> <p style="text-align: center;"><i>Зураг 1. Танхимын үйл ажиллагааны хуваарь²⁴</i></p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <thead> <tr> <th colspan="2">Даваа</th> <th colspan="2">Мягмар</th> <th colspan="2">Лхагва</th> <th colspan="2">Пүрэв</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>19.30</td> <td>ЗХ</td> <td>19.30</td> <td>ЗХ</td> <td>19.30</td> <td>ЗХ</td> <td>16.30</td> <td>ЗХ</td> </tr> <tr> <td>20.00</td> <td></td> <td>20.00</td> <td></td> <td>20.00</td> <td></td> <td>17.00</td> <td></td> </tr> </tbody> </table> <p>37 дугаар зүйл. Өдрийн хэлэлцэх асуудлын дараалал</p> <p>г) Тухайн өдрийн хэлэлцэх асуудлын дараалалд багтсан асуудлыг Танхимын хуралдаан завсарлахаас өмнө хэлэлцэж амжаагүй бол дараагийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулна.</p> <p>78 дугаар зүйл. Хэлэлцүүлэг явуулахгүй саналууд</p> <p>Дор дурдсан саналуудаар хэлэлцүүлэг явуулахгүй ба ямар нэгэн тайлбаргүйгээр, өөрчлөлт оруулахгүйгээр нэн даруй шийдвэрлэнэ:</p> <p>д) завсарлагааны хэлэлцүүлгийг эхлүүлэх (дэгийн 79 дүгээр зүйл);</p> <p>79 дүгээр зүйл. Завсарлагааны хэлэлцүүлэг явуулах (adjournment)</p> <p>а) Тухайн асуудлаар танхимын хуралдаан дээр үг хэлээгүй гишүүн, эсхүл асуултад хариулах эрхтэй гишүүн завсарлагааны хэлэлцүүлгийг эхлүүлж болно (the adjournment). Хэрэв гишүүн тусгайлан санал хураалт явуулах хүсэлт гаргаагүй бол уг асуудлыг завсарлагааны хэлэлцүүлгийн үеэр дахин хэлэлцүүлж санал хураалтад оруулж болно. Уг санал хураалтыг дахин хэлэлцүүлэхгүйгээр, өөрчлөлт оруулахгүйгээр шууд явуулж болно.</p> <p>б) Хэрэв санал дэмжигдсэн бол завсарлуулах санал гаргасан гишүүн хэлэлцүүлгийг дахин үргэлжлүүлэх үед хамгийн түрүүнд үг хэлж болно.</p> <p>в) Хэрэв санал дэмжигдээгүй бол завсарлуулах санал гаргасан гишүүн хэлэлцүүлгийн төгсгөл хэсэгт үг хэлж болно.</p> <p>95 дугаар зүйл. Ноцтой эмх замбараагүй байдлын үед Танхимын хуралдааныг завсарлуулах буюу зогсоох</p>	Даваа		Мягмар		Лхагва		Пүрэв		19.30	ЗХ	19.30	ЗХ	19.30	ЗХ	16.30	ЗХ	20.00		20.00		20.00		17.00	
Даваа		Мягмар		Лхагва		Пүрэв																				
19.30	ЗХ	19.30	ЗХ	19.30	ЗХ	16.30	ЗХ																			
20.00		20.00		20.00		17.00																				

²⁴ **Жич:** Завсарлаагатай холбоотой хэсгийг оруулсан болно. **Товчилсон үг:** ЗХ - завсарлуулах хэлэлцүүлэг.

		<p>Хэрэв Танхимд ноцтой эмх замбараагүй байдал үүссэн бол спикер санал хураалт явуулалгүйгээр:</p> <p>а) хэзээ хуралдахыг мэдэгдэж хуралдааныг түр хойшлуулна (suspend);</p> <p>б) дараагийн хуралдаан хүртэл завсарлуулна (adjourn).</p> <p>187 дугаар зүйл. Дэг сахиулах</p> <p>а) Хэрэв Холбооны танхимд эмх замбараагүй байдал үүсвэл:</p> <p>(ii) Гишүүн урьдчилан мэдэгдэхгүйгээр хуралдааныг түр хойшлуулах (suspend), эсхүл завсарлуулах (adjourn) тухай санал оруулж болно. Хэрэв хуралдааныг завсарлуулсан бол тухайн үед шийдвэрлэгдээгүй аливаа асуудлыг дараагийн хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд оруулна.</p>
<p>2.</p>	<p>Герман Улс Бундестагийн хуралдааны дэг</p>	<p>25 дугаар зүйл. Хэлэлцүүлгийг завсарлуулах буюу хаах</p> <p>1. Үг хэлэх дараалалд орсон гишүүдийн нэрс дууссан, эсхүл аль нэг гишүүн үг хэлэхээр саналаа илэрхийлэхгүй бол Ерөнхийлөгч (хуралдаан даргалагч) тухайн асуудлын хэлэлцүүлгийг хаасныг мэдэгдэнэ.</p> <p>2. Бундестаг нь намын бүлгийн буюу хуралдаанд оролцвол зохих гишүүдийн 5-аас доошгүй хувийн саналаар тухайн асуудлын хэлэлцүүлгийг завсарлуулах (adjournment) буюу хааж (close) болно. Хэлэлцүүлгийг завсарлуулах, хаах санал нэгэн зэрэг гарсан бол эхэнд нь хаах саналын талаар санал хураана. Гагцхүү бүх намын бүлгийн төлөөлөл үг хэлсний дараа хэлэлцүүлгийг хаах талаар санал хураалт явуулна.</p> <p>26 дугаар зүйл. Хуралдааныг завсарлуулах</p> <p>Бундестаг гагцхүү Ерөнхийлөгчийн, эсхүл намын бүлгийн буюу хуралдаанд оролцох ёстой гишүүдийн 5-аас доошгүй хувийн саналаар хуралдааныг завсарлуулна.</p> <p>30 дугаар зүйл. Хэлэлцэх асуудлаар тайлбар хийх</p> <p>Хэлэлцүүлэг дууссан (conclusion), түр хойшлуулсан (suspension), эсхүл завсарлуулсан (adjournment)-ы дараа хэлэлцүүлгийн талаар тайлбар хийх зөвшөөрлийг олгоно. Хэлэлцүүлгийн үед тайлбар хийхийг хүссэн гишүүдэд Ерөнхийлөгч давуу эрх олгож болно. Тухайн гишүүн тайлбар хийх хүсэлт гаргахдаа түүний үндэслэлийг Ерөнхийлөгчид мэдэгдэнэ. Гагцхүү хэлэлцүүлгийн явцад тухайн гишүүний талаар хийсэн мэдээлэлд залруулга, няцаалт хийхэд, эсхүл өөрийн хэлсэн үгийг залруулах зорилгоор энэхүү тайлбарыг хийнэ. Тайлбарын 5 хүртэлх минут хийнэ.</p> <p>32 дугаар зүйл. Хэлэлцэх асуудалд хамааралгүй асуудлаар тайлбар хийх</p> <p>Ерөнхийлөгч хэлэлцэх асуудлын дарааллын дагуу эхний асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө буюу дууссаны дараа, эсхүл хэлэлцүүлгийг түр хойшлуулсан (suspension) буюу завсарлуулсан (adjournment)-ны дараа хэлэлцэх асуудалд хамааралгүй асуудлаар тайлбар хийх хүсэлтэй гишүүнд үг хэлэх эрх олгож болно. Тухайн гишүүн тайлбар хийх үндэслэлээ Ерөнхийлөгчид мэдэгдэнэ. Тайлбарын 5 хүртэлх минут хийнэ.</p> <p>40 дүгээр зүйл. Хуралдааныг түр хойшлуулах</p> <p>Бундестагийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулах нөхцөл байдал үүссэн, үймээн дэгдсэн бол Ерөнхийлөгч хуралдааныг тодорхой хугацаагаар түр хойшлуулах (suspend), эсхүл дуусгах (terminate) эрхтэй. Ерөнхийлөгчийн үгийг сонсохгүй буюу хүлээн авахгүй бол Ерөнхийлөгч хуралдааныг түр зогсохын тулд суудлаа орхин явна. Хуралдааныг үргэлжлүүлэхийн тулд Ерөнхийлөгч хуралдааныг дахин зарлан хуралдуулна.</p>
<p>3.</p>	<p>Оросын Холбооны Улс</p>	<p>59 дүгээр зүйл.</p> <p>1. Төрийн Думаас тогтоосон хугацаа дууссан, эсхүл санал хураалтад оролцсон депутатуудын олонхын саналаар Төрийн Думын хуралдаанаар</p>

	<p>Төрийн Думын регламент (1998 онд батлагдсан)</p>	<p>хэлэлцэх асуудлын дараалалд орсон асуудлын хэлэлцүүлгийг дуусгавар болгож болно.</p> <p>2.Тухайн хэлэлцүүлгийг дуусгавар болгох тухай санал хүлээн авсан хуралдаан даргалагч нь үг хэлэх дараалалд орсон болон үг хэлсэн депутатуудын тоог Төрийн Думын депутатуудад мэдээлж, үг хэлэх дараалалд орсон боловч үг хэлж чадаагүй, үг хэлүүлэхийг шаардаж байгаа намын бүлгийн төлөөллүүдэд депутатуудын зөвшөөрснөөр үг хэлэх эрх олгоно.</p> <p>3.Асуудлын хэлэлцүүлэг дууссаны дараа илтгэгч, хамтран илтгэгч хаалтын үг хэлэх эрхтэй.</p> <p>4.Асуудлын хэлэлцүүлгийг дуусгавар болгох шийдвэр гаргасантай холбогдуулан үг хэлэх боломжгүй болсон Төрийн Думын депутатууд гарын үсгээ зурж, хуралдаан даргалагчид танилцуулсан хэлэх үгийн эх бичвэрийг хуралдааны тэмдэглэлд хавсаргах эрхтэй.</p> <p>84 дүгээр зүйл.</p> <p>2.Энэ Регламентад өөрөөр заагаагүй бол дэгтэй холбоотой асуудлыг санал хураалтад оролцсон депутатуудын олонхын саналаар шийдвэрлэнэ. Дэгтэй холбоотой асуудалд дараах асуудлууд хамаарна:</p> <p>а) хуралдааныг завсарлуулах (перерыв) буюу хуралдааныг хойшлуулах (перенос) тухай;</p> <p>д) хэлэлцэж байгаа асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулах (перенос) буюу зогсоох (прекращения) тухай;</p> <p>113 дугаар зүйл.</p> <p>3.Хуулийн төсөл өргөн мэдүүлсэн хууль санаачлагч, эсхүл түүний төлөөлөгч хуралдаанд ирээгүйн улмаас хуулийн төслийг хариуцсан хороогоор хэлэлцэх боломжгүй болсон бол уг хуулийн төслийг хэлэлцэхээр тус хорооны өөр хуралдаанд шилжүүлнэ. Хэрэв хуулийн төсөл өргөн мэдүүлсэн хууль санаачлагч нь Төрийн Думын депутат бол хариуцсан хороо хуулийн төслийн хэлэлцүүлгийг хойшлуулсан талаар холбогдох намын бүлэгт мэдэгдэнэ...</p> <p>118 дугаар зүйл.</p> <p>4.Хуулийн төсөл өргөн мэдүүлсэн хууль санаачлагч, эсхүл түүний төлөөлөгч Төрийн Думын хуралдаанд ирээгүйн улмаас хуулийн төслийг Төрийн Думын хуралдаанаар хэлэлцэх боломжгүй болсон бол уг хуулийн төслийг хэлэлцэхээр Төрийн Думын өөр хуралдаанд шилжүүлнэ.</p> <p>Хариуцсан хорооноос батлуулахаар мэдүүлсэн хуулийн төслийг Төрийн Думын хуралдаанаар хэлэлцэх үед хуулийн төсөл өргөн мэдүүлсэн хууль санаачлагч, эсхүл түүний төлөөлөгч дахин ирээгүй бол хариуцсан хорооны саналаар уг хуулийн төслийг Төрийн Дум хуулийн төсөл өргөн мэдүүлсэн хууль санаачлагч, эсхүл түүний төлөөлөгчийн оролцоогүйгээр хэлэлцэнэ.</p> <p>121.1 дүгээр зүйл.</p> <p>3.Төрийн Думын Төсөв, татварын хорооноос дараагийн санхүүгийн жил, төлөвлөсөн хугацааны холбооны төсвийн тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэхэд холбогдох хороодын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг заавал оролцуулна. Төрийн Думын Төсөв, татварын хорооны хуралдаанд холбогдох хороодын итгэмжлэгдсэн төлөөлөгчид зөвлөх саналаар оролцоно.</p> <p>Хэрэв Төрийн Думын Төсөв, татварын хорооны хуралдаанд холбогдох хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч ирээгүй бол нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Төрийн Думын Төсөв, татварын хорооны өөр хуралдаанд шилжүүлэх ба энэ талаар холбогдох хороонд мэдэгдэнэ. Төрийн Думын Төсөв, татварын хорооны хуралдаанд холбогдох хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч дахин ирээгүй бол нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлын түүний оролцоогүйгээр хэлэлцэнэ.</p>
4.	Өмнөд Солонгос Улс	74 дүгээр зүйл. Хуралдааныг завсарлуулах

<p>Үндэсний Ассамблейн тухай хууль (2012 онд батлагдсан)</p>	<p>1.Хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд орсон асуудлуудыг хэлэлцэж дууссан бол хуралдаан даргалагч хуралдааныг завсарлуулах (adjournment) тухай зарлаж болно.</p> <p>2.Хуралдааныг завсарлуулах тухай зарласан өдөр хуралдааныг дахин хуралдуулахгүй. Дотоодын эмх замбараагүй байдал, гадаад аюул заналхийлэл, байгалийн гамшиг, санхүү, эдийн засгийн ноцтой хямрал, үндэсний аюулгүй байдалд нөлөөлсөн дайсагналын ноцтой байдал, дайн бүхий байдал, эсхүл түүнтэй адилтгах үндэсний онц байдал бий болсон үед хуралдаан даргалагч намын бүлэг тус бүрийн төлөөлөлтэй зөвшилцсөн бол энэ заалт үйлчлэхгүй.</p> <p>145 дугаар зүйл. Хуралдааны дэг сахиулах</p> <p>3.Хуралдааны танхимд эмх замбараагүй байдал үүссэний улмаас дэг сахиулах боломжгүй гэж үзсэн бол Үндэсний Ассамблейн дарга, эсхүл хорооны дарга хуралдааныг түр хойшлуулж (suspend) буюу завсарлуулж (adjourn) болно.</p>
<p>5. Турк Улс Үндэсний Их Хурлын дэгийн тухай хууль (1973 онд батлагдсан)</p>	<p>57 дугаар зүйл.</p> <p>...Хэрэв нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь ирээгүй бол хуралдааныг нэг цаг хүртэл хугацаагаар хойшлуулж болно (prostrone). Хэрэв хуралдааны ирц бүрдээгүй бол уг хуралдааныг хааж болно (close).</p> <p>68 дугаар зүйл.</p> <p>Хуралдаан даргалагч хуралдааны үеэр чимээ шуугиан гаргах, зодоон цохион хийх зэрэг эмх замбараагүй байдал үүссэн үед гишүүдэд хуралдааны дэгийг сахиулж чадахгүй бол чуулганы индэр дээрээс хуралдаанаас завсарлага авахыг сануулах, хэрэв дээрх эмх замбараагүй байдал үргэлжилбэл тэрээр нэг хүртэл цагийн завсарлага зарлана. Хуралдааныг дахин нээсэн ч чимээ шуугиан, зодоон цохионыг зогсоож чадахгүй бол дарга хуралдааныг хаана.</p>
<p>6. Финланд Улс Парламентын хуралдааны дэг (1999 онд батлагдсан)</p>	<p>57 дугаар зүйл. Хойшлуулах (deferral)</p> <p>Хэрэв танилцуулах хэлэлцүүлгийн үед гишүүн хүсэлт гаргасан бол уг асуудлыг ойрын нэгдсэн хуралдаан хүртэл хойшлуулна. Танилцуулах хэлэлцүүлгийг дахин хойшлуулахгүй.</p> <p>Хорооны танилцуулгыг дараагийн өдрийн нэгдсэн хуралдааны эхэнд хэлэлцэнэ. Гэхдээ тодорхой шалтгаанаар Парламент уг асуудлыг тухайн өдрийн нэгдсэн хуралдааны төгсгөлд хэлэлцэхээр хойшлуулж болно.</p> <p>Анхны хэлэлцүүлэг болон энэ дэгийн 54, 55 дугаар зүйлд заасан асуудлын хэлэлцүүлгийг нэг удаа хойшлуулж болно. Бусад тохиолдолд хойшлуулах асуудлыг Парламент шийдвэрлэнэ.</p> <p>Засгийн газрын мэдэгдэл, тайлан, асуулгатай холбоотой хэлэлцүүлэг эхэлсэн бол уг асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулахгүй. Хойшлуулах тухай зохицуулалт нь Ерөнхий сайдын мэдээлэл, эсхүл тулгамдсан асуудлын талаарх хэлэлцүүлэгт хамаарахгүй.</p>
<p>7. Франц Улс Үндэсний Ассамблейн хуралдааны дэг (1958 онд батлагдсан)</p>	<p>52 дугаар зүйл.</p> <p>1.Ерөнхийлөгч (хуралдаан даргалагч) хуралдааныг нээх, хэлэлцүүлгийг удирдан явуулах, хуралдааны дэгийн хэрэгжилтийг хангах, хуралдааны дэг сахиулна. Тэрээр хуралдааныг хэдийд ч түр хойшлуулж (suspend) буюу завсарлуулж (adjourn) болно.</p> <p>57 дугаар зүйл.</p> <p>1.Энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулсан хэлэлцүүлэг, эсхүл ерөнхий буюу тодорхой асуудлаарх хэлэлцүүлгийн үед буюу санал хураалтыг тайлбарлах үед эсрэг байр суурьтай хоёроос доошгүй илтгэгч үг хэлсэн бол хэлэлцүүлгийн тухайн үе шатыг нэн даруй хаахыг (closure) Ерөнхийлөгч шийдвэрлэж болно, эсхүл Танхимын гишүүн санал гаргаж болно. Хэлэлцүүлгийг ийнхүү хаах нь бүхэлдээ хуулийн төслийн санал хураалтын тайлбарт хамаарахгүй.</p> <p>2.Хэрэв Танхимын гишүүн ерөнхий хэлэлцүүлэг (the general debate)-ийг хаах санал гаргасан бол нэг гишүүнд зөвхөн уг саналыг эсэргүүцэж</p>

		<p>хоёр хүртэлх минутын үг хэлэхийг зөвшөөрнө. Хэлэлцүүлэгт үг хэлэх дарааллын дагуу үгээ хэлж чадаагүй эхний гишүүн нь хамгийн түрүүнд үг хэлэх ба түүний эзгүйд үг хэлэх дарааллын дагуу хэлэлцүүлэг хаахын эсрэг саналтай бусад гишүүнд давуу эрх олгоно. Хэрэв үг хэлэх дараалалд өөр гишүүн байхгүй бол хэлэлцүүлэг хаахыг эсэргүүцэж үг хэлэх хүсэлт эхэлж гаргасан гишүүн үг хэлнэ.</p> <p>3.Ерөнхий хэлэлцүүлгээс гадуур хэлэлцүүлгийг хаахыг шаардсан бол Танхим уг асуудлыг хэлэлцэхгүйгээр шийдвэрлэнэ.</p> <p>4.Хэлэлцүүлгийг хаах асуудлыг шийдвэрлэхэд нийтийн санал хураалт явуулахгүй. Ерөнхийлөгч гар өргөж санал хураах замаар зөвлөлдөнө. Хэрэв гар өргөх санал хураалтад эргэлзэж байгаа бол Танхим босож, сууж санал хураана. Хэрэв санал хураалтад эргэлзсэн хэвээр байгаа бол хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.</p> <p>58 дугаар зүйл.</p> <p>1.Хуралдааны дэгтэй холбоотой саналыг үндсэн асуудал (the main question)-аас ямагт нэн тэргүүнд тавих ба энэ нь үндсэн асуудлын талаарх хэлэлцүүлгийг түр хойшлуулна (suspend). Энэ зорилгоор үг хэлэх хүсэлт гаргасан бүх гишүүнд нэн даруй, хэрэв өөр гишүүн үг хэлж байвал түүнийг үгээ хэлж дуусмагц үг хэлэх эрх олгоно.</p> <p>2.Хэрэв дэвшүүлсэн асуудал нь хуралдааны дэг, эсхүл хуралдааны явцтай илт холбогдолгүй, эсхүл хэлэлцэх асуудалтай холбогдолгүй бол Ерөнхийлөгч тухайн гишүүний үгийг зогсооно.</p> <p>3.Хуралдааныг түр хойшлуулах (suspend) хүсэлтийг Засгийн газар, холбогдох хорооны дарга буюу илтгэгч, эсхүл намын бүлгийн хувьд бүлгийн дарга, эсхүл түүнийг төлөөлөхөөр урьдчилан Ерөнхийлөгчид мэдэгдсэн бүлгийн гишүүн гаргаснаас бусад тохиолдолд Үндэсний Ассамблей шийдвэрлэнэ. Аливаа шинэ төлөөлөгч нь өмнөх төлөөлөгчийг хүчингүй болгоно.</p> <p>4.Хэрэв гишүүн хувийн үзэл бодлоо илэрхийлэхийг хүссэн бол зөвхөн хуралдааны төгсгөлд үг хэлэх эрх олгоно.</p> <p>5.Энэ зүйлд заасны дагуу үг хэлэх эрхийг 2 хүртэлх минут олгоно.</p> <p>77 дугаар зүйл.</p> <p>1.Гишүүн хэлэлцүүлэг явуулах болон санал өгөх эрх чөлөөнд саад учруулахыг оролдох, эсхүл нэг буюу хэд хэдэн гишүүн руу халдсан тохиолдолд Ерөнхийлөгчийн дэг сахих тухай сануулгыг биелүүлэхгүй бол Ерөнхийлөгч хуралдааныг завсарлуулж (adjourn), Ажлын албыг хуралдуулна.</p>
<p>8.</p>	<p>Эстони Улс Рийгикогугийн хуралдааны дэг, дотоод журмын тухай хууль (2003 онд батлагдсан)</p>	<p>65 дугаар зүйл. Завсарлага Хуралдаан даргалагч 30 хүртэлх минутын завсарлага (recess) зарлаж болно.</p> <p>73 дугаар зүйл. Хэлэлцүүлэг явуулах боломжгүй болох 1.Хэрэв уг асуудлыг хэлэлцэх үндэслэл болсон баримт бичгийг Рийгикогугийн гишүүдэд цаг тухайд нь тараагаагүй, эсхүл илтгэгч ирээгүй бол хуралдаан даргалагч тухайн асуудлын хэлэлцүүлгийг нээхгүй. 2.Энэ зүйлийн 1 дэх дэд хэсэгт заасан нөхцөл бий болсон бол уг хэлэлцүүлгийг дараагийн ажлын долоо хүртэлх хоног хойшлуулна (deferred).</p> <p>83 дугаар зүйл. Санал хураах журам 2.Байнгын хороо, эсхүл намын бүлгийн дарга, дэд дарга санал хураахаас өмнө 10 хүртэлх минутын завсарлага (recess) шаардаж болно.</p> <p>86 дугаар зүйл. Санал хураалтад бэлтгэх 1.Шаардлагатай гэж үзвэл хуралдаан даргалагч саналын хуудас бэлтгэхийн тулд завсарлага (recess) зарлана. 3.Саналын хуудас бэлтгэсний дараа хуралдаан даргалагч завсарлага дууссаныг зарлана.</p>

		<p>107 дугаар зүйл. Төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг түр хойшлуулах</p> <p>1.Рийгикогугийн Зөвлөл, холбогдох хороо, эсхүл төсөл санаачлагчийн саналаар Рийгикогу төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн санал хураалтыг түр хойшлуулна (suspend). Намын бүлгийн холбогдох саналаар санал хураалт явуулна.</p>
--	--	--

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол

- Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 1992 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11439>
- Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль, 1997 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=7104>
- “Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг батлах тухай” УИХ-ын 2001 оны 61 дүгээр тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203159&showType=1>
- “Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг батлах тухай” УИХ-ын 2006 оны 14 дүгээр тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203204&showType=1>
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, 2007 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=356>
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, 2020 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15412>

Ном, сурах бичиг

- Монгол Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл, харьцуулсан судалгаа, 1914-2013). Г.Батхүү, Л.Өлзийсайхан, Б.Батбаяр. УИХ-ын Тамгын газар. УБ., 2013 он.
- Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл, харьцуулсан судалгаа, 1914-2013). Г.Батхүү, Л.Өлзийсайхан, Б.Батбаяр. УИХ-ын Тамгын газар. УБ., 2013 он.
- Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс. Л.Өлзийсайхан. УБ., 2010 он.
- Улсын Их Хурлын дэгийн тухай хууль тогтоомж дахь санал хураалтыг цахим тоолуураар явуулах зохицуулалт ба гишүүдийн ирц (СТ-18/228). УИХ-ын Тамгын газар, Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба. Судалгааны эмхэтгэл, Боть 29. УБ., 2018 он.
- БНМАУ-ын Бага Хурлын 1990 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн “Дэг батлах тухай” 01 дүгээр тогтоол. Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (1990-2017 он). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018 он.

Гадаад хэл дээрх эх сурвалж

- Австралийн Холбооны Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг (House of Representatives Standing and Sessional Orders, 2004) - https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_Orders
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэг (Rules of Procedure of the German Bundestag) - <https://www.bundestag.de/en/parliament/function/legal>
- Оросын Холбооны Улсын Төрийн Думын Регламент (Регламент Государственной Думы, 1998) - <http://duma.gov.ru/duma/about/regulations/>
- Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль (National Assembly Act, 2012) - https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=25732&lang=ENG
- Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын хуралдааны дэг (Türkiye büyük millet meclisi içtüzüğü (Rules of Procedure of the Grand National Assembly of Turkey), 1973) <https://www.mevzuat.gov.tr/anasayfa/MevzuatFihristDetaylframe?MevzuatTur=17&MevzuatNo=584&MevzuatTertip=5>
- Бүгд Найрамдах Финланд Улсын Парламентын хуралдааны дэг (Parliament's Rules of Procedure, 1999) - https://www.eduskunta.fi/FI/naineduskuntatoimii/julkaisut/Documents/ekj_3+2013.pdf
- Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн Регламент (Rules of Procedure of National Assembly, 1958) - <https://www2.assemblee-nationale.fr/langues/welcome-to-the-english-website-of-the-french-national-assembly#chap12>
- Бүгд Найрамдах Эстони Улсын Рийгикогугийн хуралдааны дэг, дотоод журмын тухай хууль (Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act, 2003) - <https://www.riigiteataja.ee/en/eli/518112014003/consolide>

**ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГ, МАНДАТЫН ТООГ ТОГТООХ ЭРХ
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ШАЛГУУР: ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ (НЭГ
ТАНХИМТАЙ) ОРНУУДЫН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Д.Халиун, Г.Билгээ,
О.Нарантуяа, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*

АГУУЛГА

Нэг.ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГ, МАНДАТЫН ТООГ ТОГТООХ
ЗОХИЦУУЛАЛТ

Хоёр.ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГ, МАНДАТЫН ТООГ ТОГТООХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ БА ШАЛГУУР: ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ (НЭГ ТАНХИМТАЙ)
ОРНУУДЫН ТУРШЛАГА

2.1.Парламентын гишүүдийн тоо

2.2.Сонгуулийн тойргийг тогтоох

2.3.Сонгуулийн тойргийн хилийн цэсийг тогтоох шалгуур

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1.Кирибати Улсын Манеаба ни Маунгатабу (Парламент)-гийн сонгуулийн
тойргийн хуваарь

Хавсралт 2.Македон Улсын сонгуулийн тойргийн хуваарь

Хавсралт 3.Унгар Улсын муж, нийслэл дэх бие даасан тойргийн тоо

Нэг. ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГ, МАНДАТЫН ТООГ ТОГТООХ ЗОХИЦУУЛАЛТ

1.1.Зарчим²⁵

Сонгуулийн тойрогтой холбоотойгоор олон улсад баримталж буй стандарт нь Венецийн Комиссын Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын тухай дүрэм юм. Уг дүрэмд тэгш саналын эрхийг "Тойрог бүрт ижил тэгш саналын эрх олгох: сонгуулийн тойргууд дээр суудлын тоог ижил хуваарилсан байх" гэж заасан. Тэгш саналын эрх нь сонгуулийн шударга байдлын үзэл баримтлалын чухал хэсэг юм. Үүнийг төлөөллийн болон тойрогт мандатын тоог хуваарилахад нөлөөлж болох тэгш сонгох эрхийн бусад хэсгээс салгаж болохгүй юм. Олон улсын стандартад нийцүүлэн тойрогт мандатын тоог хуваарилахад нөлөөлөх бусад хүчин зүйлст ил тод байдал, эрх мэдлээ дур зоргоор урвуулан ашиглахгүйгээр тойргийн нутаг дэвсгэрийг тогтоох хараат бус байгууллага зэрэг багтана.

Сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг тогтооход дараах зарчмуудыг харгалзан үзэх шаардлагатай.

Төлөөлөх чадвар

Тэгш саналын эрх нь сонгуулийн төлөөллийн ардчиллын зарчимтай харилцан уялдаж байдаг. Энэ нь иргэд бүх нийтийн, чөлөөт, шууд, нууц сонгуулиар сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулан, "нэг хүн, нэг санал" гэсэн бүх нийтийн зарчмыг ашиглан улс төрийн шийдвэрт оролцох боломжтой байхыг хэлнэ.

Төлөөлөх чадвар нь дараах таван шинж чанар(элемент)-ыг агуулдаг:

1. Сонгогчдын оролцооны цар хүрээ;
2. Сонгогч болон сонгогдсон хүмүүсийн хоорондын харилцааны шууд байдал;
3. Сонгогчдод олгогдсон сонголтын хүрээ;
4. Сонгогч бүрийн үр дүнтэй, нөлөөтэй байх тэнцвэртэй түвшин;
5. Төлөөлөл хүртдэг сонгогчдын эзлэх бодит хувь.

Төлөөлөх чадвар гэдэг нь сонгогчид улс орны ашиг сонирхлыг эрхэмлэн, өөрсдийг нь бүрэн төлөөлж чадах төлөөлөгчийг нийт ард түмний төлөөлөл болгон сонгох боломжоор хангасан сонгуулийн нутаг дэвсгэрийн хүрээ буюу сонгуулийн тойрог тогтоохыг илэрхийлнэ. Зарим тохиолдолд төлөөлөх чадвар нь сонгогчид болон ард түмний өөр өөр нэгдмэл ашиг сонирхол бүхий бүлэг (communities of interests)-ийн эрх ашигтай зөрчилдөх эрсдэлтэй байдаг. Тухайлбал, нэгдмэл ашиг сонирхол бүхий бүлэг нь үндэстэн ястан, хэл болон шашнаар ижилсэх бүлгүүдтэй нэгдмэл ашиг сонирхол байж болно. Түүнчлэн нэг засаг захиргааны нэгжийн хил хязгаарт газарзүйн хувьд орон нутгийн иргэд, эсхүл арал зэргээр хязгаарлагдсан нэгдлийг нэгдмэл ашиг сонирхол бүхий бүлэг гэж тодорхойлж болно. Үүнээс үүдэн цөөнхийн төлөөллийг хангахтай холбоотой асуудлыг сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг тогтооход харгалзах шаардлага бий болно.

Тэгш саналын эрх нь парламентын ардчиллын чухал элемент юм. Сонгуулийн зөв зохион байгуулалт болон тойргийн хуваарилалтыг зөв хослуулснаар сонгогчдын санал тэнцүү байх зарчим баталгааждаг. Англо-Саксоны сонгуулийн системд үүнийг “тэгш үнэ цэнтэй тэгш саналын зарчим” буюу “principle of equal votes of equal value” гэж нэрлэдэг.

Хувь тэнцүү хүн амтай тойргууд нь сонгогчид сонгуульд ижил тэнцүү хувиар санал өгөх боломж олгодог. Тухайлбал, нэг мандаттай тойрогт тойргуудыг харьцуулахад нэг тойрог нөгөө тойргоосоо олон сонгогчтой тохиолдолд тус тойргоос сонгогдсон төлөөлөгч хүн ам

²⁵ [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2017\)034-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2017)034-e)

багатай тойрогтой харьцуулахад сонгогчдын нөлөөллийн жин багатай байна. Энэ нь бүх санал ижил жинтэй байх ёстой гэсэн сонгуулийн ардчиллын бүх нийтийн зарчмын мөн чанарыг зөрчихөд хүргэж байна. Олон мандаттай тойргийн хувьд олон хүн амтай тойрог олон төлөөлөгчтэй байх жишээтэй.

Тэгш саналын эрхийн зөрчил нь active electoral geometry буюу тойргийн нутаг дэвсгэрийн хуваарилалтыг хэрэглэснээс үүдэн төлөөллийн тэгш бус байдал үүсэх, мөн passive electoral geometry-ийн буюу мандатын тоо болон тойргийн нутаг дэвсгэрийн хуваарилалт хийхгүй удаан явснаас үүдэн тус тус үүсч болно.

Цөөнхийн төлөөлөл

Сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг тогтоох үйл явц нь үндэсний цөөнхөд хохирол учруулах ёсгүй. Тухайлбал, газарзүйн хувьд төвлөрсөн цөөнхийг сонгуулийн хэд хэдэн тойрогт хувааж, ингэснээр нэг сонгуулийн тойрог бүрт сонгогчдын цөөнх (*ethnic gerrymandering*) болгон хуваахыг хориглох ёстой бөгөөд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг зөрчсөн гэж үзнэ. Сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг төвлөрсөн цөөнхийн төлөөллийг хангах байдлаар тогтоож болно. Ингэхдээ үндэстэн ястны суудлыг сонгуулийн апартеидын хэлбэрт хүргэж болзошгүй хэлбэрээр тогтоохоос зайлсхийвэл зохимжтой.

Сонгуулийн хууль тогтоомжоор төлөөллийн тэнцвэргүй байдал уламжлагдан ирснийг шийдвэрлэх тусгай арга хэмжээ авч болно. Зарчмын хувьд “affirmative action” буюу цөөнхийг дэмжих/тэгш байдлыг тогтооход чиглэсэн зориудын арга хэмжээ бүхий ийм арга хэмжээ нь сонгууль тэгш байх зарчимд харшлахгүй.

Олон улсын эрх зүй нь дээрх тусгай арга хэмжээ буюу зорилгодоо нийцсэн ухаалаг байх зарчим (principle of proportionality)-ыг бодитой, үндэслэл бүхий шаардлага бий болсон, тэдгээр нь бусад хүний эрхэд харшлахгүй байх тохиолдолд хэрэглэхийг хориглоогүй. Тиймээс, тусгай арга хэмжээ нь өөрөө ялгаварлан гадуурхлыг дэмжиж байвал тэдгээрийг хүлээн зөвшөөрөх боломжгүй, харин тэгш байдлыг үр дүнтэй хангах, зорилгодоо нийцсэн ухаалаг байх зарчимд нийцсэн тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх юм.

Зарим улсад үндэсний цөөнх нь “minimum representation” төлөөллөөр баталгаажсан байдаг. Тухайлбал, Словени Улсад Унгар, Итали үндэстнүүд Үндэсний Ассамблейд тус бүр нэг суудалтай байна. Румын Улсад парламентад суудал авах шаардлагатай саналын босгыг даваагүй үндэсний цөөнхөд хамаарах иргэдийн байгууллага тус бүр нэг суудал авах эрхтэй байдаг. Бельги, Итали улсууд сонгуулийн хууль тогтоомждоо герман хэлтэй цөөнхөд парламентад суудал хуваарилахаар зохицуулсан байна.

Боломжийн тэгш байдал

Тэгш саналын эрхийн зарчим нь намуудад суудал хуваарилахад хамаарахгүй, улмаар пропорциональ үр дүнд хүргэхийг чухалчилдаггүй ч боломжийн тэгш байдлыг хангах ёстой. Намын төлөөллийг аль болох багасгах зорилготой оролдлогууд, сонгуулийн тойргийг эрх баригчид өөрсдөө өөрт ашигтайгаар тогтоож ялах магадлалыг нэмэгдүүлэх улс төрийн бодлого нь боломжийн тэгш байдалд харшлах юм.

1.2.Процедурын баталгаа

Ил тод байдал

Сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг тогтоох үйл ажиллагааг хуулийн дагуу сонгууль явагдахаас доод тал нь нэг жилийн өмнө явуулах ёстой. Сонгуулийн тухай хуулийн бүх чухал зохицуулалтуудын нэгэн адил тойргийн нутаг дэвсгэрийг тогтоох үйл ажиллагаа нь холбогдох бүх оролцогч талуудын оролцоотойгоор, олон нийтийн өргөн хэлэлцүүлгийн

үндсэн дээр хийгдэх ёстой. Энэ нь оролцогч талууд болон сонгогчдын аль алинд нь хүлээн зөвшөөрөгдөх баталгаа болно.

Сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг тогтоох бие даасан, хараат бус байгууллагын эрх мэдлийг хязгаарлаж, өөрийн дур зоргоор эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх

Дур зоргоор эрх мэдлээ урвуулан ашиглахыг хязгаарлах хууль зүйн чухал хамгаалалт, хуулийн засаглалын баталгаа бол эрх мэдлийг урвуулан ашиглах боломжийг хязгаарлах эрх зүйн хязгаарлалт байдаг. Ийм зөрчлөөс урьдчилан сэргийлэх аргын нэг нь тойргийн нутаг дэвсгэрийг засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн хуваарилалттай уялдуулах явдал юм. Ингэхдээ газарзүйн болон түүхэн шалгуурыг харгалзан үзэж болох юм. Үүнээс гадна тойргийн нутаг дэвсгэрийн хил хязгаар тасраагүй байна.

1.3. Сонгуулийн тойргийн хэлбэр

Улс орнууд олон мандаттай, эсхүл нэг мандаттай сонгуулийн тойрог, эсхүл хоёуланг нь хослуулан ашигладаг.

Улсын нутаг дэвсгэр нэг сонгуулийн тойрог

Зарим улс улсын хэмжээний нэг тойрогтой бол зарим улс жижиг тойргуудтай хослуулдаг байна. Нидерланд Улс 150 мандаттай, Киргиз, Израил улсууд 120 мандаттай улсын хэмжээний нэг тойрогтой байна. Монако Улс нь 24 мандаттай улсын хэмжээний нэг тойрогтой. Монтенегро Улс нь улсын хэмжээний 81 мандат бүхий нэг тойрогтой. Серби Улс 250 мандат бүхий нэг тойрогтой байна. Сан-Марино, Словак улсууд тус бүр улсын хэмжээний нэг тойрогтой байна.

Зарим улсын хувьд зөвхөн тодорхой тооны мандатыг улсын хэмжээний тойрогт хуваарилдаг. Андорра Улс нь 14 мандаттай улсын хэмжээний тойргийг 2 мандаттай 7 тойрогтой хослуулдаг. Гүрж Улс нь 77 мандаттай улсын хэмжээний нэг тойрог, 73 нэг мандаттай тойргийн хослолыг ашигладаг. Унгар Улс 106 нэг мандаттай тойргийг 93 мандаттай улсын хэмжээний тойрогтой хослуулан ашигладаг. БНСУ нь 47 суудалтай улсын хэмжээний тойргийг 253 нэг мандаттай тойрогтой хослуулдаг. Литва Улс 70 мандаттай улсын хэмжээний тойрог, 71 нэг мандаттай тойрогтой. Марокко Улс нь 90 мандаттай улсын хэмжээний тойргийг 92 олон мандаттай тойрогтой хослуулдаг. Молдова Улс 2017 онд улсын хэмжээний нэг тойрог (51 суудал), нэг мандаттай 50 тойрог бүхий тогтолцоог нэвтрүүлсэн байна. Хоёр санал бүхий системээрээ алдартай ХБНГУ нь 299 нэг мандаттай тойргийг (Länder) намын жагсаалттай хослуулдаг.

Олон мандаттай тойрог

Ихэнх улс орнууд зөвхөн олон мандаттай тойрог ашигладаг. Энэ нь ихэвчлэн засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн хуваарилалттай давхацдаг. Ийнхүү давхацсан олон мандаттай тойргийг ашиглахын давуу тал нь тойрогт суудал хуваарилах боломжтой тул тойргийг дахин хуваарилах хэрэгцээг бууруулдаг явдал юм. Харин олон мандаттай тойргууд нь хэмжээний хувьд ялгаатай байж болзошгүй.

Ихэнх улс орнуудын сонгуулийн тойрог нь холбооны, бүс нутгийн болон орон нутгийн бусад хуваарилалттай тохирч байдаг. Тухайлбал, Албани Улс парламентын 140 гишүүнийг 12 тойргоос сонгодог. Сонгуулийн тойргийн нутаг дэвсгэр нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй давхацдаг. Австри Улс нь тус бүр 7-37 мандаттай 9 тойрогтой ба тойргийн нутаг дэвсгэр нь тус улсын мужуудтай давхацдаг. Бразил Улсын муж, нутаг дэвсгэр, холбооны дүүрэг бүр 8-70 мандаттай сонгуулийн тойрогтой байна. Бельги Улс нь тус бүр 4-24 мандаттай 11 тойрогтой бөгөөд мужууд болон Брюссель хотын засаг захиргааны нэгжид

хуваарилагддаг. Болгар Улс 240 мандатыг 31 сонгуулийн тойрогт хуваадаг. Сонгуулийн тойргийн гурав нь нийслэл Софи хотод, хоёр нь Пловдив мужийн засаг захиргааны нэгжид оногддог. Үлдсэн тойрог нь одоо байгаа засаг захиргааны бүсүүдтэй давхцадаг байна. Финланд Улсад сонгуулийн тойргийг мужууд, хотын захиргаанд тулгуурлан хуваарилагддаг. Норвеги Улс олон мандаттай 19 тойрогтой бөгөөд эдгээр нь тойргуудтай давхцадаг. Португал Улсын эх газрын хувьд сонгуулийн тойргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй нийцүүлэн хуваарилдаг. Эдгээр тойргоос гадна Мадейра автономит мужийн тойрог, Азорын автономит мужийн тойрог байдаг. Мөн гадаадад амьдардаг сонгогчид хоёр тойрогт хуваагддаг, нэг хэсэг нь Европын орнуудын нутаг дэвсгэр, нөгөө нь үлдсэн улсууд болон Макао төлөөлдөг байна. Румын Улс нь нийт 43 сонгуулийн тойрогтой үүнээс 41 засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуваарилагддаг, мөн нийслэл Бухарест хот, болон гадаадад амьдардаг румынчуудыг төлөөлөх тус бүр нэг сонгуулийн тойрогтой байна.

Бусад улс орнууд олон мандаттай тусгай тойргуудтай бөгөөд тэдгээр нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй уялддаггүй байна. Энэ нь нэг тойрог ногдох суудлын тоо тогтмол байх үед энэ нь зайлшгүй юм. Тухайлбал, Македон Улсын хууль тогтоомжоор улс доторх 6 сонгуулийн тойргоос тус бүр 20 гишүүнийг сонгох бол, 1 тойрог 3 мандаттай байх ба гадаадад амьдарч байгаа сонгогчдыг төлөөлнө. Сонгуулийн тойрог нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй уялддаггүй бусад улс орнуудын тоонд Исланд Улс багтах бөгөөд 10-11 мандаттай 6 тойрогтой; Мальта Улсын Үндсэн хуульд 9-15 тойрогтой байхаар заасан бөгөөд тойргийн тоо сондгой тоо байх болно гэж заасан. Нэг тойрог ногдох мандатын тоог хуулиар тогтооно.

Хорват Улс нь тус бүр 10 суудал бүхий 14 олон мандаттай тойрог байдаг бөгөөд тус улсаас гадуур амьдардаг сонгогчдын 3 суудал бүхий 1 олон мандаттай тойрог, үндэсний цөөнхийн төлөөлөх 8 суудал бүхий 1 тойрогтой. Дани Улсын Үндсэн хуульд заасны дагуу 10 суудал бүхий олон мандаттай 10 тойрогтой байх ба Фарерын арлууд болон Гренландаас тус бүр хоёр мандаттай 2 тойрог байхаар заасан байдаг бөгөөд зөрүүг нөхөх 40 суудалтай байна.

Нэг тойрог-нэг мандат

Венецийн Комиссын гишүүн орнуудын дотор сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг хуваарилахад нэг тойрог-нэг мандатыг сонгосон улс цөөхөн байдаг. Нэг тойрог-нэг мандатыг хэрэглэж буй улс орнуудын хамгийн тод жишээ бол тус бүр нэг мандаттай 650 тойрогтой ИБУИНХУ ба Англи (533), Шотланд (59), Уэльс (40), Умард Ирланд (18)-д мандат ногддог байна. Франц Улсын Үндэсний Ассамблей тус бүр нэг мандат бүхий 577 тойрогтой. Азербайжан Улс тус бүр нэг мандаттай 125 тойрогтой байна.

Тусгай тойргууд

Зарим улс орнууд гадаадад амьдарч буй сонгогчдод зориулж тусгай тойргийг хуваарилдаг. Хорват, Португал улсууд нь гадаадад амьдардаг сонгогчдод зориулсан тусгай тойргийг ашигладаг. Итали Улс нь гадаадад амьдардаг Италичуудын төлөөллийг хангахад зориулсан 12 мандат бүхий тойрогтой бол, Франц Улс нэг мандат бүхий 11 тойрогтой байна.

Улсын нутаг дэвсгэрээс гадуур амьдарч байгаа иргэдийг сонгуульд оролцуулахад тусгайлан тойрогтой байх тохиромжтой эсэхтэй холбоотой хэд хэдэн асуудал гардаг. Тухайлбал, ИБУИНХУ-ын хувьд гадаадад оршин суугаа иргэд ИБУИНХУ-д оршин сууж байсан газрын хаягийн бүртгэлээр тодорхой жилийн хугацаанд санал өгөх боломжтой бөгөөд ингэснээр тусгай тойрогт хуваарилах шаардлага үүсдэггүй байна.

Тусгай тойрог хуваарилах өөр нэг шалтгаан бол тодорхой цөөнхийн, эсхүл нутаг дэвсгэрийн асуудалтай холбоотой юм. Тухайлбал, Хорват Улс цөөнхийн төлөөллийг хангахад зориулсан тойрогтой бол Дани Улсын Фарерын арлууд болон Гренландад тусгай мандат

олгодог. Словени Улс нь Итали, Унгарын цөөнхөд зориулсан тусгай тойргийг ашигладаг. Финланд Улсад парламентын нэг гишүүн Аландын арлуудыг төлөөлдөг.

Зарим нутаг дэвсгэр нь төрийн хяналтаас гадуур байх үед тодорхой асуудлууд үүсдэг бөгөөд үүнд сонгуулийн компани ажил зэрэг сонгуультай холбоотой үйл ажиллагаа, санал өгөх, санал тоолох зэрэг ажлыг гүйцэтгэхэд асуудал үүсэж болзошгүй байна. Ийм нутаг дэвсгэрт сонгуулийн тойрог байгуулах нь тодорхой шалгуурт үндэслэсэн байх ёстой.

Хоёр. ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГ, МАНДАТЫН ТООГ ТОГТООХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ШАЛГУУР: ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ (НЭГ ТАНХИМТАЙ) ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны энэ хэсэгт парламентын засаглалтай 42 орны нэг танхимтай парламентын гишүүд (мандат)-ийн тоо, парламентын сонгуулийн тойргийг хэрхэн тогтоодог талаарх Үндсэн хуулийн болон Сонгуулийн тухай хуулийн зохицуулалтыг авч үзсэн болно.

2.1. Парламентын гишүүдийн тоо

Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (ПССХ)-ээс 2022 онд гүйцэтгэсэн “Дэлхийн улс орнуудын хууль тогтоох байгууллагын бүрэлдэхүүн” судалгаанд дэлхийн 191 улсыг хамруулсан бөгөөд тухайн улсын хүн амын тоог парламентын гишүүний тоонд (үүнд нэг танхимтай парламентын гишүүдийн тоо, хоёр танхимтай парламентын хувьд доод танхимын гишүүдийн тоог баримтлан) харьцуулан гаргасан юм.

Хүн ам цөөнтэй арлын улс орнуудын парламентын гишүүд нь 1000 хүрэхгүй иргэд төлөөлөх тохиолдлууд байхад, хүн ам ихтэй Энэтхэг (2.532.118), АНУ (760.925), Пакистан (645.884), Нигери (572.609) зэрэг орны парламентын гишүүн нь хамгийн олон иргэнийг төлөөлөн ажилладаг байна.

Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоог авч үзвэл нийт улс орнуудын 66 нь буюу 34.7 хувь нь 100.001-ээс дээш иргэнийг төлөөлөн ажиллаж байна. Парламентын нэг гишүүн нь 40.001-60.000 иргэнийг төлөөлж буй 19 улс байна. Монгол Улсын Их Хурлын нэг гишүүн нь 44.178 иргэнийг төлөөлж дээрх хэсэгт багтаж байна.

Монгол Улстай хүн амын тоогоороо ойролцоо (2-5 сая хүн амтай), парламентын засаглалтай 14 улсын парламентын нэг ба хоёр танхимыг авч үзэхэд, 3-5 сая хүн амтай, дунджаар 40.5 мянган иргэнийг төлөөлж буй 7 улс, 2-3 сая хүн амтай, дунджаар 27.0 мянган иргэнийг төлөөлж буй 7 улс байна.

Хүснэгт 1. Хоёроос таван сая хүн амтай, парламентын засаглалтай орнуудын парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо

Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо /дунджаар/	Улсын тоо	Хүн амын тоо	Улсын нэр
40.5 мянга	7	3-5 сая хүртэл	Босни-Херцеговин, Гүрж, Ирланд, Молдова, Шинэ Зеланд, Хорват
27.0 мянга	7	2-3 сая хүртэл	Албани, Армени, Ботсван, Лесото, Словени, Умард Македон, Ямайка

Эх сурвалж: Улсын Их Хурлын Тамгын газрын ПССХ, 2022 он.

Монгол Улстай хүн амын тоогоороо ойролцоо бөгөөд парламентын засаглалтай, парламентын нэг танхимтай хоёр орныг авч үзэхэд, 2963243 хүн амтай Армени Улсын Үндэсний Ассамблей 107 гишүүнтэй бөгөөд нэг гишүүн нь 27693 иргэнийг, мөн 3989167 хүн амтай Гүрж Улсын Парламентад 150 гишүүнтэй бөгөөд нэг гишүүн нь 26594 иргэнийг тус тус төлөөлж байна.

Хүснэгт 2. Парламентын засаглалтай орнуудын (нэг танхимтай) парламентын гишүүд, хүн амын тоонд харьцуулсан байдал

№	Улсын нэр	Танхимын нэр, гишүүдийн тоо ²⁶	Хүн амын тоо ²⁷	Парламентын нэг гишүүний төлөөлж буй хүн амын тоо	
1	Тувалу	Парламент	16	11792	737
2	Сан-Марино	Ерөнхий Зөвлөл	60	33931	565
3	Лихтенштайн	Диет	25	38128	1525
4	Монако	Үндэсний Зөвлөл	24	39242	1635
5	Сент-Китс ба Невис	Үндэсний Ассамблей	16	53199	3324
6	Доминик	Ассамблейн танхим	32	71986	2250
7	Андорра	Ерөнхий Зөвлөл	28	77265	2759
8	Сент-Винсент ба Гренадин	Ассамблейн танхим	22	110940	5042
9	Кирибати	Ассамблей	45	119449	2654
10	Самоа	Хууль тогтоох Ассамблей	51	198414	3890
11	Вануату	Парламент	52	307145	5906
12	Исланд	Парламент	63	341243	5416
13	Мальта	Төлөөлөгчдийн танхим	65	441543	6792
14	Кабо-Верде	Үндэсний Ассамблей	72	555987	7722
15	Люксембург	Депутатуудын танхим	60	625978	10.432
16	Соломоны арлууд	Үндэсний Парламент	50	686884	13.737
17	Фижи	Парламент	51	896445	17.577
18	Маврики	Үндэсний Ассамблей	70	1271768	18.168
19	Зүүн Тимор	Үндэсний Парламент	65	1318445	20.283
20	Эстони	Парламент	101	1326535	13.134
21	Латви	Парламент	100	1886198	18.861
22	Македон	Ассамблей	123	2083374	16.938
23	Ботсван	Үндэсний Ассамблей	65	2351627	36.178
24	Албани	Парламент	140	2877797	20.555
25	Армени	Үндэсний Ассамблей	107	2963243	27.693
26	Монгол	Улсын Их Хурал	76	3357528	44.178
27	Гүрж	Парламент	150	3989167	26.594
28	Молдова	Парламент	101	4033963	39.940
29	Хорват	Парламент	151	4105267	27.187
30	Шинэ Зеланд	Төлөөлөгчдийн танхим	120	4822233	40.185
31	Норвег	Парламент	169	5421241	32.078

²⁶ https://data.ipu.org/compare?field=chamber%3A%3Afield_statutory_members_number&structure=any__lower_chamber#map

²⁷ <https://www.worldometers.info/world-population/population-by-country/>

32	Словак	Үндэсний Зөвлөл	150	5459642	36.397
33	Финланд	Парламент	200	5540720	27.703
34	Дани	Парламент	179	5792202	32.358
35	Болгар	Үндэсний Ассамблей	240	6948445	28.951
36	Израил	Кнессет	120	8655535	72.129
37	Серби	Үндэсний Ассамблей	250	8737371	34.949
38	Папуа- Шинэ Гвиней	Үндэсний Парламент	111	8947024	82.153
39	Унгар	Үндэсний Ассамблей	199	9660351	48.544
40	Швед	Парламент	349	10099265	28.937
41	Португал	Бүгд Найрамдах Улсын Ассамблей	230	10196709	44.333
42	Грек	Парламент	300	10423054	34.743
43	Ирак	Төлөөлөгчдийн зөвлөл	329	40222493	122.256
44	Бангладеш	Парламент	350	164689383	470.541

Эх сурвалж: Улсын Их Хурлын Тамгын газрын ПССХ, 2022 он.


2.2. Сонгуулийн тойргийг тогтоох

Судалгааг сонгуулийн мэдээллийн интерактив мэдлэгийн систем болох Сонгуулийн мэдлэгийн сүлжээ (ACE–Electoral Knowledge Network, www.aceproject.org)-ний харьцуулсан мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэсэн. Энэхүү харьцуулсан мэдээлэл нь дэлхийн 200 гаруй улс, 11 сэдвийн статистик болон сонгуультай холбоотой мэдээллийн системчилсэн юм.

Сонгуулийн зорилгоор тойргийн хилийн цэсийг тусгайлан тогтоодог эсэх

Сонгуулийн мэдлэгийн сүлжээний харьцуулсан мэдээллээс харахад, дэлхийн нийт 200 улсын 163 буюу 71 хувь нь сонгуулийн зорилгоор тойргийн хилийн цэсийг тусгайлан тогтоодог, 54 буюу 23 хувь нь тусгайлан тогтоодоггүй байна. Харин 12 улс (4 хувь)-ын мэдээлэл байхгүй байна.²⁸

Зураг 1. Дэлхийн улсуудад сонгуулийн зорилгоор тойргийн хилийн цэсийг тусгайлан тогтоодог эсэх



Эх сурвалж: www.aceproject.org

²⁸ ACE Electoral Knowledge Network – <https://aceproject.org/epic-en/>

Үүнээс энэ судалгаанд авагдсан парламентын засаглалтай нийт 42 орны 27 буюу 64.3 хувь нь сонгуулийн зорилгоор тойргийн хилийн цэсийг тусгайлан тогтоодог, 12 буюу 28.6 хувь тусгайлан тогтоодоггүй байна.

Хүснэгт 3. Сонгуулийн зорилгоор тойргийн хилийн цэсийг тусгайлан тогтоодог эсэх

Сонгуулийн зорилгоор тойргийн хилийн цэсийг тусгайлан тогтоодог эсэх	Улсын тоо	Улсын нэр
Тусгайлан тогтоодог	27	Албани, Андорра, Армени, Бангладеш, Болгар, Ботсвана, Вануату, Грек, Гүрж, Доминика, Исланд, Кирибати, Латви, Лихтенштайн, Люксембург, Македон, Монгол, Папуа Шинэ Гвиней, Самоа, Сент-Винсент ба Гренадин, Сент-Китс ба Невис, Словак, Соломоны арлууд, Тувалу, Унгар, Хорват, Швед, Шинэ Зеланд
Тусгайлан тогтоодоггүй	12	Дани, Зүүн Тимор, Ирак, Маврики, Македон, Молдова, Норвеги, Португал, Сан-Марино, Серби, Фижи, Финланд
Мэдээлэл байхгүй	3	Израил, Монако, Эстони

Эх сурвалж: www.aceproject.org

2.3. Сонгуулийн тойргийн хилийн цэсийг тогтоох шалгуур

Дэлхийн улсууд сонгуулийн тойргийн хилийн цэсийг тодорхой шалгуураар тогтоодог байна. Эдгээр шалгуурыг ихэвчлэн сонгуулийн хуульд заасан байдаг ч заримдаа тухайн улсын үндсэн хуульд заасан байдаг.

Эрх зүйн зохицуулалтад сонгуулийн тойргийг тогтоохдоо аль болох хүн амын тоог харгалзах буюу “хүн амын “тэгш байдал”-ыг хангах”-ад ихээхэн анхаардаг байна. Орон нутгийн хилийн цэс, газарзүйн онцлог, хүн ам нягтаршил, мөн тусгаарлагдсан нутаг дэвсгэр зэрэг газарзүйн бусад онцлогоос гадна ашиг сонирхлын бүлгүүдийг хүндэтгэх зэргийг шалгуур болгож байна. Зарим орнуудад, ялангуяа, хөгжиж буй орнуудад тээврийн, харилцаа холбооны хүчин чадлыг мөн анхаарч үзэхийг хүсдэг байна.²⁹

Сонгуулийн мэдлэгийн сүлжээний дэлхийн нийт 200 улсын харьцуулсан мэдээлэлд сонгуулийн тойргийн хилийн цэсийг тогтооход дараах шалгуураар харьцуулж, дүнг оруулсан байна.³⁰ Үүнд:

- а. Хүн амын "тэгш байдал"-ыг хангах - 119 буюу 52 хувь;
- б. Газарзүй, байгалийн онцлогийг харгалзах - 53 буюу 23 хувь;
- в. Тойргийн нягтаршил³¹ - 24 буюу 10 хувь;

²⁹ ACE Electoral Knowledge Network – <https://aceproject.org/ace-en/topics/bd/bdb/bdb01/bdb01a>


³⁰ ACE Electoral Knowledge Network – <https://aceproject.org/epic-en/>

³¹ Тойргийн газарзүйн хэмжээ ба хэлбэрт тавигдах шалгуур

Тойргийг хуваарилахад баримтлах хоёр хүчин зүйл нь тойргийн газарзүйн хэлбэртэй холбоотой нэгдмэл байдал болон нягтшил юм. Дүүргийн нутаг дэвсгэр нь янз бүрийн хэлбэртэй бус, хоорондоо ижил буюу ижил төстэй байхыг шаарддаг байна. Тухайлбал, Мексик Улсын Сонгуулийн хороо нь сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг тэгш өнцөгт хэлбэртэйгээр тогтоосон байна. Тойргийн нутаг дэвсгэр газарзүйн хувьд ижил байхыг шаарддаг орнууд, тухайлбал, Албани, Армени, Бангладеш, Барбадос, Беларусь, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Энэтхэг, Итали, Пакистан болон АНУ байна.

- г.Орон нутгийн хилийн цэсийг баримтлах - 109 буюу 47 хувь;
- д.Дүүргийн газарзүйн хэмжээг харгалзах - 40 буюу 17 хувь;
- е.Нэгдмэл сонирхлын бүлэг/соёлын асуудлыг харгалзах - 38 буюу 16 хувь;
- ё.Бусад - 65 буюу 28 хувь;
- ж.Мэдээлэл байхгүй - 43 буюу 18 хувь;

Зураг 2. Дэлхийн улсуудад сонгуулийн тойргийн хилийн цэсийг тогтооход тавих шалгуурууд



Эх сурвалж: www.aceproject.org

Үүнээс энэ судалгаанд авагдсан парламентын засаглалтай нийт 42 орны сонгуулийн тойргийн хилийн цэсийг тогтооход тавих шалгууруудыг хамгийн олон давтамжтай хэрэглэсэн үзүүлэлтээр ангилбал (Хүснэгт 2.):

- г.Орон нутгийн хилийн цэсийг баримтлах - 22 буюу 51.2 хувь;
- а.Хүн амын "тэгш байдал"-ыг хангах - 21 буюу 48.8 хувь;
- ё.Бусад - 17 буюу 39.5 хувь;
- б.Газарзүй, байгалийн онцлогийг харгалзах - 6 буюу 14.0 хувь;
- е.Нэгдмэл сонирхлын бүлэг/соёлын асуудлыг харгалзах - 6 буюу 14.0 хувь;
- д.Дүүргийн газарзүйн хэмжээг харгалзах - 5 буюу 11.6 хувь;
- в.Тойргийн нягтаршил - 1 буюу 2.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Сонгуулийн тойргийн хилийн цэсийг тогтоох шалгуур

№	Улсын нэр	а.Хүн амын "тэгш байдал"-ыг хангах	б.Газарзүй, байгалийн онцлогийг харгалзах	в.Тойргийн нягтаршил	г.Орон нутгийн хилийн цэсийг баримтлах	д.Дургийн газарзүйн хэмжээг харгалзах	е.Нэгдмэл сонцрхлын бүлэг/соёлын асуудлыг харгалзах	ё.Бусад	ж.Мэдээлэл байхгүй	НИЙТ
1	Албани	+	+		+			+		4
2	Андорра	+						+		2
3	Армени				+					1
4	Бангладеш	+			+					2
5	Болгар	+			+					2
6	Ботсвана	+			+	+	+	+		5
7	Вануату							+		1
8	Грек				+					1
9	Гүрж				+					1
10	Дани				+			+		2
11	Доминика	+			+	+		+		4
12	Израил								+	1
13	Ирак				+					1
14	Исланд	+								1
15	Кирибати	+	+							2
16	Латви					+		+		2
17	Лихтенштайн								+	1
18	Люксембург				+					1
19	Маврики	+	+	+	+	+		+		6
20	Македон				+					1
21	Мальта	+						+		2
22	Молдова							+		1
23	Монако								+	1
24	Монгол	+			+	+		+		4
25	Норвег				+					1
26	Папуа Шинэ Гвиней	+			+					2
27	Португал				+					1
28	Самоа	+			+		+			3
29	Сан-Марино								+	1
30	Сент-Винсент ба Гренадин	+						+		2
31	Сент-Китс ба Невис								+	1
32	Серби								+	1
33	Словак	+						+		2
34	Соломоны арлууд	+					+	+		3
35	Тувалу	+	+		+		+	+		5
36	Унгар	+			+		+	+		4
37	Фижи								+	1
38	Финланд				+					1
39	Хорват	+			+					2

40	Швед	+	+							2
41	Шинэ Зеланд	+	+				+	+		4
42	Эстони								+	1
	ДҮН	21	6	1	22	5	6	17	8	

Эх сурвалж: www.aceproject.org

Тойргийн хилийг тогтоодог 7 шалгуур үзүүлэлтээс хамгийн олон шалгуурыг Маврики (6-а,б,в,г,д,ё), Тувалу (5-а,б,г,е,ё), Унгар (4-а,г,е,ё) зэрэг улсууд тавьсан байна.

Дээр дурдсан 7 шалгуур үзүүлэлтээс хүн амын тэгш байдал болон орон нутгийн хил гэсэн 2 шалгуурыг баримталдаг 12 улс (Албани, Бангладеш, Болгар, Ботсвана, Доминика, Монгол, Папуа Шинэ Гвиней, Самоа, Тувалу, Унгар, Хорват, Швед) байна.

Хүн амын тэгш байдлыг хангах шалгуурыг баримталдаг 8 улс (Андорра, Исланд, Кирибати, Мальта, Сент-Винсент ба Гренадин, Словак, Соломоны арлууд, Шинэ Зеланд), орон нутгийн хилийг баримталдаг 10 улс (Армени, Грек, Гүрж, Дани, Ирак, Люксембург, Македон, Норвеги, Португал, Финланд), нэгдмэл сонирхлын бүлэг/соёлын асуудлын шалгуурыг баримталдаг 6 улс (Ботсвана, Самоа, Соломоны арлууд, Тувалу, Унгар, Шинэ Зеланд), газарзүй, байгалийн онцлогийг харгалздаг 5 улс (Албани, Кирибати, Тувалу, Шинэ Зеланд), дүүргийн газарзүйн хэмжээг баримталдаг 4 улс (Ботсвана, Доминика, Латви, Монгол) байна.

Хүснэгт 5. Үндсэн хууль болон Парламентын сонгуулийн тухай хууль дахь ишүүдийн тоо, сонгуулийн тойрог тогтоохтой холбоотой зохицуулалтууд

№	Улсын нэр	Хуулийн зохицуулалт
1	Албани	<p align="center">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>64.Ассамблей нь олон мандаттай сонгуулийн тойргоос пропорционал тогтолцоогоор сонгогдсон 140 депутатаас бүрддэг.</p> <p>Сонгуулийн тойрог нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууллагын аль нэг түвшний нэгжтэй нийцүүлнэ.</p> <p>Сонгуулийн пропорционал тогтолцоог хэрэгжүүлэх, сонгуулийн тойрог болон сонгуулийн тойрог бүрд мандатын тоог тогтоох шалгуур, журмыг Сонгуулийн тухай хуулиар тогтооно.</p> <p><i>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Albania_2016?lang=en</i></p> <p align="center">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>27 дугаар зүйл. Сонгуулийн тойрог</p> <p>1.Бүх төрлийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг явуулахад энэ Үндсэн хуулийн дагуу сонгуулийн тойргийг байгуулна.</p> <p>2.Сонгуулийн тойргийн нутаг дэвсгэр нь Бүгд Найрамдах Албани Улсын засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн тухай хуулийн дагуу засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэртэй давхцана. 80.000-аас дээш санал өгөх эрх бүхий иргэнтэй засаг захиргааны нэгжийг Сонгуулийн төв хороо дараах шалгуураар нэгээс олон сонгуулийн тойрогт хуваана:</p> <p>а) 80.000-аас дээш сонгогчтой засаг захиргааны нэгжээс бусад засаг захиргааны нэгжийг хуваахгүй байх;</p> <p>б) газарзүйн саад бэрхшээлээс зайлсхийхийн зэрэгцээ нутаг дэвсгэр нь хилийн цэсийн хувьд давхцсан, цомхон (compactness) байх;</p> <p>в) нутаг дэвсгэр дотор саадгүй тээвэрлэлт (transportation) хийх боломжтой байх;</p> <p>г) сонгогчдын тооны хувьд ойролцоо байх.</p> <p>74 дүгээр зүйл. Ассамблейн сонгуулийн тойрог</p>

		<p>1. Сонгуулийн тойрог нь тухайн засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт нийцсэн байх ба энэ хуульд заасан журмын дагуу тодорхой тооны мандат сонгох сонгуулийн хэсэг юм.</p> <p>2. Засаг захиргааны нэгжийн хилийн цэсийг Бүгд Найрамдах Албани Улсын засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн тухай хуулиар тогтооно.</p> <p>75 дугаар зүйл. Мандатын тоог тогтоох шалгуур, журам</p> <p>1. Сонгуулийн тойрог тус бүрийн мандатын тоог тухайн тойргийн иргэдийн тоотой тэнцүү тогтооно. Мандат бүр ойролцоогоор тэнцүү тооны иргэдийг төлөөлнө.</p> <p>2. Иргэний улсын бүртгэлийн мэдээнд байгаа нийт иргэдийн тоог 140 буюу Ассамблейн суудлын тоонд хувааж, нэг суудалд ногдох иргэдийн дундаж тоог тодорхойлно.</p> <p>3. Тойрогт оршин сууж байгаа иргэдийн тоог энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон дундаж тоонд хувааж, тойрог тус бүрийн мандатын тоог тодорхойлно.</p> <p>4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тойрог бүрд хуваасны дүнд авсан нийт тоотой тэнцэх мандатын тоог эхний ээлжид хуваарилна.</p> <p>5. Хэрэв энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хийсэн тооллогын эцэст нэг буюу хэд хэдэн мандат хуваарилагдаагүй бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хуваалтаас авсан хамгийн их бутархайн үлдэгдлийг үндэслэн тойргуудад хуваарилна. Үлдсэн мандатын хуваарилалтыг хамгийн их аравтын бутархай тэнцэл бүхий тойргоос эхэлж буурах дарааллаар хэрэгжүүлнэ.</p> <p>6. Хэрэв энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлсний дараа хоёр ба түүнээс дээш тойргийн аравтын тоо ижил байвал, энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан тооцооны дагуу бүрэн эрхээ бүрдүүлж чадаагүй үлдсэн хамгийн олон иргэнтэй тойрогт үлдсэн мандатыг олгоно.</p> <p>7. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасныг хэрэглэсэн ч сонгуулийн хоёр ба түүнээс дээш тойрогт бүрэн суудал авч чадаагүй ижил тооны иргэн байвал мандатын эрхийг Сонгуулийн төв хороо сугалаагаар олгоно. Сугалааны тохирол нь үргэлж нээлттэй байх бөгөөд тохирлыг Сонгуулийн төв хороонд байнгын төлөөлөгчтэй субъектүүдийг байлцуулан явуулна.</p> <p>Эх сурвалж: <i>Electoral Code of Albania – https://www.osce.org/files/f/documents/5/7/477547_0.pdf</i></p>
2	Андорра	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>50. Улсын болон 7 нийгэмлэг (parishes)-ийн хүн амын холимог ба пропорционал төлөөллийг төлөөлдөг Ерөнхий зөвлөл (Парламент) нь Андорра Улсын ард түмнийг төлөөлөх, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх, улсын төсвийг батлах, Засгийн газрын улс төрийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, хяналт тавина.</p> <p>52. Ерөнхий зөвлөл доод тал нь 28, дээд тал нь 42 Ерөнхий зөвлөхүүд (Consellers Generals)-ээс бүрдэх бөгөөд тэдгээрийн тал нь 7 нийгэмлэгээс тэнцүү тоогоор сонгогдоно, үлдсэн тал нь улсын нэг тойргоос сонгогдоно.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Andorra_1993?lang=en</p>
3	Армени	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>89 дүгээр зүйл. Үндэсний Ассамблейн бүрэлдэхүүн, сонгуулийн журам</p> <p>1. Үндэсний Ассамблей 101-ээс доошгүй гишүүнээс бүрдэнэ.</p> <p>2. Сонгуулийн тухай хуульд заасан журмын дагуу Үндэсний Ассамблейн суудлыг үндэсний цөөнхийн төлөөлөгчдөд хуваарилна.</p> <p>3. Үндэсний Ассамблей нь сонгуулийн пропорционал тогтолцоогоор сонгогдоно. Парламент дахь олонхыг тогтвортой бүрдүүлэх баталгааг Сонгуулийн тухай хуулиар баталгаажуулна. Хэрэв сонгуулийн үр дүнд буюу улс төрийн эвсэл байгуулах замаар парламент дахь тогтвортой олонх бүрдээгүй бол хоёр дахь шатны сонгууль явуулж болно. Хоёр дахь шатны сонгууль явагдах бол шинээр эвсэл байгуулахыг зөвшөөрнө. Улс</p>

		<p>төрийн эвсэл байгуулах хязгаарлалт, нөхцөл, журмыг Сонгуулийн тухай хуулиар тогтооно.</p> <p>Эх сурвалж: https://www.president.am/en/constitution-2015/</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p style="text-align: center;">77 дугаар зүйл. Сонгуулийн тогтолцоо</p> <p>1. Үндэсний Ассамблейн сонгуулийг пропорционал тогтолцооны дагуу, улс төрийн намуудын улсын болон дүүргийн сонгуулийн жагсаалтад нэр дэвшигчдээс Бүгд Найрамдах Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан олон мандаттай нэг тойрогт явуулна.</p> <p style="text-align: center;">78 дугаар зүйл. Сонгуулийн тойрог</p> <p>1. Бүгд Найрамдах Армени Улсад Үндэсний Ассамблейн сонгуулийн үеэр 13 тойрог байгуулагдана: тэдний 4 нь Ереван хотод, 9 нь мужууд (marzes)-д байгуулагдана.</p> <p>2. Ереван хотын нутаг дэвсгэрт сонгуулийн 4 тойрог байгуулагдана: Аван, Нор Норк, Канакер-Зейтун засаг захиргааны дүүргүүдийг 1 дүгээр сонгуулийн тойрогт, Арабкир, Ачапняк, Давиташен засаг захиргааны дүүргүүдийг 2 дугаар сонгуулийн тойрогт, Малатиа-Себастья, Шенгавит засаг захиргааны дүүргүүдийг 3 дугаар сонгуулийн тойрогт, Кентрон, Норк-Мараш, Эребуни, Нубарашен засаг захиргааны дүүргүүдийг 4 дүгээр тойрогт тус тус байгуулагдана.</p> <p>3. Мужуудын нутаг дэвсгэрт сонгуулийн 9 тойрог байгуулагдана: Армавирск, Арагацотнск, Гегаркуниск, Лорийск, Котайкск, Ширакск, Сюникск, Вайоцзорск болон Тавушский мужуудад тус тус байгуулагдана.</p> <p>Эх сурвалж: https://www.translation-centre.am/pdf/Translat/HH_Codes/Electoral_Code_04052018_en.pdf</p>
4	Бангладеш	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p style="text-align: center;">65 дугаар зүйл. Парламентыг байгуулах</p> <p>2. Парламент нь хуулийн дагуу сонгуулийн нэг тойргоос шууд сонгогдох 300 гишүүнээс бүрдэнэ.</p> <p style="text-align: center;">119 дүгээр зүйл. Сонгуулийн хорооны чиг үүрэг</p> <p>1. Сонгуулийн хороо нь энэ Үндсэн хууль болон бусад хуулийн дагуу Ерөнхийлөгчийн болон Парламентын сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргах, эдгээр сонгуулийг явуулахад удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллана:</p> <p>(б) Парламентын гишүүдийн сонгуулийг явуулах;</p> <p>(в) Парламентын сонгуулийн зорилгоор тойргийн хилийг тогтоох;</p> <p style="text-align: center;">121 дүгээр зүйл. Тойрог бүрд сонгуулийн нэрсийн нэг жагсаалт</p> <p>Парламентын сонгуулийн зорилгоор тойрог бүрд сонгогчийн нэрсийн нэг жагсаалт байх бөгөөд сонгогчдыг шашин шүтлэг, арьсны өнгө, бүлэг (caste), хүйсээр нь ангилах тусгайлан нэрийн жагсаалт гаргахгүй.</p> <p>Эх сурвалж: – http://bdlaws.minlaw.gov.bd/act-367.html</p>
5	Болгар	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>63. Үндэсний Ассамблей 240 гишүүнээс бүрдэнэ.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Bulgaria_2015?lang=en</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p style="text-align: center;">7 дугаар зүйл. Сонгуулийн тойргийн төрлүүд</p> <p>(1) Сонгууль явуулахын тулд улсын нутаг дэвсгэрийг сонгуулийн тойрогт хуваана.</p> <p>(2) Сонгуулийн тойрог гэдэг нь ард түмний төлөөлөгчид, Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Болгарын Евро-парламентын гишүүд, хотын зөвлөлийн гишүүд, хотын дарга нар сонгогддог нутаг дэвсгэр юм.</p>

		<p>(3) Сонгуулийн тойрог нь нэг, эсхүл олон мандаттай байна.</p> <p>(4) Нэр дэвшигчдийн ижил жагсаалтаас нэг нэр дэвшигч, эсхүл нэг хос нэр дэвшигч (one pair of candidates) сонгогдсон бол тухайн сонгуулийн тойрог нь нэг мандаттай байна.</p> <p>(5) Нэр дэвшигчийн жагсаалтаас хоёр ба түүнээс дээш нэр дэвшигч сонгогдсон бол тухайн сонгуулийн тойрог нь олон мандаттай байна.</p> <p>246 дугаар зүйл. Сонгуулийн пропорционал тогтолцоо</p> <p>(1) Ард түмний төлөөлөгчдийн сонгуулийг олон мандаттай тойрогт бүртгүүлсэн нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаар сонгуулийн пропорционал тогтолцоогоор явуулна:</p> <ol style="list-style-type: none"> 1. нам, эвсэл; 2. санаачлагч хороо (инициативные комитеты). <p>247 дугаар зүйл. Сонгуулийн төв хорооны бүрэн эрх</p> <p>Сонгуулийн төв хороо нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үндэсний статистикийн институтын хамгийн сүүлийн хүн амын тооллогын дүнг үндэслэж хүн амын тооноос хамааруулан улсын хэмжээнд төлөөллийн нэг хувийн коэффициентээр олон мандаттай тойргийн мандатын тоог тогтоох; <p>249 дүгээр зүйл. Сонгуулийн тойргийг тогтоох</p> <p>(1) Сонгууль явуулахын тулд улсын нутаг дэвсгэрийг олон мандаттай 31 тойрогт, тэр дундаа Софи мужийг 3 тойрогт, Пловдив мужийг 2 тойрогт хуваана. Бусад сонгуулийн тойргийн хилийн цэс нь мужийн хилийн цэстэй давхацсан байна.</p> <p>250 дугаар зүйл. Мандатын тоог тогтоох</p> <p>(1) Сонгуулийн төв хороо Урлагийн дагуу олон мандаттай тойрог тус бүрийн мандатын тоог тогтооно. 247 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сонгуулийн өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө балансын хамгийн том аргыг ашиглан.</p> <p>Сонгуулийн төв хороо нь сонгуулийн санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 247 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу олон мандаттай тойрог тус бүрийн мандатын тоог хамгийн их үлдэгдлийн аргаар тогтооно.</p> <p>(2) Олон мандаттай тойргийн мандатын тоо 4-өөс бага байж болохгүй.</p> <p>Эх сурвалж: http://dv.parliament.bg/DVWeb/showMaterialDV.jsp?idMat=82965</p>
6	Ботсвана	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>57 дугаар зүйл. Парламент</p> <p>Ботсвана Улсын Парламент нь Ерөнхийлөгч, Үндэсний Ассамблейгаас бүрдэнэ.</p> <p>58 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн бүрэлдэхүүн</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөнхийлөгч нь албан тушаалын хувьд Үндэсний Ассамблейн гишүүн байх бөгөөд Үндэсний Ассамблейн бүх хуралдаанд үг хэлэх, санал өгөх эрхтэй. 2. Үндэсний Ассамблей нь Ерөнхийлөгчөөс гадна дараах гишүүдээс бүрдэнэ: <ol style="list-style-type: none"> а) энэ Үндсэн хууль болон Парламентын тухай хуулийн дагуу сонгогдсон 57 гишүүн; б) энэ Үндсэн хуулийн нэгдүгээр жагсаалт болон Парламентын тухай хуулийн дагуу тусгайлан сонгогдсон 4 гишүүн. <p>63 дугаар зүйл. Сонгуулийн тойрог</p> <p>Ботсвана Улсын нутаг дэвсгэр нь Үндэсний Ассамблейн сонгогдсон гишүүдийн тоотой адил тооны тойрогт хуваагдана.</p> <p>65 дугаар зүйл. Комиссын тайлан</p> <ol style="list-style-type: none"> 2. Тойргийн хил цэсийн хувьд оршин суугчдын тоо нь хүн амын квоттой аль болох ойролцоо байна.

		<p>Тухайн тойргийн оршин суугчдын тоо нь ашиг сонирхол, харилцаа холбоо, газарзүйн онцлог, хүн амын нягтаршил, овгийн нутаг дэвсгэр (Tribal Territories)-ийн болон засаг захиргааны нэгжийн хилийн цэсийг харгалзан хүн амын квотоос их буюу бага байж болно.</p> <p>3.Энэ хэсэгт тусгасан “хүн амын квот” гэж Ботсвана Улсын оршин суугчдын тоог (Ботсвана Улсын хүн амын хамгийн сүүлийн тооллогын дагуу тодорхойлсон) энэ Үндсэн хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу гаргасан тойргийн тоонд хуваасан дүнг ойлгоно.</p> <p>Эх сурвалж: https://www.parliament.gov.bw/images/constitution.pdf</p>
<p>7</p>	<p>Вануату</p>	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>17 дугаар зүйл. Парламентын гишүүдийн сонгууль</p> <p>Парламент нь улс төрийн бүлгүүд, ялгаатай үзэл бодлыг шударгаар төлөөлөх үүднээс пропорционал төлөөллийн шинжийг агуулсан бүх нийтийн сонгуулиар сонгогдсон гишүүдээс бүрдэнэ.</p> <p>Вануату Улсын Парламент нь 52 гишүүнтэй.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Vanuatu_2013?lang=en</p> <p>Сонгуулийн зорилгоор тойргийн хилийг тусгайлан тогтоодог эсэх:</p> <p>Сонгуулийн хороо нь нийт нутаг дэвсгэрийг олон мандаттай 17 тойрогт хуваана.</p> <p>Эх сурвалж: http://aceproject.org/ero-en/regions/pacific/VU/vanuatu-representation-of-the-people-act-1982-as/at_download/file</p> <p>Тойргийн хилийг тогтоох шалгуур:</p> <p>Вануату Улсын 6 аймаг, 2 хотын захиргаа нь нэг мандаттай 6, олон мандаттай 12 сонгуулийн тойргуудад хуваагдах бөгөөд 309 санал авах байртай байна. Сонгуулийн тойргууд нь хүн амын тоо, нөөц баялаг болон газарзүйн байршлын хувьд ихээхэн ялгаатай байна.</p> <p>Эх сурвалж: https://aceproject.org/ace-en/topics/em/electoral-management-case-studies/vanuatu-limitations-to-the-independence-of-the-emb</p>
<p>8</p>	<p>Грек</p>	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>51 дүгээр зүйл.</p> <p>1.Парламентын гишүүдийн тоог хуулиар тогтооно; гэхдээ энэ нь хоёр зуугаас цөөнгүй, гурван зуугаас ихгүй байна.</p> <p>2.Парламентын гишүүд нь үндэстнийг төлөөлнө.</p> <p>54 дүгээр зүйл.</p> <p>1.Сонгуулийн тогтолцоо болон тойргийг хуулиар тогтоох ба үүнийг Парламентын гишүүдийн гуравны хоёрын олонхын саналаар дараагийн сонгуулиудад шууд хэрэглэнэ гэсэн өөр тодорхой заалт батлан оруулаагүй л бол удаа дараагийн сонгуульд хэрэглэнэ.</p> <p>2.Сонгуулийн тойрог тус бүрээс сонгогдох парламентын гишүүдийн тоог тухайн мужийн хамгийн сүүлийн үеийн хүн амын тооллогоос гаргасан эрх зүйн чадамжтай хүн амын тоонд үндэслэн Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.</p> <p style="text-align: center;">ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙГ СОНГОХ ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>1 дүгээр зүйл.</p> <p>1) Муж нь депутатуудыг сонгох бүс нутаг гэж тодорхойлогдоно:</p> <p>д) тус улсын дотроо хуваагддаг хоёр том муж (Атика болон Салоники)-аас бусад мужийн засаг захиргааны нутаг дэвсгэрийн хил хязгаарыг сонгуулийн тойргийн хил хязгаар гэж үзнэ.</p> <p>Эх сурвалж: http://www.dsnet.gr/Epikairothta/Nomothesia/n3231_04.htm</p>

<p>9</p>	<p>Гүрж</p>	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>37 дугаар зүйл. Парламентын сонгууль</p> <p>(2) Энэхүү зүйлийн 1-д заасан нөхцөл бүрдэхийн өмнө 150 гишүүдээс бүрдэх парламентыг олон мандаттай сонгуулийн нэг тойрогт бүх нийтийн сонгуулиар чөлөөтэй, эрх тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр пропорционал системээр нууц санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно.</p> <p>Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Georgia_2018?lang=en</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>110 дугаар зүйл.</p> <p>(1).Гүржийн парламентын сонгуульд нэг мандаттай мажоритар 73 тойрог, түүний дотор Тбилиси хотод мажоритар 10 мандат бүхий сонгуулийн тойргийг байгуулна.</p> <p>(2).Парламентын сонгуулийн хувьд Тбилиси хотоос бусад хотын захиргаа (өөрийгөө удирдах хот, дүүрэг) нэг мандаттай мажоритар сонгуулийн тойрог байна.</p> <p>Эх сурвалж: http://www.transparency.ge/sites/default/files/August%202012.%20Election_Code_of_Georgia_EN_-_codified.pdf</p>
<p>10</p>	<p>Дани</p>	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>28.Фолкетинг (Парламент) нь нэг танхимтай, 179-өөс илүүгүй гишүүнээс бүрдэх ба үүнээс хоёр нь Фарерын арлуудад, хоёр нь Гренландад сонгоно.</p> <p>31.1.Фолкетингийн гишүүдийг бүх нийтээрээ, шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдоно.</p> <p>31.2.Сонгох эрхээ хэрэгжүүлэх журмыг Дани Улсын Фолкетингийн сонгуулийн тухай хуулиар тогтоох ба энэ хууль нь сонгогчдын олон талын санал бодлыг тэгш төлөөлөхийн тулд сонгуулийн журмыг тогтоож, нэг мандаттай тойрогт пропорционал төлөөллийг сонгуультай, эсхүл сонгуульгүй (with or without elections) явуулах эсэхийг тогтооно.</p> <p>31.3.Тойрог бүрийн мандатын тоог тогтоохдоо хүн амын тоо, сонгогчдын тоо, хүн амын нягтаршил зэргийг харгалзаж үзнэ.</p> <p>Эх сурвалж: https://www.thedanishparliament.dk/en/democracy/the-constitutional-act-of-denmark</p> <p style="text-align: center;">ФОЛКЕТИНГ (ПАРЛАМЕНТЫН) СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>7.1.Фолкетинг (Парламент) нь нийт 179 гишүүнийг, хоёрыг нь Фарерын арлуудад, хоёрыг нь Гренландад сонгоно.</p> <p>7.2.Фарерын арлуудын болон Гренландын сонгуулийн журмыг тусдаа хуулиар зохицуулна.</p> <p>8.1.Дани Улс 3 мужид хуваагдана: Копенгаген метрополитан, Силанд-Өмнөд Дани, Хойд ба Төв Жутланд.</p> <p>8.2.Бүс нутгууд нь олон мандаттай тойрогт хуваагдана. Копенгаген метрополитан нь олон мандаттай 4 тойргоос бүрдэнэ. Силанд-Өмнөд Дани, Хойд ба Төв Жутланд тус бүр олон мандаттай 3 тойргоос бүрдэнэ.</p> <p>8.3.Олон мандаттай тойргууд нь нэр дэвшүүлэх дүүрэг (nomination districts)-т хуваагдана.</p> <p>8.4.Нэр дэвшүүлэх дүүрэг нь нэг буюу хэд хэдэн хотын захиргаа, эсхүл хотын захиргааны хэсгээс бүрдэнэ...</p> <p>10.1.Улсын хэмжээнд нийт 175 мандат байх ба үүний 135 нь тойргийн мандат, 40 нь зөрүүг нөхөх мандат (compensatory seats) байна. 2010, 2015, 2020 зэрэг оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хүн амын тоог нийтэлсний дараа бүс нутаг болон олон мандаттай тойрогт мандатын хуваарилалтыг Нийгмийн асуудал, дотоод хэргийн сайд тогтоож зарлах бөгөөд энэхүү хуваарилалт нь дараагийн сонгуульд хамаарна.</p>

		<p>ТАЙЛБАР: Хүн амын тоог 5 жил тутамд нийтэлнэ.</p> <p>10.2.Энэхүү хуваарилалт нь бүс нутаг болон олон мандаттай тойрог тус бүрийн нийлбэрээр тооцож тогтооно: 1) хүн ам; 2) сүүлийн ээлжит сонгуулийн сонгогчдын тоо; болон 3) тухайн бүс нутгийн, эсхүл олон мандаттай тойргийн квадрат километр талбайг 20-оор үржүүлсэн дүн. Хэрэв хуваарилалтын үр дүнд бий болсон тоо нь бүхэл тоо биш учраас бутархай тоог оруулахгүй байх үед шаардлагатай мандатын тоонд хүрэхгүй бол бүхэл тоо болох хүртэл хамгийн том бутархайг нэмэгдүүлнэ (хамгийн их үлдэгдлийн арга). Хоёр ба түүнээс дээш бутархай нь ижил хэмжээтэй бол сугалаа явуулна.</p> <p>10.3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан тооцооллын дүрмийн дагуу 175 мандатыг эхлээд гурван бүсэд хуваарилна. Дараа нь тойргийн 135 мандатыг мөн бүс нутгуудад хуваарилна. Эцэст нь тойргийн мандатыг олон мандаттай тойргуудад зохих бүс нутагт хуваарилна.</p> <p>10.4.Хэрэв энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тооцоолсноор Борнхолм (Bornholm)-ын олон мандаттай тойрог доод тал нь хоёр мандат авч чадаагүй бол суудлын хоёр дахь хуваарилалтыг хийж, Борнхолмын олон мандаттай тойрогт хоёр мандатыг урьдчилан хуваарилна. Үлдсэн тойргийн 133 мандатыг энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бусад олон мандаттай тойрогт эцэслэн хуваарилна.</p> <p>10.5.Бүс тус бүрд олгох зөрүүг нөхөх мандатын тоог тухайн бүс нутгийн нийт мандатын тоо болон тухайн бүс нутгийн тойргийн мандатын тооны зөрүүгээр тооцно.</p> <p>Эх сурвалж: https://elections.im.dk/parliament-elections</p>
11	Доминика	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>29 дүгээр зүйл. Парламентын бүрэлдэхүүн Доминика Улсын Парламент нь Ерөнхийлөгч, Ассамблейн Танхимаас бүрдэнэ.</p> <p>30 дугаар зүйл. Ассамблейн Танхимын бүрэлдэхүүн 1.Ассамблейн Танхим нь дараах бүрэлдэхүүнтэй байна: а) энэ Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу сонгогдон энэ Үндсэн хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу тухайн үед байгуулагдаж байгаа сонгуулийн тойргийн тоотой тохирсон төлөөлөгчдийн тоо; б) энэ Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу томилогдсон буюу сонгогдсон 9 сенатор.</p> <p>57 дугаар зүйл. Сонгуулийн тойргийг өөрчлөх 1.Сонгуулийн тойргийн хилийн хороо (цаашид энэ хэсэгт “Хороо” гэх) энэ хэсэгт заасны дагуу Доминика Улсын хуваагдсан сонгуулийн тойргийн тоо, хилийн заагийг хянаж, Ерөнхийлөгчид дараах тайлан (report)-ийн аль нэгийг танилцуулна: а) энэ Үндсэн хуулийн 2 дугаар хавсралтад заасан дүрмийг хэрэгжүүлэхийн тулд Доминика Улсын сонгуулийн тойргийг хуваасан саналаа танилцуулах; б) эдгээр дүрмийг хэрэгжүүлэхийн тулд одоо байгаа тойргийн тоо, хил хязгаарыг өөрчлөх шаардлагагүй гэсэн саналаа мэдэгдэх.</p> <p>2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тайланг Хороо 2-оос доошгүй, 5-аас дээшгүй жилийн хугацаанд ирүүлнэ.</p> <p>Үндсэн хуулийн хавсралт 2. Сонгуулийн тойргийн тухай дүрэм Сонгуулийн тойргийн хилийн хорооны үзэж байгаагаар бүх тойрогт бараг тэнцүү тооны оршин суугч байна. Гэхдээ Комисс дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзсэнээр энэ зарчмаас татгалзаж болно. Үүнд: а) хүн амын нягтаршил, ялангуяа сийрэг суурьшсан хөдөө орон нутгийн төлөөллийг хангах хэрэгцээ; б) харилцаа холбоо; в) газарзүйн онцлог;</p>

		<p>г) засаг захиргааны бүс нутгийн хилийн цэс.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Dominica_2014.pdf?lang=en</p> <p>Сонгуулийн зорилгоор тойргийн хилийг тусгайлан тогтоодог эсэх:</p> <p>Доминика нь нэг мандаттай 21 тойрогт хуваагддаг.</p> <p>Эх сурвалж: http://electoraloffice.gov.dm/constituencies/constituency-boundaries-3</p>
12	Зүүн Тимор	<p>ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>93 дугаар зүйл. Сонгууль, бүрэлдэхүүн</p> <p>2.Үндэсний Парламент нь доод тал нь 52, дээд тал нь 65-аас ихгүй гишүүнээс бүрдэнэ.</p> <p>3.Сонгуулийн тойрог, сонгогдох нөхцөл, нэр дэвшүүлэх, сонгуулийн журамтай холбоотой журмыг хуулиар тогтооно.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/East_Timor_2002</p> <p>ҮНДЭСНИЙ ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>9.Үндэсний Парламентын сонгуулийн төв байр нь Дили хотод байрлах ба улсын нийт нутаг дэвсгэрт тохирох нэг тойрог байна.</p> <p>Эх сурвалж: https://jsmp.tl/wp-content/uploads/2013/08/Law-on-Election-of-the-National-Parliament-English.pdf</p>
13	Израил	<p>ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>3 дугаар зүйл. Кнессет нь 120 гишүүнээс бүрдэнэ.</p> <p>4 дүгээр зүйл. Кнессет нь Сонгуулийн тухай хуульд заасны дагуу бүх нийтийн шууд, тэгш, нууц санал хураалтаар, пропорционал сонгуулиар сонгогдоно; Кнессетийн гишүүдийн олонхын саналаас бусад тохиолдолд энэ хэсгийг өөрчлөхгүй.</p> <p>Эх сурвалж: https://main.knesset.gov.il/EN/activity/Documents/BasicLawsPDF/BasicLawTheKnesset.pdf</p>
14	Ирак	<p>ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>49 дүгээр зүйл.</p> <p>Нэг. Төлөөлөгчдийн Зөвлөл буюу танхимын гишүүдийн тоо нь нийт Ирак иргэдийн 100.000 Ирак иргэн тутамд нэг суудал ногдож байхаар тогтоогдоно. Сонгуулийг бүх нийтээр шууд, нууц санал хураалтаар явуулна. Ард түмнийг бүрдүүлэгч бүх бүрэлдэхүүн хэсгийн төлөөлөгчдийг багтаан оруулна.</p> <p>Дөрөв. Сонгуулийн тухай хууль нь эмэгтэй гишүүдийн хувь хэмжээг Төлөөлөгчдийн танхимын бүх гишүүдийн дөрөвний нэгээс багагүй байлгахад чиглэнэ.</p> <p>Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Iraq_2005?lang=en</p> <p>СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>11 дүгээр зүйл.</p> <p>1.Төлөөлөгчдийн танхим нь гурван зуун хорин найман (328) суудалтай. Үүнээс хил хязгаарын зохион байгуулалтыг хуульд хавсаргасан хуваарьтай нийцүүлсний дагуу гурван зуун хорин (320) суудлыг мужуудад хуваарилж, найман (8) суудлыг квотод үлдээнэ.</p> <p>Эх сурвалж: http://aceproject.org/ero-en/regions/mideast/IQ/iraq-electoral-law-of-the-iraqi-parliament-2013/view</p> <p>ТАЙЛБАР:</p> <p>Сонгуулийн тойрог: Засаг захиргааны 18 нэгжид суурилсан 328 мандат бүхий тойргуудаас 8 мандатыг цөөнхөд хадгална:</p> <ul style="list-style-type: none"> - шууд сонгогдох - 320; - бусад - 8.

		<p>Засаг захиргааны нэгжид суурилсан 328 мандатыг дараах байдлаар хуваарилна:</p> <ul style="list-style-type: none"> - Анбар: 15; - Бабил: 17; - Багдад: 71 (үүнээс 1 нь Христүүдэд, 1 нь Сабинуудад ногдоно); - Басра: 25; - Дияала: 14; - Дахук: 11 (үүнээс 1 нь христүүдэд ногдоно); - Эрбил: 15 (үүнээс 1 нь христүүдэд ногдоно); - Карбала: 11; - Киркүк: 14 (үүнээс 1 нь христүүдэд ногдоно); - Миссан: 10; - Мутхана: 7; - Нажаф: 12; - Нинева: 35 (үүнээс 1 нь христүүдэд, 1 нь Езидид, 1 нь Шабакт ногдоно); - Кадиссия: 11; - Салахаддин: 12; - Сулаямания: 18; - Дхи-Кар: 19; - Вассит: 11 (үүнээс 1 нь Файли Курдуудад ногдоно). <p>Сонгуулийн систем: пропорционал төлөөллийн систем Суудлыг Сент-Лагийн арга (Sainte-Laguë method)-р хуваарилна.</p> <p>Жагсаалтаар хамгийн олон тооны санал авсан нэр дэвшигч сонгогдохын зэрэгцээ ялалт байгуулсан гурван эрэгтэй нэр дэвшигч бүрийн дараагаар нэг эмэгтэй нэр дэвшигчийг сонгох байдлаар нийт суудлын 25 хувийг эмэгтэйчүүдэд хуваарилна.</p> <p>Эх сурвалж: http://archive.ipu.org/parline-e/reports/2151_B.htm</p>
15	Исланд	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>31 дүгээр зүйл. Алтингийн сонгууль</p> <p>Альтинг (Парламент) нь ард түмнээс нууц санал хураалтаар пропорционал хувилбараар дөрвөн жилийн хугацаагаар сонгогдсон 63 гишүүнээс бүрдэнэ.</p> <p>Сонгуулийн тойрог нь зургаагаас цөөнгүй, долоогоос ихгүй байна. Тэдгээрийн хилийн цэсийг хуулиар тогтооно; гэхдээ Үндэсний сонгуулийн зөвлөл нь Рейкьявигийн сонгуулийн тойргийн хилийн цэсийг болон нутаг дэвсгэрийг тодорхойлж болно.</p> <p style="text-align: center;">ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>6 дугаар зүйл. Улсын нутаг дэвсгэрийг Парламентын сонгуулийн тухай хуулийн дагуу сонгуулийн 6 тойрогт хуваана. Альтингийн сонгууль зарлагдсан үед Үндэсний сонгуулийн хороо сонгуулийн өдрөөс таван долоо хоногийн өмнө Үндэсний бүртгэлийн газрын хүн амын бүртгэлд үндэслэн Рейкьявигийн тойргийн хилийн цэсийг тогтооно.</p> <p>7 дугаар зүйл. Тойргийн хилийг тогтоохдоо сонгогчдын тоог, парламентын нэг суудалд ногдох хэмжээгээр тогтооно. Ингэхдээ нэмэлт суудал (adjustment seats)-ыг оруулан тооцох бөгөөд аль болох тэгш тооны суудал ногдуулна. Мөн тойрог нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл байхад анхаарна.</p> <p>8 дугаар зүйл. Парламент 63 суудалтай бөгөөд тэдгээр нь сонгуулийн тойргуудад дараах байдлаар хуваагдана:</p> <ul style="list-style-type: none"> - Баруун хойд тойрог – 8 мандат; - Зүүн хойд тойрог – 10 мандат; - Өмнөд тойрог – 10 мандат; - Баруун өмнөд тойрог – 13 мандат; - Рейкьявигийн өмнөд хэсгийн тойрог – 11 мандат; - Рейкьявиг ийн хойд хэсгийн тойрог – 11 мандат.

		<p>Эх сурвалж: https://www.legislationline.org/download/id/3897/file/Iceland_Act_Parliamentary_Elections_to_Althing_2000_en.pdf</p>
16	Кирибати	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>53 дугаар зүйл. Манеаба ни Маунгатабу-г байгуулах нь Манеаба ни Маунгатабу (Парламент) нь дараах байдлаар бүрдэнэ: а.сонгогдсон 35 гишүүн; б.Үндсэн хуулийн 117 дугаар зүйлд заасан гишүүн; в.хэрэв сонгогдсон гишүүн биш хүн Ерөнхий шүүгчээр томилогдсон бол тэрээр албан тушаалаараа гишүүн болно.</p> <p>54 дүгээр зүйл. Сонгогдсон гишүүдийг сонгох Манеаба ни Маунгатабу-гийн сонгогдсон гишүүдийг энэ Үндсэн хуулийн дагуу сонгоно.</p> <p>Манеаба ни Маунгатабу-гийн сонгогдсон гишүүдийг сонгох зорилгоор Кирибати Улсын нутаг дэвсгэрт тодорхой хилийн цэстэй, сонгогдсон төлөөлөгчдийн тоог заасан сонгуулийн тойргуудыг байгуулна.</p> <p>Ингэхдээ энэ Үндсэн хуульд заасан журмыг мөрдөнө. Кирибати Улсын нутаг дэвсгэрийг сонгуулийн 23 тойрогт хувааж, 1977 оны Сонгуулийн тухай зарлигт (Elections Ordinance 1977 [FN: No. 12 of 1977]) заасны дагуу сонгуулийн 23 тойрог, тэдгээрийн хилийн цэсийг болон сонгогдох суудлын тоог тогтоосны адилаар хуваана.</p> <p>117 дугаар зүйл. Манеаба ни Маунгатабу-д нэр дэвшсэн гишүүн Манеаба ни Маунгатабу-гийн нэг суудлыг Банабан овгоос нэр дэвшүүлэх хүнд хадгална.</p> <p>Эх сурвалж: https://constituteproject.org/constitution/Kiribati_2013?lang=en</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>9 дүгээр зүйл. Манеаба ни Маунгатабу-д сонгогдсон гишүүдийн тоог танилцуулах зорилгоор Кирибатийн сонгуулийн 23 тойргийн хуваарийг 1 дүгээр хүснэгтийн эхний баганад, мөн сонгуулийн тойрог бүрийн тухайн тойрогт хамаарах нутаг дэвсгэрийг 1 дүгээр хүснэгтийн хоёр дахь баганад, харин 1 дүгээр хүснэгтийн гурав дахь баганад сонгогдсон гишүүдийн тоог тус тус жагсаана.</p> <p>ТАЙЛБАР: Жагсаалтыг хавсаргав.</p> <p>Эх сурвалж: https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/113880/142954/F1958582048/KIR113880%20.pdf</p> <p>ТАЙЛБАР: Үндсэн хуулийн 63 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 118 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу Сонгуулийн хороо нь 4-өөс илүүгүй жил давтамжтайгаар сонгуулийн тойргийн тоо, тойргийн хилийн цэс болон тойрогт төлөөлөх парламентын гишүүдийн тоонд хяналт тавина. Ингэхдээ Үндсэн хуулийн 118 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон Кирибати Улсын хамгийн сүүлийн хүн амын статистик тоо, хүн амын дотоодын шилжилт хөдөлгөөнийг харгалзана.</p> <p>Эх сурвалж: http://www.paclii.org/ki/legis/consol_act/eo167.pdf</p>
17	Латви	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>5 дугаар зүйл. Сейм нь ардын төлөөлөгч 100 гишүүнтэй. Сеймийг пропорционал тогтолцооны дагуу нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно.</p> <p>Латви Улсыг тусдаа сонгуулийн тойрог болгон хуваахдаа, дүүрэг тус бүрээс сонгогдох Сеймийн гишүүдийн тоо, тойрог тус бүрийн сонгогчдын тоотой пропорционал байна.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Latvia_2016?lang=en</p>

СЕЙМИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

7 дугаар зүйл. Латви Улсын Сеймийн сонгууль нь 5 тойрогт хуваагдана:

- 1.Рига;
- 2.Видземе;
- 3.Латгале;
- 4.Курземе;
- 5.Земгале.

Ригагийн сонгуулийн тойрогт Рига хот орно;

Видземе сонгуулийн тойрогт Адази, Аложа, Алюксне, Амата, Апе, Бабит, Балдоне, Беверина, Буртниеки, Карникава, Цесис, Чесвайн, Эргли, Гаркалне, Гулбене, Икскиле, Инкукалнс, Жаунпиебалга, Кочени, Кримлда, Кегумс, Кекава, Лиэлварде, Лигатне, Лимбази, Лубана, Мадона, Малпилс, Марупе, Мазсалака, Науксени, Огре, Олейн, Паргаужа, Приекули, Рауна, Ропазы, Ружиена, Салакгривая, Сакраласты, Сигурда, Смилтене, Стопини, Стренци, Валка, Вараклани, Вечпиебалгагийн хязгаар, Юрмала, Валмиера хотууд орно;

Латгалегийн сонгуулийн тойрогт Аглона, Балтинава, Балви, Цибла, Дагда, Даугавпилс, Илуксте, Карсава, Краслава, Ливани, Лудза, Преили, Резекне, Рибеину, Ругажи, Варкава, Вилака, Вилани, Зилупегийн хязгаар, Даугавпи, Резекне хотууд орно;

Курземегийн сонгуулийн тойрогт Айзпутэ, Алсунга, Брочени, Дундага, Дурбе, Гробина, Кулдигас, Ника, Павилоста, Приекуле, Рожа, Рукава, Салдус, Скрунда, Талси, Вайноде, Вентспилсийн хязгаар, Лиепая, Венципилс хотууд орно;

Земгалегийн сонгуулийн тойрогт Айзраукле, Акнистэ, Аусе, Бауска, Добеле, Энгуре, Иекава, Яунжелгава, Жаунпилс, Жекабилс, Елгава, Кандава, Кокнесе, Крустпилс, Нерета, Озольниеки, Плавинас, Рундале, Салаве, Тукрикумс, Векумниеки, Виеситийн хязгаар, Елгава ба Жекабилс хотууд орно.

8 дугаар зүйл.

(1) Сонгуулийн төв хороо иргэдийн бүртгэлийн мэдээллийн дагуу сонгуулийн өдрөөс 4 сарын өмнө тойрог тус бүрээс сонгогдох Сеймийн гишүүдийн тоог тухайн тойргийн сонгогчдын тоотой пропорционалаар тогтооно. Гадаадад оршин суугаа сонгогчдыг Рига хотын сонгуулийн тойргийн сонгогчдын тоонд оруулна.

(2) Тойрог тус бүрээс сонгогдох Сеймийн гишүүдийн тоог дараах байдлаар тооцно.

1) нийт сонгогчдын тоог 100 (Сейм 100 гишүүнтэй)-д хуваана.

2) тойрог тус бүрийн сонгогчдын тоог 1-д заасан хуваалтын дүнд хуваана. Хуваалтын дүнд гарсан бүхэл тоо нь тухайн тойргоос сонгогдох Сеймийн гишүүдийн тоог илэрхийлнэ.

3)Хэрэв 2 дахь хэсэгт заасан дүнгийн бүхэл тоонуудын нийлбэр нь 100-аас бага бол сонгогдох Сеймийн гишүүний тоог нэгээр, хамгийн их бутархай гарсан тойрогт, дараа дараагийн хамгийн их бутархайтай тойрогт гэх мэт бүх тооны нийлбэр 100 болтол нэмэгдүүлнэ.

4)Хэрэв аливаа хоёр тойрог бутархайгаар тэнцүү санал авсан бол 2 дахь хэсэгт заасан хуваалтын дүнгийн бүхэл тоо нь хамгийн бага байгаа тойрогт эхлээд Сеймийн гишүүний тоог нэмэгдүүлнэ.

5) хэрэв аливаа хоёр тойрог бутархай болон бүхэл тоогоор тэнцүү дүн гарвал аль тойрогт Сеймийн гишүүний тоог нэмэгдүүлэхийг сугалаагаар тогтооно.

(3) Тойрог тус бүрээс сонгогдох Сеймийн гишүүдийн тоог сонгуулийн өдрөөс 100-аас доошгүй хоногийн өмнө албан ёсны хэвлэлд нийтэлнэ.

Эх сурвалж: <https://likumi.lv/ta/en/en/id/35261-law-on-the-election-of-the-isaeimai>

18	Лихтенштайн	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>46 дугаар зүйл.</p> <p>1. Парламент нь пропорционал тогтолцооны дагуу нийтээрээ, тэгш, нууц, шууд сонгох замаар ард түмнээс сонгогддог 25 Төлөөлөгчөөс бүрдэнэ. Дээд муж (Оберланд), Доод муж (Унтерланд) тус бүр нэг тойрог үүсгэнэ. Төлөөлөгчийн 15-ыг Дээд муж, 10-ыг Доод мужаас сонгоно.</p> <p>2. Парламентын 25 төлөөлөгчөөс гадна тойрог тус бүрд орлогч (substitute) сонгоно.</p> <p>Нэг тойргийн гурван төлөөлөгч тутамд сонгуулийн бүлэг (electoral group) тус бүр нэг орлогчтой байх ба хэрэв сонгуулийн бүлэг нэг мандат авсан бол доод тал нь нэг орлогч байна.</p> <p>3. Мандатыг улсын хэмжээнд нийт саналын 8-аас доошгүй хувийн санал авсан сонгуулийн бүлэгт хуваарилна.</p> <p>ТАЙЛБАР: Вадуз (Оберланд, Дээд улс) болон Шелленберг муж (Унтерланд, Доод улс) нь Ариун Ромын эзэнт гүрний бие даасан лордын эзэмшил газар байв. Тэд өвөрмөц бүс нутаг гэж хүлээн зөвшөөрөгдсөн хэвээр байгаа бөгөөд тус тусад нь сонгуулийн тойрог болгодог.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitutions?lang=en&status=in_force&status=is_draft https://www.llv.li/files/rdr/Verfassung-E-01-02-2014.pdf</p>
19	Люксембург	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>51 дүгээр зүйл. Төлөөлөгчдийн танхим нь 60 гишүүнтэй.</p> <p>Гишүүдийг нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох зарчмаар (намын) нэрсийн жагсаалтаар, пропорционалаар, хуулиар тогтоосон журмын дагуу сонгуулийн квотын хамгийн бага байх зарчмыг баримтлан сонгоно.</p> <p>51 (6) дүгээр зүйл. Тус улс нь сонгуулийн 4 тойрогт хуваагддаг:</p> <ul style="list-style-type: none"> - Өмнөд хэсэг нь Эш-сюр-Альзет болон Каплен кантонуудтай; - Төв хэсэг нь Люксембург ба Мершийн кантонуудтай; - Хойд хэсэг нь Диекирх, Реданж, Вилц, Клерва, Вианден зэрэг кантонтой; - Зүүн хэсэг нь Гревенмахер, Ремих, Эхтернах кантонуудтай. <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Luxembourg_2009?lang=en</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>132 дугаар зүйл. Олон мандаттай 4 тойрогтой:</p> <ul style="list-style-type: none"> - Өмнөд 23; - Төв 21; - Хойд 9; - Зүүн 7. <p>Эх сурвалж: https://legilux.public.lu/eli/etat/leg/recueil/elections/20190216</p>
20	Маврики	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>31 дүгээр зүйл. Тус улсын парламент нь Ерөнхийлөгч, Үндэсний Ассамблейгаас бүрдэнэ.</p> <p>Үндэсний Ассамблей 70 гишүүнтэй.</p> <p>39 дүгээр зүйл. Тус улс нь сонгуулийн 21 тойрогтой. Маврики арал 20 тойрог, Родригас 1 тойрог болно.</p> <p>10 жил тутам тойргийн хилийг шинэчлэн тогтоодог.</p> <p>Тойрог бүрийн оршин суугчдын тоо нь хүн амын квоттой тэнцүү байна. Сонгуулийн Хилийн Хороо тойрог тус бүрийн оршин суугчдын тоог хүн амын квоттой тэнцүү байлгах үүднээс сонгуулийн тойргийн хилийг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл зөвлөмж гаргана.</p>

		<p>Харилцаа холбооны хэрэгсэл, газарзүйн онцлог, хүн амын нягтаршил, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн заагийг харгалзан тухайн тойргийн оршин суугчдын тоо хүн амын квотоос их, бага байж болно.</p> <p>"Хүн амын квот" гэдэг нь Маврикийн хүн амын хамгийн сүүлийн албан ёсны тооллогоор тоологдсон Маврики арлын оршин суугчдын тоог 20-д хувааж гарсан тоог хэлнэ.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Mauritius_2016?lang=en</p>
21	Македон	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>62 дугаар зүйл. Ассамблей нь 120-140 төлөөлөгчтэй. Төлөөлөгчдийг нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгогдоно.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Macedonia_2011?lang=en</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>174 (1) дүгээр зүйл. Бүгд Найрамдах Македон Улс нь сонгуулийн 9 тойрогт хуваагддаг. Сонгуулийн 1-6 дугаар тойргийг хуваасан байдлыг сонгуулийн тухай хуулийн 175(1)-д нарийвчлан жагсаалтаар зохицуулсан байна.</p> <p>ТАЙЛБАР: Жагсаалтыг хавсаргав. Сонгуулийн 7-9 дүгээр тойргийг дараах байдлаар зохицуулсан. 7 дугаар тойрог: Европ, Африкт түр хугацаагаар ажиллаж, оршин сууж буй тус улсын иргэдийн санал авах дипломат төлөөлөгчийн газар; 8 дугаар тойрог: Хойд болон Өмнөд Америкт түр хугацаагаар ажиллаж, оршин сууж буй тус улсын иргэдийн санал авах дипломат төлөөлөгчийн газар; 9 дүгээр тойрог: Австрали, Азид түр хугацаагаар ажиллаж, оршин сууж буй тус улсын иргэдийн санал авах дипломат төлөөлөгчийн газар.</p> <p>Эх сурвалж: https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2013)013-e</p>
22	Мальта	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>51 дүгээр зүйл. Парламент нь улсын Ерөнхийлөгч, Төлөөлөгчдийн танхимаас бүрдэнэ. Парламент нь 65 гишүүнтэй.</p> <p>61 дүгээр зүйл. Сонгуулийн хэсэг Сонгуулийн хороо (Electoral Commission) Үндсэн хуулийн 56(1)-д заасан сонгуулийн хэсэг (electoral division)-ийн хилийг 2-оос доошгүй, 5-аас дээшгүй жилийн интервалаар хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл сонгуулийн хэсгийн хилийг өөрчлөх саналаа парламентад гаргана.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Malta_2016?lang=en</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ</p> <p>17 (1) дугаар зүйл. Мальта арал болон түүний харьяа арлууд нь сонгуулийн 13 хэсэгт хуваагддаг. Сонгуулийн тойрог бүр 5 мандаттай. Парламентын гишүүдийг пропорционал системээр сонгоно.</p> <p>Эх сурвалж: https://legislation.mt/eli/cap/354/eng/pdf</p>
23	Молдова	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>60 дугаар зүйл. 2.Парламент нь 101 гишүүнээс бүрдэнэ.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Moldova_2016?lang=en</p>

БҮГД НАЙРАМДАХ МОЛДОВА УЛСЫН СОНГУУЛИЙН ХУУЛЬ**27 дугаар зүйл.**

1. Тойргийн хил нь Бүгд Найрамдах Молдова Улсын хоёр дахь шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон Гагаузиа, Кишинев, Балти автономит мужуудын нутаг дэвсгэрийн хилтэй тохирно.

79 дүгээр зүйл.

2. Парламентын сонгууль нь холимог систем (пропорционал болон мажоритар)-д үндэслэж, улсын хэмжээнд нэг тойргоос сонгогдох болон тойрог бүрээс нэг гишүүн сонгогдох байдлаар явагдана.

3. Ингэснээр 50 гишүүн үндэсний хэмжээнд нэг тойргоос пропорционал төлөөллөөр, 51 гишүүн нь тойрог бүрээс нэг гишүүн буюу мажоритар тогтолцоогоор сонгогдоно.

80 дугаар зүйл.

4. Нэг мандаттай тойргийг тогтооход нутаг дэвсгэр болон хүн ам зүйн дараах шалгууруудыг харгалзаж үзнэ:

a) тойргууд нь харьцангуй тэнцүү тооны буюу 55000-60000 хүртэлх тооны сонгогчтой байна;

b) нэг мандаттай тойргуудын сонгогчдын тоо нь 10%-аас илүү хэлбэлзэж болохгүй;

d) нэг мандаттай тойрог нь хоёр дахь шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон ижил түвшний хэд хэдэн нутаг дэвсгэрийн нэгжүүдээс бүрдэнэ;

e) тухайн орон нутгийн сонгогчдын тоо нь нэг мандаттай тойргийн сонгогчдын дундаж тооноос их байгаа тохиолдолд тухайн орон нутагт хэд хэдэн сонгуулийн тойрог байгуулж болно. Нэгдүгээр шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид нэг мандаттай сонгуулийн тойргийн хил тогтоохыг хориглоно;

f) үндэсний цөөнх олноор суурьшсан нутаг дэвсгэрт нэг мандаттай сонгуулийн тойргийг байгуулахдаа тэдгээрийн эрх ашиг болон нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн заагийг харгалзан үзнэ;

g) Гагаузиа автономит мужийн нутаг дэвсгэрт нэг мандаттай сонгуулийн тойргийн хилийг тогтоохдоо тухайн мужийн нутаг дэвсгэрээс дотогш болон гадна байгуулахыг хориглоно;

5. Бүгд Найрамдах Молдова Улсын нутаг дэвсгэрээс гадна нэг мандаттай сонгуулийн тойргийг тогтоохдоо дараах зүйлсийг харгалзан үзнэ:

a) Молдова Улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газруудаас авсан мэдээлэл;

b) холбогдох статистик мэдээлэл;

c) Сонгуулийн төв хорооны журмын дагуу гадаадад оршин суугаа иргэдийн урьдчилсан бүртгэл;

d) өмнөх сонгуульд оролцсон сонгогчдын бүртгэл;

e) хуулийн дагуу төрийн төв байгууллага хүлээн авагч улсын засаг захиргааны байгууллагаас авсан холбогдох бусад мэдээлэл;

f) гадаадад сонгуулийн тойргийн хилийг тогтоохдоо, Засгийн газраас баталсан журмыг баримтлан, холбогдох, нэр бүхий газарзүйн бүсүүдэд хуваана: Европын Холбооны гишүүн орнууд, Европын Холбооны гишүүн бус зүүн Европын орнууд; Хамтын нөхөрлөлийн тусгаар улсууд, Ази болон Ойрхи Дорнод; Хойд Америк, Өмнөд Америк, Африк, Австрали, Шинэ Зеланд. Ингэхдээ улс орнуудын хилийг харгалзан үзэх бөгөөд хил хязгаарыг давж болохгүй.

7. Нэг мандаттай сонгуулийн тойргийн хилийг ээлжит сонгуулиас нэг жилээс бага хугацаанд шинэчлэн тогтоож болохгүй.

Эх сурвалж: <https://cec.md/storage/ckfinder/files/cec-electoral-code-2019.pdf>

24	Монако	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>53 дугаар зүйл. Үндэсний зөвлөл нь 24 гишүүнтэй. Үндэсний зөвлөлийн гишүүдийг нийтээрээ, шууд, жагсаалтын системээр сонгоно. Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Monaco_2002?lang=en</p> <p style="text-align: center;">НИЙТИЙН БОЛОН ҮНДЭСНИЙ СОНГУУЛИЙГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>Улс бүхлээрээ нэг тойрог болдог. Эх сурвалж: https://legimonaco.mc/tnc/loi/1968/02-23-839/</p>
25	Монгол	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>Хорин нэгдүгээр зүйл. 1.Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна. 2.Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 11 (2), 12 (1) ЗҮЙЛ.</p> <p>Сонгуулийн 76 тойрогт хуваагддаг. Тойрог бүр сонгуулийн хэсэгт хуваагддаг.</p> <p>Улсын Их Хурал аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан сонгуулийн санал авах өдрөөс зургаагаас доошгүй сарын өмнө сонгуулийн тойргийг байгуулна.</p> <p>Аймаг, дүүргийн хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, нийслэлийн дүүрэгтэй нэг тойрог болгон нэгтгэж болно.</p> <p>ТАЙЛБАР: Тойргийн хилийг тогтоох: Аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг харгалзан тойргийг хуваана. Хэрэв засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт оруулсан өөрчлөлт нь тойргийн бүтцэд нөлөөлж болзошгүй, эсхүл тухайн хэсэгт байгаа хүн амын тоо (сонгогч) 200-аас дээш тоогоор өөрчлөгдсөн тохиолдолд Сонгуулийн ерөнхий хороо тойргийг өөрчлөх тухай саналыг УИХ-д оруулж болно. Эх сурвалж: https://www.legislationline.org/download/id/5845/file/Mongolia-Election-Law_2011_en.pdf</p>
26	Норвег	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>57 дугаар зүйл. Стортинг (Парламент) нь 169 төлөөлөгчтэй. Төлөөлөгчдийн 150 нь тойргоос, 19 нэмэлт төлөөлөгч (adjustment seats) сонгогддог. Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Norway_2016?lang=en</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>11.1 дүгээр зүйл. Тус улс нь сонгуулийн 19 тойрогт хуваагдана. Гишүүн болон орлогч гишүүдийг дараах тойргоос сонгоно:</p> <ul style="list-style-type: none"> а) Эстфолд (Østfold)-ын сонгуулийн тойрог; б) Акершусын сонгуулийн тойрог; в) Ослогийн сонгуулийн тойрог; г) Хедмаркийн сонгуулийн тойрог; д) Оппландын сонгуулийн тойрог; е) Бускерудын сонгуулийн тойрог; ё) Вестфолдын сонгуулийн тойрог; ж) Телемаркийн сонгуулийн тойрог; з) Ауст-Агдерийн сонгуулийн тойрог; и) Вэст-Агдерийн сонгуулийн тойрог;

		<p>й) Рогаландын сонгуулийн тойрог; к) Хордаландын сонгуулийн тойрог; л) Согн-ог-Фьорданегийн сонгуулийн тойрог; м) Море-ог-Ромсдалийн сонгуулийн тойрог; н) Сер-Тронделагийн сонгуулийн тойрог; о) Норд-Тронделагийн сонгуулийн тойрог; п) Нордландын сонгуулийн тойрог; р) Тромсын сонгуулийн тойрог; с) Финмаркийн сонгуулийн тойрог.</p> <p>11.3 дугаар зүйл. 1. Стортингийн бүх суудлыг тойрогт хуваарилна. Хуваарилалтыг 8 жил тутамд яам хийнэ. 2. Тойрог тус бүрээр хуваарилах тоон үзүүлэлтийг парламентын сонгуулийн өмнөх жилийн эцсийн тухайн тойргийн хүн амын тоо, тухайн тойргийн километр квадратын тоо (square kilometres)-г 1.8-аар үржүүлсэн тоог нэмж тооцно.</p> <p>Эх сурвалж: Сонгуулийн тухай хууль – https://www.regjeringen.no/contentassets/81a7bafa78f04d358ace73997145d974/juni_2019_election_act_updated-01.03.2019.pdf</p>
<p>27</p>	<p>Папуа Шинэ Гвиней</p>	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>101 дүгээр зүйл. Үндэсний парламент нь нэг танхимтай хууль тогтоох байгууллага бөгөөд дараах гишүүдээс бүрдэнэ: - нэг мандаттай нээлттэй сонгуулийн тойргоос сонгогдсон гишүүд; - нэг мандаттай орон нутгаас сонгогдсон гишүүд; - нэр дэвшүүлсэн 3-аас илүүгүй гишүүн (дийлэнх олонхын гуравны хоёрын саналаар парламентын гишүүнд нэр дэвшүүлж томилогдсон); - Органик хуулийн дагуу нэг мандаттай эмэгтэйчүүдийн сонгуулийн тойргоос сонгогдсон эмэгтэй гишүүд.</p> <p>125 дугаар зүйл. Нээлттэй сонгуулийн тойргийн тоо, түүний хилийг 10-аас дээшгүй жилээр, тухай бүр Хилийн комиссоос гаргасан зөвлөмжийн дагуу парламент шийдвэрлэнэ.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Papua_New_Guinea_2016?lang=en</p> <p style="text-align: center;">ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ОРГАНИК ХУУЛЬ</p> <p>36 дугаар зүйл. Хилийн комисс (Boundaries Commission) улсын нээлттэй сонгуулийн тойрог (open electorates)-ийг дахин хуваарилах зорилгоор хүн амын квотыг дараах томъёогоор тогтооно.</p> <p>Q = P/N Q-сонгуулийн тойрогт ногдох хүн амын квот P-улсын нийт хүн амын тоо N-Хилийн комиссоос тогтоосон нээлттэй сонгуулийн тойрог дахь түр тоог хэлнэ.</p> <p>Орон нутаг бүрд дор хаяж нэг нээлттэй сонгуулийн тойрог байна. Хилийн комисс нь сонгогчдын тоог (20 хувиар нэмэх, хасах) тодорхойлохдоо дараах зүйлсийг харгалзан үзнэ: а) хүн амын нягтаршил; б) бодит байдал, харилцаа холбоо (physical features and communications); в) одоо байгаа сонгуулийн тойргийн хил; г) орон нутгийн түвшний засаг захиргаа, орон нутгийн болон бусад захиргааны бүс; д) хэрэв шаардлагатай гэж үзвэл олон нийт болон сонирхлын олон талт байдал.</p>

		<p>Эх сурвалж: <i>Organic Law on National and Local-level Government Elections – http://www.paclii.org/pg/legis/consol_act/olonalqe519/</i></p>
28	Португал	<p align="center">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>148 дугаар зүйл. Бүрэлдэхүүн. Бүгд Найрамдах Улсын Ассамблей нь Сонгуулийн хуульд заасны дагуу доод тал нь 180, дээд тал нь 230 гишүүнтэй байна.</p> <p>149 дүгээр зүйл. Тойрог 1.Гишүүдийг хуулийн дагуу газар нутгийн байршлаар тогтоосон тойргуудаас сонгоно. Хуулиар сонгуулийн тойргийг олон мандаттай, нэг мандаттай гэж тогтоох бөгөөд сонгогчдын саналыг хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны дагуу Д’Хонтын аргыг ашиглан суудал хуваарилна. 2.Португал Улсын нутаг дэвсгэр дэх олон мандаттай сонгуулийн тойргуудын гишүүдийн тоо нь санал өгөхөөр бүртгэгдсэн иргэдийн тоотой хувь тэнцүү байна. Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Portugal_2005.pdf</p> <p>Сонгуулийн зорилгоор тойргийн хилийг тусгайлан тогтоодог эсэх: Эх газрын сонгуулийн тойргууд нь засаг захиргааны нэгжүүдтэй ижил байх бөгөөд тойргийг тухайн засаг захиргааны нэгжийн нэрээр нэрлэнэ. Мадейра болон Азорес автономит мужууд нь тус тус сонгуулийн тойрогтой. Португалын нутаг дэвсгэрээс гадна оршиж буй сонгогчид тус бүр нэг мандаттай 2 тойрогт хуваагдах бөгөөд 1 нь Европын улсууд, нөгөө нь Макаогийн нутаг дэвсгэрт болон бусад орнуудад суугаа сонгогчдыг хамардаг байна. Эх сурвалж: https://www.parlamento.pt/sites/EN/Parliament/Documents/LeiEleitoralARen.pdf</p>
29	Самоа	<p align="center">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>44.1А дугаар зүйл. Хууль тогтоох Ассамблейн нийт гишүүдийн 10-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүд байна.</p> <p>44.1 дугаар зүйл. Хууль тогтоох Ассамблей нь: а.хуульд тухай бүр заасан тосгон, дэд тосгодоос бүрдсэн нэр бүхий 41 сонгуулийн тойрог тус бүрээс дангаараа сонгогдсон 41 гишүүн, аа.хуульд тухай бүр заасан 6 тойрогт нэмэлтээр сонгогдох 6 гишүүн, б.хуульд заасан хотын 2 сонгуулийн тойргоос тус бүр сонгогдох 2 гишүүдээс бүрдэнэ. Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Samoa_2017?lang=en</p>
30	Сан-Марино	<p>Ерөнхий зөвлөл нь 60 гишүүнтэй.</p> <p>Сонгуулийн зорилгоор тойргийн хилийг тусгайлан тогтоодог эсэх: Сан Марино Улс нь олон мандаттай, сонгуулийн нэг тойрогтой. Эх сурвалж: <i>Сонгуулийн тухай хуулийн 10-р зүйл.</i></p>
31	Сент-Винсент ба Гренадин	<p align="center">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>24.1.Ассамблейн бүрэлдэхүүн: а.Үндсэн хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу сонгогдох төлөөлөгчдийн тоо нь, мөн хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу тухайн үед байгуулагдсан сонгуулийн тойргийн тоотой дүйнэ. 33.1.Төлөөлөгчдийг сонгох зорилгоор, Сент-Винсентийн газар нутгийг Тойргийн хил тогтоох комиссын шийдвэрээр тогтоосон хил хязгаар бүхий 13 тойрогт хуваана. 33.2.Сонгуулийн хил тогтоох комиссын шийдвэрийн дагуу сонгуулийн тойрог бүр ижил тооны оршин суугчаас бүрдэх хэдий ч дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:</p>

		<p>а.Хүн амын нягтрал, ялангуяа цөөн хүн амтай хөдөө орон нутгийн сонгогчдыг хангалттай төлөөлөх;</p> <p>б.Холбоо харилцааны хэрэглэгдэхүүн;</p> <p>в.Газарзүйн онцлог;</p> <p>г.Засаг захиргааны нутаг дэвсгэрийн хил хязгаар.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/St_Vincent_and_the_Grenadines_1979?lang=en</p> <p>ТАЙЛБАР: Ассамблей нь одоогоор 23 гишүүдээс бүрдэж байна. Үүнд, хүн амаас сонгогдсон 15 төлөөлөгч, 6 сенатор, Ерөнхий прокурор (Attorney general) болон Спикер. Ерөнхий прокурор төрийн албан хаагч, Спикер нь Ассамблейгаас гадуур сонгогдох боломжтой хэдий ч Ассамблейн гишүүдэд тооцогддог.</p> <p>Эх сурвалж: http://assembly.gov.vc/assembly/index.php/composition-of-parliament-sp-974994418</p>
32	Сент-Китс ба Невис	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>26 дугаар зүйл. Үндэсний Ассамблей</p> <p>1.Үндэсний Ассамблей нь бүрдэнэ: 50-р зүйлд заасны дагуу тухайн үеийн Төлөөлөгчдийн тоо нь сонгуулийн тойргийн тоотой дүйцнэ.</p> <p>50 дугаар зүйл.Тойргийн хил хязгаарыг хянах</p> <p>Тойргийн хил тогтоох комисс нь Сент Кристофер болон Невисийн сонгуулийн тойргийн тоо болон тойргийн хил хязгаарыг хянан үзэж Ерөнхий захирагчид дараах байдлаар тайлагнана:</p> <p>а.тойргийг дахин хуваарилах шаардлагатай;</p> <p>б.одоогийн байгаа тойргийн тоо болон хил хязгаарыг өөрчлөх шаардлагагүй.</p> <p>Энэ зүйлийн эхний хэсэгт дурдсан тайланг Комисс 2-оос багагүй, 5-аас ихгүй жилийн давтамжтай тайлагнана.</p> <p>Өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд Ерөнхий сайд өөрчлөлт хийх болсон шатгаан, өөрчлөх төслийн хамт Үндэсний Ассамблейд танилцуулан, хэлэлцүүлнэ.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/St_Kitts_and_Nevis_1983?lang=en</p>
33	Серби	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>100 дугаар зүйл. Хуульд заасны дагуу Үндэсний Ассамблей нь 250 гишүүдээс бүрдэнэ.</p> <p>Хуулиар Үндэсний Ассамблей нь хүйсийн төлөөлөл болон тэгш байдал, үндэсний цөөнхийн төлөөллийг хангана.</p> <p>Эх сурвалж: http://www.parlament.gov.rs/upload/documents/Constitution_%20of_Serbia_pdf.pdf</p> <p style="text-align: center;">ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>73 дугаар зүйл. Сонгуулийн жагсаалтад, нэр дэвшигчдийн 40%-аас доошгүй нь төлөөлөл нь хангалтгүй хүйсийн гишүүд байх ёстой. Ингэснээр жагсаалтын таван нэр дэвшигч тутамд (эхний 5 нэр дэвшигч, дараагийн 5 нэр дэвшигч гэж явсаар жагсаалт дуустал) ижил хүйсийн 3 нэр дэвшигч болон өөр хүйсийн 2 нэр дэвшигч гэсэн дарааллын дагуу бичигдэнэ.</p> <p>Сонгуулийн зорилгоор тойргийн хилийг тусгайлан тогтоодог эсэх:</p> <p>Серби Улсад парламентын гишүүд нь нэг тойргоор сонгогдоно.</p> <p>Эх сурвалж: <i>Парламентын гишүүний сонгуулийн тухай хуулийн 5-р зүйл.</i></p>
34	Словак	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>73 дугаар зүйл. Словак Улсын Үндэсний Зөвлөл нь 150 гишүүнтэй байна.</p>

		<p>11 дүгээр зүйл. Словак Улсын нутаг дэвсгэр нь сонгуулийн нэг тойрогтой.</p> <p>12 дугаар зүйл. Хотын захирагч сонгуулийн санал авах өдрөөс 70 хоногийн өмнө санал авах байруудыг бэлдэнэ. Санал өгөх нэг хэсэгт ойролцоогоор 1000 сонгогч санал өгнө.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Slovakia_2017?lang=en</p>
35	Соломоны арлууд	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>47 дугаар зүйл. Парламентын бүрэлдэхүүн</p> <p>2.Энэ Үндсэн хуулийн 54 (1)-р зүйлд заасан тойрог бүрээс нэг гишүүн парламентын гишүүнээр сонгогдоно.</p> <p>Парламент нь нэг танхимтай, 50 гишүүнтэй.</p> <p>54 дүгээр зүйл. Сонгуулийн тойргууд</p> <p>1.Парламентын гишүүдийг сонгох зорилгоор Соломоны арлууд нь тавиас цөөнгүй, далаас ихгүй сонгуулийн тойргуудад хуваагдана. Тойрог бүр нь энэ зүйлийн 4-р хэсэгт зааснаар Тойргийн хил тогтоох комиссын санал болгосны дагуу парламентаас баталсан хил хязгаартай байна.</p> <p>2.Тойргийн хил тогтоох комисс нь:</p> <p style="padding-left: 20px;">а.Шаардлагатай тохиолдолд өмнөх шийдвэр гарснаас 10-аас ихгүй жилийн дотор тойргийн тоо болон тойргийн хилийг дахин хянах нь зүйтэй гэж үзвэл хянан үзнэ;</p> <p style="padding-left: 20px;">б.Тойргийн тоо болон тойргийн хилийг өөрчлөх нь зүйтэй гэж үзвэл өөрчлөлтийн талаар парламентад санал гаргана.</p> <p>3.Тойргийн хил тогтоох комисс нь парламентад санал гаргахдаа тойргийн оршин суугчдын тоо ойролцоо байх зарчмыг баримтална. Ингэхдээ хүн амын тархалт, харилцаа холбооны хэрэгслүүд болон үндэстний харьяалал зэргийг харгалзан үзнэ.</p> <p>4.Парламент нь Тойргийн хил тогтоох комиссын саналыг хүлээн авах, эсхүл татгалзах шийдвэр гаргах хэдий ч өөрчлөх эрхгүй. Хэрэв батлагдсан тохиолдолд парламент тарснаас хойш тухайн шийдвэр хүчин төгөлдөр болно.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Solomon_Islands_2018?lang=en</p>
36	Тувалу	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>82.3.Парламентын гишүүний тоо арван хоёроос доошгүй байна.</p> <p>82.4.Парламентын гишүүдийг сонгох зорилгоор Парламентын хуулийн дагуу буюу түүнд тогтоосон (а) хил хязгаар; (б) сонгогдсон төлөөлөгчдийн тоог харгалзан сонгуулийн тойргийг байгуулна.</p> <p>83.Сонгуулийн хуваарилалтын зарчим (2) дэд хэсгийн (1), 82 дугаар зүйл (Парламентын бүрэлдэхүүн)-д заасны дагуу хуулийн төсөл нь боломжтой бол Парламентын гишүүн бүр ойролцоогоор ижил тооны сонгогчдыг төлөөлөх зарчимд тулгуурлана. Гэхдээ Тувалу Улсын хувьд дараах зүйлийг харгалзан үзэх шаардлагатай:</p> <p style="padding-left: 20px;">(а) газарзүйн онцлог;</p> <p style="padding-left: 20px;">(б) өөр өөр нутаг дэвсгэрийн ашиг сонирхол ба харилцаа - (i) нийтлэг зүйлс; эсхүл (ii) нийтлэг бус зүйлс;</p> <p style="padding-left: 20px;">(в) одоо байгаа засаг захиргааны болон уламжлалт бүс нутгийн хил хязгаар;</p> <p style="padding-left: 20px;">(г) харилцаа холбооны хэрэглэгдэхүүн;</p> <p style="padding-left: 20px;">(д) хүн амын нягтаршил, шилжилт хөдөлгөөн;</p> <p style="padding-left: 20px;">(е) энэ зорилгоор Парламентын тухай хуульд заасан бусад хүчин зүйлс.</p> <p>Эх сурвалж: http://tuvalu-legislation.tv/cms/images/LEGISLATION/PRINCIPAL/1986/1986-0001/ConstitutionofTuvalu_1.pdf</p>

		<p align="center">СОНГУУЛИЙН (ПАРЛАМЕНТЫН) ТУХАЙ ХУУЛЬ 2008</p> <p>3 дугаар зүйл. Энэхүү хууль болон Үндсэн хуулийн 82(4) ба (5) болон 83 дугаар зүйлд зааснаар Тувалу нь нэрээрээ тодорхойлогдсон бүс нутгуудаас бүрдэх 8 сонгуулийн тойрогт хуваагдана. 1 дүгээр хавсралтад холбогдох гишүүдийн тоог оруулна.</p> <p>Хавсралт 1.</p> <ol style="list-style-type: none"> 1. Funafuti 2 (сонгогдсон төлөөлөгчийн тоо); 2. Nanumanga 2; 3. Nanumea 2; 4. Nui 2; 5. Niutao 2; 6. Nukufetau 2; 7. Nukulaelae 1; 8. Vaitupu 2. <p>Эх сурвалж: https://tuvalu-legislation.tv/cms/images/LEGISLATION/PRINCIPAL/1980/1980-0002/ElectoralProvisionsParliamentAct_1.pdf</p>
37	Унгар	<p>ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ (ССIII, 2011)</p> <p>3 дугаар зүйл.</p> <p>(1) Парламентын гишүүдийн тоо 199 байна.</p> <p>(2) Парламентын 106 гишүүнийг нэг мандаттай тойргоос, 93 гишүүнийг үндэсний хэмжээний жагсаалтаас сонгоно.</p> <p>ТАЙЛБАР: Жагсаалтыг хавсаргав.</p> <p>Үндэсний хэмжээний жагсаалт нь намын, эсхүл үндэсний цөөнхийн нэр дэвшигчдийн жагсаалт байж болно.</p> <p>Эх сурвалж: https://www.parlament.hu/web/house-of-the-national-assembly/election-of-the-members-of-parliament</p> <p>4 дүгээр зүйл.</p> <p>(2) Нэг мандаттай тойргийг байгуулахад а) мужууд болон Будапештын хилийг давахгүй байхаар; б) зэргэлдээ бүсийг байгуулах байдлаар; в) сонгогчдын тоо ойролцоогоор ижил байхаар байгуулна.</p> <p>(3) Хэрэв сонгогчдын тоо нэг мандаттай тойргийн сонгогчдын дунджаас давсан бол Будапештын дүүргүүд болон аль ч хот тосгоныг нэг мандаттай хоёр буюу түүнээс дээш тойрогт хувааж болно.</p> <p>(4) (2)а, б)-д заасан заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд аль ч тойргийн сонгогчдын тоо, газарзүйн байршил, үндэс угсаа, түүх, шашин шүтлэг болон орон нутгийн бусад онцлог, хүн амын шилжилт хөдөлгөөнийг харгалзан нэг мандаттай тойргийн сонгогчдын улсын арифметик дунджаас зөвхөн арван таван хувиас дээш бага зэрэг зөрүүтэй байж болно. (15% (онцгой тохиолдолд 20% хүртэл)</p> <p>(5) Муж болон Будапешт дахь нэг мандаттай тойргийн тоог 1-р хавсралтад, тэдгээрийн серийн дугаар, суудал, нутаг дэвсгэрийн хуваарийг 2-р хавсралтад тусгана.</p> <p>(6) (4)-д дурдсан хэлбэлзэл 20 хувиас хэтэрсэн бол Парламент нь 2-р хавсралтад өөрчлөлт оруулна.</p> <p>Эх сурвалж: http://nit.hu/cgi_bin/njt_doc.cgi?docid=142940.283327 https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2014)037-e</p>
38	Фиж	<p align="center">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>53 дугаар зүйл.</p> <p>Парламентын гишүүдийн сонгууль нь нийт сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч бүр нэг сонголт хийхээр, сонголт бүр адил үнэ цэнэтэй байх нөхцөл бүхий пропорционал төлөөллийн олон мандаттай нээлттэй жагсаалтын системээр явагдана.</p>

		<p>54 дүгээр зүйл.</p> <p>(1) Парламент нь энэ Үндсэн хуулийн дагуу бүх нийтийн сонгуулиар сонгогдсон 50 гишүүнээс бүрдэнэ.</p> <p>(2) Энэхүү Үндсэн хуульд заасны дагуу анхны бүх нийтийн сонгууль бүрийн дараа явуулж буй бүх нийтийн ерөнхий сонгуулиас доод тал нь 1 жилийн өмнө Сонгуулийн хороо нь парламентын бүрэлдэхүүнийг хянан үзэх ба шаардлагатай бол нэмэгдүүлж, эсхүл цөөрүүлж болно. Парламентын гишүүдийн тоог Фижи улсын хүн амын тоонд харьцуулсан харьцаа нь энэхүү Үндсэн хуулийн дагуу явагдсан анхны бүх нийтийн сонгуулийн өдөр Фижи улсын парламентын гишүүдийн тоог хүн амын тоонд харьцуулсан харьцаатай ижил байна.</p> <p>Эх сурвалж: https://aceproject.org/ero-en/regions/pacific/FJ/fiji-constitution-2013/</p>
<p>39</p>	<p>Финланд</p>	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>24 дүгээр зүйл. Парламент нь нэг танхимтай. Танхим нь 200 төлөөлөгчөөс бүрдэх ба 4 жилийн хугацаатай сонгогдоно.</p> <p>25 дугаар зүйл. Парламентын сонгуулиар Финланд иргэдийн тоонд үндэслэн улсын нутаг дэвсгэрийг хамгийн багадаа 12, хамгийн ихдээ 18 тойрогт хуваана. Тодруулбал, Аландын арлууд нь нэг төлөөлөгчийг сонгох зорилгоор өөрсдийн тойргийг байгуулна.</p> <p>Эх сурвалж: https://faolex.fao.org/docs/pdf/fin134323.pdf https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL(2017)023rev-bil</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>6 дугаар зүйл. Аланд (Парламент)-ын сонгуулийн тойргийг эс тооцвол бусад тойрогт нийт 199 төлөөлөгч пропорционал системээр сонгогдоно. Аландын сонгуулийн тойрогт нэг төлөөлөгчийг сүүлд нь тогтоосон журмаар сонгоно.</p> <p>Аландын сонгуулийн тойргийг эс тооцвол парламентын суудлыг сонгуулийн тойрогт оршин суугч Финланд иргэдийн тоонд үндэслэн сонгууль болохоос зургаан сарын өмнө, тухайн сарын сүүлийн өдөр хуваарилна. Хуваарилалтыг хийхдээ сонгуулийн тойрог тус бүрийн Финландын иргэдийн тоог бүх сонгуулийн тойргийн Финландын иргэдийн нийлбэр тоонд хувааж, энэ тоог 199-өөр үржүүлэх байдлаар хийнэ. Сонгуулийн тойрог бүрийн парламентын мандатын тоо нь дээрх тооцооллоос гаргаж авсан бүхэл тоонд харгалзах ёстой. Хэрэв бүх суудлыг ийм байдлаар хуваагаагүй бол үлдсэн суудлыг сонгуулийн тойргуудад дээрх тооцооллоос гарсан бутархайн хуваарийн буурах дарааллаар хуваана.</p> <p>Эх сурвалж: https://constitutionnet.org/sites/default/files/Election%20Act%201998%2C%20%20amended%202004.pdf</p>
<p>40</p>	<p>Хорват</p>	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>71.Хорват Улсын Парламент 100-аас доошгүй, 160-аас илүүгүй гишүүнтэй байна. Гишүүд нь бүх нийтээрээ, шууд, тэгш сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгогдоно.</p> <p>72.Хорват Улсын Парламентын гишүүдийн тоо, тэдгээрийг сонгох нөхцөл, журмыг хуулиар зохицуулна.</p> <p>Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Croatia_2013?lang=en</p> <p style="text-align: center;">ХОРВАТЫН ПАРЛАМЕНТЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>39.Сонгуулийн тойргийг Хорватын Парламентад төлөөлөгч сонгох сонгуулийн тойргийн тухай хуульд заасан бөгөөд сонгуулийн тойргийн сонгогчдын тооны зөрүү ±5 хувиас ихгүй байхаар зохицуулна. Сонгуулийн тойргийг тодорхойлохдоо хуулиар тогтоосон Бүгд Найрамдах Хорват Улсын муж, хот, хотын захиргаадын нутаг дэвсгэрийг аль болох их хэмжээгээр харгалзан үзнэ.</p>

		<p>Эх сурвалж: https://mvep.gov.hr/UserDocsImages/files/file/dokumenti/prevodenje/zakoni/21-Zakon-o-izmjename-i-dopunama-Zakona-o-izboru-zastupnika-u-Hrvatski-sabor-NN-19-15-ENG.pdf</p>
41	Швед	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>Бүлэг 3. Риксдаг 1 дүгээр хэсэг. Риксдагийн бүрэлдэхүүн 2 дугаар зүйл. Риксдаг (Парламент) нь нэг танхимтай, 349 гишүүнтэй. Бүлэг 4. Сонгуулийн тойрог 5 дугаар зүйл. Риксдагийг бүрдүүлэх сонгуулийг зохион байгуулахад Хаант улс нь сонгуулийн тойргуудад хуваагдана. 5 дугаар хэсэг. Тойргуудад суудал хуваарилах 6 дугаар зүйл. Риксдагийн нийт суудлын 310 суудал нь тогтсон, 39 нь нэмэлт суудал (adjustment seats) байна. Тойргийн тогтсон мандатыг тойрог тус бүрийн сонгуулийн эрх бүхий иргэдийн тоо болон Хаант Улс даяарх сонгуулийн эрх бүхий иргэдийн тоонд харьцуулсан харьцаанд үндэслэн тогтооно. Тойргуудын мандатын хуваарилалтыг дөрвөн жилээр тогтооно. Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Sweden_2012?lang=en ТАЙЛБАР: 310 гишүүд нь олон мандаттай 29 тойргоос сонгогдоно. 39 нэмэлт суудлыг намуудад хуваарилсны дараа тойргуудад хуваарилдаг байна.³² Эх сурвалж: https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL(2017)023_rev-bil Сонгуулийн зорилгоор тойргийн хилийг тусгайлан тогтоодог эсэх: Риксдагийн сонгуульд Швед Улс нь 29 тойрогт хуваагддаг. Муж бүр нэг тойрог болдог, харин Стокгольм 2, Скане 4, Вастра Готаланд 5 тойрогт тус тус хуваагддаг байна. Эх сурвалж: <i>Сонгуулийн тухай хуулийн 4-р бүлэг, 1,2-р хэсэг</i> Тойргийн хилийг тогтоох шалгуур: Готланд арал нь Швед Улсын хамгийн том арал тул бүртгэлтэй оршин суугчдын тооноос үл хамааран Риксдагийн сонгуульд 1 тойрогт тооцогддог байна. Эх сурвалж: <i>Сонгуулийн тухай хуулийн 4-р бүлэг, 1-р хэсэг</i></p>
42	Шинэ Зеланд	<p>Төлөөлөгчдийн танхим нь 120 гишүүнтэй. 120 гишүүнийг бүх нийтийн, шууд санал хураалтаар сонгоно. Парламентын 65 гишүүн нь нийт сонгогчдыг төлөөлдөг бол, 7 гишүүн Маори үндэстний төлөөлөл, үлдсэн 48 нь намын жагсаалтаар сонгогддог.</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>35(3) дугаар зүйл. а/Өмнөд арал нь ерөнхий сонгуулийн 16 тойрогт хуваагдана. б/Өмнөд арлын сонгуулийн насны нийт хүн амыг 16-д хуваах ба ингэснээр олж авсан коэффициент нь Өмнөд арлын квот болно. в/Хойд арлын сонгуулийн ерөнхий хүн амыг Өмнөд арлын квотоор хуваах бөгөөд ингэснээр олж авсан коэффициент нь Хойд арлын сонгуулийн ерөнхий тойргийн тоо болно. Хэрэв энэ хэсэг нь бутархайг агуулж байгаа бол энэ нь хагасаас илүүгүй тохиолдолд энэ хэсгийг тооцохгүй бөгөөд энэ тохиолдолд сонгуулийн ерөнхий тойргийн тоо нь тухайн хэсгийн дараачийн бүхэл тоо байна.</p>

³² <https://aceproject.org/ace-en/topics/bd/bdb/bdb01/bdb01a>

		<p>г/Хойд арлын квотыг (в) хэсэгт заасны дагуу тухайн арлын сонгуулийн ерөнхий хүн амыг тухайн арлын сонгуулийн ерөнхий тойргийн тоонд хуваах замаар тогтооно.</p> <p>д/Арал бүрийн сонгуулийн ерөнхий тойрог тус бүрийн хилийг тогтоох үед сонгуулийн ерөнхий тойргийн нийт хүн ам, е, ё дахь хэсгийн заалтуудыг дагаж мөрдөнө. 36 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн заалт нь тухайн арлын квоттой тэнцүү байна.</p> <p>е/сонгуулийн хэд хэдэн ерөнхий тойргийг дараах зүйлсийг харгалзана.</p> <ul style="list-style-type: none"> - тойргийн одоо байгаа хил - нэгдмэл сонирхлын бүлэг (Маоригийн сонгуулийн тойрогт овгийн харьяаллыг оруулна); - харилцаа холбооны хэрэгсэл (зам, утасны үйлчилгээ гэх мэт); - газарзүйн онцлог (уул, ус); <p>-эдгээр тойргийн нийт сонгуулийн насны хүн амын урьдчилан таамагласан өөрчлөлтүүд</p> <p>ё/Сонгуулийн ерөнхий тойрог нь хойд аралд хэсэгчлэн, өмнөд аралд хэсэгчлэн байрлах ёсгүй.</p> <p>Сонгуулийн ерөнхий тойрог гэдэг нь Маоригийн сонгуулийн тойргоос бусад сонгуулийн тойргийг хэлнэ.</p> <p>Сонгуулийн ерөнхий хүн ам гэдэг нь Маори улсын сонгуулийн хүн амаас бусад хүн ам, орон сууцны сүүлийн үеийн тооллогоор харуулсан энгийн оршин суугчдын нийт хүн амыг хэлнэ.</p> <p>36 дугаар зүйл. Квотыг тохируулах зөвшөөрөл</p> <p>Хорооны үзэж байгаагаар сонгуулийн ерөнхий тойргийг 35-р зүйлд заасан үндэслэлийн дагуу квотыг яг багтаахын тулд бүрдүүлэх боломжгүй бол Хороо аль ч сонгуулийн ерөнхий тойрогт нэмэх, хасах замаар нэмэгдэл гаргаж болно. Нийт сонгуулийн хүн амын 5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр.</p> <p>45 дугаар зүйл. Маоригийн төлөөлөл</p> <p>а/ Шинэ Зеландын Маоригийн сонгуулийн хүн амыг 35(3)(b) хэсэгт заасны дагуу тодорхойлсон Өмнөд арал дахь ерөнхий сонгуулийн тойргийн квотоор хуваана, ингэснээр олж авсан хувь хэмжээ нь Маоригийн сонгуулийн тойргийн тоо байна:</p> <p>б/Хэрэв энэ хэсэг нь бутархайг агуулж байгаа бол энэ нь хагасаас хэтрээгүй тохиолдолд бутархайг тооцохгүй бөгөөд энэ тохиолдолд Маоригийн сонгуулийн тойргийн тоо нь тухайн хэсгийн дараачийн бүхэл тоо байна:</p> <p>в/ дэд хэсгийг харгалзан Маоригийн сонгуулийн тойрог тус бүр нь Маоригийн сонгуулийн хүн амын тэнцүү тооны гишүүдийг агуулна.</p> <p>Маоригийн сонгуулийн хүн амыг Маоригийн сонгуулийн тойргийн хооронд тэнцүү хуваахдаа дараах зүйлийг харгалзан үзнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Маоригийн сонгуулийн тойргийн одоо байгаа хил хязгаар; - маори хүмүүс болон маори овгийн гишүүдийн нэгдмэл сонирхлын бүлэг; - харилцаа холбооны хэрэгсэл; - топографийн онцлог; - эдгээр дүүргүүдийн маоричуудын сонгуулийн хүн амын амьдралын туршид урьдчилан тооцоолсон аливаа өөрчлөлт. <p>Эх сурвалж:</p> <p>https://www.parliament.nz/en/mps-and-electoralates/</p> <p>http://aceproject.org/ero-en/regions/pacific/NZ/new-zealand-electoral-act-2010/view</p>
--	--	--

<p>43</p>	<p>Эстони</p>	<p style="text-align: center;">ҮНДСЭН ХУУЛЬ</p> <p>60 дугаар зүйл. Рийгикогу нь зуун нэгэн гишүүнээс бүрдэнэ. Рийгикогугийн гишүүд пропорционал зарчмаар чөлөөт сонгуулиар сонгогдоно. Сонгууль нь бүх нийтийн, тэгш, шууд, нууц санал хураалтаар явагдана. Эх сурвалж: https://www.constituteproject.org/constitution/Estonia_2015.pdf?lang=en</p> <p style="text-align: center;">СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>6 дугаар зүйл. Сонгуулийн тойрог Рийгикогугийн сонгууль нь олон мандаттай сонгуулийн 12 тойрогт явагдана:</p> <ul style="list-style-type: none"> - сонгуулийн 1 дүгээр тойрог: Таллин хотын Хааберсти, Пхжа-Таллин, Кристиине дүүрэг; - сонгуулийн 2 дугаар тойрог: Таллин хотын Кесклинн, Ласнамае, Пирита дүүргүүд; - сонгуулийн 3 дугаар тойрог: Таллин хотын Мустамае болон Номме дүүрэг; - сонгуулийн 4 дүгээр тойрог: Харжу муж (Таллиннаас бусад) болон Рапла тойрог; - сонгуулийн 5 дугаар тойрог: Хииу муж, Ляэн муж, Сааре муж; - сонгуулийн 6 дугаар тойрог: Лаэне-Виру тойрог; - сонгуулийн 7 дугаар тойрог: Айда-Виру тойрог; - сонгуулийн 8 дугаар тойрог: Ярва муж ба Вилжанди тойрог; - сонгуулийн 9 дүгээр тойрог: Йогева муж ба Тарту муж (Тарту хотоос бусад); - сонгуулийн 10 дугаар тойрог: Тарту хот; - сонгуулийн 11 дүгээр тойрог: Вору, Валга, Полва муж; - сонгуулийн 12 дугаар тойрог: Пярну тойрог. <p>7 дугаар зүйл. (1) Үндэсний сонгуулийн хороо нь тогтоолоор сонгуулийн тойргуудад мандатын хуваарилалтыг дараах байдлаар хийнэ: 1) нийт сонгогчдын тоог 101-д (гишүүдийн тоо) хуваана; 2) сонгуулийн тойргийн сонгогчдын тоог энэ хэсгийн 1-д заасан тооцооллын үндсэн дээр гарсан тоонд хуваана; 3) энэ хэсгийн 2-т заасан тооцооллын үр дүнд гарсан тоотой тохируулан сонгуулийн тойрог бүрд тодорхой тооны мандат олгоно. 4) энэ дэд хэсгийн 3-т заасны дагуу хуваарилагдаагүй мандатыг энэ дэд хэсгийн 2)-д заасан тооцооллын дүнд гарсан тооны бутархайг ашиглан хамгийн их үлдэгдлийн дүрмийг үндэслэж хуваарилна. Эх сурвалж: https://www.riiqiteataja.ee/en/eli/506052016002/consolide https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL(2017)023rev-bil</p>
-----------	----------------------	---

ХАВСРАЛТУУД**Хавсралт 1. Кирибати Улсын Манеаба ни Маунгатабу (Парламент)-гийн сонгуулийн торгийн хуваарь**

(Кирибати Улсын Сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан сонгуулийн 23 тойргийн хуваарийн заасан 1 дүгээр хүснэгт)

№	Сонгуулийн тойрог	Хамаарах нутаг дэвсгэр	Гишүүдийн тоо
1	Makin	The island of Makin	2
2	Butaritari	The island of Butaritari	2
3	Marakei	The island of Marakei	2
4	Abaiang	The island of Abaiang	3
5	Betio	The islet of Betio	3
6	Tarawa Teinainano	The area of authority of Teinainano Urban Council together with the islet of Tanaea	3
7	Rural Tarawa	The part of Tarawa Atoll not included in the Electoral Districts of Betio and Tarawa Teinainano	3
8	Banaba	Banaba	1
9	Maiana	The island of Maiana	2
10	Abemama	The island of Abemama	2
11	Aranuka	The island of Aranuka	1
12	Kuria	The island of Kuria	1
13	Nonouti	The island of Nonouti	2
14	North Tabiteuea	The part of Tabiteuea Atoll extending from the northern most point to and including the islet of Nauketai.	2
15	South Tabiteuea	The part of Tabiteuea Atoll not included in the North Tabiteuea electoral District	1
16	Onotoa	The island of Onotoa	2
17	Beru	The island of Beru	2
18	Nikunau	The island of Nikunau	2
19	Tamana	The island of Tamana	1
20	Arorae	The island of Arorae	1
21	Washington	Washington Island	1
22	Fanning	Fanning island	2
23	Kiritimati	Kiritimati	3

Хавсралт 2. Македон Улсын сонгуулийн тойргийн хуваарь

Македон Улсын Сонгуулийн тухай хуулийн 175 дугаар зүйлийн 175.1 дэх хэсэгт заасан сонгуулийн тойрог³³

ELECTORAL DISTRICT 1			
Municipality of KARPOS	polling stations from	2592	to 2653
Municipality of KISELA VODA	polling stations from	2425	to 2427
Municipality of KISELA VODA	polling stations from	2654	to 2672
Municipality of KISELA VODA	polling stations from	2739	to 2751
Municipality of KISELA VODA	polling stations from	2761	to 2771
Municipality of KISELA VODA	polling stations from	2774	to 2795
Municipality of CENTAR	polling stations from	2796	to 2818
Municipality of CENTAR	polling stations from	2822	to 2822
Municipality of CENTAR	polling stations from	2828	to 2828
Municipality of CENTAR	polling stations from	2830	to 2868
Municipality of CENTAR	polling stations from	2870	to 2871
Municipality of CAIR	polling stations from	2819	to 2821
Municipality of CAIR	polling stations from	2823	to 2827
Municipality of CAIR	polling stations from	2829	to 2829
Municipality of CAIR	polling stations from	2869	to 2869
Municipality of CAIR	polling stations from	2872	to 2898
Municipality of AERODROM	polling stations from	2673	to 2738
Municipality of AERODROM	polling stations from	2752	to 2760
Municipality of AERODROM	polling stations from	2772	to 2773
Municipality of SARAJ	polling stations from	2428	to 2461
Municipality of MAKEDONSKI BROD	polling stations from	0224	to 0274
Municipality of SOKPISITE	polling stations from	2412	to 2424
Municipality of STUDENICANI	polling stations from	2341	to 2361
ELECTORAL DISTRICT 2			
Municipality of GAZI BABA	polling stations from	2332	to 2332
Municipality of GAZI BABA	polling stations from	2476	to 2552
Municipality of GJORCE PETROV	polling stations from	2553	to 2591
Municipality of CAIR	polling stations from	2899	to 2903
Municipality of CAIR	polling stations from	2916	to 2917
Municipality of CAIR	polling stations from	2922	to 2922
Municipality of CAIR	polling stations from	2924	to 2928
Municipality of CAIR	polling stations from	2934	to 2945
Municipality of SUTO ORIZARI	polling stations from	2955	to 2973
Municipality of BUTEL	polling stations from	2904	to 2915
Municipality of BUTEL	polling stations from	2918	to 2921
Municipality of BUTEL	polling stations from	2923	to 2923
Municipality of BUTEL	polling stations from	2929	to 2933
Municipality of BUTEL	polling stations from	2946	to 2954
Municipality of ARACINOVO	polling stations from	2333	to 2340
Municipality of KUMANOVO	polling stations from	0995	to 1104
Municipality of LIPKOVO	polling stations from	1105	to 1130
Municipality of STARO NAGORICANE	polling stations from	1156	to 1186
Municipality of CUCER – SANDEVO	polling stations from	2462	to 2475
ELECTORAL DISTRICT 3			
Municipality of BEROVO	polling stations from	0001	to 0016
Municipality of VELES	polling stations from	2135	to 2203
Municipality of VELES	polling stations from	2207	to 2210
Municipality of VINICA	polling stations from	0303	to 0332
Municipality of GRADSKO	polling stations from	2217	to 2226
Municipality of DELCEVO	polling stations from	0572	to 0604

³³ [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2013\)013-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2013)013-e)

Municipality of ZELENIKOVO	polling stations from	2362	to 2376
Municipality of ZRNOVCI	polling stations from	0888	to 0891
Municipality of ILINDEN	polling stations from	2393	to 2411
Municipality of KARBINCI	polling stations from	2316	to 2331
Municipality of KOCANI	polling stations from	0830	to 0874
Municipality of KOCANI	polling stations from	0892	to 0902
Municipality of KRATOVO	polling stations from	0903	to 0937
Municipality of KRIVA PALANKA	polling stations from	0938	to 0981
Municipality of KUMANOVO	polling stations from	1131	to 1141
Municipality of KUMANOVO	polling stations from	1144	to 1150
Municipality of LOZOVO	polling stations from	1704	to 1712
Municipality of MAKEDONSKAKAMENICA	polling stations from	0605	to 0618
Municipality of PETROVEC	polling stations from	2377	to 2392
Municipality of PEHCEVO	polling stations from	0017	to 0025
Municipality of PROBISTIP	polling stations from	1530	to 1573
Municipality of RANKOVCE	polling stations from	0982	to 0994
Municipality of SVETI NIKOLE	polling stations from	1671	to 1703
Municipality of STARO NAGORICANE	polling stations from	1142	to 1143
Municipality of STARO NAGORICANE	polling stations from	1151	to 1155
Municipality of CASKA	polling stations from	2204	to 2206
Municipality of CASKA	polling stations from	2211	to 2216
Municipality of CASKA	polling stations from	2227	to 2246
Municipality of CESINOVO -OBLESEVO	polling stations from	0875	to 0887
Municipality of STIP	polling stations from	2247	to 2315

ELECTORAL DISTRICT 4

Municipality of BITOLA	polling stations from	0194	to 0204
Municipality of BOGDANCI	polling stations from	0368	to 0377
Municipality of BOSILOVO	polling stations from	1811	to 1826
Municipality of BOSILOVO	polling stations from	1842	to 1843
Municipality of VALANDOVO	polling stations from	0280	to 0302
Municipality of VASILEVO	polling stations from	1794	to 1810
Municipality of GEVGELIJA	polling stations from	0333	to 0367
Municipality of DEMIR KAPIJA	polling stations from	1238	to 1248
Municipality of KAVADARCI	polling stations from	0659	to 0712
Municipality of KONCE	polling stations from	1608	to 1617
Municipality of KRIVOGASTANI	polling stations from	1508	to 1519
Municipality of MOGILA	polling stations from	0181	to 0193
Municipality of MOGILA	polling stations from	0214	to 0223
Municipality of NEGOTINO	polling stations from	1213	to 1237
Municipality of NOVACI	polling stations from	0158	to 0180
Municipality of NOVO SELO	polling stations from	1774	to 1792
Municipality of PRILEP	polling stations from	1350	to 1457
Municipality of PRILEP	polling stations from	1494	to 1507
Municipality of PRILEP	polling stations from	1520	to 1529
Municipality of RADOVIS	polling stations from	1574	to 1607
Municipality of RADOVIS	polling stations from	1618	to 1623
Municipality of ROSOMAN	polling stations from	0713	to 0722
Municipality of DOJRAN	polling stations from	0378	to 0385
Municipality of STRUMICA	polling stations from	1713	to 1773
Municipality of STRUMICA	polling stations from	1793	to 1793
Municipality of STRUMICA	polling stations from	1827	to 1841

ELECTORAL DISTRICT 5

Municipality of DEBAR	polling stations from	0549	0554
Municipality of CENTAR ZUPA	polling stations from	0557	0571
Municipality of DEBARCA	polling stations from	1314	to 1334
Municipality of DEBARCA	polling stations from	1343	to 1349
Municipality of BITOLA	polling stations from	0026	to 0157
Municipality of BITOLA	polling stations from	0205	to 0213
Municipality of VEVCANI	polling stations from	1921	to 1923

Municipality of VRANESTICA	polling stations from	0802	to 0813
Municipality of DEMIR HISAR	polling stations from	0619	to 0658
Municipality of DOLNENI	polling stations from	1209	to 1211
Municipality of DOLNENI	polling stations from	1458	to 1493
Municipality of DRUGOVO	polling stations from	0758	to 0781
Municipality of KICEVO	polling stations from	0723	to 0757
Municipality of KRIVOGASTANI	polling stations from	1212	to 1212
Municipality of KRUSEVO	polling stations from	1187	to 1208
Municipality of OHRID	polling stations from	1249	to 1313
Municipality of OHRID	polling stations from	1335	to 1342
Municipality of PLASNICA	polling stations from	0275	to 0279
Municipality of RESEN	polling stations from	1624	to 1670
Municipality of STRUGA	polling stations from	1844	to 1920
Municipality of STRUGA	polling stations from	2976	to 2976
ELECTORAL DISTRICT 6			
Municipality of BOGOVINJE	polling stations from	2050	to 2079
Municipality of BRVENICA	polling stations from	2032	to 2049
Municipality of VRAPCISTE	polling stations from	0436	to 0462
Municipality of GOSTIVAR	polling stations from	0386	to 0435
Municipality of GOSTIVAR	polling stations from	0480	to 0480
Municipality of GOSTIVAR	polling stations from	0499	to 0533
Municipality of GOSTIVAR	polling stations from	0782	to 0782
Municipality of GOSTIVAR	polling stations from	2974	to 2975
Municipality of DEBAR	polling stations from	0477	to 0477
Municipality of DEBAR	polling stations from	0534	to 0548
Municipality of DEBAR	polling stations from	0555	0556
Municipality of ZELINO	polling stations from	2089	to 2114
Municipality of ZAJAS	polling stations from	0814	to 0829
Municipality of JEGUNOVCE	polling stations from	2115	to 2134
Municipality of KICEVO	polling stations from	0783	to 0801
Municipality of KICEVO	polling stations from	0814	to 0829
Municipality of MAVROVO I ROSTUSA	polling stations from	0463	to 0476
Municipality of MAVROVO I ROSTUSA	polling stations from	0478	to 0479
Municipality of MAVROVO I ROSTUSA	polling stations from	0481	to 0498
Municipality of OSLOMEJ	polling stations from	0783	to 0801
Municipality of TEARCE	polling stations from	2007	to 2031
Municipality of TETOVO	polling stations from	1924	to 2006
Municipality TETOVO	polling stations from	2080	to 2088

Хавсралт 3. Унгар Улсын муж, нийслэл дэх бие даасан тойргийн тоо³⁴

№	Сонгуулийн тойрог	Тойргийн тоо
1	Budapest	18
2	Baranya	4
3	Bács-Kiskun	6
4	Békés	4
5	Borsod-Abaúj-Zemplén	7
6	Csongrád-Csanád	4
7	Fejér	5
8	Győr-Moson-Sopron	5
9	Hajdú-Bihar	6
10	Heves	3
11	Jász-Nagykun-Szolnok	4
12	Komárom-Esztergom	3
13	Nógrád	2
14	Pest	12
15	Somogy	4
16	Szabolcs-Szatmár-Bereg	6
17	Tolna	3
18	Vas	3
19	Veszprém	4
20	Zala	3
	Бүгд	106

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ (ШҮҮХ)-ЭЭР ХҮНИЙ ЭРХИЙН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Э.Дашзэвэг,
Д.Аюуш, П.Уранчимэг, Ц.Ариунаа*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. Үндсэн хуулийн шүүхийн хяналт ба хүний эрхийн хамгаалалт

1.1. Үндсэн хуулийн хяналт

2.2. Үндсэн хуулийн шүүхийн хяналт

2.3. Үндсэн хуулийн шүүхийн хяналтын хүний үндсэн эрхийн хамгаалалт

Хоёр. Үндсэн хуулийн шүүхээр хүний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэдэг зарим орны туршлага

2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

2.2. Бүгд Найрамдах Азербайжан Улс (Азербайжан)

2.3. Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

2.4. Тайландын Хаант Улс (Тайланд)

2.5. Бүгд Найрамдах Тажикстан Улс (Тажикстан)

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ЕЗВК	Европын зөвлөлийн Венецийн комисс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ХҮХШ	Холбооны Үндсэн Хуулийн Шүүх
БНТУ	Бүгд Найрамдах Тажикстан Улс
ҮХШТХ	Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль
ҮХШ	Үндсэн хуулийн шүүх

УДИРТГАЛ

“Үндсэн хуулийн цэц (шүүх)-ээр хүний эрхийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой бусад орнуудын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Үндсэн хуулийн хяналтын нэг хэлбэр болох шүүхийн хяналт, түүний хүний үндсэн эрхийн хамгаалалтын баталгаатай холбогдох хууль эрх зүйн зохицуулалтын талаарх гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү судалгаанд 177 орны тойм мэдээллийг оруулж тэдгээрээс эрх зүйн тогтолцоо, эдийн засаг, хөгжлийн түвшин, бүс нутаг зэрэг хүчин зүйлсийг харгалзан ХБНГУ, Азербайжан, БНСУ, Тайланд, Тажикстан улсуудыг сонгон эдгээр орнуудын Үндсэн хуулийн шүүхээр хүний эрхийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын талаарх асуудлыг хууль, эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судалсан болно. Мөн Үндсэн хуулийн шүүхийн хяналтын онол, арга зүй, харьцуулсан судалгааны талаарх холбогдох ном, товхимол, судалгаа, шинжилгээний материалуудын хүрээнд судалсан. Судалгаанд Европын Зөвлөлийн Венецийн комисс (Venice Commission)-ын болон Азийн Үндсэн хуулийн шүүх, адилтгах байгууллагуудын холбоо (Association of Asian Constitutional Courts and Equivalent Institutions (ААСС))-ноос гаргасан судалгаа, дүн шинжилгээний тайлан, холбогдох олон улсын гэрээ конвенц, судалгаанд авагдсан орнуудын мэдээлэл, хууль, эрх зүйн баримт бичгүүд болон бусад мэдээллийн эх сурвалжуудыг ашиглав.

Судалгааны бүтэц: Судалгаа нь Хураангуй болон үндсэн 2 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, Үндсэн хуулийн хяналт, Үндсэн хуулийн шүүхийн хяналтын ойлголт, онол, арга зүйн үндэслэл, Үндсэн хуулийн шүүхийн хяналтаар дамжуулан хүний үндсэн эрхийн хэрэгжилтийн баталгааг хангуулах талаарх, Хоёрдугаар хэсэгт, ХБНГУ, Азербайжан, БНСУ, Тайланд, Тажикстан улсуудын Үндсэн хуулийн шүүхээс хүний үндсэн эрхийн маргааныг хүлээн авч шийдвэрлэж байгаа хууль эрх зүйн орчны талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: Үндсэн хуулийн хяналт, Үндсэн хуулийн шүүхийн хяналт, Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Дээд шатны шүүх, Дээд шүүхийн тусгай танхим, Үндсэн хуулийн зөвлөл, Үндсэн хуулийн гомдол.

Key words: *Constitutional Review, Constitutional Judicial Review, Constitutional Court, Supreme Court, High Court, Special Senate of the high Court, Constitutional Council, Constitutional Complaint.*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

“Үндсэн хууль”-ийн мөн чанар нь нэг талаас, тухайн улс орны хамгийн тулгуур гол хууль болохын хувьд төрийн байгууламжийн үндсийг тогтоодог нийгмийн гэрээ боловч нөгөө талаас, түүнээс дутахааргүй бас нэг гол чухал мөн чанар нь иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөний баталгаа болж байдаг оршино. Иймээс энэ хоёр асуудлын бодит хэрэгжилтийн баталгаа нь үндсэн хуулийн дээд хяналтыг хэрэгжүүлдэг үндсэн хуулийн хяналтын тогтолцоо юм. Үндсэн хуулийн хяналт нь хууль тогтоох байгууллагын, шүүхийн, олон нийтийн гэсэн хэлбэрээр хэрэгждэг бөгөөд эдгээрээс хамгийн үр дүнтэй нь шүүхийн хяналт хэмээн үздэг.

Эрх мэдэл хуваарилах тогтолцоонд үндсэн хуулийн шүүхийн хяналт нь хууль тогтоох (парламентын) эрх мэдлийг хязгаарлах харилцаа байдаг тул хууль тогтоох байгууллагаас баталсан хуулийг хүчингүй болгох онцгой эрх бүхий, тусгай журмаар байгуулагдсан шүүхийн институт хэлбэртэй байдаг.

Үүсэл хөгжил, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтынх нь хувьд авч үзвэл улс орнуудад үндсэн хуулийн шүүхийн хяналтын Америкийн, Австрийн, Францын гэсэн үндсэн 3 загвар³⁵ бий болсон гэж үздэг бөгөөд бусад нь тэдгээрийн холимог болон хосолмол хэлбэртэй байна. Тоймловол:

Америкийн загвар: 1803 онд АНУ-ын Дээд шүүхээр хэлэлцэн шийдвэрлэсэн Марберигийн хэрэг болон Жон Маршаллын номлол дээр үндэслэгдсэн шүүхийн хяналтын загвар бөгөөд үндсэн хуулийн асуудлыг ердийн журмаар бүх шатны шүүх авч үздэг. Үндсэн хуулийн хяналтын төвлөрсөн бус (decentralized), сарнимал (diffuse) хяналтын систем;

Австрийн загвар: Х.Келзений 1920 оны загварт үндэслэсэн. Үндсэн хууль дээд хүчин чадалтай байх зарчимд суурилсан бөгөөд парламент төрийн эрх барих дээд байгууллага байх зарчимтай харилцан уялдаа холбоотой. Үндсэн хуулийн шүүхийн төвлөрсөн (concentrated) хяналтын систем;

Францын загвар: Францын Үндсэн хуулийн зөвлөл (Conseil Constitutionnel)-ийн загвар дээр үндэслэгдсэн. Францын Үндсэн хуулийн зөвлөл нь шүүн таслах чиг үүрэг хэрэгжүүлдэггүй бөгөөд парламентын нэг бүрэлдэхүүн хэсэг болдог. Энэ тогтолцоонд Үндсэн хуулийн хяналт нь урьдчилан сэргийлэх (consultative) шинж чанартай байдаг.

Одоогоор дэлхий дээр НҮБ-ын гишүүнээр бүртгэлтэй 193³⁶ улс оршин тогтнож байна. Тэдгээр улсуудаас 177³⁷ улсад үндсэн хуулийн шүүхийн хяналтыг ямар нэг хэлбэрээр хэрэгжүүлж байгаа бөгөөд 52 улс хүний эрхийн хамгаалалтын асуудлаар, 35 улс хүний эрхийн асуудлаар үндсэн хуулийн гомдол хүлээн авч шийдвэрлэдэг байна. *Дэлгэрэнгүйг хүснэгт 2-оос харна уу.*

Эдүгээ дэлхий дахинд иргэдийн үндсэн эрхийг баталгаажуулж, улмаар **үндсэн хуулийг амьдралд шууд үйлчлэх эрх зүй болгох** гол бөгөөд үр дүнтэй арга замыг “Үндсэн хуулийн гомдол” (Constitutional Complaint) шийдвэрлэх хэлбэрээр практикт нэвтрүүлж байна. Иймээс үндсэн хуулийн гомдол нь шүүхийн замаар иргэд (хуулийн этгээд) үндсэн эрхээ хамгаалуулах харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн арга хэлбэр болон хөгжиж байна.³⁸

Хүний үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн гомдлоор хүлээн авч шийдвэрлэдэг тэдгээр 35 улсын 25 нь Үндсэн хуулийн шүүхээр, 9 нь Дээд шүүх эсхүл түүний тусгай танхимаар, 1 нь Үндсэн

³⁵ Хууль батлах эрх мэдэлд тавих шүүхийн хяналт: Улс төрийн сонголтыг үндсэн хуулиар хязгаарлах нь. П.Амаржаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019

³⁶ НҮБ-ын гишүүн орнуудын тоо

³⁷ <http://concourts.net/tab/tab1.php?lng=en&stat=1&prt=0&srt=0>

³⁸ Үндсэн хуулийн шүүхээр үндсэн эрхийг хамгаалах арга зам, А.Бямбажаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019

хуулийн зөвлөлөөр тус тус хүний үндсэн эрхийн асуудлыг хянадаг. Үүнээс харахад Үндсэн хуулийн шүүхийн институцтэй 51 улсын тал хувь нь хүний үндсэн эрхийн асуудлаар Үндсэн хуулийн гомдол хүлээн авах, шийдвэрлэх механизм нэвтрүүлсэн байна.

Үндсэн хуулийн шүүхэд үндсэн эрхийн гомдол хүлээж авах хүрээнд “хуульд заасан бүх арга замыг авч хэрэгжүүлсэн байх”, “Тухайн асуудал нь Үндсэн хуулиар тодорхойлсон хүний үндсэн эрхийн хүрээний байх”, “Үндсэн хуулийн гомдол нь үүсмэл буюу субсидар шинжтэй байх” зэрэг үндсэн шаардлага нийтлэг байдлаар тавигддаг байна.

Судалгаанд хамрагдсан орнуудын зарим онцлох зүйл, зохицуулалтуудыг дурдвал: *(Дэлгэрэнгүйг хүснэгт 1-ээс харна уу.)*

- **Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад** Үндсэн хуулийн гомдлыг ердийн шүүхээр шийдвэрлэх бүх хууль зүйн арга хэмжээг авч хэрэгжүүлж дууссан тохиолдолд л хүлээн авах боломжтой. Түүнчлэн Үндсэн хуулийн зөрчлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх бусад бүх боломжуудыг ашигласан байх ёстой байдаг. Холбооны Үндсэн хуулийн шүүх төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн, хуулийг хүчин төгөлдөр бус гэж тооцож, Үндсэн хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг эрх бүхий шүүхэд шилжүүлдэг. Шаардлагатай бол дараагийн шийдвэр гаргах эрх тухайн ердийн шүүхэд хамаардаг. Холбооны Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн гомдлын дагуу эдгээрээс өөр шийдвэр гаргах боломжгүй. Тухайлбал, хохирлыг барагдуулах, эрүүгийн хэрэг үүсгэх, эсхүл албадлагын арга хэмжээ авах гэх мэт. Түүнчлэн зарчмын хувьд үндсэн хуулийн гомдлын дагуу хууль тогтоогчийн зүгээс тодорхой арга хэмжээ авахыг шаардах, даалгах боломжгүй.
- **Бүгд найрамдах Азербайжан Улсад** Үндсэн хуулийн гомдлыг шууд Үндсэн хуулийн шүүхэд гаргах боломжтой бөгөөд Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуульдаа гомдлын агуулгыг тусгаж өгсөн байна. Үндсэн агуулга нь Үндсэн хуулийн түвшинд зөрчигдсэн эрхийг сэргээх талаар байна. Үндсэн хуулийн шүүхийн гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа нь төрлөөсөө шалтгаалан гурваас зургаан сараар тогтоогдсон байдаг.
- **Бүгд Найрамдах Солонгос Улсад** энгийн шүүхийн шийдвэр гарсныг эс тооцвол төр эрх мэдлээ хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлээгүйн улмаас Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх нь зөрчигдсэн гэж үзсэн аливаа этгээд Үндсэн хуулийн гомдлоо хянан шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно. Хэрэв бусад хууль тогтоомжоор дээрх зөрчигдсэн эрхийг хянан шийдвэрлэхээр хуульчилсан, тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж буй бол Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах боломжгүй байдаг.
- **Тайландын Хаант Улсад** 2017 онд батлагдсан шинэ Үндсэн хуульд үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр иргэдийн эрх, эрх чөлөөг бодитоор хүлээн зөвшөөрч, хамгаалах тогтолцоог оруулж өгсөн байна. Үүндээ “Үндсэн хуульд заасан Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахыг төрөөс шаардах эрхтэй, төрийн холбогдох байгууллагуудыг хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх эрхийг хангах” заалтыг хэрэгжүүлэхээр оруулж өгчээ. Ингэхдээ иргэд, олон нийт гомдлыг Үндсэн хуулийн шүүхэд шууд гаргадаггүй бөгөөд холбогдох төрийн байгууллага болон Омбудсманг гаргадаг байна. Гомдлын хариуг иргэд, олон нийт хүлээн зөвшөөрөхгүй бол Сайд нарын зөвлөл (Council of Ministers)-д мэдэгддэг байна. Үүний дараа Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах эрхтэй болдог байна.

Үндсэн хуулийн шүүх гомдол хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор хянан шийдвэрлэдэг. Энэ шийдвэр эцсийн бөгөөд төрийн байгууллага заавал биелүүлэх ёстой байдаг.

- **Бүгд найрамдах Тажикстан Улсад** иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд иргэн, хуулийн этгээд төдийгүй тодорхой эрх бүхий албан тушаалтнууд өргөдөл, гомдол гаргах эрхтэй байна. Дурдвал: Хүний эрхийн комиссын дарга, төлөөлөгч, Дээд шүүхийн шүүгчид, Эдийн засгийн дээд шүүхийн шүүгчид болон бусад шүүгчид (Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдээс бусад)

Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.

Хүснэгт 1. Үндсэн хуулийн шүүхэд гаргасан хүний эрхийн гомдлыг хянан шийдвэрлэх талаарх орнуудын харьцуулалт

Улс орнууд	Үндсэн хуулийн гомдол гаргах хүрээ	Үндсэн хуулийн гомдол гаргах этгээд	Үндсэн хуулийн гомдлын хэлбэр, агуулга	Хөөн хэлэлцэх хугацаа	Үндсэн хуулийн гомдол гаргах урьдчилсан нөхцөл	Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, түүний үр дагавар
ХБНГУ	Хүний үндсэн эрх, түүнтэй адилтгах тодорхой эрхүүдийг зөрчсөн тухай гомдол	-Иргэн -Хуулийн этгээд	Герман хэлээр, хуульд заасан бүрдүүлбэрийг бүрдүүлж, бичгээр гаргана. Ингэхдээ факсаар гомдлоо хүргүүлж болох боловч э-мэйлээр илгээх боломжгүй байдаг.	Шүүхийн шийдвэр, захиргааны актын эсрэг Үндсэн хуулийн гомдлыг тухайн шийдвэр гарснаас хойш нэг сарын дотор гаргах ёстой.	Үндсэн хуулийн гомдлыг тухайн асуудлаар шүүхийн болоод шүүхийн бус хууль зүйн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж дууссан тохиолдолд л хүлээн авах боломжтой.	Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн, хуулийг хүчин төгөлдөр бус гэж тооцож, Үндсэн хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг эрх бүхий шүүхэд шилжүүлж болно. Шаардлагатай бол дараагийн шийдвэр гаргах эрх ердийн шүүхэд хамаардаг. Холбооны Үндсэн хуулийн шүүх (ҮХШ) үндсэн хуулийн гомдлын дагуу эдгээрээс өөр шийдвэр гаргах боломжгүй.
Азербайжан	Үндсэн хуулийн гомдол гаргах хүрээ (Үндсэн эрхийг зөрчсөн тухай гомдол)	-Этгээд болон хуулийн этгээд	Бичгээр гаргана.	3-6 сар	Гомдлыг ҮХШТХ-ийн 34.6-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэх судалгааг Үндсэн хуулийн шүүхийн Тамгын газар хэрэгжүүлдэг. Гомдлыг 30 хоногийн дотор анхан шатны журмаар хянан хэлэлцэж, хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв гомдлыг хүлээн авах боломжгүй бол 7 хоногийн дотор гомдол гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв гомдлыг хүлээн авсан гэж үзвэл 60 хоногийн дотор хянан, хэлэлцүүлнэ.	Гомдлын талаар гурван төрлийн шийдвэр байна. Үүнд: Татгалзах: Хүсэлт нь үндэслэлгүй байх тохиолдлыг хэлнэ. Хэрэгсэхгүй орхих: Хууль бусаар хүсэлт гаргасан тохиолдлыг хэлнэ. Баталгаажуулах: Тав буюу түүнээс дээш шүүгч хүсэлтийг үндэслэлтэй гэж үзэж, хүлээж авах тохиолдлыг хэлнэ. ҮХШ-ийн бүрэлдэхүүний шийдвэр эцсийнх байх бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан хүчингүй болгох, өөрчлөх, албан ёсоор тайлбарлах боломжгүй.
БНСУ	Үндсэн эрх нь зөрчигдсөн тухай гомдол	-Иргэн	Биечлэн шуудангаар, бичгээр, гар утсаараа http://ecourt.cco	Гомдлыг хянан шийдвэрлэх шалтгаан байгаа нь тогтоогдсон	Үндсэн хуулийн гомдлыг тухайн асуудлыг хянан шийдвэрлэх эрхтэй шүүх болон бусад байгууллага	ҮХШ гомдол хүлээн аваад гомдлыг хэрэгсэхгүй болгох, гомдлыг хангах шийдвэрийн аль нэгийг гаргана. Гомдол хангах тухай ҮХШ-ийн шийдвэрийг төрийн бүх байгууллага,

			<p>url.go.kr программаар тус тус гаргана.</p>	<p>өдрөөс хойш 90 хоногийн дотор, харин шалтгаан үүссэнээс хойш 1 жилийн дотор шийдвэрлэнэ.</p>	<p>хэлэлцэж буй бол хүлээн авахгүй. Бусад хуульд заасан хянан шийдвэрлэх ажиллагааг дүүсгасны дараа гаргасан Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэхийг уг процессын эцсийн шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гаргана.</p>	<p>орон нутгийн засаг захиргаа заавал биелүүлэх үүрэгтэй. Ийнхүү гомдлыг авч үзэхдээ зөрчигдсөн үндсэн эрх, зөрчлийг үүсгэсэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, эс ашиглах зэргийг шийдвэрт тусгана. ҮХШ үндсэн эрхийг зөрчсөн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхийг хүчингүй болгож, эсхүл түүнийг хэрэгжүүлэхгүй байгаа нь Үндсэн хууль зөрчсөн болохыг баталж болно. ҮХШ төрийн эрх мэдлээ хэрэгжүүлээгүй тухай Үндсэн хуулийн гомдлыг хангах тухай шийдвэр гаргахад хариуцагч уг шийдвэрийн зорилгод нийцүүлэн шинээр шийдвэр гаргана. ҮХШ төрийн эрх мэдлийг хэрэгжүүлсэн, эс хэрэгжүүлсэн нь үндсэн хууль, түүний заалтаас үүдэлтэй гэж үзвэл уг хууль, заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн шийдвэртээ дурдаж болно.</p>
<p>Тайланд</p>	<p>Үндсэн хуульд заасан Хүний эрх, чөлөөг хамгаалахыг төрөөс шаардах эрхтэй, төрийн холбогдох байгууллагуу- дыг хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх эрхийг хангах.</p>	<p>Иргэн</p>	<p>Бичгээр гаргана.</p>	<p>1-6 сар</p>	<p>Төрийн байгууллагын үйл ажиллагаа доголдох, түүний улмаас ард иргэд, олон нийт хохирсон. Иргэд, олон нийт үндсэн эрхийн гомдлыг гаргадаг боловч сайд нарын зөвлөлөөр урьдчилан авч хэлэлцэж байгаа нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн байр суурьтай байна. Үндсэн хуулийн шүүхэд гомдлоо гаргах, хэлэлцүүлэх эрхтэй.</p>	<p>ҮХШ гомдол хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор хянан шийдвэрлэдэг. Энэ шийдвэр эцсийн бөгөөд төрийн байгууллага заавал биелүүлэх ёстой байдаг.</p>
<p>Тажикстан</p>	<p>Иргэдийн үндсэн хуулиар</p>	<p>-Хүний эрхийн комиссын дарга, төлөөлөгч;</p>	<p>Тажик хэлээр бичгээр гаргана.</p>	<p>6 сар</p>	<p>Давж заалдах</p>	<p>ҮХШ-ийн тогтоол нь эцсийнх бөгөөд давж заалдах эрхгүй, хамаарал бүхий хуулийн этгээд, хувь хүн бүгд</p>

	<p>олгогдсон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тухай томдол</p>	<p>-Хувь хүмүүс; -Хуулийн этгээд; -Дээд шүүхийн шүүгчид, Эдийн засгийн дээд шүүхийн шүүгчид, бусад шүүгчид (Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдээс бусад)</p>			<p>дагаж мөрдөх, заавал биелүүлэх үүрэгтэй байна. Хэрэв шүүхийн тогтоолыг дагаж мөрдөөгүй, хагас дутуу биелүүлсэн, хэрэгжүүлэхэд саад учруулсан бол Тажикстаны хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.</p>
--	--	---	--	--	---

НЭГ.ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ХЯНАЛТ БА ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

1.1.Үндсэн хуулийн хяналт (constitutional review)

Үндсэн хуулийн хяналт гэдэг нь эрх бүхий байгууллага үндсэн хуулийг тайлбарлаж, хууль тогтоомж, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа, төрийн бодлого Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг тодорхойлон тогтоох үйл ажиллагаа юм. Үндсэн хуулийн хяналтын гол зорилго нь төр, төрийн байгууллага үндсэн хуулиар тогтоосон хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад оршино. “Үндсэн хуулийн дээд хяналтын асуудал нь “Үндсэн хуулийг шууд үйлчлэх эрх зүй” болгох онцгой ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж байгаа билээ. Учир нь “Үндсэн хууль” хэдийгээр тухайн улс орны гол хууль байж, төрийн байгууламжийг тогтоох нийгмийн гэрээ хэдий боловч түүнээс дутахааргүй бас нэгэн гол чанар нь иргэдийн эрх, эрх чөлөөний баталгаа мөн болоход оршино. Иймээс энэ хоёр асуудлын баталгаа нь үндсэн хуулийн дээд хяналтыг хэрэгжүүлэх үндсэн хуулийн хяналтын тогтолцоо юм.³⁹

Үндсэн хуулийн хяналт нь дараах үндсэн 3 хэлбэртэй. Үүнд:

- Шүүхийн хяналт (judicial review);
- Хууль тогтоох эрх мэдлийн хяналт (legislative review);
- Олон нийтийн хяналт (popular review): Үүнд референдум, санал асуулга, зөвлөлдөх ардчилал гэх мэт арга хэрэгслүүд багтана.

Эдгээрээс хамгийн үр дүнтэй хяналтын хэлбэрийг шүүхийн хяналт гэж үздэг. Учир нь шүүхүүд үндсэн хуулийг тайлбарлах болон Үндсэн хууль зөрчсөн хуулийг хүчингүй болгох эрхтэй байдаг.

1.2.Үндсэн хуулийн шүүхийн хяналт (constitutional-judicial review)

Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуульд ёсыг хамгаалагчийн хувьд эрх мэдлийн бусад салаа мөчрийн байгууллагуудаас хууль зүйн тодорхой давуу эрх эдэлдэг тусгай байгууллага юм. Үндсэн хуулийн шүүхийн хяналт нь эрх мэдэл хуваарилах тогтолцоонд хууль тогтоох (парламент) эрх мэдлийг хязгаарлах харилцаа байдаг тул хууль тогтоох байгууллагаас баталсан хуулийг хүчингүй болгох онцгой эрх бүхий бөгөөд тусгай журмаар байгуулагдсан шүүхийн институц болдог. Гэвч шүүхийн ердийн тогтолцооноос гадуур оршдог бөгөөд төрийн эрх мэдлийн бусад салаанаас бүрэн хараат бус байдаг. “Үндсэн хуулийн шүүхийн гол зориулалт нь Үндсэн хуулийг хамгаалах мэт боловч түүний тулах цэг нь “Үндсэн хуулийн басхүү нөгөө талын зориулалт болох иргэдийн үндсэн эрхийг хангах, хамгаалах” асуудлаас огт хөндийрөх учиргүй билээ.”

Үүсэл хөгжил, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтынх нь хувьд авч үзвэл улс орнуудад үндсэн хуулийн шүүхийн хяналтын 3 үндсэн загвар⁴⁰ байдаг гэж үздэг бөгөөд бусад нь тэдгээрийн холимог болон хосолмол байдлаар оршдог.

Америкийн загвар⁴¹

Америкийн загвар: 1803 онд АНУ-ын Дээд шүүхээр хэлэлцэн шийдвэрлэгдсэн Марберигийн хэрэг болон Жон Маршаллын сургаал дээр үндэслэгдсэн шүүхийн хяналтын загвар бөгөөд үндсэн хуулийн асуудлыг ердийн журмаар бүх шатны шүүх авч үздэг. Энэ тогтолцоонд Дээд (дээд шатны)

³⁹ Үндсэн хуулийн шүүхээр үндсэн эрхийг хамгаалах арга зам, А.Бямбажаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019

⁴⁰ Үндсэн хуулийн хяналтын хэрэгждэг хэлбэрийн харьцуулсан судалгаа, Д.Солонго, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019

⁴¹ Constitutional Review Systems Around the World, Dr. Arne Marjan Mavčič, 2018

шүүх нь харьяаллын нэгдмэл байдлыг хангадаг тусгай бөгөөд дараагийн (a posteriori) хяналт юм. Шүүхийн шийдвэрийг цаашид дагаж мөрдөх зарчмыг эс тооцвол энэхүү сарнисан (diffuse) системд шийдвэр нь онол ёсоор зөвхөн талуудын хооронд хүчин төгөлдөр үйлчилнэ. Үндсэн хууль зөрчсөн тухай шийдвэр нь зарчмын хувьд тунхаглалын шинж чанартай бөгөөд буцаан хэрэглэдэг, өөрөөр хэлбэл ex tunc (pro praeterito) үр дагавартай. Энэхүү системийг дараах улс орнууд хэрэгжүүлсэн.

Үүнд:

- ЕВРОПТ: Дани, Эстони, Ирланд, Норвеги, Швед;
- АФРИКТ: Ботсвана, Гамби, Гана, Гвиней, Кени, Малави, Намиби, Нигери, Сейшелийн арлууд, Сьерра-Леон, Свазиланд, Танзани;
- Ойрх Дорнодод: Израил;
- АЗИД: Бангладеш, Фижи, Хонконг (1997 оны 07-р сарын 01 хүртэл), Энэтхэг, Япон, Кирибати, Малайз, Микронезын Холбооны Улс, Науру, Балба, Шинэ Зеланд, Палау, Папуа Шинэ Гвиней, Сингапур, Тонга, Тувалу, Вануату, Баруун Самоа;
- ХОЙД АМЕРИКТ: Канад, АНУ;
- ТӨВ БОЛОН ӨМНӨД АМЕРИКТ: Аргентин, Багамын арлууд, Барбадос, Белиз, Боливи, Доминик, Доминикан, Гренада, Гайана, Гаити, Ямайка, Мексик, Сент Кристофер/Невис, Тринидад, Тобаго.

Австрийн загвар⁴²

Австрийн загвар: Х.Келзений 1920 оны загварт үндэслэсэн. Үндсэн хууль дээд хүчин чадалтай байх зарчим ба парламент төрийн эрх барих дээд байгууллага байх зарчмын харилцан уялдаа холбоог агуулсан. Энэ загварт үндсэн хуулийн асуудлыг мэргэшсэн хүмүүс авч үздэг. Тусгай мэргэшсэн шүүгчтэй Үндсэн хуулийн шүүх, эсвэл ердийн Улсын дээд шүүх, Дээд шүүх, эсхүл тэдгээрийн тусгай танхим (үндсэн хуулийн төвлөрсөн хяналт) тусгай хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шийдвэрлэдэг.

Онол ёсоор энэ нь хийсвэр хяналт боловч тодорхой хяналт хийх боломжтой. Дээрх хяналтаас гадна априори, приори хяналтыг ч хэрэгжүүлдэг. Шийдвэрүүд нь түүнийг гаргаж буй байгууллагын үнэмлэхүй эрх мэдлээс хамааран erga omnes (зөвхөн маргалдагч талуудад бус бүх нийтэд хамаарал бүхий) нөлөөтэй байдаг.

Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь дараах байж болно.

Үндсэн Хуулийн Шүүх:

- ЕВРОПТ: Албани, Андорра, Австри, Беларусь, Босни-Херцеговинын Холбоо (Босни-Херцеговин, Босни Бүгд Найрамдах Сербийн холбооны байгууллагуудын Үндсэн хуулийн шүүхтэй), Болгар, Хорват, Чех, Серб, Монтенегро, Герман (бус нутгийн Үндсэн хуулийн шүүхүүдтэй: Баден-Вюртемберг, Бавари, Бранденбург, Бремен, Гамбург, Гессен, Нидерсахсен, Нордрхайн-Вестфален, Рейнланд-Пфальц, Саарланд, Саксен-Анхалт, Сах)), Унгар, Итали, Латви, Литва, Люксембург, Македон, Мальта, Молдова, Польш, Румын, ОХУ (холбооны нэгжийн Үндсэн хуулийн шүүхүүд: Адигей, Алтай, Баскир, Буриад, Чечен, Чувачи, Дагестан, Ингуш, Иркутск муж, Кабардин-Балкар Бүгд Найрамдах Улс, Какаса, Карачаево-Черкез Бүгд Найрамдах Улс, Карелия, Халмук, Кома, Марий-Эл, Хойд Осет, Татарстан, Тува, Удмурт, Якут/Саха), Словак, Словени, Испани, Турк, Украин;

⁴² Constitutional Review Systems Around the World, Dr. Arne Marjan Mavčič, 2018

- АФРИКТ: Ангол, Бенин, Бурунди, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Египет, Экваторын Гвиней, Габон, Мадагаскар, Мали, Руанда, Өмнөд Африк, Того;
- Ойрх Дорнодод: Кипр, хуучин Ирак, Палестин, Сири;
- АЗИД: Армен, Азербайжан, Гүрж, Киргиз, Монгол, Өмнөд Солонгос, Шри-Ланка, Тажикстан, Тайланд, Узбекистан (Бүгд Найрамдах Каракалпакстан Улс Үндсэн хуулийн хороотой);
- ТӨВ болон ӨМНӨД АМЕРИКТ: Чили, Суринам, Тукуман муж (Аргентин) 1990 оны 04-р сарын 28-ны өдрийн Тукуман улсын Үндсэн хуультай;

Дээд шүүх, түүний тусгай танхим:

- ЕВРОПТ: Бельги (Арбитрын шүүх), Исланд, Лихтенштайн, Монако, Косово (FRY);
- Ойрх Дорнодод: Йемен;
- АФРИКТ: Буркина Фасо, Камерун, Чад, Эритрей, Нигер, Судан, Уганда (1995), Заир, Замби;
- АЗИД: Филиппин;
- ТӨВ болон ӨМНӨД АМЕРИКТ: Коста Рика, Никарагуа, Панам, Парагвай, Уругвай;

Үндсэн хуулийн зөвлөл:

- Ойрх Дорнодод: Ливан;
- АФРИКТ: Мавритани, Сенегал;
- АЗИД: Камбож, Казахстан.

Францын загвар⁴³

Францын Үндсэн хуулийн зөвлөл (Conseil Constitutionnel)-ийн загвар дээр үндэслэгдсэн. Францын Үндсэн хуулийн зөвлөл нь шүүн таслах чиг үүрэг хэрэгжүүлдэггүй бөгөөд парламентын нэг бүрэлдэхүүн хэсэг болдог. Үндсэн хуулийн асуудлыг үндсэн хуулийн хяналтын тусгай байгууллага (ихэнхдээ Үндсэн хуулийн зөвлөл) эсвэл ердийн Дээд шүүхийн тусгай танхим (үндсэн хуулийн төвлөрсөн хяналт) тусгай журмын дагуу хянадаг. Энэ тогтолцоонд Үндсэн хуулийн хяналт нь голчлон урьдчилан сэргийлэх (зөвлөлдөх) шинж чанартай байдаг. Жишээлбэл: Үндсэн хуулийн зөвлөл парламентаар батлагдсан боловч ерөнхийлөгч соёрхон батлаагүй хуулийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг ерөнхий сайд, ерөнхийлөгч, парламентын гишүүн зэрэг эрх бүхий албан тушаалтны өргөн мэдүүлснээр хянадаг байна.

- ЕВРОПТ: Франц;
- Ойрх Дорнодод: Иран;
- АФРИКТ: Алжир, Комор, Жибути, Зааны ясан эрэг, Марокко, Мозамбик.

Холимог загвар

Америкийн буюу сарнимал хяналтын систем болон Австрийн буюу төвлөрсөн хяналтын системийн аль алиных нь элементүүдтэй холимог загвар: Үндсэн хуулийн хяналтын төв байгууллага болох Үндсэн хуулийн шүүх эсхүл Дээд шүүх (түүний тусгай танхим)-ийн үндсэн хуулийн хяналтын бүрэн эрхийг үл харгалзан тухайн улсын бүх энгийн шүүхүүд Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн хуулийг хэрэглэхгүй байх эрхтэй байдаг.

Үндсэн хуулийн шүүхүүд

- ЕВРОПТ: Португал;

⁴³ Constitutional Review Systems Around the World, Dr. Arne Marjan Mavčič, 2018

- ТӨВ БОЛОН ӨМНӨД АМЕРИКТ: Колумб, Эквадор, Гватемал, Перу;

Дээд шүүхүүд эсвэл тэдгээрийн тусгай танхим

- ЕВРОПТ Грек, Швейцар;
- АЗИД: Индонез, Тайвань;
- АФРИКТ: Кабо Верде;
- ТӨВ болон ӨМНӨД АМЕРИКТ: Бразил, Сальвадор, Гондурас, Венесуэл.

Шинэ (Британийн) Хамтын нөхөрлөлийн загвар⁴⁴

Шинэ (Британийн) хамтын нөхөрлөлийн загварыг (Маврики) Америк эсвэл Европын загварын аль алинд нь ангилж боломжгүй. Энэ нь ямар нэг улс төрийн нэр дэвшүүлэлтгүйгээр томилогдсон ердийн шүүгчдээс бүрдсэн Дээд шүүхийн харьяаллын үндсэн хуулийн төвлөрсөн хяналтаар тодорхойлогддог. Онол ёсоор урьдчилан сэргийлэх (priori) хяналт, Дээд шүүхийн зөвлөх чиг үүргийг хамардаг боловч албадах (posteriori) хяналт бас байдаг. Шийдвэр нь erga omnes (зөвхөн маргалдагч талуудад бус бүх нийтэд хамаарал бүхий) нөлөө үзүүлдэг.

Үндсэн хуулийн шүүхийн хяналтын эрх бүхий бусад байгууллага

(Үндэсний зөвлөл, парламент эсвэл парламентын төрөлжсөн байгууллага гэх мэт):

- ЕВРОПТ: Финланд;
- Ойрх Дорнодод: Бахрейн, Кувейт, Оман;
- АФРИКТ: Конго, Этиоп, Гвиней-Бисау, Сан-Томе ба Принсипи, Тунис, Зимбабве;
- АЗИД: Афганистан, Бруней, Бирм/Мьянмар, Хятад (мөн 1997 оны 07-р сарын 01-ээс хойш Хонконг), Лаос, Хойд Солонгос, Пакистан, Туркменистан, Вьетнам;
- ТӨВ АМЕРИКТ: Куба.

Үндсэн хуулийн шүүхийн хяналтгүй тогтолцоо

- ЕВРОПТ: Их Британи, Нидерланд;
- АФРИКТ: Лесото, Либери, Ливи.

1.3. Үндсэн хуулийн шүүхийн хяналтын хүний үндсэн эрхийн хамгаалалт

Одоогоор дэлхий дээр НҮБ-ын гишүүнээр бүртгэлтэй 193⁴⁵ улс оршин тогтнож байна. Тэдгээр улсуудаас 177⁴⁶ улсад үндсэн хуулийн шүүхийн хяналтыг ямар нэг хэлбэрээр хэрэгжүүлж байгаа бөгөөд 52 улс хүний эрхийн хамгаалалтын асуудлаар, 35 улс хүний эрхийн асуудлаар үндсэн хуулийн гомдол хүлээн авч шийдвэрлэдэг байна. *Дэлгэрэнгүйг хүснэгт 2-оос харна уу.*

Эдүгээ дэлхий дахинд иргэдийн үндсэн эрхийг баталгаажуулах, улмаар үндсэн хуулийг амьдралд шууд үйлчлэх эрх зүй болгох гол үр дүнтэй арга зам нь **үндсэн хуулийн гомдол** болон практикт нэвтэрчээ.⁴⁷ Иймээс үндсэн хуулийн гомдол нь шүүхийн замаар иргэд (хуулийн этгээд) үндсэн эрхээ хамгаалуулах харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн хэлбэр болон хөгжиж байна. Үндсэн хуулийн гомдлын дагуу иргэд төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас Үндсэн хуульд заасан эрхээ хөндөгдсөн, зөрчигдсэн хэмээн үзвэл түүнийгээ

⁴⁴ Constitutional Review Systems Around the World, Dr. Arne Marjan Mavčič, 2018

⁴⁵ НҮБ-ын гишүүн орнууд

⁴⁶ <http://concourts.net/tab/tab1.php?lng=en&stat=1&pri=0&srt=0>

⁴⁷ Үндсэн хуулийн шүүхээр үндсэн эрхийг хамгаалах арга зам, А.Бямбажаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019

хамгаалуулахаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу Үндсэн хуулийн шүүхэд хандах байдлаар хэрэгжиж байна.

Сонгодог утгаараа үндсэн хуулийн гомдол нь Үндсэн хуулийн шүүх дэх хамаарлын зарчимд үндэслэгддэг. Өөрөөр хэлбэл, үндсэн хуулийн гомдол гаргах этгээдийн Үндсэн хуулийн шүүхэд хандах асуудал нь гагцхүү тухайн этгээдийн үндсэн эрхийн хүрээнд багтаж байхыг шаардаж байдаг. Тухайн шүүхэд хандах асуудал үндсэн эрхийн хүрээнд байх нөхцөл нь дараах гурван шинжээр илрэн гардаг.⁴⁸ Үүнд:

- Өөрт хамааралтай байх: Үндсэн хуулийн гомдол гаргагч этгээдийн хувьд тухайн асуудал нь гагцхүү түүний субъектив эрхийн зөрчилтэй холбоотой байх ёстой. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн шүүхэд өөр хэн нэгний буюу нийтийн ашиг сонирхлын үүднээс төлөөлөн хандах боломжийг үгүйсгэж байдаг.
- Яг одоо байх: Тухайн этгээдийн эрхийг зөрчиж буй төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа эдүгээ буюу яг энэ цаг мөчид байх ёстой гэж үздэг.
- Шууд байх: Гомдол гаргагчийн эрх төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас шууд зөрчигдсөн байхыг ойлгоно. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагааны улмаас тухайн этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах, үүрэг ногдуулах зэрэг хууль зүйн ямар нэг үр дагавар учирдаг.

Хүний үндсэн эрхийн маргааныг үндсэн хуулийн гомдлоор хүлээн авч шийдвэрлэдэг дээр дурдсан 35 улсуудын 25 нь Үндсэн хуулийн шүүхээр, 9 нь Дээд шүүх эсхүл түүний тусгай танхимаар, нэг улс Үндсэн хуулийн зөвлөлөөр тус тус хүний үндсэн эрхийн асуудлыг хянадаг. Үүнээс харахад Үндсэн хуулийн шүүхийн институцтэй 51 улсын тал хувь нь хүний үндсэн эрхийн асуудлаар үндсэн хуулийн гомдол хүлээн авах, шийдвэрлэх механизм нэвтрүүлсэн байна.


Үндсэн хуулийн шүүхэд үндсэн эрхийн гомдол хүлээж авах хүрээнд дараах шаардлага тавигддаг.⁴⁹

1. Хуульд заасан бүх арга замыг авч хэрэгжүүлсэн байх: Тухайн гомдол гаргагч этгээд өөрийн зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах талаар дээд шатны албан тушаалтан, хяналтын байгууллага, шүүх гэх зэрэг хуульд заасан бүхий л арга замыг дуусгасан байхыг ойлгоно.
2. Үндсэн хуулийн гомдол нь үүсмэл байх зарчимд үндэслэгдэн тулгуурладаг: Үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан нь үүсмэл байх буюу субсидар байх зарчимд тулгуурладаг.
3. Тухайн асуудал нь Үндсэн хуулиар тодорхойлсон хүний үндсэн эрхийн хүрээний байх.

⁴⁸ Helga Seibert, "Admissibility requirements for constitutional complaints and mechanisms for avoiding an excessive case load". European Commission for Democracy Through Law (Venice Commission), The protection of Fundamental Rights by The Constitutional Court, Science and technique of democracy, No. 15, P. 125

⁴⁹ Үндсэн хуулийн шүүхээр үндсэн эрхийг хамгаалах арга зам, А.Бямбажаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019

Зураг 1. Эх сурвалж: <https://concourts.net/tab/maps.html>



Хүснэгт 2: Үндсэн хуулийн шүүхийн хяналт (Constitutional-judicial review)-ын хэлбэр ба хүний эрхийн хамгаалалт

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)		Австри-Америкийн холимог загвар (Mixed European-American Model)		Австри-Америкийн холимог загвар (Mixed European-American Model)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional judicial Review)		Үндсэн хуулийн шүүхийн хяналт байдаггүй (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нөхөрлөлийн загвар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загвар (European Model)	Австри-Америкийн холимог загвар (Mixed European-American Model)	Австрийн загвар (European Model)	Америкийн загвар (American Model)	Америкийн загвар (American Model)	Австри-Америкийн холимог загвар (Mixed European-American Model)	Францын загвар (French Model)	Европын загвар (European Model)	Үндсэн хэлбэр (Other Institutional forms of the constitutional judicial Review)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)
Албани	CC-EM													
Андорра	CC-EM													
Австри	CC-EM													
Бельги			HC-EM											
Беларусь	CC-EM													
Босни-Херцеговин	CC-EM													
Болгар	CC-EM													
Хорваат	CC-EM													
Чех	CC-EM													
Дани				HC-AM										
Эстони				HC-AM										
Финланд									ELSE					
Франц						CN-FM								
Герман	CC-EM													
Грек								HC-MX						
Унгар	CC-EM													
Исланд			HC-EM											

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional Judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн хяналт байдлаги (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нөхөрлөлийн загвар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загвар (European Model)	Австри-Америкийн (Mixed European-American Model)	Австрийн загвар (European Model)	Америкийн загвар (American Model)	Австри-Америкийн (Mixed European-American Model)	Францын загвар (French Model)	Европын загвар (European Model)					
Ирланд												
Итали	СС-ЕМ											
Косово			НС-ЕМ									
Латви	СС-ЕМ											
Лихтенштайн			НС-ЕМ									
Литва	СС-ЕМ											
Люксембург	СС-ЕМ											
Македон	СС-ЕМ											
Мальта	СС-ЕМ											
Молдав	СС-ЕМ											
Монако			НС-ЕМ									
Монтенегро	СС-ЕМ											
Нидерланд									W/O			
Норвег												
Польш	СС-ЕМ			НС-АМ								
Португал		СС-МХ										
Румын	СС-ЕМ											
Орос	СС-ЕМ											
Серби	СС-ЕМ											
Словак	СС-ЕМ											
Словени	СС-ЕМ											

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional Judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн хяналт байдалгүй (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нийгэмчлэлийн загвар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загвар (European Model)	Австри-Америкийн холимог загвар (Mixed European-American Model)	Австрийн загвар (European Model)	Америкийн загвар (American Model)	Австри-Америкийн холимог загвар (Mixed European-American Model)	Францын загвар (French Model)	Европын загвар (European Model)					
Испани	СС-ЕМ			НС-АМ								Хүний эрх (Human Rights)
Швед												
Швейцар					НС-МХ							
Турк	СС-ЕМ											
Украин	СС-ЕМ											
Их Британи								W/O				
Африк												
Алжир												
Ангол	СС-ЕМ											
Бенин	СС-ЕМ											
Ботсвана				НС-АМ								
Буркино Фасо			НС-ЕМ									
Бурунди	СС-ЕМ		НС-ЕМ									
Камерун												
Капе Верде					НС-МХ							
ТАБНУ	СС-ЕМ											
Чад			НС-ЕМ									
Коморо												
Конго												ELSE
Жибути												

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional Judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн хяналт байдаггүй (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нэгнэхээрлийн загвар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загвар (European Model)	Австри-Америкийн холимог загвар (Mixed European-American Model)	Австрийн загвар (European Model)	Америкийн загвар (American Model)	Австри-Америкийн холимог загвар (Mixed European-American Model)	Францын загвар (French Model)	Европын загвар (European Model)					
Египет	СС-ЕМ											
Эритри			НС-ЕМ									
Этиоп								ELSE				
Экваторын Гвинейн	СС-ЕМ											
Габон	СС-ЕМ											
Гамби				НС-АМ								
Гана				НС-АМ								
Гвиней				НС-АМ								
Гвиней-Бисау								ELSE				
Зааны ясан эрэг												
Кени				НС-АМ			СН-FM					
Лесото									W/O			
Либерри				НС-АМ								
Ливи									W/O			
Мадагаскар	СС-ЕМ											
Малави				НС-АМ								
Мали	СС-ЕМ											
Маврики												
Мавритан										NCW		
Марокко												

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional Judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн хяналт ба дагтуу (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нийгэмчлөлийн загвар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загвар (European Model)	Австри-Америкийн хольцот загвар (Mixed European-American Model)	Австрийн загвар (European Model)	Америкийн загвар (American Model)	Австри-Америкийн хольцот загвар (Mixed European-American Model)	Францын загвар (French Model)	Европын загвар (European Model)					
Мозамбик												
Намиби				НС-АМ								
Нигер			НС-ЕМ									
Нигери				НС-АМ								
Руанда												
Сао Томе & Принсипе		СС-ЕМ						ELSE				
Сенегал							CN-EM					
Сейшептийн Арлууд				НС-АМ								
Сьерра леон				НС-АМ								
ӨАБНУ												
Судан			НС-ЕМ									
Свазиланд				НС-АМ								
Танзани				НС-АМ								
Того		СС-ЕМ										
Тунис												
Уганда			НС-ЕМ					ELSE				
Зайр			НС-ЕМ									
Замби			НС-ЕМ									
Зимбабве								ELSE				

Дундад Ази

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн хяналт байдлаггүй (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нөхөрлөлийн загвар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загвар (European Model)	Австри-Америкийн Холбог Загвар (Mixed European-American Model)	Австрийн загвар (European Model)	Америкийн загвар (American Model)	Австри-Америкийн Холбог Загвар (Mixed European-American Model)	Францын загвар (French Model)	Европын загвар (European Model)					
Бахрейн								ELSE				
Кипр				HC-AM								
Иран						CN-EM						
Израил				HC-AM				ELSE				
Кувейт								ELSE				
Ливан							CN-EM					
Оман								ELSE				
Палестин	СС-ЕМ							ELSE				
Сири	СС-ЕМ											
Йемен			HC-EM									
Ази, Австрали												
Афганистан				HC-AM								
Армени	СС-ЕМ											
Австри								ELSE				
Азербайжан	СС-ЕМ											
Бангладеш				HC-AM								
Бруней								ELSE				
Бирм								ELSE				
Камбож							CN-EM					
Хятад								ELSE				

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional Judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн хяналт байдалгүй (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нийгэмчлэлийн загар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загвар (European Model)	Австри-Америкийн хольмог загвар (Mixed European- American Model)	Австрийн загвар (European Model)	Америкийн загвар (American Model)	Австри-Америкийн хольмог загвар (Mixed European- American Model)	Францын загвар (French Model)	Европын загвар (European Model)					
Фиджи			НС-АМ					ELSE				
Хонконг												
Гүрж	СС-ЕМ											
Энэтхэг			НС-АМ									
Индонез					НС-МХ							
Япон			НС-АМ									
Казахстан						ОН-ЕМ						
Кирибати			НС-АМ									
Киргиз	СС-ЕМ							ELSE				
Лаос												
Малайз			НС-АМ									
Микронез			НС-АМ									
Науру			НС-АМ									
Балба			НС-АМ									
Шинэ Зеланд			НС-АМ									
БНАСАУ								ELSE				
Пакистан								ELSE				
Палау			НС-АМ									
Папуа Шинэ Гвиней			НС-АМ									
Филиппин			НС-ЕМ									

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional Judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн хяналт байдаггүй (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нийгэмчлэлийн загар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загар (European Model)	Австри-Америкийн хелимэгт загар (Mixed European- American Model)	Австрийн загар (European Model)	Америкийн загар (American Model)	Австри-Америкийн хелимэгт загар (Mixed European- American Model)	Францын загар (French Model)	Европын загар (European Model)					
Сингапур				НС-АМ								
БНСУ	СС-ЕМ											
Шри Ланк	СС-ЕМ											
Тайвань					НС-МХ							
Тажикстан	СС-ЕМ											
Тайланд	СС-ЕМ											
Тонга				НС-АМ								
Тувалу				НС-АМ								
Туркменистан								ELSE				
Узбекистан	СС-ЕМ											
Вануату				НС-АМ								
Вьетнам								ELSE				
Баруун Самоа				НС-АМ								
Умард Америк												
Канад				НС-АМ								
Америк				НС-АМ								
Төв ба Өмнөд Америк												
Аргентин				НС-АМ								
Бахам				НС-АМ								
Барбадос				НС-АМ								

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional Judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн хяналт багдалт (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нөхөрлөлийн загвар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)
	Австрийн загвар (European Model)	Австри-Америкийн Холбоот загвар (Mixed European-American Model)	Америкийн загвар (American Model)	Австри-Америкийн Холбоот загвар (Mixed European-American Model)	Францын загвар (French Model)	Европын загвар (European Model)						
Боливи			НС-АМ									
Бразил				НС-МХ								
Чили	СС-ЕМ											
Колумби		СС-МХ										
Коста Рика			НС-ЕМ									
Куба												
Доминик			НС-АМ									
Доминикан			НС-АМ									
Эквадор		СС-МХ										
Эль Салвадор												
Гренада			НС-АМ									
Гвана			НС-АМ									
Гватемал		СС-МХ										
Хаити			НС-АМ									
Хондурас												
Ямайка			НС-АМ									
Мексик			НС-АМ									
Никарагуа				НС-ЕМ								
Панама				НС-ЕМ								
Парагвай				НС-ЕМ								
Перу		СС-МХ										

Улсууд	Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court)		Дээд шүүх эсхүл түүний тусгай танхим (High Court or Special senate of the high Court)			Үндсэн хуулийн зөвлөл (Constitutional council)		Бусад хэлбэр (Other Institutional forms of the constitutional Judicial Review)	Үндсэн хуулийн шүүхийн нийн хяналт байдалгүй (Without Constitutional Judicial Review)	Шинэ Хамтын нөхөрлөлийн загар (New Commonwealth Model)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	Үндсэн хуулийн гомдол (Constitutional Complaint)	35
	Австрийн загар (European Model)	Австри-Америкийн Холбоот загар (Mixed European- American Model)	Австрийн загар (European Model)	Америкийн загар (American Model)	Австри-Америкийн Холбоот загар (Mixed European- American Model)	Францын загар (French Model)	Европын загар (European Model)							
Сант Киттс				НС-АМ										
Суринам	СС-ЕМ													
Тринидад ба Тобаго				НС-АМ										
Урагвай			НС-ЕМ											
Венесуэл					НС-МХ									
177	51	5	21	53	9	8	5	20	4	1	52	35		

Эх сурвалж: <https://concourts.net/tab/tab1.php?lng=en&stat=1&prt=0&sr=0>

ХОЁР. ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

2.1.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх⁵⁰

ХБНГУ-ын Үндсэн хууль 1949 онд батлагдсан. Улмаар Холбооны Үндсэн хуулийн шүүх (ХҮХШ) 1951 онд байгуулагдсан бөгөөд тухайн цагаасаа хойш Германы чөлөөт, ардчилсан дэг журмыг хүндэтгэн сахиж, хэрэгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн. Энэ нь нэн ялангуяа хүний үндсэн эрхийг хэрэгжүүлэх, хамгаалахтай холбоотой. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх байгууллага Үндсэн хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй.

ХҮХШ нь дагнасан шүүхийн байгууллага хэдий ч түүний үйл ажиллагаа улс төрийн нөлөө, үр дагавар үзүүлдэг. Тухайлбал, шүүхээс тодорхой хууль тогтоомжийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл тэрхүү нөлөө, үр дагавар нь тодорхой харагдана. Гэвч ХҮХШ бол улс төрийн байгууллага биш. Түүний хяналтын цорын ганц стандарт нь Үндсэн хууль юм. ХҮХШ шийдвэр гаргахдаа улс төрийн тодорхой ашиг сонирхлын асуудлыг авч үзэх ёсгүй, зөвхөн тухайн бодлого, үйл ажиллагаа үндсэн хуулийн хүрээ, хязгаар дотор байгаа юу гэдгийг л тодорхойлдог. Төрийн эрх мэдлийг хязгаарлах чадвар нь орчин үеийн ардчилсан үндсэн хуультай төрийн гол шинж чанар юм.

ХҮХШ-ийн бүрэлдэхүүн⁵¹

ХҮХШ нь 2 Сенатаас бүрдэх ба тус бүр 8 шүүгчтэй. Одоогийн байдлаар тус шүүхийн Ерөнхийлөгч нь нэгдүгээр Сенатыг, дэд Ерөнхийлөгч нь хоёрдугаар Сенатыг тус тус тэргүүлж байна. Хоёр Сенат тус бүр гурван гишүүнтэй танхимуудыг бүрдүүлдэг.

ХҮХШ-ийн 16 шүүгчийн 8-ыг нь Бундестаг, 8-ыг нь Бундесрат сонгодог. ХҮХШ-ийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг мөн Бундестаг болон Бундесратаас ээлжлэн сонгож томилдог.

Сенат тус бүрээс дор хаяж гурваас доошгүй гишүүн Холбооны дээд шүүхээс (Холбооны шүүх, Холбооны захиргааны шүүх, Холбооны санхүүгийн шүүх, Холбооны хөдөлмөрийн шүүх, Холбооны нийгмийн шүүх (*Federal Court of Justice, Federal Administrative Court, Federal Finance Court, Federal Labour Court and Federal Social Court*)) сонгогдох ёстой.

ХҮХШ-ийн шүүгчийн туршлага: Германы Шүүхийн тухай хуульд зааснаар 40-өөс доошгүй настай, шүүгчийн албан тушаал хаших чадвартай хүн бүр сонгогдож болно. Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа арван хоёр жил байх бөгөөд тэтгэвэрт гарах нас (68) хүрсэн үед дуусна. Бие даасан байдлаар хангах үүднээс шүүгчид дахин сонгогдохгүй байж болно.

Эрх зүйн орчин

ХБНГУ-ын Үндсэн Хуулийн шүүхийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа дараах эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна. Үүнд:

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн Хууль⁵² (Basic law for the Federal Republic of Germany (1949));
- Холбооны Үндсэн Хуулийн Шүүхийн хууль⁵³ (Act on the Federal Constitutional Court (1951));

⁵⁰ The Federal Constitutional Court: https://www.bundesverfassungsgericht.de/EN/Homepage/home_node.html

⁵¹ https://www.bundesverfassungsgericht.de/EN/Das-Gericht/Organisation/organisation_node.html

⁵² Basic law for the Federal Republic of Germany (1949): https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/

⁵³ Act on the Federal Constitutional Court (1951):

https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/BVerfGG.pdf?__blob=publicationFile&v=19

- Холбооны Үндсэн Хуулийн Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэм⁵⁴ (Rules of Procedure of the Federal Constitutional Court (2014));
- Холбооны Үндсэн хуулийн шүүхийн бүгд хурлын тогтоол⁵⁵ (Order issued by the Plenary of the Federal Constitutional Court on 21 December 2022 pursuant to 14(4) of the Federal Constitutional Court Act (2022)).

Үндсэн эрхийн асуудлаар гаргасан Үндсэн хуулийн гомдол

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 93(1)4а-д төрийн байгууллагын шийдвэрээр үндсэн эрх, түүнтэй адилтгах тодорхой эрхүүд нь зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа хувь хүн, хуулийн этгээд үндсэн хуулийн асуудлаар ХҮХШ-д гомдол гаргаж болно.

Үндсэн эрх гэдэгт:

- Хүний үндсэн эрх (Үндсэн хуулийн 1-19 дүгээр зүйлд тусгагдсан)
- Үндсэн эрхтэй адилтгах тодорхой эрх (Үндсэн хуулийн 20(4), 33, 38, 101, 103, 104 дугаар зүйлд тусгагдсан)-ийг авч үздэг.

Үндсэн хуулийн гомдол нь ХҮХШ-ийн шийдвэрлэдэг хамгийн түгээмэл хэрэг маргаан юм. ХҮХШ анх байгуулагдах үед жилд 500 хүрэхгүй үндсэн хуулийн гомдол ирдэг байсан байна. 1980-аад он гэхэд энэ тоо 3107 болж өссөн бөгөөд өнөөдөр тус шүүх жил бүр 6000 орчим үндсэн хуулийн гомдол хүлээн авч шийдвэрлэж байна.

Үндсэн хуулийн гомдлын хэлбэр, агуулга

Үндсэн хуулийн гомдлыг герман хэлээр, бичгээр гаргах ёстой бөгөөд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн хуулийн 23(1), 92 дугаар зүйлд дурдсан дараах мэдээллийг агуулсан байх шаардлагатай. Үүнд:

1. Үндсэн хуулийн гомдол гаргаж буй, үндсэн эрх зөрчсөн гэх төрийн байгууллагын шийдвэр (шүүхийн шийдвэр, захиргааны акт, хууль)-ийн мэдээллийг нарийн тодорхой (шийдвэрийн огноо, дугаар, хэргийн лавлагаа, уншиж сонгосон, хүлээн авсан огноо гм) зааж өгөх;
2. Төрийн байгууллагын шийдвэрийн улмаас зөрчигдсөн гэж үзсэн үндсэн эрх, түүнтэй адилтгах тодорхой эрхээ заан нэрлэх эсхүл хууль зүйн агуулгаар нь тодорхойлсон байх;
3. Тухайн үндсэн болон адилтгах эрх нь хэрхэн зөрчигдөж байгаа учраас шүүхэд гомдол гаргаж буй талаараа нэг бүрчлэн тодорхой дурдах. Үүний тулд маргаан бүхий шүүхийн шийдвэр (мөн иш татсан бүх баримт бичиг), захиргааны акт гэх мэтийг бүрдүүлсэн байх. Гомдол гаргагчийн өөрийнх нь бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны танилцуулга, нэмэлт баримт бичгүүдийн лавлагаа хангалттай эсэх;
4. Маргаан бүхий шийдвэрүүдээс гадна анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад баримт бичиг (жишээлбэл, холбогдох товч танилцуулга, сонсголын тэмдэглэл, шинжээчийн дүгнэлт гм);
5. Үндсэн хуулийн гомдол нь зөрчигдсөн эрхээ сэргээхээр шаардлагатай хууль зүйн бүхий л арга замыг дуусгасан болохыг дурдсан үндэслэлээр харуулах ёстой. Үүний тулд ердийн шүүх дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан өргөдөл,

⁵⁴ Rules of Procedure of the Federal Constitutional Court (2014): https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/GO_BVerfG.pdf?__blob=publicationFile&v=11

⁵⁵ Order issued by the Plenary of the Federal Constitutional Court on 21 December 2022 pursuant to 14(4) of the Federal Constitutional Court Act (2022): https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/GV_Plenum/GV-Plenum_2022-12-21.pdf?__blob=publicationFile&v=3

хүсэлт болон эдгээр хянан шийдвэрлэх ажиллагааны бусад хураангуйг хавсаргасан байх эсхүл тэдгээрийн агуулгыг тодорхойлсон байх;

6. ХҮХШ-д ирүүлсэн холбогдох материал болон бусад баримт бичиг нь шүүхийн хавтаст хэргийн нэг хэсэг болох тул ерөнхийдөө буцааж өгдөггүй. Иймд хавтаст хэрэгт үлдээх боломжтой баримт материал болон хуулбарыг илгээх.⁵⁶

Үндсэн хуулийн гомдол хүлээн авах урьдчилсан нөхцөл

- Хугацааны хязгаарлалт: (Холбооны Үндсэн хуулийн шүүхийн хуулийн 93-р зүйл)⁵⁷ Шүүхийн шийдвэр, захиргааны актын эсрэг Үндсэн хуулийн гомдлыг нэг сарын дотор гаргах ёстой. Энэ хугацаанд гомдлын бүрдүүлбэрийг бүрэн гүйцээж өгөх ёстой. Хэрвээ гомдол гаргагчаас үл хамаарах шалтгаанаар энэ хугацааг дагаж мөрдөх боломжгүй байсан бол хүсэлт гаргасны дагуу хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тогтоолгох эрхтэй. Тухайн дагаж мөрдөөгүй шалтгааныг арилгаснаас хойш хоёр долоо хоногийн дотор гомдлыг гаргаж болдог.
- Хуульд заасан бүх арга замыг авч хэрэгжүүлсэн байх:
 - Ерөнхий: Үндсэн хуулийн гомдлыг ердийн шүүхээр шийдвэрлэх бүх хууль зүйн арга хэмжээг авч хэрэгжүүлж дууссан тохиолдолд л хүлээн авах боломжтой. Түүнчлэн Үндсэн хуулийн зөрчлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх бусад бүх боломжуудыг ашигласан байх ёстой байдаг.
 - Сонсох эрхийг зөрчсөн талаарх гомдлын урьдчилсан шаардлага
 - Хууль Үндсэн хууль зөрчсөн талаарх гомдлын урьдчилсан шаардлага

ХҮХШ-ийн шийдвэр, түүний үр дагавар

Холбооны Үндсэн хуулийн шүүхийн хуулийн 95-р зүйлд⁵⁸ дурдсанаар: ХҮХШ төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн, хуулийг хүчин төгөлдөр бус гэж тооцож, Үндсэн хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг эрх бүхий шүүхэд шилжүүлж болно. Шаардлагатай бол дараагийн шийдвэр гаргах эрх ердийн шүүхэд хамаардаг. Холбооны Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн гомдлын дагуу эдгээрээс өөр шийдвэр гаргах боломжгүй. Тухайлбал, хохирлыг барагдуулах, эрүүгийн хэрэг үүсгэх, эсхүл албадлагын арга хэмжээ авах гэх мэт. Түүнчлэн зарчмын хувьд үндсэн хуулийн гомдлын дагуу хууль тогтоогчийн зүгээс тодорхой арга хэмжээ авахыг шаардах, даалгах боломжгүй.

2.2.Бүгд Найрамдах Азербайжан Улс

Үндсэн хуулийн шүүх (Constitutional court)

Азербайжаны Үндсэн хуулийн шүүх нь 1995 онд батлагдсан “Үндсэн хууль”⁵⁹-ийн дагуу 1998 онд байгуулагдсан. Үндсэн хуулийн шүүх нь 9 гишүүнтэй бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь 1 удаа, 15 жил байдаг. Гишүүдийг Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр парламент нь томилдог бөгөөд дундаасаа даргаа сонгодог. Түүнийг нь Ерөнхийлөгч томилдог.

⁵⁶ Constitutional Complaints: https://www.bundesverfassungsgericht.de/EN/Verfahren/Wichtige-Verfahrensarten/Verfassungsbeschwerde/verfassungsbeschwerde_node.html Annual Report 2022:

⁵⁷ Act on the Federal Constitutional Court (1951):

https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/BVerfGG.pdf?__blob=publicationFile&v=19

⁵⁸ Act on the Federal Constitutional Court (1951):

https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/BVerfGG.pdf?__blob=publicationFile&v=19

⁵⁹ https://www.constituteproject.org/constitution/Azerbaijan_2016.pdf?lang=en Бүгд Найрамдах Азербайжан улсын Үндсэн хууль (1995)

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн 130 дугаар зүйлийн III дахь хэсэгт заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:⁶⁰

- Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн хууль болон бусад хэм хэмжээний актыг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах;
- Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн хууль, дүрэм, журам нь дээд шатлалын эрх зүйн баримт бичигтэй нийцэж байгаа эсэхийг хянах;
- Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн үндсэн дээр Үндсэн хууль, хуулийг тайлбарлах;
- Импичмент;
- Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хуваарилалтын талаарх маргаан;
- Ерөнхийлөгч, Парламентын сонгуулийн дүнг хянан баталгаажуулах;
- **Хуульд заасан Үндсэн хуулийн гомдол;**
- Үндсэн хуульд заасан бусад бүрэн эрх.

Үндсэн хуулийн гомдол

1. **Хууль зүйн үндэслэл:** “Үндсэн хууль”⁶¹-ийн 130 дугаар зүйл, “Үндсэн хуулийн цэцийн тухай хууль”⁶²-ийн 34 дүгээр зүйлд гомдлын агуулга, 52 дугаар зүйлд процессын талаар зааж өгчээ.
2. **Зорилго:** Үндсэн хуулийн түвшинд зөрчигдсөн хүний эрхийг сэргээх
3. **Хүсэлт гаргах үндэслэл:** Үндсэн хуулиар баталгаажуулсан үндсэн эрх нь төрийн эрх мэдлээ хэрэгжүүлсэн, эс хэрэгжүүлснээр зөрчигдсөн гэж үзэж байгаа этгээд⁶³ Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргаж болно.
4. **Процесс:**
 - **Гомдол гаргах хугацаа:**
 - ҮХШТХ⁶⁴-ийн 34.4.1-т зааснаар гомдлыг шүүхийн эцсийн шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор гаргана.
 - ҮХШТХ-ийн 34.4.2-т зааснаар гомдлыг иргэний хэргийн шүүхэд хандах эрхийг зөрчсөнөөс хойш гурван сарын дотор гаргана.
 - Гомдолд тусгах зүйл: Хэргийн заалт, гомдол гаргагч болон түүний өмгөөлөгчийн мэдээлэл, зөрчигдсөн гэх үндсэн эрхүүд, зөрчлийн шалтгаан (эс үйлдэхүй), хүсэлт гаргасан шалтгаан болон маргаан бүхий актын нэр, огноо, бусад шаардлагатай мэдээллүүд.
 - **Урьдчилсан хэлэлцүүлэг:** Гомдлыг ҮХШТХ-ийн 34.6-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэх судалгааг Үндсэн хуулийн шүүхийн Тамгын газар хэрэгжүүлнэ. Үндсэн хуулийн шүүхэд гаргасан асуулга, хүсэлттэй холбогдуулан мөн хуулийн 36.1-т заасны дагуу урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэхээр илтгэгч шүүгчийг томилно. Шүүгч нь нэг болон хэд хэдэн шүүгч байж болно. Үндсэн хуулийн цэцийн шүүх бүрэлдэхүүн гомдлыг 30 хоногийн дотор анхан шатны журмаар хянан хэлэлцэж, хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв гомдлыг хүлээн авах боломжгүй бол 7 хоногийн дотор

⁶⁰ <http://www.aaccsrd.org/en/membersLst.do#1> Азийн Үндсэн хуулийн шүүхийн холбоо (ААСС)

⁶¹ https://www.constituteproject.org/constitution/Azerbaijan_2016.pdf?lang=en Бүгд Найрамдах Азербайжан улсын Үндсэн хууль (1995)

⁶² <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/71141/143896/F1602049173/AZE-71141.pdf> Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, Азербайжан (2003)

⁶³ ҮХШТХ-ийн 34.5-т зааснаар “Өргөдөл гаргагчийн эрх, эрх чөлөөг зөрчсөний улмаас бусад шүүхээр дамжуулан ноцтой, нөхөж баршгүй хохирол учрахаас урьдчилан сэргийлэх боломжгүй бол гомдлоо Үндсэн хуулийн цэцэд шууд гаргаж болно” гэж заажээ.

⁶⁴ Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль

гомдол гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв гомдлыг хүлээн авсан гэж үзвэл 60 хоногийн дотор хянан, хэлэлцүүлнэ.

- **Холбогдох байгууллагуудын санал, дүгнэлтийг танилцуулах:** Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх ашиг сонирхол бүхий төрийн байгууллага, олон нийтийн байгууллага шийдвэрийн талаарх дүгнэлтээ Үндсэн хуулийн шүүхэд бичгээр гаргаж болно.

5. Шийдвэр ба үр дүн

- **Шүүхийн шийдвэрийн агуулга:** Гомдлын талаар гурван төрлийн шийдвэр байна. Үүнд:
 - **Татгалзах:** Хүсэлт нь үндэслэлгүй байх тохиолдлыг хэлнэ.
 - **Хэрэгсэхгүй орхих:** Хууль бусаар хүсэлт гаргасан тохиолдлыг хэлнэ.
 - **Баталгаажуулах:** Тав буюу түүнээс дээш шүүгч хүсэлтийг үндэслэлтэй гэж үзэж, хүлээж авах тохиолдлыг хэлнэ.

Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүний шийдвэр нь хуралдаанаас гаргасан бичмэл баримт бичиг бөгөөд шийдвэрийн үндэслэл, дүгнэлтийг эс зөвшөөрч байгаа шүүгч зарчмын зөрүүтэй саналаа бичгээр гаргаж болно. Зарчмын зөрүүтэй саналыг Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хамт нийтэлнэ.

- **Шийдвэрийн хүчин төгөлдөр байдал:** Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүний шийдвэр эцсийнх байх бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан хүчингүй болгох, өөрчлөх, албан ёсоор тайлбарлах боломжгүй.

2.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

Үндсэн хуулийн шүүх байгуулагдсан нь: Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Үндсэн хуульд орсон (1987 он) нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тус улсад 1988 онд анх Үндсэн хуулийн шүүх (Constitutional Court of Korea) байгуулагджээ. Үндсэн хуулийн шүүх (ҮХШ) байгуулагдаад харьцангуй богино хугацаа өнгөрсөн ч Солонгосын иргэдийн дунд явуулсан санал асуулгаар иргэдийн үндсэн эрх, нэр төрийг хамгаалах хамгийн найдвартай төрийн байгууллагаар ҮХШ шалгарсан байна.⁶⁵ Мөн ҮХШ нь Венецийн Комиссын гишүүн юм.


Ийнхүү Үндсэн хуулийн шүүх (ҮХШ) байгуулагдсанаас хойш хугацаанд (2023 оны 03 дугаар сарын байдлаар) Үндсэн хуулийн §68.1 буюу үндсэн эрх нь зөрчигдсөн гэж үзэж Үндсэн хуулийн шүүхэд 37,248 гомдол ирсэн тухай ҮХШ-ийн албан ёсны цахим хуудаст мэдээлсэн байна. Эдгээрээс 1,557 гомдол нь одоогоор хянан шийдвэрлэгдэх шатандаа байна.⁶⁶

Үндсэн хуулиар үндсэн хуультай холбоотой бүх эрх мэдлийг Үндсэн хуулийн шүүхэд хуваарилсан. Герман зэрэг Европын орнуудад үндсэн хууль зөрчигдсөн асуудлаар иргэд шууд ҮХШ-д өргөдөл гаргах боломжтой тогтолцоог ийнхүү бий болгосон нь иргэдийн үндсэн эрхийг чухалчилсан үндсэн хуулийн үзэл санааны бэлгэдэл юм.

Зураг 1. Солонгосын ҮХШ-ийн томоохон шийдвэрүүдийн тойм

⁶⁵ Past and Present of the Korean Constitutional Justice - Independence of the Constitutional Court of Korea - https://www.venice.coe.int/WCCJ/Rio/Papers/KOR_Constitutional_Court_E.pdf

⁶⁶ Constitutional Court of Korea <https://english.ccourt.go.kr/site/eng/jurisdiction/caseLoadStatic.do>



Эх сурвалж: “Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн 30 жил” (1988-2018) ном 2018 он.

Зураг 1-ээс үзвэл, ҮХШ 30 жилийн хугацаанд хувь хүний үндсэн эрх чөлөөтэй холбоотой 16, уг хэлэх эрхтэй холбоотой 15, сонгууль, улс төртэй холбоотой 35, орон нутгийн бие даасан байдалтай холбоотой 8, өмч, татвар, эдийн засгийн асуудалтай холбоотой 14, гэр бүл, хүйсийн тэгш байдалтай холбоотой 16, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой 15, нийгмийн хамгаалал, боловсролтой холбоотой 25, эрүүгийн хэрэг, хоригдлуудтай харилцахтай холбоотой 36 томоохон шийдвэрийг гаргажээ.⁶⁷

Үндсэн хуулийн шүүхийн Үндсэн хуулийн статус: “Үндсэн хуулийн шүүх” гэсэн үндсэн хуулийн зургаадугаар бүлэг нь бүхэлдээ ҮХШ-ийн эрх зүйн үндсийг тавьж, ҮХШ-ийн эрх мэдэл, бүрэлдэхүүн, ҮХШ-ийн шүүгчдийг томилох, огцруулах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хуульчилсан байна.

Үндсэн хуулийн шүүгчид: ҮХШ нь мэргэшсэн есөн шүүгчээс бүрдэх бөгөөд тэдгээрийг БНСУ-ын Ерөнхийлөгч томилно. Эдгээр шүүгчдийн гурвыг нь Үндэсний Ассамблейгаас сонгогдсон хүмүүсээс, гурвыг нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосон хүмүүсээс томилно. ҮХШ даргыг Үндэсний Ассамблейн зөвшөөрснөөр Солонгос Улсын Ерөнхийлөгч шүүгчдийн дундаас томилно. ҮХШ-ийн шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх бөгөөд хуульд заасан нөхцлөөр улиран томилогдож болно.

Үндсэн хуулийн §111.1-д зааснаар Үндсэн хуулийн шүүх дараах асуудлыг шийдвэрлэх эрхтэй. Үүнд:

1. Шүүхийн хүсэлтээр хууль Үндсэн хуульд нийцсэн эсэх;
2. Импичмент;
3. Улс төрийн намыг татан буулгах;
4. Төрийн байгууллагуудын хоорондын, төрийн байгууллага ба орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн засаг захиргааны хоорондын эрх мэдлийн маргаан;
5. Хуульд заасан Үндсэн хуулийн гомдол.


Хуульд заасан Үндсэн хуулийн гомдол: Энгийн шүүхийн шийдвэр гарсныг эс тооцвол төр эрх мэдлээ хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлээгүйн улмаас үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх нь зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд уг гомдлоо хянан шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно. Хэрэв бусад хууль тогтоомжоор дээрх зөрчигдсөн эрхийг хянан шийдвэрлэхээр хуульчилсан, тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж буй бол ҮХШ-д гомдол гаргахгүй.

Үндсэн хуулийн гомдол хянан шийдвэрлэх: Хуульд заасан үндсэн хуулийн гомдол гэдэгт үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрхээ эдлэх эрх нь зөрчигдсөн иргэд эсвэл Засгийн газар эрх мэдлээ хэрэгжүүлсэн ба хэрэгжүүлээгүй улмаас үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх нь зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд уг гомдлыг хянан шийдвэрлэх тухай хүсэлт Үндсэн

⁶⁷ Энэ талаар дэлгэрэнгүйг <https://english.court.go.kr/site/eng/ex/bbs/List.do> холбоосоос үзнэ үү.

хуулийн шүүхэд гаргах⁶⁸-ыг хэлдэг. Иргэд ҮХШ-д гомдлоо биечлэн, шуудангаар, бичгээр, мөн түүнчлэн гар утсаараа (<http://ecourt.ccourt.go.kr>) гаргах боломжтой. Харин хууль үндсэн хуульд нийцэж буй эсэх, импичментийн асуудлыг бичгээр гаргадаг байна. ҮХШ гомдлыг хянан шийдвэрлэхээр хүлээн авснаас хойш 180 хоногийн дотор эцсийн шийдвэрийг гаргана.⁶⁹

Зураг 2. Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх схем⁷⁰



Эх сурвалж: “Солонгосын Үндсэн хуулийн шүүх” 2021 он.

Үндсэн хуулийн §113.3-д Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалт, чиг үүрэг болон шаардлагатай бусад асуудлыг хуулиар тогтооно хэмээн заасан. (Дэлгэрэнгүйг хүснэгт 1-ээс үзнэ үү)

Хүснэгт 1.

Үндсэн хууль, Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль дахь үндсэн эрхийн гомдол шийдвэрлэхтэй холбоотой заалтууд		
Хуулийн нэр	Зүйл заалт	
1. Үндсэн хууль ⁷¹	I БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 8 дугаар зүйл (4) Улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нь ардчиллын язгуур үнэт зүйлд харшилбал Засгийн газар түүнийг татан буулгах тухай нэхэмжлэлийг Үндсэн хуулийн шүүхэд гаргаж болох бөгөөд <u>улс төрийн намыг Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр татан буулгана.</u>	
2.	III БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙ 65 дугаар зүйл (1) Энэ тохиолдолд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Төрийн зөвлөлийн гишүүд, Яамдын сайд нар, <u>Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид</u> , шүүгчид, Үндэсний сонгуулийн хорооны гишүүд, Хяналт, шалгалтын зөвлөлийн дарга, гишүүд, бусад хуулиар томилогдсон төрийн албан хаагчид тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэхдээ Үндсэн хууль болон бусад хууль зөрчсөн бол Үндэсний Ассамблей тэднийг огцруулах саналыг гаргаж болно.	
3.	V БҮЛЭГ. ШҮҮХ 107 дугаар зүйл (1) Шүүх хуралдаан хууль, Үндсэн хуульд нийцсэн эсэх маргаан гарсан тохиолдолд шүүх <u>Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг гаргуулж, түүний шийдвэрээр шүүнэ.</u>	
4.	VI БҮЛЭГ. ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ 111 дүгээр зүйл (1) Үндсэн хуулийн шүүх дараах асуудлыг шийдвэрлэх эрхтэй.	

⁶⁸ The Constitutional Court Act §68.1

⁶⁹ Filing Process <https://english.ccourt.go.kr/site/eng/03/10302010000002020081101.jsp>

⁷⁰ Constitutional Court of Korea 2021 https://english.ccourt.go.kr/fixfile/eng/ccourt_brochure_2021.pdf

⁷¹ Constitution of the republic of Korea https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1&lang=ENG

		<ol style="list-style-type: none"> 1. <u>Шүүхийн хүсэлтээр хууль Үндсэн хуульд нийцсэн эсэх;</u> 2. <u>Импичмент;</u> 3. <u>Улс төрийн намыг татан буулгах;</u> 4. <u>Төрийн байгууллагуудын хоорондын, төрийн байгууллага ба орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн засаг захиргааны хоорондын эрх мэдлийн маргаан;</u> 5. <u>Хуульд заасан Үндсэн хуулийн гомдол.</u> <p>(2) Үндсэн хуулийн шүүх нь мэргэшсэн есөн шүүгчээс бүрдэх бөгөөд тэдгээрийг Ерөнхийлөгч томилно.</p> <p>(3) (2)-д заасан шүүгчдийн гурвыг нь Үндэсний Ассамблейгаас сонгогдсон хүмүүсээс, гурвыг нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосон хүмүүсээс томилно.</p> <p>(4) Үндсэн хуулийн шүүхийн даргыг Үндэсний ассамблейн зөвшөөрснөөр Ерөнхийлөгч шүүгчдийн дундаас томилно.</p> <p>112 дугаар зүйл</p> <p>(1) Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх бөгөөд хуульд заасан нөхцлөөр улиран томилогдож болно.</p> <p>(2) Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид улс төрийн намд элсэхгүй, улс төрийн үйл ажиллагаанд оролцох ёсгүй.</p> <p>(3) Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг хорих ял, бусад хүнд ялаар шийтгэгдсэнээс бусад тохиолдолд албан тушаалаас нь огцруулахгүй.</p> <p>113 дугаар зүйл</p> <p>(1) Үндсэн хуулийн шүүхээс хууль Үндсэн хуульд нийцсэн эсэх, огцруулах тухай шийдвэр, улс төрийн намыг татан буулгах тухай шийдвэр, эсхүл Үндсэн хуульд заасан гомдлыг дэмжсэн тухай шийдвэр гаргахдаа зургаан буюу түүнээс дээш шүүгч зөвшилцөнө.</p> <p>(2) Үндсэн хуулийн шүүх хуулийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон дотоод сахилга баттай холбоотой журам, захиргааны хэргийн журам тогтоож болно.</p> <p>(3) Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалт, чиг үүрэг болон шаардлагатай бусад асуудлыг хуулиар тогтооно.</p>
<p>5.</p>	<p>Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль⁷² (1988.05.05) 68 дугаар зүйл 1</p>	<p>V БҮЛЭГ. ҮНДСЭН ХУУЛИЙН ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ</p> <p>68 дугаар зүйл (Гомдол гаргах үндэслэл)</p> <p>(1) Энгийн шүүхийн шийдвэр гарсныг эс тооцвол төр эрх мэдлээ хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлээгүйн улмаас үндсэн хуулиар баталгаажсан <u>үндсэн эрх нь зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд уг гомдлоо хянан шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно.</u> Хэрэв бусад хууль тогтоомжоор дээрх зөрчигдсөн эрхийг хянан шийдвэрлэхээр хуульчилсан, тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж буй бол үндсэн хуулийн гомдол гаргахгүй.</p> <p>69 дүгээр зүйл (Гомдол гаргах хугацаа)</p> <p>(1) Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх шалтгаан байгаа нь тогтоогдсон өдрөөс хойш 90 хоногийн дотор, харин шалтгаан үүссэнээс хойш нэг жилийн дотор шийдвэрлэнэ. Бусад хуульд заасан хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгасны дараа гаргасан Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэхийг уг процессын эцсийн шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гаргана.</p> <p>71 дүгээр зүйл (бичгээр гомдол гаргахад анхаарах зүйлс)</p> <p>(1) 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үндсэн хуулийн <u>гомдлыг хянан шийдвэрлэх тухай бичгээр гаргасан хүсэлтэд дараах зүйлийг тусгана.</u></p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Гомдол гаргагч болон түүний өмгөөлөгчийн талаарх мэдээлэл;</u> 2. <u>зөрчигдсэн эрх;</u> 3. <u>эрх зөрчигдөхөд хүргэсэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэхгүй байх;</u> 4. <u>Гомдлын шалтгаан;</u> 5. <u>Бусад шаардлагатай зүйлс.</u>

⁷² The Constitutional court act https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47509&lang=ENG

	<p>(3) Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх тухай бичгээр гаргасан хүсэлтэд өмгөөлөгч томилсныг гэрчлэх баримт бичиг, эсхүл шүүхээс томилогдсон өмгөөлөгчийг томилсон тухай мэдэгдлийг хавсаргана.</p> <p>72 дугаар зүйл (Урьдчилсан хяналт)</p> <p>(1) Үндсэн хуулийн шүүхийн дарга тус бүр гурван шүүгчээс бүрдсэн бүрэлдэхүүнийг Үндсэн хуулийн шүүхэд байгуулж, Үндсэн хуулийн шүүхэд гаргасан гомдлыг шүүх бүрэлдэхүүнээр хянуулж болно.</p> <p>(3) Дараах тохиолдолд шүүх бүрэлдэхүүн санал нэгдсэн бол гомдлыг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Үндсэн хуульд заасан гомдлыг бусад хуулиар хянан шийдвэрлэх боломжтой, эсхүл энгийн шүүхийн шийдвэрийн эсрэг шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол; 2. 69 дүгээр зүйлд заасан гомдол гаргах хугацаа дууссаны дараа үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх тухай хүсэлт гаргасан бол; 4. Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх тухай хүсэлт нь хууль бус бөгөөд хууль бус байдлыг засаж залруулах боломжгүй тохиолдолд. <p>75 дугаар зүйл (Дэмжих шийдвэр) Decision of Upholding</p> <p>(1) Үндсэн хуулийн гомдлыг хангах шийдвэрийг төрийн бүх байгууллага, орон нутгийн засаг захиргаа заавал биелүүлэх ёстой.</p> <p>(2) Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдлыг хангахдаа зөрчигдсэн үндсэн эрх, зөрчлийг үүсгэсэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, эс ашиглах зэргийг шийдвэрт тусгана.</p> <p>(3) (2)-д заасан тохиолдолд Үндсэн хуулийн шүүх үндсэн эрхийг зөрчсөн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхийг хүчингүй болгож, эсхүл түүнийг хэрэгжүүлэхгүй байгаа нь Үндсэн хууль зөрчсөн болохыг баталж болно.</p> <p>(4) Үндсэн хуулийн шүүх төрийн эрх мэдлээ хэрэгжүүлээгүй тухай Үндсэн хуулийн гомдлыг хангах тухай шийдвэр гаргахад хариуцагч уг шийдвэрийн зорилгод нийцүүлэн шинээр шийдвэр гаргана.</p> <p>(5) (2)-д заасан тохиолдолд Үндсэн хуулийн шүүх төрийн эрх мэдлийг хэрэгжүүлсэн, эс хэрэгжүүлсэн нь үндсэн хууль, түүний заалтаас үүдэлтэй гэж үзвэл уг хууль, заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн шийдвэртээ мэдэгдэж болно.</p>
--	--

2.4.Тайландын Хаант Улс

Үндсэн хуулийн шүүх (Constitutional court)

Тайландын Үндсэн хуулийн шүүх нь 1997 оны (анхны) “Үндсэн хууль”⁷³-ийн дагуу байгуулагдсан. Мөн 2017 онд шинэ “Үндсэн хууль”⁷⁴ батлагдсан. Энэ Үндсэн хуульд үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр иргэдийн эрх, эрх чөлөөг бодитоор хүлээн зөвшөөрч, хамгаалах тогтолцоог оруулж өгсөн байна.⁷⁵ Үндсэн хуулийн шүүх нь 9 шүүгчтэй. Шүүгч нар дундаасаа Үндсэн хуулийн шүүхийн ерөнхийлөгчийг сонгодог. Бүрэн эрхийн хугацаа нь 7 жил байдаг бөгөөд 75 насандаа тэтгэвэрт гардаг байна.

Үндсэн хуулийн шүүх нь “Үндсэн хууль”-ийн 9-р бүлэг, 200-214 дүгээр заалт болон “Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны тухай хууль”⁷⁶-ийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж

⁷³ https://constitutionnet.org/sites/default/files/Paper_on_the_1997_constitution_2.pdf Тайландын хаант улсын (анхны) Үндсэн хууль (1997)

⁷⁴ [https://constitutionnet.org/sites/default/files/2017-05/CONSTITUTION+OF+THE+KINGDOM+OF+THAILAND+\(B.E.+2560+\(2017\)\).pdf](https://constitutionnet.org/sites/default/files/2017-05/CONSTITUTION+OF+THE+KINGDOM+OF+THAILAND+(B.E.+2560+(2017)).pdf) Тайландын хаант улсын (шинэ) Үндсэн хууль (2017)

⁷⁵ <http://www.aaccsr.org/en/membersLst.do#1> Азийн Үндсэн хуулийн шүүхийн холбоо (AACC)

⁷⁶ [https://www.constitutionalcourt.or.th/occ_web/download/constitutionalcourt/lawrespon/statute/Organic%20Act%20on%20Procedures%20of%20CC\(2018\).pdf](https://www.constitutionalcourt.or.th/occ_web/download/constitutionalcourt/lawrespon/statute/Organic%20Act%20on%20Procedures%20of%20CC(2018).pdf) Тайландын “Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны тухай хууль” (2018)

байна. Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн 210 дугаар зүйлд заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:⁷⁷

1. Хууль, хуулийн төслийг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хэлэлцэж шийдвэрлэх;
2. Төлөөлөгчдийн танхим, Сенат, Үндэсний Ассемблей, Сайд нарын зөвлөл болон бусад бие даасан байгууллагуудын үүрэг, бүрэн эрхийн тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх (эрх мэдлийн хуваарилалт);
3. Үндсэн хуульд заасан бусад бүрэн эрх (Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах).

Үндсэн хуульд заасан бусад бүрэн эрх (Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах)

1. **Хууль зүйн үндэслэл:** “Үндсэн хууль”⁷⁸-ийн 5-р бүлэг (Төрийн үүрэг, хариуцлага)-ийн 51 дүгээр хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлэх.
2. **Зорилго:** Үндсэн хуульд заасан Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахыг төрөөс шаардах эрхтэй, төрийн холбогдох байгууллагуудыг хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх эрхийг хангах.
3. **Хүсэлт гаргах үндэслэл:** Төрийн байгууллагын үйл ажиллагаа доголдох, түүний улмаас ард иргэд, олон нийт хохирсон. Иргэд, олон нийт үндсэн эрхийн гомдлыг гаргадаг боловч сайд нарын зөвлөлөөр урьдчилан авч хэлэлцэж байгаа нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн байр суурьтай. Үндсэн хуулийн шүүхэд гомдлоо гаргах, хэлэлцүүлэх эрхтэй.
4. **Процесс:**
 - **Гомдол гаргах хугацаа:**
 - o Иргэд, олон нийт гомдлоо холбогдох төрийн байгууллагад гаргаж болно. (90 хоног)
 - o Иргэд, олон нийт гомдлоо Омбудсмэнд гаргаж болно. (30 хоног) Омбудсмэнээс төрийн байгууллагын буруу гэж үзвэл иргэд олон нийтэд эргэж мэдээлдэг бол төрийн байгууллагын зөв гэж үзвэл Сайд нарын зөвлөл (Council of Ministers)-д мэдэгддэг.
 - o Сайд нарын зөвлөл хэлэлцээд шийдвэр нь иргэд, олон нийт хүлээн зөвшөөрөхгүй бол Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах эрхтэй. (30 хоног)
5. **Шийдвэр ба үр дүн:** Үндсэн хуулийн шүүх гомдол хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор хянан шийдвэрлэдэг. Энэ шийдвэр эцсийн бөгөөд төрийн байгууллага заавал биелүүлэх ёстой байдаг.

2.5.Бүгд Найрамдах Тажикстан Улс

Үндсэн хууль

Бүгд Найрамдах Тажикстан Улс (БНТУ) нь 1991 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр тусгаар тогтнолоо зарласан бөгөөд Үндсэн хуулиа (Constitution of the republic of Tajikistan)⁷⁹ 1994 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр баталсан байна. Үндсэн хуульдаа дараах зүйлсийг тунхаглажээ.

Үүнд: “Тажикстаны ард түмэн бид:

- өнгөрсөн, одоо, хойч үеийнхээ өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлах;
- улсынхаа бүрэн эрхт байдал, хөгжлийг хангах зайлшгүй шаардлагатайг ойлгох;

⁷⁷ [https://constitutionnet.org/sites/default/files/2017-05/CONSTITUTION+OF+THE+KINGDOM+OF+THAILAND+\(B.E.+2560+\(2017\)\).pdf](https://constitutionnet.org/sites/default/files/2017-05/CONSTITUTION+OF+THE+KINGDOM+OF+THAILAND+(B.E.+2560+(2017)).pdf) Тайландын хаант улсын (шинэ) Үндсэн хууль (2017)

⁷⁸ [https://constitutionnet.org/sites/default/files/2017-05/CONSTITUTION+OF+THE+KINGDOM+OF+THAILAND+\(B.E.+2560+\(2017\)\).pdf](https://constitutionnet.org/sites/default/files/2017-05/CONSTITUTION+OF+THE+KINGDOM+OF+THAILAND+(B.E.+2560+(2017)).pdf) Тайландын хаант улсын (шинэ) Үндсэн хууль (2017)

⁷⁹ Constitution of the republic of Tajikistan, <https://www.prokuratura.tj/en/legislation/the-constitution-of-the-republic-of-tajikistan.html>

- хүний эрх, эрх чөлөөг бататгах;
- бүх үндэстэн, ард түмнийхээ эрх тэгш байдал, эв найрамдлыг хүлээн зөвшөөрөх;
- шударга нийгмийг байгуулахыг зорилгоо болгох” гэжээ.

Хуулийн 1-р бүлгийн 5 дугаар зүйлд “Хүн, түүний эрх, эрх чөлөө нь дээд үнэт зүйл мөн.” гэж заасан.

БНТУ-ын Үндсэн хуулийн 2-р бүлэг нь “Хувь хүн, иргэний эрх, эрх чөлөө, үндсэн үүрэг” гэсэн агуулгыг багтаажээ.

Хуулийн 14 дүгээр зүйлд “Хувь хүн, иргэний эрх, эрх чөлөөг Үндсэн хууль болон Бүгд Найрамдах Улсын хууль тогтоомж, БНТУ-д хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр хамгаална.” гэж, 17 дугаар зүйлд “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, мэдлэг боловсрол, нийгмийн гарал, эд хөрөнгийн байдлаас үл хамааран хувь хүн, иргэн бүрийн эрх, эрх чөлөөг төр баталгаажуулна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй.” гэж, 31 дүгээр зүйлд “Иргэд төрийн байгууллагад ганцаараа болон хэсэг бүлэг хүмүүстэй хамтран өргөдөл, гомдол гаргах эрхтэй.”, 42 дугаар зүйлд “Тажикстан Улсад хүн бүр Үндсэн хууль, бусад хуулийг дагаж мөрдөх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх үүрэгтэй.” гэж тус тус заасан байна.

БНТУ-ын Ерөнхийлөгч нь төрийн болон гүйцэтгэх засаглалын (Засгийн газар) тэргүүн байна гэж Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд тусгажээ. Ерөнхийлөгч нь “Үндсэн хуулийн шүүх, Улсын дээд шүүх, Эдийн засгийн дээд шүүхийн дарга, орлогч, шүүгчдийг томилуулах буюу эргүүлэн татуулахаар УИХ-д нэрийг нь дэвшүүлэх” бүрэн эрхтэй байна.

Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд “Шүүх эрх мэдэл нь хараат бус байх бөгөөд төрийн нэрийн өмнөөс шүүгч хэрэгжүүлнэ. Шүүх эрх мэдэл нь хувь хүн, иргэний эрх, эрх чөлөө, төр, байгууллагын хууль ёсны ашиг сонирхол, шударга ёсыг хамгаална.

Шүүхийн тогтолцоо нь:

- Үндсэн хуулийн шүүх;
- Улсын дээд шүүх;
- Эдийн засгийн дээд шүүх;
- Цэргийн шүүх;
- Бадахшан Уулын Өөртөө Засах Орны шүүх, бүс нутгийн эдийн засгийн шүүх;
- Душанбе хот, дүүргийн шүүх;
- Бадахшан Уулын эдийн засгийн шүүхээс бүрдэнэ.

Үндсэн хуулийн шүүх

БНТУ-ын Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн хэм хэмжээг дээдлэх, шууд үйл ажиллагааг хангах зорилгоор байгуулагдсан үндсэн хуулийн хяналтын, бие даасан шүүх эрх мэдлийн байгууллага юм. Тус байгууллагын үйл ажиллагааг БНТУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай (**On constitutional court of the republic of Tajikistan**)⁸⁰ хуулиар зохицуулж байна.

Үндсэн хуулийн шүүх нь БНТУ-ын Ерөнхийлөгчийн 1995 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 238 дугаар “БНТУ-ын Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалтын үйл ажиллагааны тухай” зарлигаар анх байгуулагдах үндэс нь тавигдсан.

⁸⁰ On constitutional court of the republic of Tajikistan., <https://constcourt.tj/en/hujatho/the-constitutional-law-of-the-republic-of-tajikistan-on-constitutional-court-of-the-republic-of-tajikistan/>

Үндсэн хуулийн шүүх нь долоон гишүүнээс (дарга, дэд дарга, таван шүүгч) бүрдэнэ. Тэдгээрийн нэг нь Горно-Бадахшан өөртөө засах орны (Gorno-Badakhshan Autonomous Region) төлөөлөгч байна.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрх зүйн байдал, өндөр хариуцлагатай нөхцөл байдлыг харгалзан үзэж эдгээр албан тушаалд сонгогдох хүсэлтэй хүмүүст хэд хэдэн шаардлага тавьсан. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн албан тушаалд нэр дэвшигч нь хууль зүйн дээд боловсролтой, 30-аас доошгүй, 65-аас дээшгүй настай, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, БНТУ-ын иргэн байх ёстой. Шүүгч нь 10 жилийн хугацаагаар сонгогдоно.

БНТУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь халдашгүй эрхтэй байна.

Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үйл явц:

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг бүх тохиолдолд нийтэд зарлах бөгөөд шүүх хуралдаан нь талуудын өрсөлдөх чадвар, тэгш байдлын үндсэн дээр явагдана.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид нь бүгд тэгш эрхтэй байна.

БНТУ-ын Үндсэн хуулийн шүүхэд *иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн* гэж үзвэл дараах байгууллагын албан тушаалтнууд өргөдөл, гомдол гаргах эрхтэй байна. Үүнд: (§28, §40)

- БНТУ-ын Хүний эрхийн комиссын дарга, төлөөлөгч;
- Хувь хүмүүс;
- Хуулийн этгээд;
- Дээд шүүхийн шүүгчид, Эдийн засгийн дээд шүүхийн шүүгчид, БНТУ-ын бусад шүүгчид (Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдээс бусад хамаарна)

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн хэм хэмжээг даган биелүүлэх, дээдлэх, иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хамгаалах болон бусад асуудлаар БНТУ-ын Ерөнхийлөгчид гомдол гаргаж болно. §37

Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах:

БНТУ-ын Үндсэн хуулийн шүүхэд гомдлыг бичгээр (мэдүүлэг болон өргөдөл) гаргана.

Давж заалдах гомдол гаргагч нь холбогдох шийдвэр гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно. Үндсэн хуулийн шүүх нь өргөдлийг хүлээн авснаас хойш 6 сарын хугацаанд хянан шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн шүүх нь хэргийг хянан хэлэлцээд тогтоол гаргана, тогтоолд Үндсэн хуулийн шүүхийн дарга, шүүгч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Шүүхийн тогтоолыг шүүх хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхын саналаар дэмжиж баталсан бол хүчин төгөлдөр болсонд тооцно. Хүчин төгөлдөр болсон шүүхийн тогтоол, дүгнэлтийг нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нийтэд зарлана.

БНТУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тогтоол нь эцсийнх бөгөөд давж заалдах эрхгүй, хамаарал бүхий хуулийн этгээд, хувь хүн бүгд дагаж мөрдөх, заавал биелүүлэх үүрэгтэй байна. Хэрэв шүүхийн тогтоолыг дагаж мөрдөөгүй, хагас дутуу биелүүлсэн, хэрэгжүүлэхэд саад учруулсан бол БНТУ-ын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

БНТУ-ын Хүний эрхийн комисс

БНТУ-ын Хүний эрхийн комисс (Ваколатдор оид ба ҳуқуқи инсон дар чумҳурии Тоҷикистон)⁸¹ нь ардчилсан, эрх зүйт, иргэний нийгмийн төр, хүний эрхийг хамгаалах, дэмжих үр дүнтэй механизмыг төлөвшүүлэхэд чиглэгддэг.

Хүний эрхийн комисс нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, дэмжихтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөө хамгаалах асуудалд хяналт шалгалт хийх, хяналт тавих, хүний эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр дүн шинжилгээ хийх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

БНТУ-ын Дээд Ассамблейгаас (Мачлиси Олии ҶТ) 2008 онд “БНТУ-ын хүний эрхийн комиссын тухай” (Конуни чумҳурии тоҷикистон дар бораи ваколатдор оид ба ҳуқуқи инсон дар чумҳурии Тоҷикистон)⁸² хуулийг баталсан байна.

Тус хуулийг БНТУ-д Хүний эрхийн Омбудсман байгуулах зорилгоор баталсан байна. Хүний эрхийн комисс нь иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах үндсэн хуулийн баталгааг бэхжүүлэх, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага (олон нийтийн) болон тэдгээрийн албан тушаалтнууд, аж ахуйн нэгж, байгууллага, байгууллагын удирдлага, албан тушаалтнууд, тэдгээрийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрээс үл хамааран тэдгээрийг дагаж мөрдөх, хүндэтгэхийг сурталчлах үндсэн чиг үүрэгтэй.

Хүний эрхийн комисс БНТУ-ын Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргах: Иргэний эрх, эрх чөлөөг БНТУ-ын эрх зүйн актууд зөрчсөн тохиолдолд Хүний эрхийн комисс нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг тогтоохоор Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргах эрхтэй байна.

⁸¹ Ваколатдор оид ба ҳуқуқи инсон дар чумҳурии Тоҷикистон, <http://ombudsman.tj/dar-borai-ma-otot/malumoti-umum.html>

⁸² Конуни чумҳурии тоҷикистон дар бораи ваколатдор оид ба ҳуқуқи инсон дар чумҳурии Тоҷикистон, <http://mmk.tj/content/>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Үндсэн хуулийн хяналтын хэрэгждэг хэлбэрийн харьцуулсан судалгаа, Д.Солонго, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019
- Үндсэн хуулийн шүүхээр үндсэн эрхийг хамгаалах арга зам, А.Бямбажаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019
- Хууль батлах эрх мэдэлд тавих шүүхийн хяналт: Улс төрийн сонголтыг үндсэн хуулиар хязгаарлах нь. П.Амаржаргал, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, 2019
- Helga Seibert., “Admissibility requirements for constitutional complaints and mechanisms for avoiding an excessive case load”. European Commission for Democracy Through Law (Venice Commission)
- Constitutional Review Systems Around the World, Dr. Arne Marjan Mavčič, 2018
- <http://concourts.net/introen.php>
- <http://concourts.net/tab/tab1.php?lng=en&stat=1&prt=0&srt=0>
- <http://www.aaccsrd.org/en/main.do>
- <http://www.aaccsrd.org/en/pubsDtl.do>
- <https://www.un.org/en/about-us#:~:text=Currently%20made%20up%20of%20193,contained%20in%20its%20founding%20Charter> <https://www.un.org/en/>
- <https://www.venice.coe.int/webforms/events/>
- <http://www.aaccsrd.org/en/aboutUs.do>

ХБНГУ

- The Federal Constitutional Court:
https://www.bundesverfassungsgericht.de/EN/Homepage/home_node.html
- Constitutional Complaints:
https://www.bundesverfassungsgericht.de/EN/Verfahren/Wichtige-Verfahrensarten/Verfassungsbeschwerde/verfassungsbeschwerde_node.html
- Annual Report 2022:
https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Jahresbericht/jahresbericht_2022.pdf?__blob=publicationFile&v=3
- Legal source:
https://www.bundesverfassungsgericht.de/EN/Verfahren/Rechtsquellen/rechtsquellen_node.html;jsessionid=56BA0B787C9DDEE4A458C67B52D94DB1B.internet991
- Basic law for the Federal Republic of Germany (1949):
https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/
- Act on the Federal Constitutional Court (1951):
https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/BVerfGG.pdf?__blob=publicationFile&v=19
- Rules of Procedure of the Federal Constitutional Court (2014):
https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/GO_BVerfG.pdf?__blob=publicationFile&v=11
- Order issued by the Plenary of the Federal Constitutional Court on 21 December 2022 pursuant to 14(4) of the Federal Constitutional Court Act (2022):
https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/GV_Plenum/GV-Plenum_2022-12-21.pdf?__blob=publicationFile&v=3

БНСУ

- The Constitution of the Republic of Korea
https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1&lang=ENG
- The Constitutional Court Act
https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47509&lang=ENG
- Rules of Adjudication of the Constitutional Court 2007.12.07 p-690
- Constitutional Court of Korea <https://english.ccourt.go.kr>
- “Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн 30 жил” (1988-2018) 2018 он.
<https://english.ccourt.go.kr/site/eng/ex/bbs/List.do>
- Constitutional Court of Korea 2021.
https://english.ccourt.go.kr/fixfile/eng/ccourt_brochure_2021.pdf

Тажикстан

- Constitution of the republic of Tajikistan, <https://www.prokuratura.tj/en/legislation/the-constitution-of-the-republic-of-tajikistan.html>
- On constitutional court of the republic of Tajikistan, <https://constcourt.tj/en/hujatho/the-constitutional-law-of-the-republic-of-tajikistan-on-constitutional-court-of-the-republic-of-tajikistan/>
- Уполномоченный по правам человека в республике Таджикистан,
<http://ombudsman.tj/>
- Конуни чумхурии тоҷикистон дар бораи ваколатдор оид ба ҳуқуқи инсон дар чумхурии Тоҷикистон, <http://mmk.tj/content/>
- Jurisdictions and Organization of AACC Members,
<http://www.aaccsrd.org/en/membersLst.do#1>

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН ТООНЫ ХУВИЛБАНУУДАД УЛСЫН ИХ ХУРЛААС ШИЙДВЭР ГАРГАХ САНАЛЫН ТООГ ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА

*Г.Билгээ, Д.Халиун,
Э.Дагшээгвэ, Л.Хурцбилээ*

Монгол Улсын Их Хурал 2022 оны 54 дүгээр тогтоолоороо “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 01, 02 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт-тэнцлийг хангах хүрээнд төрийн эрх барих дээд байгууллагад ард түмнийг төлөөлөх Улсын Их Хурлын гишүүдийн тоог шинэчлэн тодорхойлох, Улсын Их Хурлын сонгуулийн дэвшилтэт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд төслийг холбогдох Байнгын хороод болон нэгдсэн хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр явуулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу Улсын Их Хурал (УИХ)-ын гишүүд Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг олон нийтэд танилцуулах, иргэд, сонгогчдоор хэлэлцүүлж, санал авах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 08-наас 16-ны өдрүүдэд тойрогтоо зохион байгуулсан.

УИХ-ын гишүүдийн тойрогтоо хийсэн уулзалтын үеэр иргэд “УИХ-ын гишүүдийн тоо хэд байвал оновчтой гэж үзэж байна вэ?” гэсэн асуултад олон хувилбаруудыг дэвшүүлжээ. Үүнтэй уялдуулан энэхүү судалгаанд УИХ-ын хуралдааныг хүчинтэйд тооцох ирц болон УИХ-аас шийдвэр гаргах саналын тоо нь иргэдээс хамгийн олон давтамжтай ирсэн УИХ-ын гишүүдийн тооны хувилбаруудтай уялдан хэрхэн өөрчлөгдөхийг авч үзсэн болно. (Хүснэгт 3.)

Монгол Улсын Үндсэн хуулинд заасан УИХ-ын хуралдааныг хүчинтэйд тооцох ирц болон УИХ-аас шийдвэр гаргах саналын тоог дараах байдлаар тогтоосон байна. (Хүснэгт 1.)

Хүснэгт 1. УИХ-аас шийдвэр гаргах саналын босготой холбоотой Үндсэн хуулийн зохицуулалт

Үндсэн хуулийн заалт	Шийдвэр гаргах саналын босго
Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж санал болгосон бол Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.”	66.7%
Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг “Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. ”	50.0% + 1
Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг эцэслэн батална.	50.0% + 1
Хорин долдугаар зүйлийн 7 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол нууц санал хураалт явуулна.”	50.0% + 1
Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо	25.0%

байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.”	
Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт “Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ”	66.7%
Гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна.”	66.7%
Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.”	25.0% 50.0% + 1
Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.”	50.0% + 1
Жаран наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно.”	66.7%
Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална.” Жаран есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй.”	75.0%

Үндсэн хуульд УИХ-аас шийдвэр гаргах саналын босгыг “гишүүдийн гуравны нэг, гуравны хоёр, дөрөвний гурав, дийлэнх олонхи, (энгийн) олонхи” гэж томъёолсон байдаг. Эдгээр томъёоллыг хэрхэн ойлгохыг дараах Хүснэгтээс харж болно.

Хүснэгт 2. Нэр томъёоны тайлбар

Нэр томъёо	Олон улсын нэршил	Тайлбар
Энгийн олонхи	Simple Majority	тоологдсон нийт саналын (санал хураалтад оролцсон гишүүдийн) 50.0% + 1 санал авсныг
Үнэмлэхүй олонхи	Absolute Majority	тоологдвол зохих нийт саналын (нийт гишүүдийн) 50.0% + 1 санал авсныг
Харьцангуй олонхи	Effective Majority	хамгийн олон санал авсныг
Дийлэнх олонхи	Special Majority	“гуравны хоёр” (66.7%), “дөрөвний гурав” (75.0%) г.м. тодорхой заасан санал авсныг

Эх сурвалж: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа. Монгол Улсын Их Хурал. УБ., 2017 он. 39 дэх тал.

Үндсэн хуульд УИХ-аас шийдвэр гаргах саналын босгыг тооцохдоо “нийт гишүүдийн”, эсхүл “хуралдаанд оролцсон гишүүдийн” гэсэн хоёр үндсэн нөхцөлөөс хамаарахаар тогтоосон. Тухайлбал, УИХ-ын тодорхой зарим шийдвэрүүд нь “нийт гишүүдийн” 3/4, 2/3, олонхийн

саналаар хүчин төгөлдөр болно. Харин “хуралдаанд оролцсон гишүүдийн” 2/3, олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

Ирцийн хувьд Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар УИХ-ын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны **хуралдааныг гишүүдийн олонхи** (50.0%+1) нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

Хүснэгт 3. УИХ-ын гишүүдийн тооны хувилбаруудад УИХ-аас шийдвэр гаргах саналын тоог харьцуулсан байдал

Гишүүдийн тооны хувилбар	Нийт гишүүний				Хуралдаанд оролцсон	
	3/4-аас доошгүй	2/3-оос доошгүй	олонхи	1/4-ээс доошгүй	нийт гишүүний 2/3-оос доошгүй / дийлэнх олонхи	гишүүдийн олонхи
	75.0%	66.7%	50.0% + 1	25.0%	66.7%	50.0% + 1
	Үндсэн хуулийн заалт					
	§69.1.	§22.2; 68.2.	§27.6; 43.1; 44.1.	§28.2; 43.1.	§33.1.1; 35.2.	§27.6; 27.7.
76	57.0	50.7	39.0	19.0	26.0	19.5
84	63.0	56.0	43.0	21.0	28.7	21.5
96	72.0	64.0	49.0	24.0	32.7	24.5
99	74.3	66.0	50.5	24.8	33.7	25.3
108	81.0	72.0	55.0	27.0	36.7	27.5
111	83.3	74.0	56.5	27.8	37.7	28.3
120	90.0	80.0	61.0	30.0	40.7	30.5
126	94.5	84.0	64.0	31.5	42.7	32.0
132	99.0	88.0	67.0	33.0	44.7	33.5
144	108.0	96.0	73.0	36.0	48.7	36.5
152	114.0	101.3	77.0	38.0	51.3	38.5
156	117.0	104.0	79.0	39.0	52.7	39.5

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН
СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦОО**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Г.Билгээ,
Ц.Ариунаа, П.Уранчимэг*

АГУУЛГА

УДИРТГАЛ

ТОВЧИЛСОН ҮГ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

1. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо
2. Парламентын сонгуулийн холимог тогтолцоотой зарим орны туршлага
 - 2.1. Мажоритар болон хувь тэнцүүлсэн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа
 - 2.2. Хувь тэнцүүлэх тогтолцооны тойргуудын түвшин болон хэмжээ
 - 2.3. Хувь тэнцүүлэх зарчмаар жагсаалтаас сонгогдох шалгуур
 - 2.4. Саналын хуудасны тоо
 - 2.5. Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны суудал хуваарилах арга
 - 2.6. Хувь тэнцүүлсэн тогтолцоон дахь намын нээлттэй болон хаалттай жагсаалт
 - 2.7. Парламентад суудал хуваарилах саналын босго
 - 2.8. Гадаадад суугаа сонгогчдын санал авах ажил

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн холимог тогтолцоо

Хүснэгт 2. Сонгуулийн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа

Хүснэгт 3. Тойргуудын түвшин, хэмжээ

Хүснэгт 4. Саналын хуудасны тоо

Хүснэгт 5. Тойргуудын хэмжээ, түвшин

Хүснэгт 6. Намын жагсаалт

Хүснэгт 7. Жагсаалтаар хувь тэнцүүлэх (ЖХТ) босго

Хүснэгт 8. Гадаадад суугаа сонгогчдын санал авах ажил

Зургийн жагсаалт

Зураг 1. Парламентын сонгуулийн тогтолцооны ангилал

Зураг 2. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо (засаглалын хэлбэрээр)

Товчилсон үг

ХОТ харьцангуй олонхын тогтолцоо

ХШТ хоёр шатлалт тогтолцоо

ХИҮ хамгийн их үлдэгдэл

ХИД хамгийн их дундаж

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Гадаадын зарим орны парламентын сонгуулийн холимог тогтолцоо” сэдэвт мэдээлэл, лавлагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (ПССХ)-д гүйцэтгэв.

Судалгааны захиалгын даалгавар:

Дэлхийн улс орнуудын парламентын холимог тогтолцоон дахь пропорционал ба мажоритар суудлын хувь, харьцааны талаарх мэдээлэл.

Судалгааны зорилго:

Гадаадын зарим орны парламентын сонгуулийн холимог тогтолцоо, холимог тогтолцооны зэргэлдээ болон холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны хэлбэрүүд, сонгуулийн холимог тогтолцоо, тэр дундаа суудлын хувь, харьцааны талаарх олон улсын туршлагыг судлах.

Судалгааны хамрах хүрээ:

Аль ч улс оронд сонгууль бүх нийтийн, чөлөөтэй, тэгш, шууд, нууц байх гэсэн зарчмуудад нийтлэг байдлаар суурилах боловч зарим улсад эдгээр зарчмын аль нэг нь байхгүй, эсхүл заавал санал өгөх зарчмыг нэмж тусгасан байдаг. Онолын үүднээс авч үзвэл, шууд сонгох эрх гэдэгт сонгогч хэн нэгэн төлөөллөөр дамжуулахгүйгээр өөрөө саналаа өгөхийг ойлгоно. Тиймээс онолын болон нийтлэг зарчмуудын хүрээнд бусад орнуудад сонгуулийн холимог тогтолцоог хэрхэн нутагшуулж, пропорционал болон мажоритар тогтолцооны элементүүдийг хослуулан хэрэглэж байгаа талаарх мэдээллийг дараах асуудлуудын хүрээнд авч үзлээ:

- Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо;
- Парламентын сонгуулийн холимог тогтолцоотой зарим орны туршлага.

Судалгааны бүтэц:

Судалгаа нь бүтцийн хувьд удиртгал, судалгааны хураангуй, дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо, парламентын сонгуулийн холимог тогтолцоотой зарим орны туршлага гэсэн хэсгээс бүрдэнэ.

Судалгаанд Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA)-гээс гаргасан “Сонгуулийн холимог тогтолцоо” судалгааны тайлан (2023 он), Улсын Их Хурлын Тамгын газрын ПССХ-гээс гаргасан “Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо” (2022 он) тойм судалгаануудыг мэдээллийн эх сурвалж болгон ашигласан болно.

Түлхүүр үг: парламентын сонгуулийн тогтолцоо, холимог тогтолцоо, мажоритар тогтолцоо, пропорционал тогтолцоо, зэрэгцээ (параллел) тогтолцоо, холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо.

Key words: mixed system, plurality/majority system, proportional representation system, parallel system, mixed member proportional (MMP).

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Сонгуулийн тогтолцооны хүрээнд нэр дэвшүүлэх, санал хураах ба тоолох, эцсийн дүнг нэгтгэн гаргах зэрэг асуудлуудыг авч үздэг. Сонгуулийн тогтолцооны онолыг сонгуулийн эрх зүй гэж хэлбэр талаас нь тодорхойлж болох боловч түүний цаана улс төр, эдийн засаг, математикийн олон агуулга оршиж байдаг.

Парламентын сонгуулийн тогтолцоог (1) олонхыг төлөөлөх, (2) хувь тэнцүүлэн хуваарилах, (3) холимог гэсэн 3 ангилалд авч үздэг. Түүнчлэн эдгээрийн алинд ч хамааруулж болохооргүй үл шилжих нэг саналын арга, хязгаарлагдмал саналын арга, саналыг дугаарлаж өгөх Бордагийн тооцооны арга гэх мэт аргууд байдаг.

Олон улсын парламентын холбоо (IPU)-ны судалгаанаас үзэхэд, 2022 оны байдлаар дэлхийн 192 улс орны парламент (парламентын нэг танхимт болон доод танхим)-ын сонгуульд дараах сонгуулийн тогтолцоог хэрэглэж байна:

- сонгуулийн холимог тогтолцоог - 32 улс (16.7%);
- олонхыг төлөөлөх тогтолцоог - 65 улс (34.8%);
- хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоог - 77 улс (41.1%);
- бусад тогтолцоог - 6 улс (3.2%);
- шууд сонгууль явуулдаггүй - 7 улс (3.7%);
- мэдээлэл байхгүй - 5 улс байна.

Парламентын сонгуулийн холимог тогтолцоо нь хувь тэнцүүлсэн болон олонхыг төлөөлөх гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй нийлмэл тогтолцоо юм. Холимог тогтолцоо нь дараах хоёр үндсэн хэлбэртэй байна:

- (1) *зэрэгцээ (параллел) тогтолцоо нь* сонгогч олонхыг төлөөлөх хэсэгт нэг санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт нэг санал өгдөг тогтолцоо юм;
- (2) *холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо нь* сонгогчийн нэг саналаар хоёр өөр тогтолцоонд суудал хуваарилах арга юм. Өөрөөр хэлбэл, олонхын тогтолцооны дүнг тодруулсны дараа хувь тэнцүүлэх журмаар хуваарилах суудлын тоог тогтоож, улмаар хувь тэнцүүлсэн дүн буюу нийлбэрийг нь тооцон гаргадаг тогтолцоо юм.

Сонгуулийн холимог тогтолцоог хэрэглэдэг 32 улсын 19 буюу 59.4 хувь нь зэрэгцээ тогтолцоог, 9 буюу 28.1 хувь нь холимог хувь тэнцүүлсэн тогтолцоог хэрэглэдэг байна. Бусад 4 улсын мэдээлэл байхгүй байна. (Хүснэгт 1.)

Сонгуулийн тогтолцоотой холбоотой харилцааг хангалттай түвшинд тодорхой зохицуулаагүйгээс сонгуулийн маргаан үүсэх нөхцөл бий болж, цаашлаад сонгуулийн үр дүнг хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөхөд хүндрэлтэй болдог.

Сонгуулийн тогтолцоо практикт чухам ямар үр дүнд хөтлөх нь ихэнх тохиолдолд сонгуулийн холимог тогтолцоотой холбоотой дараах хүчин зүйлсээс хамаарах бөгөөд тэдгээрийг улс орнуудад хэрхэн зохицуулсан байдгийг авч үзэхэд:

(1) *Мажоритар болон хувь тэнцүүлсэн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа:* Холимог тогтолцооны зорилго нь гол гол улс төрийн хүчнүүдийн оролцоог хангахад чиглэдэг бөгөөд сонгуулийн холимог тогтолцооны хоёр бүрэлдэхүүн хэсгийн суудлын тоо нь ойролцоо байдаг. Судалгаанд авагдсан орнуудад энэ тооны харьцаа 2:1 байна. Тухайлбал, Балба, Шинэ Зеланд, Японд 60:40, Герман, Литвад 50:50, Итали, Киргизид 40:60-ийн харьцаатай байна. (Хүснэгт 2.)

(2) *Хувь тэнцүүлэх тогтолцооны тойргийн түвшин болон хэмжээ* нь үндэсний хэмжээний нэг тойрогт, эсхүл засаг захиргаа, бусад холбогдох нэгжид үндэслэн байгуулсан

орон нутгийн тойргуудын түвшинд хуваарилагдсан байдаг. Тухайлбал, Балба, Лесото, Литва, Шинэ Зеланд, Япон зэрэг 5 улсад үндэсний хэмжээний нэг тойрогтой байдаг бол Италид - 63, Германд - 16, Киргизид - 11, Шотландад - 8 тойрогт хуваарилагддаг байна. (Хүснэгт 3.)

(3) *Хувь тэнцүүлэх зарчмаар жагсаалтаас сонгогдох шалгуур*: Хувь тэнцүүлэх тогтолцооны зорилго нь улс төрийн янз бүрийн үзэл санаа, бодлого, байр суурьтай улс төрийн бүлгүүдийн оролцоог хувь тэнцүүлэн хангахад чиглэдэг. Судалгаанаас үзэхэд, улс орнуудад энэ хуваарилалтанд улс төрийн намууд давуу байдлаар нийтлэг оролцдог бол Шотландад намаас гадна бие даагчид оролддог. (Хүснэгт 7.)

(4) *Саналын хуудасны тоо*: Сонгуулийн холимог тогтолцооны үед сонгогч нэг, эсхүл хоёр тусдаа саналын хуудсанд дараалан бөглөх байдлаар саналаа өгдөг. Тухайлбал, Герман, Итали, Киргиз, Литва, Шинэ Зеланд, Шотланд, Япон зэрэг 7 улсад хоёр саналын хуудсаар саналаа өгдөг байдал нийтлэг ажиглагдаж байгаа бол Балба, Лесотод нэг саналын хуудсаар саналаа өгдөг байна. (Хүснэгт 4.)

(5) *Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны үед суудал хуваарилах үндсэн хоёр арга* байдаг:

- хамгийн их үлдэгдлийн арга буюу нэг суудалд ногдох саналын квотыг тооцсоны үндсэн дээр нэг буюу түүнээс олон квот хангасан намуудад ногдох суудлыг хуваарилсны дараа үлдсэн суудлыг квотод хамгийн их дөхсөн намуудад олгох арга. Нийт хүчинтэй саналын тоог парламентын суудлын тоонд хуваах “Харе” (Hare)-гийн томьёог улс орнуудад хамгийн өргөн ашигладаг ажээ. Судалгаанд авагдсан орнуудад Германаас бусад нь энгийн хэлбэрийн хуваарилалтын аргыг хэрэглэдэг байна;
- хамгийн их дунджийн арга буюу тодорхой шатанд хамгийн олон санал авсан улс төрийн намд суудал хуваарилах арга. Нийтлэг хэрэглэдэг хуваагчийн 2 аргыг дурдвал, Японд “Д’Хонт” (d’Hondt)-ын томьёог (1, 2, 3...), Шинэ Зеландад “Сент-Лагю” (Sainte-Laguë)-гийн томьёог (1, 3, 5...) хэрэглэдэг байна.

Практикаас үзэхэд, “д’Хонт”-ын хамгийн их дунджийн арга нь том намуудад илүү таатай байдаг бол “Харе”-гийн хамгийн их үлдэгдлийн арга нь жижиг намуудад тохиромжтой ажээ. (Хүснэгт 5.)

(6) *Хувь тэнцүүлсэн тогтолцоон дахь намын нээлттэй болон хаалттай жагсаалт*: Хувь тэнцүүлсэн тогтолцоонд хаалттай жагсаалтаар санал хураах бол хэнийг, ямар дарааллаар оруулахыг улс төрийн нам шийдвэрлэдэг. Энэ тохиолдолд жендэрийн, цөөнхийн төлөөллийг хангах гэх мэт хуулийн шаардлагад нийцүүлэх ёстой. Харин нээлттэй жагсаалтаар санал хурааж байгаа тохиолдолд сонгогч нэр дэвшигчийг сонгож саналаа өгнө.

Судалгаанаас үзэхэд, Балба, Герман, Итали, Лесото, Шинэ Зеланд, Шотланд, Япон зэрэг 7 улсад намын хаалттай жагсаалтыг нийтлэг хэрэглэж байна. Харин Киргиз, Литва улсад намын нээлттэй жагсаалтыг хэрэглэж байна.

(7) Сонгуулийн холимог тогтолцоотой орнуудад *парламентад суудал хуваарилах саналын босго* буюу улс төрийн намд авбал зохих саналын доод хувийг тогтоож өгдөг нь улс төрийн намын хуваагдлаас урьдчилан сэргийлэх зорилготой байдаг. Босгыг давсан улс төрийн намд намын жагсаалтаар нэр дэвшигчид суудал авах эрх үүсдэг. Судалгаанд авагдсан улс орнуудаас Герман, Литвад саналын босго нь нийт хүчинтэй саналын 5 хувь байдаг бол Итали, Японд 3 хувь байна. Италид эвсэлд илүү өндөр босго тавьж, Герман, Шинэ Зеландад мажоритар суудал цөөн авсан нам босгыг автоматаар давах зэрэг нэмэлт зохицуулалт хийдэг байна. (Хүснэгт 7.)

(8) Холимог сонгуулийн тогтолцоогоор гадаадад суугаа сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулахад зохион байгуулалт талаасаа бэрхшээл үүсэх магадлалтай тул энэ асуудлыг сонгуулийн тогтолцооны хүрээнд тусгайлан авч үздэг байна. Судалгаанаас үзэхэд, Балба Улсад гадаадад суугаа сонгогчдын саналыг авдаггүй бол Лесото Улсад зөвхөн дипломат ажилтнууд, тэдний гэр бүл санал хураалтад оролцдог байхаар хязгаарласан. Харин судалгаанд авагдсан бусад улс орнуудын хувьд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгүүлсэн хүмүүс гадаадаас саналаа өгөх боломжтой ажээ.

Сүүлийн үед холимог тогтолцооны хоёр бүрэлдэхүүн хэсгийн аль алинд нь гадаадад суугаа сонгогчдод саналаа өгөх боломжоор хангадаг жишиг тогтож байна. Энэ тохиолдолд тухайн сонгогчийг аль нэг мажоритар тойрогт хуваарилах шаардлага үүсдэг. Үүнийг Италид сонгуулийн дөрвөн тойргийг гадаадад байгуулах замаар, Герман, Япон, Шинэ Зеландад гадаадад суугаа сонгогчдыг эх орондоо байхдаа хамгийн сүүлд бүртгэгдсэн тойрогт нь санал өгүүлэх замаар, Литвад Парламентын ордонд байрладаг тойрогтоо санал өгүүлэх замаар тус тус шийдвэрлэжээ. (Хүснэгт 8.)

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.)

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦОО

1. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо⁸³


Сонгуулийн тогтолцоо нь нэр дэвшүүлэх, санал хураах, санал тоолох, эцсийн дүнг нэгтгэн тооцох дүрэм журмыг өөртөө агуулж байдаг. Сонгуулийн тогтолцооны онолыг сонгуулийн эрх зүй гэж хэлбэр талаас нь тодорхойлж болох бөгөөд түүний цаана улс төр судлал, эдийн засаг, математикийн агуулга оршиж байдаг.

Парламентын сонгуулийн тогтолцоог үндсэн гурван ангилалд хуваадаг. Үүнд:

- (1) сонгуулийн олонхыг төлөөлөх тогтолцоо;
- (2) хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо;
- (3) холимог тогтолцоо.

Эдгээрийн алинд ч хамааруулж болохооргүй үл шилжих нэг саналын, хязгаарлагдмал саналын, саналыг дугаарлаж өгөх Бордагийн тооцооны арга гэсэн сонгуулийн тогтолцооны ангилал байдаг. (Зураг 1.)

Зураг 1. Парламентын сонгуулийн тогтолцооны ангилал



Олонхыг төлөөлөх тогтолцоо (Plurality/Majority Systems)	FPTP	Нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүн ялах дүрэмтэй харьцангуй олонх	<i>First Past The Post</i>
	TRS	Хоёр шатлалтай санал	<i>Two-Round system</i>
	AV	Альтернатив санал	<i>Alternative Vote</i>
	BV	Багц санал	<i>Block Vote</i>
	PBV	Намын багц санал	<i>Party Block Vote</i>
Холимог тогтолцоо (Mixed Systems)	Parallel	Зэрэгцээ	<i>Parallel Systems</i>
	MMP	Холимог хувь тэнцүүлсэн	<i>Mixed Member Proportional</i>
Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо (Proportional Representation)	List PR	Жагсаалт	<i>List PR</i>
	STV	Шилжих бололцоотой нэг санал	<i>Single Transferable Vote</i>
Бусад	SNTV	Үл шилжих нэг санал	<i>Single Non-Transferable Vote</i>
	LV	Хязгаарлагдмал санал	<i>Limited Vote</i>
	BC	Бордагийн тооцооны арга	<i>Borda Count</i>

Эх сурвалж: *Elections, Electoral Systems and Party Systems, A Resource Guide, IDEA, 2017.*

⁸³ Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306). ПССХ. “Парламент” судалгааны эмхтгэл, Боть 40. УБ., 2022 он.


Парламентын сонгуулийн тогтолцооны талаар Улсын Их Хурлын Тамгын газрын ПССХ-ийн 2022 онд гүйцэтгэсэн “Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо” тойм судалгаанаас⁸⁴ дэлгэрүүлж үзнэ үү.

Олон улсын парламентын холбоо (IPU)-ны судалгаанаас үзэхэд, 2022 оны байдлаар дэлхийн 192 улсын парламентын (парламентын нэг танхимт болон доод танхимууд) хувьд дараах сонгуулийн тогтолцоог хэрэглэж байна.⁸⁵ Үүнд:

- сонгуулийн холимог тогтолцоог - 32 улс (16.7%);
- олонхыг төлөөлөх тогтолцоог - 65 улс (34.8%);
- хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоог - 77 улс (41.1%);
- бусад тогтолцоог - 6 улс (3.2%);
- шууд сонгууль явуулдаггүй - 7 улс (3.7%);
- мэдээлэл байхгүй - 5 улс байна.

Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоог засаглалын хэлбэрээр авч үзвэл, парламентын, ерөнхийлөгчийн болон холимог засаглалтай улсуудын дийлэнх нь сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоог хэрэглэж байна. (Зураг 2.)

Зураг 2. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн тогтолцоо (засаглалын хэлбэрээр)



Эх сурвалж: Олон улсын парламентын холбоо (IPU).

Парламентын засаглалтай улс орнуудын хувьд судалгаанд авагдсан нийт 76 улсаас:

- сонгуулийн холимог тогтолцоотой - 12 улс (15.8%);
- олонхыг төлөөлөх тогтолцоотой - 26 улс (34.2%);
- хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой - 37 улс (48.7%);
- бусад - 6 улс (1.3%) байна.

2. Парламентын сонгуулийн холимог тогтолцоотой зарим орны туршлага⁸⁶

Парламентын сонгуулийн холимог тогтолцоо нь хувь тэнцүүлэн хуваарилах, олонхыг төлөөлөх тогтолцооны аль алиных нь шинжийг агуулдаг.⁸⁷ Тодруулбал, холимог

⁸⁴ Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306). ПССХ. “Парламент” судалгааны эмхтгэл, Боть 40. УБ., 2022 он.

⁸⁵ Олон улсын парламентын холбоо (IPU)-ын мэдээллийн сан.

https://data.ipu.org/compare?field=chamber%3A%3Afield_electoral_system&structure=any_lower_chamber#map

⁸⁶ Mixed electoral systems: Design and Practice. IDEA. 2023. <https://www.idea.int/publications/catalogue/mixed-electoral-systems-design-and-practice>

⁸⁷ Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306). ПССХ. “Парламент” судалгааны эмхтгэл, Боть 40. УБ., 2022 он.

тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг нь хувь тэнцүүлсэн тогтолцоо, нөгөө бүрэлдэхүүн хэсэг нь олонхыг төлөөлөх тогтолцоо юм. Олонхыг төлөөлөх тогтолцоонд харьцангуй олонхын тогтолцоо (ХОТ), багц санал буюу томсгосон тойрогт олон мандат бүхий тогтолцоо, хоёр шатлалт тогтолцоо (ХШТ)-г хэрэглэдэг.

Холимог тогтолцоо нь (1) зэрэгцээ (параллел), (2) холимог хувь тэнцүүлсэн гэсэн хоёр үндсэн хэлбэртэй.

Зэрэгцээ (параллел) тогтолцооны хувьд, сонгогч олонхыг төлөөлөх хэсэгт нэг санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт нэг санал өгдгөөрөө ялгаатай.⁸⁸ Өөрөөр хэлбэл, зэрэгцээ тогтолцооны бүрэлдэхүүнд багтах сонгуулийн хоёр тогтолцоо нь тусдаа бөгөөд харилцан хамааралгүй байдаг. Энд парламентын хэдэн гишүүнийг буюу хэдэн суудлыг аль тогтолцоогоор сонгох нь тогтмол тодорхой тоо байдаг.

Зэрэгцээ тогтолцоогоор явагдсан сонгуулийн дүн нь нэг талаас олонхын тогтолцоогоор явагдсан сонгуулийн дүн буюу хувь тэнцүүлээгүй дүн, нөгөө талаас хувь тэнцүүлсэн тогтолцооны дүнгийн нийлбэрээр тодорхойлогдоно. Зэрэгцээ тогтолцоо нь цэвэр олонхын тогтолцоотой харьцуулбал, сонгогчдын санал гээгдэх буюу хувь тэнцвэргүй байдлыг багасгадаг ч хууль тогтоох байгууллагыг бүхэлд нь хувь тэнцүүлэх зарчмаар бүрдүүлж чаддаггүй.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын өгсөн нэг саналаар хоёр өөр тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдгээрээ онцлог юм.⁸⁹ Өөрөөр хэлбэл, олонхын тогтолцооны дүнг тодруулсны дараа хувь тэнцүүлэх журмаар хуваарилах суудлын тоог тогтоож, улмаар хувь тэнцүүлсэн дүн буюу нийлбэрийг нь тооцон гаргадаг.

Дэлхийн 192 улсын парламентууд (парламентын нэг танхимт болон доод танхимууд)-ын 32 нь улс (танхим) нь сонгуулийн холимог тогтолцоог хэрэглэдэг талаар дээр өгүүлсэн. Эдгээр улсуудын 19 буюу 59.4 хувь нь зэрэгцээ тогтолцоог, 9 буюу 28.1 хувь нь холимог хувь тэнцүүлсэн тогтолцоог хэрэглэдэг байна. Бусад 4 улсын мэдээлэл байхгүй байна.⁹⁰ (Хүснэгт 1.)

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын парламентын сонгуулийн холимог тогтолцоо

Сонгуулийн холимог тогтолцооны хэлбэр	Улсын тоо	Улсын нэр
Зэрэгцээ тогтолцоо	19	Андорра, Балба, БНКонго Улс, Венесуэл, Гүрж, Египет, Итали, Йордан, Литва, Мавритани, Нижер, Орос, Панам, Сейшелийн арлууд, Сенегал, Украин, Умард Македон, Филиппин, Япон
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо	9	Герман, Жибути, Лесото, Мексик, Өмнөд Солонгос, Тажикистан, Тайланд, Унгар, Шинэ Зеланд
Мэдээлэл байхгүй	4	Боливи, Гайана, Ливи, Мадагаскар

Эх сурвалж: -Олон улсын парламентын холбоо (IPU);
-Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA).

Сонгуулийн холимог тогтолцоог ихэнх тохиолдолд газар нутгийн хэмжээ томтой, олон хүн амтай, олон үндэстэн ястан оршин суудаг, бүс нутгийн болон үндэстний эрх ашгийг төлөөлөх зайлшгүй шаардлагатай улс орнуудад сонгосон байдаг.⁹¹

⁸⁸ Мөн тэнд.

⁸⁹ Мөн тэнд.

⁹⁰ Олон улсын парламентын холбоо (IPU)-ын мэдээллийн сан.

https://data.ipu.org/compare?field=chamber%3A%3Afield_electoral_system&structure=any_lower_chamber#map

⁹¹ Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306). ПССХ. “Парламент” судалгааны эмхтгэл, Боть 40. УБ., 2022 он.

Сонгуулийн тогтолцооны хамгийн шилдэг туршлага бол холбогдох харилцааны нарийвчилсан зохицуулалтуудыг таньж мэдсэний үндсэн дээр эрх зүйн орчныг боловсруулсан тогтолцоо юм. Холбогдох харилцааг хангалттай түвшинд тодорхой зохицуулаагүйгээс сонгуулийн маргаан үүсэх нөхцөл бий болж, цаашлаад сонгуулийн үр дүнг хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөх байдалд сөргөөр нөлөөлдөг.

Сонгуулийн тогтолцоо практикт чухам ямар үр дүнд хөтлөх нь ихэнх тохиолдолд сонгуулийн тогтолцоогоо хэрхэн нарийвчлан зохицуулснаас хамаарах ба үүнд дараах хүчин зүйлс багтана:

- (1) мажоритар болон хувь тэнцүүлсэн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа;
- (2) хувь тэнцүүлэх тогтолцооны тойргуудын түвшин болон хэмжээ;
- (3) хувь тэнцүүлэх зарчмаар жагсаалтаас сонгогдох шалгуур;
- (4) саналын хуудасны тоо;
- (5) намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны суудал хуваарилах арга;
- (6) хувь тэнцүүлсэн тогтолцоон дахь намын нээлттэй болон хаалттай жагсаалт;
- (7) парламентад суудал хуваарилах саналын босго;
- (8) гадаадад суугаа сонгогчдын санал авах ажил.

2.1. Мажоритар болон хувь тэнцүүлсэн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа

Парламентын сонгуулийн холимог тогтолцооны зорилго нь гол гол улс төрийн хүчнүүдийн оролцоог хангахад чиглэж байгаа бол хоёр бүрэлдэхүүн хэсгийн суудлын тоо нь ойролцоо байдаг. Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас харахад, хоёр тогтолцоогоор хуваарилах суудлын тооны харьцаа 2:1 байна.

Зэрэгцээ тогтолцоонд намын жагсаалтаас сонгох суудлын тоо ахиу байх тутам сонгуулийн нийт дүн тэр хэмжээгээр хувь тэнцүү байх талтай.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны үндсэн зарчим нь сонгуулийн дүнг ерөнхийд нь хувь тэнцүүлэхэд чиглэдэг. Гэхдээ улс төрийн намуудын авсан саналыг хувь тэнцүүлэхэд гарах дүнтэй харьцуулахад, мажоритар суудал нь тооны хувьд илүү гарах тохиолдол байдаг. Тэдгээр илүү суудлыг нэмэгдэл суудал (overhang seats) гэж нэрлэдэг. Нэмэгдэл суудал нь парламентын суудлын тоог нэмж томсгоход нөлөөлнө. Энэ тохиолдолд нэмэгдэл суудал авсан намуудын төлөөлөл түлхүү болж хууль тогтоох байгууллагын бүтцийг авч үзэхэд, сонгогчдын өгсөн саналтай хувь тэнцэх чанар нь нэмэгддэггүй. Намын жагсаалтаас сонгогдох нийт суудлын хувь буурахад нэмэгдэл суудлын тоо өсөх тал ажиглагддаг. Тухайлбал, үндэсний хэмжээний нэг жагсаалтаас хэд хэдэн тойргийн жагсаалтад шилжихэд ийнхүү нэмэгддэг.

Үүнээс зайлсхийх нэг боломж нь нэмэлт суудлыг цөөн төлөөлөлтэй намуудад хуваарилж, парламентын бүтцийг бүхэлд нь хувь тэнцэх байдлаар бүрэлдүүлэн тэнцвэржүүлэх механизмыг үндсэн хуулиар зохицуулах боломжтой. Тухайлбал, 2013 онд Герман Улс ийм арга хэмжээ авч байсан.

Парламентын суудлын тоо нэмэгдэхээс зайлсхийх арга замын нэг нь намын жагсаалтаас хувь тэнцүүлэх зарчмаар ногдох суудлын тоог зохих хэмжээгээр цөөлөх явдал юм. Хоёр дахь арга нь холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны нэмэгдэл мандатын тогтолцооны хувилбарыг (additional member system) хэрэглэх юм. Дээр дурдсан хоёр хувилбарын алинд ч хувь тэнцүүлэх зарчмаас нэлээд хазайсан үр дүн ажиглагдах ба нэмэгдэл мандатын тогтолцоонд энэ хазайлт арай бага байдаг.

Судалгаанд авагдсан орнуудын мажоритар, хувь тэнцүүлсэн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа гол төлөв 60:40, 50:50, 40:60 хувьтай байна. Тухайлбал, Балба, Шинэ

Зеланд, Японд 60:40 харьцаатай, Герман, Литвад 50:50 харьцаатай, Итали, Киргизид 40:60 харьцаатай байна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Сонгуулийн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа

№	Улсын нэр	Мажоритар суудал		Хувь тэнцүүлсэн суудал		Бусад суудал	Нийт суудал
		Тоо	Хувь	Тоо	Хувь		
Зэргэлдээ тогтолцоо							
1	Балба	165	60.0	110	40.0	-	275
2	Итали	232	36.8	386	61.3	12	630
3	Киргиз	36	40.0	54	60.0	-	90
4	Литва	71	50.4	70	49.6	-	141
5	Япон	289	62.2	176	37.8	-	465
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо							
6	Герман	299	50.0	299	50.0	-	598
7	Лесото	80	66.7	40	33.3	-	120
8	Шинэ Зеланд	72	60.0	48	40.0	-	220
9	Шотланд	73	56.6	56	43.4	-	129

Эх сурвалж: Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA).

2.2. Хувь тэнцүүлэх тогтолцооны тойргуудын түвшин болон хэмжээ

Намын жагсаалтаас хувь тэнцүүлэх тогтолцоог үндэсний хэмжээний нэг тойрогт, эсхүл засаг захиргаа, бусад холбогдох нэгжид үндэслэн байгуулсан орон нутгийн тойргуудын түвшинд хэрэглэдэг. Орон нутгийн тойргийг хэрэглэх бол жагсаалтаас сонгогдсон гишүүд нь орон нутгаа төлөөлөх буюу тухайн орон нутгийн засаглалын бүтэцтэй ажил хэргийн бодит холбоо харилцаа тогтоох боломж бүрддэг.

Судалгаанд авагдсан орнуудаас Балба, Лесото, Литва, Шинэ Зеланд, Япон зэрэг 5 улсад үндэсний хэмжээний нэг тойргийн түвшинд намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоотой байна. Харин Италид сонгуулийн тойргийн тоо 63, Германд - 16, Киргизэд - 11, Шотландад - 8 байна. (Хүснэгт 3.)

Хүснэгт 3. Тойргуудын түвшин, хэмжээ

№	Улсын нэр	Дүүргийн түвшин	Тойргийн тоо	Мандатын тоо		
				Дундаж	Хамгийн бага	Хамгийн их
Зэргэлдээ тогтолцоо						
1	Балба	Үндэсний	1			
2	Итали	Орон нутгийн	63	6.1	4	9
3	Киргиз	Орон нутгийн	11	16.0	6	30
4	Литва	Үндэсний	1			
5	Япон	Үндэсний	1			
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо						
6	Герман	Орон нутгийн	16	18.7		
7	Лесото	Үндэсний	1			
8	Шинэ Зеланд	Үндэсний	1			
9	Шотланд	Орон нутгийн	8	7.0		

Эх сурвалж: Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA).

Герман, Итали, Япон зэрэг томоохон парламенттай орнуудад орон нутгийн тойргуудад намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо байдаг. Орон нутгийн тойрогт намын жагсаалтаас сонгогдох суудлын дундаж тоо тойрог тус бүрд байх нь улс төрийн

намуудын төлөөллийг хангахуйц түвшинд байдаг. Тухайлбал, Германд 19, Японд 16, Италид 6 байна. Цөөн суудал бүхий харьцангуй жижиг парламенттай орнуудад орон нутгийн тойргуудад суудал хуваарилах байдлаар улс төрийн олон намын төлөөллийг хангах бололцоо байдаггүй. (Хүснэгт 3.)

2.3. Хувь тэнцүүлэх зарчмаар жагсаалтаас сонгогдох шалгуур

Хувь тэнцүүлэх тогтолцооны зорилго нь янз бүрийн улс төрийн үзэл санаа, бодлого, байр суурийг дэмжигч улс төрийн бүлгүүдийн оролцоог хувь тэнцүү зарчмаар хангахад чиглэдэг. Жагсаалтаар санал хурааж хувь тэнцүүлэх зарчмаар суудал хуваарилахад бие даагчдыг оролцуулах нь техникийн талаасаа боломжтой боловч улс төрийн намуудаар хязгаарлах нь илүү хялбар байдаг аж.

Балба, Герман, Итали, Киргиз, Лесото, Литва, Шинэ Зеланд, Япон зэрэг улсуудад зөвхөн намууд оролцдог бол Шотландад намуудаас гадна бие даагчид оролддог ажээ. (Хүснэгт 6.)

2.4. Саналын хуудасны тоо

Зэргэлдээ болон холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны аль аль нь сонгуулийн хоёр тогтолцооноос бүрэлдэх тул сонгогч нэр дэвшигчид болон намын жагсаалтад хоёуланд нь санал өгөх шаардлагатай: нэг дэх хэлбэр нь хоёр тусдаа саналын хуудсаар бөглөх бол хоёр дахь нь нэг саналын хуудсаар саналаа дараалан бөглөдөг. (Саналын нэг хуудастай тохиолдолд сонгогч нь саналын хуудсанд хоёр санал өгч байгаа тул саналын хоёр хуудас бөглөсөн гэж тооцож болно.) Түгээмэл биш боловч сонгогч нэг саналын хуудсаар нэр дэвшигчид өгсөн саналыг тухайн нэр дэвшигчийн намд өгсөн санал гэж автоматаар давхар тооцох нь бас бий.

Судалгаанд авагдсан орнуудаас Балба, Лесото улс нэг саналын хуудсаар, бусад 7 улс хоёр саналын хуудсаар саналаа өгдөг байна. (Хүснэгт 4.)

2.5. Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны суудал хуваарилах арга

Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны суудал хуваарилах үндсэн хоёр арга байдаг. Үүнд:

- (1) **Хамгийн их үлдэгдэл** (ХИҮ)-ийн арга нь нэг суудалд ногдох саналын квотыг тооцсоны үндсэн дээр нэг буюу түүнээс олон квот хангасан намуудад ногдох суудал хуваарилсны дараа үлдсэн суудлыг квотод хамгийн их дөхсөн намуудад олгодог арга юм.

Нийт хүчинтэй саналын тоог парламентын суудлын тоонд хуваах “Харе” (Hare)-гийн томьёог хамгийн өргөн ашигладаг бөгөөд судалгаанд авагдсан улсуудад Германаас бусад нь энгийн хэлбэрийг хэрэглэдэг байна.

Германд “Харе”-гийн томьёоны илүү төвөгтэй хэлбэрийг ашигладаг. Тодруулбал, үлдэгдлийг тоолохдоо “Харе”-гийн томьёогоор квотын хагасыг давсан саналуудыг бүхэлд нь нэмж, “Харе”-гийн томьёогоор квотын хагаст хүрээгүй саналуудыг бүхэлд нь хасдаг. Ингэснээр ихэнх тохиолдолд “Харе”-гийн томьёоны квотыг энгийн хэлбэрээр нь хэрэглэсэнтэй ижил үр дүн гардаг ч зарим тохиолдолд

Хүснэгт 4. Саналын хуудасны тоо

№	Улсын нэр	Саналын хуудасны тоо
Зэргэлдээ тогтолцоо		
1	Балба	1
2	Итали	2
3	Киргиз	2
4	Литва	2
5	Япон	2
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо		
6	Герман	2
7	Лесото	1
8	Шинэ Зеланд	2
9	Шотланд	2

Эх сурвалж: Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA).

хуваарилсан суудлын тоо нь нийт суудлын тоонд хүрэхгүй үе байдаг. Энэ нөхцөлд хоёр тоог тохируулахын тулд квотыг өөрчилдөг байна.

- (2) **Хамгийн их дундаж** (ХИД)-ийн зарчмыг ашиглах нөхцөлд тодорхой шатанд хамгийн олон санал авсан улс төрийн намд суудал хуваарилдаг. Тухайн намын суудлын тоо нь урьдчилан тогтоосон хүчин зүйлүүдэд хуваагдах замаар багасдаг байна.

Нийтлэг хэрэглэдэг хуваагчийн 2 аргыг дурдвал, Японд “д’Хонт” (d’Hondt)-ын томьёог (1, 2, 3...), Шинэ Зеландад “Сент-Лагю” (Sainte-Laguë)-гийн томьёог (1, 3, 5...) хэрэглэж байна.

Хүснэгт 5. Тойргуудын хэмжээ, түвшин

№	Улсын нэр	Мажоритар тогтолцоо	Хувь тэнцүүлсэн тогтолцоо
Зэргэлдээ тогтолцоо			
1	Балба	ХОТ	ЖХТ - ХИД “Сент-Лагю”
2	Итали	ХОТ	ЖХТ - ХИУ “Харе”
3	Киргиз	ХОТ	ЖХТ - ХИУ “Харе”
4	Литва	ХШТ	ЖХТ - ХИУ “Харе”
5	Япон	ХОТ	ЖХТ - ХИД “д’Хонт”
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо			
6	Герман	ХОТ	ЖХТ - ХИУ
7	Лесото	ХОТ	ЖХТ - ХИУ “Харе”
8	Шинэ Зеланд	ХОТ	ЖХТ - ХИД “Сент-Лагю”
9	Шотланд	ХОТ	ЖХТ - ХИД “д’Хонт”

Эх сурвалж: Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA).

Мөн чанарын хувьд “д’Хонт”-ын ХИД-ийн арга нь том намуудад илүү таатай бол “Харе”-гийн ХИУ-ийн арга нь жижиг намуудад тохиромжтой байдаг.

Эдгээр шийдлүүдийн үр дүн нь тухайн улс орны нөхцөл байдлаас ихээхэн шалтгаалдаг. Ихэнх тохиолдолд ялгаа нь тодорхой бөгөөд харьцангуй бага байх боловч цөөн тохиолдолд тийм биш үе тохиолдоно. Үүний нэг тод жишээг Тунисийн туршлагаас харж болно. 2011 онд тус улс нь цэвэр хувь тэнцүүлэх тогтолцоо сонгож, намын жагсаалтаар санал хураан суудал хуваарилахад нийт хүчинтэй саналын 37 хувийг авсан хамгийн том намд “Харе”-гийн ХИУ-ийн аргаар Парламентын нийт суудлын 41 хувь ногдож, Парламент дахь бусад намтай зөвшилцөхөд хүрчээ. Хэрэв “Сент-Лагю”-гийн ХИД-ийн аргаар суудал хуваарилсан бол уг намд нийт суудлын 55 хувь ногдож Засгийн газрыг дангаараа бүрдүүлэх, “д’Хонт”-ын ХИД-ийн аргаар нийт суудлын 69 хувь ногдох байжээ.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд суудал хуваарилахад ХИД-ийн аргыг ашиглах нь парламентын суудлын тоог тогтмол байлгах сайн талтай тул улс төрийн хувьд хүсмээр төдийгүй, үндсэн хуультай нийцэх талаасаа ч давуу байж болох юм. Мажоритар суудлыг тоолсны дараа улс төрийн нам тус бүрийн парламентад эзлэх мажоритар суудлын тоонд үндэслэх хуваагч ашиглан ХИД-ийн аргаар намын жагсаалтаас сонгогдох суудлыг хуваарилна.

Жишээ нь: намын жагсаалтын суудал хуваарилахын өмнө нэг мажоритар суудал авсан намын саналыг “д’Хонт”-ын ХИД-ийн аргаар 2-т, “Сент-Лагю”-гийн ХИД-ийн аргаар 3-т хуваана. Мөн хоёр мажоритар суудал авсан намын саналыг “д’Хонт”-ын ХИД-ийн аргаар 3-т, “Сент-Лагю”-гийн ХИД-ийн аргаар 5-д хуваах бөгөөд энэ зарчмыг хэрэглэснээр нэмэгдэл суудлын асуудал үүсэхгүй.

2.6. Хувь тэнцүүлсэн тогтолцоон дахь намын нээлттэй болон хаалттай жагсаалт

Намын хаалттай жагсаалтаар санал хураах нөхцөлд нэр дэвшигчдээ хэрхэн жагсаах нь улс төрийн намын эрх мэдлийн асуудал болох бөгөөд нэр дэвшүүлэхэд жендэр, цөөнхийн төлөөллийг хангах хуулийн шаардлага тавигдаж болох юм. Нэр дэвшүүлэх үйл явцыг улс төрийн намын тухай хуульд дотоод ардчилал, намын гишүүний талаар болон намын жагсаалтын эхний байруудыг мөнгөөр авахад хяналт тавих замаар зохицуулж болно.

Намын нээлттэй жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо нь аль нэг намын төдийгүй, тухайн намын санал болгосон тодорхой нэр дэвшигчийн талаар сонголт хийх боломжийг сонгогчдод олгодог. Сонгогчдоос хангалттай дэмжлэг авсан нэр дэвшигчийн намын жагсаалтад эзлэх байр дээшилдэг байна.

Киргиз, Литва улсад нээлттэй, бусад 7 улсад хаалттай жагсаалтыг хэрэглэдэг байна.

Хүснэгт 6. Намын жагсаалт

№	Улсын нэр	Саналын хуудасны тоо
Зэргэлдээ тогтолцоо		
1	Балба	Хаалттай
2	Итали	Хаалттай
3	Киргиз	Нээлттэй
4	Литва	Нээлттэй
5	Япон	Хаалттай
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо		
6	Герман	Хаалттай
7	Лесото	Хаалттай
8	Шинэ Зеланд	Хаалттай
9	Шотланд	Хаалттай

Эх сурвалж: Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA).

2.7. Парламентад суудал хуваарилах саналын босго

Парламентын сонгуулийн холимог тогтолцооны хэлбэрүүдийг хэрэглэдэг орнууд улс төрийн нам хуваагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд парламентад төлөөлөлтэй болох намд албан ёсны босго буюу авбал зохих саналын доод хувийг тогтоож өгдөг. Тэрхүү босгыг давсан намд намын жагсаалтаас нэр дэвшигчид нь суудал эзлэх нөхцөл бүрддэг. Судалгаанд хамрагдсан Герман, Литвад саналын босго нь нийт хүчинтэй саналын 5 хувь байна. Харин Итали, Японд 3 хувийн босгыг хүлээн зөвшөөрч байна. Италид эвсэлд илүү өндөр босго тавьж, Герман, Шинэ Зеландад мажоритар суудал цөөн авсан нам босгыг автоматаар давах зэрэг нэмэлт зохицуулалт хийдэг байна. (Хүснэгт 7.)

Хүснэгт 7. Жагсаалтаар хувь тэнцүүлэх (ЖХТ) босго

№	Улсын нэр	Оролцогчид	Жагсаалтаар хувь тэнцүүлэх (ЖХТ) босго
Зэргэлдээ тогтолцоо			
1	Балба	Намууд	Үндэсний - 5%
2	Итали	Намууд	Нам - 3%, Эвсэл - 10%
3	Киргиз	Намууд	Үгүй
4	Литва	Намууд	Үндэсний - 5%, 9 дүүрэг тус бүрд - 0.5%
5	Япон	Намууд	Үндэсний - 3%
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо			
6	Герман	Намууд	Үндэсний буюу ХОТ3 суудал - 5%
7	Лесото	Намууд	Үгүй
8	Шинэ Зеланд	Намууд	ХОТ 1 суудал
9	Шотланд	Намууд, бие даагчид	Үгүй

Эх сурвалж: Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA).

Албан ёсны босго байдаг эсэхээс үл хамаарч намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоотой улсуудад “нуугдмал” босго байдаг ба энэ нь тойргийн цар хүрээнээс хамаардаг. Тухайлбал, намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоонд ХИҮ-ийн аргаар суудал авахын тулд улс төрийн намд сонгуулийн нэг квот байна. “Харе”-гийн ХИҮ-ийн аргыг хэрэглэсэн тохиолдолд арван мандаттай тойргийн квот

нь 10, таван мандаттай бол 20, дөрвөн мандаттай бол 25 хувь байна. Энэхүү босгыг даваагүй улс төрийн нам үлдсэн суудал ногдоно.

2.8. Гадаадад суугаа сонгогчдын санал авах ажил

Холимог сонгуулийн тогтолцоогоор санал хураах ажлыг зохион байгуулахад зохион байгуулалт талаасаа бэрхшээл үүсэх магадлалтай тул энэ асуудлыг сонгуулийн тогтолцооны хүрээнд тусгайлан авч үздэг байна. Судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд, төрийн захиргааны хүчин чадлын хувьд хязгаарлагдмал Балба Улсад гадаадад суугаа сонгогчдын саналыг авдаггүй бол Лесото Улсын хувьд зөвхөн дипломат ажилтнууд, тэдний гэр бүл санал хураалтад оролцдог байхаар хязгаарладаг. Харин судалгаанд авагдсан бусад улс орнуудын хувьд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгүүлсэн хүмүүс гадаадаас саналаа өгөх боломжтой ажээ. (Хүснэгт 8.)

Гадаадаас санал өгөх ажиллагааг зохион байгуулалтын талаас нь хялбар байлгахын тулд эхлээд зөвхөн намын жагсаалтад санал өгөх байдлаар хязгаарлах эсэхийг шийдвэрлэх шаардлагатай. Хувь тэнцүүлсэн тогтолцоонд тухайн улс нь нэг тойрог болох тохиолдолд гадаадад суугаа сонгогч Киргизийн жишээгээр нэг л саналын хуудас хүлээж авдаг байна.

Сүүлийн үед холимог тогтолцооны хоёр бүрэлдэхүүн хэсгийн аль алинд нь гадаадад суугаа сонгогчдод саналаа өгөх боломжоор хангадаг жишиг улам бүр нийтлэг болж байна. Энэ тохиолдолд сонгогчийг аль нэг мажоритар тойрогт хуваарилах шаардлага үүсдэг. Итали хувь тэнцүүлэх зарчмын дагуу намын жагсаалтаар санал хураах сонгуулийн дөрвөн тойрог гадаадад байгуулах замаар энэ асуудлыг шийддэг. Герман, Япон, Шинэ Зеланд гадаадад суугаа сонгогчийг эх орондоо байхдаа хамгийн сүүлд бүртгэгдсэн тойрогт нь санал өгүүлэх, эсхүл Литва парламентын ордон байрладаг тойрогтоо санал өгүүлдэг жишээ байна.

Эдгээрийн алийг ч сонгосон сонгуулийн зохих тойргийн саналын хуудсыг тухайн сонгогчид алдаа мадаггүй илгээх, саналын хуудсыг нь холбогдох журмын дагуу тээвэрлэж тооллогод хамруулахад шаардлагатай зохион байгуулалтын болон санхүүгийн нөөцийг бүрдүүлсэн шаардлагатай байдаг. Тухайлбал, дипломат төлөөлөгчийн газруудад санал авах байр ажиллуулах, шуудангаар болон цахимаар санал илгээх боломжууд бий. Гэхдээ тэдгээр нь дэд бүтэц, байр, сонгогчийн боловсрол, ялангуяа шуудангаар санал өгөхөд сонгуулийн цаглабарт заасан цаг хугацааг баримтлах зэрэг асуудлууд үүсдэг.

Хүснэгт 8. Гадаадад суугаа сонгогчдын санал авах ажил

№	Улсын нэр	Хэн	Хаана	Ямар сонгууль	Хэрхэн
Зэргэлдээ тогтолцоо					
1	Балба	Байхгүй			
2	Итали	Эрх бүхий сонгогч	Гадаадад дөрвөн тойрог	Гадаадад санал хураах ажил	Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газарт хүргүүлээд, буцааж шуудангаар авдаг.
3	Киргиз	Эрх бүхий сонгогч	Улс нь нэг том тойрог	Хувь тэнцүүлэх бүрэлдэхүүн	Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар
4	Литва	Эрх бүхий сонгогч	Парламент байрладаг тойрогт	Тогтолцооны хоёр бүрэлдэхүүний аль алинд	Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газарт очиж, эсхүл эдгээр газраас зохих журмын дагуу саналын хуудас хүлээн авч, шуудангаар илгээнэ.
5	Япон	Эрх бүхий сонгогч	Хамгийн сүүлд оршин сууж байсан тойрогт	Тогтолцооны хоёр бүрэлдэхүүний аль алинд	Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар, эсхүл сонгуулийн байгууллагаас зохих журмын дагуу саналын хуудас хүлээн авч, шуудангаар илгээнэ.
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо					
6	Герман	Эрх бүхий сонгогч	Сүүлийн оршин сууж байсан тойрогт (25 жил хүртэлх хугацааны өмнө)	Тогтолцооны хоёр бүрэлдэхүүний аль алинд	Герман дахь холбогдох сонгуулийн байгууллагаас зохих журмын дагуу саналын хуудас хүлээн авч, шуудангаар илгээнэ.
7	Лесото	Гадаадад алба хашиж буй дипломат ажилтнууд, тэднийг дагалдах гэр бүлийн гишүүд, төлөөлөгчийн газрын ажилтнууд	Бүртгэлтэй сонгуулийн тойрогт	Тогтолцооны хоёр бүрэлдэхүүний аль алинд	Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газарт байрлах хэсгийн хороонд.
8	Шинэ Зеланд	Эрх бүхий сонгогч	Сүүлд оршин сууж байсан тойрогт	Тогтолцооны хоёр бүрэлдэхүүний аль алинд	Цахимаар, эсхүл хэсгийн хороонд биеэр очиж, эсхүл зохих журмын дагуу сонгуулийн байгууллагаас хүлээн авсан саналын хуудсыг гадаадад байрлах хэсгийн хороонд шуудангаар илгээнэ.
9	Шотланд	Байхгүй			

Эх сурвалж: Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA).

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
- Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо (СТ-22/306). ПССХ. “Парламент” судалгааны эмхтгэл, Боть 40. УБ., 2022 он.
- Монгол Улсын сонгуулийн тогтолцооны харьцуулсан судалгаа. Удирдлагын Академи. 2019 он.
- Сонгуулийн тогтолцоо ба намын санхүүжилт: Монгол Улсад тохирох хувилбар. Флориан Гротц (ХБНГУ-ын профессор). 2023 он. <https://mpress.mn/p/15198>
- Сонгуулийн тогтолцоо гэж юу бэ? Гэрэлт-Од Э. (Ph.D). 2020 он. <https://ikon.mn/opinion/1xdt>
- Олон улсын парламентын холбоо (IPU)-ын мэдээллийн сан. <https://data.ipu.org>
- Elections, Electoral Systems and Party Systems, A Resource Guide, IDEA, 2017.
- Mixed electoral systems: Design and Practice. IDEA. 2023. <https://www.idea.int/publications/catalogue/mixed-electoral-systems-design-and-practice>

**ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ГАДААДЫН
ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

(Мэдээлэл, лавлагаа)

*Г.Билгээ, О.Нарантуяа,
Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*

№	Улсын нэр	Үндсэн хуулийн хуулийн зохицуулалт
1	Австри	26.Үндэсний Зөвлөлийг Холбооны ард түмэн (сонгууль явагдах өдөр 16 нас хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс) пропорционал төлөөллийн зарчмын үндсэн дээр тэгш, шууд, биечлэн болон саналаа нууцаар гаргах замаар сонгоно.
2	Азербайжан	83.Парламентын гишүүдийг бүх нийтийн, тэгш, шууд сонгуулиар чөлөөт, биечлэн, саналаа нууцаар гаргах үндсэн дээр мажоритар тогтолцоогоор сонгоно.
3	Албани	64.Ассамблей нь олон мандаттай сонгуулийн тойргоос пропорционал тогтолцоогоор сонгогдсон 140 депутатаас бүрддэг. Сонгуулийн тойрог нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууллагын аль нэг түвшний нэгжтэй нийцсэн байна. Сонгуулийн пропорционал тогтолцоог хэрэгжүүлэх, сонгуулийн тойрог болон сонгуулийн тойрог бүрд мандатын тоог тогтоох шалгуур, журмыг Сонгуулийн тухай хуулиар тогтооно.
4	Армени	89.Үндэсний Ассамблейн бүрэлдэхүүн, сонгуулийн журам 3.Үндэсний Ассамблей нь сонгуулийн пропорционал сонгуулийн шалгаруулалтаар сонгогдоно. Парламент дахь олонхыг тогтвортой бүрдүүлэх баталгааг Сонгуулийн тухай хуулиар баталгаажуулна. Хэрэв сонгуулийн үр дүнд буюу улс төрийн эвсэл байгуулах замаар парламент дахь тогтвортой олонх бүрдээгүй бол хоёр дахь шатны сонгууль явуулж болно. Хоёр дахь шатны сонгууль явагдах бол шинээр эвсэл байгуулахыг зөвшөөрнө. Улс төрийн эвсэл байгуулах хязгаарлалт, нөхцөл, журмыг Сонгуулийн тухай хуулиар тогтооно.
5	Бразил	45.Төлөөлөгчдийн танхим нь муж, нутаг дэвсгэр, холбооны тойрог бүрээс пропорционал тогтолцоогоор сонгогдсон ард түмний төлөөлөгчдөөс бүрдэнэ.
6	Гүрж	37 дугаар зүйл. Парламентын сонгууль (2) Энэхүү зүйлийн 1-д заасан нөхцөл бүрдэхийн өмнө 150 гишүүдээс бүрдэх парламентыг олон мандаттай сонгуулийн нэг тойрогт бүх нийтийн сонгуулиар чөлөөтэй, эрх тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр пропорционал тогтолцоогоор нууц санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно.
7	Дани	31.1.Фолкетингийн гишүүдийг бүх нийтээрээ, шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдоно. 31.2.Сонгох эрхээ хэрэгжүүлэх журмыг Дани Улсын Фолкетингийн сонгуулийн тухай хуулиар тогтоох ба энэ хууль нь сонгогчдын олон талын санал бодлыг тэгш төлөөлөхийн тулд сонгуулийн журмыг тогтоож, нэг мандаттай тойрогт пропорционал төлөөллийн сонгуультай, эсхүл сонгуульгүй (with or without elections) явуулах эсэхийг тогтооно.
8	Израил	4.Кнессетийг үндэсний, бүх нийтийн, шууд, тэгш, нууц, пропорционал төлөөллийн сонгуулиар Кнессетийн сонгуулийн тухай хуулийн дагуу сонгоно. Энэ хэсгийг Кнессетийн олонхын саналаас бусад байдлаар өөрчлөхгүй.
9	Ирланд	16.2.Гишүүд нь пропорционал төлөөллийн тогтолцоонд үндэслэн шилжих дан санал (single transferable vote - STV)-ын аргаар сонгогдоно.

10	Исланд	31.Парламент нь бүх ард түмнээс нууц санал хураалтаар, пропорционал төлөөллийн үндсэн дээр, 4 жилийн хугацаагаар сонгогддог 63 гишүүнтэй байна.
11	Киргиз	70.Жогорку Кенеш (парламент) нь пропорционал төлөөллийн үндсэн дээр 5 жилийн хугацаатай сонгогдсон 120 депутатаас бүрдэнэ.
12	Латви	5.Сейм нь ардын төлөөлөгч 100 гишүүнтэй. Сеймийг пропорционал тогтолцооны дагуу нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно.
13	Лихтенштайн	46.1.Парламент нь пропорционал тогтолцооны дагуу нийтээрээ, тэгш, нууц, шууд сонгох замаар ард түмнээс сонгогддог 25 Төлөөлөгчөөс бүрдэнэ. Дээд муж (Оберланд), Доод муж (Унтерланд) тус бүр нэг тойрог үүсгэнэ. Төлөөлөгчийн 15-ыг Дээд муж, 10-ыг Доод мужаас сонгоно.
14	Люксембург	51.Төлөөлөгчдийн танхим нь 60 гишүүнтэй. Гишүүдийг нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох зарчмаар (намын) нэрсийн жагсаалтаар, пропорционалаар, хуулиар тогтоосон журмын дагуу ... сонгоно.
15	Молдова	61.Парламентын гишүүдийг бүх нийтийн, тэгш, шууд, саналаа нууцаар гаргаж сонгоно. Сонгуулийг зохион байгуулах, явуулах журмыг органик хуулиар тогтооно.
16	Намиби	18.1.Үндэсний Ассамблей дараах бүрэлдэхүүнтэй байна: А.96 гишүүнийг сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчид бүх нийтийн, шууд, нууц санал хураалтаар сонгоно. 49. 46.1.а-д заасан гишүүдийн сонгуулийг намын нэрсийн жагсаалтаар Хавсралт 4-т заасны дагуу пропорционал төлөөллийн үндсэн дээр явуулна.
17	Непал	84.Төлөөлөгчдийн танхим нь нийт 275 гишүүнээс бүрдэх бөгөөд дараах байдлаар бүрдүүлнэ: 165 гишүүнийг хүн ам, газарзүй болон онцлог байдлыг харгалзан хуваасан 165 тойргоос хамгийн олон санал авсан хүн ялах дүрэмтэй харьцангуй олонхыг (FPTP) төлөөлөх тогтолцоогоор; а.10 гишүүнийг сонгогчид намын төлөө санал өгөх хувь тэнцүүлэх (пропорционал төлөөллийн) тогтолцоогоор улсыг бүхэлдээ нэг тойрог гэж үзэж сонгуулийг явуулна.
18	Нидерланд	53.Хоёр танхимын гишүүдийг Парламентын тухай хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд пропорционал төлөөллөөр сонгоно.
19	Польш	96.2.Сеймийн сонгууль бүх нийтийн, тэгш, шууд, пропорционал байх ба нууцаар саналаа өгөх замаар явагдана.
20	Руанда	75.Төлөөлөгчдийн танхимын бүрэлдэхүүн, гишүүдийг сонгох: Төлөөлөгчдийн танхим 80 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийг дараах төлөөллүүдээс сонгоно. Үүнд: 53 гишүүнийг улс төрийн байгууллагаас нэр дэвшүүлсэн нэрсийн тогтмол жагсаалтаас, эсхүл бие даагч нэр дэвшигчдийг пропорционал тогтолцоогоор шууд бүх нийтийн сонгуулийн үндсэн дээр; 24 эмэгтэй гишүүнийг үндэсний засаг захиргааны нэгжээс сонгуулийн тусгай коллегитор дамжуулан; 2 гишүүнийг Үндэсний залуучуудын зөвлөлөөс; 1 гишүүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Үндэсний зөвлөлөөс тус тус сонгоно. ...гишүүдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэй байна.
21	Уругвай	88.Төлөөлөгчдийн тахим нь улс орны лема (нам) бүрд өгсөн саналыг харгалзан үздэг пропорционал төлөөллийн үндсэн дээр иргэдээс шууд сонгогдсон 99 гишүүнээс бүрдэнэ.
22	Фижи	53.Парламентын гишүүдийн сонгууль нь нийт сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч бүр нэг сонголт хийхээр, сонголт бүр адил

		үнэ цэнэтэй байх нөхцөл бүхий пропорционал төлөөллийн олон мандаттай нээлттэй жагсаалтын системээр явагдана.
23	Финланд	25.Парламентын гишүүдийг шууд, пропорционал, нууц санал хураалтаар сонгоно. Санал өгөх эрх бүхий иргэн бүр сонгуульд тэгш эрхтэй оролцоно.
24	Чех	18.Төлөөлөгчдийн танхимын сонгуулийг бүх нийтийн, тэгш, саналаа шууд гаргах эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар пропорционал төлөөллийн үндсэн дээр явуулна.
25	Эстони	60.Рийгикогу (Парламент) нь 101 гишүүнээс бүрдэнэ. Рийгикогугийн гишүүдийг чөлөөт сонгуулиар пропорционал зарчмын үндсэн дээр сонгоно. Сонгууль нь бүх нийтийн, жигд нэг хэлбэрээр, шууд явагдана. Саналаа нууцаар гаргана.

Aguzublaghinmashatanaragbisontatahmananain

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТУХАЙ

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун, Р.Нургүл

АГУУЛГА

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Парламентын доод танхим буюу Мажилисийн талаар

Парламентын дээд танхим буюу Сенатын талаар

8 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Мажилисийн тухай

8 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Дээд танхим буюу Сенатын тухай

1.БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ДООД ТАНХИМ БУЮУ МАЖИЛИС

Мажилисийн Анхдугаар бүрэн эрх (1996-1999)

Хоёр дахь удаагийн бүрэн эрх (1999-2004)

Гурав дахь удаагийн бүрэн эрх (2004-2007)

Дөрөв дэх удаагийн бүрэн эрх (2007-2011)

Тав дахь удаагийн бүрэн эрх (2012-2016)

Зургаа дахь удаагийн бүрэн эрх (2016-2021)

Долоо дахь удаагийн бүрэн эрх (2021-2023)

Найм дахь удаагийн бүрэн эрх (2023 оноос)

2.БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ДЭЭД ТАНХИМ БУЮУ СЕНАТ

Анхдугаар бүрэн эрх (1996 оны 01 дугаар сараас 1999 оны 11 дүгээр сар)

Хоёр дахь удаагийн бүрэн эрх (1999 оны 12 дугаар сараас 2004 оны 11 дүгээр сар)

Гурав дахь удаагийн бүрэн эрх (2004 оны 11 дүгээр сараас 2007 оны 09 дүгээр сар)

Дөрөв дэх удаагийн бүрэн эрх (2007 оны 09 дүгээр сараас 2012 оны 01 дүгээр сар)

Тав дахь удаагийн бүрэн эрх (2012 оны 01 дүгээр сараас 2016 оны 01 дүгээр сар)

Зургаа дахь удаагийн бүрэн эрх (2016 оны 03 дугаар сараас 2021 оны 01 дүгээр сар)

Долоо дахь удаагийн бүрэн эрх (2021 оны 01 дүгээр сараас 2023 оны 03 дугаар сар)

Найм дахь удаагийн бүрэн эрх (2023 оны 03 дугаар сараас)

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1995 оны 08 дугаар сард Казахстан Улс бүх нийтийн санал асуулга явуулж, Казахстан Улсын шинэ Үндсэн хуулийг баталсан бөгөөд түүнд “парламент” гэх ойлголтыг анх удаа албан ёсоор тодорхойлсон байна. Энэхүү Үндсэн хуульд Казахстан Улсын парламент нь дээд, доод 2 танхимтай, хууль тогтоох эрхийг хэрэгжүүлэх төлөөллийн дээд байгууллага гэж заасан байна. Ийнхүү анх удаа 2 танхим бүхий парламент бий болсноор дэлхийн практикт хүлээн зөвшөөрөгдсөн парламентад ёсны зарчимд нийцсэн 2 танхимтай парламентын бүтэц улс төрийн хувьд төлөвшиж, батлагдсан хуулиудын чанар сайжрах боломж бүрдсэн гэж үздэг. Энэ нь Казахстан Улсын хувьд шинэ түүхэн үйл явдал байлаа.

Парламентын доод танхимыг Мажилис, дээд танхимыг Сенат гэж нэрлэдэг. Одоо Мажилисийн 8 дахь удаагийн бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь 2023 онд сонгогдсон 98 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Сенатын хувьд мөн адил 8 дахь удаагийн бүрэн эрх хэрэгжиж байгаа ба одоогийн Сенат 50 гишүүнтэй байна.

Парламентын доод танхим буюу Мажилисийн талаар

Казахстан Улс нь 1995 оноос хойш 1998, 2007, 2022 онуудад Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Эдгээр өөрчлөлтийн дүнд Мажилисийн гишүүдийн тоо дараах байдлаар өөрчлөгдсөн байна.

Хүснэгт 1. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой Мажилисийн гишүүдийн тооны өөрчлөлт (1995-2023)

Үндсэн хуульд НӨ оруулсан он	Мажилисийн бүрэн эрхийн хугацаа	Гишүүдийн тоо	Сонгуулийн хэлбэр
1995	Анхдугаар (1996-1999)	67	Нэг мандат тойргоос сонгогдсон.
1998	Хоёр дахь (1999-2004), Гурав дахь (2004-2007)	77	Нэг мандаттай тойргоос 67, намын жагсаалтаар 10 гишүүн сонгогдсон.
2007	Дөрөв дэх (2007-2011), Тав дахь (2012-2016), Зургаа дахь (2016-2021), Долоо дахь (2021-2023.01)	107	Улс төрийн намуудаас намын жагсаалтаар 98 гишүүн сонгогдсон, Казахстаны Ардын Чуулган /Ассамблей/-аас 9 гишүүнийг томилсон.
2022	Найм дахь (2023.03.19-нөөс)	98	Улс төрийн намуудаас намын жагсаалтаар 69, нэг мандаттай тойргоос 29 гишүүн сонгогдсон.

Түүнчлэн Гурав, Дөрөв, Тав болон Долоо дахь удаагийн Мажилисийн бүрэн эрхийн хугацаа нь Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу хугацаанаасаа өмнө дуусгавар болж, 4 удаа ээлжит бус сонгууль явуулсан.

Хүснэгт 2. Мажилис дахь дэх эмэгтэй гишүүдийн тоо

Мажилисийн бүрэн эрхийн хугацаа	Нийт гишүүдийн тоо	Эмэгтэй гишүүдийн тоо
Анхдугаар (1996-1999)	67	9
Хоёр дахь (1999-2004)	77	8
Гурав дахь (2004-2007)	77	8
Дөрөв дэх (2007-2011)	107	17
Тав дахь (2012-2016)	107	26

Зургаа дахь (2016-2021)	107	29
Долоо дахь (2021-2023.01)	107	29
Найм дахь (2023.03.19-нөөс)	98	18

Парламентын дээд танхим буюу Сенатын талаар

Сенатын гишүүдийн нэг хэсэг нь бүс нутаг, улсын ач холбогдолтой хот, нийслэл (*Казахстан Улс 2023 оны байдлаар 17 бүс нутаг, 3 улсын холбогдол бүхий хоттой байна*) болгоны бүх төлөөллийн байгууллагын депутатуудын хамтарсан хурлаас сонгогдсон хоёр гишүүнээс бүрдэх ба зарим хэсгийг Ерөнхийлөгч томилдог байна. Сенатын гишүүдийн тал нь 3 жил тутамд ротацийн журмаар сэлгэдэг. Ерөнхийлөгчийн томилох гишүүдийн тоо Үндсэн хуульд оруулж байсан шинэчлэлийн дагуу дараах байдлаар өөрчлөгдөж байсан байна.

Хүснэгт 3. Ерөнхийлөгчөөс Сенатад томилогдох гишүүний тоо

Хэрэгжиж байсан хугацаа	Төрийн тэргүүнээс Сенатад томилогдох гишүүний тоо
1996 оны 01 дүгээр сараас 2007 оны 08 сар хүртэл	7
2007 оны 08 дугаар сараас 2023 оны 01 дүгээр сар хүртэл	15
2023 оны 03 сараас	10 (5 гишүүнийг Казахстаны Ардын Чуулган /Ассамблей/-аас)

Найм дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Мажилисийн тухай

Одоо Мажилисийн даргаар КОШАНОВ Ерлан Жаканович, дэд даргаар ЕСПАЕВА Дания Мадиевна, РАУ Альберт Павлович нар ажиллаж байна. Мажилис нь 7 байнгын хороотой:

1. Нийгэм, соёлын байнгын хороо;
2. Хууль тогтоомж болон шүүх эрх зүйн шинэчлэлийн байнгын хороо;
3. Гадаад бодлого, батлан хамгаалах, аюулгүй байдлын байнгын хороо;
4. Санхүү, төсвийн байнгын хороо;
5. Хөдөө аж ахуйн байнгын хороо;
6. Экологийн болон байгаль ашиглах асуудал хариуцах байнгын хороо;
7. Эдийн засгийн шинэчлэл болон бүсийн хөгжлийн байнгын хороо.

Одоогийн Мажилисийн зөвлөл (бюро) 15 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнд Мажилисийн дарга, 2 дэд дарга, 7 байнгын хорооны дарга, мөн Мажилисийн 5 гишүүнээс бүрдсэн байна.

Мажилист суудал авсан 6 намын бүлгүүд:

1. “АМАНАТ” намын бүлэг;
2. “Ауыл” ардчилсан эх оронч намын бүлэг;
3. “Respublica” намын бүлэг;
4. “Ак жол” Казахстаны ардчилсан намын бүлэг;
5. Казахстаны ардын намын бүлэг;
6. Үндэсний социал демократ намын бүлэг.

Үндсэн хууль болон Сонгуулийн хуулийн дагуу Мажилисийн сонгуулийг холимог тогтолцоогоор явуулах бөгөөд нийт 98 гишүүний 29 нь нэг мандаттай нутаг дэвсгэрийн сонгуулийн тойргоос (улсын ач холбогдол бүхий 3 хот болон 17 бүс нутгаас), 69 нь дээрх 6 намаас намын жагсаалтаар сонгогджээ.

Намын жагсаалтаар “АМАНАТ” намаас 40, “Ауыл” ардчилсан эх оронч намаас 8, “Respublica” намаас 6, “Ак Жол” Казахстаны Ардчилсан намаас 6, Казахстаны Ардын нам 5, Үндэсний социал демократ намаас 4 гишүүн тус тус сонгогдсон байна. Сонгуулийн нэг мандаттай нутаг дэвсгэрийн тойрогт “АМАНАТ” намаас нэр дэвшсэн 22, бие даан нэр дэвшүүлсэн 7 гишүүн байна. Парламентын шинэ бүрэлдэхүүнд эрэгтэй 80 (81.6%), эмэгтэйчүүд 18 гишүүн суудал авч 18.4%-ийг бүрдүүлжээ. Мөн казах, орос, герман, беларусь, азербайжан үндэстний төлөөлөл Мажилисийн бүрэлдэхүүнд багтсан байна.

Мажилис нь Тамгын газартай бөгөөд Тамгын газар нь 13 нэгжтэй байна.

Найм дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Дээд танхим буюу Сенатын тухай

Сенатын даргаар АШИМБАЕВ Маулен Сагатханулы, дэд даргаар АСАНОВ Жакип Кажманович, ПЕРЕПЕЧИНА Ольга Валентиновна нар ажиллаж байна.

Сенат нь 6 байнгын хороотой:

1. Үндсэн хуулийн эрх зүй, шүүхийн тогтолцоо, хууль сахиулах байгууллагын асуудал хариуцах байнгын хороо;
2. Санхүү, төсвийн байнгын хороо;
3. Гадаад бодлого, батлан хамгаалах, аюулгүй байдлын байнгын хороо;
4. Эдийн засгийн бодлого, инновацын хөгжил, аж ахуйн нэгж/бизнес эрхлэлтийн асуудал хариуцах хороо;
5. Нийгэм, соёл, шинжлэх ухааны байнгын хороо;
6. Экологи, байгаль ашиглах, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо.

Түүнээс гадна Сенаторуудын зөвлөл, Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Сенатын дэргэдэх орон нутгийн төлөөлөгчийн байгууллага (маслихат)-тай харилцах зөвлөл, “Өнир” гишүүдийн сайн дурын бүлэг ажиллаж байна. Сенат нь Тамгын газартай бөгөөд 15 нэгжтэй үйл ажиллагаа явуулдаг.

1. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ДООД ТАНХИМ БУЮУ МАЖИЛИС⁹²

Мажилисийн анхны сонгууль 1995 онд болсон бөгөөд Казахстан Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийг харгалзан ойролцоо тооны сонгогч бүхий нэг мандаттай тойргоос нийт 67 гишүүн сонгогдохоор зохион байгуулжээ.

1998 онд улс оронд явагдсан нийгэм, эдийн засгийн шинэчлэлийн хүрээнд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд үүний дагуу парламентын танхимын бүрэн эрх, гишүүдийг бүрдүүлэх журамд өөрчлөлт оруулсан байна. Түүнээс гадна танхимын бүрэн эрхийн хугацаа болон гишүүдийн мандатын тоо нэмэгдсэн байна. Үүний үр дүнд Танхимын гишүүдийн тоо 77 болж нэмэгдсэн бөгөөд 67 гишүүн 1 мандаттай нутаг дэвсгэрийн тойргоос, 10 гишүүн намын жагсаалтаар сонгогдохоор болжээ.

2007 онд Казахстан Улсад улс төрийн бас нэгэн түүхэн өөрчлөлт хийгдсэн бөгөөд түүний үр дүнд Ерөнхийлөгчийг засаглалын хэлбэрээс Ерөнхийлөгч-парламентын засаглалын хэлбэрт шилжсэн байна. Энэ онд хийгдсэн өөрчлөлтийн дагуу Мажилис буюу доод танхимыг намын жагсаалтын дагуу бүрдүүлэхээр тогтоов. Үүнээс хойш Дөрөв дэх, Тав дахь, Зургаа дахь, Долоо дахь удаагийн сонгуулиудаар доод танхим 107 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласан ба тэдгээрийн 98 нь намын жагсаалтын дагуу улс төрийн намуудаас, 9 нь Казахстаны Ардын Чуулган /Ассамблей/-аас сонгогдсон байна. (*Казахстаны Ардын Чуулган*

⁹² Официальный интернет ресурс Мажилиса Парламента Республики Казахстан <https://www.parlam.kz/kk/mazhilis/history?id=history>

/Ассамблей/ нь 1995 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Казахстан Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Төрийн тэргүүний дэргэд байгуулагдсан зөвлөх үүрэг бүхий байгууллага юм.)

2022 онд Төрийн тэргүүний 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Илгээлтийн дагуу Үндсэн хуульдаа дахин өөрчлөлт оруулахаар болсон бөгөөд 06 дугаар сард бүх нийтийн санал асуулга явуулсан. Энэхүү санал асуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дэмжигдсэн ба үүгээр танхимын үүрэг ролийг бэхжүүлж, статусыг дээшлүүлсэн байна. Түүнээс гадна Мажилисийн сонгуулийг холимог хэлбэрээр явуулах зохицуулалт хийжээ.

Одоогийн буюу Найм дахь удаагийн парламент нь нийт 98 гишүүнтэй ажиллаж байгаа бөгөөд 69 гишүүн улс төрийн намуудаас намын жагсаалтаар, 29 гишүүн 1 мандат бүхий нутаг дэвсгэрийн тойргоос сонгогдсон байна.

Мажилисийн Анхдугаар бүрэн эрх (1996-1999)

Анхны сонгууль 1995 оны 12 дугаар сарын 09-нд явагдсан ба мажоритар тогтолцоогоор 67 гишүүн сонгогджээ. 1996 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Анхдугаар чуулганы хуралдааныг хийж анхны гишүүдийн бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн байна. Мажилисийн гишүүдийн 9 нь эмэгтэй гишүүд байжээ.

Мажилисийн анхны даргаар ОСПАНОВ Марат Турдыбекович, дэд даргаар ОСИПОВ Василий Иванович нар ажилласан байна.

Хоёр дахь удаагийн бүрэн эрх (1999-2004)

1999 оны намар Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу Казахстан Улс Төв азийн бүс нутагт анх удаа Парламентын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсан бөгөөд энэ нь улс төрийн намуудад сонгуульд оролцох боломжийг олгосноороо онцлогтой. Гишүүд намын жагсаалтаар тэгш төлөөллийн үндсэн дээр сонгогдсон ба энэ удаагийн сонгууль улс төрийн өндөр ач холбогдолтой, альтернатив хэлбэрээр явагдсанаараа онцлог болж, улс төрийн намуудыг байгуулах үйл явцыг идэвхжүүлсэн гэж үздэг.

Энэ удаагийн сонгуульд улс төрийн 10 нам оролцож, мажоритар нэг мандаттай тойрогт 547 нэр дэвшигч бүртгүүлсэн нь Казахстанд урьд өмнө байгаагүй олон нэр дэвшигч буюу нэг суудалд дунджаар найман хүн бүртгүүлсэн байна. Сонгуулийн дүнгээр нэг мандаттай тойргоос 67, намаас 10 нэр дэвшигч гишүүнээр сонгогдсон бөгөөд тэдгээр нь 7 хувийн босгыг давсан “Отан” нам, “Иргэний нам”, “Аграри нам”, “Коммунист нам” зэрэг 4 намын төлөөлөл байв.

Танхимын даргаар ТУЯКБАЙ Жармахан, дэд даргаар КОПЕЕВ Мухамбет Жуманазар нар ажилласан байна.

Гурав дахь удаагийн бүрэн эрх (2004-2007)

2004 оны 09 дүгээр сард явагдсан бөгөөд 12 улс төрийн нам оролцсон байна. Нийт 77 гишүүн сонгогдсон бөгөөд тэдний 69 нь нэг мандат бүхий нутаг дэвсгэрийн тойргоос, 10 нь улс төрийн намуудын жагсаалтаар пропорциональ тогтолцоогоор улсын нэг сонгуулийн тойргоос сонгогдсон. Үүнээс "Отан" намаас 7, "Асар" нам, "Ак жол" ардчилсан нам, "АИСТ" (Аж үйлдвэрийн ажилчдын холбоо)-с тус бүр 1 гишүүн сонгогджээ.

Нийт сонгогдсон гишүүдийн 59 нь улс төрийн намуудаас нэр дэвшсэн байна ба "Отан" намаас 42, "АИСТ" холбооноос 11, "Асар" намаас 4, "Ак жол" ардчилсан намаас 1, Казахстаны ардчилсан намаас 1, бие даан нэр дэвшигч 18 гишүүн байна.

Энэ удаагийн сонгуульд 8 эмэгтэй гишүүн ялалт байгуулжээ. Танхимын даргаар МУХАМЕДЖАНОВ Урал Байгунсович, дэд даргаар ДЬЯЧЕНКО Сергей Александрович нар ажилласан байна.

Казахстан Улсын Ерөнхийлөгчийн "Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Мажилисийг тараах, Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Мажилисийн ээлжит бус сонгуулийг явуулах тухай" зарлиг гарсантай холбогдуулан 2007 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Гурав дахь удаагийн Мажилисийн бүрэн эрх хугацаанаасаа дуусгавар болжээ.

Дөрөв дэх удаагийн бүрэн эрх (2007-2011)

Энэ удаагийн сонгууль 2007 оны 08 дугаар сард явагдсан бөгөөд мөн оны 05 дугаар сард Үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар Мажилисийн танхимын гишүүдийн тоо нэмэгджээ. Үүний дагуу сонгуулиар 107 гишүүн Мажилист сонгогдсон ба үүнээс 98 гишүүнийг намын жагсаалтаар бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр улсын хэмжээнд 1 тойрогт нууц санал хураалтаар сонгосон бол 9 гишүүнийг Казахстаны Ардын Чуулган /Ассамблей/-аас сонгосон байна. Сонгуульд өрсөлдсөн 7 намаас зөвхөн "Нур отан" нам 7 хувийн босгыг давах болзлыг хангаж дангаараа ялалт байгуулан намын жагсаалтаар сонгогдох бүх суудал буюу 98 суудал авчээ.

Тус сонгуулиар Казахстан Улсын олон үндэстний төлөөлөл Мажилист суух болсноороо онцлог бөгөөд нийт гишүүдийн 82 нь казах, 17 нь орос, 2 нь герман, мөн беларусь, балкар, солонгос, украин, узбек, уйгур үндэстний төлөөлөл тус бүр 1 байна. Өөр нэг онцлох зүйл эмэгтэй гишүүдийн тоо энэ удаад 17 хүрч, өмнөх сонгуулиудтай харьцуулахад бараг 2 дахин нэмэгджээ.

Танхимын даргаар МУСИН Аслан Еспулаевич 2008 оны 10 дугаар сар хүртэл, түүний дараа МУХАМЕДЖАНОВ Урал Байгунсович, дэд даргаар ДЬЯЧЕНКО Сергей Александрович 2010 оны 03 дугаар сар хүртэл, ЖУМАГУЛОВ Бакытжан Турсынович 2008 оны 04 дүгээр сар хүртэл, КАРИБЖАНОВ Жаныбек Салимович 2008 оны 05 дугаар сарын 14-нөөс, БОБРОВ Владимир Яковлевич 2010 оны 04 дүгээр сараас тус тус ажилласан байна.

Казахстан Улсын Ерөнхийлөгчийн "Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Мажилисийг тараах, Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Мажилисийн ээлжит бус сонгуулийг явуулах тухай" зарлиг гарсантай холбогдуулан 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Дөрөв дэх удаагийн Мажилисийн бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон.

Тав дахь удаагийн бүрэн эрх (2012-2016)

Тав дахь удаагийн Мажилисийн шинэ бүрэлдэхүүн 2012 оны 01 дүгээр сард байгуулагдсан. Сонгуульд улс төрийн 7 нам оролцоноос 3 нь эцсийн дүнгээр 7 хувийн босгыг давсан бөгөөд "Нур Отан" иргэний ардчилсан нам 80.99%, Казахстаны "Ак жол" ардчилсан нам 7.47%, Казахстаны Ардын Коммунист нам 7.19% санал авсан. Танхим нийт 107 гишүүнтэй байсан ба "Нур Отан" намаас 83, Казахстаны "Ак Жол" ардчилсан намаас 8, Казахстаны Ардын Коммунист намаас 7 гишүүн тус тус сонгогдсон бол Казахстаны Ардын Чуулган /Ассамблей/-аас 9 гишүүн сонгогджээ.

Нийт гишүүдийн 76 нь казах, 21 нь орос, 3 нь украин, 2 нь герман, мөн татар, чечень, солонгос, узбек, уйгур үндэстний төлөөлөл тус бүр 1 гишүүн сонгогдсон байна. Эмэгтэй гишүүдийн тоо 26 хүрсэн байна.

Танхимын даргаа НИГМАТУЛИН Нурлан Зайруллаевич 2014 оны 04 дүгээр сар хүртэл, түүнээс хойш ДЖАКУПОВ Кабибулла Кабенович, дэд даргаар ДЬЯЧЕНКО Сергей Александрович 2012 оны 09 дүгээр сар хүртэл, түүний дараа энэ өдрөөс ДЖАКУПОВ Кабибулла Кабенович, 2014 оны 04 дүгээр сараас НАЗАРБАЕВА Дарига Нурсултановна нар ажиллажээ.

Казахстан Улсын Ерөнхийлөгчийн "Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Мажилисийг тараах, Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Мажилисийн ээлжит

бус сонгуулийг явуулах тухай” зарлиг гарсантай холбогдуулан 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Тав дахь удаагийн Мажилисийн бүрэн эрх хугацаанаасаа дуусгавар болсон байна.

Зургаа дахь удаагийн бүрэн эрх (2016-2021)

Энэ удаагийн сонгууль 2016 оны 03 дугаар сарын 20-нд болсон бөгөөд сонгуульд 6 улс төрийн нам өрсөлдсөнөөс 3 нам нь 7 хувийн босго давах болзлыг хангасан байна. Үүнд “Нур Отан” нам 82.20%, Казахстаны Ардчилсан нам “Ак жол” 7.18%, Казахстаны Ардын Коммунист Нам 7.14% авч босго давжээ. Мажилист “Нур Отан” намаас 84, “Ак Жол” намаас 7, Казахстаны Ардын Коммунист намаас 7 суудал авсан бол Казахстаны Ардын Чуулган /Ассамблей/-аас 9 гишүүн сонгогдсон. Эмэгтэй гишүүд 29 болж нийт гишүүдийн 27%-ийг эзэлсэн байна.

Мажилисийн бүрэлдэхүүнд казах, орос, украин, түүнчлэн азербайжан, армен, солонгос, дунган, узбек, уйгур, чечень болон бусад үндэстэн ястнуудын төлөөлөл суудал авсан байна.

Мажилисийн даргаар ИЗМУХАМБЕТОВ Бактыкожа Салахатдинович 2016 оны 06 дугаар сар хүртэл, түүний дараа НИГМАТУЛИН Нурлан Зайруллаевич, ИСИМБАЕВА Гульмира Истайбековна, БОЖКО Владимир Карпович нар дэд даргаар ажилласан байна.

Долоо дахь удаагийн бүрэн эрх (2021-2023)

2021 оны 01 дүгээр сарын 10-нд Казахстан Улсын Мажилисийн Долоо дахь удаагийн сонгууль болсон байна. Сонгуульд оролцсон 5 намын 3 нь 7%-ийн босгыг давсан ба үүнд: “Нур Отан” нам 71.09%, “Ак Жол” ардчилсан нам 10.95%, Казахстаны Ардын нам 9.10%-ийн санал тус тус авсан байна. “Нур Отан” намаас 76, “Ак жол” намаас 12, Казахстаны Ардын намаас 10 гишүүн сонгогдож, Казахстаны Ардын Чуулган (Ассамблей)-аас 9 гишүүн сонгогдсон. Мөн Мажилисийн энэ удаагийн бүрэлдэхүүнд нийт 7 сонгуульд 7 удаа удаа сонгогдсон 32 гишүүн багтжээ. Мажилисийн шинэ бүрэлдэхүүн эрэгтэй 78 (73%), эмэгтэй гишүүд 29 болж нийт гишүүдийн 27%-ийг бүрдүүлсэн байна. Түүнээс гадна казах, орос, белорус, солонгос, герман, азербайжан, армян, курд, татар, узбек, уйгр, украин зэрэг олон үндэстний төлөөлөл сонгогджээ. Танхимын даргаар Нурлан Зайроллаұлы Ныгматулин 2022 оны 02 дугаар сар хүртэл, 2022 оны 02 дугаар сарын 01-нээс КОШАНОВ Ерлан, дэд даргаар КАЗАНЦЕВ Павел Олегович, КЕСЕБАЕВА Балаим Туганбаевна нар ажилласан байна.

Казахстан Улсын Ерөнхийлөгчийн “Бүгд Найрамдах Казахстан Улсын Мажилисийг тараах, Бүгд Найрамдах Казахстан Улсын Мажилисийн ээлжит бус сонгуулийг явуулах тухай тухай” зарлиг гарсантай холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Долоо дахь удаагийн Мажилис буюу Парламентын доод танхимын үйл ажиллагаа бүрэн эрхийн хугацаанаас өмнө дуусгавар болжээ.

Найм дахь удаагийн бүрэн эрх (2023 оноос)

2023 оны 03 дугаар сарын 19-нд Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын 8 дахь удаагийн Мажилисийн сонгууль болов. Сонгууль улсын хэмжээнд нэг тойргийн нутаг дэвсгэрт, мөн нэг мандаттай нутаг дэвсгэрийн тойрогт холимог тогтолцооны дагуу явагдсан.

2. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ДЭЭД ТАНХИМ БУЮУ СЕНАТ⁹³

Сенат нь бүс, улсын ач холбогдолтой хот, нийслэл болгоны бүх төлөөллийн байгууллагын депутатуудын хамтарсан хурлаас сонгогдсон хоёр гишүүнээс бүрдэнэ. Сенатын гишүүдийн тал нь 3 жил тутамд дахин сонгогддог.

⁹³ Сенат Парламента Республики Казахстан, <http://senate.parlam.kz/kk-KZ/about/history>

1996 оны 01 дүгээр сараас 2007 оны 08 дугаар сар хүртэл Төрийн тэргүүн Сенатын 7 орлогчийг томилдог байжээ.

2007 оны Үндсэн хуулийн шинэчлэлийн дараа мөн оны 08 дугаар сараас эхлэн Төрийн тэргүүн дахин Сенатын 8 орлогчийг нэмж томилохоор зохицуулагдсан ба үүний дагуу 2023 оны 01 дүгээр сар хүртэл Сенатын 15 орлогчийг томилдог байв.

2022 оны Үндсэн хуульд хийсэн шинэчлэлийн дагуу Төрийн тэргүүнээс томилогддог Сенатын депутатуудын тоо 15 байсныг 10 болгон бууруулсан. 2023 оны 01 дүгээр сараас Төрийн тэргүүн Сенатын 10 гишүүнийг томилдог болсон ба үүний дагуу 2023 онд томилогдсон 10 гишүүний хагасыг нь Казахстаны Ардын Чуулган /Ассамблей/-аас санал болгожээ.

Анхдугаар бүрэн эрх (1996 оны 01 дугаар сараас 1999 оны 11 дүгээр сар)

Бүгд Найрамдах Казахстан Улсын Анхдугаар парламентын бүрэн эрх 1996 оны 01 дүгээр сарын 30-нд Анхдугаар чуулганы хуралдааны нээлтээр эхэлж, 1999 оны 11-р сарын 30-ны өдөр буюу Хоёр дахь удаагийн Парламентын Анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээр дуусгавар болсон байна.

1995 оны 12-р сард болсон сонгуулиар Казахстан Улсын 19 бүс нутаг болон нийслэлээс тус бүр 2 төлөөлөл нийт 40 төлөөлөл парламентын Сенатын танхимын гишүүнээр сонгогдсон ба Сенатын 7 орлогчийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилсон байна.

1997 оны 10 дугаар сарын 08-нд 1995 онд 2 жилээр сонгогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан Сенатын гишүүдийн сонгуулийг явуулж, 4 жилийн хугацаатай сонгосон байна.

Бүс нутгуудыг оновчтой зохион байгуулах ажлын үр дүнд тэдгээрхийн тоо өөрчлөгдсөнөөр 14 бүс нутаг, Алматы хотод сонгууль явуулсан ба 1997 оны 10 дугаар сард Сенатын 15 гишүүнийг сонгов. Түүнчлэн Акмола хотыг Бүгд Найрамдах Казахстан Улсын нийслэлээр зарласантай холбогдуулан 1998 оны 02 дугаар сарын 11-нд Акмола хотоос Сенатын гишүүдийг нэмж сонгожээ.

Хоёр дахь удаагийн бүрэн эрх (1999 оны 12 дугаар сараас 2004 оны 11 дүгээр сар)

Хоёр дахь удаагийн парламентын бүрэн эрх 1999 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Анхдугаар чуулганаа нээснээр эхэлж, 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр буюу дараагийн парламентын Анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээр дуусгавар болов.

1999 оны 09 дугаар сарын 17-нд 1995 онд 4 жилээр сонгогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан Сенатын гишүүдийг шинээр 6 жилийн хугацаатай сонгосон байна (1998 оны 10 дугаар сар хүртэл гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байсан бөгөөд түүнээс хойш 6 жил болсон).

1997 онд сонгогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрх Үндсэн хуулийн дагуу энэ хугацаанд 2002 оны 12 дугаар сар хүртэл үргэлжилсэн.

Гурав дахь удаагийн бүрэн эрх (2004 оны 11 дүгээр сараас 2007 оны 09 дүгээр сар)

Гурав дахь удаагийн бүрэн эрх 2004 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Анхдугаар чуулганаа нээснээр эхэлж, 2007 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр буюу Дөрөв дэх удаагийн бүрэн эрх хэрэгжиж эхэлснээр дуусгавар болсон.

2005 оны 12 дугаар сард 1999 оны 09 дүгээр сарын 17-нд сонгогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан 2005 оны 08 дугаар сарын 19-нд Сенатын гишүүдийг шинээр сонгосон ба 2002 онд сонгогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрх энэ хугацаанд үргэлжилсэн байна.

Дөрөв дэх удаагийн бүрэн эрх (2007 оны 09 дүгээр сараас 2012 оны 01 дүгээр сар)

Дөрөв дэх удаагийн бүрэн эрх 2007 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Анхдугаар чуулганаа нээснээр эхэлж, 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр буюу Тав дахь удаагийн бүрэлдэхүүний Анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдөр өндөрлөв.

2007 оны 05 дугаар сард Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу тус улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн зарлигаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Парламентын Сенатын 8 гишүүнийг шинээр нэмж томилов.

Дөрөв дэх удаагийн бүрэн эрхийн хугацаанд 2002 онд сонгогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрх 2008 оны 12 дугаар сар хүртэл, 2005 онд сонгогдсон, томилогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрх 2011 оны 09 дүгээр сар хүртэл үргэлжилсэн байна.

Тав дахь удаагийн бүрэн эрх (2012 оны 01 дүгээр сараас 2016 оны 01 дүгээр сар)

Тав дахь удаагийн бүрэн эрх 2012 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Анхдугаар чуулганы хуралдааныг нээснээр эхэлж, Зургаа дахь удаагийн бүрэн эрхийн Анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээр дуусгавар болсон.

Энэ удаагийн бүрэн эрхийн хугацаанд 2007, 2011 онуудад томилогдсон болон 2008, 2011 онуудад сонгогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрх үргэлжилсэн.

Харин Төрийн тэргүүний зарлигаар 2007 оны 08 дугаар сард томилогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан тул 2013 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Сенатын 8 гишүүнийг томилсон байна.

2014 оны 10 дугаар сарын 01-нд Казахстан Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Сенатын гишүүдийг сонгосон ба сонгогдсон гишүүдийг бүртгэснээр 2008 онд сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлсэн.

Зургаа дахь удаагийн бүрэн эрх (2016 оны 03 дугаар сараас 2021 оны 01 дүгээр сар)

Зургаа дахь удаагийн бүрэн эрх 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Анхдугаар чуулганаа нээснээр эхэлж, Долоо дахь удаагийн ээлжит Анхдугаар чуулган эхэлснээр өндөрлөсөн.

Энэ бүрэн эрхийн хугацаанд 2011, 2013 онуудад томилогдсон болон 2011, 2014 онуудад сонгогдсон Сенатын гишүүдийн бүрэн эрх үргэлжилсэн.

2017 оны 06-р сарын 28-нд Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Сенатын гишүүдийг сонгосон ба 2017 онд сонгогдсон гишүүдийн бүрэн эрх хэрэгжиж эхэлснээр 2011 онд сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг 06 дугаар сарын 30-ны өдөр түдгэлзүүлсэн.

2018 онд Чимкент хот улсын ач холбогдолтой хот болсноор 10 дугаар сард тус хотоос Сенатын хоёр гишүүнийг шинээр нэмж сонгосон байна. Мөн 2020 оны 08 дугаар сарын 12-нд Сенатын гишүүдийг сонгосон ба тэдгээр гишүүдийн бүрэн эрх үүссэнээр 2014 онд сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг 08 дугаар сарын 28-нд түдгэлзүүлсэн.

Долоо дахь удаагийн бүрэн эрх (2021 оны 01 дүгээр сараас 2023 оны 03 дугаар сар)

Долоо дахь удаагийн бүрэн эрхийн хугацаа 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Анхдугаар чуулганаа нээснээр эхэлж, Найм дахь ээлжит бус чуулганы Анхдугаар хуралдаан эхэлснээр дуусгавар болсон.

2017, 2020 онуудад сонгогдсон болон 2017, 2019 онуудад томилогдсон Зургаа дахь удаагийн Сенатын гишүүдийн бүрэн эрх үргэлжилсэн.

Улсад шинээр 3 бүс бий болсонтой холбогдуулан 2022 оны 08 дугаар сарын 24-нд эдгээр бүс нутгаас Сенатын 6 гишүүнийг шинээр нэмж сонгосон байна.

2023 оны 01 дүгээр сарын 14-нд Сенатын гишүүдийн сонгосон ба 2023 оны 01 дүгээр сарын 25-нд сонгогдсон Сенатын гишүүдийг Сонгуулийн төв хороо бүртгэн авснаар 2017 онд сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэв.

2022 оны 06 дугаар сард Казахстан Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 24-нд Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Сенатын 10 гишүүнийг томилж, 2017-2021 онд томилогдсон Сенатын депутатуудын бүрэн эрхийг түдгэлзүүлэв.

Найм дахь удаагийн бүрэн эрх (2023 оны 03 дугаар сараас)

Найм дахь удаагийн Бүгд Найрамдах Казахстан Улсын Сенатын бүрэн эрхийн хугацаа 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Анхдугаар чуулганаа нээснээр эхэлж, 9 дэх удаагийн Анхдугаар чуулган хуралдаан хуралдах хүртэл үргэлжилнэ.

2020, 2023 онуудад сонгогдсон, 2023 онд томилогдсон Зургаа дахь удаагийн Сенатын гишүүдийн бүрэн эрх үргэлжилж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Официальный интернет ресурс Мажилиса Парламента Республики Казахстан, <https://www.parlam.kz/kk/mazhilis/history?id=history>
- Сенат Парламента Республики Казахстан, <http://senate.parlam.kz/kk-KZ/about/history>

**МОНГОЛ УЛС, БНЭУ-ЫН ХАРИЛЦАА БОЛОН БНЭУ-ЫН
ТАЛААРХ ЛАВЛАГАА**

Г.Билгээ

АГУУЛГА

1.МОНГОЛ УЛС, БНЭУ-ЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- 1.1.Хоёр улсын дипломат харилцаа
- 1.2.Хоёр улсын хамтын ажиллагаа
- 1.3.Худалдаа, эдийн засгийн харилцаа
- 1.4.Хүмүүнлэгийн болон бусад харилцаа

2.БНЭУ-ЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 2.1.БНЭУ-ын товч мэдээлэл
- 2.2.Улс төрийн тогтолцоо
- 2.3.Эдийн засгийн үзүүлэлт

3.БНЭУ-ЫН ПАРЛАМЕНТЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 3.1.Парламентын дээд танхим - Ражья Сабха
- 3.2.Парламентын доод танхим - Лок Сабха

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. МОНГОЛ УЛС, БНЭУ-ЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Орчин үеийн Монгол Улсын гадаад бодлогын стратеги нь гадаад харилцааг гурван үндсэн чиглэлээр хөгжүүлдэг. Эхний хоёрт Монгол Улсын уламжлалт түнш, мөнхийн хөршүүд болох Орос, Хятад улстай харилцах харилцаа, хамтын ажиллагаа ордог. Гурав дахь чиглэлийг “гуравдагч хөрш” гэсэн нэр томъёогоор тодорхойлсон бөгөөд энэ нь Монгол Улстай нэгдмэл хиллэдэггүй боловч хэд хэдэн шалтгааны улмаас энэ бүс нутагт өөрийн гэсэн ашиг сонирхолтой байдаг. Монгол Улсын энэхүү стратегийн гол зорилго нь гадаад бодлогын гол түншүүдийн нөлөөг тэнцвэржүүлж, тус бүртэй хамтран ажиллах нь үр шимийг хүртэх явдал юм. Өөрөөр бол олон векторт гадаад бодлого гэсэн үг юм. Монгол Улсын “гуравдагч хөрш”-д хамааруулдаг Америкийн Нэгдсэн Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк Улс, Европын Холбооны улсуудаас Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ) нь бие даасан байр эзэлдэг.⁹⁴ БНЭУ бол манай улсын “оюун санааны хөрш” юм.

1.1. Хоёр улсын дипломат харилцаа

Монгол, Энэтхэг хоёр улсын харилцааг одоогоос 3000 жилийн тэртээгээс эхтэй гэж судлаачид үздэг. Түүнчлэн хоёр улсын харилцаа холбооны талаарх түүхэн эх сурвалжуудын эхнийх нь Хүн гүрний үе буюу МЭӨ 209 оны үед хамаардаг. Хожим буддын шашны нөлөөгөөр хоёр улсын ард түмэнд нийтлэг соёл бий болсон гэж үздэг.

Энэтхэг судлаач, дипломатч О.Нямдаваа “Дэлхийн өнцөг булан бүрт монгол гаралтай, өөрсдийгөө монгол гэж үздэг олон хүмүүс бий. Энэтхэгт 30 сая гаруй монгол гарал үүсэлтэй хүмүүс байна. Энэтхэгийн зүүн хойд дүүргийн 8 муж байдаг. Эдгээр мужид яг монголчууд бидэн шиг зүс царайтай, хоол хүнс ижил, бидэнтэй ижил төсөөтэй хувцас өмсдөг улсууд байдаг. Тэд ярихдаа бид бол монголчууд. Түүхийн олон зуун жилийн нугачаанаас үүдэн Энэтхэгт амьдрах болсон. 3000, 2000, 1500 жилийн өмнө Энэтхэгт ирж амьдрах болсон гэдэг.” хэмээн өгүүлжээ.⁹⁵

Орчин үеийн Монгол-Энэтхэгийн хоорондын харилцааны түүх Дэлхийн II дайны дараа эхэлсэн. Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Засгийн газар, Энэтхэг Улсын түр Засгийн газрын эрх баригчдын хооронд 1947 оны хавар Шинэ Дели хотноо болсон Азийн харилцааны бага хурлын үеэр анхны албан ёсны харилцаа тогтоогджээ. (ФХ)

Үүний үр дүнд Их Британийн колоничлолоос чөлөөлөгдсөн БНЭУ манай улсыг хүлээн зөвшөөрсөн социалист бус анхны орон байсан. Мөн БНЭУ нь 1955 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон социалист бус анхны орон болжээ. Монгол Улс 1956 онд Шинэ Делид, БНЭУ 1971 онд Улаанбаатарт ЭСЯ-аа нээж байжээ.⁹⁶

Дайны дараах үеийн харилцааны чухал үндэс нь колоничлолын өвийг даван туулж, олон улсад бүрэн хүлээн зөвшөөрөгдөхийг эрмэлзэж байсан хоёр орны нийтлэг асуудал, үүрэг даалгавар байв. Үндсэндээ энэ шалтгааны улмаас 1961 онд Монгол Улсыг НҮБ-д элсэхийг тууштай дэмжиж байсан орнуудын нэг нь БНЭУ байсан юм. Хуучнаар Зөвлөлт Холбоот Улс, БНЭУ-ын харилцааны найрсаг шинж чанар нь ийнхүү Улаанбаатар, Шинэ Делигийн хооронд харьцангуй нягт хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд эергээр нөлөөлжээ. (ФХ)

⁹⁴ Р.В.Александрович. Улс төрийн харилцааны соёл иргэншлийн асуудал. Евроазийн бус нутаг дахь Монгол, Оросын соёл иргэншлийн харилцан үйлчлэл (Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт /2019-2022/ хэрэгжүүлсэн “Евроазийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл” сэдэвт гадаадтай хамтарсан төслийн судалгааны үр дүн). УБ., 2023 он. 224-232 дахь тал. (Цаашид “ФХ”)

⁹⁵ Монгол, БНЭУ дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой тохиож байна. МОНЦАМЭ.
<https://www.montsame.mn/mn/read/247835> (Цаашид “МОНЦАМЭ”)

⁹⁶ Гадаад харилцааны яам (Цаашид “ГХЯ”).

Шигтгээ 1.**Хоёр улсын Элчин сайд нар**

Монгол Улсаас БНЭУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Д.Ганболд 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Итгэмжлэх жуух бичгээ БНЭУ-ын Ерөнхийлөгч Рам Натх Ковиндод өргөн барьсан.

БНЭУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мохиндер Пратап Сингх 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад Итгэмжлэх жуух бичгээ өргөн барьжээ.

Эх сурвалж: ГХЯ.

1.2.Хоёр улсын хамтын ажиллагаа

Монгол, Энэтхэг хоёр улс харилцаагаа улс төр, батлан хамгаалах, соёл, боловсрол, хүмүүнлэгийн чиглэлд өргөжүүлж, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулахаар ажиллаж байна. Олон улсын тавцанд идэвхтэй хамтран ажиллаж ирсэн уламжлалаа ч хадгалж ирсэн. (ГХЯ)

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Юмжаагийн Цэдэнбал 1959, 1973 онд хоёр удаа БНЭУ-д албан ёсны айлчлал хийсэн байдаг. Тэрээр хоёр дахь айлчлалын үеэр Монгол-Энэтхэгийн хамтарсан тунхаглалд гарын үсэг зурсан түүхтэй. Энэхүү баримт бичигт хоёр орны харилцаа энх тайванч зэрэгцэн орших, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, маргааныг энхийн замаар шийдвэрлэх хүсэл эрмэлзэл зэрэг зарчмуудыг тусгасан байна.

Харин 1988 онд БНЭУ-ын Ерөнхийлөгч Шри Рамасвами Венкатараман БНМАУ-д албан ёсны айлчлал хийж, шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Мөн БНЭУ уламжлал ёсоор тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд БНМАУ-ыг элсэхэд дэмжлэг үзүүлж байсан түүхтэй. Ийнхүү 1990-ээд оны эхээр Монгол-Энэтхэгийн харилцаа тодорхой түвшинд хүрч, улмаар талууд хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаан ажилласаар байв.

Хоёр улсыг үзэл суртлын хүрээнд ойртуулах хүчин зүйлүүдийн нэг нь Буддын шашин юм. 1980-90-ээд оны зааг дээр Монголд буддын шашны нэгэн төрлийн сэргэн мандалтын давлагаа болж, тухайн үед дээрх хоёр орны шашны нийгэмлэгүүдийн харилцаа үлэмж идэвхэжсэн. Буддын шашны өлгий нутаг руу олон монголчууд тогтмол аялах болсноор өнөөдөр БНЭУ бол олон монгол лам нарын шашны боловсрол эзэмшсэн, цаашид ч эзэмших газар болсон. Тус улсын Дармасала дахь Дээрхийн гэгээн XIV Далай ламын өргөө нь Төвөдийн буддизмын оюун санааны удирдагчийн номлолд нэгдэхийг эрмэлзэж буй монголын олон мянган иргэдийн очдог газар болсон юм.

Социализмын дараах үеийн хоёр талын харилцааг бэхжүүлэхийг 1990-ээд онд Буддын шашны нэрт зүтгэлтэн Бакула Ринбүчи идэвхтэй сурталчилж байв. Тэрээр БНЭУ-аас Монгол Улсад суух Элчин сайдаар ажиллаж байсан юм. Түүний шууд оролцоотойгоор манай улсад Буддын шашны шинэ сүм, боловсролын байгууллагууд байгуулагдсан юм. (ФХ)

Шигтгээ 2.**Хоёр улсын харилцан хийсэн гол айлчлалууд**

Монголын талаас:

1959 онд	БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал
1973 онд	БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал
1989 онд	Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх
1994 онд	Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат
1996 онд	УИХ-ын дарга Н.Багабанди
1998 онд	УИХ-ын дарга Р.Гончигдорж
2001 онд	Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди
2003 онд	УИХ-ын дарга С.Төмөр-Очир
2004 онд	Ерөнхий сайд Н.Энхбаяр
2009 онд	Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж
2010 онд	УИХ-ын дарга Д.Дэмбэрэл
2015 онд	Шадар сайд Ц.Оюунбаатар
2016 онд	Гадаад харилцааны сайд Л.Пүрэвсүрэн
2019 онд	Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар айлчилж, “Райсина диалог-2019” хуралд оролцсон
2019 онд	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга
2021 онд	УИХ-ын дарга Г.Занданшатар

Энэтхэгийн талаас:

1957 онд	Дэд ерөнхийлөгч Др.С.Радхакришнан
1976 онд	Гадаад харилцааны сайд Шри Чаван
1988 онд	БНЭУ-ын Ерөнхийлөгч Шри Р.Венкатараман
1992 онд	Дэд ерөнхийлөгч Др.Шанкал Даяар Шарма
1996 онд	Дэд ерөнхийлөгч К.Р.Наяаранан
1999 онд	Дэд ерөнхийлөгч Кришнан Кант
2001 онд	Парламентын доод танхимын дарга Шри Балаиоги
2010 онд	Парламентын доод танхимын дарга МейраКумар
2011 онд	БНЭУ-ын Ерөнхийлөгч Пратибха Девиснигх Патил
2015 онд	Ерөнхий сайд Нарендра Модри
2016 онд	Дэд ерөнхийлөгч Хамид Ансари (АСЕМ)
2016 онд	Парламентын доод танхимын дарга Сумитра Махажан
2018 онд	Гадаад харилцааны сайд Шушма Свараж
2018 онд	Дотоод хэргийн сайд Шри Ражнат Сингх
2018 онд	Дотоод хэргийн төрийн сайд Кирен Рижжигу
2022 онд	Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх

Гадаад харилцааны төрийн сайдын түвшинд 2003, 2009, 2011, 2021 онд Монгол Улсад тус тус айлчилсан.

Эх сурвалж: ГХЯ.

Буддын шашин нь Монгол-Энэтхэгийн дипломат харилцааны чухал элементийн үүрэг гүйцэтгэдэг. Хоёр орны харилцааны түүхэнд буддын шашин онцгой үүрэг гүйцэтгэсэн тухай хоёр орны улс төрчдийн мэдэгдэл давтагдаж байна. Тухайлбал, Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр 2006 оны 02 дугаар сард Хятадын төв телевизэд өгсөн ярилцлагадаа: “Бид Энэтхэгийг оюун санааны хөрш улс гэж үздэг. Учир нь Монголд буддын сургаал Энэтхэгээс орж ирсэн. Түүгээр ч зогсохгүй хоёр орны Буддын шашны нийгэмлэгийг ардчиллын үнэт зүйлстэй уялдуулан танилцуулдаг” хэмээн хэлсэн байдаг. Мөн БНЭУ-ын Ерөнхий сайд Нарендра Модри хэлэхдээ, “Хиндучууд болон Монголчууд хоёулаа ардчиллын нийтлэг үнэт зүйлтэй. Эдгээр үнэт зүйлсийг тусгадаг Буддизм гэсэн нийтлэг итгэл үнэмшилтэй ард түмэн юм. Мөн энэ нь цаашдын ойртох хүчирхэг үндэс юм.” гэсэн байдаг. Харин энэтхэгийн судлаач Ш.Сони “Буддын шашныг бүс нутгийн болон олон улсын хэтийн төлөвт Энэтхэгийн геополитикийн хэрэгсэл болгон ашиглаж янз бүрийн асуудлыг шийдвэрлэх боломжтой.” гэж үзжээ. (ФХ)

Шигтгээ 3.**Хоёр улсын харилцаа**

- 1973 онд Монгол, Энэтхэгийн Хамтарсан тунхаглалд гарын үсэг зурсан.
- 1989, 2001, 2004, 2015, 2019 онд Хамтарсан мэдэгдэл хийж байсан.
- 1994 онд Найрсаг харилцаа хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан.
- 2009 онд Иж бүрэн түншлэлийн түвшинд хүрсэн.
- 2015 оны 5 дугаар сард Стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн.

Эх сурвалж: ГХЯ.

Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Монгол-Энэтхэгийн хамтын ажиллагаа харилцааны бүхий л томоохон салбарт хадгалагдаж ирсэн. Монгол Улсын төлөөлөгчид БНЭУ-д удаа дараа албан ёсны болон ажлын айлчлал хийж, олон салбарын үйл ажиллагааны хоёр талын баримт бичигт гарын үсэг зурсан. (ФХ)

1973 онд байгуулсан хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх анхны санамж бичгийг 1994 оны 02 дугаар сард Ерөнхийлөгч П.Очирбатын Делид хийсэн БНЭУ-д хийсэн албан ёсны айлчлалын үр дүнд агуулга, хэлбэрээ “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ” болгон тэлж, улмаар талууд дипломат, эдийн засаг, цэрэг, соёл, боловсролын зэрэг үндсэн чиглэлээр хамтран ажиллах хөгжлийн төлөвлөгөөгөө тодорхойлсон явдал байв. Уг гэрээг 2001, 2004, 2009 онд шинэчилсэн байна. (МОНЦАМЭ)

Социализмын дараах үеийн харилцааны ихэнх хугацаанд Монголын дипломат ажиллагаа Энэтхэгийн дипломатаас илүү идэвхтэй байсныг энд тэмдэглэж болно. Монголын бүх ерөнхийлөгчид эхний үеэс эхлэн Энэтхэгт өөр өөр цаг үед албан ёсны айлчлал хийсэн байдаг. Жишээлбэл: Пунсалмаагийн Очирбат (1994), Нацагийн Багабанди (2001), Намбарын Энхбаяр (2004), Цахиагийн Элбэгдорж (2009), Халтмаагийн Баттулга (2019) тус тус өндөр дээд хэмжээний айлчлалуудыг хийсэн байдаг. БНЭУ-ын талаас өндөр албан тушаалтнуудын хийсэн цөөхөн айлчлалын дотроос 2011 оны 07 дугаар сард БНЭУ-ын Ерөнхийлөгч Пратибха Патил ирж байсан. (ФХ)

2015 онд БНЭУ-ын Ерөнхий сайд Н.Модигийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр “Газрын тос боловсруулах үйлдвэр барих тэрбум ам.долларын зээл” амласнаар манай хоёр улсын харилцаа шинэ түвшинд хүрсэн юм.

Уг айлчлалын үер хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол Энэтхэгийн стратегийн түншлэлийн тухай хамтарсан мэдэгдэл гарын үсэг зурсан юм. Мөн энэ үеэр соёл, хүмүүнлэг, батлан хамгаалах, эрүүл мэнд, боловсролын чиглэлд хэд хэдэн санамж бичиг, хэлэлцээрт хоёр орны Ерөнхий сайд нар гарын үсэг зурсан юм. Тухайлбал, Монгол Улсын Гадаад хэргийн яам, БНЭУ-ын Гадаад хэргийн яам хооронд хамтран ажиллах тухай, Ялтан шилжүүлэх тухай хоёр улсын хооронд санамж бичиг байгуулах тухай, Агаарын харилцааны тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Соёлын салбарт 2015-2018 он хүртэл хамтран ажиллах тухай санамж бичиг, Монгол, Энэтхэгийн хамтарсан сургууль байгуулах тухай, Уламжлалт анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай, Кибер аюулгүй байдлын сургалтын төв байгуулах тухай, Малын эрүүл мэнд, сүүний чиглэлээр хамтран ажиллах тухай, Сэргээгдэх эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг, Монгол Улсын ЯАБЗ, Энэтхэг улсын ЯАБЗ хоорондын хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичиг, Хил хамгаалал, хилийн дэглэм сахиулах тухай, Хавдар судлалын Үндэсний төв, Энэтхэгийн Тата момера төв хоорондын хамтын ажиллагааны тухай санамж бичгүүдэд тус тус гарын үсэг зурлаа. Мөн хоёр 2016-2020 он

хүртэл хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.⁹⁷

Шигтгээ 4.

Хоёр талын харилцааны механизмууд

Засгийн газар хоорондын комисс:

- Монгол-Энэтхэгийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны анхдугаар хуралдаан 2006 онд Улаанбаатар хотноо болсон бөгөөд талууд 7 дугаар хуралдааныг 2020 онд цахим хэлбэрээр зохион байгуулсан.
- Хамтарсан хорооны Монголын хэсгийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ийн дарга Д.Амарбаясгалан даргалж байна.

Парламентын бүлэг:

- Хоёр орны Парламент 1995, 2001, 2016 онд "Хамтын ажиллагааны протокол" байгуулсан.
- Монгол-Энэтхэгийн Парламентын бүлгийг 2020 онд УИХ-д байгуулсан. Бүлгийн дарга Б.Саранчимэг, нийт 28 гишүүнтэй.

Эх сурвалж: ГХЯ.

1.3.Худалдаа, эдийн засгийн харилцаа

Монгол Улсын хувьд “гуравдагч хөрш”-тэй харилцах хамгийн чухал тал бол худалдаа, эдийн засгийн харилцааг төрөлжүүлэхийг эрмэлзсээр ирсэн. Монголын тал Энэтхэгийн түншүүдтэйгээ мэдээллийн технологийн технологи, эм зүй, уран, нүүрсний салбарт хамтран ажиллах сонирхолтой байгаагаа удаа дараа илэрхийлсээр ирсэн. Үүний зэрэгцээ Монгол-Энэтхэгийн худалдаа, эдийн засгийн харилцаа сүүлийн гучин жилийн хугацаанд тийм ч амжилттай байгаагүй. Хоёр талын худалдааны хэмжээ жилд 60 сая ам. доллараас давж байгаагүй бөгөөд 2019 онд Монгол Улсын гадаад худалдааны түншүүдийн дунд БНЭУ-ын эзлэх хувь 0.27 хувьтай байна. (ФХ)

Хүснэгт 1. Монгол-Энэтхэгийн худалдааны динамик (2015-2019 онд)

Жил	2015	2016	2017	2018	2019
Эзлэхүүн (мянган ам.доллар)	20573.2	26988.43	37031.51	53539.5	38138.3
Нийт эргэлтэд эзлэх хувь (хувь)	0.24	0.32	0.35	0.41	0.27

*Эх сурвалж: Монгол Улсын Гадаад худалдаа.
https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L14&type=tables*

Давхар татвараас чөлөөлөх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байсан ч сүүлийн 10 жилийн хугацаанд БНЭУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ 10 сая ам.долларт ч хүрээгүй байхад гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 22 тэрбум ам.доллар давсан.

Социализмын үетэй харьцуулахад, орчин үед цэргийн салбарт хамтран ажиллах явдал нь шинэ зүйл байв. 2004 оноос хойш Улаанбаатар, Шинэ Дели хотууд «Нүүдэлчин заан» сэдэвт хоёр талын цэргийн сургуулилтыг жил бүр зохион байгуулж ирсэн. 2006 оноос БНЭУ-ын цэргийнхэн монголын нутаг дэвсгэрт жил бүр зохиогддог «Хааны эрэлд» олон улсын сургуулилтад тогтмол оролцож байна. Монгол цэрэг, офицерууд цэргийн ур чадвараа дээшлүүлэхийн зэрэгцээ цэргийн шинэ техник хэрэгсэлтэй танилцах, англи хэл сурах сонирхолтой байгаа нь НҮБ-ын ивээл дор энхийг сахиулах ажиллагаанд оролцоход тус дөхөм болдог. БНЭУ кибер аюулгүй байдал, терроризм, хар тамхины наймаа болон бусад аюул заналхийлэлтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой байгаагаа удаа

⁹⁷ Энэтхэг Улс нэг тэрбум долларын хөнгөлөлттэй зээл олгоно. Нийтэлсэн 2015.05.17. <https://itoim.mn>

дараа илэрхийлж байсан. (ФХ)

Худалдааны харилцааны хувьд, 2022 онд Монгол Улсаас мал амьтны самнасан үс, хялгас, хонины ноос, хивс экспортолж, өргөгч, ачигч, буулгагч машин механизмд зориулалттай эд анги, хар төмрөн хоолойд зориулсан ган ба ширмэн холбоос, лаазалсан хүнсний ногоо, эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн хаймран эдлэл зэрэг бараа, бүтээгдэхүүнийг голдуу импортолсон байна. (ГХЯ)

Хүснэгт 1. Монгол-Энэтхэгийн худалдааны харилцаа (2011-2022 онд)

Он	Экспорт (сая ам.доллар)	Импорт (сая ам.доллар)
2011	1,4	45,3
2012	6,0	54,2
2013	0,8	34,2
2014	3	12,8
2015	3,8	16,8
2016	2,2	24,8
2017	1,8	35,9
2018	0,99	51,7
2019	1,15	37,14
2020	0,74	34,6
2021	0,275	63,6
2022	0,744	90,9

Эх сурвалж: ГХЯ.

БНЭУ-аас хэрэгжүүлж байгаа томоохон төсөл хөтөлбөрүүдийг дурдвал, тус улсын 1.2 тэрбум ам.долларын зээлээр баригдаж буй Монголын хамгийн том газрын тос боловруулах үйлдвэрийн ажил юм. Мөн Атали Бихари Важпайн нэрэмжит Мэдээлэл Технологи Аутсорсингийн төв (20 сая долларын өртөг), Кибер аюулгүй байдлын сургалтын төв, Энэтхэг-Монголын хамтарсан Найрамдлын дунд сургуулийг нэрлэж болно.

Шигтгээ 5.

БНЭУ-аас Монгол Улсад олгосон зээл, тусламж

Хөнгөлөлттэй зээл:

- 2009 онд 25 сая ам.долларыг Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулахад олгосон.
- 2012 онд 20 сая ам.долларыг Мэдээллийн технологи, Аутсорсингийн төв байгуулахад олгосон.
- 2015 онд БНЭУ-ын Ерөнхий сайд Н.Моди Монгол улсад айлчлах үеэр 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болсон.
- 2019 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын БНЭУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр нийт зээлийн хэмжээг 1.236 тэрбум ам.доллар болгож нэмэгдүүлсэн.

(үргэлжлэл)

Тусламж:

- 2.8 сая ам.долларыг Ражив Гандийн нэрэмжит Технологийн Сургуулийн техник, технологийн шинэчлэл хийхэд,
- 1 сая ам.долларыг ШУТИС-ийн КТМС-д зарим шинэчлэл хийхэд,
- 1.5 тэрбум төгрөгтэй тэнцэх Бабатрон-II туяа эмчилгээний аппаратыг Хавдар судлалын үндэсний төвд,
- 50.000 ам.долларыг үерийн гамшигт өртсөн аймгуудад (2018 онд)
- 5 сая ам.долларын буцалтгүй тусламжийг Монгол-Энэтхэгийн найрамдлын дунд сургууль барихад.

Монгол Улсаас БНЭУ-д олгосон тусламж

Энэтхэг Улсад “КОВИД-19” цар тахлын халдварын дэгдэлт нэмэгдэж, олон хүний амь нас эрсдэсэнд Монгол Улсын Засгийн газраас 1 сая ам.долларын буцалтгүй тусламж өгсөн.

Эх сурвалж: ГХЯ.

1.4. Хүмүүнлэгийн болон бусад харилцаа

2022 оны байдлаар тус улсад манай улсын 480 иргэн, Монгол Улсад БНЭУ-ын 471 иргэн оршин сууж байна. 2022 онд тус улсад манай улсын 2287 иргэн зорчсон бол Монгол Улсад БНЭУ-ын 1471 иргэн нэвтэрч, 1467 иргэн гарсан байна.

Боловсролын харилцааны хувьд, 1987 оноос эхлэн жил бүр БНЭУ-ын Соёл, боловсрол, Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа (ИТЕС)-ны хөтөлбөрийн хүрээнд 200, Энэтхэгийн Соёлын зөвлөл (ICCR)-ийн хөтөлбөрийн хүрээнд 60, бусад хөтөлбөрийн хүрээнд 20 мэргэжилтнүүд тус улсад урт, богино хугацааны сургалтад хамрагдаж байна.

Түүнчлэн БНЭУ-д манай 800 орчим лам, хувраг шавилан суралцаж байна. Тус улсад бага насны, харах хандах хүнгүй хүүхдүүд олноор очиж сурдаг бөгөөд тэнд суралцаж байх хугацаандаа зөвхөн төвөд хэлээр хичээлээ үздэг нь монгол хэл, соёлоо мартаж, эх хэлээрээ уншиж, бичиж чадахгүйд хүргэдэг ажээ.

1967 онд Энэтхэг-Монголын найрамдлын нийгэмлэг байгуулагдсан, одоогоор 10 гаруй хотод 17 салбартай болоод байна.

Үндэсний бүтээмжийн төв, хүүхдийн байгууллага, зарим спортын холбоод зэрэг нэлээд байгууллагууд хоорондоо ажил төрлийн холбоотой ажиллаж, төлөөлөгчид солилцож байна. Мөн тус улсад Монгол оюутны холбоо үйл ажиллагаа явуулж байна.

Соёлын харилцааны хувьд, 1959 онд Монгол, Энэтхэгийн соёлоор харилцах нийгэмлэг байгуулагдаж байсан бол 1986 онд Өмнөд Азийн орнуудтай харилцах Монголын нийгэмлэг, 1990 онд Монгол, Энэтхэгийн найрамдлын нийгэмлэг болон шинэчлэгдсэн. 1992 оноос “Энэтхэгийн соёлын төв” Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж, энэтхэгийн соёл, урлагийг монголчуудад сурталчилж, хүүхэд залуучуудад хинди хэл сургаж байна. Мөн 2007 онд “Энэтхэг судлалын төв” Улаанбаатар хотод нээгдсэн байна.

БНЭУ-ын Бихар мужийн Бодгаяад Монгол сүм баригдаж, 2017 оны 01 дүгээр сард нээх ёслол болсон.

2012 оны 02 дугаар сарын 01-нээс 03-ны өдрүүдэд Шинэ Дели хотод байрладаг Индра Гандигийн нэрэмжит Урлаг, соёлын өвийн үндэсний төвд Олон Улсын Монголч эрдэмтдийн хурлыг зохион байгуулж байсан. Дашрамд дурдахад, БНЭУ-ын эрдэмтэд Локеш Чандра, Шарад Сони, Мансура Хайдар зэрэг Монгол судлалын нэртэй судлаачид байдаг.

2015 онд дипломат харилцаа тогтоосны 60 жилийг хоёр тал бүтэн нэг жилийн туршид хамтран тэмдэглэж олон нийтийг хамарсан урлаг, соёлын арга хэмжээг Улаанбаатар, Шинэ Дели хотноо зохион байгуулж байсан.

2018 оны 08 дугаар сард Энэтхэгийн соёлоор харилцах зөвлөлийн ерөнхий захирал Рива Гангули Дас Монгол Улсад айлчилж байжээ. (ГХЯ)

2.БНЭУ-ЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1.БНЭУ-ын товч мэдээлэл

БНЭУ бол Өмнөд Азийн Энэтхэгийн хойгт орших бүрэн эрхт улс юм. Дэлхийд газар хүн амын тоогоор нэгдүгээрт, эдийн засгийн үзүүлэлтээр тавдугаарт, газар нутгийн хэмжээгээр долдугаарт жагсдаг дэлхийн их гүрэн улс юм.

Тус улс нь Индусийн соёл иргэншил болон бусад эртний соёл иргэншил үүссэн өлгий нутаг бөгөөд түүхийн ихэнх үед худалдааны замын зангилаа болж, суурин иргэншил, соёл, шашин (Хиндү, Будда, Сикх, Жэйн гэсэн дөрвөн) үүсэж хөгжжээ.

18 дугаар зууны эхээс 20 дугаар зууны дунд үе хүртэл Их Британийн колони улс байв. 1947 онд тусгаар тогтсоны дараа эдийн засаг, цэргийн хүчин маш хурдацтай хөгжиж, дэлхийн 5 дахь том эдийн засаг (2022 онд) бүхий орон болжээ.

Гэхдээ тэрбум илүү хүн амтайн хувьд ядуурал, бичиг үсэг тайлагдсан байдлын хувьд доогуур зэрэг сул талууд байсаар байгаа боловч 2014 оны нийтийн сонгуулиар засгийн эрхэнд гарсан Ерөнхий сайд Н.Моди-гийн Засгийн газар ядуурлыг бууруулах, боловсролын түвшинг дээшлүүлэх талаар олон үр бүтээлтэй хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь тус улсын хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байна.

БНЭУ нь Пакистан, Хятад, Балба, Бутан, Бангладеш, Мьянмар гэсэн зургаан улс оронтой газраар хиллэдэг, Энэтхэгийн далайгаар хүрээлэгдэн оршдог. Энэтхэгийн далайд Мальдив, Шри Ланка, Индонез гэсэн гурван улстай усаар хиллэдэг байна. (ГХЯ)

Нийслэл	Дели хот (1,521,000 сая хүн амтай)
Үндэсний баяр	БНЭУ-ын тусгаар тогтнолын өдөр - 08 дугаар сарын 15-ын өдөр
Хүн ам	Хүн амын тоо: 1,407,563,842 Хүн амын нягтрал: 473.42/км ² Эрэгтэй: 723.97 сая буюу нийт хүн амын 51.96% Эмэгтэй: 669.44 сая буюу нийт хүн амын 48.04% 100 эмэгтэй тутамд 108.15 эрэгтэй ногддог.
Газар нутгийн хэмжээ	3.3 сая км ²
Албан ёсны хэл	Хинди, англи хэл
Засаг захиргааны нэгж	БНЭУ нь 28 муж (states), 8 Холбооны нутаг дэвсгэртэй (union territories), мужууд дүүрэг, жижиг захиргааны нэгжид хуваагддаг.
Шашин	Хиндү - 1.3 тэрбум, Ислам - 311 сая, Христ - 37 сая, бусад - 46 сая (Үүнд: Будда, Сикх, Жэйн, Жүүд, уламжлалт шашныг шүтэгч болон шашингүй иргэд хамаардаг.)

<p>Улсын далбаа</p>	
<p>Төрийн сүлд</p>	 <p>Нийтийн тооллын өмнөх III зууны дунд үед эзэн хаан Ашока нь Будда Гаутама анх бурхны ном зааж байсан, буддын томоохон санг байгуулсан газрыг тэмдэглэхийн тулд Ашока баганыг босгожээ. Энэхүү баганын дөрвөн арсланг бие биедээ ойртсон бөгөөд титэмлэн “abacus” хавтан дээр зогсож байгаагаар дүрсэлсэн байдаг ба Энэтхэг Улсын төрийн сүлдэнд тэрхүү байдлаар нь оруулсан байна.</p> <p>Төрийн сүлдэнд ердөө гурван арслан харагдах бөгөөд дөрөв дэх арслан харагддаггүй. Дугуй нь “abacus” дээр үндэсний бэлгэ тэмдэг болох “chakras” буюу дугуй хүрдний хооронд морь, бухыг дүрсэлсэн байдаг (зураг дээр заан, арслан нь харагддаггүй). Төрийн сүлдний доод хэсэгт “Гагцхүү үнэн л ялна” гэж деванагари үсгээр бичсэн байна.</p> <p>Бэлгэдлийн хувьд арслангууд нь улс орныхоо энх тайван, шударга ёс, хүлээцтэй байдлын төлөө тууштай байхыг, бух нь хөдөлмөрч, тууштай байдлыг, морь нь үнэнч, хурд, эрч хүчийг илэрхийлдэг байна.</p> <p>Төрийн сүлдтэй холбоотой харилцааг Энэтхэг Улсын төрийн сүлдний тухай 2005 оны хуулиар⁹⁸ зохицуулдаг. Энэ хуулийн дагуу төрийн сүлдийг тус улсын Засгийн газар болон төрийн байгууллагууд ашиглах ба аливаа хувь хүн, хувийн байгууллага албан ёсны захидал харилцаанд ашиглахыг хориглодог байна.</p> <p style="text-align: right;"><i>Эх сурвалж: УИХ-ын Тамгын газрын ПССХ, 2022.</i></p>

Эх сурвалж: ГХЯ.

2.2.Улс төрийн тогтолцоо

<p>Сонгууль</p>	<p>Сонгуулийн пропорционал тогтолцоотой.</p> <p>Сонгуулийн төрлүүд: -Ерөнхийлөгчийн, -Дэд ерөнхийлөгчийн, -Парламентын доод танхим Лок Сабха-гийн, -Мужуудийн Хууль тогтоох ассамблейн.</p> <p>Ерөнхийлөгчийг БНТУ-ын Парламентын дээд, доод танхим, Муж, Дели ба Подучерри Холбооны нутаг дэвсгэрийн Хууль тогтоох ассамблейд сонгогдсон гишүүдээс бүрдсэн Сонгуулийн комисс санал хураалтаар 5 жилээр сонгоно.</p> <p>Парламентын доод танхим болох <i>Лок Сабха-гийн гишүүдийг</i> 5 жил тутам бүх нийтийн шууд санал хураалтаар сонгоно.</p> <p>Муж болон Холбооны нутаг дэвсгэрийн Хууль тогтоох ассамблейн гишүүдийг шууд санал хураалтаар тухайн муж, Холбооны нутаг дэвсгэрийн тойргийн санал өгөх иргэд 5 жилийн хугацаатай сонгоно.</p>
<p>Улс төрийн тогтолцоо</p>	<p>Олон намын тогтолцоотой Парламентын БНЭУ-ын одоогийн эрх баригч нам <i>Бхартия Жаната Парти</i> (Bharatiya Janata Party), (Энэтхэгийн Ардын Нам буюу Би Жа Па)</p>

⁹⁸ <https://legislative.gov.in/sites/default/files/A2005-50.pdf>

Ерөнхийлөгч	БНЭУ-ын 15 дахь Ерөнхийлөгч Хатагтай Дроупади Мурму (Droupadi Murmu, 1958.06.20-ны өдөр төрсөн) 2022.07.25-ны өдөр тангаргаа өргөсөн. Тэрээр БНЭУ-ын түүхэнд анх удаа омгийн гаралтай хоёр дахь эмэгтэй Ерөнхийлөгч болсон байна.
Парламент	Хоёр танхимтай: -Дээд танхим Ражья Сабха - 245 гишүүнтэй, -Доод танхим Лок Сабха – 543 гишүүнтэй. Парламентын буюу бүх нийтийн сонгууль 2019.04.11-нээс 05.19-ний өдрүүдэд 7 үе шаттай болж өнгөрсөн. Парламентын дараагийн сонгууль 2024 онд болно.
Дээд танхим Ражья Сабха-гийн дарга	Жагдийп Данкар (Jagdeep Dhankar, 1951.05.18-ны өдөр төрсөн) 2022.08.11-ний өдрөөс бүрэн эрхээ хэрэгжүүлж байна. Ражья Сабха-гийн дарга нь БНЭУ-ын Дэд ерөнхийлөгчөөр ажилладаг. Ражья Сабха-гийн даргын алба нь орон тооны бус, тус танхимын хуралдааныг даргалдаг ажээ.
Доод танхим Лок Сабха-гийн спикер	Ом Бирла (Om Birla, 1962.11.23-ны өдөр төрсөн) нь Би Жа Па намын гишүүн бөгөөд 2019.07.19-ний өдрөөс бүрэн эрхээ хэрэгжүүлж байна.
Ерөнхий сайд	БНЭУ-ын 14 дэх Ерөнхий сайд Нарендра Моду (Narendra Modi, 1950.09.17-ны өдөр төрсөн) нь Ерөнхий сайдаар анх 2014.05.26-ны өдөр томилогдсон байна. 2019 оны 5 дугаар сард болсон бүх нийтийн ээлжит сонгуульд ялалт байгуулж, ийнхүү хоёр дахь удаагаа Ерөнхий сайдаар томилогдон ажиллаж байна.
Гадаад хэргийн сайд	Др. Субрахманьям Жайшанкар (Subrahmanyam Jaishankar, 1955.01.05-ны өдөр төрсөн) нь 2019.05.30-ны өдрөөс БНЭУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байна. Мөн тэрээр Парламентын дээд танхим Ражья Сабха-гийн гишүүн юм.
Эрх баригч нам	Бхартия Жаната Парти (Bharatiya Janata Party) Парламентын Доод танхим Лок Сабха-д 303 суудалтай (55.90%) ажээ. Намын дарга ар тус улсын Ерөнхий сайд Нарендра Моду ажиллаж байна.
Сөрөг хүчний нам	Сөрөг хүчин одоогоор байхгүй (10 хүртэлх хувийн суудалтай сөрөг хүчин байхгүй).

Эх сурвалж: ГХЯ.

2.3.Эдийн засгийн үзүүлэлт

ДНБ	2022 онд тус улсын ДНБ 7.7 хувиар өссөн. 2022 онд 1 хүнд ногдох ДНБ 11,7 их наяд ам.доллар. (БНЭУ 1 хүнд ногдох ДНБ-ээр 2022 оны дэлхийн эдийн засгийн 7.2 хувийг бүрдүүлжээ.)
Эдийн засгийн өсөлт	2022-2023 оны санхүүгийн жилийн ДНБ-ийн өсөлт 7.2 хувь, 2022 оны 09-12 дугаар сард эдийн засаг 4.4 хувиар өсөв.
Ажилгүйдэл	Ажилгүйдлийн түвшин - 8.3% (2022 он)
Худалдаа	Экспорт: 2022 онд санхүүгийн жилд тус улсын экспорт 13.84 хувиар өсч, 770.18 тэрбум ам.долларт хүрэв. Экспортын гол бүтээгдэхүүн: -нефтийн бүтээгдэхүүн (52.71%), -цахилгаан бараа (41.46%), -бүх төрлийн бэлэн хувцас (22.94%).

	<p>Импорт: 2020-2021 онд - 613.05 тэрбум ам.долларт, 2022 онд - 714.24 тэрбум ам.долларт хүрсэн байна.</p> <p>Импортын гол бүтээгдэхүүн: -боловсруулаагүй түүхий газрын тос (93.5 тэрбум ам.доллар), -алт (54.4 тэрбум ам.доллар), -шахмал нүүрс (28.4 тэрбум ам.доллар), -алмаз эрдэнэ (26 тэрбум ам.доллар), -байгалийн хий (21.9 тэрбум ам.доллар).</p> <p>Импортыг голлогч улс орон: -БНХАУ (94.1 тэрбум ам.доллар), -Арабын Нэгдсэн Эмират Улс (42 тэрбум ам.доллар), -АНУ (39.1 тэрбум ам.доллар), -Швейцар (31.8 тэрбум ам.доллар), -Сауди Араб (25.6 тэрбум ам.доллар).</p>
Инфляцын түвшин	2023 оны 05 дугаар сарын байдлаар БНЭУ-ын инфляцын жилийн дундаж түвшин 4.5 хувь болж буурсан.
Байгалийн баялаг	Баялгийн гол нөөцөд нүүрс (нүүрсний нөөцөөр дэлхийд 4 дүгээр байранд жагсдаг), төмрийн хүдэр болон марганцын хүдэр (2013 оны байдлаар дэлхийд 7 дахь том нөөцтэй байв), литийн давсны хүдэр (2023 оны байдлаар дэлхийд 6 дахь том нөөцтэй байв), гялтгануур болон хөнгөн цагааны хүдэр (2013 оны байдлаар дэлхийд 5 дахь том нөөцтэй байв), хромит, байгалийн хий, алмаз эрдэнэ, шохойн чулуу зэрэг ордог болно.
Эдийн засгийн гол салбарууд	<p>Энэтхэгийн эдийн засгийн голлох салбарууд: -хөдөө аж ахуй (Энэтхэгийн эдийн засгийн хамгийн гол чухал салбар ба ДНБ-ий 14 хувийг бүрдүүлдэг), -аж үйлдвэр, -үйлчилгээний салбар, -хүнс боловсруулах салбар, -боловсруулах аж үйлдвэрийн салбар.</p>

Эх сурвалж: ГХЯ.

3.БНЭУ-ЫН ПАРЛАМЕНТЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

БНЭУ-ын Парламент нь хоёр танхимтай: дээд танхимыг Ражья Сабха (Rajya Sabha), доод танхимыг Лок Сабха (Lok Sabha) гэж нэрлэдэг.

3.1.Парламентын дээд танхим - Ражья Сабха

Ражья Сабха нь 6 жилийн хугацаатай сонгогддог 250-аас илүүгүй гишүүнтэй, тэдний 238 гишүүн нь БНЭУ-ын муж болон гурван холбооны нутаг дэвсгэрийг төлөөлж, 12 гишүүнийг тус улсын Ерөнхийлөгч томилдог. Ражья Сабха нь байнгын ажиллагаатай парламент бөгөөд хугацаанаас нь өмнө тараадаггүй боловч нийт гишүүдийн 1/3 нь хоёр жил тутам шинээр сонгогдсон гишүүдээр солигддог аж.

Одоогийн Ражья Сабха нь 245 гишүүнтэй, тэдний 233 нь муж болон Дели, Подучерри, Жамму Кашмирийн Холбооны нутаг дэвсгэрийн тойргоос сонгогдсон бол 12 гишүүнийг БНЭУ-ын Ерөнхийлөгч нь томилжээ. Ерөнхийлөгчийн томилсон дээд танхимын гишүүд нь уран зохиол, шинжлэх ухаан, урлаг, нийгмийн үйлчилгээний салбарын мэргэшсэн буюу тодорхой туршлагатай иргэдээс бүрддэг.

БНЭУ-ын Дэд ерөнхийлөгч нь Парламентын дээд танхим Ражья Сабха-гийн орон тооны бус даргаар ажилладаг. Дээд танхим нь мөн Дэд даргатай ба түүнийг Ражья Сабха-гийн гишүүдийн саналаар сонгоно. Ражья Сабха дахь олонхийн бүлгийн даргыг БНЭУ-ын Ерөнхий сайд томилно.

Ражья Сабха-гийн удирдлагын бүтэц:

- 1) дарга – Эдүгээгийн БНЭУ-ын Дэд ерөнхийлөгч Жагдийп Данхар;
- 2) дэд дарга – Хариванш;
- 3) олонхын бүлгийн дарга – Пиюүш Гоял;
- 4) сөрөг хүчний дарга – Маликаржун Карге, Энэтхэгийн Үндэсний Конгресс намын Ерөнхийлөгч;
- 5) Ражья Сабха-гийн дэд дарга нар – нийт 9 гишүүн;
- 6) ерөнхий нарийн бичгийн дарга – П.С.Моди.

Ражья Сабха-гийн хороод:

- 1) Байнгын 12 хороотой. Үүнд: Бизнесийн зөвлөх, ёс зүйн, өргөдөл гомдол, мэдээлэл, харилцааны технологийн удирдлагын, дүрмийн, онцгой эрхийн зэрэг хороо орно.
- 2) Салбар дундын 8 байнгын хороотой. Үүнд: Боловсрол, эмэгтэйчүүд, хүүхэд залуучуудын байнгын хороо, эрүүл мэнд, гэр бүлийн сайн сайхны байнгын хороо, хүний нөөцийн байнгын хороо, гомдлын байнгын хороо, худалдааны байнгын хороо, аж үйлдвэрийн байнгын хороо, тээвэр, аялал жуулчлал ба соёлын байнгын хороо зэрэг хороо орно.
- 3) Тусгай 14 хороотой. Үүнд: төлбөр болон төлбөр барагдуулах системийн тусгай хороо, нүүрсний уурхайн, даатгалын тухай хуулийн, автомашины тухай, Үндсэн хуулийн тусгай хороо зэрэг хороо орно.
- 4) Дээрхээс гадна 17 хамтарсан хороо, 10 онцгой хороо үйл ажиллагаа явуулж байна.

3.2. Парламентын доод танхим - Лок Сабха

БНЭУ-ын Парламентын доод танхим буюу Лок Сабха нь нийтийн санал хураалтаар ард түмнээс шууд сонгогдсон гишүүдээс бүрддэг. БНЭУ-ын Үндсэн хуулийн дагуу Лок Сабха нь 550 хүртэлх гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 530 гишүүн нь тус улсын мужуудыг, 20 төлөөлөгч нь Холбооны нутаг дэвсгэрийг тус тус төлөөлдөг.

Одоогийн Лок Сабха нь 543 гишүүнтэй. Хамгийн олон гишүүнтэй муж нь Уттар Прадеш, нийт 79 гишүүнтэй байна.

Лок Сабха-гийн бүрэн эрхийн хугацаа Парламентын анхдугаар хуралдаан болсон өдрөөс эхлэн 5 жилийн хугацаатай байна. Хэрвээ улсын хэмжээнд онц байдал зарласан тохиолдолд холбогдох хуулийн дагуу нэг удаа нэг жилээс хэтрэхгүй хугацаагаар Парламентын бүрэн эрхийн хугацааг сунгаж болдог. **Доод танхим Лок Сабха-гийн дарга:** Парламентын гишүүд нь тус бүрийн тойргийг төлөөлдөг бол Спикер нь Парламентын танхимыг бүхэлд нь төлөөлдөг. Спикерийн үйл ажиллагаа, үйл хөдлөл зөвхөн танхим доторх хяналтад байдаггүй, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн мэдээлэгддэг. Парламентын чуулганыг телевизээр шууд орон даяар нэвтрүүлдэг учир олон сая иргэд Парламентын үйл ажиллагааг шууд хянаж, үнэлэх боломжтой тул Спикерийн ажлын хариуцлагыг улам өндөржүүлдэг. Спикер нь чуулганаар үг бараг хэлэхгүй, үг хэлбэл Парламентын танхимын өмнөөс үг хэлэх учир хариуцлага өндөртэй байдаг.

Спикер нь сонгогдсон өдрөөс эхлэн дараагийн шинээр сонгогдсон Доод танхим Лок Сабха-гийн анхдугаар чуулган хуралдах хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлдэг. Лок Сабха-г тараахад Спикер нь Парламентын доод танхимын гишүүнээс чөлөөлөгддөг ч бүрэн эрх нь хэвээр байна.

Лок Сабха-гийн дарга 1949 онд байгуулагдсан Энэтхэгийн Парламентын бүлгийн орон тооны бус Ерөнхийлөгчийн албан үүргийг хавсран гүйцэтгэдэг байна. Энэ бүлэг нь Парламент хоорондын холбооны Үндэсний бүлэг болон Хамтын нөхөрлөлийн парламентын холбооны Төв салбарын үүргийг гүйцэтгэнэ. Иймд Энэтхэгийн Парламентын төлөөлөгчид гадаадад айлчлахад төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох гишүүдийг дээд танхим Ражья Сабха-гийн даргатай зөвлөлдсөний үндсэн дээр томилдог журамтай. Ихэнх тохиолдолд Лок Сабха-гийн дарга өөрөө эдгээр төлөөлөгчдийг тэргүүлж гадаадад айлчилдаг. (ГХЯ)

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын Гадаад харилцааны яамны БНЭУ-ын талаарх танилцуулга.
- Р.В.Александрович. Улс төрийн харилцааны соёл иргэншлийн асуудал. Евроазийн бүс нутаг дахь Монгол, Оросын соёл иргэншлийн харилцан үйлчлэл (Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт /2019-2022/ хэрэгжүүлсэн “Евроазийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл” сэдэвт гадаадтай хамтарсан төслийн судалгааны үр дүн). УБ., 2023 он. 224-232 дахь тал.
- Монгол, БНЭУ дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой тохиож байна. МОНЦАМЭ. <https://www.montsame.mn/mn/read/247835>
- Энэтхэг Улс нэг тэрбум долларын хөнгөлөлттэй зээл олгоно. Нийтэлсэн 2015.05.17. <https://itoim.mn>

**БОДЛОГЫН НАМЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ
УЛС ТӨРИЙН НАМЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР**

Д.Халиун, Э.Дашзэвэ, П.Уранчимэг

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НЭГ. УЛС ТӨРИЙН НАМЫН ТАЛААРХ ДЭЛХИЙ ДАХИНЫ ЧИГ ХАНДЛАГА БА МОНГОЛ
УЛС ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШИЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ХОЁР. БОДЛОГЫН НАМ: ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АГУУЛГА

ГУРАВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УЛС ТӨРИЙН НАМЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР

3.1. ГЕРМАН УЛСЫН НАМУУДЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР

3.1.1 Германы Социал Демократ Нам

3.1.2 Германы Христосын ардчилсан холбоо нам

3.2.АВСТРИ УЛСЫН НАМУУДЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР

3.2.1 Австрийн Социал Демократ нам

3.2.2.Австрийн Ардын намын үндсэн хөтөлбөр

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

УДИРТГАЛ

“Бодлогын намыг төлөвшүүлэх нь: Гадаадын зарим орны улс төрийн намын үндсэн хөтөлбөр” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Улс төрийн нам, түүний тодорхойлолт, ойлголт, агуулга, төлөвшил, бодлогын нам байх шалгуур, арга зүй, гадаадын зарим орны улс төрийн намын үндсэн хөтөлбөрийн талаарх туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу ХБНГУ (Герман), Австри зэрэг орнуудын зүүн төвийн болон баруун төвийн үзэл баримтлалтай намуудыг хамруулж, эдгээр намуудын үнэт зүйл, үзэл баримтлал, бодлого, зорилтууд зэргийн ялгааг тэдгээрийн үндсэн хөтөлбөр (тунхаг)-ийн хүрээнд харьцуулан судалсан болно. Судалгаанд Олон улсын IDEA болон ACE зэрэг байгууллагаас гаргасан судалгаа, дүн шинжилгээний тайлан болон улс төрийн шинжлэх ухааны холбогдох ном, товхимол, судалгаа, шинжилгээний материалууд, холбогдох бусад мэдээллийн эх сурвалжуудыг ашиглав.

Судалгааны бүтэц: Судалгаа нь хураангуй болон үндсэн 3 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, улс төрийн намын талаарх дэлхий дахины чиг хандлага ба Монгол улс дахь улс төрийн намын төлөвшил, өнөөгийн байдлын талаар, хоёрдугаар хэсэгт, бодлогын намын ойлголт, тодорхойлолт, агуулгын талаар, гуравдугаар хэсэгт, захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ХБНГУ (Герман), Австри зэрэг орны зүүн төвийн болон баруун төвийн үзэл баримтлалтай намууд, тэдгээрийн үндсэн хөтөлбөрийн талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: Улс төрийн нам, бодлогын нам, улс төрийн намын үнэт зүйлс, үзэл суртал, үзэл баримтлал, намын үндсэн хөтөлбөр (тунхаг)

Key words: Political Party, Programmatical Political Parties, Core values of political parties, Political Ideology, Political concepts, Political parties programme (Manifesto)

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Улс төрийн намыг тодорхойлж буй нийтлэг чиг хандлагуудын үүднээс авч үзвэл улс төрийн нам нь үзэл санаа нэг хүмүүсийн сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, засгийн эрхийн төлөөх, мэргэшсэн улс төрчдийн байгууллага бөгөөд улс орны хэтийн бодлого, чиглэлийг тодорхойлогч улс төрийн институт болдог байна.

Улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн намыг янз бүрийн хүчин зүйл, харгалзах талуудаас нь судалж шинжилсэн төрөл бүрийн үзэл онол, хандлагууд байдаг. Энэ хүрээнд тэдгээрийг олон талт шалгуур, үзүүлэлтээр нь олон янз байдлаар ангилсан байдаг.

Улс төрийн намын, нэг талаас тухайн нам үүсэн бүрэлдэх, нөгөө талаас улс төрийн талбар дах өрсөлдөгч бусад намуудаас ялгарах үндсэн арга зам нь түүний үзэл суртал, үзэл баримтлал юм. Намын үзэл суртал, үзэл баримтал гэдэг ойлголтууд нь харилцан хамаарах боловч басхүү ялгаатай ажээ. Үзэл суртал нь илүү өргөн хүрээний, харьцангуй өндөр түвшинд системчлэгдсэн байдаг ойлголт байна.

21-р зууны эхэн үе буюу өнөөгийн улс төрийн намуудын үзэл баримтлалд интеграц хүчтэй явагдаж, нийгмийн хөгжлийн тулгамдаж буй асуудалд намын бодлогыг түлхүү чиглүүлэх хандлага ажиглагдаж байна. Гэвч үзэл суртал, үзэл баримтлалгүйгээр орчин үеийн улс төрийн нам оршин тогтнох боломжгүй тул намуудад үзэл баримтлалаа илүү ялгаатай

байдлаар танин мэдүүлэх, илэрхийлэх чиглэлээр онол болон практикийн томоохон сорилттой тулгарч байгаа гэж үздэг.

Монгол Улсад 2019 онд Конрад Аденаурын сангаас намуудын рейтинг, танигдсан байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс болон иргэдийн сонголтод улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөр хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилгоор судалгаа хийгдсэн байдаг. Тус судалгаанаас харахад иргэдийн улс төрийн намд итгэх итгэл маш их суларч, мөн олон намын тогтолцооны талаарх байр суурь, намуудаас хүлээх хүлээлт асар их унасан үзүүлэлттэй гарсан байна.

Иймд ардчилал, олон ургальч байдал, олон намын тогтолцоог бэхжүүлэхийн тулд улс төрийн намуудыг төлөвшүүлэх, тэдгээрт итгэх ард иргэдийн итгэл, хүлээлтийг дээшлүүлэх шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуульд орсон “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах” бодлогын намыг төлөвшүүлэх, цаашид бодлогын намын тогтолцоо бүрдүүлэх тухай асуудал бидний өмнө тулгамдаад байна. Орчин үед бодлогын нам (programmatic political parties) гэдгийг улс төрийн үзэл суртлын тогтвортой чиг баримжаанд суурилсан сайн бүтэц, зохион байгуулалттай байх агуулгаар тодорхойлж байна.

Бодлогын намыг тодорхойлохдоо гишүүд, дэмжигчидтэйгээ хэрхэн уялдаж ажиллаж байгаа, бусад улс төрийн намтай сонгуульд хэрхэн өрсөлдөж байгаа болон бодлого боловсруулах үйл явцад хэрхэн оролцож байгаа зэргээр үнэлж дүгнэдэг. Бодлогын нам нь үйлчлүүлэгчид шүтсэн (клиентелист) намаас хэд хэдэн давуу талтай байдаг. Улс төрийн нам болон иргэд, сонгогчдын хоорондын холбоог тодорхойлох механизм нь намын бодлого, хөтөлбөр тул нийгмийн хэрэгцээнд тулгуурласан, улс орны хөгжлийн алсын хараа, бодлогод нийцсэн бодит, хэрэгжихүйц байх нөхцөлийг шаарддаг онцлогтой байна.

Улс төрийн намууд урт хугацаанд тогтвортой үзэл баримтлалтай байхын тулд Үндсэн хөтөлбөр хэмээх бодлогын баримт бичиг боловсруулж баталдаг байна. Тэдгээр нь үндсэн хөтөлбөр, тунхаг, зарчмууд, үндсэн чиглэл гэх зэрэг янз бүрийн нэршилтэй байдаг боловч агуулгын хувьд тулгуур үнэт зүйл, зарчим, үзэл баримтлал, үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх үндсэн бодлого, зорилтуудаа тусгасан байдаг. Намын үндсэн хөтөлбөр нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс ялгагдах онцлогтой бөгөөд илүү урт хугацааны, суурь шинжтэй байдаг.

Герман, Австри Улсын баруун болон зүүн төвийн намын бодлогын бичиг баримтуудаас тэдгээрийн үзэл суртал, үзэл баримтлалын ялгаа зааг нарийн тодорхой харагдаж байна. Тухайлбал: Германы Социал Демократ нам (ГСДН) “чөлөөт аж ахуйн элементүүдийг нийгмийн зохицуулалттай хослуулсан нийгэм-зах зээлийн холимог эдийн засгийг дэмждэг бөгөөд эдийн засгийн өсөлт, инновац, тогтвортой хөгжлийн үр өгөөжийг нийгэм даяар түгээх, хүртээх зорилготой” бол Германы Христосын Ардчилсан Холбоо нам (ГХАХН) чөлөөт зах зээлийн эдийн засгийг тууштай дэмждэг бөгөөд нийгмийн баримжаатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж болох боловч тэдгээрийг хэрэгжүүлэх хүч, нөөц, чадавхыг бүрдүүлэхийн тулд хүчирхэг зах зээлийн эдийн засаг зайлшгүй гэж үздэг байна.

НЭГ. УЛС ТӨРИЙН НАМЫН ТАЛААРХ ДЭЛХИЙ ДАХИНЫ ЧИГ ХАНДЛАГА БА МОНГОЛ УЛС ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШИЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Судлаачдын дунд улс төрийн намыг тодорхойлж буй дараах хэд хэдэн нийтлэг хандлагууд байна.⁹⁹ Үүнд:

- үзэл санаа нэгтнүүд чөлөөтэй эвлэлдэн нэгдсэн нийгмийн чөлөөт, сайн дурын бүлэг, холбоо;
- төр, засаглалын харилцааны гол оролцогч, засгийн эрхийн төлөөх байгууллага;
- мэргэжлийн болон мэргэшсэн улс төрчдийн байгууллага;
- нам бол улс орны улс төр-эдийн засгийн бодлого тодорхойлох үүрэг хүлээгч улс төрийн институт.

Улс төрийн намын чиг баримжаа болон үзэл суртлын хувьд гарч буй сорилтууд:

Нам бий болох үндсэн шалтгаан болоод өөр хоорондоо ялгарах үндсэн арга зам нь намын үзэл суртал юм. Улс төрийн үзэл суртал нь нэг талаас хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах үзэл санаа, үзэл баримтлалуудын нийлбэр цогц, нөгөө талаас улс төрийн засаглалын хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны шинжийг хангах үнэт зүйлсийн илэрхийлэл гэж үздэг. Эндээс улс төрийн үзэл баримтлал, үзэл суртал нь хоорондоо хамаарах ойлголтууд боловч ялгагдах онцлогтой юм. Тодорхой хэсэг бүлгийн үзэл санаа, үзэл баримтлалуудын нийлбэр нь үзэл суртлыг бий болгох бөгөөд үзэл суртал нь харьцангуй өндөр түвшинд системчлэгдэн боловсруулагдсан байдгаараа онцлогтой.

21-р зууны эхэн үеэс буюу өнөөгийн улс төрийн намуудын үзэл баримтлалд интеграц явагдаж, нийгмийн хөгжлийн тулгамдаж буй асуудалд бодлогыг чиглүүлэх хандлага ажиглагдаж байна. Дестют де Траси үзэхдээ ямар ч тохиолдолд улс төрийн нам байгаа цагт улс төрийн үзэл суртал оршино гэсэн санааг дэвшүүлсэн бөгөөд “нийгэм, улс төрийн бүлэг, улс төрийн нам, хувь хүний үйл ажиллагаандаа баримтлах үнэт зүйл, зарчмуудын цогцыг үзэл суртал гэж үзсэн. Тиймээс орчин үеийн улс төрийн нам үзэл баримтлалгүйгээр оршин байх боломжгүй бөгөөд цаашлаад намын системийн хэв маяг, ялгаа онцлогийг тодорхойлох боломжгүй болох юм. Эцэстээ энэ үзэгдэл даамжирвал улс төрийн намын нийгмийн төлөөллийг хангах суурь зарчим алдагдаж, нийгэмд олон ургальч үзэл санааны өрсөлдөөний механизмгүй болоход хүрэх тул намуудад үзэл баримтлалаа илүү ялгаатай байдлаар танин мэдүүлэх, илэрхийлэх онол болон практикийн томоохон сорилттой тулгарч байгааг харуулж байна.

Нам нь улс төрийн бодлого тодорхойлогч, тодорхой үүрэг хүлээдэг улс төрийн институтын хувьд:

Улс төрийн намын нийгэмд хүлээх үүрэг нь түүний мөн чанар, зорилгоор илэрч, нам судлалын онол болон практикийн уялдаа холбоог хангах чухал үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн нам байх шалгуур үзүүлэлт болон түүний гадаад, дотоод үүргийн үр дүнгээр дамжуулан нийгмийн өмнө хүлээх хариуцлага тодорхойлогдоно гэсэн үг. Дээрх хэсгүүдэд гарсан намын өмнө тулгамдаж буй асуудлыг нэгтгэн үзвэл орчин үеийн улс төрийн намын үүргүүдийг хөндсөн байгааг ажиглаж болно. Тоймлон үзвэл:

- Нийгмийн бүлэг, төлөөллийн эрх ашиг, сонирхлыг илэрхийлж, дамжуулж, нэгтгэх;
- Тодорхой үнэт зүйлс, үзэл баримтлалд тулгуурласан улс төрийн үзэл сурталтай байж, түүндээ нийцэхүйц улс төр-эдийн засгийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Улс төр-эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлэх хүний нөөцийн бүрэлдэхүүнтэй, нийгмийн элит лидерүүдийг шилж, сонгох, нөхөн сэлгэх ардчилсан механизмтай байх;

⁹⁹ Я.Төгөлдөр, Намууд мөхөх үү? Намуудад тулгарч буй сорилт, Нээлттэй улс төр, №2/2020 KAS

- Чадварлаг хүний нөөцөөр дамжуулан иргэдийн улс төрийн мэдлэг, оролцоог дээшлүүлж, улс төрийн соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх үүргүүд юм.

Нийгмийн харилцаанд оролцож байгаа тодорхой эрхтэй хувь хүн, бүлэг, хуулийн этгээд бүр үүрэг хүлээж, түүнийхээ төлөө хариуцлага үүрч, хохирлыг барагдуулах ёстой байдаг. Хариуцлага нь хамрах хүрээ, шинж чанар, үйлчлэх орчноосоо хамаарч янз бүр байх боловч аливаа хүн, этгээд өөрийн эрх, үүрэгт хамаарч байгаа үйл ажиллагааныхаа үр дүн, үр дагаврыг бүрэн хариуцах гэсэн утга санаа илэрхийлэгддэг. Хариуцлага хүлээнэ гэдэг нь үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас үүдэх эерэг, сөрөг үр дагавраар тодорхойлогдоно. Иймд улс төрийн намын хариуцлага нь нэг талаас нийгмийн гишүүдийн намд өгсөн үнэлгээ буюу сонгуулийн санал өгөх үйл явцаар илэрнэ, нөгөө талаас улс төрийн намын гишүүдийн өөрсдийнх нь ёс зүйн үйлдлээр илэрхийлэгдэх боломжтойг судлаачид онцлон үзэж байна.

Улс төрийн намуудын ангилал

Судлаач Питер Мейр, Ричард Катз нар улс төрийн намуудын гишүүнчлэлийн бодлогод тулгуурлан улс төрийн намын зохион байгуулалтын сонгодог 4 загварыг тодорхойлсон байна. Үүнд, массын буюу олон түмний, элитийн буюу боловсон хүчний, catch-all буюу бүхнийг баригч, картель буюу хоршсон нам гэж ангилсан байна.

Улс төрийн намын зохион байгуулалтын хэв маяг гишүүнчлэлийн бодлогод нөлөөлдөг болохыг доорх хүснэгтээс харж болно. Намын гишүүдийн оролцооны түвшин нь улс орны түүх, соёл, нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөлөөс түлхүү хамаардаг байна.¹⁰⁰

Хүснэгт 1. Улс төрийн намын зохион байгуулалтын сонгодог хэв маяг

	Элитийн нам /Causus party/	Массын нам /Mass party/	Бүхнийг баригч нам /Catch-all party/	Хоршсон нам /Cartel party/
Гарал үүсэл	19-р зуунд	1880-1960	1945 он	1970-аад он
Уг гарал	Элит давхарга	Аж үйлдвэрийн хувьсгалын үр дүнд шинээр төрөн гарсан ажилчин анги	Элитийн болон массын намуудаас үүссэн (Холимог)	Гишүүнчлэл буурч, намуудыг төрөөс санхүүжүүлдэг болсон, сонгуулийн кампанит ажилд телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглагдах болсон.
Тулгуурладаг зүйл	Лидерийн уламжлалт статус	Нийгмийн бүлгүүдийг төлөөлдөг	Засаглах чадвар	Оршин буй намуудын хоорондын өрсөлдөөн суларсан.
Гишүүнчлэл	Цөөхөн элитүүд	Гишүүдээ тоолж, батламж олгодог.	Гишүүнчлэл хүссэн хүн бүрт нээлттэй, гишүүдэд хатуу үүрэг хүлээлгэдэггүй.	Намын гишүүн ба гишүүн бус хүмүүсийн хоорондын ялгаа багасч, гишүүдийн эрх, үүрэг байхгүй болсон.
Коммуникацийн суваг	Хүмүүс хоорондын харилцаа	Нам өөрийн коммуникацийн сувагтай.	Нам бус суваг ашигладаг.	Төрийн дэмжлэг бүхий мэдээллийн суваг ашигладаг.
Жишээ	19-р зууны либерал намууд	Социалист намууд	АНУ-ын намууд	ХБНГУ, Австри, Скандинавын орнуудын намууд

Эх сурвалж: Democracy and the cartelization of political parties, Richard S. Katz, Peter Mair

Улс төрийн намын ангилал:

- Үйл ажиллагааны арга барилаар нь прагматик болон номлогч;
- Улс төрийн тогтолцоонд эзлэх байр сууриар нь эрх баригч болон сөрөг;

¹⁰⁰ Э.Гэрэлт-Од, Монголын улс төрийн намын дотоод ардчилал: шийдвэр гаргах түвшин дэх гишүүдийн оролцоо, Шинэ толь №62, 2008 <https://academy.edu.mn/content/511556-2/>

- Улс төрийн үйл ажиллагааны шинжээр нь радикал (эрс шинэчлэгч), экстремист (хэт хувьсгалч) гэх зэргээр ангилдаг.
- Зохион байгуулалтын зарчмаар нь боловсон хүчний болон олон түмний нам гэж ангилсан байна.

Намын тогтолцоог ангилахдаа дараах гурван шалгуурыг үндэс болгодог байна. Үүнд:

- улс төрийн намуудын тоо;
- зонхилгоч улс төрийн нам юм уу эвсэл байгаа, эсэх;
- улс төрийн намуудын хоорондын өрсөлдөөний түвшин хэр байгаа гэсэн гурван шалгуур ордог.

Улс төрийн шинжлэх ухаанд дээрх шалгуурыг баримтлан намын тогтолцоог дараах байдлаар ангилдаг байна:

- нэг намт;
- хоёр намт;
- олон намт тогтолцоо.

Хүснэгт 2. Бусад ангилал

	Гол шалгуур	Тодорхойлсон намын тогтолцооны ангилал
М.Дюверже (1954)	Намуудын тоо	Хоёр намын тогтолцоо Олон намын тогтолцоо
Р.Даль (1966)	Сөрөг хүчний өрсөлдөх чадвар	Чанд өрсөлдөгч Хамтран ажиллан өрсөлдөгч Нэгдэн өрсөлдөгч Чанд нэгдэгч
Ж.Блондель (1968)	Намуудын тоо Улс төрийн намын хэмжээ	Хоёр намын тогтолцоо Хоёр хагас намын тогтолцоо Нэг нам зонхилсон олон намын тогтолцоо Зонхилсон намгүй олон намын тогтолцоо
С.Роккан (1968)	Намуудын тоо Нэг нам дангаараа олонх болох Цөөнхийн хүч	Британи-Германы “1 vs 1+1” тогтолцоо Скандинавын “1 vs 3-4” тогтолцоо Тэгш тооны олон намын “1 vs 1 vs 1+2-3” тогтолцоо
Ж.Сартори (1976)	Намуудын тоо Үзэл суртлын алслалт	Хоёр намын тогтолцоо Аядуу плюраль тогтолцоо Туйлширсан плюраль тогтолцоо Ноёлох намуудын тогтолцоо

Баруун европ, Хойд америкийн улс төрийн томоохон намуудыг зохион байгуулалтын бүтцийн хувьд шууд харьцуулах боломжгүй юм. Жишээлбэл, Европоос гаралтай улс төрийн намууд гишүүнчлэл, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэв маяг, дотоод дүрэм журмыг чанд сахих, төвлөрсөн зохион байгуулалтад үргэлж онцгой анхаарал хандуулдаг. Нөгөөтэйгүүр, Америкийн улс төрийн нам нь зохион байгуулалтын төвлөрсөн бус бүтэцтэй, чөлөөт гишүүнчлэлтэй, дотоод үйл ажиллагааны зарчим нь олон хэв шинжтэй байна.

Засгийн эрх барьж буй нам нь өөрийн төлөөлөгчдөө төрийн өндөр албан тушаалд тавьдаг жишиг тогтоод хагас зуун жил болж байна. Энэ бол орчин үеийн “Catch-all party” буюу бүхнийг баригч намын онцгой шинж юм.¹⁰¹

Хүснэгт 3. Намын гишүүнчлэлийн хэлбэр

	Хатуу гишүүнчлэл	Сул гишүүнчлэл
Гишүүн элсүүлэх шалгуур	Үндсэн хууль ба бусад хууль, намын дүрэмд заасан зохих шалгуурыг баримтална.	Үндсэн хуульд заасан хүний эрхийг суурь зарчим болгоно.
Гишүүний татвар	Дүрмээр заасан татварыг зайлшгүй төлөх үүрэгтэй.	Намын жирийн гишүүн сайн дураараа төлөх эрхтэй.


¹⁰¹ Э.Гэрэлт-Од, Монголын ардчилал ба улс төрийн намууд, 2006 <https://forum.mn/product/152127>

Гишүүний хариуцлага	Дүрмийн хүрээнд гишүүдэд өндөр хариуцлага ногдуулна. Шаардлагатай гэж үзвэл намаас хөөнө.	Дүрмийн хүрээнд гишүүдэд өндөр хариуцлага ногдуулна.
Шийдвэр гаргах түвшин дэх гишүүний оролцоо	Намын бүх шатны байгууллагын удирдлагууд дангаар шийдвэр гаргана.	Шийдвэр гаргах түвшин дэх гишүүдийн оролцоо нээлттэй.

Сүүлийн 100 жилд хөгжингүй орнуудад намуудын мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалын эрс ялгаа улам багсаж, үзэл санааны хувьд хоорондоо ойртох, ижилсэх чиг хандлагатай болж байгаа хэмээн улс төр судлаачид үзсээр байна. Тиймээс орчин үед улс төрийн үзэл баримтлалыг баруун, зүүн гэж хуваах нь улс төрийн нам, хөдөлгөөний бодит зураглалыг хангалттай илэрхийлж чадахгүй хэмээх болжээ.

Үүнтэй холбоотойгоор эдийн засгийн салбарт барууны үзлийг илүүд үзсэн, улс төр, хүний эрхийн хувьд зүүний үзэлтэй хүмүүс олшрох болжээ. Тиймээс намууд өөрсдийн үзэл баримтлалд хатуу зогсохоос илүүтэй нийгмийн хөгжлийн тулгамдаж буй асуудалд бодлогоо чиглүүлэх хандлага ажиглагдаж байна. Шинжлэх ухаан, техник технологи хөгжихийн хэрээр хатуу үзэл суртал гэхээс илүүтэйгээр орчин цагийн шаардлагад нийцсэн уян хатан, олон асуудлыг шийдэх тайлал болсон чиг хандлага түгэх болсоор байна.

Зураг 1. Улс төрийн намуудын шинэ ангилал¹⁰²



Монгол Улс дахь улс төрийн намын төлөвшил, өнөөгийн байдал

2019 онд Конрад Аденаурын сангаас намуудын рейтинг, танигдсан байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс болон иргэдийн сонголтод улс төрийн намуудын бодлого, үйл

¹⁰² Gunther, R., & Diamond, L. (2003). Species of Political Parties: A New Typology. Party Politics, 9(2), 167–199. <https://doi.org/10.1177/13540688030092003>

ажиллагаа, мөрийн хөтөлбөр хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилгоор хийгдсэн “Улс төрийн намуудын төлөвшил, өнөөгийн нөхцөл байдал”¹⁰³ судалгааны тайлангийн үр дүнг хураангуйлан дурдвал:

- Иргэдийн хувьд төрийн эрх барьж байсан МАН, АН, МАХН-ын талаар мэдээлэл сайтай боловч бусад улс төрийн хүчин, нам эвслүүдийн талаар мэдээлэл хангалтгүй байна. 2023 оны байдлаар Монгол Улсын Дээд шүүхэд 37 улс төрийн нам бүртгэлтэй байна.¹⁰⁴ Иргэд сонгуулиар дамжуулан сонгож баталгаажуулсан улс төрийн үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид болох УИХ дах намын төлөөллийг иргэдийн улс төрийн үзэл баримтлал, үнэт зүйлсийг төлөөлж чадахгүй хэмээн судалгаанд оролцогчдын 60 хувь үзэж байна.
- Мөн иргэд улс төрийн сонголт хийхдээ урт хугацааны хүчин зүйлс бус тухайн цаг үеийн нөхцөл байдал, үйл хөдлөлд хөтлөгдсөн буюу сонгуулийн нөхцөл байдал, уур амьсгал зэрэгт үндэслэн сонгуулийн өдөр болон сонгуулийн сурталчилгааны өдрүүдэд судалгаанд оролцогчдын 62 хувь шийдвэрээ гаргаж сонголт хийж байна.
- Иргэдийн тал буюу 41.6 хувь улс төрийн шийдвэр гаргахдаа намуудын бодлого, мөрийн хөтөлбөрт суурилсан үндэслэл бүхий оновчтой шийдвэр гаргаж чадахгүй байна. Мөн иргэдийн 59 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад субъектийн нөлөөлөлд автан сонголт хийж байгаа нь улс төрийн хүлээн зөвшөөрөгдөхүйц бие даасан шийдвэр болж чадахгүй байна.
- Иргэдийн намуудад итгэх итгэл маш сул буюу намуудын сөрөг дэмжлэг өндөр, эерэг дэмжлэг маш бага байна. Олон ургальч үзэл бодлыг илэрхийлсэн олон намын тогтолцоонд иргэдийн итгэх итгэл суларсан байна. Харин намын хэрэг байхгүй хүчтэй ерөнхийлөгчийн засаглал байх шаардлагатай гэсэн иргэдийн хандлага нэмэгдсэн байна.
- Иргэдийн намуудаас хүлээх хүлээлт маш бага буюу иргэдийн 82 хувь намуудын өгсөн сонгуулийн амлалт, мөрийн хөтөлбөр биелэхгүй гэсэн хүлээлттэй байна. Иргэдийн дийлэнх нь намуудыг бодлого хөтөлбөр, үзэл баримтлалын хувьд буруу чиглэлд хөгжиж байна хэмээн тодорхойлж байна. Мөн иргэдийн хувьд улс төрийн нам, эвслүүдийн бодлого, үзэл баримтлал, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн талаарх мэдлэг, ойлголт маш сул байна.

ХОЁР. БОДЛОГЫН НАМ: ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АГУУЛГА

Монгол Улсын Үндсэн Хуулийн 19¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Нам Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 10-г заасны дагуу байгуулагдаж, **улсын хэмжээний бодлого** дэвшүүлж ажиллана” гэсэн заалтыг тус хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр хийсэнтэй холбоотойгоор бодлогын нам төлөвшүүлэх цаашид бодлогын намын тогтолцоог хэрхэн бүрдүүлэх тухай асуудал тулгамдаж байна.

Улсын Их Хурлаас 2023 онд баталсан “Улс төрийн намын тухай” хуульд улс төрийн нам нь тодорхой үзэл баримтлал, үнэт зүйлстэй байхыг хуульчилсан. Энэ нь намууд сонгуулийн үечлэлээр хязгаарлагдахгүйгээр хүний нийгмийн хөгжил, улс орныхоо улс төр, нийгэм, оюун санааны хөгжлийн чиг баримжааг өөрийн бүрдүүлсэн үзэл баримтлал, үнэт зүйл, итгэл үнэмшлийн дагуу үнэлэн цэгнэж, тухайн намын баримтлах үзэл суртлын тогтвортой чиг хандлагыг илэрхийлж, түүнийгээ дээдлэн үйл ажиллагаагаа явуулахыг шаардана гэсэн үг юм.

¹⁰³ <http://mirim.mn/wp-content/uploads/2020/02/Songuuli-Sudalgaanii-tailan-2019.pdf>

¹⁰⁴ <https://www.supremecourt.mn/home?page=party&id=69&pr=63&tp=list>

“Улс төрийн намын тухай” хуулийн 3.1.4-т “намын хөтөлбөр” гэж намын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд тулгуурлан үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго, бодлогыг тодорхойлсон үндсэн баримт бичгийг, 4 дүгээр зүйлд “Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргадаг, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн, Нам нь Үндсэн хуульт байгуулал, ардчилсан тогтолцооны зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ард түмний улс төрийн хүсэл зориг, олон нийтийн үзэл бодлыг илэрхийлэх, төр, ард түмний хооронд байнгын, тогтвортой, идэвхтэй холбоо харилцаа үүсгэх, иргэдийн улс төрийн боловсрол, идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих, төрийн улс төрийн алба хаах, хариуцлагатай иргэнийг бэлтгэх, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцох, сонгуульд нэр дэвшүүлэн шударгаар өрсөлдөх чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан болно.

XXI зуунд улс төрийн намуудын уламжлалт хэв шинж өөрчлөгдөж байна. Тухайлбал, намыг нийгмийн тодорхой анги, нийтлэг бүлгийн ашиг сонирхлын төлөөлөл гэхээсээ илүү нийгмийг бүхэлд нь хамарсан бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх улс төрийн институт талаас нь авч үзэх хандлага онол, практикийн түвшинд давамгайлж байна.¹⁰⁵

1. Бодлогын нам

Орчин үед бодлогын нам (programmatic political parties) гэдгийг улс төрийн үзэл суртлын тогтвортой чиг баримжаанд суурилсан сайн бүтэц, зохион байгуулалттай байх агуулгаар тодорхойлж байна. Энэхүү агуулга нь дараах шинжээр илэрхийлэгдэж байна:

- нам нь бүтэц, зохион байгуулалт сайтай, тогтвортой улс төрийн хөтөлбөрөөрөө олон нийтэд танигдсан бодлогын байр суурьтай байх;
- бодлогын олон талын байр суурийн талаарх дотоод зөвшилцөл, уялдаа холбоотой байх;
- улс төрийн амлалт болон эрх мэдэлд хүрсэн үедээ наад зах нь дээрх бодлогын гол амлалтуудыг биелүүлэх чадвар, чадамжтай байх;
- намын бодлого, хөтөлбөр нь тухайн нам гишүүдээ хэрхэн татан оролцуулж байгааг тодорхойлох хамгийн чухал элемент байдаг.

Энгийнээр хэлбэл энэ нь цомхон бөгөөд оновчтой бүтэц, зохион байгуулалттай, тогтвортой үзэл сурталтай нам байх тухай асуудал юм. Үүнийг улс төрийн шинжлэх ухаанд бодлогын нам буюу бодлого, хөтөлбөрт чиглэсэн намын хэв маяг бүхий төлөвшил гэж тодорхойлдог.

Улс төрийн намыг бодлогын хэмээн тодорхойлоход дараах 3 талбарт¹⁰⁶ хэрхэн үйл ажиллагаа явуулж байгаагаар үнэлж үздэг байна. Үүнд:

- нам болон түүний гишүүд, дэмжигч, сонгогчдын хоорондын харилцаа холбоо;
- намуудын хоорондох сонгуулийн өрсөлдөөн;
- бодлого боловсруулах үйл явц дах гишүүдийн идэвх, оролцоо.

Бодлогын нам нь дараах давуу талуудтай байдаг. Үүнд:

- бодлогын чиг баримжаатай байх нь намын дотоод эв нэгдлийг илүү хангадаг;
- бодлогын нэгдмэл байдал нь "намын улс төрийн дүр төрх"-ийн үзэл суртлын агуулгыг бэхжүүлдэг;
- бодлогын нам нь үйлчлүүлэгчийг шүтсэн (клиентелист) тогтолцооноос илүү хямд, төсөр байдаг;
- бодлогын намын тогтолцоо нь ардчиллыг илүү дээд шатанд гаргах дэмжлэг болдог.

¹⁰⁵ https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Chukhal%20sedev_Political%20Party-1.pdf

¹⁰⁶ https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Chukhal%20sedev_Political%20Party-1.pdf

Дараах алхмуудыг хийснээр улс төрийн нам бодлогын нам болно хэмээн үздэг.¹⁰⁷ Үүнд:

- Бодлогын зорилтуудаа зарлаж, өрсөлддөг байх. Энэ нь нам доторх улстөрчдөөс бодлогын зөрөөтэй зарим байр суурийг дотооддоо зөвшилцөж, гадагш нэг дуугаар ярихыг шаарддаг бөгөөд ингэснээр хувь улстөрчийн дуу хоолойноос дээгүүр “намын дуу хоолой” бий болдог байна;
- Дотоод уялдаа холбоогоо сайжруулах. Энэ нь ялангуяа боломжит сонгогчидтойгоо харилцах сонгуулийн стратеги болон бусад асуудлуудтай онцгой хамааралтай;
- Улс төрийн байр суурь нь бусад намаас тод ялгагдахуйц байх. Хэрэв намуудад тухайн асуудлаар бусад намаас ялгарах хангалттай бодлого, шийдэл байхгүй бол сонгогч уруу хандах боломжгүй. Улс төрийн намууд тухайн асуудлаар ялгагдах онцлог бүхий байр суурьтай байх хангалттай улс төрийн “туйлшрал”-ыг бий болгож байж бодлогын улс төр хөгждөг байна.

Эдгээрээс харахад улс төрийн нам болон иргэд, сонгогчдын хоорондын холбоо тодорхойлох механизм нь намын бодлого, хөтөлбөр тул нийгмийн хэрэгцээнд тулгуурласан, улс орны хөгжлийн алсын хараа, бодлогод нийцсэн бодит, хэрэгжихүйц байх нөхцөлийг шаарддаг онцлогтой.

Манай улсад бодлогын нам төлөвшиж чадахгүй байгаа асуудал хөндөгддөг нь намууд нийгмийн асуудлыг тодорхойлж, шийдэл дэвшүүлсэн үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөр боловсруулан, түүгээрээ өрсөлдөж чадахгүй байгаатай холбоотой байна. Намууд бодлогоороо ялгарч өрсөлдөж чадахгүй байгаагийн улмаас иргэдийн улс төрийн сонголт мухардаж, үйлчлүүлэгчийг шүтсэн (клиентилест) намын хэв маяг руу шилжиж, улмаар ардчилсан сонгуулийн зарчим алдагдан, популизм газар авахад хүргэж байна.

2. Бодлогын баримт бичиг

1. Улс төрийн намын зүгээс нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлуудад хандах үзэл хандлага, тэдгээрийг шийдвэрлэх бодлогын зорилтууд нь тухайн намын үнэт зүйл, үзэл баримтлалаас урган гардаг. Тэрхүү эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин, соёл, шинжлэх ухаан, эрх зүйт ёс, батлан хамгаалах, гадаад харилцаа гэх зэрэг нийгмийн амьдралын бүхий л салбар, чиглэлд баримтлах бодлого, зорилтуудын нийлбэр нь намын **бодлогын ерөнхий хүрээ** (general policy framework)-г тодорхойлдог байна. Баруун төв ба зүүн төвийн үзэл баримтлалтай улс төрийн хүчнүүдийн тухайд дээр дурдсан хүрээний бодлого нь харьцангуй ялгаатай байр суурийг илэрхийлдэг. Хавсралт 1-ээр баруун төв, зүүн төвийн үзэл баримтлалтай улс төрийн намын бодлогын ерөнхий хүрээг харуулав.
2. Улс төрийн намууд урт хугацаанд тогтвортой үзэл баримтлалтай байхын тулд **Үндсэн хөтөлбөр** хэмээх бодлогын баримт бичиг боловсруулж баталдаг байна. Тэдгээр нь үндсэн хөтөлбөр, тунхаг, зарчмууд, үндсэн чиглэл гэх зэрэг янз бүрийн нэршилтэй байдаг боловч агуулгын хувьд тулгуур үнэт зүйл, зарчим, үзэл баримтлал, үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх үндсэн бодлого, зорилтуудаа тусгасан байдаг (Хэсэг 3-аас харна уу). Намын үндсэн хөтөлбөр нь дараах онцлог шинжтэй.¹⁰⁸ Үүнд:
 - а. **Урт хугацааны алсын хараа болдог:** Үндсэн хөтөлбөр нь улс төрийн намын бодлогын суурь бөгөөд хэтийн алсын хараа, зарчим, үнэт зүйлсийг

¹⁰⁷<https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/politics-meets-policies-the-emergence-of-programmatic-political-parties-pdf.pdf>

- тодорхойлж, намын бүхий л шийдвэр, бодлогыг урт хугацааны туршид чиглүүлдэг гол үзэл суртлыг тусгадаг;
- b. **Иж бүрэн, цогц шинжтэй:** Үндсэн хөтөлбөр нь нийгмийн амьдралын өргөн хүрээг хамардаг. Эдийн засаг, нийгэм, гадаад бодлого, засаглал гэх мэт асуудлаарх намын байр суурийг тодорхойлж, итгэл үнэмшлийн иж бүрэн, цогц систем бүрдүүлдэг;
 - c. **Тогтвортой байдлыг хангадаг:** Үндсэн хөтөлбөрүүд нь цаг хугацааны хувьд харьцангуй тогтвортой байх хандлагатай байдаг. Тухайлбал: Германы Социал Демократ намын үндсэн хөтөлбөрийн дундаж насжилт 19.3 жил байна;
 - d. **Бодлого, байр суурийн үндэс суурь болдог:** Үндсэн хөтөлбөр нь аливаа асуудалд хандах намын бодлого, байр суурийг тодорхойлох үндэс суурь болдог бөгөөд тухайлсан тодорхой асуудлаар нарийвчилсан бодлого, платформыг бий болгох уялдаа холбоо бүхий тогтолцоог үүсгэдэг;
 - e. **Дотоод баримт бичиг байдаг:** Үндсэн хөтөлбөр олон нийтэд нээлттэй хэдий ч үндсэндээ намын гишүүд, намын идэвхтэн, улс төрчид, удирдлагуудад зориулсан дотоод баримт бичиг юм.
3. Улс төрийн намууд шат, шатны сонгуульд зориулж, үндсэн хөтөлбөрийнхөө хүрээнд **сонгуулийн мөрийн хөтөлбөр** боловсруулдаг бөгөөд энэ нь үндсэн хөтөлбөрөөсөө ялгарах дараах онцлогтой.¹⁰⁹ Үүнд:
- a. **Богино хугацаатай:** Сонгуулийн хөтөлбөр нь үндэсний болон орон нутгийн сонгууль гэх мэт сонгуулийн тодорхой мөчлөгт тусгайлан зориулагдсан байдаг. Энэ нь тухайн сонгуультай холбоотой цаг үеийн асуудал, бодлогын талаар намын байр суурийг тодорхойлдог.
 - b. **Тодорхой асуудлуудад төвлөрдөг:** Үндсэн хөтөлбөрөөс ялгаатай нь сонгуулийн мөрийн хөтөлбөр сонгуулийн кампанит ажлын явцад онцгой анхаарал хандуулах тодорхой тооны багц асуудлуудад л төвлөрдөг. Ингэснээр нам ойрын зорилго, тэргүүлэх чиглэлээ сонгогчдод хүргэх боломжтой болдог.
 - c. **Уян хатан шинж чанартай:** Мөрийн хөтөлбөрүүд нь тухайн асуудлын нөхцөл байдал, олон нийтийн санаа бодол, шинээр гарч ирж буй сорилтуудад дасан зохицдог. Өөрөөр хэлбэл, тухайн цагийн улс төрийн уур амьсгал, нөхцөл байдалд тохирсон байдаг гэсэн үг юм.
 - d. **Олон нийтэд хандсан:** Мөрийн хөтөлбөр нь засгийн эрх авсан тохиолдолд хэрэгжүүлэх амлалт, зорилгын илэрхийлэл болгож олон нийтэд хандсан агуулгатай.
 - e. **Сонгуулийн сурталчилгааны хэрэгсэл болдог:** Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь сонгуулийн кампанит ажлын гол хэсэг юм. Намын олон нийттэй харилцах стратегийг удирдан чиглүүлж, нэр дэвшигчдэд байр сууриа илэрхийлэхэд нь тусалж, сонгогчдод саналаа хэнд өгөх талаар үнэлгээ, дүгнэлт гаргах боломжийг мөрийн хөтөлбөр олгодог байна.

3. Намын улс төрийн хөтөлбөр

Намын улс төрийн хөтөлбөр гэдэг нь улс төрийн харилцаан дахь намын анхдагч баримт бичиг юм. Намын хөтөлбөр нь:

¹⁰⁹ <https://www.eisa.org/storage/2023/05/Political-Parties-Programme-Handbook-No-18-EISA.pdf>

1. парламентын болон орон нутгийн бүх шатны сонгуульд нэр дэвшигчээ дэмжих гол хэрэгсэл болдог;
2. сонгууль хоорондын үе шатанд намын баримтлах үзэл суртлын үндсэн баримт бичиг болж мөрдөгддөг;
3. “Улс төрийн намын тухай” хуульд заасны дагуу намын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд тулгуурлан үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго, бодлогыг тодорхойлсон үндсэн баримт бичиг;
4. тухайн намын бусдаас ялгарах үндсэн шинж чанарыг илэрхийлж, сонгогчдын улс төрийн сонголтыг бүрдүүлэх хамгийн чухал баримт бичиг мөн болно.

Иймд улс төрийн намын хөтөлбөр боловсруулахдаа дараах зүйлийг анхааран тусгахыг санал болгож байна. Энэ нь хөтөлбөрийн үндсэн бүрдэл хэсэг юм. Үүнд:

- 1) улс төрийн намын баримт бичгийн бүрэн нэр;
- 2) улс төрийн намын өөрийн товч тодорхойлолт;
- 3) улс орны өнөөгийн цаг үеийн нөхцөл байдлыг шүүмжлэлтэй өнцгөөс үнэлсэн үнэлгээ;
- 4) хүндрэлийг нөхцөлдүүлж буй учир шалтгаан, түүний тодорхой илрэлүүд;
- 5) намын үнэт зүйлс, үндсэн зорилгоо тодорхойлох;
- 6) намын үнэт зүйл, үндсэн зорилгоо тайлбарлах;
- 7) тулгамдсан асуудал, саад бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам, бололцоо, чадамжийг тодорхойлох;
- 8) тухайн улс төрийн намын бусдаас ялгарах онцлог шинж чанарыг илэрхийлэх;
- 9) замнал, уриа хэлбэрээр нэгтгэн дүгнэсэн тунхаглал.

Намууд улс төрийн хөтөлбөр боловсруулахдаа эдгээр бүрдэл хэсгийг хэлбэр, агуулгын хувьд бүрэн хангахаас гадна боловсруулах үйл явцаа ил тод, нээлттэй зохион байгуулж, гишүүд, дэмжигчдийнхээ идэвх, оролцоог бүрэн хангахуйц орчин бүрдүүлэх нь бодлогын нам болохын үндсэн гол нөхцөл болдог байна.

ГУРАВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УЛС ТӨРИЙН НАМЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР

3.1. GERMAN УЛСЫН НАМУУДЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР

3.1.1 Германы Социал Демократ Нам

Германы Социал Демократ Нам¹¹⁰ (Sozialdemokratische Partei Deutschlands (Гер.), Social Democratic Party (Анг.), SPD) (ГСДН) нь сүүлийн 100 гаруй жилийн турш Германы нийгэмд нөлөө бүхий улс төрийн томоохон хүчин байсаар ирсэн. Тус нам 1875 онд байгуулагдсан цагаасаа хойш улс орныхоо нийгэм, эдийн засаг, улс төрийн дүр төрхийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Зүүн төвийн чиг баримжаатай улс төрийн намын хувьд ГСДН ардчилсан зарчмуудыг баримталж дэвшилтэт бодлого, нийгмийн халамжийн шинэчлэлийг тууштай дэмжиж ирсэн.

ГСДН-ын бодлого, үндсэн чиглэл, хөтөлбөрийг авч үзэхийн өмнө түүний түүхэн замналыг товчхон дурдах нь зүйтэй. Тус намын түүх Герман дахь ажилчин ангийн хөдөлгөөнүүд улс төрийн төлөөлөл, нийгмийн шударга ёсыг шаардаж эхэлсэн 19-р зууны сүүлч үеэс улбаатай. 1875 онд Гота хотод болсон социалист болоод хөдөлмөрийн янз бүрийн бүлгүүдийн нэгдсэн их хурлын үеэр тус нам албан ёсоор байгуулагджээ. Он жилийн туршид ГСДН-ын хүч нөлөөлөл нийгэмд улам бүр өсөн нэмэгдсээр улмаар Германы улс төрийн гол тоглогчийн нэг болсон байна. Веймарын Бүгд Найрамдах Улсын (1919-1933) үймээн самуунтай цаг үед ГСДН тус улсын ардчилсан үндэс суурийг тавихад ихээхэн хувь нэмэр

¹¹⁰ ГСДН-ын албан ёсны веб хуудас:<https://www.spd.de>

оруулсан байдаг. Гэвч 1930-аад оны эхэн үеэс Адольф Гитлер болон нацист нам хүчирхэгжсэн нь ГСДН-ыг мөрдлөг хавчлагад өртөж дарангуйлагдахад хүргэсэн юм. Нацист дэглэмийн үед тус намын олон мянган гишүүд баривчлагдаж, цөлөгдөж мөн алагдсан байдаг.

Дэлхийн II дайны дараа ГСДН дайны хөлд бүрэн сүйдсэн Герман орныг сэргээн босгоход үнэтэй хувь нэмэр оруулсан чухал хүчнүүдийн нэг болж улс төрийн тавцанд дахин гарч ирсэн. ХБНГУ-ын Үндсэн хууль (Constitution)-ийн гол үндэс, эх суурь нь болсон хуулийн (Grundgesetz) төслийг боловсруулалцахад тус нам гол үүрэг гүйцэтгэсэн байна. Дайны дараах үед ГСДН нь ажилчдын эрх, нийгмийн шударга ёс, эдийн засгийн шинэчлэлийг хамгаалахад мөн онцгой чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. 1970-аад онд Вилли Брандт канцлер болсон нь Остполитикийн (Ostpolitik-зүүний хүчний улс төр) үеийг эхлүүлж, зүүн Европын орнуудтай ойр дотно харилцаатай болж, эцэст нь 1990 оны 10 дугаар сарын 03-нд хоёр Германыг нэгтгэх үйлсэд түүхэн хувь нэмэр оруулсан байна.

Одоогийн байдлаар ХБНГУ-ын парламент буюу Бундестаг нийт 736 суудалтайгаас тус нам 206¹¹¹ мандаттай буюу хамгийн олон суудалтай улс төрийн хүчин байна.

ГСДН дараах улс төрийн тулгуур үзэл баримтлал, зарчмуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог байна. Үүнд:

1. **Нийгмийн ардчилал:** Төр зайлшгүй шаардлагатай үйлчилгээг үзүүлэх, нийгмийн халамжийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг холимог эдийн засгийг дэмжинэ. Шударга, зүй ёсны нийгмийг бий болгохын тулд зах зээлд суурилсан капитализмыг нийгмийн хамгааллын хүчтэй бодлоготой тэнцвэржүүлэхийг эрмэлздэг.
2. **Ажилчдын эрх:** Түүхэн гарал үүсэлтэйгээ холбоотойгоор ГСДН нь ажилчдын эрхийг хамгаалах, шударга хөдөлмөрийн практикийг дэмжих үүрэг хүлээсээр байна. Хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн зохицуулалт нь тэдний тэргүүлэх чиглэлүүдийн нэг юм.
3. **Нийгмийн шударга ёс:** ГСДН нь нийгмийн эмзэг бүлгийн гишүүдийг дэмжихийн тулд шат дараалсан татвар, дахин хуваарилах бодлого, зорилтот халамжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар нийгэм-эдийн засгийн ялгааг бууруулах зорилготой.
4. **Европын интеграц:** ГСДН нь Европын интеграцыг тууштай дэмжиж, Европын Холбоо (ЕХ)-н дахь Германы оролцоог тогтмолжуулж, хэвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь гишүүн орнуудын хамтын ажиллагааг дэмжин, нэгдмэл, цэцэглэн хөгжсөн Европыг дэмжинэ.

ГСДН улс орныхоо хөгжил дэвшил, сайн сайханд ихээхэн хувь нэмэр оруулсан. Эдгээрээс заримыг нь дурдвал:

- Халамжийн шинэчлэл: ГСДН нь нийгмийн хамгааллын хүчирхэг сүлжээ, хямд орон сууцны хөтөлбөр, хүртээмжтэй эрүүл мэндийн болон боловсролын тогтолцоог бий болгох зэрэг халамжийн томоохон шинэчлэлийг тэргүүлсэн.
- Хөдөлмөрлөх эрх: Намаас ажилчдын эрх ашгийг хамгаалж ажилласнаар хөдөлмөрийн нэн чухал хуулиуд хэрэгжиж, ажилчдад шударга хандах, ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдсэн.
- Жендэрийн тэгш байдал: ГСДН нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчин дэх оролцоо, тэгш цалингийн санаачилга, эмэгтэйчүүдийн манлайллын үүргийг ахиулахад чиглэсэн бодлогоор дамжуулан жендэрийн тэгш байдлыг идэвхтэй дэмжсээр ирсэн.

¹¹¹ <https://www.bundestag.de/en/parliament/plenary/distributionofseats>

- Байгаль орчны санаачилга: ГСДН нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг дэмжих, байгальд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд Герман улсын хүчин чармайлтын тэргүүн эгнээнд явж ирсэн.

3.1.1.1 ГСДН-ын бодлогын баримт бичгүүд

ГСДН-ын Үндсэн хөтөлбөр (Das Grundsatzprogramm):

ХБНГУ-ын Улс төрийн намын тухай хуулийн¹¹² 1-р зүйлийн 3 дах хэсэг болон 6 дугаар зүйлд зааснаар улс төрийн нам нь бичмэл дүрэм, хөтөлбөртэй байна. ГСДН байгуулагдсан цагаасаа эхлэн улс төрийн үнэт зүйл, үзэл баримтлал, зарчим, үндсэн чиглэлээ тусгасан Үндсэн хөтөлбөрийг батлан мөрдөж ирсэн бөгөөд түүхэн цаг үеийнхээ туршид найман¹¹³ үндсэн хөтөлбөр баталжээ. Тэдгээр үндсэн хөтөлбөрүүдийг түүхэн он дарааллаар харуулбал:

- 1869 оны Айзенах (Eisenacher)-ын хөтөлбөр;
- 1875 оны Гота (Gothaer)-ын хөтөлбөр;
- 1891 оны Эрфурт (Erfurter)-ын хөтөлбөр;
- 1921 оны Гөрлиц (Görlitzer)-ын хөтөлбөр;
- 1925 оны Хайделберг (Heidelberger)-ын хөтөлбөр;
- 1959 оны Годесберг (Godesberger)-ын хөтөлбөр;
- 1989 оны Берлин (Berliner)-ын хөтөлбөр;
- 2007 оны Хамбург (Hamburger)-ын хөтөлбөр.

Эдгээр он дарааллаас үзэхэд нэг үндсэн хөтөлбөрийн хүчин төгөлдөр үйлчилж байсан дундаж хугацаа нь 19,3 жил байна. Хамгийн сүүлд батлагдсан, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үндсэн хөтөлбөр нь Хамбург (Hamburger)-ийн хөтөлбөр¹¹⁴ юм.

Хамбургийн хэмээн нэрлэгддэг тус үндсэн хөтөлбөрийг найман жилийн турш хэлэлцсэний эцэст 2007 оны 10-р сард Хамбургийн намын бага хурлаар баталж, 21-р зууны шинэ сорилтуудыг даван туулах шинэ үндсэн хөтөлбөрийн хэлэлцүүлгийн үйл явц дууссан байна.

"Хамбургийн хөтөлбөр" нь нийгмийн ардчиллын үнэт зүйлсийн уламжлалыг үргэлжлүүлж, ойрын хэдэн арван жилдээ орчин үеийн, тогтвортой байх улс төрийн үзэл баримтлалыг боловсруулсан.

ГСДН нь даяаршлыг улс төрийн хувьд хэлбэршүүлэх, идэвхжүүлэх хөтөлбөр боловсруулсан Германы анхны нам байсан. Энэ нь ардчиллыг бизнесийн эрх ашгаас дээгүүрт тавихыг олон улсын түвшинд хэрэгжүүлэх арга барил, хандлага болсон. Даяаршилд үзүүлэх хамгийн чухал хариу арга хэмжээ бол Европыг бэхжүүлэх явдал гэж үзсэн. ГСДН нь өөрийгөө энх тайвны төлөө хүч гэж үзэн дэлхийн шударга дэг журмыг тогтоохын төлөө тэмцдэг.

Социал демократ үзэл баримтлалын үндсэн үнэт зүйлс болох эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл нь өнөө ч ач холбогдолтой хэвээр байгааг цохон тэмдэглэхийн сацуу, эдгээр үнэт зүйлсийг зөвхөн дэвшүүлээд зогсохгүй ухамсарлаж ухаарна гэдэг нь нэн чухал. Өнөөгийн цаг үеийн нөхцөлд түүнийг ухаарна гэдэг улс төрийн тэргүүлэх байр суурь, тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлнэ гэсэн үг хэмээн тунхагласан байна.

¹¹² ХБНГУ-ын Улс төрийн намын тухай хууль:

https://www.bmi.bund.de/SharedDocs/downloads/DE/gesetzestexte/Parteiengesetz_PartG_engl_042009.pdf?__blob=publicationFile&v=2

¹¹³ ГСДН-ын Үндсэн хөтөлбөрүүд: <https://www.spd.de/programm/grundsatzprogramm>

¹¹⁴ ГСДН-ын 2007 оны "Хамбургийн хөтөлбөр" хэмээх Үндсэн хөтөлбөр (Англи хэлээр):

https://www.spd.de/fileadmin/Dokumente/Beschluesse/Grundsatzprogramme/hamburger_programm_englisch.pdf

Хамбургийн хөтөлбөрийн бүтэц:

Оршил

1. Бидний цаг үе
2. Бидний үндсэн үнэт зүйл, үндсэн итгэл үнэмшил
3. Бидний зорилго, бодлого
 - 3.1 Амар амгалан, шударга ертөнц
 - 3.2 Нийгмийн чиг баримжаатай ардчилсан Европ
 - 3.3 Эв санааны нэгдэл, ардчилсан төрд суурилсан иргэний нийгэм
 - 3.4 Жендэрийн тэгш байдал
 - 3.5 Тогтвортой хөгжил, чанарын өсөлт
 - 3.6 Бүгдэд нь сайн ажил
 - 3.7 Урьдчилан сэргийлэх нийгмийн халамжийн төр
 - 3.8 Илүү сайн боловсрол, хүүхдэд тохиромжтой нийгэм, бат бөх гэр бүл
4. Бидний зам

2007 оны "Хамбургийн хөтөлбөр"-ийн зарим гол үзэл санааны хураангуйг¹¹⁵ дурдвал:

1. Нийгмийн зүй ёс (Social justice): ГСДН тэгш бус байдлыг бууруулж, бүх иргэдэд тэгш боломж олгохыг зорьж, нийгмийн шударга ёсны төлөө тууштай байгаа гэдгээ дахин нотолсон. Тус нам хамгийн эмзэг бүлгийн гишүүдээ дэмжсэн, нийгмийн тэгш бус байдлыг шийдвэрлэсэн, шударга, хүртээмжтэй нийгмийг бий болгохыг зорьж буй.
2. Эдийн засгийн бодлого: ГСДН нь чөлөөт аж ахуйн элементүүдийг нийгмийн хамгаалалтай хослуулсан нийгэм-зах зээлийн эдийн засгийг дэмждэг. Тэд эдийн засгийн өсөлт, инновац, тогтвортой хөгжлийг дэмжихийн зэрэгцээ тэдгээрийн үр өгөөжийг нийгэм даяар түгээх зорилготой.
3. Байгаль орчныг хамгаалах: Байгаль орчны тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхийн чухлыг тус нам хүлээн зөвшөөрдөг. Тэд нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг дэмжих, хойч үедээ үлдээх зорилгоор байгалийн нөөцийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх зорилготой.
4. Боловсрол ба судалгаа: Тус нам хувь хүний хөгжил, нийгмийн дэвшилд боловсрол, судалгааны ач холбогдлыг онцлон чухалчилдаг. Тэд бүх иргэдэд өндөр чанартай боловсролын хүртээмжийг хангах, эдийн засаг, технологийн дэвшлийг хөтлөх судалгаа, инновацыг дэмжихийг эрмэлзэж байна.
5. Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал: Нам нь эрүүл мэндийн тогтолцоо, нийгмийн халамжийн хөтөлбөрийг бэхжүүлж, хүн бүрийг хүртээмжтэй, иж бүрэн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамруулах зорилт тавьсан.
6. Жендэрийн тэгш байдал: ГСДН нь хүйсийн тэгш байдлын төлөө тэмцэж, ялгаварлан гадуурхалтыг арилгах, нийгмийн бүх салбарт бүх хүйсийн тэгш боломжийг дэмжих зорилготой.
7. Интеграц ба шилжилт хөдөлгөөн: Тус нам цагаачид болон дүрвэгсдийг өөрийн нийгэмд амжилттай нэгтгэн авахад анхаарч, соёлын олон янз байдлыг эрхэмлэдэг олон талт, хүртээмжтэй нийгмийг бий болгохыг зорьдог.
8. Ардчилал ба оролцоо: ГСДН эрч хүчтэй, оролцоот ардчиллыг дэмжиж, шийдвэр гаргах үйл явц дах иргэдийн оролцоо болон бүх түвшний улс төрийн идэвх оролцоог хөхиүлэн урамшуулдаг.
9. Европын болон олон улсын хамтын ажиллагаа: Дэлхий дахинд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх, энх тайвныг дэмжих, хүний эрхийг хамгаалахад Европ болон олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг тус нам хүлээн зөвшөөрдөг.

¹¹⁵ ГСДН-ын 2007 оны "Хамбургийн хөтөлбөр" хэмээх Үндсэн хөтөлбөр (Англи хэлээр): https://www.spd.de/fileadmin/Dokumente/Beschluesse/Grundsatzprogramme/hamburger_programm_englisch.pdf

10. Дижиталчлал: ГСДН дижиталчлалын өөрчлөлтийн үр нөлөөг хүлээн зөвшөөрч, мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ иргэдийн ашиг тусын тулд боломжоо ашиглахыг зорьсон.

Энэхүү үндсэн хөтөлбөрийн хүрээнд холбооны болон бусад сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдийг боловсруулдаг байна. Хамгийн сүүлд холбооны сонгууль 2021 онд болсон байдаг бөгөөд энэхүү сонгуулиар тус намаас дэвшүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн бүтэц, агуулгыг жишээ болгон тоймлон харуулъя. Үүнд:

ГСДН-ын 2021 оны холбооны сонгуулийн мөрийн (ирээдүйн) хөтөлбөр¹¹⁶ (Das Zukunftsprogramm der SPD):

ГСДН-ын 2021 оны холбооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийн бүтэц:

I. Ирээдүй. Хүндлэл. Европ.

- 1.1 Ирээдүйгээ баталгаажуулах
- 1.2 Хүндлэлийг сэргээх
- 1.4 Нийгмийн эв нэгдлийг эрхэмлэх

II. Амьдрахад үнэ цэнтэй ирээдүй

- 2.1 Ирээдүйд чиглэсэн эрхэм зорилго I. Уур амьсгалд (сөрөг) нөлөөлөлгүй Герман
- 2.2 Ирээдүйн эрхэм зорилго II. Европын хамгийн орчин үеийн хөдөлгөөнт систем
- 2.3 Ирээдүйн эрхэм зорилго III. Герман, Европын дижитал бие даасан байдал
- 2.4 Ирээдүйн эрхэм зорилго IV. Эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэлт
- 2.5 Тогтвортой эдийн засгийг дэмжих бидний төлөвлөгөө
- 2.6 Шинжлэх ухаан, судалгааг шинэлэг, тогтвортой байлгахын тулд бид хэрхэн төлөвлөж байгаа вэ.
- 2.7 Бид бодлогоо хэрхэн санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа вэ
- 2.8 Манай засаглалын загвар

III. Хүндлэлийн нийгэм

- 3.1 Ажлыг үнэлэх
- 3.2 Ажил мэргэжлээр ажиллах боломжийг сайжруулах
- 3.3 Эв нэгдлийг бэхжүүлэх
- 3.4 Өндөр настны хангамжийг бүрдүүлэх
- 3.5 Бие биедээ анхаарал халамж тавих
- 3.6 Хямд үнэтэй орон сууц
- 3.7 Хүүхдийн аюулгүй байдал, баталгаат байдал
- 3.8 Тэгш байдлыг бодит болгох
- 3.9 Хамтдаа амьдрах
- 3.10 Ардчиллыг бэхжүүлэх
- 3.11 Соёлыг сурталчлах
- 3.12 Бие биеэ илүү сайн ойлгох
- 3.13 Аюулгүй орчинд амьдрах
- 3.14 Эрүүл мэндийг хамгаалах, залуучуудыг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь эмийн талаар баримтлах бодлогыг тодорхойлно
- 3.15 Байгальд ээлтэй

IV. Дэлхий даяарх бүрэн эрхт Европ

¹¹⁶ ГСДН-ийн 2021 оны холбооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (Англи хэлээр): https://www.spd.de/fileadmin/Dokumente/Regierungsprogramm/202105_Zukunftsprogramm_EN.pdf

- 4.1 Эв нэгдлийг бэхжүүлэх
- 4.2 Экологи, нийгмийн хариуцлагатай менежмент
- 4.3 Ардчиллыг өргөжүүлэх
- 4.4 Европын хөршүүдтэйгээ харилцах харилцааг хөгжүүлэх
- 4.5 Энхийг сахиулах

V. Ирээдүй, хүндэтгэл, эв нэгдлийн Европ – шинэ арван жилийн удирдамж

*ГСДН-ын 2021 оны холбооны сонгуулийн мөрийн (ирээдүйн) хөтөлбөрийн товч агуулга:*¹¹⁷

- Нийгмийн шударга ёс ба халамж: ГСДН нь нийгмийн хамгааллын сүлжээг бэхжүүлж, бүх иргэдийг орон сууц, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хүртээмжтэй хамруулахыг зорьдог. Тэд орлогын тэгш бус байдлыг бууруулж, нийгмийн эмзэг бүлгийн гишүүдийг хамгаалахын тулд шат дараатай татвар ногдуулахыг дэмждэг.
- Ажилчдын эрх, шударга цалин: Нам нь ажилчдын эрхийг хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахын төлөө байна. Тэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, хамтын хэлэлцээрийг шударгаар явуулах, ажил амьдралын тэнцвэрийг хангах арга хэмжээ авахыг дэмжиж байна.
- Уур амьсгалын өөрчлөлт ба хүрээлэн буй орчин: SPD нь уур амьсгалын эсрэг арга хэмжээ авч, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжихийг чухалчилдаг. Тэд уур амьсгалын өөрчлөлттэй үр дүнтэй тэмцэх тогтвортой бодлого, санаачилгыг дэмжихийг эрмэлздэг.
- Дижитал өөрчлөлт: Дижитал эриний боломжуудыг ашиглан ГСДН нь инновацыг дэмжих, дижитал дэд бүтцийг өргөжүүлэх, иргэдийн мэдээллийн хамгаалалтыг хангах зорилготой.
- Жендэрийн тэгш байдал ба олон талт байдал: ГСДН нь жендэрийн тэгш байдлыг дэмжиж, нийгмийн бүх талбарт олон талт байдал, оролцоог нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.
- Европын интеграц: Нам нь нэгдсэн бодлого, санаачилгаар нэгдмэл, цэцэглэн хөгжсөн Европыг бий болгохыг зорин Европын интеграцлал, хамтын ажиллагааг тууштай дэмжиж байна.
- Боловсрол ба судалгаа: ГСДН нь ирээдүйд чадварлаг, мэдлэгтэй ажиллах хүчийг бий болгохын тулд боловсрол, судалгаанд хөрөнгө оруулахыг чухалчилдаг.
- Боломжийн орон сууц: Орон сууцны хямралыг шийдвэрлэхийн тулд SPD нь хямд үнэтэй орон сууцны сонголтыг өргөжүүлэх, түрээслэгчдийг хамгаалахын тулд түрээсийн хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулдаг.
- Эрүүл мэндийн салбарын шинэчлэл: Нам эрүүл мэндийн тогтолцоог боловсронгуй болгож, чанартай тусламж, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй байлгахыг зорьж байна.
- Ардчилал ба иргэний эрх: ГСДН нь ардчилсан зарчим, иргэний эрхийг хамгаалах, бэхжүүлэх, хүртээмжтэй, оролцоотой нийгмийг дэмжих зорилготой.

3.1.2 Германы Христийн ардчилсан холбоо нам

Дэлхийн 2-р дайны дараах Германы улс төрийн орчинд цаашдын тогтвортой байдал, шинээр сэргэх, дахин эвлэлдэн нэгдэх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай тулгарсан байлаа. Энэхүү түүхэн цаг үед буюу 1945 онд Германы Христийн ардчилсан холбоо нам (Die Christlich Demokratische Union Deutschlands (Гер), Christian Democratic Union of Germany (Анг) CDU) (ГХАХН) ард түмний дунд нэр хүндтэй, үндэстнийхээ ирээдүйн замналыг тодорхойлох улс төрийн гол хүчин болон үүсгэн байгуулагдсан байна. Тус намыг үүсгэн байгуулагчид нь гол төлөв өмнөх улс төрийн хүчнүүд болох Төвийн нам, Ардчилсан нам,

¹¹⁷ ГСДН-ийн 2021 оны холбооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (Англи хэлээр): https://www.spd.de/fileadmin/Dokumente/Regierungsprogramm/202105_Zukunftsprogramm_EN.pdf

Ардын нам, Үндэсний ардын намын хуучин гишүүд, дэмжигчдээс бүрдэж байв. ГХАХН нь христийн ардчилсан, либерал консерватив үзэл баримтлалтай, баруун төвийн, нийтийг хамарсан улс төрийн нам юм.

ГХАХН-ыг Герман орны хэтийн төлөв болон тус намын бодлого чиглэлийн тодорхойлогч нөлөө бүхий эрхмүүд удирдаж ирсэн бөгөөд эдгээрээс хамгийн алдартай нь дайны дараах сэргээн босголтод чухал үүрэг гүйцэтгэж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсыг байгуулалцсан Конрад Аденауэр юм. Мөн Хоёр Германыг нэгтгэхэд идэвхийлэн зүтгэсэн Хельмут Коль, Европын санхүүгийн хямралыг даван туулсан прагматик бодлоготон Ангела Меркель зэрэг нэр хүндтэй улс төрч, удирдагчид байв.

Тус нам нь Германы улс төрд зонхилох байр суурьтай улс төрийн хүчин байсаар ирсэн бөгөөд ихэнхдээ эвслийн засгийн газруудыг толгойлж эсхүл тэдгээрт хамтран оролцож байв. ГХАХН-ын бодлого, үйл ажиллагаа өөрчлөгдөж буй нийгмийнхээ хэрэгцээ шаардлагад дасан зохицож, нийцсэн хэвээр байх чадвартай байсан нь сонгуульд олон удаа ялалт байгуулж, эвслийн Засгийн газар тэргүүлэхэд нөлөөлсөн.

ГХАХН-ын бодлогын хөтөлбөрт эдийн засгийн шинэчлэлээс эхлээд нийгмийн халамжийн хөтөлбөр хүртэл олон асуудлууд туссан. Төсвийн хариуцлага, ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэгт тус нам ихээхэн анхаарал хандуулж ирсэн нь эдийн засгийн бодлогынх нь гол цөм байсаар ирсэн. Нийгмийн бодлогын хүрээнд ГХАХН нь гэр бүлийн үнэ цэнэ, боловсрол, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг дэмжиж ирсэн. ГХАХН-ын Германы нийгэмд үзүүлэх нөлөө нь дотоод бодлогын хүрээндээс даван гарч бүс нутаг дэлхийн түвшинд хүрсэн. Тус намын Европын интеграцчлалын төлөөх бодлого нь Герман улс Европын Холбоонд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, голлох нөлөө бүхий гишүүн болоход нөлөөлсөн. Түүнчлэн ГХАХН-ын хоёр Германыг дахин нэгтгэхэд гүйцэтгэсэн үүрэг нь Герман Улсыг илүү хүчирхэг, нэгдмэл болгох эх суурийг тавьсан юм.

Олон жилийн туршид ГХАХН иргэд, сонгогчдын санаа бодлын өөрчлөлт, бусад альтернатив намуудын өсөлт, хөгжилт зэрэг сорилтуудтай тулгарч байсан. Гэвч тэд бодлого, манлайлал, зохицуулалтаа тухайн нөхцөл байдалд тохируулан өөрчилсөөр дасан зохицож ирсэн. Цагаачлал, эрчим хүчний шилжилт, дижиталчлал зэрэг асуудлуудыг шийдвэрлэх үйл явц нь ГХАХН-ыг үнэт зүйл, үндсэн зарчмууддаа үнэнч байхыг шаардаж байна.

ГХАХН-ын үнэт зүйл, үзэл баримтлал:

ГХАХН-ын үнэт зүйл, үндсэн үзэл баримтлал нь Христийн нийгмийн ёс зүй, нийгмийн консерватизм, эдийн засгийн либерализм, Европын интеграцчлал зэрэг үзэл санааны хослол дээр бүрэлддэг. ГХАХН-ын үнэт зүйл, үзэл баримтлалын онцлох зарим гол талуудыг дурдвал: Үүнд:

- 1. Христийн нийгмийн ёс зүй:** ГХАХН-ын үнэт зүйлсийн гол цөм нь Христийн нийгмийн ёс зүйд тууштай хандах явдал юм. Тус нам Христийн шашны үндсэн зарчмуудыг хүндэтгэн дээдэлж, бодлого, үйл ажиллагаандаа тусгахыг эрмэлздэг. Тэдгээр зарчимд хүний нэр төр, нийгмийн шударга ёс, энэрэн нигүүлсэхүй, нийтийн сайн сайхны төлөө анхаарал хандуулах зэрэг ордог. Энэхүү үнэт зүйлс нь намын засаглал болон шийдвэр, хандлагыг бүхэлд нь чиглүүлж байх ёстой гэж үздэг байна.
- 2. Нийгмийн консерватизм:** ГХАХН нийгмийн уламжлалт үнэт зүйлс, институцийг хадгалахад чухал ач холбогдол өгдөг. Энэ нь гэр бүлийн бүтцийг хадгалах, нийгмийн бүлгүүдийн (community) ач холбогдлыг онцлох, ёс суртахууны үнэт зүйлсийг эрхэмлэх зэрэг бодлогыг дэмжих хандлагатай байдгаар нь илэрнэ. Ихэвчлэн консерватив нийгмийн хэм хэмжээнд нийцсэн гэрлэлт, гэр бүл, боловсрол зэрэг асуудлаарх байр суурийг илэрхийлдэг.

3. **Эдийн засгийн либерализм:** ГХАХН нь нийгмийн үнэт зүйлсийг чухалчлахын зэрэгцээ зах зээлд чиглэсэн эдийн засгийн хандлагыг баримталдаг. Тэд бизнес эрхлэлт, инновац, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг дэмждэг. Нийгмийн баримжаатай хөтөлбөр, үйлчилгээг дэмжих боломж, тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх нөөц, чадавхыг бүрдүүлэхэд хүчирхэг эдийн засаг хамгаас чухал хэмээн тус нам үздэг байна.
4. **Европын интеграц:** ГХАХН Европын интеграцлал, хамтын ажиллагааг анхнаас нь хүчтэй дэмжигч байсаар ирсэн. Тэд хамтын сорилтуудаа даван туулахын тулд хамтран ажилладаг, нэгдмэл, энхтайван Европыг бүтээхийг зорьдог. Тус намын Европын интеграцлалын бодлого, зорилтууд нь нэгдмэл Европ л тогтвортой байдал, энхтайван, хөгжил цэцэглэлтийг бий болгоно гэсэн тэдний дээрх итгэл үнэмшлээс урган гардаг.
5. **Хувь хүний эрх чөлөө ба хариуцлага:** ГХАХН хувь хүний эрх чөлөөг эрхэмлэдэг боловч хариуцлагатай эрх чөлөөний үзэл баримтлалыг чухалчилдаг. Хувь хүн өөрийн зорилго, хүсэл тэмүүлэлдээ хүрэх эрх чөлөөтэй байхын зэрэгцээ нийгэмд эерэг хувь нэмэр оруулах үүрэг хариуцлагаа ухамсарлах ёстой гэж үздэг. Хувь хүний эрх чөлөө, нийгмийн хариуцлагын энэхүү тэнцвэрт байдал нь намын үзэл баримтлалын гол ойлголт юм.
6. **Харилцан туслах ба орон нутгийн бие даасан байдал:** ГХАХН нь харилцан туслах зарчмыг дэмждэг бөгөөд энэ нь шийдвэрийг аль болох орон нутгийн түвшинд гаргах ёстой гэсэн үг юм. Энэхүү үзэл баримтлал нь хүй элгэн, орон нутаг, бүс нутгууд өөрсдийн эрх ашигт шууд нөлөөлөх аливаа асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгох итгэл үнэмшилтэй нийцэж байдаг.
7. **Нийгмийн халамж ба эв санааны нэгдэл:** ГХАХН нь эдийн засгийн либерализмыг дэмжихийн зэрэгцээ эмзэг бүлэгт зориулсан, тэдний аюулгүй байдлыг хангах нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг. Эв санааны нэгдлийн үзэл баримтлал нь тусламж хэрэгтэй хүмүүсийг дэмжиж, тэгш бус байдлыг бууруулах чиглэлээр тус намын баримталж буй тууштай бодлогыг илэрхийлдэг.
8. **Байгаль орчны менежмент:** Сүүлийн жилүүдэд ГХАХН байгаль орчныг хамгаалах, тогтвортой байдлыг хангахад ихээхэн анхаарч байна. Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжих, хойч үедээ эх дэлхий, унаган байгалиа хэвээр үлдээхийн тулд байгальд ээлтэй бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг тус нам хүлээн зөвшөөрдөг.
9. **Олон улсын хүчтэй оролцоо:** ГХАХН олон улсын асуудалд Германы гүйцэтгэх үүргийг чухалчилдаг. Энэ нь дэлхийн хэмжээнд энхтайван, аюулгүй байдал, хүний эрхийг дэмжих дипломат хүчин чармайлт, олон улсын хамтын ажиллагаа, хүчирхэг холбоотнуудыг дэмждэг.

"Эрх чөлөө, аюулгүй байдал: Германы зарчим" ГХАХН-ын тунхаг:

ГХАХН-ын "Эрх чөлөө, аюулгүй байдал: Германы зарчим" тунхаг 2007 онд батлагдсан. Тус тунхагт намын үндсэн зарчим, үндэстний үзэл баримтлалыг тусгасан байдаг.

Тус тунхагийн агуулга нь:

Оршил: 21-р зуунд Германы Христийн ардчилсан бодлого

I. Бид Христийн ардчилсан намынхан

1. Бид хэн бэ - Хүн төрөлхтний тухай бидний үзэл баримтлал ба ГХАХН-ийн үндсэн үнэт зүйлс
2. Нийгмийн тухай бидний ойлголт
 - Хувь хүний үнэгүй хөгжил

- Манай нийгэм дэх эв нэгдэл
- II. Бидний цаг үеийн сорилтууд - ГХАХН-ын ирээдүйг тодорхойлох хэтийн төлөв
1. Бидний цаг үеийн сорилтууд
 - Аюултай орчинд өсөж торних
 - Даяаршсан ертөнц
 - Мэдлэгт суурилсан нийгмийн эрэлт хэрэгцээ
 - Аюулгүй байдал
 - Хүн ам зүйн өөрчлөлт
 2. Герман, Боломжит нийгэм - Эрх чөлөө, аюулгүй орчинд амьдрах
- III. Хүчтэй гэр бүл – хүмүүнлэг нийгэм
1. Амьдралын шинэ хэв маяг - Үе үеийн шинэ харилцаа
 2. Нийгмийн суурийг бэхжүүлэх – Эрх чөлөөг бий болгох, Гэр бүлд зориулсан сонголт
- IV. Герман бол боловсрол, соёлын үндэстэн - Мэдлэгт суурилсан нийгэмд өгөх хариулт
1. Хүн бүрт өндөр боловсрол олгох - эхнээс нь амьдралынхаа туршид
 2. Сонирхолтой Герман: Шинжлэх ухааны судалгаа нь хөгжил цэцэглэлтийг баталгаажуулдаг
 3. Соёл: Үндэсний өвөрмөц байдлын илэрхийлэл
- V. Даяаршсан дэлхийн нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн шинэчлэл
1. Хөгжил дэвшил, оролцоо, аюулгүй байдлын төлөөх дэг журамтай байх зарчим
 2. Даяаршсан дэлхийн нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг
 3. Бизнес ба Хөдөлмөр эрхлэлт
 4. Хүн ам зүйн өөрчлөлтийг төлөвшүүлэх нь - Бүх үеийнхний нийгмийн хамгаалал
 5. Хүчирхэг Герман улсын хатуу төсөв
 6. Түүхэн ололт амжилтад тулгуурлах - шинийг эрэлхийлэх Холбооны улсууд
- VI. Бурханы бүтээл ба амьдралыг хамгаалах - амьдрах таатай орчин
1. Хүний нэр төрийг хамгаалах - Амьдралын эхнээс эцэс хүртэл
 2. Байгалийн баялгийг хамгаалах
 3. Хөдөө аж ахуй, хөдөөгийн ирээдүй
- VII. Идэвхтэй иргэд, хүчирхэг төр, нээлттэй улс
1. Иргэний нийгмийг бэхжүүлэх - Идэвхтэй санаачлагыг хөхүүлэн дэмжих
 2. Хүчирхэг төрийн төлөө: Иргэдийн эрх чөлөө, аюулгүй байдлын төлөө
 3. Герман, Интеграцын орон
- VIII. Германы үүрэг хариуцлага, ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх
1. Германы боломж бол Европ
 2. Эрх чөлөө, энхтайвны төлөө зогсох нь - Германы дэлхийн үүрэг

ГХАХН энэхүү "Эрх чөлөө ба аюулгүй байдал: Германы зарчим" тунхагтаа хувь хүний эрх чөлөө, хамтын аюулгүй байдлыг дээдэлсэн нийгмийг дэмжих бодлого, зорилтуудаа тодорхойлсон. Христийн ардчиллын үнэт зүйлсэд тулгуурласан ГХАХН нь үндэстнийхээ аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ иргэн бүр хөгжин дэвших орчныг бүрдүүлэхийг эрмэлздэг бөгөөд тус тунхагт дараах үзэл санаа, бодлого чиглэлүүдийг тусгасан. Үүнд:

1. **Эрх чөлөө ба хариуцлага:** ГХАХН нь эрх чөлөөний дотоод үнэ цэнийг үзэл суртлынхаа тулгын чулуу хэмээн онцолдог. Энэ нь хувь хүн өөрийнхөө, гэр бүлийнхээ болон нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хүсэл эрмэлзэлдээ хүрэх эрх чөлөөтэй нийгэм үрүү тэмүүлдэг. Энэхүү зарчим нь хувь хүний эрх чөлөө, нийгмийн сайн сайхан байдлын хоорондын тэнцвэрт байдлыг агуулдаг.
2. **Эрх зүйл ёс ба ардчилал:** Тунхагт эрх зүйт ёс, ардчиллын бат бөх тогтолцоо чухал болохыг онцлон тэмдэглэсэн. ГХАХН нь ардчилсан институцыг дэмжих, шударга ёсыг

- тэгш хүртээмжтэй байлгах, бүх иргэдийн эрх, нэр төрийг хамгаалах үүрэг хүлээдэг. Мөн оролцоо, хүртээмжтэй байдлыг дэмжсэн оролцооны ардчиллыг дэмждэг.
3. **Эдийн засгийн чадамж ба нийгмийн эв нэгдэл:** Эдийн засгийн хөгжил цэцэглэлт нь ГХАХН-ын алсын хараанд гол байр суурь эзэлдэг. Тус нам инновацыг дэмжиж боломж, бололцоо бий болгодог хөгжил хөдөлгөөнт, зах зээлийн баримжаатай эдийн засгийг дэмждэг. Үүний зэрэгцээ нийгэмд эв нэгдэл зайлшгүй шаардлагатайг хүлээн зөвшөөрч, боловсрол, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх зэрэг зорилтот бодлогоор тэгш бус байдлыг арилгахыг зорьдог байна.
 4. **Тогтвортой хөгжил:** ГХАХН нь байгаль орчны зохистой удирдлага, эдийн засгийн өсөлтийг тэнцвэржүүлсэн тогтвортой хөгжилд хүрэхийг эрмэлздэг. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийг яаралтай шийдвэрлэх, даван туулах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжих, байгальд ээлтэй туршлагыг сурталчлах, эх дэлхийнхээ унаган байгалийг сэргээх хүчин чармайлтад хувь нэмрээ оруулахыг бодлого, зорилтууддаа тусгасан байна.
 5. **Гэр бүл ба боловсрол:** Гэр бүл бол нийгмийн үндэс суурь. ГХАХН-ын зүгээс гэр бүлийн үнэт зүйлс, эцэг эхчүүдэд эрх мэдэл олгох бодлого хэрэгжүүлэхээ онцолдог байна. Тус нам нь бага насны хүүхдийн боловсролыг дээшлүүлж, боловсролын стандартыг сайжруулж, эцэг эхчүүдэд ажил мэргэжлээ дээшлүүлэх боломжийг олгох зорилгоор хүүхэд харах үйлчилгээний хүртээмжтэй боломжоор хангах зорилготой.
 6. **Олон улсын оролцоо ба Европын нэгдэл:** Тунхаг бичигт ГХАХН-ын хүчирхэг, нэгдмэл Европыг бий болгох бодлогыг тууштай баримталдаг. Энэ хүрээнд дипломат харилцаа, хамтын ажиллагаа, зөрчилдөөнийг шийдвэрлэхэд онцгойлон анхаарч, олон улсын идэвхтэй оролцоог дэмжинэ. Тус нам нь Герман улсыг хүний эрх, энх тайван, тогтвортой байдлыг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэгч орон гэж үздэг.
 7. **Аюулгүй байдал ба хамгаалалт:** ГХАХН-ийн алсын хараанд аюулгүй байдал хамгийн чухал. Тус нам нь шинээр гарч ирж буй аюул заналхийллийг үр дүнтэй даван туулах чадвартай, сайн тоноглогдсон, орчин үеийн батлан хамгаалах хүчнийг дэмждэг. Энэ нь бүс нутгийн болон дэлхийн аюулгүй байдлыг хангахад НАТО болон бусад олон улсын түншлэлийн ач холбогдлыг онцлон авч үздэг гэсэн үг юм.
 8. **Шилжилт хөдөлгөөн ба интеграц:** ГХАХН нь шилжилт хөдөлгөөн ба интеграцлалд хандахдаа дэг журам, шударга ёс, соёлын нэгдмэл байдалд илүү анхаарлаа төвлөрүүлдэг. Тус нам нь жинхэнэ хамгаалалт шаардлагатай хүмүүст орогнол олгох, хэлний сургалт, боловсрол, ажлын байраар дамжуулан өөрийн нийгэмдээ амжилттай нэгтгэхийг дэмжсэн цагаачлалын бодлого баримтлан ажилладаг.
 9. **Дижиталчлал ба инновац:** Дижитал эрин зуунд ГХАХН нь технологи, инновацийн чадавхыг нийгмийн сайн сайханд ашиглахыг зорьдог. Энэ хүрээнд мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдлыг хамгаалахын зэрэгцээ технологийн дэвшлийг хүлээн зөвшөөрч, дижитал засаглалтай Герман улсыг байгуулахыг зорьж байна.
 10. **Эрүүл мэнд ба амьдралын чанар:** Тунхаг бичигт ГХАХН бүх иргэдэд хүртээмжтэй, өндөр чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх бодлого баримталдаг. Тус нам нь эрүүл мэндийн тогтолцоог шинэчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжиж, өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулахыг дэмждэг.

Товчхондоо "Эрх чөлөө ба аюулгүй байдал: Германы зарчим" тунхагт хувь хүний эрх чөлөө, хамтын аюулгүй байдлын тэнцвэрийг бий болгохыг зорьж буй цогц алсын харааг тусгасан байдаг бөгөөд хариуцлагатай байх, ардчилсан, тогтвортой байдал, хүртээмжтэй байх зарчмууд дээр тулгуурлан чинээлэг, эв нэгдэлтэй, шударга, цэцэглэн хөгжсөн Герман орныг цогцлон бүтээхийг зорьдог.

3.2. АВСТРИ УЛСЫН НАМУУДЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР

3.2.1 Австрийн Социал Демократ нам

Бүгд Найрамдах Австри Улс нь парламентын засаглалтай, төлөөллийн ардчилсан системтэй. Парламент нь Холбооны зөвлөл болон Үндэсний зөвлөл гэсэн хоёр танхимтай. Дээд танхим болох Холбооны зөвлөл нь муж улсуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс тухайн муж улсын хүн амын тооноос хамааруулан сонгодог 60 гишүүнтэй. Доод танхим болох Үндэсний зөвлөлийг 4 жил тутам намын нэрсийн жагсаалтаар шууд сонгодог 183 гишүүнтэй.

Австрийн Социал Демократ нам (Sozialdemokratische Partei Österreich-SPÖ)¹¹⁸ нь XIX зууны сүүлчээр үүсгэн байгуулагдсан бөгөөд социал–демократ үзэл баримтлалыг баримталдаг. Намын бодлого нь ард түмний сайн сайхан амьдралын төлөө эрх чөлөө, эв нэгдэл, тэгш байдал, шударга нийгэм, ардчилсан Австри Улсыг байгуулахыг гол зорилгоо болгосон байна.

Намын их хурал бол намын шийдвэр гаргах дээд байгууллага юм. Намын их хурлаас SPÖ-ийн гүйцэтгэх зөвлөл, SPÖ-ийн тэргүүлэгчид болон SPÖ-ийн даргыг сонгодог.

Намын бага хуралд орон нутгийн намын байгууллага болон харьяа социал демократ байгууллагуудын төлөөлөгчид гишүүнээр сонгогддог. Намын бага хурал нь SPÖ-ийн улс төрийн чиг хандлагыг тодорхойлсон үндсэн хөтөлбөр, намын дүрэм, бусад санал хүсэлтүүдийг шийдвэрлэдэг байна.

Австрийн Социал Демократ нам нь улс төрийн чиг хандлагаа тодорхойлсон үндсэн хөтөлбөрөө Уэлс (Wels)¹¹⁹ хотод 2018 онд болсон Намын бага хурлын XXXXIV хуралдаанаар баталсан байна.

ҮНДСЭН ХӨТӨЛБӨР¹²⁰

Австрийн Социал Демократ намын үндсэн хөтөлбөр нь нийт 11 бүлэгтэй бөгөөд дэлхийн хөгжлийн тасралтгүй байдал, намын цаг үеийн сорилт, үнэт зүйлс, Австри Улсын ирээдүйн хөгжил, өөрчлөлтийн асуудлуудыг тусгаж өгсөн байна.

Бүлэг нь:

1. Дэлхийн эв нэгдлийг бий болгох (Eine solidarische Welt ist möglich)
2. Европыг илүү ардчилсан, илүү нийгмийн хариуцлагатай болгох (Europa demokratischer und sozialer machen)
3. Эдийн засгийн ил тод байдлын төлөө (Für eine gerechte Wirtschaftsordnung)
4. Хүн бүрд сайн ажил (Gute Arbeit für alle)
5. Боловсрол бол эрх чөлөөний түлхүүр (Bildung als Schlüssel zur Freiheit)
6. Аюулгүй байдал бол нийгмийн баталгаа (Sicherheit ist sozial)
7. Хот ба хөдөө (In Stadt und Land)
8. Дэлхийг хамгаалах нь бидний үүрэг (Die Pflicht zur Erhaltung unseres Planeten)
9. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах (Die Gleichstellung der Geschlechter)
10. Эв нэгдлийг бэхжүүлэх нь (Das Miteinander stärken)
11. Нээлттэй дижитал нийгэм ба урлагийн эрх чөлөө (Die offene Digitalgesellschaft und die Freiheit der Kunst)

Нэг. Дэлхийн эв нэгдлийг бий болгох (Eine solidarische Welt ist möglich)

¹¹⁸ Sozialdemokratische Partei Österreich., <https://www.spoe.at/das-sind-wir/das-sind-wir/>

¹¹⁹ Wels is a city in Upper Austria, on the Traun River near Linz. It is the county seat of Wels-Land, and with a population of approximately 60,000, the eighth largest city in Austria.

¹²⁰ Grundsatzprogramm., <https://www.spoe.at/wp-content/uploads/sites/739/2018/12/Parteiprogramm2018.pdf>

Даяаршил нь дэлхий нийтийг ойртуулсан ч шударга нийгмийг бий болгож чадаагүй. Үүнийг өөрчлөх нь биднээс шалтгаална. Хүмүүс хамтдаа хэрхэн амьдрахаа шийдэх нь бидний гарт байна.

Социал демократууд бид дэлхийг илүү шударга болгохыг хүсэж байна. Нийгмийн ардчиллын олон улсын эв санааны нэгдэл урьд өмнөхөөсөө илүү шинэчлэгдэж байна. Бид хүн бүрд сайхан амьдрах боломжийг олгохыг хүсэж байна. Сайн боловсрол эзэмших, гүйцэтгэсэн ажилдаа тохирсон цалин хөлстэй байх, хамгийн сайн эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, шаардлагатай үед бусад дэмжлэг үзүүлэх эрхтэй. Ингэснээр хүн бүр хүсэл мөрөөдлөө биелүүлэх боломжоор хангагдаж, хүчирхийлэл, ядууралгүй амьдрах боломжтой болно. Үүнийг бий болгох нь төрийн үүрэг. SPÖ-ийн үндсэн бодлого нь эв нэгдэлд суурилдаг, мөн Европыг улам хүчирхэгжүүлэхэд чиглэгддэг. Учир нь бид хүчирхэг Европт л даяарчлал, дижиталчлалын сорилтуудын хариултыг олж чадна. Бид дэлхийн нэг хэсэг тул улсынхаа хэмжээнд болон дэлхийн хэмжээнд сэтгэж ажиллах ёстой. Үүнд:

1. Дэлхий даяарх хөдөлгөөн (Eine weltweite Bewegung)
2. Зөрчилдөөнийг шийдвэрлэж, энхтайвныг хангах (Konflikte lösen und Frieden sichern)
3. Дайнаас урьдчилан сэргийлэх (Kriege an den Wurzeln verhindern)
4. Хамтын аюулгүй байдлыг бий болгох (Kollektive Sicherheit herstellen)
5. Зэвсэггүйгээр энхтайван тогтоох (Frieden schaffen ohne Waffen)
6. Дүрвэгсдэд болон тусламж хэрэгтэй хүмүүст туслах (Fluchtursachen bekämpfen, Menschen in Not helfen)
7. Хамгаалах нь хамтын үүрэг (Schutz als gemeinsame Verpflichtung)
8. Төвийг сахисан бодлогоо баталгаажуулах, сулруулахгүй байх (Die Neutralität stärken, nicht untergeben)
9. Хүн бүрт хэрэгтэй даяаршлын төлөө (Für eine Globalisierung, die allen Menschen nützt)
10. Дэлхийн шударга худалдаа (Fairer Welthandel)
11. Корпорацуудын заавал дагаж мөрдөх дүрэм (Verbindliche Regeln für Konzerne)
12. Шударга байдал нь зөрчилтэй асуудлыг барасрана (Mehr Fairness, weniger Probleme)
13. Хүн амын хөгжлийн зөв бодлого (Für verantwortungsvolle Bevölkerungspolitik)

Хоёр. Европыг илүү ардчилсан, илүү нийгмийн хариуцлагатай болгох (Europa demokratischer und sozialer machen)

Европын Холбоо бол эдийн засаг, улс төрийн хувьд нягтарсан, өргөн хүрээтэй, өвөрмөц тогтолцоо юм. Энэ нь Австри болон бусад гишүүн орнуудад энх тайван, эдийн засгийн амжилтыг бий болгосон. Гишүүн улс орон бүр үүнээс илүү их ашиг ирээдүйд хүртэх болно. Тийм ч учраас Европын Холбоог хагалан бутаргах, хохироох гэсэн барууны популистуудад бид зүгээр орхиж болохгүй.

Гэхдээ Европт бүх зүйл сайн сайхан биш байгаа бөгөөд, бид зөвхөн Европын төлөө байх нь хангалтгүй юм. Европт маш олон тэргүүлэх чиглэлийн буруу бодлогууд явагдсан. Татварын хямрал, томоохон корпорацуудыг тэтгэх бодлого, цалин буурч, ашиг буурах явдал газар авсан. Европын Холбооны амлалт хэвээр байгаа боловч хүн бүрийн сайн сайхны төлөө зориулагдаагүй. Үүнийг өөрчлөх хэрэгтэй. SPÖ-ийн хувьд бид хүн бүрд ямар нэгэн сайн зүйл авчрах Европын төлөө тэмцдэг. Ялангуяа ажилчид өмнөхөөсөө илүү их ашиг хүртэх ёстой, шударга ёсыг Европын улс төрийн гол цөмд буцааж тавих ёстой. Тийм ч учраас бид Европыг илүү ардчилсан, нийгмийн хариуцлагатай болгохын төлөө байна.

Бидний хувьд хүчирхэг Австри зөвхөн хүчирхэг Европын Холбооны хүрээнд оршин тогтнох ёстой гэж үзэж байна. Европын Холбоо нь эдийн засгийн нийтлэг бүс гэхээсээ илүү

нийгмийн бүхий л хэрэгцээг хангасан, хөгжих боломжтой газар байх ёстой. Европт амьдрах нь цөөхөн хүнд биш, бүх хүнд хөгжин дэвших, сайн сайхан амьдрах, шударга хариуцлагатай нийгэмтэй гэдгийг бид баталгаажуулах ёстой.

Гурав. Эдийн засгийн ул тод байдлын төлөө (Für eine gerechte Wirtschaftsordnung)

Социал демократчуудын хувьд эдийн засгийн бүхий л үйл ажиллагааны төвд хүмүүс байдаг. Хүний нэр төр, хүн төрөлхтний оршин тогтнох үйл явц нь ямагт ашиг орлогоос дээгүүр байх ёстой. Тийм ч учраас бид эдийн засгийн үйл ажиллагааг ардчилсан, эв нэгдэлд суурилсан, байгаль орчинд ээлтэй байдлаар төлөвлөж байна.

1. Бидний зорилго бол хүн бүрийн сайхан амьдралын төлөө (Unser Ziel ist ein gutes Leben für alle)
2. Бид үр ашигтай халамжийн тогтолцооны төлөө тэмцэнэ (Wir kämpfen für einen leistungsfähigen Sozialstaat)
3. Auch Roboter sollen den Sozialstaat mitfinanzieren
4. Бид баялгийн шударга хуваарилалтын төлөө тэмцэнэ (Wir kämpfen für eine gerechte Verteilung des Wohlstands)
5. Эрх мэдлийн хуваарилалт (Eine Frage der Macht)
6. Санхүүгийн зах зээлийг зохицуулах (Finanzmärkte bändigen)
7. Бага цалин болон татварын хөнгөлөлтийн эсрэг (Gegen Lohn und Steuerdumping)
8. Төсвийн хөрөнгө оруулалт нь инновац, эдийн засгийн хөдөлгөгч хүч (Öffentliche Investitionen als Motor der Innovation und der Konjunktur)
9. Эдийн засгийг дэмжигч төр (Der unternehmerische Staat)
10. Бид хүчирхэг аж үйлдвэрийг хүсч байна (Wir wollen eine starke Industrie)
11. Бид жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжинэ (Wir stärken die Klein- und Mittelbetriebe)
12. Бид Австри Улсыг гарааны бизнесийг дэмжигч тэргүүлэгч орон болгоно (Wir machen Österreich zum führenden Land für Unternehmensgründungen)

Дөрөв. Хүн бүрт сайн ажил (Gute Arbeit für alle)

Сайн ажил бол шударга цалин хөлсний тогтолцоотой, аюулгүй, утга учиртай сайхан амьдралын үндэс. Сайн ажил нь хүнийг биеэ даасан, өөртөө итгэлтэй, өөрийгөө тодорхойлох, хөгжих боломжийг олгодог. SPÖ нь: Хүн бүр сайн ажилтай, сурч боловсрох, чөлөөт цагаа өөртөө зориулах эрхтэй гэж үздэг. Бидний зорилго бол Австрийн хүн бүр өөрсдийгөө хүндэтгэж, эрхээ хамгаалдаг, сайн ажилтай байх явдал юм. Тиймээс төрөөс ард түмэнд тулгасан өдрийн 12 цаг, долоо хоногийн 60 цагийн эсрэг тэмцэж байна. Энэ тогтолцоо нь ажилчдын эрх ашигт харшилж, зөвхөн ажил олгогчдын эрх ашигт үйлчилж байна.

Нийгмийн ардчилал бол ардчилсан, саад бэрхшээлгүй, эрүүл ажиллах орчныг бүрдүүлэх учиртай. Тиймээс технологийн дэвшлийг ашиглан ажлын цагийг шударгаар хуваарилж болно. Бүтэн хөдөлмөр эрхлэлт, шударга цалин хөлсний тогтолцоо бол бидний зорилго юм. Үүний тулд дараах үнэт зүйлсийг баримтална.

1. Сайхан амьдралын төлөө ажиллах (Arbeit für ein gutes Leben)
2. Хүнлэг, шударга, эв нэгдэлтэй ажиллах орчин нөхцөлийн төлөө (Für eine humane, gerechte und solidarische Arbeitswelt)
3. Ажиллах орчин нөхцөлийг дижитал болгох нь шинэ боломжийг авчирна (Die Digitalisierung der Arbeitswelt bringt neue Möglichkeiten mit sich)
4. Хүн бүрийн хөгжил, ахиц дэвшлийн төлөө (Fortschritt für alle)
5. Нийгмийн баталгаатай ажлын шинэ хэлбэрүүд (Neue Arbeitsformen sozial absichern)

6. Бид хамтдаа хүчтэй (Gemeinsam sind wir stark)
7. Бүх нийтийн хөдөлмөрлөх эрхээр дамжуулан баталгаатай ажлын байр бий болгох (Vollbeschäftigung schaffen durch ein Recht auf gute Arbeit für alle)
8. Бид шударга цалин хөлсний тогтолцооны төлөө тэмцэнэ (Wir kämpfen für gerechte Löhne)
9. Технологийн дэвшлийг ашиглах (Den Fortschritt nützen)
10. Хагас-хагас ба багагүй цалин хөлс (Halbe-Halbe und nicht weniger)
11. Бид хүн бүрт тэгш боловсрол олгох боломжийг хүсч байна (Wir wollen Bildungsmöglichkeiten für alle)

Тав. Боловсрол бол эрх чөлөөний түлхүүр (Bildung als Schlüssel zur Freiheit)

Боловсрол бол шинэ боломжуудыг нээж өгдөг. Иймээс амжилт гаргахын тулд өөртөө урам зориг өгч, шинэ боломж гаргах ёстой. SPÖ нь боловсролыг өөрийгөө тодорхойлох амьдралын үндэс гэж үздэг. Шүүмжлэл, чөлөөт, бүтээлч сэтгэлгээний үндэс. Боловсрол нь ажил хийж, сайхан ирээдүйтэй болох боломжийг олгодог. Иймээс энэ нь хувь хүн бүрийн эрх чөлөөний түлхүүр бөгөөд ардчилсан нийгмийн ирээдүйн түлхүүр юм. Тиймээс бид хүн бүрд гарал үүсэл, өссөн орчин нөхцөлөөс үл хамааран сайн боловсрол эзэмшүүлэхийн төлөө тэмцэж байна.

Австри Улсад боловсрол өвлөгдсөн хэвээр байна. Манай улсын консерватив хүчнүүд энэ "уламжлал"-ыг хадгалахыг хүсч байгаа бол бид үүнийг өөрчлөхийг хүсэж байна. Хүн бүр нийгмийн хөгжил дэвшилд хүрэх боломжтой байх ёстой, хүн бүр үнэ төлбөргүй бүх шатны боловсрол эзэмшдэг байх ёстой. Иймээс шинэ, зөв гарцуудыг яаралтай хайх ёстой.

1. Хүн бүрт хамгийн сайн боловсрол (Die beste Bildung für alle)
2. Боловсрол бүгдээс илүү (Bildung ist mehr)
3. Сургуулийн өмнөх, бага боловсрол урьд өмнөхөөсөө илүү хэрэгтэй (Emanzipatorische Elementarpädagogik notwendiger denn je)
4. Ардчилсан, нээлттэй сургуулийн төлөө (Für eine Schule der Demokratie)
5. Бид шавь нарынхаа төлөө тэмцэнэ (Wir kämpfen für die Lehrlinge)
6. Бид насанд хүрэгчдэд ч гэсэн хамгийн сайн боловсролыг хүсч байна (Wir wollen die beste Bildung – auch für Erwachsene)
7. Насан туршийн боловсрол, бусад ур чадварыг үнэлэх (Außerschulische Kompetenzen anerkennen)
8. Нийгмийн ардчилал нь бүх нийтийн боловсролын тогтолцоог хөгжүүлэхийн төлөө байна (Die Sozialdemokratie steht für einen Ausbau der öffentlichen Bildungsinfrastruktur)
9. Бид их дээд сургууль, сургалт, судалгааг илүү сайн дэмжинэ (Wir setzen uns für die bessere Förderung der Hochschulen, der Lehre und der Forschung ein)

Зургаа. Аюулгүй байдал бол нийгмийн баталгаа (Sicherheit ist sozial)

Бидний алсын хараа бол хүн бүр мөрөөдлөө биелүүлэх боломжтой нийгмийг бүтээх юм. Хүн бүр нийгмийн хөгжил цэцэглэлт, нийтийн амгалан тайван байдлыг хангахад хувь нэмрээ оруулна. Тухайлбал, хүн бүр нэр төртэй амьдарч, хүчтэй нь сул доройгоо дэмждэг. Бидний эв нэгдэлтэй байдал нь Австри Улсыг амжилтад хүргэсэн. Төр нь тусламж хэрэгтэй байгаа ард иргэддээ дэмжлэг үзүүлдэг, хүн бүр нэгдүгээр зэрэглэлийн эмнэлгийн тусламж авах эрхтэй, тэгш боломж дээр суурилсан боловсролын тогтолцоотой улсад бид амьдарч байна.

Иймээс бидний байгуулсан эв нэгдэлтэй нийгмийг хагалан бутаргах, нийгмийн халамжийг сулруулж, хүн бүрийн эрүүл мэндэд аюул учруулах, баян хоосны ялгааг нэмэгдүүлэх гэсэн олон оролдлогын эсрэг SPÖ бүхий л хүчээрээ тэмцэж байна.

Нийгмийн хамгаалал гэдэг нь ядуурал, хомсдол, ажилгүйдлээс ангижрах гэсэн утгатай. Бидний зорилго иргэдэд нэр төртэй амьдралыг бий болгож, мөрөөдлөө биелүүлэх боломжийг бий болгоход чиглэдэг.

1. Бид эрх чөлөөтэй, бие даан амьдрахын төлөө тэмцдэг (Wir brennen für das Ideal eines freien und selbstbestimmten Lebens)
2. Бид хүн бүрт чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүсч байна (Wir wollen eine erstklassige Gesundheitsversorgung für alle)
3. Бид нэр төртэй, оршихуйн айдасгүй хөгшрөлтийн төлөө тэмцдэг (Wir kämpfen für ein Altern in Würde und frei von Existenzängsten)
4. Бид баталгаатай тэтгэврийн тогтолцооны төлөө ажилладаг (Wir garantieren sichere Pensionen)
5. Орлогын доод хэмжээг тогтооно (Das Mindeste sichern)
6. Аюулгүй байдлыг хангах (Sicherheit geben)
7. Аюулгүй байдлыг хангах нь олон нийтийг хамгаалах үүрэг хариуцлага юм (Sicherheit ist eine öffentliche Aufgabe)
8. Ард түмэнд ойр ардчиллыг төлөвшүүлэх (Demokratie bürgernah gestalten)
9. Хуулийн өмнө хүн бүрийн тэгш байдлыг хангах (Gleichheit vor dem Gesetz und durch das Gesetz muss garantiert sein)
10. Шүүхэд хандах боломжийг олгох, хөнгөвчлөх (Zugang zum Recht erleichtern)

Долоо. Хот ба хөдөө (In Stadt und Land)

Бидний зорилго нь хот, хөдөөгийн ялгаа, аливаа боломжийн зөрүүг нэмэгдүүлэхгүй байхад чиглэнэ. Нийслэл хоттой харьцуулахад хөдөө орон нутгийн хөгжил бага тул түүнийг хөгжүүлэхийн тулд зөв бодлого, юуны түрүүнд дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

1. Хүн бүрт тэгш нөхцөл (Gleiche Voraussetzungen für alle)
2. Орон сууцтай болох нь хүний эрх бөгөөд боломжийн үнэтэй байх ёстой (Wohnen ist ein Menschenrecht – und muss leistbar sein)
3. Амьдрах орон зай ба татвар (Jede Spekulation mit Wohnraum und Fördermitteln ist zu unterbinden)
4. Социал демократууд бид хямд үнээр нийтийн тээвэр, дэд бүтцийг хөгжүүлэхийг дэмжиж байна (Wir Sozialdemokratinnen und Sozialdemokraten treten für den Ausbau von leistbaren öffentlichen Verkehrsmitteln und Infrastruktur ein)
5. Спортыг бүх нийтэд хүртээмжтэй болгох (Mehr Lust am Sport)
6. Сайн дурын клубыг дэмжих, идэвхтэй амьдрал (Für ein aktives Vereinsleben und ein starkes Ehrenamt)

Найм. Дэлхийг хамгаалах нь бидний үүрэг (Die Pflicht zur Erhaltung unseres Planeten)

Австрийн нийгмийн ардчилал экологийн асуудлыг эртнээс чухалчилж ирсэн боловч ач холбогдлыг нь тэргүүн эгнээнд тавьж байсангүй. Байгаль-экологи болон эдийн засагт асуудал тулгарсан тохиолдолд эдийн засгийн өсөлтийг нэн тэргүүнд тавьдаг.

Бид экологийн тогтвортой байдалд чиглэсэн, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн өөрчлөлт хийж бусад хандлага чиглэлээс ялгарах болно. Иймээс дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд бид хамгийн их ач холбогдол өгч анхаарах, арга хэмжээ авах ёстой.

1. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн хямрал нь экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахаас гадна нийгмийн тэгш бус байдлыг ихэсгэнэ (Die Klimakatastrophe hinzunehmen ist nicht nur aus ökologischen Gründen fatal, sondern auch eine soziale Ungerechtigkeit)

2. Дэлхий нийтээрээ орон нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагааг сайжруулахыг хүсч байна (Globale Verantwortung erfordert lokales Handeln)
3. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгаль орчныг хамгаалах нь нийгэмдээ оруулж буй хувь нэмэр юм (Klima- und Umweltschutz tragen zu einer gleichberechtigten Gesellschaft bei)
4. Gemeingüter fördern heißt weniger verbrauchen
5. Байгаль орчноо хамгаалах нь нийтийн сайн сайхан төлөө юм (Umwelt ist ein öffentliches Gut)
6. Эрчим хүчний зохистой хэрэглээ (Verantwortungsvoller Umgang mit Energie)
7. Бидний зорилго бол чулуужсан шаталтат хөдөлгүүрээс уур амьсгалд ээлтэй хөдөлгүүрт шилжих явдал юм (Unser Ziel ist ein Umstieg von fossilen Verbrennungsmotoren auf alternative klimafreundliche Antriebsformen)
8. Бид хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой байлгахыг хүсч байна (Wir wollen eine nachhaltige Lebensmittelproduktion)
9. Бид экологи, нийгмийн шалгуурт нийцсэн хөдөө аж ахуйг дэмжиж байна (Wir bekennen uns zu einer gerechten und transparenten Landwirtschaftsförderung, die an ökologische und soziale Kriterien gebunden ist)
10. Бид амьтдад хандах хандлагаа өөрчлөхийн төлөө байна (Wir stehen für einen nachhaltigen Wandel unseres Umgangs mit Tieren)

Ес. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах (Die Gleichstellung der Geschlechter)

Жендэрийн эрх тэгш байдал нь шударга ёс, хүний нэр төртэй холбоотой асуудал. Улс төрийн эрх мэдэл, нөлөөлөл, шийдвэр гаргах түвшинд тэгш оролцоотой байх нь манай орчин үеийн соёлт нийгэмд байх зүй ёсны хэрэг бөгөөд ижил төрлийн ажил хөдөлмөр эрхэлж, ижил орлоготой байх зэрэг үндсэн зарчмыг баримтлах ёстой. Үүнийг бий болгохын тулд хийх зүйл их байна.

1. Viele offene Baustellen.
2. Хууль, эрх зүйн хувьд тэгш бус байна (Rechtlich gleich, praktisch nicht)
3. Auf halbem Weg
4. Бид хүйсийн тэгш бус байдлын төлөө, ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцдэг (Wir kämpfen für die Gleichstellung der Geschlechter und gegen Diskriminierungen)
5. Halbe-Halbe.
6. Бид лесби, гей, бисексуал, трансжендер, интерсекс, асексуал зэрэг бэлгийн цөөнх хүмүүсийн эрхийг хамгаалахын төлөө тэмцдэг (Wir kämpfen für die völlige Gleichstellung von Lesben, Schwulen, Bisexuellen, Transgender, Intersexuellen, Queer und Asexuellen)
7. Бие биенээ хүндэлдэг нийгмийг бүтээнэ (Eine Gesellschaft des wechselseitigen Respektes)

Араг. Эв нэгдлийг бэхжүүлэх нь (Das Miteinander stärken)

Австри Улс нь амьдарч буй хүн бүрийн хувьд гэр орон шиг нь байж чадаж байна уу гэдэгт хамгийн эхэнд хариулах ёстой. Үүний тулд дараах зүйлд анхаарах ёстой.

- 1) Бид хүн бүр аз жаргалтай зэрэгцэн амьдардаг, эв нэгдэлд суурилсан нийгмийг хүсч байна (Wir wollen eine solidarische Gesellschaft, in der alle an einem guten Zusammenleben mitwirken)
- 2) Бид хүн бүрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг эрхэмлэнэ (Wir setzen uns für die volle Freiheit des Denkens und Glaubens ein)
- 3) Eine umfassende Integrationspolitik
- 4) Ялгаварлан гадуурхахгүй нийгмийн төлөө (Für eine Gesellschaft ohne Diskriminierung)

- 5) Суурь үндэс (Die gemeinsame Basis)
- 6) Иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих (Für ein breites zivilgesellschaftliches Bündnis)
- 7) Ängste beim Namen nennen

Арван нэг. Нээлттэй дижитал нийгэм ба урлагийн эрх чөлөө (Die offene Digitalgesellschaft und die Freiheit der Kunst)

Шинэ дижитал технологи, урлаг, соёл нь асар их боломжийг олгодог. Иргэд нийгмийг илүү нээлттэй, ардчилсан, шударга болгоход тусалж чадна. Тэд хүмүүсийн бүтээлч чадавхыг хөгжүүлэх боломжийг олгох ёстой. Харин бид урлагийн болон хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах, уран бүтээлчдийн нийгмийн баталгааг хангах, хүн бүрд нээлттэй, харилцан хүндэтгэл, харилцан ойлголцлыг дэмжсэн урлаг, соёлын бодлогыг хэрэгжүүлэх гэсэн шинэ зорилтоо биелүүлэхэд чиглэж ажиллах ёстой.

1. Дижиталчлалыг ашиглацгаая (Nutzen wir die Digitalisierung)
2. Дижитал эрин үед ардчиллыг баталгаажуулах (Demokratie im Digitalzeitalter sichern)
3. Хүн бүрт зориулсан өндөр хурдны интернэт (Breitband für alle)
4. Бид өөрсдийн хувийн нууцыг хамгаалах эрхийн төлөө тэмцэнэ (Wir kämpfen für Selbstbestimmung und das Recht auf Privatsphäre)
5. Монополийн эсрэг (Gegen neue Monopole)
6. Цахим сүлжээний аюулгүй байдлыг хангах (Netzneutralität sichern)
7. Дижитал нийгмийн сөрөг талуудтай тэмцэх (Die Schattenseiten der Digitalisierung bekämpfen)
8. Бид хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэнэ (Wir setzen uns für die freie Information ein)
9. ORF нь Австри Улсын төрийн үйлчилгээний хэрэгслийн хувьд зайлшгүй шаардлагатай (Der ORF ist als öffentlich-rechtliches Medium für Österreich unverzichtbar)
10. Хэвлэл мэдээллийн олон ургальч байдлыг дэмжих (Medienvielfalt fördern)
11. Зохиогчийн эрх (Zeitgemäßes Urheberrecht)
12. Урлаг, соёл нь эрх чөлөөг бэхжүүлж, дэлхий ертөнцийг ойлгоход тусалдаг (Kunst und Kultur stärken die Freiheit und helfen uns, die Welt zu verstehen)
13. Соёлын боловсрол, соёлын зуучлал (Kulturelle Bildung und Kulturvermittlung von Anfang an)
14. Бид уран бүтээл туурвих, урлагийн үйл ажиллагааг дэмжинэ (Wir fördern künstlerisches Schaffen und die Auseinandersetzung mit Kunst)
15. Урлаг, соёлын ажилтны нийгмийн баталгааг хангана (Kunst- und Kulturschaffende sozial absichern)

3.2.2. Австрийн Ардын намын үндсэн хөтөлбөр

Австрийн Ардын нам (Österreichische Volkspartei-ÖVP) нь Австрийн баруун төвийн үзэл баримтлалтай улс төрийн нам юм. Дэлхийн II дайн дууссанаас хойш Австрийн улс төрд томоохон байр суурь эзэлсээр ирсэн бөгөөд олон тооны эвслийн засгийн газарт орж байсан.

2021 оны 12 дугаар сараас намыг Карл Нехаммер (Karl Nehammer) түр удирдаж байна. Одоогийн байдлаар Австрийн Парламентын доод танхим болох болон Үндэсний зөвлөлийн 183 суудлын 71-ийг нь авсан парламент дахь хамгийн том нам бөгөөд 2019 оны парламентын сонгуульд нийт сонгогчдын 37.5 хувийн санал авчээ. Тус нам нь бүх есөн муж улсын хууль тогтоох байгууллагад суудалтай бөгөөд долоод нь Засгийн газрын бүрэлдэхүүнд, зургаад нь муж улсын Засгийн газрыг тэргүүлдэг. ÖVP нь Олон улсын ардчилсан холбоо, Европын Ардын нам (EPP)-ын гишүүн, Европын парламент дахь EPP

бүлэгтэй хамтран ажилладаг бөгөөд Австрийн Европын Парламентын 19 гишүүний 7 нь ÖVP-ын гишүүн байна.

Үүсэл хөгжил: Австрийн Ардын нам нь 1945 онд Дэлхийн II дайны дараа, нацист дэглэмийн төгсгөлд албан ёсоор байгуулагдсан бөгөөд Австри дахь дайны өмнөх консерватив улс төрийн нам байсан Христийн нийгмийн намаас үүссэн. ÖVP дайны дараа шинэ, ардчилсан Австри Улсыг байгуулах зорилготой байсан бөгөөд тус улсын шинэ Үндсэн хуулийг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

ÖVP өнгөрсөн жилүүдэд үзэл суртлын хувьд ч, бодлогын тэргүүлэх чиглэлийн хувьд ч хувьсан өөрчлөгдөж ирсэн. Энэ нь Католик сүм болон консерватив үнэт зүйлсийг голлон баримжаалж байснаас баруун төвийн үзэл баримтлалыг өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд чиглэсэнтэй холбоотой юм.

ÖVP нь эвслийн засгийн газарт байнга оролцож, Австрийн Социал Демократ Нам (SPÖ), Австрийн Эрх чөлөөний нам (FPÖ) зэрэг бусад намуудтай хамтран ажилладаг. Тус намын бодлого, хөтөлбөрийн онцлогт эвслийн улс төрийн динамик нөлөөлсөн байдаг.

Баримталж буй бодлого: Австрийн Ардын нам олон жилийн турш баруун төвийн чиг баримжаагаа тусгасан олон төрлийн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжсээр ирсэн. Австрийн Ардын намын баримталж буй гол чиглэлүүд:

1. Эдийн засгийн бодлого: ÖVP нь чөлөөт зах зээлийн эдийн засгийн бодлогыг дэмжихийн сацуу нийгмийн хариуцлага, халамжийн арга хэмжээг чухалчилдаг. Эдийн засгийн өсөлтийг нийгмийн тэгш байдлыг хангахтай тэнцвэржүүлэхийг зорьсон.
2. Европын интеграци: ÖVP нь Европын интеграцлал, Австри Улсыг Европын Холбоонд элсүүлэхийг дэмжиж ирсэн. Европын нэгдсэн бодлогыг дэмжсэн байр суурийг илэрхийлж ирсэн.
3. Гэр бүлийн үнэ цэнэ ба нийгмийн бодлого: ÖVP түүхэндээ гэр бүлийн үнэ цэнэ, нийгмийн эв нэгдлийг чухалчилж ирсэн. Гэр бүл, боловсрол, нийгмийн халамжийг дэмжих бодлогыг дэмжиж ирсэн.
4. Хууль дэг журам: ÖVP нь олон нийтийн аюулгүй байдал, аюулгүй байдалтай холбоотой бодлого зэрэг хууль, эрх зүйг хамгаалах байр суурийг баримталж ирсэн.
5. Байгаль орчин, эрчим хүчний бодлого: Сүүлийн жилүүдэд ÖVP нь байгаль орчин, эрчим хүчний асуудалд илүү анхаарч, тогтвортой үйл ажиллагааг сурталчлах, уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд анхаарч байна.
6. Цагаачлал ба интеграци: Цагаачлал ба интеграцлалын талаарх намын байр суурь нь Австрийн нийгэм дэх эдгээр асуудлын эргэн тойронд өрнөж буй мэтгэлцээнүүдийг тусгаж, цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж ирсэн.
7. Татвар ба төсөв: ÖVP тэнцвэртэй төсөв, хариуцлагатай төсвийн бодлого, төсвийн сахилга батыг хэрэгжүүлэхийг дэмжсэн бодлого хэрэгжүүлдэг.

Бодлогын баримт бичгүүд:

- 1945 он - Үндсэн хөтөлбөр (15 үндсэн зарчим)
- 1972 он - Зальцбургийн хөтөлбөр
- 1985 он - Ирээдүйн Тунхаг бичиг
- 1995 он - Үндсэн хөтөлбөр
- 2015 он - Шинэ үндсэн хөтөлбөр “New People's Party”

Австрийн Ардын намын 2015 оны бодлогын хөтөлбөр (Grundsatzprogramm 2015):¹²¹

¹²¹ https://www.dievolkspartei.at/Files/Grundsatzprogramm_dieVolkspartei.pdf

I Нэг: Бидний зарчим

II Бид хэн бэ: Хүн төрөлхтний талаарх төсөөлөл, бидний өөрийн талаарх төсөөлөл

III Бидний хүсэж буй зүйл: Бидний зорилго, анхаарал хандуулж буй асуудал

- Ардчилал ба төр: Оролцоо их, хүнд суртал бага
- Эко-нийгмийн зах зээлийн эдийн засаг: Хүн бүрд хөгжил цэцэглэлт, ирээдүй
- Нийгэм ба хойч үе: Сонгох эрх чөлөө, тэгш боломжуудын төлөө
- Амьдрал ба орчин: Амьдрахад үнэ цэнтэй Австри
- Боловсрол, соёл: Шинэ боломж, шинэ хэтийн төлөв
- Европ ба дэлхий: Австрийн загвар

Нэг: Бидний зарчим

Төр иргэдийн төлөө байдаг ба эсрэгээрээ биш.

Бид хувь хүний эрх чөлөө, хувийн хариуцлагын төлөө, тэдний эрхийг бэхжүүлэхийн төлөө зогсдог. Бид хариуцлагатай иргэний нийгмийн нэг хэсэг болох иргэдийг хүрээлэн буй орчин, холбооны муж, Австри, Европ дахь амьдралтай холбоотойгоор илүү их шийдвэр гаргах боломжоор хангахыг хүсэж байна. Төрийн үйл ажиллагаа иргэдэд үйлчилж, сонгох эрх чөлөөг дээд зэргээр хангах ёстой.

Бид хүмүүст яаж амьдрахыг заагаагүй.

Бид чиг баримжаа олгохыг санал болгож байна.

Хүмүүс амьдралаа хэрхэн тодорхойлох, ямар амьдралын төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь тэдний чөлөөт сонголт юм. Христийн ардчилсан намын хувьд бид амжилттай амьдрал, амжилттай нийгмийн баримжаа олгохыг хүсэж байна. Хүүхэдтэй гэр бүлүүд (төрөл бүрийн хэлбэрээр) нь нийгмийн ирээдүйд зайлшгүй шаардлагатай байдаг тул бидний үндсэн зарчим юм. Бид гэр бүлд ээлтэй нийгмийн төлөө ажилладаг. Хүүхдүүдийн сайн сайхан байдал нь бусад бүх ашиг сонирхлоос дээгүүрт тавигддаг. Мөн бид иргэдийн нийгмийн амьдралд хариуцлагатай, идэвхтэй оролцохыг уриалж байна.

Бид нийгэмд байгаа хүн бүрийг үүрэг даалгавар хүлээсэн гэж үздэг. Мөн манай нийгэм, түүний үнэт зүйлсийг хүндэтгэнэ гэж найдаж байна.

Хүн бүр амьдрахад үнэ цэнтэй нийгэмд хувь нэмрээ оруулах боломжтой: гэр бүл, ажил, клуб болон бусад сайн дурын үүрэг амлалтаар. Энэ нь улс оронд хүчтэй ардчилал, бие биеэ хүндэтгэх, эв нэгдэлтэй байх урьдчилсан нөхцөл учраас бид олон нийтийн өмнө хүлээх хариуцлагыг чангатгахыг хүсэж байна. Үндсэн хуульд заасан нийгмийн үнэт зүйлс, улмаар манай зонхилох соёлыг үндсээр нь үгүйсгэдэг хэн бүхэн тэдний ололт амжилтаас ашиг хүртэх ёсгүй.

Бид эко нийгмийн зах зээлийн эдийн засгийн нам.

Учир нь бизнес эрхлэх сэтгэлгээ, гүйцэтгэлгүйгээр тогтвортой хөгжил цэцэглэлт, нийгмийн баталгаа байхгүй.

Ажилтан, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засгийн гүйцэтгэл нь манай нийгмийн загварын үндэс суурь болдог. Бид тэднийг шийтгэхийг биш харин урамшуулахыг хүсэж байна. Эко-нийгмийн зах зээлийн эдийн засгийн эдийн засаг, нийгмийн загвар нь эдийн засгийн хамгийн их эрх чөлөө, гүйцэтгэлийг нийгэм, экологийн тогтвортой байдалтай хослуулдаг. Бизнесийн сэтгэлгээ, үйлдэл нь нийгмийн бүхий л салбарт бидэнд тусалдаг. Хөдөлмөр, хуримтлал нь үнэ цэнтэй байх ёстой. Бид нийгмийн дэвшил, тэгш боломж, өмч хөрөнгөтэй болох явдлыг дэмжихийг хүсэж байна. Өмчлөх нь

тусгаар тогтнол, эдийн засгийн эрх мэдлийн түлхүүр юм. Бидний зорилго бол нийгэмд хүчирхэг, өргөн хүрээ бүхий дундаж давхарга юм.

Австрийн Ардын намын хувьд бид европ маягаар сэтгэж, ажилладаг.

Яагаад гэвэл илүү сайн Европ нь Австрийн хувьд илүү эрхэм юм.

1955 онд Австри Улсын гэрээ байгуулж, 1995 онд Австри Улс Европын Холбоонд элсэхэд бид хөдөлгөгч хүч болж байсан. Австрийг хайрлах, нэгдмэл Европын төлөөх урам зориг хоёр эсрэг тэсрэг зүйл биш юм. Бид Европыг хариуцлагатайгаар хөгжүүлж, гүнзгийрүүлэхийг хүсэж байна, учир нь энэ нь Австрийн хувьд ч ашигтай. Европ нь мужууд, улс орнууд дангаар шийдэж чадахгүй байгаа томоохон асуудлуудыг илүү шийдвэрлэх ёстой. Зорилго нь нэгдмэл, ардчилсан, аюулгүй Европыг дэлхийд хүчирхэг болгох явдал юм.

Хоёр: Бид хэн бэ: Хүн төрлөхтний талаарх бидний төсөөлөл, өөрсдийн талаарх бидний төсөөлөл

Хүн төрлөхтний талаарх бидний төсөөлөл

Манай улс төрийн үндэс нь Христийн-хүмүүнлэгийн хүний дүр төрх юм. Угаасаа хүн бүр амьд явах, чөлөөтэй хөгжих салшгүй эрхтэй. Хүний эрх чөлөө, хувь хүн өөрөө өөрийгөө тодорхойлох, нийгмийн оролцоотой байх эрх нь бидний хувьд салшгүй эрх бөгөөд үл маргахгүй. Хүн, хүний нэр төрийг хүндэтгэх нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхэд тусгалаа олсон төдийгүй Австри, Европын тэргүүлэх соёлын үндэс суурь, манай улс төрийн сэтгэлгээ, үйл ажиллагааны эхлэлийн цэг юм.

Хүний нэр төр нь амьдралын бүхий л үе шатанд халдашгүй бөгөөд нас, арьсны өнгө, хүйс, онцлог, чадвар, нөхцөл байдал, нөхцөл байдлаас үл хамааран хүн бүрд хамаарах бөгөөд энэ нь хүн байхын үр дагавар юм. Иймд хүний нэр төрийг алдаршуулсан, үгүйсгэсэн нөхцөл байхгүй. Хүн өөрийнхөө төлөө хариуцлага хүлээдэг, мөн өөрийнх нь төлөө хариуцлага хүлээдэг нийгэмд нэгдсэн байдаг. Хүний хамгийн анхны бөгөөд хамгийн чухал хүрээлэл бол гэр бүл юм. Хүмүүсийн хариуцлага хүлээх нийгэмлэгүүд нь шашин, соёл, нийгэм, улс төр, эдийн засгийн нийгэмлэгүүд юм. Хариуцлагатай үйлдэл, бүтээлч сэтгэлгээ, шүүмжлэлтэй тусгал нь хүний бодол санаа, үйл ажиллагааны шинж чанарыг тодорхойлдог.

Бид эрх чөлөө, хариуцлага, тогтвортой байдал, гүйцэтгэл, эв нэгдэл, бие биедээ туслах/эрх үүргийг хуваарилах, шударга ёс гэсэн хүн төрөлхтний дүр төрхөөс улс төрийн сэтгэлгээ, үйл ажиллагааныхаа үндсэн үнэт зүйлсийг олж авдаг. Амжилттай амьдрал, амжилттай нийгмийн чиг баримжааг бид санал болгож байна.

Хүний төгс бус байдал, аливаа зүйлийг төлөвлөх, хэлбэржүүлэх чадварын хязгаарлагдмал байдал нь улс төрд ч гэсэн хязгаарлалт тавьдаг гэдгийг бид мэднэ. Ийм учраас ч гэсэн үзэл суртлын хэт туйлшрал, улс төрийн тоталитар ойлголт Ардын намд байхгүй.

Эрх чөлөө

Хүн бүр эрх чөлөөтэй хүн тул үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг. Эрх чөлөө гэдэг нь хүн бүрийн дотоод сэтгэл, ухамсарт тулгуурлан өөрийгөө тодорхойлохыг хэлнэ. Эрх чөлөө нь нийгэмд бий болдог: нэгнийх нь эрх чөлөө нөгөөгийнх нь эрх чөлөө эхэлдэг газар дуусдаг. Либерал үндсэн хуульт улсын хамгийн чухал үүрэг бол хүний эрх чөлөөг хамгаалах явдал юм. Бид төрийн патернализм аливаа хэлбэрийн эсрэг, хувийн эрх чөлөөний илэрхийлэл болох хувийн өмчийг тууштай хамгаалахын төлөө зогсдог. Эрх чөлөө, өмчийн эрх, хувийн нууцыг мөн технологийн хөгжлийг харгалзан баталгаажуулж, цаашид хөгжүүлэх ёстой.

Хариуцлага

Хариуцлагагүй эрх чөлөө гэж байхгүй. Эрх чөлөөгөөрөө хүн өөрийнхөө болон нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг. Хувийн амьдрал, ажил, нийгэм, улс төрд нухацтай хандаж байж ирээдүйн сорилтыг шийдэж чадна. Хариуцлага хүлээлгэдэггүй, хүлээж авдаг идэвхтэй иргэний нийгмийг бид дэмжиж байна. Нийгмийн хариуцлагын мэдрэмж, аливаа зүйлийг хэлбэржүүлэх, өөрчлөх хүсэл хоёр зэрэгцэн оршдог. Юуны өмнө бид хүмүүсийн өөрсдийнхөө асуудлыг зохицуулах чадварт итгэдэг.

Эв нэгдэл

Эв нэгдлийн үнэ цэнэ нь хүн төрөлхтний хувьд бидний харилцан хамаарлын талаарх мэдлэг дээр суурилдаг бөгөөд Христийн шашны энэрэлд тусгалаа олдог. Бид хүн бүрийн чадвараас үл хамааран үүрэг даалгавар хүлээж, нийгэмд байр суурь эзэлнэ гэж үздэг. Хамт олны тусламж хэнд хэрэгтэй байна, тэр тусламжийг авах хэрэгтэй. Эв нэгдэл бол төрийн онцгой үүрэг биш. Хувь хүний хангамж, төрийн баталгаатай эв нэгдэл тэнцвэртэй байх ёстой. Эв нэгдэл бол зөвхөн нэг урсгалтай биш. Зөвхөн нийгмийн үйлчилгээ авах ёстой хүмүүстэй эв нэгдэлтэй байх нь бидний хувьд чухал төдийгүй нийгмийн үйлчилгээг санхүүжүүлж, үзүүлж буй хүмүүс мөн чухал юм. Хувь хүн ганцаараа хүрч чадахгүй зүйлээ л хамт олноос шаардаж болно. Бид бүх салбарт авагч, ашигч сэтгэлгээг үл тэвчинэ. Үндсэн хуульд заасан нийгмийн үнэт зүйлсийг үндсээр нь эсэргүүцэж байгаа хэн бүхэн тэдгээрээс олж авсан эв нэгдлийн үр шимийг хүртэх ёсгүй.

Туслах/эрх үүргийг хуваарилах

“Subsidiarity” гэдэг нь хувийн хариуцлага, жижиг нэгжид тэргүүлэх ач холбогдол өгөхийг хэлнэ. Хувь хүмүүс болон жижиг бүлгүүд өөрсдийн асуудлаа аль болох бие даан шийдвэрлэх боломжоор хангагдах ёстой. Томоохон нэгжүүд зөвхөн тэдний хийж чадах үүрэг, эрх мэдлийг авах ёстой. Subsidiarity нь практик шийдлүүдийг дэмжиж, дээд түвшний нэгдэл болон төрийн ачааллыг хөнгөвчилдөг. Тиймээс орон нутаг, бус нутаг, үндэсний, европ, олон улсын түвшинд үүрэг даалгаврыг хуваарилахдаа туслах зарчмыг баримтлах ёстой. Тийм ч учраас бид тусгаар тогтносон улс орон, үр ашигтай хамтын нийгэмлэгийн төлөө зогсдог. Subsidiarity бол нийтлэг Европ дахь гол үнэт зүйл юм. Энэ нь мөн Европын Холбоон дахь төвлөрсөн үзэл/хандлагын эсрэг баталгаа юм.

Шударга ёс

Шударга ёсны үндэс нь хүмүүсийн нэр төр, эрх чөлөөгөөр тэгш эрхтэй байх явдал юм. Бүх хүмүүс хуулийн өмнө тэгш эрхтэй бөгөөд шударга ёсыг тэгш хүртэх ёстой. Хүмүүс өөрсдийн авъяас чадвар, сонирхлоороо ялгаатай байдаг. Энэ бол хүний өвөрмөц, дахин давтагдашгүй байдлын илэрхийлэл юм. Бидний хувьд хамгийн том сорилт бол бүх хүмүүст тэгш боломж олгох явдал юм. Бид тэгш үр дүн амлахгүй, шударга боломжийн төлөө ажилладаг. Бид бүх түвшинд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрхийн төлөө зогсдог.

Бид бол орчин үеийн ардчиллын нам. Хариуцлагатай иргэний нийгмийн нэг хэсэг болох иргэд өөрсдийн хүрээлэн буй орчин, холбооны муж, Австри, Европ дахь амьдралынхаа талаар илүү их шийдвэр гаргах боломжоор хангахыг бид хүсч байна. Тийм ч учраас бид төлөөллийн ардчиллын туршигдсан тогтолцоог хамтын шийдвэр, оролцооны орчин үеийн хэлбэрүүдээр баяжуулж, улс төрийн боловсрол, сайн дурын үйл ажиллагааг дэмжмээр байна.

Бид бол улс төр, нийгмийн төвийн нам. Бид даруу, ухаалаг улс төрийн соёлыг дэмждэг. Бид аливаа хэлбэрийн хэт даврах үзлийг үгүйсгэдэг. Бидний зорилго бол Австри дахь улс төр, нийгмийн хамгийн хүчирхэг төв юм. Энэ нь Австри Улсын тогтвортой, тогтвортой хөгжлийн хамгийн сайн үндэс суурь юм.

Бид энтрепренер сэтгэлгээ, үйл ажиллагааны нам. Энэ нь асуудлыг илүү сайн шийдвэрлэх, нөөцийг илүү үр ашигтай ашиглах, улмаар манай нийгмийн бүхий л салбарт маневр хийх орон зайг нэмэгдүүлэх болно гэдэгт бид итгэлтэй байна. Ажиллаж, хуримтлал үүсгэх нь ирээдүйг баталгаажуулж, ажилчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд үнэ цэнтэй байх ёстой. Бид нийгмийн дэвшил, тэгш боломж, өмч хөрөнгөтэй болох явдлыг дэмжихийг хүсэж байна. Хүчирхэг эдийн засаг л хөдөлмөрлөх, нийгмийн хамгааллын үндэс суурь болдог.

Ардын намын хувьд бид нийгмийн интеграцийн нам. Бид нийгэм дэх янз бүрийн ашиг сонирхол, санаа зовоосон асуудлуудыг нэгтгэж, нийтлэг эрх ашгийн төлөө шударга тэнцвэртэй байдлын төлөө ажилладаг. Үүнийг бодолцож, салбар байгууллагууд болон улс төрийн оролцооны бусад хэлбэрийг ч зорилтот түвшинд хөгжүүлмээр байна.

Эко-нийгмийн зах зээлийн эдийн засгийн нэг намын хувьд бид эдийн засаг, нийгмийн тогтвортой дэг журмыг баримталдаг. Эко-нийгмийн зах зээлийн эдийн засаг нь инновацын хүч, өсөлт, хөгжил цэцэглэлт, нийгмийн аюулгүй байдлыг тогтвортой, уур амьсгалд ээлтэй, байгаль орчинд ээлтэй хөгжилд нийцүүлэх зөв тогтолцоо, хөшүүргийг бий болгодог. Бид эко-нийгмийн зах зээлийн эдийн засгийг Европ болон дэлхийн улс төрийн анхдагч загвар болгон идэвхтэйгээр төлөөлдөг.

Бид Австрийн гэр бүлийн нам. Хүүхдүүдийн сайн сайхан байдал нь бусад бүх ашиг сонирхлоос дээгүүрт тавигддаг. Бидний баримтлах зарчим бол хүүхэдтэй гэр бүл (аав, ээж, хүүхэд) нь нийгмийн үндэс суурь, гол цөм болох үе удам бие биеэ халамжилдаг. Гэхдээ бид хүмүүст яаж амьдрахыг заагаагүй. Тиймээс бид бие биенийхээ төлөөх үүрэг хариуцлага, анхаарал халамжийг хуваалцаж, тогтвортой, хариуцлагатай нийгэмд хувь нэмэр оруулдаг хосолсон гэр бүл, ганц бие эцэг эх, ижил хүйстний нөхөрлөл гэх мэт хамтын амьдралын бусад хэлбэрийг хүндэтгэж, хүлээн зөвшөөрдөг.

Одоо болон ирээдүй хойч үеийнхээ өмнө хариуцлага хүлээсэн учраас бид өөрсдийгөө шинэчлэл, шинэтгэлийн нам гэж харж байна. Төр, нийгмийн институцыг цаг тухайд нь, урьдчилан таамаглах боломжтой цаашдын хөгжил, өөрчлөгдсөн нөхцөл байдалд дасан зохицох нь өөрөө зорилго биш юм. Бид бүх үеийнхэнд сайн, чухал зүйлийг хадгалах хариуцлагадаа хөтлөгдөн өөрчлөгддөг. Энэ нь бидний шударга ёсны талаарх ойлголттой бас нийцдэг.

Бид Австри Улсын дижитал ертөнцийн боломжийг идэвхтэй бүрдүүлэхийг хүсэж буй нам юм. "Бодит" болон "дижитал" ертөнцийн хооронд ямар ч ялгаа байхгүй. Дижиталчлал нь орчин үеийн амьдралын өөр нэг хэмжээс юм. Энэ бол бидний цаг үеийн инновацын хөдөлгүүр юм. Амьдралын бүхий л салбарт дижитал нэвтрэлт дөнгөж эхэлж байна. Энэ нь нийгэм, боловсрол, шинжлэх ухаан, бизнес, улс төрд цоо шинэ сорилтуудыг бий болгож байна гэсэн үг. Бид эдийн засгийн тогтвортой өсөлт, амьдралын чанар, хүний хөгжлийг хангах дижиталчлалын онцгой боломжуудыг бодлогынхоо төвд тавьдаг. Австри Улс ажиглагч биш, харин дижитал ертөнцөд тоглогч байх ёстой. Иргэд дижитал ертөнцийн чадварлаг дизайнерууд байх ёстой. Эрх чөлөө, хариуцлага, аюулгүй байдал, өмч гэх мэт нийгмийн дэг журмын үндсэн дүрэм, үнэт зүйлсийг дижитал ертөнцөд ч хангуулахыг бид зорьж байна.

Австрийн намын хувьд бид хот, хөдөөгийн төлөөх бодлого баримталдаг. Хот, хөдөөгийн бүс нутаг бидний хувьд ижилхэн гэр орон, өвөрмөц байдал, ирээдүй, үнэт зүйлс, шинэ замуудын газар юм. Бид хот, хөдөөгийн ашиг сонирхлыг түншлэлд суурилсан тэнцвэртэй байлгахыг эрхэмлэдэг.

Бид Австрийн Европын нам. 1955 онд Австрийн Төрийн гэрээ байгуулж, 1995 онд Австри улс Европын Холбоонд элссэний гол хөдөлгөгч хүчний хувьд нэгдсэн Европ бол Австри

Улсын энхтайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн ирээдүйн хамгийн сайн баталгаа гэдгийг бид мэднэ. Бид Европын бодлогын бүхий л чадвар, хүч чадлаараа дэлхийд хүчирхэг, ардчилсан, хариуцлагатай, аюулгүй Европын төлөө ажилладаг.

Бид Христийн шашны болон бусад үнэт зүйлсийн эх сурвалжийн үндсэн дээр хүн төрөлхтний дүр төрх, бидний үнэт зүйлсийг эрхэмлэдэг бүх хүмүүст нээлттэй. Хүн хаанаас ирсэн нь чухал биш, хүн юуны төлөө зогсож, зүтгэх нь чухал. Бид Австри Улсад олон янз байдлын санал болгож буй боломжуудыг хамгийн сайн ашиглахыг хүсэж байна. Иргэдийг эх орон, ард түмэн, ирээдүйнхээ төлөө хамтдаа хариуцлага хүлээхийг уриалж байна. Яагаад гэвэл бид Ардын нам.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Chukhal%20sedev_Political%20Party-1.pdf
- <https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/politics-meets-policies-the-emergence-of-programmatic-political-parties-pdf.pdf>
- ГСДН-ын албан ёсны веб хуудас: <https://www.spd.de>
- ХБНГУ-ын Улс төрийн намын тухай хууль: https://www.bmi.bund.de/SharedDocs/downloads/DE/gesetzestexte/Parteiengesetz_PartG_engl_042009.pdf?__blob=publicationFile&v=2
- ХБНГУ-ын Бундестаг: <https://www.bundestag.de/en/parliament/plenary/distributionofseats>
- ГСДН-ын Үндсэн хөтөлбөрүүд: <https://www.spd.de/programm/grundsatzprogramm>
- ГСДН-ын 2007 оны “Хамбүргын хөтөлбөр” хэмээх Үндсэн хөтөлбөр (Англи хэлээр): https://www.spd.de/fileadmin/Dokumente/Beschluesse/Grundsatzprogramme/hamburger_programm_englisch.pdf
- ГСДН-ийн 2021 оны холбооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (Англи хэлээр): https://www.spd.de/fileadmin/Dokumente/Regierungsprogramm/202105_Zukunftsprogramm_EN.pdf
- ГСДН-ийн 2021 оны холбооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (Герман хэлээр): <https://www.spd.de/fileadmin/Dokumente/Beschluesse/Programm/SPD-Zukunftsprogramm.pdf>
- Австрийн Социал Демократ намын цахим хуудас., <https://www.spoe.at>
- Австрийн парламентын цахим хуудас., <https://www.parlament.gv.at/erleben>
- Австрийн Социал Демократ намын үндсэн хөтөлбөр., <https://www.spoe.at/wp-content/uploads/sites/739/2018/12/Parteiprogramm2018.pdf>
- https://en.wikipedia.org/wiki/Social_Democratic_Party_of_Austria#National_Council
- <https://www.britannica.com/place/Austria/Political-process#ref409270>
- <https://www.rotbewegt.at/#/epoche/2017-2020>
- https://www.cairn-int.info/article-E_RFSP_645_0905--the-political-programme-as-genre.htm
- "Political Ideologies: An Introduction" by Andrew Heywood
- "Comparative Political Party Systems: A Reader" edited by Alan Ware
- "Party Politics in America" by Marjorie Randon Hershey

ХАВСРАЛТ 1**Зүүн төвийн үзэл баримтлалтай улс төрийн намын
бодлогын ерөнхий хүрээ****1. Нийгмийн халамж, тэгш байдал:**

- Тэгш бус байдлыг бууруулж, бүх иргэдийн аюулгүй байдлыг хангах нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Чанартай боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хямд орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Ядуурлыг арилгах, түүнд чиглэсэн нийгмийн хөдөлгөөнийг дэмжих.

2. Хөдөлмөр ба ажил эрхлэлт:

- Ажилчдын эрх ашгийг хамгаалах, шударга цалин хөлс, аюулгүй ажиллах нөхцөлийг хамгаалах.;
- Тогтвортой үйлдвэрлэл, инновацын хөрөнгө оруулалтаар ажлын байр бий болгохыг дэмжих;
- Хүүхэд асрах чөлөө, ажлын цагийн уян хатан зохицуулалт зэрэг ажил болон хувийн амьдралаа тэнцвэржүүлсэн бодлогыг дэмжих.

3. Эдийн засгийн шударга ёс:

- Зах зээлийн механизмыг нийгмийн баримжаатай зохицуулалттай хослуулсан холимог эдийн засгийг дэмжих;
- Төрийн үйлчилгээ, нийгмийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхийн тулд өсөн нэмэгдэх татварыг дэмжих;
- Хариуцлагатай компанийн үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагыг хөхүүлэн дэмжих.

4. Байгаль орчны тогтвортой байдал:

- Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих бодлогыг тэргүүнд эрэмбэлэх;
- Бизнес болон өдөр тутмын амьдралд тогтвортой үйл ажиллагааг дэмжих зохицуулалт, урамшууллыг нэвтрүүлэх;
- Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг дэмжих (Хариуцлагатай уул уурхай гм).

5. Боловсрол ба инновац:

- Бүх түвшинд чанартай, хүртээмжтэй боловсрол олгох боловсролын системд хөрөнгө оруулалт хийх;
- Инновац, технологийн дэвшлийг эрчимжүүлэхэд чиглэгдсэн судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих;
- Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицохын тулд мэргэжлийн сургалт, тасралтгүй суралцахууд дэмжлэг үзүүлэх.

6. Ардчилал ба оролцоо:

- Ардчилсан институцийг бэхжүүлж, хууль дээдлэх ёсыг эрхэмлэх;
- Ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигатай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн идэвх, оролцоог дэмжих.

7. Нийгмийн оролцоо ба олон талт байдал:

- Эмэгтэйчүүд, нийгмийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг зорилтот бүлгүүдийн эрхийг хамгаалах;
- Тэгш боломжийг хангах, ялгаварлан гадуурхахтай тэмцэх бодлогыг дэмжих.

8. Гадаад харилцаа ба энх тайван:

- Олон улсын зөрчилдөөнийг нэн тэргүүнд энхийн замаар, дипломат аргаар шийдвэрлэх;

- Хөрш орнууд болон гуравдагч хөршүүд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтын ажиллагааг дэмжих;
- Дэлхийн тавцанд хүний эрх, хүмүүнлэгийн зарчмуудын талд зогсох.

Баруун төвийн үзэл баримтлалтай улс төрийн намын бодлогын ерөнхий хүрээ

1. Ардчилал ба эрх зүйт ёс:

- Чөлөөт, шударга сонгууль, үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг хувь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалж, ардчиллын үнэт зүйл, зарчмыг тууштай баримтлах;
- Эрх зүйт ёс, бие даасан, хараат бус шүүхийн тогтолцоо, төрийн эрх мэдлийн хуваарилалтыг бэхжүүлэх;
- Хувь хүн өөрийнхөө, гэр бүлийнхээ болон нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хүсэл эрмэлзэлдээ хүрэх эрх чөлөөт орчныг бүрдүүлэх.

2. Эдийн засгийн хөгжил:

- Бизнес эрхлэх, инновац бүтээх, ажлын байр бий болгохыг дэмжсэн чөлөөт зах зээлд тулгуурласан эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх;
- Гол салбар, дэд бүтцэд хөрөнгө оруулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах.

3. Нийгмийн халамж:

- Бүх иргэдэд чанартай эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Ядуурал, тэгш бус байдал, нийгмийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэх арга хэмжээ авах.

4. Байгаль орчин ба тогтвортой байдал:

- Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг дэмжих;
- Байгальд ээлтэй туршлагыг сурталчлах, эх дэлхийнхээ унаган байгалийг сэргээх хүчин чармайлтад хувь нэмрээ оруулах.

5. Боловсрол ба инновац:

- Гэр бүлийн үнэт зүйлсийг эрхэмлэж, эцэг эхчүүдэд илүү эрх мэдэл олгох, бага насны хүүхдийн боловсролыг дээшлүүлж, боловсролын стандартыг сайжруулж, эцэг эхчүүдэд ажил мэргэжлээ дээшлүүлэх боломжийг олгох зорилгоор хүүхэд харах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Бүх түвшинд чанартай, хүртээмжтэй боловсрол олгох боловсролын системд хөрөнгө оруулалт хийх.

6. Хүний эрх ба нийгмийн оролцоо:

- Жинхэнэ хамгаалалт шаардлагатай цагаачдад орогнол олгох, хэлний сургалт, боловсрол, ажлын байраар дамжуулан өөрийн нийгэмдээ амжилттай нэгтгэх;
- Эмэгтэйчүүд, цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг гадуурхагдсан бүлгүүдийн эрхийг хамгаалах;
- Тэгш боломжийг хангах, ялгаварлан гадуурхахтай тэмцэх бодлогыг дэмжих.

7. Гадаад харилцаа, дипломат харилцаа:

- Олон улсын энхтайван харилцаа, зөрчил мөргөлдөөнийг дипломат аргаар шийдвэрлэхийг дэмжих;
- Хөрш орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа, хамтын ажиллагааг дэмжинэ.

8. Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ:

- Эрүүл мэндийн тогтолцоог шинэчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих, өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах;
- Хүн амын эмзэг бүлгийнхэнд тусламж үзүүлэх нийгмийн хөтөлбөрүүдийг дэмжих.

9. Дижиталчлал ба технологи:

- Мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдлыг хамгаалахын зэрэгцээ технологийн дэвшлийг нэвтрүүлж, дижитал засаглалд шилжих;
- Дижитал бичиг үсгийн боловсрол, технологийн хүртээмжийг дэмжих бодлогыг дэмжинэ.

БҮЛЭГ II

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ПРАКТИК ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Д.Халиун,
Г.Алтан-Оч (Ph.D.), Р.Нургул, О.Билгүүтэй,
С.Золжаргал, И.Жаргалзаяабямба,
Б.Баянмөнх, А.Номин-Эрдэнэ*

АГУУЛГА**УДИРТГАЛ****СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ**

Нэг. ДЭЛХИЙ ДАХИНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

- 1.1. Аялал жуулчлалын олон улсын эрх зүйн зохицуулалт
- 1.2. ЭЗХАХБ-ын гишүүн болон түнш орнуудын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААР**2.1. ГҮРЖ УЛС**

- 2.1.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт
- 2.1.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг
- 2.1.3. Аялал жуулчлалын салбарт агаарын болон бусад тээврийн үзүүлэх нөлөөлөл, холбогдох зохицуулалт
- 2.1.4. Жуулчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого
- 2.1.5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, зохицуулалт, арга хэмжээ

2.2. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Дотоодын аялал жуулчлал

- 2.2.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт
- 2.2.2. БНСУ-ын аялал жуулчлалын засаглал ба санхүүжилт
- 2.2.3. Аялал жуулчлалын салбарын татварын хөнгөлөлт
- 2.2.4. Жуулчдын аюулгүй байдлыг хангах

2.3. ТАЙЛАНД УЛС

- 2.3.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт
- 2.3.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг, түүний үр дүн
- 2.3.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа бодлого, зохицуулалт
- 2.3.4. Жуулчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого /холбогдох даатгалын талаарх зохицуулалт/

2.4. БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС

2.4.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт

2.4.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, түүний үр дүн

2.4.3. Аялал жуулчлалын салбарт агаарын болон бусад тээврийн үзүүлэх нөлөөлөл, холбогдох зохицуулалт

2.4.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа бодлого, зохицуулалт

2.4.5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого

2.5. БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС

2.5.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт

2.5.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн захиалгын дагуу “Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар гадаадын зарим орны баримталж буй бодлого, эрх зүйн орчин ба практик туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэлээ.

Судалгааны хамрах хүрээ: Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу сэдвийн хүрээнд дараах асуудлуудыг хамруулан судаллаа. Үүнд:

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн болон түнш 50 гаруй улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
- Захиалагчийн хүсэлтэд дурдсан Гүрж Улс, БНСУ, Тайланд Улс болон Австри, Чех зэрэг улсын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх хүрээнд гадаадын жуулчдыг өөрийн оронд татахад чиглэсэн бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ; тухайн салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг; төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа бодлого, зохицуулалт; жуулчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого; дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, зохицуулалт, арга хэмжээ зэрэг асуудлуудын талаар.

Судалгааны бүтэц: Судалгааны ажил нь хоёр бүлэгтэй. Нэгдүгээр бүлэгт: Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага, олон улсын сайн туршлагын талаар, хоёрдугаар бүлэгт: Гадаадын зарим орны бодлого, эрх зүйн орчны талаар авч үзэв.

Түлхүүр үг: аялал жуулчлалын бодлого, дотоодын аялал жуулчлал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг

Keywords: *tourism policy, domestic tourism, tax reduction and exemptions, state support*

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага (UN)
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)
ДАЖБ	НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага (WTO)
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕХ	Европын Холбоо

ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. БНСУ-ын аялал жуулчлалын салбарын статистик мэдээ 2017-2021 (Table: Total Market Size, US dollar)

Хүснэгт 2. ДНБ-ийн эзлэх хувийг 2020-2024 оны байдлаар харьцуулсан үзүүлэлт

Хүснэгт 3. БНЧУ-аас АНУ руу зорчсон жуулчдын тоо

Хүснэгт 4. Австри Улсын дотоодын болон дотоод, гадаад аялал жуулчлал

Хүснэгт 5. Австрийн аялал жуулчлалын байгууллага, ажилтан

Хүснэгт 6. Австрийн аялал жуулчлалын дотоод хэрэглээ 2020 он [САЯ ЕВРО]

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Гүржийн Засгийн газрын аялал жуулчлалд төсөвлөсөн зарцуулалтын хэмжээ

Зураг 2. Гүржийн аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ болон нийт төсөвт эзлэх хувь хэмжээ

Зураг 3. БНСУ: Аялал жуулчлалын байгууллагуудын зохион байгуулалтын схем

Зураг 4. Био-Тойрог-Ногоон (Bio-Circular-Green (BCG)) эдийн засгийн загвар

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ**Нэг. ДЭЛХИЙ ДАХИНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА**

Аялал жуулчлалын салбар нь коронавирусийн халдварт /КОВИД-19/ цар тахал /цаашид “цар тахал” гэх/-ын нөлөөгөөр эдийн засгийн хүндрэлд хамгийн их өртсөн салбарын нэг бөгөөд хөл хорио, хязгаарлалтын дэглэм нь аж ахуйн нэгж, компаниуд төдийгүй аялал жуулчлалаас хараат улс орнуудад хүнд цохилт болсон. 2020 онд л гэхэд дэлхийн хэмжээнд тус салбар 4.5 их наяд ам.долларын алдагдал хүлээж, 62 сая ажлын байр алдагдсанаар иргэдийн амьжиргааны түвшин, сайн сайхан аж байдалд нөлөөлсөн.¹²²

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)-аас¹²³ олон улсын аялал жуулчлал 2023 онд сэргэх төлөвтэй байна гэж дүгнэсэн байна.¹²⁴ Тухайлбал:

- 2022 онд олон улсын жуулчдын тоо цар тахлын өмнөх үеийн 63 хувьд хүрсэн. 2022 онд 900 сая жуулчин олон улсад аялсан нь 2021 оныхоос хоёр дахин өссөн үзүүлэлт боловч, 2019 онтой харьцуулахад 37 хувиар бага байна.
- 2022 онд хамгийн өндөр өсөлт Ойрх дорнод бүсэд бүртгэгдсэн бөгөөд жуулчдын тоо цар тахлын өмнөх үеийн 83 хувьтай тэнцэж байна. Европ тив 585 сая жуулчин хүлээн авсан нь цар тахлын өмнөх үеийн 80 гаруй хувьтай тэнцэж байна.
- Африк болон Америк тивд аялсан жуулчдын тоо тус бүр цар тахлын өмнөх үеийн 65 хувьтай тэнцэж байгаа бол цар тахалтай холбоотой халдвар хамгааллын хатуу дэглэм тогтоосон Ази, Номхон далайн бүсэд аялсан жуулчдын тоо цар тахлын өмнөх 23 хувьтай тэнцүү байна.
- Дээрхээс үзэхэд олон улсын аялал жуулчлалын сэргэлт 2023 онд үргэлжлэн, Ази Номхон далайн бүсийн зах зээл нээгдэж байгаатай холбоотойгоор улам бэхжих хандлагатай байна.
- Аялал жуулчлалын салбарын сэргэлт, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн талаар шинжээчдийн дунд хийсэн судалгаанд хамрагдсан экспертүүдийн 72 хувь нь 2023 оны үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад сайжирна гэж дүгнэсэн бол цар тахлын өмнөх буюу 2019 оны хэмжээнд 2024 он болон түүнээс хойш хүрнэ гэж таамаглажээ.

- UNWTO-ын таамаглалаар 2023 онд олон улсын аялал жуулчлалын хэмжээ цар тахлын өмнөх үеийн 80-95 хувьд хүрэх боловч эдийн засаг болон геополитикийн эрсдэл өндөр хэвээр байгааг анхааруулж байна.
- Эдийн засаг бүрэн сэргээгүй байгаа үед (Тухайлбал, газрын тос, эрчим хүчний үнэ эрчимтэй нэмэгдэж, инфляцын түвшин өссөнтэй холбоотойгоор тээвэр болон буудаллах үнэ нэмэгдэх нь хэрэглэгчдийн худалдан авах чадвар болон хадгаламжид сөрөг нөлөө үзүүлэхээс гадна бизнесийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлнэ.) жуулчдын хувьд үр өгөөж өндөртэй, ойрын аяллыг илүүтэйгээр эрэлхийлэх болно гэж дүгнэжээ.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас аялал жуулчлалын салбарыг сэргээхэд дараах асуудлууд чухал болохыг онцолсон байна.¹²⁵ Үүнд:

Аялал жуулчлалын салбарын хөгжлийг цогц, уян хатан, алс хэтийг харсан бодлогоор хөхиүлэн дэмжих

- Сэргэлтийг эрчимтэй нэмэгдүүлэх, ногоон болон дижитал шилжилтийг хурдасгах, Засгийн газрын хэмжээнд ирээдүйн шокод бэлтгэх, хариу үйлдэл үзүүлэх, дасан зохицох чадавхыг бий болгоход чиглэсэн аялал жуулчлалын хэтийн стратегийг хөхиүлэн дэмжих.
- Хувийн хэвшил, иргэний нийгэмтэй хамтран шинэлэг арга барилд тулгуурлан цар тахлын хариу арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, илүү хүчтэй, тогтвортой салбарыг бий болгоход шаардлагатай бүтцийн өөрчлөлт хийх, оновчтой болгох.

Аялал жуулчлалын экосистемийн *resilience* буюу уян хатан чанар, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх

- Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, ур чадвар, чадавхыг бэхжүүлэх, ногоон, дижитал дадлыг дэмжих замаар аялал жуулчлалын салбарын ЖДҮ эрхлэгчдийг дэмжсэн бизнесийн орчныг хөхиүлэн дэмжих.
- Аялал жуулчлалын экосистемд оролцогчдын хамтын ажиллагааг дэмжих замаар орчны өөрчлөлт, асуудалд хариу үйлдэл үзүүлэх, дасан зохицох чадавхыг бий болгох, мэдээлэл, туршлагаа хуваалцах, эрсдэл, боломжийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх.
- Аялал жуулчлалын уян хатан чанар, тэсвэртэй байдлыг хэмжих, хянахад найдвартай, харьцуулж болохуйц өгөгдөл, хэрэгслийг бий болгох, болзошгүй хямралын үед авах хариу арга хэмжээ, үр дүнтэй шийдлийн талаар шуурхай дамжуулах, мэдээллийн цоорхойг нөхөх.

Ногоон аялал жуулчлалын сэргэлтийг дэмжих

- Тогтвортой аялал жуулчлалын алсын хараа, зорилго, зорилт бүхий урт хугацааны цогц стратегийг боловсруулж, Засгийн газрын хэмжээнд нөөц төвлөрүүлэх, зохицуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, механизмтай болох.
- Аялал жуулчлалын нэмүү өртгийн сүлжээн дэх ногоон дадлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, байгальд ээлтэй үйл ажиллагааг урамшуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих үр нөлөө бүхий арга хэмжээнд ач холбогдол өгсөн, баримт нотолгоонд суурилсан бодлогыг хэрэгжүүлэх.

¹²⁵ ЭЗХАХБ-аас 2008 оноос хойш хоёр жил тутам “Аялал жуулчлалын чиг хандлага, бодлого” (OECD Tourism Trends and Policies) тайланг нийтэлж байгаа бөгөөд ЭЗХАХБ-ын гишүүн болон түнш 50 гаруй орны аялал жуулчлалын салбарын бодлого, засаглалын гол шинэчлэлүүд, тулгарч буй сорил бэрхшээл, мөн улс орнуудын сайн туршлагыг тусгадаг. OECD (2022), OECD Tourism Trends and Policies 2022, OECD Publishing, Paris, https://www.oecd-ilibrary.org/industry-and-services/oecd-tourism-trends-and-policies_20767773

- *Carbon literacy* буюу уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдын шинэлэг шийдлийг боловсруулах, тогтвортой аялал жуулчлалын сонголтыг хийх, бизнес эрхлэгчдэд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чадавхыг бий болгоход туслах.
- Ногоон шилжилтийг хурдасгахад Засгийн газрын үүргийг нэмэгдүүлж, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор төрөөс санхүүжүүлсэн, эсхүл төрийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулах.

1.1. Аялал жуулчлалын олон улсын эрх зүйн зохицуулалт

Аялал жуулчлалын олон улсын эрх зүйн зохицуулалтын үндэс болсон олон талт гэрээ, конвенц, эрх зүйн баримт бичгүүд:

- олон улсын хэмжээнд: Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас баталсан “Аялал жуулчлалын ёс зүйн тухай дэлхийн конвенц”;¹²⁶
- бүс нутгийн хэмжээнд: 2015 оны Багц аяллын тухай Европын Холбооны удирдамж, Өмнөд Африкийн хөгжлийн хамтын нийгэмлэг (SADC), Өмнөдийн нэгдсэн зах зээл (Mercosur), Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (ASEAN)-ийн гишүүн улс орнуудын хамтын ажиллагааг дурдаж болох юм.

Мөн олон тооны Европын Холбооны гишүүн бус улс орнууд Европын Холбооноос аялал жуулчлалтай холбоотой гаргасан хууль тогтоомжийг батлах, нийцүүлэх зэрэг арга хэмжээ авч байна.¹²⁷

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO) болон холбогдох бусад олон улсын байгууллагаас баталсан аялал жуулчлалын салбарын гол баримт бичгүүд:

- 1980 оны Дэлхийн аялал жуулчлалын Манилын тунхаг;¹²⁸
- 1982 оны Акапулькийн баримт бичиг;¹²⁹
- 1989 оны Аялал жуулчлалын Гаагийн тунхаг;¹³⁰
- 1985 оны UNWTO-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Аялал жуулчлалын харти ба Жуулчны ёс зүй;
- 1994 оны Аялал жуулчлалын Осакагийн тунхаг;¹³¹
- 2001 оны Осакагийн мянганы тунхаг.¹³²

¹²⁶ Дэлхий нийтээр баримтлах аялал жуулчлалын ёс зүйн хэм хэмжээг НҮБ-ын дэлхийн аялал жуулчлалын байгууллага боловсруулсан. Үүний зорилго нь аялал жуулчлалын байгаль орчин, соёлын өвд оруулах сөрөг үр дагаврыг багасган, аялал жуулчлал эрхэлж буй газруудын иргэдэд хүрэх ашиг тусыг нэмэгдүүлэх явдал юм. Энэхүү ёс зүйн хэм хэмжээний 10 зүйл ангийг 2001 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаар албан ёсоор баталсан юм. Энэ бичиг баримт нь аялал жуулчлалтай холбоотой хэн бүхний дагаж мөрдөх зарчмууд юм.

Олон улсын аялал жуулчлалын ёс зүйн хэм хэмжээ нь дэлхийн аялал жуулчлалыг хариуцлагатай, тогтвортой хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор боловсруулагдсан баримт бичиг юм. Энэ нь аялал жуулчлалын салбарынханд зориулсан багц зарчмуудыг багтаасан. Тэрчлэн засгийн газар, аялал жуулчлалын салбар, олон нийт, жуулчдад хандаж, дэлхийн хэмжээнд байгаль орчин, соёлын өв, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын зэрэгцээ салбарын ашиг тусыг нэмэгдүүлэхэд туслах зорилготой юм. <https://www.giz.de/en/downloads/giz-2022-mn-CBT.pdf>

¹²⁷ https://pdf.usaid.gov/pdf_docs/PA00W4N5.pdf

¹²⁸ <https://www.e-unwto.org/doi/epdf/10.18111/unwtodeclarations.1980.01.01?role=tab>

¹²⁹ <https://www.e-unwto.org/doi/epdf/10.18111/unwtodeclarations.1982.02.01?role=tab>

¹³⁰ <https://www.e-unwto.org/doi/epdf/10.18111/unwtodeclarations.1989.03.01?role=tab>

¹³¹ <https://www.e-unwto.org/doi/epdf/10.18111/unwtodeclarations.1994.04.02?download=true>

¹³² <https://www.e-unwto.org/doi/epdf/10.18111/unwtodeclarations.2001.11.03?role=tab>

Аялал жуулчлалын тодорхой асуудал хамаарах НҮБ, Дэлхийн худалдааны байгууллага (ВТО) болон бусад байгууллагын баримт бичгүүд:

- 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал;
- 1966 оны Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт;
- 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт;
- 1929 оны Олон улсын агаарын тээвэр дэх ачаа ба иргэний тээврийн тухай Варшавын конвенц;
- 1944 оны Иргэний нисэхийн тухай Чикагогийн олон улсын конвенц, түүнтэй холбоотойгоор батлагдсан Токио, Гааг, Монреалийн конвенцууд;
- 1954 оны Аялал жуулчлалын гаалийн хөнгөлөлтийн тухай конвенц болон протокол (Жуулчдын гаалийн татварын хөнгөлөлтийн тухай нэмэлт протокол, Жуулчдад зориулсан зар сурталчилгааны бичиг баримт болон материалыг оруулах тухай);
- 1972 оны Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц;
- 1990 оны Хүүхдийн эрхийн тухай конвенц;
- 1995 оны ДХБ-аас зохион байгуулалттай секс-жуулчлалаас урьдчилан сэргийлэх тухай гаргасан мэдэгдэл (Мадрид, Испани болон Гэгээн Винсент, Балле-д’Аоста, Итали);
- 1995 оны Аялал жуулчлалын аюулгүй байдал, аялал дахь эрсдэлийг бууруулах олон улсын бага хурлын баримт бичгүүд (Эстерсуд, Швед);
- 1996 оны Нийгмийн аялал жуулчлалын асуудлаар Нийгмийн аялал жуулчлалын олон улсын товчооны Ерөнхий Ассамблейгаас баталсан Монреалийн тунхаг;
- 2000 оны Аялал жуулчлалын салбар дахь ажиллах хүчийг бэлтгэх асуудлаарх ДХБ-ын Мадридын олон улсын семинарын баримт бичгүүд;
- 1994 оны Худалдаа, үйлчилгээний ерөнхий хэлэлцээр (GATS);
- 1995 оны Биологийн олон янз байдлын тухай конвенц;
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хамтын гэрээ байгуулах, албадан болон хүүхдийн хөдөлмөрийг хориглох тухай, уугуул иргэдийн эрхийг хамгаалах, ажлын байр дахь эрх тэгш байдлыг хангах, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх талаар баталсан конвенц болон гаргасан зөвлөмжүүд;
- Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хоёр талын хэлэлцээр.

Европын Холбооны гишүүн орнуудын аялал жуулчлалын салбарыг зохицуулж буй хууль эрх зүйн орчин¹³³

Европын Холбооны гишүүн орнуудын аялал жуулчлалын салбарыг зохицуулж буй хууль эрх зүйн зохицуулалтууд хоорондоо ялгаатай бөгөөд дараах хүчин зүйлээс хамаарч байна. Үүнд: тухайу улсын аялал жуулчлалын салбарын хөгжил болон тухайн салбарт өгч буй ач холбогдол, тухайн улс орны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зохион байгуулалт, эрх зүйн тогтолцоо зэрэг байна.

Ихэнх гишүүн орны хувьд аялал жуулчлалыг нийтийн ашиг сонирхолд хамаарах үйл ажиллагаа гэж тодорхойлсон байх бөгөөд аялал жуулчлалыг дэмжих, жуулчдыг мэдээллээр хангах, орон нутгийн түвшний аялал жуулчлалыг төсвөөс санхүүжүүлэх, орон нутгийн түвшний байгууллагуудыг хувийн хэвшилтэй холбох зэргийг төрөөс зохицуулдаг байна.

¹³³ ESHTЕ. (2022). Tourism Law in Europe. <https://publications.eshte.pt/dir/ttie/ttie/>

Тухайлбал, Австри Улсад аялал жуулчлалыг үндэсний хэмжээнд зохицуулж буй бие даасан хууль тогтоомж байхгүй, зөвхөн бүс нутаг, орон нутгийн хэмжээнд зохицуулсан байна.¹³⁴

Итали Улсын аялал жуулчлалтай холбоотой харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны хувьд бүс нутаг, орон нутгийн хууль тогтоомжоор зохицуулах нь нийтлэг байна. Үндэсний хэмжээнд зохицуулж буй эрх зүйн акт нь 2011 онд батлагдсан Аялал жуулчлалын кодекс юм.¹³⁵ Уг кодекст аялал жуулчлалтай холбоотой үндсэн зарчим болон аялал жуулчлалын талаар баримтлах бодлогыг тусгасан байна. Аялал жуулчлалын талаар баримтлах бодлого нь аялал жуулчлалын маркетинг буюу аялал жуулчлалын зах зээл, жуулчны зан төлөв, худалдан авах чадвар буюу эрэлтийг тодорхойлж хангах хэрэгцээт бараа, үйлчилгээг зохион байгуулах, идэвхжүүлэх, хуваарилах болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн үндэслэл болдог байна.

Хорват Улсын хувьд аялал жуулчлалтай холбоотой харилцааг хэд хэдэн хуулиар зохицуулж байна. Тухайлбал, Аялал жуулчлалын зөвлөлүүд болон аялал жуулчлалыг дэмжих тухай хууль, Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тухай хууль, Жуулчны татварын тухай хууль, Зочлох үйлчилгээ болон катерингийн тухай хууль гм.¹³⁶

Мөн багц аялалтай холбоотой зохицуулалт нь улс орнуудын хувьд ялгаатай байна. Тухайлбал, зарим улс зохион байгуулалттай аяллын үйлчилгээ үзүүлэхэд тусгай зөвшөөрөл, зохион байгуулагч аж ахуйн нэгж, иргэний санхүүгийн баталгаа, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний мэдлэгийг нотлох гэрчилгээ зэргийг шаарддаг бол бусад улсад дээрх асуудлыг зохицуулаагүй байна.¹³⁷

1.2.ЭЗХАХБ-ын гишүүн болон түнш орнуудын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар¹³⁸

1.2.1.Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт

Цар тахлын улмаас үүссэн аялал жуулчлалын хямралаас өмнө ЭЗХАХБ¹³⁹ зэрэг олон улсын байгууллагаас аялал жуулчлалын урт хугацааны, урт хугацааны, тогтвортой бодлого, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө чухал болохыг онцолж байсан. Аялал жуулчлал сэргэхийн хэрээр улс орнуудын засгийн газрууд урт хугацааны стратегийн зорилтыг богино хугацааны сэргэлттэй уялдуулах бэрхшээлтэй тулгарч байна. Цар тахал нь аялал жуулчлалын экосистемийн сул талыг (шинээр үүссэн болон өмнө байсан) тодруулж гаргасан боловч хямрал удаан үргэлжилсэн нь эдгээрийг боломж болгон ашиглан урт хугацаандаа шийдвэрлэх боломжийг бий болгосон.

Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг шинэчлэн батлах замаар аялал жуулчлалын салбар дахь эдийн засаг, геополитикийн орчны өөрчлөлтөөс үүдэлтэй шинэ сорилтуудыг шийдвэрлэх боломжтой юм. Цар тахлын эхэн үед ЭЗХАХБ-ын цөөнгүй гишүүн улс аялал жуулчлалын урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, шинэчилж эхэлж байсан боловч цөөнгүй нь хойшлогдсон байна. Харин Чех, Итали, Япон, Латви зэрэг зарим улс

¹³⁴ Мөн тэнд, 53 дахь тал

¹³⁵ Мөн тэнд, 315 дахь тал

¹³⁶ Мөн тэнд, 93 дахь тал

¹³⁷ Saša Zupan Korže, Legal framework for tourism: necessity or necessary evil, Innovative Issues and Approaches in Social Sciences, Vol. 11, No. 1, 2018, <http://www.iiass.com/pdf/IIASS-2018-no1-art3.pdf>

¹³⁸ OECD (2022), OECD Tourism Trends and Policies 2022, OECD Publishing, Paris, https://www.oecd-ilibrary.org/industry-and-services/oecd-tourism-trends-and-policies_20767773

¹³⁹ Мөн тэнд.

орнууд цар тахлын тодорхойгүй нөхцөл байдалд 2-3 жилийн хугацаатай богино хугацааны сэргэлтийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан бол АНУ, Австрали, Хорват, Дани, Финланд, Франц, Грек, Унгар, Израил зэрэг улс 2027-2030 он хүртэлх урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулсан байна.

Холбогдох баримт бичгүүдээс харахад улс орнууд аялал жуулчлалын стратеги төлөвлөлт, хөгжилд илүү уян хатан хандлагыг нэвтрүүлэхийг зорьсон байна. Тухайлбал, ИБУИНХУ хоёр чиглэлт стратеги баталсан бөгөөд нэг чиглэл нь 2019 оны түвшинд буцаж сэргэх, харин урт хугацааны стратегийн зорилт нь бүс нутгийн тархалтыг дэмжих, салбарын уян хатан байдлыг бий болгох, хүртээмж, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Унгар Улс нь 2021 онд аялал жуулчлалын стратегиа шинэчлэн боловсруулсан бөгөөд Үндэсний аялал жуулчлалын стратеги 2030-д цар тахлын нөлөөлөл болон эхний гурван жилийн хугацаанд олж авсан сургамжийг тусгасан байна.

Тогтвортой байдал нь аялал жуулчлалын бодлогын тулгуур, чухал хэсгийн нэг хэвээр байна. Тухайлбал, Итали, АНУ зэрэг орнууд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицоход илүүтэйгээр анхаарч байна. Итали Улс нь 2023-2027 оны Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө боловсруулж байгаа бөгөөд зан төлөвийн талаарх ойлголтыг (*behavioural insights*) ашиглан жуулчид, бизнес эрхлэгчдэд илүү тогтвортой, байгаль орчинд ээлтэй зан үйлийг бий болгох, дадуулахаар төлөвлөж байна.

Швейцар Улс 2021 онд гурван жилийн хугацаатай "Swisstainable" шинэ стратеги хэрэгжүүлж, дэлхийн хамгийн тогтвортой аялал жуулчлалын чиглэл болохыг зорьж байна. Португал Улс 2020-2023 онд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц төлөвлөгөө боловсруулж, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд анхаарал хандуулж байна. Үүнд эрчим хүчний хэрэглээг бууруулж, тойрог эдийн засгийн шийдлийг нэвтрүүлэх, холбогдох сургалт, ур чадварыг хөгжүүлэх, барилгын тогтвортой шийдлүүдийг дэмжих, гольфийн талбайн усны үр ашгийг дээшлүүлэх зэрэг орж байна. Эстони Улсын "Аялал жуулчлалын стратеги 2022-2025"-даа аялал жуулчлалын ухаалаг болон ногоон чиглэл болох зорилтыг дэвшүүлсэн бол Тогтвортой байдлын хөтөлбөрүүдийг Бельги Улс ((Фландерс) "2019-2024 оны Аялал жуулчлалын төлөвлөгөөний зөвлөмж"), Румын Улс (Эко аялал жуулчлалын хөгжлийн стратеги) тус тус боловсруулсан байна.

Мөн сүүлийн үеийн стратеги төлөвлөгөөнүүд хэмжээ бус чанарыг эрхэмлэх, дижитал шилжилт болон ажиллах хүчний асуудлыг чухалчлан авч үзэж байна. Эдгээр нь цар тахлаас өмнө боловсруулсан Австри Улсын Аялал жуулчлалын Мастер төлөвлөгөөнд туссан ба тооноос чанарыг эрхэмлэх, хамтын ажиллагааны соёл бий болгох зэргийг тусгасан байна. Австрали Улсын THRIVE 2030 стратеги төлөвлөгөө нь өвөрмөц, өндөр чанартай бүтээгдэхүүн дээр анхаарлаа төвлөрүүлж, найдвартай, уян хатан ажиллах хүчийг нэмэгдүүлэх, уян хатан, тогтвортой, шинэлэг, өрсөлдөх чадвартай аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн "аж үйлдвэр манлайлж, төрөөс дэмжлэг үзүүлэх" үйл ажиллагааны төлөвлөгөөг багтаасан байна.¹⁴⁰

¹⁴⁰ Аялал жуулчлалын бодлого, хөтөлбөрүүд Австрали Улсын үндэсний урт хугацааны эдийн засгийн стратеги болох THRIVE 2030-ийг 2022 оны 03 дугаар сард баталсан. Аж үйлдвэр болон засгийн газрын дэмжлэгтэйгээр THRIVE 2030 нь эдийн засгийг сэргээн босгож, урт хугацааны тогтвортой өсөлтөд чиглүүлэх зорилготой юм. Энэ нь 2024 он гэхэд Ковид-19 цар тахлын өмнөх аялал жуулчлалын салбарын 166 тэрбум австрали долларын орлогыг нэмэгдүүлж, 2030 он гэхэд 230 тэрбум австрали доллар хүргэх зорилт тавьсан байна. Энэ зорилтын 40 орчим хувийг бүс нутгийн дотоодын аялалын чиглэлүүд эзэлж байна. THRIVE 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Холбооны Засгийн газрын 21 агентлаг оролцож байна. 2022 оны 05 дугаар сард Холбооны Засгийн газар аялал жуулчлалтай холбоотой арга хэмжээнд 48 сая австрали доллар олгохоор төсөвлөсөн байна. Энэхүү хүрээнд чанартай аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг дэмжих, дэд бүтцийг шинэчлэх, ажилчдыг сургах, ур чадварыг дээшлүүлэх, бизнес эрхлэгчдэд олон улсын жуулчдыг татахад туслах зэрэг олон талын дэмжлэг үзүүлэх юм. Австрали Улсын засгийн газраас Ковид-

1.2.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг, түүний үр дүн

Аялал жуулчлал нь төсвийн орлогод хувь нэмэр оруулахаас гадна, төсвийн зарлагаас ашиг хүртдэг салбар юм. Аялал жуулчлалын салбар нь маш өргөн хүрээг хамардаг тул тухайн салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийн хэмжээг нарийн тогтоох бэрхшээлтэй байдаг. Энэ нь цар тахлаас хойш ЖДҮ болон эдийн засгийг бүхэлд нь сэргээх арга хэмжээ нэмэгдсэнээр улам өргөн хүрээтэй болсон.

Улс орнууд цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болгон аялал жуулчлалын салбарт дараах хөнгөлөлт, дэмжлэгүүдийг үзүүлсэн байна. Үүнд:

Австрали Улс: Тус улс нь эдийн засгийг бүхэлд нь сэргээхэд чиглэсэн дэмжлэгээс гадна 2020-2022 онд бизнесийн аялал жуулчлалыг эрчимжүүлэх Бизнесийн арга хэмжээний грант¹⁴¹ (56 сая австрали доллар), аялал жуулчлалын тур оператор, турагент зэрэг бизнес эрхлэгчдийг дэмжих Хэрэглэгчийн аяллыг дэмжих хөтөлбөр /The Consumer Travel Support programme/ (258 сая австрали доллар), бүс нутгийн аялал жуулчлалыг сэргээх замаар олон улсын аялал жуулчлалаас өндөр хамааралтай есөн бүс нутагт дэмжлэг үзүүлэх Бүс нутгийн аялал жуулчлалыг сэргээх хөтөлбөр /Recovery for Regional Tourism programme/ (50 сая австрали доллар)-ийг тус тус хэрэгжүүлсэн. Агаарын тээврийн салбарыг дэмжих, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Аялал жуулчлал, нисэхийн сүлжээг дэмжих хөтөлбөрийг¹⁴² тус тус хэрэгжүүлсэн байна.

Австри Улс: Австри Улсын аялал жуулчлалын хөгжлийн банкнаас аялал жуулчлалын салбарыг дэмжихэд түр зээлийн баталгаа /guarantees for bridging loans/ (1.6 тэрбум евро), арга хэмжээ зохион байгуулагчдад үзүүлэх дэмжлэг (300 сая евро), багц аялал зохион байгуулагчдад үзүүлэх дэмжлэг (300 сая евро), зочлох үйлчилгээ эрхлэгчдэд нээлттэй талбайд үйл ажиллагаа явуулахыг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтад 10 сая еврогийн урамшууллыг тус тус олгосон байна. Цаашилбал, хувийн орон сууц, фермийг буудаллах зориулалтаар үйлчилгээ үзүүлж буй түрээслүүлэгч/ хөрөнгө эзэмшигч нарт үзүүлэх дэмжлэг, мөн татварын хөнгөлөлтийн багц, орон сууц, хоол хүнс, уух зүйлийн НӨАТ-ыг 10 хувиас 5% болгож бууруулах зэрэг дэмжлэгийг үзүүлсэн байна.

19 тахлын улмаас хямралд өртсөн аялал жуулчлалын томоохон бүс нутгуудад дэмжлэг үзүүлж 2020 оны 3 дугаар сараас хойш цалингийн татаас (жишээ нь: JobKeeper) болон салбарын тусламжийн хөтөлбөрүүд зэрэг зорилтот болон зорилтот бүс дэмжлэгээр аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт 20 тэрбум гаруй австрали долларын тусламж үзүүлсэн. Энэхүү тусламжийн нэг хэсэг болох 1 тэрбум австрали долларыг Ковид-19-ийн тусламж, нөхөн сэргээх сангаас санхүүжүүлсэн богино хугацааны арга хэмжээнд зориулж: Бүс нутгийн агаарын тээврийн компаниудад (100 сая австрали доллар), бүс нутгийн агаарын сүлжээний тусламж (198 сая австрали доллар), Ковид-19 Аялал жуулчлалын дэмжлэг (258 сая австрали доллар), Бүс нутгийн нөхөн түншлэлийг сэргээхэд (100 сая австрали доллар), Бизнесийн арга хэмжээний тэтгэлэгт хөтөлбөрт (56 сая австрали доллар), Австралийн амьтны хүрээлэн, аквариумыг дэмжих хөтөлбөрт (139.6 сая австрали доллар) зэрэг тусламж үзүүлсэн байна. Салбарын өсөлтийг сэргээхэд чиглэсэн дунд хугацааны арга хэмжээнд: Үндэсний эдийн засгийг сэргээх төлөвлөгөөний нэг хэсэг болох аялал жуулчлал, агаарын тээврийн салбарт 1.2 тэрбум австрали доллар, Аялал жуулчлалын агаарын тээврийг дэмжих хөтөлбөрт 204 сая австрали доллар, Бүс нутгийн аялал жуулчлалыг сэргээх хөтөлбөрт 50 сая австрали доллар, үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт болон аялал жуулчлалын бусад дэд бүтцэд зориулж 233 сая австрали доллар, мөн Австралийн соёлын салбарыг бэхжүүлэх зорилгоор ойролцоогоор 800 сая австрали долларын санхүүжилт тус тус олгосон байна. Австрали Улсын Ковид-19 цар тахалтай холбоотой хилээ хаасан хэдий ч аялал жуулчлалын салбарын сэргэлтэд дотоодын аялал жуулчлал томоохон нөлөө үзүүлсэн байна. Дотоодын аялал жуулчлалыг өргөжүүлэх "эпик аялал" болон "аялалын бэлэн" компани ажлыг хэрэгжүүлж, Австраличуудыг дотоодын аялал жуулчлалын салбарыг дэмжихийг уриалав. Мөн "Австралийн аялал жуулчлал" нь аялал жуулчлалын туршлагатай компаниудад өөрсдийгөө илүү сайн сурталчлахад ашиглаж болох маркетингийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлж 12 сая австрали долларын татаас олгосон байна.

¹⁴¹ Business Events Grants

¹⁴² The Tourism and Aviation Network Support programme

Мөн жуулчдын урсгал хумигдаж, ажлын байр цөөрсөнтэй холбоотойгоор цагийн ажил эрхлэлтийг дэмжих хүрээнд цагийн ажлын хөлсийг нэмэгдүүлсэн байна.

Канад Улс: Аялал жуулчлалын бизнес эрхлэгчид яаралтай хариу арга хэмжээний хүрээнд ойролцоогоор 23 тэрбум канад доллар хүлээн авсан байна. Канад Улс нь Яаралтай хариу арга хэмжээнд олгох тэтгэмж, Яаралтай тусламжийн цалингийн татаас зэрэг өргөн хүрээний хөтөлбөрүүд хэрэгжүүлснээс гадна Аялал жуулчлал, зочлох үйлчилгээг сэргээх хөтөлбөр, Хамгийн хүнд цохилтод өртсөн бизнесүүдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, Орон нутгийн хөл хорионы хөтөлбөр, Канадын сэргэлт, ажилд авах хөтөлбөр зэрэг цар тахлын сөрөг үр нөлөөллийг бууруулах олон талт хөтөлбөрүүдийг 2022 оны 05 дугаар сар хүртэл хэрэгжүүлж, аялал жуулчлалын бизнест дэмжлэг үзүүлсэн байна.

Марокко Улс: Аялал жуулчлалын компанийн ажилтнууд, аяллын хөтөч нарт сар бүр мөнгөн тэтгэмж олгох, үндсэн цалингаас бусад цалин хөлс, нэмэлтэд татвараас чөлөөлөх, аялал жуулчлалын хөтөч-тайлбарлагчдыг нийгмийн баталгаагаар хангах зэргээр арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Мөн Марокко Улс нь аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн нийгмийн даатгалын шимтгэл, өрийн эргэн төлөлтийг хойшлуулж, Сусс-Масса мужийн аялал жуулчлалын ЖДҮ-ийн хөгжлийг хурдасгах зорилгоор түншлэлийн гэрээ байгуулсан байна.

Словак Улс: Аялал жуулчлалын салбарт үзүүлэх дэмжлэгийн тогтолцоог (нийт 100 сая евро) Аялал жуулчлалыг дэмжих тухай хуулиар дамжуулан бий болгосон. 2020 онд 40% ба түүнээс дээш хувиар алдагдал хүлээсэн аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх нь ажлын байрыг хадгалах, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг хангах зорилготой байв.

Словени Улс: Цар тахлын үр нөлөөг бууруулах, ажлын байрыг хадгалах, корпорацийн хөрвөх чадвартай холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор 10 багц арга хэмжээ болон Тусгай оролцооны тухай хуулийг баталж, хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээнд дотоодын аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд мөнгөн тэтгэмж олгох, грант, татварын хөнгөлөлт, цалингийн дэмжлэг үзүүлэх, ЖДҮ эрхлэгчдэд олгох зээлийн баталгаа, жуулчны эрхийн бичиг зэрэг багтжээ. 2020, 2021 онуудад ойролцоогоор 3.7 сая евротой тэнцэх ваучерыг ашигласан байна.

1.2.3. Аялал жуулчлалын салбарт агаарын болон бусад тээврийн үзүүлэх нөлөөлөл, холбогдох зохицуулалт

Аялал жуулчлалын салбар нь хүлэмжийн хийн ялгаруулалтад ихээхэн хувь нэмэр оруулдаг, мөн олон төрлийн бөгөөд ихэвчлэн хуримтлагдах нөлөөлөлд өртдөгөөр уур амьсгалын эрсдэлийн голд байдаг. Аялал жуулчлалын салбарын ялгаруулж буй нүүрсхүчлийн хэмжээг тооцоолох нь хүндрэлтэй хэдий ч сүүлийн үеийн тооцооллуудаас үзэхэд дэлхийн нүүрсхүчлийн хийн ялгарлын 8-11 хувийн хооронд хэлбэлздэг байна. Дэлхийн агаарын температур 1850-1900 он ба 2010-2019 оны хооронд 1.1°C-ээр нэмэгдсэн байна. 2030 он гэхэд 1.5 °C дулаарах магадлалтай байгаа нь аялал жуулчлалын чиглэлүүдэд ихээхэн хэмжээний нөлөө, үр дагавар үүсгэхээр байна. ХБНГУ, Бельги Улсад тохиолдсон үерийн гамшигт үзэгдэл, мөн сүүлийн жилүүдэд Австрали, Франц, Грек, Португал, АНУ-д жуулчид, нутгийн иргэдэд аюул учруулсан гал түймэр зэрэг нь үүний жишээ юм.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, цаг уурын өөрчлөлтөд (дасан зохицох) бэлтгэх аялал жуулчлалын бодлого хязгаарлагдмал хэвээр байгаа бөгөөд аялал жуулчлал, уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын нэгдмэл байдлыг бэхжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа аялал жуулчлалын нэмүү өртгийн сүлжээний гол элемент, нүүрсхүчлийн хийн

ялгарлыг нэмэгдүүлэхэд гол хувь нэмэр оруулдаг тээврийн салбарт бодлого дутагдаж байна. UNWTO /Олон улсын тээврийн форум/-ын дүн шинжилгээгээр 2005-16 онд аялал жуулчлалын нүүрсхүчлийн хийн ялгаруулалт доод тал нь 60 хувиар өссөн бөгөөд Аялал жуулчлалаас ялгарах ялгаруулалт нь 2016 онд дэлхийн нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын 5 хувийг эзэлж байсан бол 2030 он гэхэд энэхүү үзүүлэлт 25 хувь ба түүнээс дээш хэмжээгээр өсөх магадлалтай болохыг тогтоожээ.

Олон улсын тээврийн форумын мэдээлснээр одоогийн нүүрсхүчлийн хийн бодлого нь зорчигчдын агаарын тээврийг тогтвортой голдиролд оруулахад хангалтгүй гэж үзсэн байна. Энэ хүрээнд Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Агаарын тээврийн ажлын хэсгээс 2050 он гэхэд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг тэглэх, агаарын тээврийн салбарын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх хурдавчилсан арга хэмжээ авах, эрчим хүчний шилжилт хийх, инновацыг нэвтрүүлэх томоохон зорилтыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн байна.

Цаг уурын эрсдэл, шаардлагатай арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх асуудал аялал жуулчлалын салбарт хүлээн зөвшөөрөгдөх нь нэмэгдэж байна.

2021 онд Дэлхийн аялал, жуулчлалын зөвлөл (WTTC), НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр (UNEP)-тэй хамтран аялал, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд зориулсан “тэг замын зураглал”-ыг дэвшүүлсэн бол Дэлхийн эдийн засгийн форумын Маргаашийн төлөөх цэвэр тэнгэр эвсэл 2030 он гэхэд дэлхийн агаарын тээврийн 10 хувийг тогтвортой нисэхийн түлшээр хангах зорилт тавьжээ. Нэг гараг тогтвортой аялал жуулчлалын хөтөлбөр, Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв маягийн 10 жилийн хөтөлбөр зэрэг хөтөлбөрүүд нь энэхүү чухал асуудлыг шийдвэрлэхэд анхаарч байна. 2021 онд G20-ийн удирдагчид Аялал жуулчлалын ирээдүйн талаарх Ромын удирдамжийг баталсан бөгөөд ногоон шилжилт нь аялал жуулчлалыг өөрчлөх долоон тулгуур баганын нэг юм гэж тогтоосон байна.

1.2.4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа бодлого, зохицуулалт

Аялал жуулчлалын талаар баримтлах бодлого боловсруулах гол оролцогч тал нь хувийн хэвшил байдаг. Цар тахал гарахаас өмнө үүнийг хүлээн зөвшөөрөх нь нэмэгдэж байсан хэдий ч аялал жуулчлалын салбарын олон салбарыг хамарч, олон салбартай холбогдож, зарим тохиолдолд салбаруудын ашиг сонирхол өөр хоорондоо зөрчилдөж, өрсөлддөг нь бодлого боловсруулагчдын хувьд хамтран ажиллахад бэрхшээлтэй салбар болгодог. Цар тахлын эхэн үеэс эхлэн Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэмтэй орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд нягт хамтран ажиллах олон сайн туршлагыг бий болгосон. Эдгээр туршлагуудын тусламжтайгаар ирээдүйн аялал жуулчлалын бодлогын сорилтуудыг даван туулах боломжтой юм.

Олон улс орон аялал жуулчлалын салбарын төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын аль алийг хамарсан зөвлөх баг болон ажлыг хэсгүүдийг байгуулсан байна.

Эстони Улс: Аялал жуулчлалын зөвлөх зөвлөл нь Эдийн засаг, харилцаа холбооны яам, Соёлын яам, Аялал жуулчлалын зөвлөл, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, зорин очих газар, жуулчин хүлээн авах, дамжин өнгөрүүлэх боомт, зогсоол зэргийн төлөөллөөс бүрдэх бөгөөд жилд хоёр удаа хуралдана. Энэ нь цар тахлын үеэр дугуй ширээний ярилцлага амжилттай явагдсаны дараа байгуулагдсан бөгөөд албан бус уулзалтын хэв маягаар үргэлжлүүлсэн байна.

Финланд Улс: Аялал жуулчлалын асуудлаарх дээд түвшний ажлын хэсэг 2021 оны 09 дүгээр сард байгуулагдсан бөгөөд Эдийн засаг, хөдөлмөрийн ямаар ахлуулан

холбогдох яамд, бүс нутгийн зөвлөл, Төрийн захиргаа, бүс нутгийн аялал жуулчлалын байгууллага, аялал жуулчлалын компани, судалгаа, боловсролын хүрээлэн, байгууллагуудын төлөөллөөс бүрдэж байна. Ажлын хэсэг нь 2028 он хүртэл аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой стратегиар мэргэжлийн зөвлөх шинжээчээр ажиллах юм. Мөн салбарын үйл ажиллагааны орчин, өнөөгийн нөхцөл байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аялал жуулчлалын бодлогын арга хэмжээ боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

Ирланд Улс: Зочлох үйлчилгээ, аялал жуулчлалын форум нь 2020 оны 10 дугаар сард байгуулагдсан бөгөөд хувийн хэвшил болон Засгийн газрын холбогдох бүтцүүдийн хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хангах зорилгоор байгуулагдсан. Үүний зорилго нь практик (үндэсний болон орон нутгийн) засгийн газар, хувийн хэвшлийн үйл ажиллагааг тодорхойлох үүднээс тухайн салбарт хамааралтай гол асуудлуудыг хэлэлцэх боломжоор хангах явдал юм.

Нидерланд Улс: Засгийн газар болон салбарын оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Амралт, аялал жуулчлалын асуудлаарх үндэсний ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн богино хугацааны зорилго нь цар тахлаас үүдэлтэй хямралд хариу арга хэмжээ авч, аялал жуулчлалыг дахин сэргээх явдал юм. Дунд болон урт хугацааны зорилтууд нь уян хатан, тогтвортой аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын тогтвортой хамтын ажиллагааг хангах явдал юм. Ажлын хэсэг нь аялал жуулчлалын үндэсний стратеги болох Хэтийн төлөв 2030-ийн хамтарсан үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах үүрэгтэй байна.

1.2.5. Жуулчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого

НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 2022 онд баталсан “Жуулчдыг хамгаалах олон улсын дүрэм”-ийн холбогдох хэсгийн тоймлон орчуулсныг Хавсралтаас дэлгэрүүлж үзнэ үү.

1.2.6. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, зохицуулалт, арга хэмжээ

Аялал жуулчлалын салбар нь өргөн хүрээтэй эдийн засгийн дэмжлэгийн арга хэмжээ, буцалтгүй тусламж, зээл, бүс нутгийн дэмжлэг, “niche” буюу тусгай сонирхлын бүтээгдэхүүнийг дэмжих, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх хөтөлбөр зэрэг салбарын онцлог шинж чанар бүхий дэмжлэгүүдээс ихээхэн ашиг хүртсэн. Канад Улс цар тахлын эхэлснээс 2022 оны 4 дүгээр сар хүртэл аялал жуулчлал, зочид буудлын салбар Холбооны онцгой байдлын хөтөлбөрөөр дамжуулан ойролцоогоор 23 тэрбум канад долларын дэмжлэг олгосон байна.

Улс орнууд цар тахлын үед олон улсын аялал жуулчлалын маркетингийн төсвийг танах, эсхүл дотоодын аялал жуулчлалын маркетингт шилжүүлэх арга хэмжээг ихээр авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Грек Улсад 2020 онд нэвтрүүлсэн “Бүх хүмүүст зориулсан аялал жуулчлал” хөтөлбөр нь зочид буудал болон бусад буудаллах газруудад татаас олгох замаар дотоодын аялал жуулчлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2020-2025 онд нийтдээ 100 сая еврогийн санхүүжилтийг төсөвлөсөн байна. Аялал жуулчлалын бизнесийн дэмжлэгээс гадна аялал жуулчлалын маркетинг нь богино хугацааны өсөлтийн гол хөдөлгөгч хүч юм.

2021 онд “Швед Улсад зочлоорой” хөтөлбөрийн санхүүжилтэд дотоодын аялал жуулчлалын маркетингт зориулан 20 сая швед крон нэмэлтээр хуваарилсан бол “Зорин очих газар-Канад Улс” хөтөлбөрт 2021 онд дотоодын аялал жуулчлалын маркетингт 100 сая канад доллар төсөвлөсөн байна. АНУ нь хувьд 2022 онд олон улсын жуулчдын тоо

буурсны улмаас санхүүжилтийн эх үүсвэрийн орлого тасарсан “Brand USA” хөтөлбөрийн санхүүжилтэд 250 сая ам.долларыг төсөвлөсөн байна. Эстони Улсын Аялал жуулчлалын зөвлөлийн хөгжлийн үйл ажиллагааны санхүүжилт 2021 онд 2.0 сая еврогоос 2022 онд 11.5 сая евро болж нэмэгдсэн байна.

Зарим улс орон дотоод хүчин чадлаа нэмэгдүүлээд хөрөнгө оруулалт хийсэн байна Тухайлбал, Шинэ Зеланд Улсын 2022-2023 оны улсын аялал жуулчлалын дата мэдээлэл, бодлогод 8 сая шинэ зеланд доллар төсөвлөсөн бол Австрали Улс аялал жуулчлалын мэдээлэл, дүн шинжилгээг сайжруулахад 4.8 сая австрали долларыг хуваарилсан байна. Европын Холбооны хувьд улс орнууд Европыг нөхөн сэргээх болон “NextGen EU”-ны төлөвлөгөө зэргийн хүрээнд аялал жуулчлалын салбарт дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, 2021-2027 онд ЕХ-ны Ногоон хэлцэл зэрэг ЕХ-ны бүтцийн сангаас Польш Улсын аялал жуулчлалын салбарын тодорхой төслүүдэд санхүүжилт олгохоор төсөвлөсөн байна. “NextGen EU” болон “React EU”-ны сангаас Словени Улсын аялал жуулчлалын салбарт санхүүжилт олгосон байна. Тухайлбал, “ЕХ-ны техникийн дэмжлэг-2022” нь Хорват, Грек, Итали, Мальта, Португал, Словени, Испани зэрэг долоон улсын сэргээн босголт, шинэчлэлийн хөтөлбөрийг дэмжиж, илүү тогтвортой, уян хатан, дижитал аялал жуулчлалын экосистемийг бий болгохыг зорьж байна. Эдгээр төслүүд нь тогтвортой аялал жуулчлалын үзүүлэлтүүд, засаглал, зорин очих газрын менежментийн хэрэгслүүд, ЖДҮ-ийн дэмжлэг, аялал жуулчлалын экосистемийг дижитал болгоход чиглэсэн аялал жуулчлалын өгөгдөл, статистик (*Tourism Satellite Account*) зэрэгт шинэчлэл, сайжруулалт хийхэд анхаарч байна.

Хоёр.ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААР

2.1.ГҮРЖ УЛС

Гүрж Улс нь 69,700 хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, 3,708.61 сая¹⁴³ хүн амтай. Зүүн Европ болон Баруун Азийн уулзвар дээрх Кавказын бүс нутагт оршдог бөгөөд газарзүйн байршлын хувьд Европ, Ази тивүүдийн хилийг дамнан байрладаг онцлогтой. Баруун талаараа Хар тэнгист гарцтай, хойд болон зүүн хэсгээрээ Орос, баруун урд талаараа Турк, урд хэсгээрээ Армен, зүүн урд талаараа Азербайжантай тус тус хиллэдэг.

Гүрж Улс нь байгалийн үзэсгэлэн, газарзүйн байршил, цаг уурын тааламжтай нөхцөл, өвөрмөц сайхан хоол унд, ялангуяа улаан дарс, мөн баялаг түүх, соёлын өв зэрэг онцлого давуу талуудтай ба үүнийг ашиглаж аялал жуулчлал сайн хөгжих боломж өндөртэй байна.

Тус улс нь 2009-2013 онуудад аялал жуулчлалын салбарын өсөлтөөрөө дэлхийд өндөр үзүүлэлттэй орнуудын тоонд багтсан. Энэ хугацаанд тус улсад ирсэн жуулчдын тоо 300 хувиас илүү өсөлттэй байсан бөгөөд 1.5 саяас 5.4 саяд хүрч аялал жуулчлалын үйл ажиллагаанаас олсон орлого 475 сая ам.доллараас 1.8 тэрбум ам.доллар хүрсэн байна. 2019 онд 9.4 сая гадаадын жуулчин хүлээн авсан бөгөөд 2018 онтой харьцуулахад 8 хувиар өсчээ. 2019 онд хамгийн их жуулчин хүлээн авсан бөгөөд аялал жуулчлалын салбар нь ДНБ-ийн 8.4 хувьтай тэнцсэн нь 2015 оноос хойш 8 жилийн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлтийг харуулсан байна. 2020 онд аялал жуулчлалын салбар ДНБ-ийн 5.9 хувьтай, 2021 онд 6.4 хувьтай тэнцсэн байна.

¹⁴³ World bank, https://data.worldbank.org/indicator/SP.POP.TOTL?locations=GE&name_desc=false

Ковид-19 цар тахлын үеэр энэ салбар зогсонги байдалд орсон боловч 2021-2022 онуудад эргээд сэргэх хандлагатай байна.¹⁴⁴ Аялал жуулчлалын үндэсний захиргааны мэдээлснээр 2021 оны 5 дугаар сарын байдлаар жуулчдын тоо 2020 оны мөн үетэй харьцуулахад 264 хувиар өссөн. 2022 онд мэдэгдэхүйц өсөлттэй, ялангуяа аялал жуулчлалын салбарын орлого цар тахлын өмнөх үеийнхээс давсан үзүүлэлттэй гарчээ.

Гүрж Улсыг зорих жуулчдын ихэнх хэсгийг хөрш орны жуулчид бүрдүүлдэг бөгөөд үүнд нөлөөлдөг томоохон хүчин зүйлийн нэг социализмын үеэс эхлэлтэй Гүрж бол амралтын орон гэсэн ойлголт юм. Цаашдаа илүү өндөр зардалтай зах зээлээс жуулчдыг татах, тухайлбал, Америк, Хятадын жуулчдыг татах зорилготой байна.

Хууль эрх зүйн орчин

Аялал жуулчлалын харилцааг тусгайлсан хууль буюу **Гүржийн Аялал жуулчлал болон амралтын газрын тухай хуулиар** (Law of Georgia on Tourism and Resorts) зохицуулж байна.¹⁴⁵ Энэ хуулиар тухайн салбарын үндсэн ойлголтууд болох аялал жуулчлал, жуулчин, аялал жуулчлалын үйл ажиллагаа, амралтын газар, аялал болон бусад ойлголтуудыг тодорхойлсон байдаг.

Энэхүү хуулиар салбарын бүх асуудал зохицуулагдаагүй бөгөөд зарим асуудлыг бусад хуулиар зохицуулсан байна. Дээрх хуулиас гадна **Амралтын газар болон амралтын газар орчмын бүсийн эрүүл ахуйг хамгаалах тухай** (Law of Georgia on Sanitary Protection Zones of Resorts and Resort Sites) хуулийг хэрэгжүүлдэг. Энэ хуулиар амралтын газруудын байршил, амралтын газрын бүсэд байх аж ахуйн нэгж, бизнес эрхлэлт, нийтийн орон сууц болон байгалийн эм, эмчилгээний нөөцийг ашиглахад шаардагдах нөхцөлийн талаар, мөн байгалийн эмчилгээнд ашиглагдах нөөцийг хадгалан хамгаалах болон тэдгээрийг бохирдох, муудах, хомстохоос сэргийлэн хамгаалах талаар зохицуулсан байна.¹⁴⁶

Аялал жуулчлалын зарим үйл ажиллагааг **Гүржийн Иргэний хуульд** зохицуулсан байдаг. Энэ хуульд талуудын гэрээний үүргийг, тухайлбал, аялал зохион байгуулагчийн (travel organiser) зүгээс үйлчилгээ үзүүлэх, аяллын талаар нарийвчилсан мэдээлэл өгөх, жуулчдын санал хүсэлт, гомдолд хурдан шуурхай хариу өгөх, төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд баталгаа гаргах зэрэг үүргийг тодорхойлсон. Аялал жуулчлалын гэрээгээр талуудын эрх, үүргийг тодорхойлохоос гадна банкны үйлчилгээ, зорчигч тээвэр, ачаа тээврийн болон бусад ижил төрлийн хэлэлцээрийн талаарх харилцааг зохицуулдаг.¹⁴⁷

Гүржид аялал жуулчлалын асуудлыг Эдийн засаг, тогтвортой хөгжлийн яам болон Гүржийн аялал жуулчлалын үндэсний захиргаа хариуцан ажилладаг. Яам нь салбарын удирдлага болон бодлого боловсруулах асуудлыг хариуцан ажилладаг бол Үндэсний захиргаа нь салбарын бүтээгдэхүүн болон бизнес эрхлэлтийг хөгжүүлэх, мөн салбарын маркетингийн асуудлыг хариуцах, салбарыг хөхиүлэн дэмжих чиг үүрэгтэй байна.

Аялал жуулчлалын төрөл

Гүржид аялал жуулчлалаар ирсэн хүмүүс дараах аялал жуулчлалын төрлүүдээс сонгон аялж амрах боломжтой байна.¹⁴⁸

¹⁴⁴ «Грузия – страна жизни». Стратегия развития туризма в Грузии, <https://www.vsemirnyjbank.org/ru/news/feature/2015/12/07/a-tourism-strategy-for-georgia-country-of-life>

¹⁴⁵ Ministry of Economy and Sustainable Development of Georgia, <https://www.economy.ge/?page=ecoleg&s=15>

¹⁴⁶ Tourism law in Europe, <https://publications.eshte.pt/dir/tlie/tlie/214/>

¹⁴⁷ Tourism law in Europe, <https://publications.eshte.pt/dir/tlie/tlie/214/>

¹⁴⁸ How to open a travel company in Georgia, <https://accounting.jara.ge/how-to-open-a-tourist-company-in-georgia/?lang=en>

- **Бизнес аялал.** Бизнесийн томоохон арга хэмжээ, хурал, чуулган гэх мэт. Энэ төрлийн үйлчилгээ үзүүлэхэд Radisson, Intercontinental, Holiday Inn зэрэг дэлхийн зочид буудлын сүлжээнүүд асар их үүрэг гүйцэтгэдэг.
- **Соёл, шашны аялал.** Энэхүү хөтөлбөр нь Гүржийн алдартай түүх, соёлын гол дурсгалт газрууд, сүм хийд болон сүм хийдийн цогцолборуудыг үзэх хүсэлтэй жуулчдад тохиромжтой.
- **Уулын аялал.** Гүржид уулын аялал хийх өргөн боломжтой бөгөөд Шхара, Казбекийн оргил бүхий Кавказын нуруу уулчдын сонирхлыг татдаг.
- **Өвлийн аялал.** Цанын баазууд, ялангуяа Гудаури, Бакуриани, Местиа руу өвлийн аялал хийх нь алдартай байдаг.
- **Эко хөтөлбөрүүд.** Энэ нь өвөрмөц ургамал, амьтан бүхий тусгай хамгаалалттай газар нутгийг зорих хүсэлтэй хүмүүст чиглэгддэг.
- **Хөдөө аж ахуйн аялал жуулчлал.** Тус улс нь амттай хоол, ялангуяа дарсны амтыг мэдрэхийг хүссэн хүмүүст сонирхолтой байдаг.
- **Эмчилгээний аялал жуулчлал.** Өвөрмөц эмчилгээ, рашаан, шавар эмчилгээ, цэвэр агаар нь оршин суугчид болон гадаадын жуулчдад сайн үр дүнтэй.
- **Амралтын газар.** Энэ нь Хар тэнгисийн эрэгт амрах хүсэлтэй хүмүүст тохиромжтой.
- **Экстрим аялал.** Ууланд аюултай авиралт хийхээс гадна аялал жуулчлалын компаниуд гол мөрний хавцал руу буух гэх мэт жинхэнэ адал явдалтай аяллуудыг санал болгодог.

2.1.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт

Тус салбарыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ

Гүрж Улсын Засгийн газар 2015 онд “Гүржийн аялал жуулчлалын стратеги 2015-2025” урт хугацааны стратеги төлөвлөгөөгөө баталсан. Стратегийг боловсруулахдаа Дэлхийн банкны дэмжлэгийг авсан бөгөөд хувийн сектор, үндэсний болон орон нутгийн түвшний удирдах байгууллагууд, тур операторууд, хөрөнгө оруулагчид, соёлын өвийн объектууд болон тусгай хамгаалалт бүхий газар нутгийн захиргааны төлөөлөл, зочид буудлын эзэд, боловсролын аялал жуулчлалын төлөөлөл болон бүх давхаргын иргэдийн төлөөлөл зэрэг бүх оролцогч талуудын оролцоог өргөнөөр хангаж ажилласан байна.

Энэхүү стратеги нь улс орны эдийн засаг, ялангуяа иргэдийн тусын тулд аялал жуулчлалын үнэ цэнэ, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилготой 10 жилийн алсын хараа, стратеги төлөвлөгөө юм. Үүнийг жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зах зээл болон бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, үйлдвэрлэлийн хэмжээ, ашигт ажиллагааг тогтвортой өсгөх, ажлын байр бий болгох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр боловсруулсан байна.

Стратегийн алсын харааг “2025 он гэхэд өөрийн өвөрмөц соёл, зочломтгой зан заншил, байгалийн өв уламжлалдаа төвлөрсөн, үйлчлүүлэгчиддээ өндөр чанартай, дээд зэрэглэлийн үйлчилгээ үзүүлдэг, жилийн турш үргэлжилдэг аялал жуулчлалын газар гэдгээрээ дэлхийд танигдах болно” гэж тодорхойлжээ.

Стратегийн гол зорилго нь дэд бүтцийн хөгжилд стратегийн хөрөнгө оруулалт хийх, холбогдох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, төлбөрийн чадвар сайтай гадаадын жуулчдад Гүрж орны өвөрмөц байдлыг танилцуулах замаар Гүржийг аялал жуулчлалын зах зээлд тэргүүлэгч байр сууринд хүргэх явдал юм. Түүнээс гадна Гүржийн аялал жуулчлалын

салбарын үнэ цэн, ашигт ажиллагаа, тогтвортой хөгжлийг нэмэгдүүлэх замын зураглал гаргахыг зорьсон байна.

Уг стратегид 8 зорилтыг дэвшүүлсэн байна.¹⁴⁹

- Гүржийн байгалийн болон соёлын үнэт зүйлсэд хүндэтгэлтэй хандах, сэргээн сайжруулах, хамгаалах;
- Байгалийн болон соёлын үнэт зүйлсэд төвлөрсөн жуулчдын онцгой, өвөрмөц туршлагыг бий болгох;
- Жуулчдад үзүүлэх үйлчилгээг дэлхийн жишигт нийцүүлж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлалын үйлчилгээний маркетинг болон дэмжлэгийг өргөжүүлэн нэмэгдүүлэх замаар төлбөрийн чадвар өндөртэй жуулчдыг татах;
- Аялал жуулчлалын дата мэдээллийг цуглуулах, анализ хийх, мөн үйлдвэрлэлийн гүйцэтгэлийг хэмжих чадварыг сайжруулах, өргөжүүлэх;
- Аялал жуулчлалын салбарт төрийн болон хувийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах;
- Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд төр, аж үйлдвэр, төрийн бус байгууллагууд болон нийгэмлэгүүд хоорондын түншлэлийг бий болгох.

Энэхүү аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөндөө салбарын 2025 он хүртлэх төсөөллийг тодорхой зааж өгсөн байна.

Засгийн газар нь аялал жуулчлалын зах зээлийг төрөлжүүлэх, тус улсын талаарх мэдлэг, мэдээллийг илүү сайн түгээх, чанар сайтай аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгоход хувийн хэвшилд дэмжлэг үзүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, дотоодын аялал жуулчлалын зах зээлийг идэвхжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Засгийн газар аялал жуулчлалыг дэмжих зорилгоор виз авах журмыг хялбаршуулсан. Мөн хурдны замаа нэмэгдүүлэх, энтертайнмент парк болон зочид буудлуудаа хувьчлах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн тур операторуудыг татварын урамшуулал олгох замаар дэмждэг.

Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхэд, мөн хөрөнгө оруулалт татахад анхаардаг бөгөөд төрийн өмчит “Түншлэлийн сан” болон хувийн “Гүржийн Хамтын хөрөнгө оруулалтын сан”-гууд аялал жуулчлалын бүс болох Имерети, Аджара, Кахети зэрэг бүс нутгуудад дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийхэд анхааран ажилладаг.

2021 онд тус улсад ирсэн гадаад жуулчдын ихэнх хэсгийг Орос, Азербайжан, Армени, Турк зэрэг хөрш орны жуулчид бүрдүүлсэн байна. Засгийн газар нь Ойрх Дорнод чиглэлийн нислэгийн тоог нэмэгдүүлэх замаар бусад орнуудаас ирэх жуулчдын тоог өсгөх, мөн Гүржийг жилийн 4 улирлын турш аялал жуулчлалын орон болгохыг тэргүүлэх зорилгоо болгосон. Түүнээс гадна эрүүл мэнд, энтертайнмент, биеийн тамир, улаан дарс болон эко аялал жуулчлалыг дэмжиж байна.

Аялал жуулчлалын агентууд аялах боломжит жуулчдад (potential tourists) ашигтай, тав тухтай үйлчлэх авиакомпаниуд болон аяллын маршрут, ямар зочид буудалд буудаллах, ямар газруудаар аялах талаар зөвлөх, санал болгох замаар жуулчдыг татаж байдаг.

¹⁴⁹ A Tourism Strategy for Georgia – New Path Ahead, <https://www.worldbank.org/en/news/feature/2015/12/07/a-tourism-strategy-for-georgia-new-path-ahead>

Гүрж Улсад гадаад, дотоодын жуулчдад аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгөх, Гүржийн бүс нутгийн аялал жуулчлал болон тэдний санал болгож буй шинэ бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор байгуулагдсан аялал жуулчлалын мэдээллийн төвүүд ажилладаг.

Аялал жуулчлалын мэдээллийн төвүүд жуулчдад дараах үйлчилгээг үзүүлж байна.¹⁵⁰

- Тус улсад одоо байгаа аялал жуулчлалын байгууламжийн талаарх мэдээлэл, түүн дотроо байрлах байр, нийтийн хоолны газар, нийтийн тээвэр, үйлчилгээний цагийн хуваарь, музей, галерей, дарсны үйлдвэр, дарсны зоорь зэрэг мэдээллийг өгөх;
- Аялал жуулчлалын, соёлын өвийн дурсгалт, дархан цаазат, байгалийн цогцолборт болон амралтын газар гэх мэт улс орны үзэсгэлэнт газрууд, аялал жуулчлалын бусад газруудын талаарх мэдээлэл;
- Аяллуудын талаар мэдээлэл өгөх, тодорхой аялал зохион байгуулахад туслах;
- Зохион байгуулж буй болон төлөвлөгдсөн зугаа цэнгэл, баяр наадмын (үндэсний, соёл урлаг, үзвэр, спорт гэх мэт) талаар мэдээлэл өгөх;
- Хэвлэмэл материал (бүс нутгийн болон хот суурингийн газрын зураг, товхимол, гарын авлага гэх мэт) түгээх.

Гүржийн Үндэсний аялал жуулчлалын газар нь 24/7 горимоор үнэгүй лавлах утасны үйлчилгээ явуулдаг. Мөн аялал жуулчлалын мэдээллийг онлайнгаар 24/7 горимоор www.georgia.travel вэб хаягаар авах боломжтой.

Гүржийн Үндэсний Аялал жуулчлалын захиргаанаас улсаа сурталчлах зорилгоор олон төрлийн бэлэг дурсгалын зүйл, аялал жуулчлалын бараа бүтээгдэхүүн дээр "Гүрж бол амьдралын орон" (Грузия – страна жизни) гэсэн уриаг дүрслэх санаачилга гарган хэрэгжүүлсэн нь тус улсыг гадаадад таниулах үр дүнтэй аргуудын нэг юм.


Аялал жуулчлалд Засгийн газраас энэ салбарт төсөвлөсөн зарцуулалт тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна. Түүнээс гадна маркетингийн кампанит ажил, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд байршуулсан зар сурталчилгаа нөлөө үзүүлдэг.

Доорх зургаас харахад Гүржийн аялал жуулчлалын салбартаа зарцуулж буй зардал ихээхэн хэлбэлзэлтэй байна. Аялал жуулчлалын зардал 2020 онд хамгийн их буурсан бөгөөд цар тахлын улмаас тус улсад гадаадын жуулчид бараг ирээгүй. Энэ салбар дотоодын жуулчдаас ихээхэн хамааралтай болсон тул бизнесүүд хаагдахаас сэргийлж Засгийн газраас татаас олгосон. Аялал жуулчлал сэргэхийн хэрээр төрийн зардал ч нэмэгдэж байгаа бөгөөд 2022 онд төсвийн зарлага 99%-аар, 2023 онд 45%-аар нэмэгдэхээр төсөвлөсөн байна.¹⁵¹


¹⁵⁰ Ministry of Economy and Sustainable Development of Georgia, <https://www.economy.ge/?page=services&s=32>

¹⁵¹ Tourism industry in Georgia, December 2022, TBC Capital, <https://tbccapital.ge/static/file/202212280624-tourism-industry-in-georgia-december-2022.pdf>

Зураг 1. Гүржийн Засгийн газрын аялал жуулчлалд төсөвлөсөн зарцуулалтын хэмжээ



Зураг 2. Гүржийн аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ болон нийт төсөвт эзлэх хувь хэмжээ



2.1.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг

Гүржийн Засгийн газрын зүгээс аялал жуулчлалын бизнес эрхлэхийг сайн дэмждэг. Гадаад, дотоодын ялгаагүй энэ чиглэлээр бизнес явуулах компанийг түргэн шуурхай бүртгэх тааламжтай нөхцөл бүрдүүлсэн бөгөөд хүндрэл чирэгдэлгүйгээр 24 цагийн дотор хялбархан бүртгүүлэх боломжтой.

Тус улсад аялал жуулчлалын бизнес эрхлэхэд дараах давуу талууд нөлөөлж байна.¹⁵²

- Улс орны эдийн засгийн хэтийн төлөв;
- Европ болон Азийн зах зээлтэй нэгдэх боломжийг нээж өгсөн газарзүйн ашигтай байршил;
- Бизнесийг бүртгэх энгийн хялбар механизм, оршин суугч болон оршин суугч бус хүмүүст тавигдах шаардлага хамгийн бага;
- Гүржийн Засгийн газраас аялал жуулчлалын компаниудад үзүүлдэг идэвхтэй дэмжлэг;
- Татварын таатай хувь хэмжээ.

Аялал жуулчлалын бизнес эрхлэгч нь аялал жуулчлалын багц үйлчилгээ үзүүлэх бөгөөд уг багцад жуулчдын унаа тээврийн, зочид буудалд байрлуулах, хоол ундны, аялал хийх үйлчилгээ, түүнээс гадна албан ёсны арга хэмжээнд зориулсан хурлын танхим, бусад

¹⁵² Services for tourist company in Georgia, <https://accounting.jara.ge/how-to-open-a-tourist-company-in-georgia/?lang=en>

техник, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг үйлчилгээ багтана. Тухайн аялал жуулчлалын бизнес эрхлэгч нь эдгээрээс дор хаяж хоёр үйлчилгээг багтаасан багц үйлчилгээ үзүүлэх ёстой. Жишээлбэл, жуулчдыг нисэх онгоцны буудлаас зорьсон газарт нь хүргэх унаа тээврийн болон оройн хоолны үйлчилгээ гэх мэт.

Татварын хуулийн 168 дугаар зүйлд заасны дагуу ийм үйл ажиллагаанд НӨАТ ногдуулдаггүй. Хэрэв НӨАТ төлөх шаардлага гарвал буцаан авах боломжтой байна. Энэ хуулиар татварын хөнгөлөлт эдэлдэг микро болон жижиг бизнесүүдийг тодорхойлсон бөгөөд энд аялал жуулчлалын салбарт хамаарах бизнесүүд мөн багтана. Түүнчлэн зочид буудал болон түүнтэй ижил төрлийн газрууд ч хамрагдана. Мөн хуулиар аялал жуулчлалын бүсэд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжид үзүүлэх татварын хөнгөлөлттэй нөхцөлийн талаар зохицуулсан байдаг.

Жуулчны карт.¹⁵³ Гүржийн банкнаас тус улсад ирсэн жуулчдын тав тухыг хангах зорилгоор олон зориулалт бүхий Жуулчны карт олон улсын Visa картыг гаргасан бөгөөд гадаадын жуулчид болон Гүржийн иргэд автобус, метро, микроавтобус, дүүжин зам гэх мэт нийтийн тээвэрт уг картыг ашиглах боломжтой.

Энэхүү картыг хэрэглэгчдэд тус улсын кафе, ресторан, музей, үндэсний цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын компаниуд, зочид буудал, бэлэг дурсгалын зүйлс, дагалдах хэрэгслийн дэлгүүрүүд тусгай хөнгөлөлт үзүүлдэг. Мөн карт эзэмшигчид үүрэн холбооны оператораас сим карт, өндөр хурдны интернет эрх бэлэглэдэг.

Жуулчны карт авах нь маш хялбар бөгөөд биеийн байцаалт шаардлагагүй. Картад гадаад валютаар хийсэн мөнгө автоматаар Гүржийн мөнгөн тэмдэгт Лари руу хөрвүүлэгдэнэ.

2.1.3. Аялал жуулчлалын салбарт агаарын болон бусад тээврийн үзүүлэх нөлөөлөл, холбогдох зохицуулалт

Гүрж Улсад аялал жуулчлалаар ирэхдээ агаарын, хуурай, усан замын аль алийг ашиглах боломжтой. Энэ нь аялал жуулчлалд эерэгээр нөлөөлж байна.

- **Агаарын зам.** Онгоцоор ирэх нь хамгийн хялбар бөгөөд хурдан арга юм. Гүржид Тбилиси, Батуми, Кутаиси зэрэг гурван гол нисэх онгоцны буудал байдаг бөгөөд ихэнх тохиолдолд жуулчид эдгээр буудалд буудаг. Мөн Абастумани амралтын газарт бууж байна. Тус улсад тээврийн дэд бүтэц боломжийн хөгжсөн тул эдгээр нисэх буудлуудаас бусад амралтын газрууд руу явахад хялбар байдаг. Гүржийг зорих жуулчдын гол урсгал нийслэл хот Тбилисид ирдэг. Тэндээс Казек, Гудаури зэрэг уулын хотууд руу явах боломжтой бөгөөд Тбилисиэс эдгээр хот руу чиглэсэн тээврийн гол зам нь Гүржийн цэргийн зам юм. Түүнээс гадна нийслэл хотоос Гүржийн дарсны бүс нутаг Кахетигийн төв рүү явахад бас тохиромжтой. Мөн унтарсан галт уул, нуур, асар том тэгш өндөрлөг бүхий газар Самцхе-Жавахетид (Гүржийн "Төвд" гэгддэг) хүрч болно. Агуйн бүс нутаг - Вардзиа, Уплистсихе, Боржоми, Давид Гарежи хийд хүртэл явахад тохиромжтой. Илүү хямд нислэг сонирхсон хүмүүс Кутаисиг сонгох ба тэндээс Батуми болон бусад хот руу явах боломжтой.
- **Хуурай зам (Автозам).** Онгоцоор нисэхээс гадна хувийн машинаар тус улсад очих боломжтой. Хамгийн тохиромжтой сонголт бол Гүржийн цэргийн зам юм. Гүржийн Автозамын газраас тус улсад машинаараа ирэх жуулчдад мэдээлэл өгөх зорилготой www.georoad.ge вэбсайтыг ажиллуулдаг. Энэ нь замын төлөв

¹⁵³ Tourist Card from Bank of Georgia gives benefits to visitors, <https://agenda.ge/en/news/2018/984>

байдлын талаарх мэдээллийг агуулдаг. Түүнээс гадна тусгай дугаарын лавлах утсанд холбогдож мэдээлэл авах боломжтой байна.

- **Усан зам.** Сочи хотоос Батуми хотод ирдэг Ильичевск-Батуми чиглэлийн зорчигч тээврийн усан онгоцоор хүрэх боломжтой.
Хот хооронд зорчиход тээврийн хэрэгслээ сонгох боломжтой бөгөөд галт тэрэг, шугамын болон микроавтобус, такси үйлчилгээ, түрээсийн автомашин ашиглаж байна.
- **Төмөр зам.** Боломжит маршрут, галт тэрэгний явах хуваарийг www.railway.ge төмөр замын вэбсайтаас авч болно. Сайт дээрх бүх мэдээллийг англи болон орос хэлээр авах боломжтой. Хамгийн их ашиглагддаг чиглэл бол Тбилиси-Батуми бөгөөд тав тухтай Экспресс галт тэрэг явдаг.
- **Шугамын автобус, микроавтобус.** Энэ нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг тээврийн хэрэгсэл юм. Нийслэл хотод хоёр том автобусны буудалтай бөгөөд тэдгээрээс Гүржийн бүх цэгүүд рүү явдаг. Үүнээс гадна илүү тав тухтай үйлчилгээ буюу зорчигч тээврийн үйлчилгээг дээд зэргээр хангадаг автобусаар үйлчилдэг 2 компани байдаг. Эдгээр автобусны тасалбарын үнэ нь микроавтобусны тасалбартай ижил үнэтэй. "Метро", "Гүржийн автобус" гэсэн нэртэй эдгээр хоёр компанийн маршрут, тасалбарын үнэ, хуваарийг geometro.ge вэбсайтаас авах боломжтой. "Гүржийн автобус" компани нь Жуулчны карт эзэмшигчдэд 10%-ийн хөнгөлөлт үзүүлдэг байна.
- **Такси, transfer үйлчилгээ.** Машинаар явахыг илүүд үздэг хүмүүс такси үйлчилгээг сонгож болно. Гүржид хот хооронд явахад ихэвчлэн такси ашигладаг. Мөн **transfer** тээврийн үйлчилгээ захиалах боломжтой.
- **Машин түрээслэх.** Дээрх сонголтуудаас гадна машин түрээслэж аялах боломжтой. Машины түрээсийн үйлчилгээ үзүүлэгч ихэнх компаниуд Жуулчны карт хөтөлбөрт хамрагдсан байх тул хөнгөлөлт эдлэх боломжтой байдаг. Олон тооны уулын замтай учраас жийп төрлийн машин илүү тохиромжтой.
- **Замын унаанд** дайгдах боломжтой.

Тээврийн үйлчилгээ жуулчдыг зорьсон газарт нь хүргэдэг тул аялал жуулчлалын чухал хэсэг байдаг. Гүрж нь тус улсад ирж буй жуулчдад олон төрлийн тээврийн хэрэгслийг санал болгодог. Энэ улсыг зорьсон жуулчдын дийлэнх нь агаарын болон хуурай замаар онгоц болон машинаар ирдэг. 2020 онд нийт ирсэн жуулчдын 2% төмөр зам болон усан зам ашигласан бол энэ нь бусад жилүүдэд ердөө 1% байжээ. 2020 онд цар тахлын улмаас агаарын тээврийг хязгаарласан тул хуурай замаар тус улсад орж ирэх нь дээд цэгтээ (80%) хүрсэн байна. Харин цар тахлын дараа агаарын хилээр орж ирэх хүмүүсийн эзлэх хувь харьцангуй өндөр болсон. Гүржид гадаадаас ирэх жуулчдын ихэнх хувийг хөрш орнуудын жуулчид эзэлдэг бөгөөд тэдний ихэнх нь хуурай замаар орж ирдэг. Тус улс нь гадаадын жуулчдыг хүлээж авах Тбилиси, Кутаиси, Батуми зэрэг гурван онгоцны буудалтай. Эдгээр буудлуудын хүлээн авч буй зочдын тоо цар тахлын өмнөх түвшинд хүртлээ сэргэж амжаагүй байгаа ч 2021, 2022 онуудад өндөр өсөлттэй гарсан байна. Нийслэл Тбилиси хотын нисэх онгоцны буудал нь Гүржийн хамгийн том буудал бөгөөд агаарын замаар ирэх жуулчдын дийлэнх нь үүгээр үйлчлүүлдэг. 2021 онд Гүржид 39 агаарын тээврийн компани ажиллаж байснаас зорчигчдын тоогоор Турк Эйрлайнс хамгийн их хувийг эзэлжээ. Агаарын тээвэр нь ихэвчлэн төсвийн агаарын тээврийн компаниудаас бүрддэг. Нислэгийн боломж нь гадаадын жуулчдыг төрөлжүүлэхэд чухал

ач холбогдолтой бөгөөд ая тухтай аялах боломж бүрдүүлэх нь жуулчид тухайн улс орон руу аялах шийдвэр гаргахад ихээхэн нөлөөлдөг байна.¹⁵⁴

2.1.4. Жуулчны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого¹⁵⁵

Гадаад орон руу аялахад юуны түрүүнд аюулгүй байдал хамгийн чухал асуудлын нэг байдаг. Гүрж Улс нь жуулчдын хувьд Европтоо аюул багатай орны тоонд ордог. Numbeo-гийн хийсэн судалгаагаар¹⁵⁶ Гүрж Улс нь 2022 оны байдлаар аюулгүй байдлын индексээрээ дэлхийн 459 орноос 48-р байранд жагссан байна.

Түүнчлэн гүржүүд зочноо бурхнаас илгээсэн бэлэг гэж билэгшээдэг тул зочломтгой хандаж тав тухтай байлгахад ихээхэн анхаардаг. Энэ нь тус улсад аялж амрахаар ирсэн гадаад жуулчдад ээлтэй, тааламжтай байдаг. Мөн Гүржийн цагдаа нар жуулчдад 24/7 горимоор үйлчилнэ. Цагдаагийн байгууллага нь тус улсын хамгийн найдвартай байгууллагуудын нэг бөгөөд хүн амын 74 орчим хувь нь өндөр итгэл үзүүлдэг. Гүрж энэ үзүүлэлтээрээ Европын орнуудыг тэргүүлдэг байна.¹⁵⁷

2.1.5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, зохицуулалт, арга хэмжээ¹⁵⁸

Гүржийн Үндэсний статистикийн газрын (Геоостат) мэдээлснээр 2021 онд тус улсын 15 ба түүнээс дээш насны 1,2 сая иргэн дотооддоо 1,4 сая удаа зорчиж, нийт зардал нь 226 сая лари (70 сая доллар/63,7 сая евро) болсон байна.

2021 онд Гүржийн оршин суугчдын дотоодын жуулчдын сарын дундаж тоо 662.6 болсон нь өмнөх оныхоос 37.9%-аар өссөн байна. Дотоодын жуулчдын дийлэнх нь Гүржийн нийслэл Тбилиси (сард дунджаар 300,1 айлчлал) болон баруун Имеретид (сард 241,9 айлчлал) ирсэн байна.

Дотоодын аялал жуулчлал хийх гол шалтгаанууд:

- Найзууд / хамаатан садандаа зочлон очих – 46.9%;
- Өөр газар байрлах байрандаа түр шилжин амьдрах (зуслангийн байшин, хаус гэх мэт) – 15.9%;
- Худалдан авалт хийх (shopping)– 13.2%;
- Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ – 8.9%;
- Баяр наадамд оролцох / амрах – 8.1%;
- Бизнес болон ажлын шугамаар – 3.5%;
- Шашны үйл ажиллагаа / мөргөл үйлдэх – 1.5%;
- Боловсрол / сургалт – 0.2%.

2021 онд 31-50 насныхан дотооддоо хамгийн их аялсан (38.4 хувь) ба үүний 53.6 хувь нь эмэгтэйчүүд байжээ. Дотоодын аялал жуулчлалын дийлэнх буюу 43.9%-ийг Тбилиси хотын, 11.5%-ийг Квемо Картли бүс нутгийн оршин суугчид хийжээ. 2021 оны дөрөвдүгээр улиралд жуулчдын сарын дундаж тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.1%-аар өссөн үзүүлэлт гарчээ.

¹⁵⁴ Tourism industry in Georgia, December 2022, TBC Capital, <https://tbccapital.ge/static/file/202212280624tourism-industry-in-georgia-december-2022.pdf>

¹⁵⁵ https://georgia.travel/en_US/georgia

¹⁵⁶ Numbeo бол Сербийн олон нийтийн мэдээллийн сан юм. 2009 оны 4 дүгээр сард үүсгэн байгуулагдсан ба энэ нь хэрэглэгчдэд "улс, хот хоорондын амьдралын өртөг, аюулгүй байдал, гэмт хэргийн байдал болон бусад мэдээллийг хуваалцах, харьцуулах боломжийг олгодог. <https://www.numbeo.com/crime/rankings.jsp?title=2021&displayColumn=1>

¹⁵⁷ Explore Georgia, https://georgia.travel/en_US/georgia

¹⁵⁸ Agenda.ge, <https://agenda.ge/en/news/2022/730>

2.2. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Аялал жуулчлалын салбар нь БНСУ-ын эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулдаг голлох салбаруудын нэг бөгөөд 2018 онд буюу Ковид-19 цар тахлын өмнө ДНБ-ийн 4.7%-ийг эзэлж, (2023 оны байдлаар 0.72%) 1.4 сая ажлын байрыг бий болгож, нийт ажил эрхлэлтийн 5.3%-ийг эзэлж байгаа тооцоолол гарсан байна. Аялал жуулчлалын экспорт 2018 онд нийт үйлчилгээний экспортын 15.5%-ийг эзэлж байсан байна.¹⁵⁹

БНСУ-д айлчилсан жуулчдын тоо¹⁶⁰ 15.1%-аар өсч 15.3 саяд хүрсэн. Хамгийн их зочдын урсгалыг Азийн орнууд, тэр дундаа Хятад (2017 оныхоос 14.9%-аар өссөн) болон Япон (2017 оныхоос 27.6%-аар өссөн) улсууд эзэлж байна. Эдгээр хоёр улсын жуулчдын тоо БНСУ-д ирсэн олон улсын нийт иргэдийн 50.4%-ийг бүрдүүлсэн байна.

2018 онд БНСУ-ын нийт олон улсын жуулчдын зарлага 14.6%-аар нэмэгдэж, 16.7 их наяд вонд хүрсэн байна. Өдгөө БНСУ-ын эдийн засагт хамгийн их хувь нэмэр оруулж буй Хятадын жуулчдын зарлага 2018 онд 6.2 их наяд вон болжээ. Мөн түүнчлэн аялал жуулчлалын салбарт АНУ (1.9 их наяд вон) болон Япон (1.7 их наяд вон) улсууд өндөр байр суурь эзэлж байна.

Дотоодын аялал жуулчлал

БНСУ-ын дотоодын аялал нийт эдийн засагт 311.2 сая вон бүрдүүлж, 2017 оныхоос 9.2%-аар өссөн байна. Нэг өдрийн аялал 14.1%-аар буурч, 147.9 сая вон болсон бол шөнийн аялал 44.7%-аар өсч, 163.2 сая болсон байна.

Хүснэгт 1. БНСУ-ын аялал жуулчлалын салбарын статистик мэдээ 2017-2021 (Table: Total Market Size, US dollar)¹⁶¹

БНСУ	2017	2018	2019	2020	2021
Нийт гадагш чиглэсэн аялал (Total Outbound Travel)	26,496,447	28,695,983	28,714,247	4,276,006	1,222,541
АНУ руу явах аялал (Outbound Travel to the U.S)	2,334,839	2,210,597	2,298,279	439,286	202,711
Дотоодын аялал (Inbound Travel)	13,335,758	15,346,879	17,502,756	2,519,118	967,003

2018 онд БНСУ-д ирсэн гадаадын жуулчдын хамгийн их буюу 79% нь Сөүл хотод зочилсон гэж БНСУ-ын Аялал жуулчлалын байгууллагаас мэдээлсэн ба Сөүлийн дараа нь Кёнги муж, 14.9%, Пусан 14.7%, Канвон муж 9.7%, Чэжү арал 8.5% тус тус орсон байна.¹⁶²

2.2.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт

БНСУ-ын аялал жуулчлалын шинэчилсэн стратегийг үндэсний аялал жуулчлалын стратегийн гурав дахь уулзалтын үер буюу 2019 оны 4 дүгээр сард зарласан.

¹⁵⁹ OECD Tourism Trends and Policies 2020, <https://www.oecd-ilibrary.org/sites/6e8b663c-en/index.html?itemId=/content/component/6e8b663c-en>

¹⁶⁰ 2018 онд

¹⁶¹ Source: Korea Ministry of Culture, Sports and Tourism (MCST), Korea Tourism Organization (KTO), U.S. Department of Commerce National Travel & Tourism Office (USDOT, NTTO).

¹⁶² Current Tourism Trends in South Korea: A SWOT Analysis

Энэхүү аялал жуулчлалын стратеги нь аялал жуулчлалын салбарыг удирдан чиглүүлэх, аялал жуулчлалын эдийн засагт оруулах хувь нэмрийг өсгөхөд чиглэсэн. Уг стратегийг тогтвортой хэрэгжүүлэхэд дараах сорилтуудтай тулгарсан байна.

- БНСУ улс руу нэвтрэх визийг хөнгөвчлөх замаар жуулчдын тоог нэмэх, өндөр орлоготой жуулчдын баталгааг хангах;
- аялал жуулчлалын ирээдүйн чиг хандлагад нийцүүлэн аялал жуулчлалын ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх;
- аялал жуулчлал багатай бүс нутагт жуулчдын тоог нэмэх;
- аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх.

Аялал жуулчлал-2020 стратегийг (Tourism 2020 Strategy) хэрэгжүүлэхэд БНСУ дээрх сорилтыг шийдвэрлэхийн тулд олон төрлийн бодлогын хариу арга хэмжээ авсан байна.

- Нэгдүгээрт, Засгийн газар Хятад, Вьетнам, Филиппин, Индонез, Энэтхэгээс илүү олон жуулчдыг татахын тулд визний журмыг хөнгөвчилсөн;
- Хоёрдугаарт, орон нутгийн дөрвөн хотын захиргааг бүс нутгийн аялал жуулчлалын төв болгон хөгжүүлж, БНСУ-ын К-поп соёлыг дэлгэрүүлж гадаадын шүтэн бишрэгчдийг татахын тулд аялал жуулчлалын хөтөлбөрүүд нь К-поп зэрэг соёлын агуулгыг өөрөө багтаасан;
- Гуравдугаарт Засгийн газар аялал жуулчлалын татаасыг боловсруулж аж үйлдвэрт олгохтой адил хэмжээнд хүртэл нэмэгдүүлсэн. Энэ нь аялал жуулчлалын компаниудад 198 тэрбум вон хүртэлх санхүүжилт олгосон байна.

Гадаадын жуулчдыг БНСУ-ын олон газраар аялахыг дэмжихийн тулд Засгийн газар болон аялал жуулчлалын салбар хэд хэдэн арга хэмжээг боловсруулсан. Үүнд тус улсын эдийн засгийн хувьд илүү хөгжингүй хотуудад оршин суудаг Хятад иргэдэд олон удаагийн виз олгох явдал юм. Одоогоор БНСУ руу тодорхой хугацаанд хязгааргүй нэвтрэх, гарах визийг зөвхөн Бээжин, Шанхай, Гуанжоу, Шэньжэнь хотын оршин суугчид авах боломжтой байна.

Бусад санаачилга:


- Бүх төрлийн аялал жуулчлалын хөтөлбөрүүд нь насны хувьд хүүхдүүдээс эхлээд ахмад настан хүртэл бүх насны бүлэгт тохирсон байхаар төлөвлөсөн. Мөн зарим аялал жуулчлалын хөтөлбөрүүд орлого багатай бүлгүүдийг татах, дэмжихэд зориулагдсан байдаг.
- Аялал жуулчлалыг сурталчилсан сурталчилгаа, маркетингийн стратеги, агуулга нь дэлхийн томоохон зах зээлд зориулагдсан өндөр чанартай байхаар чиглэсэн байна.
- Цахим орчин дахь онлайн платформ, дижитал маркетингийн сайжруулсан стратеги нь бие даасан аялагчдад зориулсан туршлагыг сайжруулах, мэдээллийг илүү тодорхой хялбар олгоход чиглэсэн болно. Санал болгож буй аяллын маршрутын үйлчилгээ бүтээгдэхүүнийг интернэт ашиглан худалдан авах боломжтой болгосон.

2.2.2.БНСУ-ын аялал жуулчлалын засаглал ба санхүүжилт

БНСУ-д Ерөнхий сайдаар ахлуулсан аялал жуулчлалын үндэсний стратегийн уулзалтыг (National tourism strategy) 2017 оны 12 дугаар сард зохион байгуулсан бөгөөд тус уулзалтад аялал жуулчлалын сайд төдийгүй гадаад харилцаа, зам тээвэр, далай тэнгисийн салбарын сайд нар оролцсон байна. 2019 оны 04 дүгээр сард болсон гурав дахь удаагийн уулзалтаар бүс нутгийн эдийн засгийг идэвхжүүлэхийн тулд гадаадын жуулчдыг татах, дотоодын аялал жуулчлалыг нэмэгдүүлэх арга замыг хэлэлцсэн.

БНСУ-ын Соёл, спорт, аялал жуулчлалын яам нь (The Ministry of Culture, Sports and Tourism) БНСУ-ыг дотоод болон олон улсад сурталчлах, улсаас санхүүжүүлэх тал дээр БНСУ-ын аялал жуулчлалын байгууллагатай (Korea Tourism Organisation) нягт хамтран ажилладаг. Тус байгууллага Засгийн газрын аялал жуулчлалын бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй нягт уялдуулах замаар бүтцээ шинэчилсэн байна. Үүнд аялал жуулчлалын халамж, аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүдийн өсөлтийг дэмжих, аюулгүй байдлын менежмент, олон улсын хамтын ажиллагаа, аялал жуулчлалд Big data технологийг ашиглах зэрэг шинэ нэгжүүдийг багтаасан байна.

Зураг 3. БНСУ: Аялал жуулчлалын байгууллагуудын зохион байгуулалтын схем



Соёл, спорт, аялал жуулчлалын яамны 2-р дэд сайдын эрхлэх асуудлын хүрээнд аялал жуулчлалын салбар шинээр хоёр үндсэн газартай болсон.

- Аялал жуулчлалын бодлогын товчоо нь (Tourism Policy Bureau) бодлого, дотоод аялал жуулчлалыг дэмжих, олон улсын аялал жуулчлал, үйлчилгээг сайжруулах үндсэн чиг үүрэгтэй байна.
- Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн бодлогын товчоо нь (Tourism Industry Policy Bureau) аялал жуулчлалын салбарын бодлого, аялал жуулчлалын салбарыг нэгтгэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэгт чиглэсэн байна.

Аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх сан нь (The Tourism Promotion and Development Fund) Аялал жуулчлалын тухай хуулийн суурь хүрээнд аялал жуулчлалыг дэмжин ажилладаг. 2018 онд тус сангийн нийт зарлага ойролцоогоор 811 тэрбум вон байсан ба үүнээс аялал жуулчлалын салбарыг сурталчлах, аялал жуулчлалын дэд бүтэц болон гадаадын жуулчдыг татах бусад төслүүдэд нийт 97 тэрбум вон зарцуулсан байна.

2.2.3. Аялал жуулчлалын салбарын татварын хөнгөлөлт

БНСУ-ын Засгийн газраас аялал жуулчлалын салбарт олон улсын жуулчдыг татах зорилгоор зочид буудлын татварын 10%-ийг жуулчдад буцаан олгож байна.

БНСУ-ын аялал жуулчлалын байгууллагаас (Korea Tourism Organization) мэдээлснээр, бусад орны жуулчид зочид буудалд 2-оос дээш 30-аас доош хоног хоносон тохиолдолд татварын буцаан олголтыг авах боломжтой. Гэвч аялал жуулчлалын багцаар зочид буудал захиалж, төлбөр төлдөг аялагчид татварын буцаан олголт авах боломжгүй байна. Буцаан олголт нь өглөөний цай багтсан өрөөний үнийн татварыг оруулсан боловч зочид буудлын бусад төлбөрийн үйлчилгээний татварыг оруулаагүй. Жуулчид буцаан олголтыг авахын тулд зочид буудлаас эсвэл БНСУ дахь татваргүй бүсээс зочид буудлын татварын буцаан олголтын маягтыг бөглөснөөр авах боломжтой байна.

Мөн Аялал жуулчлалын дэмжих тухай тогтоолын 41 дүгээр зүйлд зааснаар Гадаадын жуулчдад ногдуулах Нэмэгдсэн өртгийн албан татвар, хувь хүний хэрэглээний албан татварын онцгой тохиолдлын тухай журмын 4 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу гадаадын жуулчдаас зарим эрх бүхий татвараас чөлөөлөгдсөн дэлгүүрүүд НӨАТ авдаггүй байна.

2.2.4. Жуулчдын аюулгүй байдлыг хангах

Аялал жуулчлалын салбарт жуулчдыг ая тухтай аялах аюулгүй байдлыг хангах нь хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Иймээс аялал жуулчлалын салбарт, аюулгүй байдлыг хангах стандартыг хэрэгжүүлдэг байна. Уг салбарт тохиолддог хамгийн түгээмэл 5 эрсдэл байдаг байна.¹⁶³ Үүнд:

- гэмт хэрэг;
- хүнсний аюулгүй байдал;
- терроризм;
- эрүүл мэндийн асуудал;
- гамшигт үзэгдлүүд багтдаг байна.

Судалгаанаас үзэхэд хүчирхийллийн гэмт хэргийн гаралтын түвшин 2020 онд БНСУ-д 100,000 хүнд 0.60 хэрэг гарсан байна. Энэ нь дэлхийн дундаж үзүүлэлт болох 100,000 хүнд 7 гэмт хэрэг тохиолддог тоо хэмжээнээс бага байгаа нь БНСУ гэмт хэрэг гаралт бага, аюулгүй улс болохыг харуулж байна.

БНСУ-ын Жэжү арал нь аялал жуулчлалын салбарын үндсэн гол төлөөлөгч бөгөөд БНСУ-ын цорын ганц өөрөө удирдах ёсны муж юм. Тус арал нь нийт 660,000 гаруй хүн амтай бөгөөд 2018 оны байдлаар жилд 15,000,000 гаруй жуулчин хүлээн авдаг. Жэжү арал дээр далайн усанд жуулчид эндэгдэх эрсдэл байдаг бөгөөд урьдчилан сэргийлэх бодлогын хувьд дагаж мөрдөх дүрмийг баримтлан хэрэгжүүлдэг байна. Үүнд урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хурдан хариу арга хэмжээ авах үүднээс хоёр цаг тутамд хуваарийн дагуу эргүүл хийдэг байна.

2.3. ТАЙЛАНД УЛС

Тайланд Улс нь Энэтхэг-Хятадын хойгт оршдог ба Мьянмар, Лаос, Камбож, Малайз гэсэн дөрвөн улстай 4863 км урт зурвасаар хиллэдэг, далайд гарцтай 514 мянган км² газар нутагтай, 66.09 сая (2022 он) хүн амтай.¹⁶⁴

Аялал жуулчлал нь Тайланд Улсын эдийн засгийн 6%-ийг бүрдүүлж байна. Шууд бус нөлөөг нь тооцвол улсын эдийн засгийн 20%-д нөлөөлдөг байна. Ихэвчлэн Азийн жуулчид ирдэг бөгөөд Тайландын түүхт газар, байгалийн үзэсгэлэн, соёлын өв зэргийг сонирхдог. Өмнөд нутгийн далайн эргийн амралтын газрууд нь дэлхийн өнцөг булан бүрээс жуулчдыг татдаг. Умард нутагт экстрим, шугуйт уулын аялал хөгжсөн байна.

¹⁶³ Understanding the perception of safety and security of tourists at Jeju Island, South Korea

¹⁶⁴ Тайланд Улс Үндсэн өрөгдөл <https://www.mofa.go.jp/mofaj/area/thailand/data.html>

Мөн тус улс нь эмнэлгийн аялал жуулчлалыг хөгжүүлсэн бөгөөд жилд 2.5 сая жуулчин хүлээн авдаг. Үүнд хүйс шилжүүлэн суулгах, гоо сайхны хагалгаа зэрэг орно. Өмнөд эргийн хотуудаар секс жуулчлал хөгжсөн.

Хууль эрх зүйн орчин

Тайланд Улс нь 1979 онд батлагдсан **Тайландын аялал жуулчлалын тухай хууль**¹⁶⁵ (Thai Tourism Law)-тай бөгөөд хуулийн гол агуулга нь Тайланд Улсын аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан байна. Хууль нь 4 бүлэг 44 зүйлээс бүрддэг.

- I бүлэг Зорилго, зорилт, хөрөнгө орлого
- II бүлэг Хяналт, удирдлага
- III бүлэг Ажилтан, албан тушаалтны халамж, тэтгэлэг
- IV бүлэг Санхүү, нягтлан бодох бүртгэл, аудит гэсэн бүлгүүдтэй.

Тус хуулийн хэрэгжилтийг Ерөнхий сайд хариуцаж, хяналт тавих бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах тухай журам гаргах бүрэн эрхтэй. Хуульд дараах байгууллагын зорилго, чиг үүргийг нарийн тусгаж өгсөн.

Тайланд Улсын аялал жуулчлалын газар¹⁶⁶ (Tourism Authority of Thailand-TAT):

- Тайланд Улсыг байгалийн үзэсгэлэнт газар, эртний дурсгалт газрууд, эртний эдлэл, түүх, урлаг, соёл, спорт, технологийн хөгжил болон аялал жуулчлалыг дэмжих зорилгоор бусад үйл ажиллагаагаар таниулах;
- Жуулчдад зориулсан байгууламж, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах;
- Аялал жуулчлалын замаар ард түмэн, үндэстнүүдийн хоорондын холбоо, найрамдлыг дэмжих;
- Жуулчдад зориулсан аялал жуулчлал, дэд бүтэц, бусад байгууламжийг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлэх.

Тайландын аялал жуулчлалын үйл ажиллагаа ба хөтөчийн тухай хууль¹⁶⁷ (Tourism Business and Guide Act). Тус хуульд жуулчны хөтөчтэй холбоотой үйлчилгээ үзүүлэхэд тусгай зөвшөөрөл авах шаардлагын талаар заасан байна. Тусгай зөвшөөрөл нь дараах дөрвөн төрөлтэй:

1. Аялал жуулчлалын иж бүрэн зөвшөөрөл;
2. Гадаад аялал жуулчлалын зөвшөөрөл (гадаадын жуулчдад зориулсан);
3. Дотоод аялал жуулчлалын зөвшөөрөл (Тайландын жуулчдад зориулсан);
4. Тодорхой бүсийн нутгийн аялал жуулчлалын зөвшөөрөл байна.

Түүнчлэн тус хуулиар жуулчны хөтөчийн үнэмлэхийг төрөлжүүлэн заасан. Ерөнхий хөтөч болон тодорхой муж, дүүргээр хязгаарлагдах хөтчийн зөвшөөрлийг Аялал жуулчлалын газарт (TAT) хандан гаргах шаардлагатай.

2.3.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт

Тайланд Улс нь удаан хугацаагаар аялж, амьдрах гадаадын иргэдэд Тайланд Улсад арав хүртэлх жил оршин суух урт хугацааны Long-Term Residents¹⁶⁸ (LTR) визний шинэ ангиллыг нэвтрүүлжээ. (2022 оны 01 дүгээр сард Дотоод хэргийн сайд Засгийн газрын зөвшөөрлөөр 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын мэдээллийн

¹⁶⁵ Тайландын аялал жуулчлалын тухай хууль <https://thailawyers.com/thai-laws/thai-tourism-law/>

¹⁶⁶ Тайландын аялал жуулчлалын газар <https://www.tourismthailand.org/home>


¹⁶⁷ Тайландын аялал жуулчлалын лицензийн ба жуулчны хөтөчийн тухай хууль, <https://www.samuiforsale.com/company-law/thailand-tat-tourism-license-tourism-business-and-guide-act.html>

¹⁶⁸ Long-Term Residents visa <https://www.w-lawthai.com/en/type-of-visa-2023/>

эмхэтгэлд нийтлэгдсэн.)¹⁶⁹ LTR виз нь Инээмсэглэлийн орон - Тайланд Улсад гадаадын иргэдийг найрсаг угтан авах түлхүүр юм. Тус визийг Тайланд Улсад 1 сая ам.доллараас доошгүй хөрөнгө оруулалттай хувь хүн, 50 ба түүнээс дээш насны жилд 80,000 ам.доллараас доошгүй хувийн орлоготой тэтгэвэр авагчид, гадаадын нэр хүндтэй компанийн өндөр ур чадвартай ажилчид хүсэх боломжтой.

Тайланд Улсын Засгийн газрын алсын хараа 4.0 бодлогын нэг хэсэг болох Био-Тойрог-Ногоон¹⁷⁰ (Bio-Circular-Green (BCG)) эдийн засгийн загвар нь байгалийн нөөц, экосистемийг хамгаалах НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцдэг. Тус загварын нэг салбар нь Аялал жуулчлал, бүтээлч эдийн засаг байдаг бөгөөд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, эрүүл мэнд, эко аялал жуулчлал зэрэг өндөр чанартай аялал жуулчлалыг бий болгох зорилготой байна.

Зураг 4. Био-Тойрог-Ногоон (Bio-Circular-Green (BCG)) эдийн засгийн загвар¹⁷¹



2.3.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг, түүний үр дүн

“Жуулчдын НӨАТ-ын буцаан олгох” тэмдэглэгээтэй дэлгүүрүүд жуулчдад НӨАТ-ын буцаан олголт олгодог. Барааг худалдан авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор Тайланд Улсаас гаргах, нэг дэлгүүрт хамгийн багадаа 2000 батын бараа худалдаж авах, худалдан авах үедээ жуулчид паспортоо үзүүлж Жуулчдад зориулсан НӨАТ-ын буцаан олголтын мэдүүлгийн маягт (PP10) татварын нэхэмжлэхийн эх хувьтай хамт гаалийн байцаагчид шалгуулах ёстой.

Шалган нэвтрүүлэх цэгийг өнгөрсний дараа жуулчид НӨАТ-ын буцаан олголтыг нисэх онгоцны буудлын Жуулчны НӨАТ-ын буцаан олголтыг олгох цэгээс, эсхүл хотын төвд боломжит борлуулагчдаас авна.

Тансаг зэрэглэлийн бараа болон 10000 батаас дээш үнэтэй барааны буцаан олголтыг бараагаа гартаа авч яван, дахин шалгуулсны дараа олгодог байна.

Тайланд Улсын Засгийн газар 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Тайланд Улсад зорчих гадаадын жуулчдаас 150-300 хүртэлх батын (4-9 ам.доллар) хураамж авах шийдвэр гаргасан байна. Хуурай газар болон далайн тээврээр хүрэлцэн ирж буй жуулчдаас 150 бат, нисэх онгоцоор зорчин ирэгсдээс 300 батын хураамж авна. Энэхүү

¹⁶⁹ LTR виз <https://kpmg.com/th/en/home/insights/2022/11/legal-news-flash-issue-19.html>

¹⁷⁰ Био-Тойрог-Ногоон эдийн засгийн загвар <https://mahanakornpartners.com/the-bio-circular-green-economic-model/>

¹⁷¹ Мөн тэнд.

хураамжаас цугласан хөрөнгийг гэнэтийн осолд орсон жуулчдад туслах, жуулчдын аяллын шинэ чиглэлийг хөгжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дээрх зохицуулалт нь дипломат паспорт, Хөдөлмөрийн яамнаас тогтоосон тодорхой мэргэжлээр ажиллах зөвшөөрөл авсан иргэд, тусгай зөвшөөрөлтэй хүмүүс, хоёр хүртэлх насны хүүхэд, дамжин өнгөрөх зорчигчдод хамаарахгүй.

2.3.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа бодлого, зохицуулалт;

Аялал жуулчлал, спортын яам¹⁷² нь аялал жуулчлал, амралт зугаалгыг дэмжих, хөгжүүлэх болон хуульд заасан төрийн бусад үйлчилгээг дараах байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.

- Аялал жуулчлалын газар¹⁷³ ((ТАТ) Tourism Authority of Thailand) Тайланд Улсын төрийн алба, институци, хуулийн этгээд, хувийн хэвшилд зөвлөгөө, зөвлөмж өгөх, хамтран ажиллах, зохицуулах, аялал жуулчлалын салбартай холбоотой статистик мэдээ гаргах, аялал жуулчлалын газруудыг барих, сурталчлах, хамгаалах, нөхөн сэргээх, сэргээн босгох, хөгжүүлэх, түүнчлэн аялал жуулчлалын нөөц, байгаль орчны чанарт холбогдох хууль тогтоомжийн дагуу судалгаа хийх, төлөвлөх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон бусад аливаа үйл ажиллагаа явуулна.
- Тайландын аялал жуулчлалын зөвлөл¹⁷⁴ (Tourism Council of Thailand) аялал жуулчлалын салбарын бүх операторуудын төлөөллийг багтаасан бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг хангах, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа эрхлэгчдийн төлөөлөгчөөр ажиллана. Тус зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл нь жуулчдад зориулсан үйлчилгээтэй холбоотой аж ахуйн нэгжүүдийн чанарын баталгаажуулалт, стандартын тогтолцоог сурталчлах, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг чанар, ёс суртахуун, ёс зүйтэй явуулахад нь дэмжлэг үзүүлдэг. Түүнчлэн үйл ажиллагааны гол зорилго нь аялал жуулчлалын салбарын төлөөлөгчид Засгийн газар, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны уялдаа холбоотойгоор нийгмийн салбар, олон улсын байгууллагуудтай холбох, хууль тогтоомжийн шинэчлэлд бодитой оролцон хуулийг хэрэгжүүлэхэд оршдог байна.

2.3.4.Жуулчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого /холбогдох даатгалын талаарх зохицуулалт/

Тайланд Улсын Хааны цагдаагийн албанаас 2017 онд Жуулчны цагдаагийн алба¹⁷⁵ (Tourist Police Bureau of Tailand) байгуулсан нь аялал жуулчлал, зугаа цэнгэлийн салбар хөгжин, жуулчдын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор жуулчдын аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн. Тус албаны ажилтнууд гартаа ялгах тэмдэг зүүж, англи хэл болон Европын бусад улсын хэлээр ярьдаг. Зам тээврийн осол, хулгай дээрэм, гадаадын жуулчин оролцсон зочид буудал, дэлгүүрийн эзэнтэй маргаан гарах зэрэг бүх төрлийн нөхцөл байдалд тэднийг дуудаж болно.

Аялал жуулчлалын цагдаагийн газар нь дараах үндсэн бүрэн эрх, үүрэгтэй:

- Аялал жуулчлалын хөгжлийн стратегийг төлөвлөх, хяналт тавих, цагдаагийн бусад хэлтэс газруудтай хамтран ажиллах;
- Жуулчдын аюулгүй байдлыг ханган, эрх ашгийг хамгаалах.

¹⁷² Аялал жуулчлал, спортын яам https://www.mots.go.th/mots_en/news/3151

¹⁷³ Аялал жуулчлалын газар <https://www.tourismthailand.org/home>

¹⁷⁴ Тайландын аялал жуулчлалын зөвлөл <https://www.thailandtourismcouncil.org/about-us/>

¹⁷⁵ Жуулчны цагдаагийн алба <https://www.amazing-thailand.com/thai-tourist-police.html>

2.4. БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС

Бүгд Найрамдах Чех Улс (БНЧУ) нь Төв Европ дахь далайд гарцгүй улс юм. Өмнөд талаараа Австри, баруун талаараа Герман, зүүн хойд талаараа Польш, зүүн өмнөд талаараа Словак Улстай тус тус хиллэдэг байна. Нийслэл нь Прага хот. Зүүн Европын пост-коммунист орнуудын дунд хамгийн өндөр хөгжилтэй, эдийн засгийн хөгжил сайтай орон юм.

БНЧУ-ын нутаг дэвсгэр 78,871 км² газар талбайтай, 2022 оны байдлаар 10.6 сая хүн амтай, 2023 онд ДНБ-д ногдох зардал: 541,058 тэрбум ам.доллар, нэг хүнд ногдох зардал 51,329 ам доллартай тэнцүү байна.

Аялал жуулчлалын салбарын онцлог: БНЧУ нь 2004 оноос Европын Холбоо болон Шенгений бүсийн гишүүнээр элссэн, ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн 16 газартай байна.¹⁷⁶

Жуулчдын сонирхлыг татдаг хэсэг нь архитектурын өв болох Карлштейн цайз, Чески Крумлов, Ледниц-Вальтице соёлын ландшафт гэх мэт эртний үеийн түүхэн цайзууд, Пап ламын сүм хийд, далайн эргийн амралтын үзэсгэлэнт газруудыг хамруулдаг байна. Хотуудаас гадна байрлах Богемийн цэцэрлэгт хүрээлэн, ойн төгөл, аварга том уулууд, Чарльз гүүр, Үндэсний галерей болон театр, зоо парк зэрэг нь жуулчдын сонирхлыг ихэд татдаг байна. Тус улс нь Үндэсний музей болон олон төрлийн үзмэрээр алдартай байна.

Мөн олон амьтны хүрээлэн, усан парк төвүүд, амралт, зугаа цэнгэлийн газрууд бөгөөд хамгийн алдартай нь Динопарк гэж нэрлэдэг. БНЧУ-ын байгалийн үзэсгэлэнт газруудыг жуулчид болон дугуйчид, мөн явган зорчигчид байгалийн цэцэрлэгт хүрээлэн, тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг нь жуулчдын сонирхлыг ихээр татдаг байна.

Аялал жуулчлалын салбарт ДНБ-ийн эзлэх хувь: БНЧУ-ын аялал жуулчлалын салбар нь 2019 оны байдлаар ДНБ-ийн 2.9%-ийг эзэлж, нийт ажил эрхлэлтийн 4.4% хувь буюу 239,506 ажилтан ажлын байраар хангагдсан байна.¹⁷⁷

Олон улсын жуулчдын эх үүсвэр нь Герман, Орос, Итали, АНУ, Их Британи, Словак Улсын жуулчид зочилж, нийт 52%-ийг эзэлдэг байна.

БНЧУ-ын нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий аялал жуулчлал нь сүүлийн 20 жилийн хугацаанд хурдацтай өссөөр ирсэн ч 2020 онд “Ковид-19” цар тахлын нөлөөллөөр аялал жуулчлалын салбарт ДНБ-ий эзлэх хувь хоёр дахин их буюу 82 тэрбум кроноор буурсан үзүүлэлтэй байна. Аялал жуулчлалын салбарт ажил эрхлэлтийн байдал ихээхэн нөлөөлж, 17,494 ажилтан буюу 7.3%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Харин 2022 онд БНЧУ-ын ДНБ-ийн эзлэх хувь 2.4% байсан бол 2023 онд -0.1% хүртэл удааширсан бөгөөд 2024 онд ДНБ-ийн эзлэх хувь 2.4% хүртэл өснө гэж таамагласныг ЭЗХАХБ (OECD)-ын 2022 оны тайланд¹⁷⁸ дурдсан байна. Дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. ДНБ-ийн эзлэх хувийг 2020-2024 оны байдлаар харьцуулсан үзүүлэлт

ДНБ	2019	2020	2021	2022	2023	2024
	(тэрбум кроноор)	(өөрчлөлт 2015 оны үнээр) %-аар				
ДНБ зах зээлийн үнээр	5,793.9	-5.5	3.5	2.4	-0.1	4.2
Хувийн хэрэглээ	2,712.0	-7.2	4.0	0.5	-0.5	2.4

¹⁷⁶ Visit Czechia <https://www.visitczechrepublic.com/en-US/Destinations>

¹⁷⁷ OECD Tourism Trends and Policies 2022, page -146 <https://www.mlit.go.jp/kankocho/content/001577527.pdf>

¹⁷⁸ <https://issuu.com/oecd.publishing/docs/czech-republic-oecd-economic-outlook-projection-no>

ЗГ-ын хэрэглээ	1,134.5	4.2	1.5	0.2	1.0	1.4
ДНБ-ийн дефлятор ¹⁷⁹	-	4.3	3.3	8.7	8.8	4.1
Хэрэглээний үнийн индекс	-	3.2	3.8	15.2	9.9	4.1
Суурь инфляцийн индекс ¹⁸⁰	-	3.6	5.0	12.4	10.0	4.1
Ажилгүйдлийн түвшин (ажиллах хүчний %-аар)	-	2.5	2.8	2.3	2.6	2.8
ЗГ -ын тэнцэл (ДНБ эзлэх хувь)	-	-5.8	-5.1	-4.5	-4.1	-2.4
ЗГ-ын нийт өр (ДНБ эзлэх хувь)	-	47.0	48.5	51.7	54.5	55.7
Нийт ЗГ-ын өр	-	37.6	42.0	45.2	48.0	49.3
Урсгал зардал (ДНБ-д эзлэх хувь)	-	2.0	-0.8	-4.0	-2.9	-3.1

OECD Economic Outlook 112 мэдээллийн сан. StatLink 2 <https://stat.link/9wrfqg>

Зорчигчдын тоо: 2020 онд БНЧУ нь 3.9 сая олон улсын жуулчид хүлээн авсан нь өмнөх оныхоос 73.2%-аар буурсан бөгөөд 2021 онд олон улсын жуулчдын тоо 6.5 сая хүртэл буурсан үзүүлэлтэй байна.

Олон улсын гадаад аялал жуулчлалыг 2024-2025 онд өмнөх 2019 оны түвшинд ирэх байх гэж тооцоолж байна.

Дотоодын аялал жуулчлалын салбарт 2021 онд 8.8 сая жуулчин зорчиж, 2019 оны түвшнээс 20.7%-аар доогуур жуулчин хүлээн авсан нь цар тахал нөлөөсөн гэж үзжээ. Дотоодын аялал жуулчлалыг 2020 оны байдлаар авч үзвэл, дотоодод эзлэх хувь 36.1% буюу 79.1 тэрбум кроноор буурсан үзүүлэлттэй байна.

Харин БНЧУ-аас гадаад орон руу зорчсон жуулчдын тоог АНУ-ын жишиг үзүүлэлтийг авч харуулав. Үүнд: АНУ-ын Худалдааны яам, (United States Department of Commerce), Олон Улсын Худалдааны Байгууллага (International Trade Administration), Үндэсний аялал жуулчлалын байгууллага (National Travel and Tourism Office)-ын хамтарсан тайланд¹⁸¹ 2019-2022 онуудад БНЧУ-аас АНУ руу зорчсон жуулчдын тоог тайлагнажээ. Үүнд:

Хүснэгт 3. БНЧУ-аас АНУ руу зорчсон жуулчдын тоо

Онууд	БНЧУ-ын жуулчдын тоо	Өөрчлөлт (%-аар)
2019	127,022	6.4%
2020	19,960	-84.3%
2021	15,087	-24.4%
2022	80,000	530%

Эх сурвалж: Олон Улсын Худалдааны байгууллагын хураангуй тайлангаас, 2023 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн байдлаар <https://www.trade.gov/country-commercial-guides/czech-republic-travel-and-tourism>

Хууль, эрх зүйн орчин

1999 онд батлагдсан “Аялал жуулчлалын чиглэлээр бизнес эрхлэх, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлийн тухай”¹⁸² (Act No. 159/1999 Coll. Act on certain

¹⁷⁹ ДНБ-ийн дефлятор буюу далд үнийн дефлятор нь инфляцийн хэмжүүр. Энэ нь тухайн эдийн засгийн жилд үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний үнийг бодит үнэтэй харьцуулсан харьцаа юм.

¹⁸⁰ Хүнс, эрчим хүчийг оруулаагүй хэрэглээний үнийн индекс

¹⁸¹ <https://www.trade.gov/country-commercial-guides/czech-republic-travel-and-tourism>

¹⁸² <https://www.podnikatel.cz/zakony/zakon-c-159-1999-sb-o-nekteryach-podminkach-podnikani-v-oblasti-cestovniho-ruchu>

conditions of business in the field of travel) хуулиар аялал жуулчлалын бизнес эрхлэх үйл ажиллагааг зохицуулдаг байна.

Бусад тодорхой салбарын хуулиудаар, тухайлбал, “Иргэний хууль”¹⁸³ (*The Civil Code*), “Зам тээврийн тухай”¹⁸⁴ (*About transport*), “Бизнесийн корпорацын тухай”¹⁸⁵ (*Business Corporations Act*), “Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай”¹⁸⁶ (*About consumer protection*), Тусгай зөвшөөрөлтэй худалдааны тухай хууль¹⁸⁷ (*Trade licensing Act*) зэрэг аялал жуулчлалын салбарын эдгээр хуулиудаар тус тус зохицуулдаг байна.

БНЧУ нь Европын Холбооны гишүүн орны хувьд тус Холбооны аялал жуулчлалын салбарын хөгжлийн талаар баримтлах бодлого, зарчмыг тодорхойлсон Европын Парламент болон Зөвлөлийн Удирдамж гэсэн эрх зүйн баримт бичгүүдийг баримталдаг байна. Тухайлбал,

- “Багц аялал жуулчлал, багц амралт, цогцолбор аяллын тухай”¹⁸⁸ ЕХ-ны Зөвлөлийн Удирдамж 90/314/ (*Council Directive 90/314/EEC of 13 June 1990 on package travel, package holidays and package tours*),
- “Иргэдийн багц аяллын тухай 2015/2302 дугаар Удирдамж”¹⁸⁹ (*Directive (EU) 2015/2302 of the European Parliament and of the Council of 25 November 2015 on package travel and linked travel arrangements*),
- Европын Парламент болон Зөвлөлийн 261/2004 дугаартай дүрэм¹⁹⁰ (*Regulation (EC) No 261/2004 of the European Parliament and of the Council of 11 February 2004*),
- Европын Холбооны Парламент ба Зөвлөлийн 2011.02.16-ны өдрийн 181/2011 тоот “Автобус болон тээврийн хэрэгслээр зорчигчдын эрхийн тухай журам 181/2011 дугаар”¹⁹¹ (*Regulation (EU) No 181/2011 of the European Parliament and of the Council of 16 February 2011 concerning the rights of passengers in bus and coach transport*);
- Европын Парламент ба Зөвлөлийн 2007.10.23-ны өдрийн Төмөр замын зорчигчдын эрх, үүргийн тухай журам (EC) No 1371/2007) 1371/2007 дугаар¹⁹² (*Regulation (EC) No 1371/2007 of the European Parliament and of the Council of 23 October 2007 on rail passengers’ rights and obligations*) -ууд тус тус болно.

Дээр дурдагдсан “Аялал жуулчлалын чиглэлээр бизнес эрхлэх, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлийн тухай” (*Act No. 159/1999 Coll. Act on certain conditions of business in the field of travel*) хуулиар аялал жуулчлалын агентлаг, тур операторын хүлээх үүрэг, аялал жуулчлалын гэрээнд тавигдах шаардлага, аялал жуулчлалын тухай ойлголт, түүнчлэн аялал жуулчлалын агентлагуудын дампуурлын эсрэг хууль ёсны даатгалыг тодорхойлсон байна. Энэ хууль нь дараах 5 хэсэгтэй. Үүнд:

- **Нэгдүгээр хэсэг:** Аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэх тодорхой нөхцөлийн зохицуулалт;
- **Хоёрдугаар хэсэг:** Ууланд аялагчдыг аврах албаны үндсэн үйл ажиллагаа, хэрэгжилт;

¹⁸³ <https://www.podnikatel.cz/zakony/novy-obcansky-zakonik>

¹⁸⁴ <https://www.podnikatel.cz/zakony/zakon-o-silnicni-doprave/uplne/>

¹⁸⁵ <http://zakony.centrum.cz/zakon-o-obchodnich-korporacich/>

¹⁸⁶ <http://zakony.centrum.cz/zakon-o-ochrane-spotrebitele>

¹⁸⁷ https://www.mpo.cz/assets/en/business/licensed-trades/legislation/2023/1/ZZ_UPLNE_ZNENI_k_15_1_2023_WEB_EN-amendment-.pdf

¹⁸⁸ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:31990L0314>

¹⁸⁹ <https://eur-lex.europa.eu/eli/dir/2015/2302/oj>

¹⁹⁰ <https://eur-lex.europa.eu/eli/reg/2004/261/oj>

¹⁹¹ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A32011R0181>

¹⁹² <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A32007R1371>

- **Гуравдугаар хэсэг:** Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа, түүний хэрэгжилт;
- **Дөрөвдүгээр хэсэг:** 1991 оны 455 дугаар Худалдааны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- **Тавдугаар хэсэг:** Шилжилтийн болон эцсийн заалтууд зэргийг тусгасан болно.

Хуулийн гол нэр томъёоны тодорхойлолтууд:

Тур буюу аялал гэдэг нь¹⁹³ доод тал нь хоёр үйлчилгээг урьдчилан тохиролцож, нийлмэл үнээр худалдан, борлуулахаар санал болгосон эсхүл 24 цагаас илүү буюу хонох байрыг багтаасан иж бүрэн үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.

Аялал жуулчлалын агент нь¹⁹⁴ концессын үндсэн дээр аялал зохион байгуулах, санал болгох, борлуулах эрх бүхий бизнес эрхлэгч юм. Аялал жуулчлалын агентлаг гэж аяллын гэрээ байгуулах үед Европын Холбооны өөр гишүүн улс, эсвэл Чех Улсаас бусад Европын эдийн засгийн бүсийг бүрдүүлэгч өөр улсад оршин суугч хүнийг **аялал жуулчлалын агент** гэнэ.

Захиалагч гэдэг нь¹⁹⁵ аялал жуулчлалын агентлагтай аялал жуулчлалын гэрээ байгуулсан хүн, эсхүл энэ гэрээг өөрийн талд байгуулсан этгээд юм. Тусгай эрх зүйн зохицуулалтаар тогтоосон нөхцөлөөр аяллыг шилжүүлсэн этгээдийг мөн захиалагч гэнэ.

Хөтөч гэдэг нь тухайн орны соёл, түүх, байгалийн өв, өнөөгийн амьдралын талаар хэсэг бүлэг хүмүүст тайлбар өгдөг хувь хүнийг хэлнэ.

2.4.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт

Аялал жуулчлалын салбарт төрөөс баримтлах бодлогыг Засгийн газрын хөтөлбөрт тодорхойлсноор Бүс нутгийн хөгжлийн яам (*Ministry of Regional Development*) хэрэгжүүлдэг байна.

Тус яам нь стратегийн баримт бичгүүдийг боловсруулж, нийтийн аялал жуулчлалын дэд бүтцэд санхүүжилт олгох, маркетингийн үйл ажиллагаа явуулах, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх замаар аялал жуулчлалыг дэмждэг байна.

БНЧУ-д 2019 онд батлагдан хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын төрийн бодлогын үзэл баримтлал 2021-2030”¹⁹⁶ (*Concept of State Tourism Policy*) гэсэн стратегийн баримт бичгийг Чехийн аялал жуулчлалын бодлогын үндэс суурь гэж үздэг байна.

Уг бодлогын баримт бичигт аялал жуулчлалын бизнесийн орчин, үйлчилгээний чанарыг сайжруулах, аялал жуулчлалын үндсэн болон туслах дэд бүтцийг бий болгох, шинэчлэх, шинэлэг санаа, туршлагыг хөгжүүлэх, аялал жуулчлалын менежмент, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний болон бүс нутгийн аялал жуулчлалын чиглэлүүд, түүний үндсэн төрлүүдийн талаар тодорхойлж, тус улсад аялал жуулчлалыг цаашид хөгжүүлэх асуудал, түүнийг шийдвэрлэх арга хэмжээний талаар тусгажээ.

Дээрх стратегийн баримт бичигт Дэлхийн эдийн засгийн форум (*World Economic Forum*)-ын Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексээр БНЧУ-ыг 2029 он гэхэд 30 дугаар байр эзлэхэд дараах тэргүүлэх зорилтуудыг тавьжээ. Үүнд:

- аюулгүй, тогтвортой аялал жуулчлалаар хангах;

¹⁹³ <https://www.podnikatel.cz/zakony/zakon-c-159-1999-sb-o-nekterych-podminkach-podnikani-v-oblasti-cestovniho-ruchu>

¹⁹⁴ Мөн тэнд.

¹⁹⁵ Мөн тэнд.

¹⁹⁶ <https://www.cestovni-ruch.cz/zdroje/docs/koncepcie.htm>

- бүс нутгийн хөгжил, бүтээн байгуулалтыг дэмжих, төрийн болон бизнесийн аялал жуулчлалын дэд бүтцийг шинэчлэх;
- жуулчдын очих дуртай газруудыг танилцуулж, мэдээлэх;
- маркетингийн харилцаа, уялдаа холбоог хөгжүүлэх;
- аялал жуулчлалын мэдээллийн хүртээмж, харилцан үйлчлэлийг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих;
- аялал жуулчлалын салбарт ажиллагсдын хүртээмжийг сайжруулах;
- аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Бүс нутгийн хөгжлийн яам¹⁹⁷ (*Ministry of Regional Development*) нь аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх операторуудыг арга зүйгээр хангах бөгөөд аялал жуулчлалыг 2021-2030 онд хөгжүүлэх стратегийн баримт бичгийн төлөвлөгөөнд тусгаж, хуваарь, хэрэгжүүлэх гарц шийдэл, үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгажээ.

БНЧУ-ын Засгийн газрын 2021 оны 641 дүгээр тогтоолоор одоогийн мөрийн хөтөлбөрийн хүрээнд 2022-2023 онуудын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулан батлуулсан байна.¹⁹⁸ Уг арга хэмжээний зорилго нь цар тахлын хямралыг бууруулж, өмнөх нөхцөлийг аажмаар сэргээн бүрдүүлэх, тогтвортой, үр ашигтай байдлаар сөрөг нөлөөллийг багасгах явдал юм. Уг стратегийн баримт бичиг урт хугацаанд тусгагдсан бөгөөд 6 хэсгийн 13 арга хэмжээ, 33 дэд арга хэмжээнүүдийг¹⁹⁹ тусгасан байна.

БНЧУ-д аялал жуулчлалыг хөгжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хууль тогтоомжийн орчин сайжруулах, нэмэлт, өөрчлөлтийг тусгах, тур оператор болон аялал жуулчлалын агентлагийн үйл ажиллагааны журмыг нэн түрүүнд бий болгох нь Бүс нутгийн хөгжлийн яамны зорилго болоод байна.

Тус яам нь Чехийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хэд хэдэн төслийг Европын Холбооны сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж эхлээд байна. Энэ Европын Холбооны сан нь 2021-2027 онуудад аялал жуулчлалыг дэмжих, аялал жуулчлалын дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих асуудал чухал хэвээр байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх энэхүү төсөлд:

- Зочид буудлын ангилал, үйлчилгээ ЕХ-ны жишгээр (*Hotel Stars.EU*);
- Бүс нутгийн мэдээллийн үйлчилгээ (*Regional Information service*);
- Чехийн аялал жуулчлалын чанарын үйлчилгээ (*Czech service quality system*) багтаасан болно.

2.4.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, түүний үр дүн

Нэмэгдсэн өртгийн албан татварын нийтлэг тогтолцооны тухай Европын Холбооны Зөвлөлийн 2006 оны 112 дугаар удирдамж (*Council Directive 2006/112/EC on the Common System of Value Added Tax*)²⁰⁰-ийг үндэслэн БНЧУ-ын Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын тухай 2004 оны 235 дугаар хууль (*Act No. 235/2004 Coll. The Law on Value Added Tax*)²⁰¹-ийг хэрэгжүүлдэг байна.

¹⁹⁷ <https://www.mmr.cz/en/ministerstvo/cestovni-ruch>

¹⁹⁸ <https://www.mmr.cz/cs/ministerstvo/cestovni-ruch/pro-profesionaly/koncepcie-strategie/akcni-plan-2022-2023?feed=AllPageFefed>

¹⁹⁹ <https://www.mmr.cz/getmedia/3c162618-90cf-4fad-9100-5e4edc8bdfab/Shmuti-AP-2022-2023.pdf.aspx?ext=.pdf>

²⁰⁰ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:32006L0112>

²⁰¹ <https://www.zakonyprolidi.cz/cs/2004-235#2551634>

Энэхүү НӨАТ-ын тухай хууль²⁰² нь 113 зүйлтэй бөгөөд Европын Холбооны нэмэгдсэн өртгийн албан татвар болон холбогдох БНЧУ-ын НӨАТ-ын зохицуулалтуудыг тусгажээ.

Уг хуульд Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг энэхүү НӨАТ-ын тухай хууль (*Act No. 235/2004 Coll. The Law on Value Added Tax*)-ийн 63 дугаар зүйл (*НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт*), 89 дүгээр зүйл (*Аялал жуулчлалын тусгай горим*) -д тодорхой тусгасан байна.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй түр оператор, жуулчны салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, түүний үр дүн

Тус улсын НӨАТ-ын тухай хуулийн 2 а дэд хэсэгт заасны дагуу “Өөр гишүүн улсаас бараа худалдаж авсан тохиолдолд татвар ногдуулахгүй, тухайн жилд татваргүй бараа худалдан авсан үнэ 326,000 кронаос хэтрээгүй бол татвараас чөлөөлнө” гэж тусгажээ.

Уг хуулийн 63 дугаар зүйлд заасан НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх асуудлыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- барааг өөр гишүүн улс руу хүргэх (64 дүгээр зүйл);
- өөр гишүүн улсаас бараа худалдаж авах (65 дугаар зүйл);
- бараа экспортлох (66 дугаар зүйл);
- гуравдагч улсад үйлчилгээ үзүүлэх (67 дугаар зүйл);
- онцгой тохиолдолд чөлөөлөх (68 дугаар зүйл);
- барааг импортлох, экспортлохтой шууд холбоотой тээвэр, үйлчилгээ (69 дүгээр зүйл);
- хүн тээвэрлэх (70 дугаар зүйл);
- бараа импортлох (71 дүгээр зүйл);
- жуулчид эсхүл онгоцны багийн гишүүдийн хувийн ачаа тээшийг импортлох, зорчигчдын шатахуун импортлох (71 а дэд-ээс 71 дүгээр зүйл);
- гуравдагч улсаас тээвэрлэж байгаа барааг импортлох ба барааг тээвэрлэх, хүргэхэд татвараас чөлөөлөгдөх (71 дүгээр зүйл) тус тус болно.

НӨАТ-ын тухай хуулийн 89 дүгээр зүйлд “Аялал жуулчлалын салбарт үйлчилгээний тусгай горим²⁰³” гэсэн тусгай заалтаар дагнан зохицуулжээ. Аялал жуулчлалын салбарт үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үйлчлүүлэгчид аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахдаа энэхүү тусгай горимыг ашиглах үүрэгтэй байна.

Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний татвар нь аялал жуулчлалын үйлчилгээний нэмэгдэл хураамжаас хасагдсан татвар юм. Энэхүү нэмэлт хураамж нь аялал жуулчлалын салбарт үйлчилгээ үзүүлсний төлөө үйлчлүүлэгч, гуравдагч этгээдээс хүлээн авсан буюу нийт мөнгөн дүн, аялал жуулчлалын төлбөр төлсөн буюу төлөх төлбөрийн нийлбэрийн зөрүүгээр тодорхойлогдоно.

Аялал жуулчлалын салбарт үйлчилгээ үзүүлэхээс өмнө хураамж авсан байх бөгөөд түүнийг татварт мэдүүлэх үүрэгтэй. Энэхүү нэмэгдэл төлбөрийг коэффициентоор тодорхойлно.

Нэмэлт төлбөрийг тооцох коэффициентыг пропорционал байдлаар тооцно.

Үүнд:

а) хоорондын ялгаа

²⁰² Мөн тэнд.

²⁰³ Хуулийн 89 дүгээр зүйл <https://www.zakonyprolidi.cz/cs/2004-235#f2551634>

- аялал жуулчлалын салбарт үйлчилгээ үзүүлснийхээ төлөө үйлчлүүлэгч болон гуравдагч этгээдээс төлбөр төлөгчийн хүлээн авсан буюу хүлээн авах нийт мөнгөн дүн;
- аялал жуулчлалын салбарын үйлчилгээнд шууд хамаарах бусад татвар ногдуулах этгээдээс худалдан авсан бараа, аялал жуулчлалын үйлчилгээнд төлбөр төлөгчийн урьд төлсөн үнийн дүнгийн нийлбэр.

б) аялал жуулчлалын салбарт үйлчилгээ үзүүлснийхээ төлөө төлбөр төлөгчөөс үйлчлүүлэгч эсвэл гуравдагч этгээдээс хүлээн авсан буюу хүлээн авах нийт мөнгөн дүн.

Нэмэлт төлбөрийг тооцох итгэлцүүрийг хувь болгон тооцож болно. Үүнд:

а) хоорондын ялгаа

- аялал жуулчлалын салбарт үйлчилгээ үзүүлснийхээ төлөө үйлчлүүлэгч болон гуравдагч этгээдээс төлбөр төлөгчийн хүлээн авсан буюу хүлээн авах нийт мөнгөн дүн;
- аялал жуулчлалын салбарын үйлчилгээнд шууд хамаарах бусад татвар ногдох этгээдээс худалдан авсан аялал жуулчлалын бие даасан үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний төлбөр төлөгчийн төлсөн буюу төлөхөөр хүлээгдэж буй үнийн дүнгийн нийлбэр.

б) аялал жуулчлалын салбарт үйлчилгээ үзүүлснийхээ төлөө төлбөр төлөгчөөс үйлчлүүлэгч эсвэл гуравдагч этгээдээс хүлээн авсан буюу хүлээн авах нийт мөнгөн дүн.

Аялал жуулчлалын салбарын үйлчилгээнд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчийн төлбөрийн нэмэлт төлбөрийг тодорхойлохын тулд нэмэлт төлбөрийг тооцох итгэлцүүрийг тооцоолох нэг аргыг ашиглаж болно.

Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч нь 6 дугаар зүйлд заасны дагуу коэффициентыг тооцоолох аргыг ашигласан тохиолдолд хүлээн авсан анхны төлбөрийн нэмэгдлийг тодорхойлох зорилгоор тооцоолсон коэффициентыг дараагийн бүх төлбөрийн нэмэлт төлбөрийг тодорхойлоход ашиглаж болно.

Дээрх хуулийн дагуу 3, 5, 6 дахь зүйлд заасны дагуу зөрүү сөрөг байвал **татварын суурь нь тэг** байна.

НӨАТ-ын үндсэн хувь хэмжээ нь аялал жуулчлалын үйлчилгээнд хамааруулна. (Энэ хуулийн 47 дугаар зүйлд татварын үндсэн хувь хэмжээг 21%-аар, эхний бууруулсан хувь хэмжээг 15%-аар, хоёр дахин бууруулсан хувь хэмжээг 10%-аар тус тус татвар ноогдуулдаг)

Бусад татвар ногдуулах этгээдээс худалдан авсан аялал жуулчлалын салбарын үйлчилгээг гуравдагч улсад үзүүлж байгаа бол аялал жуулчлалын үйлчилгээ нь **татвараас чөлөөлөгдөнө**.

Хэрэв бусад татвар ногдуулах этгээдээс худалдан авсан аялал жуулчлалын салбарын үйлчилгээг гуравдагч улс болон Европын Холбооны нутаг дэвсгэрт байгаа бол зөвхөн гуравдагч улсад үзүүлсэн үйлчилгээтэй **хувь тэнцүүлэн татвараас чөлөөлөгдөх эрхтэй**.

Өөр гишүүн улсад татвар төлөгч, бүртгэлтэй хүмүүсээс худалдан авсан аялал жуулчлалын бараа, үйлчилгээний татварыг өөр гишүүн улсаас хасаж, НӨАТ **буцаан олгогдохгүй**.

Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхдээ татварыг "тусгай горим-аялал жуулчлалын үйлчилгээ" гэсэн мэдээллийг заавал зааж өгнө. Нэмэлт төлбөртэй холбоотой татварыг

тусад нь харуулахгүй байж болно. Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлсэн төлбөр төлөгч нь энэхүү үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд нэмэлт төлбөрөөс татварыг суутгах эрхгүй байна.

Аялал жуулчлалын салбарын үйлчилгээ үзүүлэгч өөрийн үйл ажиллагаанаас бий болгосон бараа бүтээгдэхүүнийг аялал жуулчлалын үйлчилгээнд тусгаж болохгүй тохиолдолд НӨАТ ногдох татварын хувь хэмжээ, албан татварын дагуу татвар ногдуулах үүрэгтэй. НӨАТ-ыг мөнгөн дүнгээр тооцогдох эд хөрөнгийн үнэлгээг зохицуулах эрх зүйн зохицуулалтын дагуу тогтоосон үнээс тооцно.

Аялал жуулчлалын салбарын үйлчилгээг дотоодод үзүүлж байгаа тохиолдолд холбогдох татварын хувь хэмжээгээр татвар ногдуулна.

Тусгай горимоор бусдын нэрийн өмнөөс болон аялал жуулчлалын салбарын үйлчилгээ үзүүлдэг төлбөр төлөгч ашиглахыг зөвшөөрөхгүй. Татварыг төлбөр төлөгч нь аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлсний төлөө хүлээн авсан буюу авах ёстой төлбөрөөс тооцдог бөгөөд энэ нь татварыг оролцуулан мөнгөн дүн гэж тооцогддог.

Аялал жуулчлалын үйлчилгээнд багтсан бие даасан аялал жуулчлалын үйлчилгээг гуравдагч улсад үзүүлж байгаа бол өөр этгээдийн нэрийн өмнөөс болон түүний нэрийн өмнөөс аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхээс бүрдсэн үйлчилгээ нь татвараас чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд аялал жуулчлалын үйлчилгээг гуравдагч улс болон Европын Холбооны нутаг дэвсгэрийг хамарсан байх ёстой байна.

Гадаадын жуулчны худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд татварын буцаан олголт

БНЧУ-ын Прага хотод нисэх онгоцны буудал болон хилийн боомтод татваргүй бараа (tax free) бүтээгдэхүүн худалдан авсан тохиолдолд гаалийн байцаагчид үзүүлж баталгаажуулан тамга даруулна. Гадаадын жуулчдын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүн нь 30 хоногийн хугацаанд байх бөгөөд НӨАТ-ын буцаан олголтын журмаар тооцож, зээлийн картаар төлнө. БНЧУ-д татваргүй бараа (tax free) бүтээгдэхүүнд нэг удаа дэлгүүрт, өдрийн нийт худалдан авалт 2001 крон CZK (ойролцоогоор 80 €)-оор хязгаарладаг байна.²⁰⁴

Жуулчны татвар

2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн байдлаар Европын аялал жуулчлалын мэдээнд дэлхийн зарим улс орнуудын жуулчны татварын талаар дурдсан байна. Үүнд: БНЧУ-ын Прага хотод зорчсон жуулчдаас жуулчны татвар авдаг байна. Нэг хүн ноогдох татварыг 60 хоногийн хугацаанд 1 евро орчим бага хэмжээтэй төлдөг байна. Энэ нь 18-аас доош насны хүүхдэд хамаарахгүй юм байна.²⁰⁵

2.4.3. Аялал жуулчлалын салбарт агаарын болон бусад тээврийн үзүүлэх нөлөөлөл, холбогдох зохицуулалт

БНЧУ-ын аялал жуулчлал нь агаарын болон газрын, далайн гэх мэт тээвэртэй салшгүй холбоотой. Агаарын тээврийн хувьд Европын Парламент болон Зөвлөлийн 261/2004²⁰⁶ (261/2004 of the European Parliament and of the Council) журам нь хуваарьт нислэг цуцлагдах, саатах, зорчигч онгоцонд суухаас татгалзсан, ангиллын өөрчлөлт хийсэн зэрэг нөхцөлд зорчигчдын эрхийг зохицуулдаг.

²⁰⁴ <https://www.globalblue.com/tax-free-shopping/czech-republic/>

²⁰⁵ <https://www.euronews.com/travel/2023/01/09/tourist-taxes-all-of-the-countries-you-will-have-to-pay-to-enter-in-2022>

²⁰⁶ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A32004R0261>

Автобус тээврийн хувьд Автобусны зорчигчдын эрхийн тухай 181/2011 (*181/2011 on the rights of bus passengers*) гэсэн журам үйлчилнэ. Энэхүү журам нь тогтмол болон тогтмол бус, хот хоорондын ба хуваарьт зорчигч тээвэрлэлтэд хамаарах ба зорчигчдыг үл ялгаварлан тэгш үйлчлэх зарчмыг баталгаажуулж, ослын улмаас нас барсан, тээш алдагдсан, гэмтсэн тохиолдолд тээвэрлэх, нөхөн төлбөр, тусламж үзүүлэх нөхцөл, автобусны явах хуваарийг цуцалсан эсвэл хойшлуулсан тухай зорчигчдод мэдээлэх болон бусад зүйлсийг тодорхойлсон байна.

Төмөр замын зорчигчийн эрх, үүргийн тухай 1371/2007 дугаар (*No. 1371/2007 on the rights and obligations of railway passengers*) журмыг төмөр замын тээвэрт заавал биелүүлэх ёстой бөгөөд үүнд, тээвэрлэгч нь аяллын өмнө болон аяллын үеэр зорчигчдод ямар мэдээлэл өгөх ёстойг тодорхой заасан.

Түүнчлэн тус журамд төмөр замын зорчигч тээвэрлэлтийн саатал, цуцлалт, тасалбарын нөхөн төлбөрийн тухай болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх тээвэрлэгчийн үүрэг, зорчигч гэмтсэн, нас барсан тохиолдолд зорчигчдоос тавих шаардлагын талаар заажээ.

2.4.4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа бодлого, зохицуулалт

БНЧУ-ын аялал жуулчлалын агентлаг (*CzechTourism*) нь аялал жуулчлалыг хариуцсан Засгийн газрын агентлаг бөгөөд Бүс нутгийн хөгжлийн яаманд (*Ministry of Regional Development*)-д харьяалагддаг.

“Цогц аялал жуулчлал, цогц амралт, цогцолбор аяллын тухай”²⁰⁷ ЕХ-ны Зөвлөлийн Удирдамж 90/314/ (*Council Directive 90/314/EEC of 13 June 1990 on package travel, package holidays and package tourism*), ЕХ-ны Зөвлөлийн Удирдамж нь аялал жуулчлалын бүх үйлчилгээнд хамаарахгүй, зөвхөн тур буюу аялалд хамаарах асуудлыг зохицуулдаг байна.

Уг баримт бичигт аяллын үндсэн ойлголтууд, үнэ, түүний өөрчлөлтийн талаарх заалтууд, аялал зохион байгуулагч, худалдагчийн үүрэг, гэрээний үндсэн шаардлага, түүнчлэн үйлчлүүлэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд үүсэх баталгааны асуудал зэргийг тодорхойлжээ.

Аялал жуулчлалын зарим төрлийн төрийн үйлчилгээг аялал жуулчлалын мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлогыг тус агентлаг боловсруулан тууштай хэрэгжүүлж байна. Аялал жуулчлалын чиглэлээр бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах, бизнес эрхлэгчдэд маркетингийн дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалын мэргэжлийн холбоодтой хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдэнд зориулсан семинар, танилцуулга, төрөл бүрийн төсөл, сурталчилгааны кампанит ажил зохион байгуулдаг байна.

Чехийн Аялал жуулчлалын агентлагийн 2021-2025 он хүртэлх шинэ стратегийн баримт бичигт (*Strategie agentury CzechTourisma destinace Česká republika 2021–2025*) БНЧУ-ын аялал жуулчлалын нэгдсэн брэнд бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлж, мэдээллийг дижитал болгох, бүс нутаг, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд үр дүнтэй маркетингийн дэмжлэг үзүүлэхэд анхаарал хандуулахаар төлөвлөжээ. Таван жилийн

²⁰⁷ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:31990L0314>

стратегийг зах зээлийн тодорхой нөхцөл байдалд үндэслэн жилийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх юм.

БНЧУ-ын Аялал жуулчлалын агентлагаас БНЧУ-ын бүх бүс нутгийн төлөөлөгчидтэй хамтран ажиллах, үйл ажиллагааны төлөвлөгөөг улирал тутам хэлэлцүүлэхээр тохиролцсон. Таван жилийн төлөвлөгөөний гол зорилтуудын нэг бол Чехийн Аялал жуулчлалын агентлаг, Чехийн бизнес эрхлэгчид, бүс нутгийн төлөөлөгчид, гадаадын түншүүдийн хоорондын харилцааны тодорхой дүрэм, журмыг бий болгох явдал бөгөөд хамтдаа үр дүнтэй ажиллаж чадна хэмээн тэмдэглэжээ.²⁰⁸

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжиж буй арга хэмжээ, хөтөлбөрөөс дурдвал, Нийслэл Прага хотын аялал жуулчлалын үзэл баримтлалыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхэд Прага хот, хот суурин газрууд, хотын түвшний гол албан газар, байгууллагууд, орон нутгийн иргэд, бизнесийн болон ашгийн бус байгууллагууд бүх оролцогчдын оролцоотой хэрэгжүүлдэг.

Түүнчлэн “Прагад гэртээ байгаа мэт байгаарай” гэсэн дотоодын аяллыг дэмжихэд чиглэгдсэн хөнгөлөлттэй хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Прага хотын захиргаа нь Зочид буудал, ресторануудын холбоо, Худалдаа-аялал жуулчлалын холбоо, Худалдааны танхимтай хамтран оролцсон байна.

2.4.5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас нь эдийн засгийн хүнд цохилт хүлээсэн салбаруудын нэг бол аялал жуулчлалын салбар юм. Зочид буудал, амралт, сувиллын бүх газрууд хаалттай, одоо ч гадаадын жуулчдын урсгал сайн нэмэгдэхгүй байгаа учраас дотоодын аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр БНЧУ-ын төр засаг ч, орон нутгийн удирдлагууд ч янз бүрийн хөтөлбөр, арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж байна.

2022-2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дотоодын аялал жуулчлалаар бүс нутагт идэвхтэй амралт зугаалгыг илүүд үзэж жуулчдын тоо нэмэгдэх, тусгай хамгаалалтын байгалийн бүсэд учрах хүндрэлээс гадна эрүүл ахуй, аюулгүй байдлыг анхаарах нь чухал гэж үзсэн байна.

Хямралд нэрвэгдсэн аялал жуулчлалын салбарыг дэмжиж, дотоодын аялал жуулчлалыг идэвхжүүлэхийн тулд Засгийн газар 2020 оны 6 дугаар сарын 29-нд Аялал жуулчлалыг дэмжих төрийн хөтөлбөр (*Government program to support tourism*)²⁰⁹ баталсан бөгөөд Чехийн хэд хэдэн бүс нутагт өөрсдийн бие даасан хөнгөлөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ.

Энэхүү хөтөлбөрийн дагуу БНЧУ-ын Засгийн газар орон нутгийн амралтын газруудад амралт, сувиллын зардалд санхүүжилт олгосон ба тус хөтөлбөрт хөнгөлөлттэй үнээр 18-аас дээш насны, БНЧУ-д байнга оршин суудаг, улсын эрүүл мэндийн даатгалтай иргэд хамрагдсан байна.

Прага, Карловы Вары, Острава, Өмнөд-Чех зэрэг хот, нутгуудын орон нутгийн байгууллагууд тус тусын дотоодын аялал жуулчлалыг дэмжих хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн ба эдгээр нь тодорхой хугацаанд тухайн хотын амралт, сувиллын газар, зочид буудал, кафе, ресторан болон музей, үзвэр, үйлчилгээнд

²⁰⁸ https://www.czechtourism.cz/cms/getmedia/ea2d3dad-b831-45b0-87b0-6a771a1bf891/Strategie-CzT-2021_2025.pdf

²⁰⁹ Ministry of Regional Development. Cz <https://mmr.cz/cs/ostatni/web/novinky/mmr-od-dnesniho-dne-je-mozne-stahnout-slevovy-vou>

хөнгөлөлттэй үнээр амарч, сувилуулах, үйлчлүүлэх эрхийн бичиг олгох хэлбэрээр хэрэгжсэн байна.

Тухайлбал, Нийслэл Прага хотын аялал жуулчлалын шинэ стратеги нь дотоодын жуулчид болон хотынхонд голлон чиглэжээ. БНЧУ-ын нийслэл Прага хот нь улсынхаа аялал жуулчлалын гол төв бөгөөд дэлхийн хамгийн сайхан хотуудын нэг юм.

Нийслэлийн удирдлагууд Прага хотын аялал жуулчлал (*Prague City Tourism*)²¹⁰ компани болон Төлөвлөлт, хөгжлийн хүрээлэнтэй хамтран нийслэлийн дотоодын аялал жуулчлалын концепцыг боловсруулсан ба аялал жуулчлалаас олох эдийн засгийн үр ашгийг хотын болон оршин суугчдын эрх ашигт нийцүүлэн өгөөжийг нь нэмэгдүүлэхэд түлхүү анхаарчээ. Ийнхүү энэ үзэл баримтлал нь нийслэл хотын аялал жуулчлалын асуудалд хандах шинэ, нэгдсэн, тогтвортой хандлагыг бий болгосон гэж үзэж байгаа юм байна.

Уг үзэл баримтлал нь Прага хотын оршин суугчдын амьдралын чанарыг сайжруулах зорилготой бөгөөд Прага хотын соёлын өв, өвөрмөц байдлыг онцлон тэмдэглэж, аялал жуулчлалыг хотын тогтвортой хөгжлийн нэг хэсэг болгон хөгжүүлэх орчныг бүрдүүлэхийг зорьжээ.

Нийслэл захиргаа гадаадын жуулчдын тоотой харьцуулахад дотоодын жуулчдын эзлэх хувийг нэмэгдүүлж, аялал жуулчлалын тогтвортой байдлыг хангахыг хүсэж байгаа юм.

БНЧУ-ын Аялал жуулчлалын агентлаг нь стратегийн зорилго, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд оролцох хүсэлтэй бизнес эрхлэгчид болон аж ахуйн нэгж, байгууллагуудын стратегийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах болсон байна.²¹¹

Прага хотын аялал жуулчлал (*Prague City Tourism*) компанитай хамтран стратегид тусгагдсан эхний алхмуудыг тодорхой төлөвлөгөөний дагуу аль хэдийн хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайлбал, хотын төвөөс гадагш чиглэсэн аялал жуулчлалын шинэ маршрутуудыг бий болгох, ухаалаг аялал жуулчлал гэж нэрлэгддэг хэрэгслүүд, өөрөөр хэлбэл, аяллын сонголтын талаарх мэдээлэл өгөх программыг бэлтгэж байгаа бөгөөд ингэснээр бусад холбогдсон үйлчилгээг тохируулах боломжтой болно.

2.5. БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС

Аялал жуулчлал²¹² (АЖ) нь Австрийн эдийн засагт чухал байр суурь эзэлдэг байна. 2019 оны байдлаар, энэ салбар нь Австрийн эдийн засагт шууд 22 тэрбум евро оруулж, ДНБ-ийн 5.6% эзэлж байна. Салбарын 205 700 ажилтан нь Австрийн ажиллах хүчний 5.2%-ийг бүрдүүлж байна. Үйлчилгээний экспортын 30%-ийг аяллын экспорт илэрхийлж байна.

Австрийн аялал жуулчлалын салбарт гадаад аялал жуулчлал давамгайлсан байдал уламжлалтай байна.

Аялал жуулчлалын салбарын засаглал, санхүүжилт

Австрийн Холбооны улсын Үндсэн хуулийн дагуу 9 муж улс нь аялал жуулчлалын салбарын хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байна. Гэсэн хэдий ч аялал жуулчлал нь салбар дамнасан шинжтэй учир холбооны улсын болон европын хууль эрх зүйг мөрддөг байна.²¹³

²¹⁰ Прага Аялал Жуулчлал Компани

²¹¹ <https://www.czechtourism.cz/cs-CZ/Celocorni-vyzvy-ke-spolupraci/archiv-celocornich-vyzev-k-partnerstvi/Strategicka-partnerstvi-spolupracujte-s-CzechTourism>

²¹² Tourism-англиар

²¹³ OECD Tourism Trends and Policies-англиар <https://www.mlit.go.jp/kankochu/content/001577527.pdf>

Үндэсний түвшинд аялал жуулчлалын бодлогыг Холбооны улсын Хөдөлмөр ба эдийн засгийн яам буюу Аялал жуулчлалын төрийн нарийн бичгийн дарга тодорхойлдог байна. Австрийн парламент дахь Аялал жуулчлалын байнгын хороо нь хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Үндэсний болон бүсийн түвшин хоорондын уялдаа холбоо (синергийг) Аялал жуулчлалын Удирдах бүлэг²¹⁴ ханган ажилладаг байна. Бусад яам, газар, байгууллага болон аялал жуулчлалын салбар хоорондын хамтын ажиллагааг тодорхой асуудлаар байнгын ажлын хэсэг буюу дугуй ширээ (харилцаа холбоо, тогтвортой тээвэр, виз, жуулчны ёс зүй, дугуйн аялал г.м.) байгуулан эсвэл тухайн асуудлын онцлогт тохируулан (шинэ санхүүжилтийн бүтэц, аялал жуулчлалтай холбоотой шинэ хууль эрх зүйн орчин г.м.) зохион байгуулдаг байна.

Австрийн Үндэсний Аялал жуулчлалын Газар (ANTO) нь үндэсний аялал жуулчлалын маркетингийн байгууллага юм. ANTO нь зах зээлийн судалгаа, брэндийн удирдлага, маркетинг, аялал жуулчлалын сүлжээ болон мэдээллийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Яам болон Австрийн Холбооны улсын Эдийн засгийн Танхим (Аялал жуулчлал, чөлөөт цаг, соёл, эрүүл мэндийн аж үйлдвэр) хамтран ANTO-г санхүүжүүлдэг байна. Мөн Австрийн аялал жуулчлалын худалдааны танхим (Муж улсын аялал жуулчлалын зөвлөл, жуулчны бааз, тур оператор г.м.)-тай нягт хамтран ажилладаг байна.

2021 онд үндэсний аялал жуулчлалын захиргааны нийт төсөв 57.3 сая евро байв. Үүнээс 28.4 сая евро жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-д санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэгч тусгай банк болох Австрийн Аялал жуулчлалын Хөгжлийн Банкны мэдэлд зарцуулсан байна. ANTO жилийн төсөвтөө 24 сая евро (2020 онд Ковид-19 цар тахлын дараах сэргээн босгох зориулалтаар нэмж 40 сая евро авч байсан) хүлээн авсан байна. Яам нь аялал жуулчлалын төсөл болон ажил үйлчилгээний гэрээг хамтран санхүүжүүлэх зорилгоор 5 сая евро хувийн хэвшилд субсид хийсэн байна.

Аялал жуулчлалын салбар дахь ЖДҮ нь Европын сэргээн босгох хөтөлбөрийн хүрээнд 70 сая евро зээл хүртсэн байна. Үндэсний төсвөөс гадна бүх 9 муж улс нь аялал жуулчлалын хөгжлийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор өөрийн аялал жуулчлалын төсөвтэй байдаг байна.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 90 мянга орчим аж ахуйн нэгж Австрийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимд бүртгэлтэй бөгөөд ДНБ-ийн 15% орчмыг бүрдүүлж байгаа нь 600 000 гаруй бүтэн цагийн ажилтантай тэнцэх хэмжээний ажлын байрны үр өгөөжийг бий болгож байна гэсэн үг юм. Танхимын гишүүн байгууллагын ихэнх нь гэр бүлийн аж ахуйн нэгж байдаг байна.²¹⁵

Хүснэгт 4. Австри Улсын дотоодын болон дотоод, гадаад аялал жуулчлал

	2017	2019	2021
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН УРСГАЛ [МЯНГА]			
Дотоодын аялал жуулчлал			
Хоноглосон зочин (жуулчин)	13 619	14 312	9 416
Өдрийн зочин (аялагч)
Нийт ор-хоног	38 523	39 944	29 599
Зочид буудал	33 539	34 767	24 577
Бусад олноор хоноглох байр	1 543	1 737	2 098
Хувийн байр	3 441	3 440	2 924

²¹⁴ Steering Group-англиар

²¹⁵ Австрийн Худалдаа, Аж үйлдвэрийн Танхим-Wirtschaftskammer Österreich-репманаар <https://www.wko.at/branchen/tourismus-freizeitwirtschaft/ziele-und-grundsaeetze.html>

Гадаадаас ирсэн дотоод аялал жуулчлал			
Хоноглосон зочин (жуулчин)	29 460	31 884	12 728
Өдрийн зочин (аялагч)
Топ-5 зах зээл			
Герман	13 443	14 383	12 728
Голланд	1 935	2 074	934
Швейцарь, Лихтенштайн	1 454	1 451	573
Итали	1 102	1 108	335
Нэгдсэн вант улс	942	966	86
Нийт ор-хоног	105 977	112 765	49 964
Зочид буудал	81 179	85 982	35 753
Бусад олноор хоноглох байр	4 865	5 404	4 282
Хувийн байр	19 933	21 379	9 930
Гадаадад зорчсон гадаад аялал жуулчлал			
Нийт гадаадад зорчсон	14 068	14 388	8 628
Хоноглосон зочин (жуулчин)	11 491	11 902	7 522
Өдрийн зочин (аялагч)	2 577	2 486	1 106
Топ-5 зорчсон улс			
Итали	2 221	2 269	1 994
Герман	2 189	2 559	1 633
Хорват	1 413	1 000	845
Грек	375	577	469
Испани	620	629	351
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРЛОГО, ЗАРЛАГА [САЯ ЕВРО]			
Дотоод (ирсэн) аялал жуулчлал			
Нийт гадаадын орлого	19 952	23 127	10 094
Гадаадын аяллын орлого	18 112	20 493	8 762
Гадаадын зорчигч тээврийн орлого	1 840	2 634	1 332
Гадаад (зорчсон) аялал жуулчлал			
Нийт гадаад зарлага	11 300	12 491	7 463
Гадаад аяллын зарлага	9 454	10 364	6 810
Гадаад зорчигч тээврийн зарлага	1 846	2 127	653

Тайлбар: .. дүн мэдээ байхгүй

Эх сурвалж: OECD Tourism Statistics (Database)

Хүснэгт 5. Австрийн аялал жуулчлалын байгууллага, ажилтан

	2018	2019	2020
Аялал жуулчлалын аж үйлдвэрийн нийт	199 293	205 654	137 756
Зочдын байрны үйлчилгээ	130 563	134 686	102 465
Зорчигч тээвэр	34 536	35 750	12 124
Тур-оператор, бусад захиалга авах байгууллага	11 480	11 868	10 836
Соёлын аж үйлдвэр	22 681	23 337	12 300
Спорт, сэргээн засах аж үйлдвэр	6 036

Тайлбар: .. дүн мэдээ байхгүй

Эх сурвалж: OECD Tourism Statistics (Database)

Хүснэгт 6. Австрийн аялал жуулчлалын дотоод хэрэглээ 2020 он [САЯ ЕВРО]

Дотоодын жуулчдын хэрэглээ	9 148
Гадаадаас ирсэн жуулчдын дотоод хэрэглээ	11 760
Нийт хэрэглээ	21 265

Эх сурвалж: OECD Tourism Statistics (Database)

2.5.1. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг татахад чиглэсэн бодлого, хэрэгжилт

Аялал жуулчлалын салбарын мэргэжилтэн, бизнес эрхлэгчдийн оролцоотой 2018-2019 онд 9 семинар дамжин боловсруулан 2019 оны 03 дугаар сард баталсан “Т төлөвлөгөө буюу аялал жуулчлалын мастер план” нь Австрийн аялал жуулчлалын бодлогын суурь юм.²¹⁶ Аялал жуулчлалын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах Т-төлөвлөгөөний бүтцээс харж болно. Үүнд:

- Аялал жуулчлалын талаарх ухамсрыг хүчтэй болгох;
- Хамтран ажиллах соёлыг бий болгох;
- Дижитал боломжийг ашиглах;
- Тур баазыг сэтгэл татмаар бүтээн байгуулах;
- Боловсрол, хөдөлмөрийн зах зээлийг ирээдүйд нийцүүлэн бэлтгэх;
- Амьжиргааны суурийг тогтвортой хангах;
- Бүсийн нэмүү өртөг бий болгох;
- Аялал жуулчлалын маркетингийг амжилттай хөгжүүлэх;
- Санхүүжилт, тэтгэлгийг уян хатан болгох.

Цар тахлаас улбаатай уналт, түүний дараах улсын төсвийн дэмжлэгээр эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын салбарын онцлогийг харгалзан ялангуяа, хоноглох байр, зочдыг дайлах болон аяллыг зохион байгуулах чиглэлд дараах дэмжлэгийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 2020-2022 онд Австри нь аялал жуулчлалын найдвартай чиглэл гэдэг итгэл, баталгааг сэргээн хүчтэй болгохын тулд аялал жуулчлалын ажиллах хүч болон зочдын Ковид-19 дэлгэрэнгүй шинжилгээг үнэгүй хийх;
- 2020.07.01-нээс 2021.12.31 хүртэл хугацаанд НӨАТ-ыг 5% болгон бууруулах багц (байр, хоолны НӨАТ 10%, ундааных 20%);
- Аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор бизнесийн үйл ажиллагаандаа оруулсан хөрөнгө оруулалтын 7%-тай тэнцэх хэмжээний грант олгох. Хэрэв ногоон, дижитал буюу эрүүл мэндийн чиглэлээр бол хөрөнгө оруулалтын урамшууллыг 2 дахин нэмэгдүүлэх (нийт хэмжээ 7.8 тэрбум евро);
- 2021 оныг дуустал эргэлтийн хөрөнгө буурснаас үүдэлтэй төлбөрийн чадвар алдалтыг түр зогсоох зорилгоор гүүрэн зээлийн 100% хүртэл хэмжээний баталгаа гаргах, 2021 оны 09 дүгээр сарыг дуустал хязгаарлалтаас үүдэлтэй тогтмол зардал, алдагдлыг дарах хэмжээний грант олгох;
- 2021 оны 03 дугаар сараас 2022 оны 12 дугаар сарыг дуустал нийтийн арга хэмжээ цуцлагдсан, хязгаарлагдсанаас үүдэлтэй зохион байгуулагчид үзүүлэх санхүүгийн нөхөн олговор олгох дэмжлэг; нийт хэмжээ 300 сая евро (Австрийн Аялал жуулчлалын Хөгжлийн Банк хариуцна), нэг зохион байгуулагчийн дээд хэмжээ 10 сая евро;
- 2021-22 онд аяллын багц зохион байгуулагч нь дампуурснаас үүдэлтэй Австрийн Аялал жуулчлалын Хөгжлийн Банк батлан даасан бол аялагчийн төлбөрийн тэтгэлэг (багцын нийт хязгаар 300 сая евро);
- 2022 оны 03 дугаар сар хүртэл “Agrarmarkt Austria GmbH” ХХК-аар зуучлуулан хувийн байрны үйлчилгээ үзүүлэх газрын эзэн, фермд үзүүлэх тэтгэлэг.

²¹⁶ Т-төлөвлөгөө буюу аялал жуулчлалын мастер план-Plan T-Masterplan für Tourismus-германаар <https://www.bmaw.gv.at/Themen/Tourismus/plan-t.html>

Урт хугацаандаа олон аж ахуйн нэгж төлбөрийн чадвар болон үндсэн хөрөнгийн хүндрэл, ажиллах хүчний хомсдол, ур чадварын шаардлагатай нүүр тулж буй тул санхүүгийн зохицуулалтыг шинэчилж, дэмжлэг тусламжийг үргэлжлүүлэх хэрэгцээ байсаар байна. Ялангуяа, аялал жуулчлал дахь ногоон болон дижитал шилжилт, бүс нутаг болон хот хөгжүүлэх чиглэлийг онцгойлон анхаарах нь зүйтэй юм. 2022 онд ногоон шилжилтийг хурдасгах, бүс нутгийн нэмүү өртгийг сайжруулах болон тогтвортой амралтын хэрэгцээ нэмэгдсэнийг хангах зорилгоор тур баазад эко шошго шинээр олгож эхлээд байна.

Хүчтэй засаглал, зохицуулалт болон мэдээлэл нь Австрийн АЖ-ын салбарын гол түлхүүр бөгөөд орон нутаг, бүсийн нэмүү өртгийг сайжруулахын тулд аялал жуулчлал болон бүсийн бодлогыг харилцан зохицуулах нь чухал ач холбогдолтой юм.

Аялал жуулчлалын эрэлт, нийлүүлэлтээс авхуулан засаглал хүртэлх хүрээнд дунд болон урт хугацааны чухал ач холбогдол бүхий Т-төлөвлөгөөний чиглэл зорилтуудыг сайжруулан боловсронгуй болгож, 2023-2024 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 0дүгээр сард батлаад байна.

АНТО-гийн харьяаны *Австрийн Сурталчилгаа* (OW) агентлагийн шугамаар гадаадад 200 ажилтан 21 зах зээлийн товчоонд 27 зах зээлийг товлон үйлчилж, боломжит 8 зах зээлийг судалж байна.²¹⁷ 2023 оны 03 дугаар сард гадаад дахь бүтцийг оновчтой болгохын тулд бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөж байна. OW-товчоодыг холбогдох элчин сайдын яамдтай буюу Гадаад худалдааны байгууллага (AWO)-тай нэгтгэж, хүчийг төвлөрүүлэн синерги бий болгоно.

Мөн бүх хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-иудыг татан буулгаж элчин сайдын яамны товчооны буюу AWO-гийн ажилтан болгоно.

Аялал жуулчлалын тэтгэлгийн хэмжээ өмнөх онтой адил 24.5 сая евро төсөвлөгдсөн байна. Тогтвортой байдлын үнэлгээг үндэслэн 04 дүгээр сараас эхлэн шинэ аргачлалын дагуу санхүүжилт олгож эхэлнэ.

Үйл ажиллагааны хөтөлбөрт туссан бас нэгэн шинэлэг зүйл бол дижитал шилжилт юм. Энэ хүрээнд зочны бүртгэл бүрэн цахимжина. Харин түрээслүүлэгчийн бүртгэлийг 2023 оны эцэст ашиглалтад оруулах болно.

2.5.2. Аялал жуулчлалын салбарт үзүүлж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, төрийн дэмжлэг

2023 оны 11 дүгээр сараас эхлэн Европын Холбооны бус бөгөөд визгүй зорчдог байсан улсын иргэн хүсэлт гаргасны төлбөрт 7 евро төлж шенгений бүсэд нэвтэрнэ. 18-аас доош буюу 70-аас дээш настай хүн төлбөрөөс чөлөөлөгдөнө.²¹⁸

Австри нь жуулчны татвар нэвтрүүлсэн 22 орны нэг юм. Жуулчны татварын зорилго нь *нэгдүгээрт*, жуулчдын тоог хазаарлаж, жуулчдын хөлд хэт дарагдахаас сэргийлэх; *хоёрдугаарт*, зорчигч бүрээс тогтвортой татвар татахад оршдог байна. Энэхүү татварын эх үүсвэрийг чухамхүү аялал жуулчлалын байгууламжийн засвар, үйлчилгээ болон байгаль орчны нөөцийг хадгалан хамгаалахад зарцуулдаг байна.

²¹⁷ Австрийн аялал жуулчлал санаснаас илүү амжилт гаргалаа. Ажлын хөтөлбөр нэмэлт жигүүр ургуулах нь Österreich-Tourismus performt besser als gedacht! Arbeitsprogramm soll ihn zusätzlich beflügeln-германаар <https://www.tai.at/hotellerie/tourismuspolitik/oesterreich-tourismus-performt-besser-als-gedacht-arbeitsprogramm-soll-ihn-zusaetzlich-befluegeln>

²¹⁸ Жуулчны татвар-Tourist taxes-англиар <https://www.euronews.com/travel/2023/01/09/tourist-taxes-all-of-the-countries-you-will-have-to-pay-to-enter-in-2022>

Австрид хоноглосон байрны татвар төлдөг ба хэмжээ нь орон нутгаас хамааран харилцан адилгүй байна. Вена, Залцбург хотуудад нэг хүнд оногдох зочид буудлын үнийн 3.02% байдаг.

Жуулчны албан татварыг Аялал жуулчлалын тухай хуульд хоноглох татвар гэж тусгасан байна.

АШИГЛСАН ЭХ СУРВАЛЖ

- Juliet Masiga, What next for travel and tourism? Here's what the experts say, World Economic Forum, June 30, 2022, <https://www.weforum.org/agenda/2022/06/what-next-for-travel-and-tourism-industry-experts-explain/>
- <https://www.parliament.mn/nn/10345/>
- UNWTO World Tourism Barometer, Latest tourism data, <https://www.unwto.org/unwto-world-tourism-barometer-data>
- OECD (2022), OECD Tourism Trends and Policies 2022, OECD Publishing, Paris, https://www.oecd-ilibrary.org/industry-and-services/oecd-tourism-trends-and-policies_20767773

ГҮРЖ УЛС

- Georgia - Country Commercial Guide: Tourism, <https://www.trade.gov/country-commercial-guides/georgia-tourism>;
- «Грузия – страна жизни». Стратегия развития туризма в Грузии, <https://www.vsemirnyjbank.org/ru/news/feature/2015/12/07/a-tourism-strategy-for-georgia-country-of-life>
- Agenda.ge, <https://agenda.ge/en/news/2022/730>
- https://georgia.travel/en_US/georgia
- Tourism industry in Georgia, December 2022, TBC Capital, <https://tbcapital.ge/static/file/202212280624-tourism-industry-in-georgia-december-2022.pdf>
- Services for tourist company in Georgia, <https://accounting.jara.ge/how-to-open-a-tourist-company-in-georgia/?lang=en>
- How to open a travel company in Georgia, <https://accounting.jara.ge/how-to-open-a-tourist-company-in-georgia/?lang=en>
- DETAILED CONCEPT ON THE LAW OF TOURISM, USAID, 20 MAY 2019, https://pdf.usaid.gov/pdf_docs/PA00W4N5.pdf
- Explore Georgia, https://georgia.travel/en_US/georgia

БНСУ

- <https://www.trade.gov/country-commercial-guides/south-korea-travel-and-tourism>
- https://english.visitkorea.or.kr/enu/SHP/SH_ENG_1_1.jsp#:~:text=The%20immediate%20tax%20refund%20is,the%20entire%20travel%20in%20Korea.&text=Must%20spend%20over%2030%2C000%20won,than%20six%20months%20in%20Korea
- <https://www.seoulsolution.kr/en/content/guide-transportation-policy-general>
- <https://www.oecd-ilibrary.org/sites/6e8b663c-en/index.html?itemId=/content/component/6e8b663c-en>

ТАЙЛАНД УЛС

- Тайланд Улс, <https://www.mofa.go.jp/mofaj/area/thailand/data.html>
- Long-Term Residents visa, <https://www.w-lawthai.com/en/type-of-visa-2023/>
- LTR виз <https://kpmg.com/th/en/home/insights/2022/11/legal-news-flash-issue-19.html>
- Био-Тойрог-Ногоон эдийн засгийн загвар, <https://mahanakornpartners.com/the-bio-circular-green-economic-model/>
- Тайландын аялал жуулчлалын тухай хууль, <https://thailawyers.com/thai-laws/thai-tourism-law/>
- Тайландын аялал жуулчлалын газар, <https://www.tourismthailand.org/home>
- Тайландын аялал жуулчлалын лицензийн ба жуулчны хөтөчийн тухай хууль, <https://www.samuiforsale.com/company-law/thailand-tat-tourism-license-tourism-business-and-guide-act.html>
- Аялал жуулчлал, спортын яам, https://www.mots.go.th/mots_en/news/3151
- Аялал жуулчлалын хөгжлийн газар, <https://www.tourismthailand.org/home>

- Тайландын аялал жуулчлалын зөвлөл, <https://www.thailandtourismcouncil.org/about-us/>
- Жуулчны цагдаагийн алба, <https://www.amazing-thailand.com/thai-tourist-police.html>

ЧЕХ УЛС

- Act 159/1999 Coll. Act on certain conditions of business in the field of travel. <https://www.podnikatel.cz/zakony/zakon-c-159-1999-sb-o-nekterych-podminkach-podnikani-v-oblasti-cestovniho-ruchu>
- The concept of state tourism policy <https://www.cestovni-ruch.cz/zdroje/docs/koncepcie.htm>
- Government program to support tourism. mmr.cz/cs/ostatni/web/novinky/mmr-od-dnesniho-dne-je-mozne-stahnout-slevovy-vou
- Strategy of the CzechTourisma agency destination Czech Republic 2021–2025 New strategy of the travel agency for the years 2021-2025
- https://www.czechtourism.cz/cms/getmedia/ea2d3dad-b831-45b0-87b0-6a771a1bf891/Strategie-CzT-2021_2025.pdf
- Directive (EU) 2015/2302 of the European Parliament and of the Council of 25 November 2015 on package travel and linked travel arrangements. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:31990L0314>
- Directive (EU) 2015/2302 of the European Parliament and of the Council of 25 November 2015 on package travel and linked travel arrangements). <https://eur-lex.europa.eu/eli/dir/2015/2302/oj>
- Regulation (EC) No 261/2004 of the European Parliament and of the Council of 11 February 2004. <https://eur-lex.europa.eu/eli/reg/2004/261/oj>
- Regulation (EU) No 181/2011 of the European Parliament and of the Council of 16 February 2011 concerning the rights of passengers in bus and coach transport. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A32011R0181>
- Regulation (EC) No 1371/2007 of the European Parliament and of the Council of 23 October 2007 on rail passengers' rights and obligations.

АВСТРИ УЛС

- OECD Tourism Trends and Policies-*англиар* <https://www.mlit.go.jp/kankocho/content/001577527.pdf>
- Австрийн Холбооны улсын Аж үйлдвэрийн Танхим-Wirtschaftskammer Österreich-*германаар* <https://www.wko.at/branchen/tourismus-freizeitwirtschaft/ziele-und-grundsaeetze.html>
- Т-төлөвлөгөө буюу аялал жуулчлалын мастер план-Plan T-Masterplan für Tourismus-*германаар* <https://www.bmaw.gv.at/Themen/Tourismus/plan-t.html>
- Жуулчны татвар-Tourist taxes-*англиар* <https://www.euronews.com/travel/2023/01/09/tourist-taxes-all-of-the-countries-you-will-have-to-pay-to-enter-in-2022>
- Австрийн аялал жуулчлал санаснаас илүү амжилт гаргалаа! Ажлын хөтөлбөр нэмэлт жигүүр ургуулах нь-Österreich-Tourismus performt besser als gedacht! Arbeitsprogramm soll ihn zusätzlich beflügeln-*германаар* <https://www.tai.at/hotellerie/tourismuspolitik/oesterreich-tourismus-performt-besser-als-gedacht-arbeitsprogramm-soll-ihn-zusaetzlich-befluegeln>

ХАВСРАЛТ (Албан бус орчуулга)**ЖУУЛЧДЫГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ДҮРЭМ (UNWTO)²¹⁹**
(INTERNATIONAL CODE FOR THE PROTECTION OF TOURISTS)**ОРШИЛ**

2021 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 03-ны хооронд Испанийн нийслэл Мадрид хотноо болсон Ерөнхий Ассамблейн 24 дүгээр чуулганы 732 (XXIV) дугаар тогтоолоор батлагдсан Жуулчдыг хамгаалах олон улсын дүрэм нь онц байдлын үед жуулчдыг хамгаалах болон жуулчдын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тал дээрх олон улсын наад захын стандартуудыг уялдуулж жуулчдыг хамгаалахад чиглэсэн цогц зарчим, зөвлөмжийг багтаасан бөгөөд тус дүрмээр дамжуулан Ковид-19 цар тахлын дараах олон улсын жуулчлалд хангалттай баталгаа өгөхийг зорьж байна.

Жуулчдыг хамгаалах олон улсын дүрэм нь тус дүрэмд заасан асуудлаар үүрэг, хариуцлага, эрх, үүрэг хүлээсэн Засгийн газар, төрийн болон хувийн хэвшлийн оролцогч талууд болон жуулчид гэх зэрэг төр, хувийн хэвшлийн бүх талуудад бодитой зөвлөмж өгөх зорилготой.

Энэ дүрэм нь таван бүлгээс бүрдэх ба дараах зөвлөмжийг багтаасан болно: (I) Тодорхойлолт ба тодруулга; (II) Онцгой байдлын үед олон улсын жуулчдад үзүүлэх тусламж; (III) Гэрээн дэх жуулчдын хамгаалал; (IV) Аялал жуулчлалын маргааныг олон улсын хэмжээнд шийдвэрлэх тогтоолын хувилбарууд; (V) Жуулчдыг хамгаалах олон улсын дүрмийн зөвлөмжийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх механизм.

Жуулчдыг хамгаалах олон улсын дүрэм нь онц байдлын үед жуулчдыг хамгаалах, жуулчдын хэрэглэгчийн эрхийг хамгаалах наад захын стандартыг олон улсын түвшинд уялдуулах замаар тэдэнд бүх талын аюулгүй байдлыг бий болгож, аяллын орчныг илүү сонирхол татахуйц болгох мөн аялал жуулчлалын төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэгч болон үйлчлүүлэгч талын хоорондын гэрээний харилцааг сайжруулахыг зорьж байна.

Энэхүү дүрэм нь эрх зүйн хувьд үүрэг хүлээлгэдэггүй буюу зөвлөмжийн чанартай хуулийн хэрэгсэл болохын хувьд улс орнуудын өмнө үүрэг хариуцлага үүсгэдэггүй бөгөөд тэдэнд нэмэлт дарамт учруулдаггүй. Үүний эсрэгээр, жуулчдын итгэлийг сэргээхэд гишүүн орнуудын авч буй хүчин чармайлтыг дэмжиж, үндэсний хэмжээнд санал болгож буй бодлого, хууль тогтоомж, зохицуулалтын практикийн талаар засгийн газруудад зааварчилгаа өгөх замаар аялал жуулчлалын сэргэлтийг хурдасгахад туслах зорилготой юм.

Иймээс НҮБ болон Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын бүх гишүүн орнуудыг энэхүү дүрмийг даган мөрдөж, дүрмийг баримтлахыг санал болгохын зэрэгцээ уг дүрмийг хэрэгжүүлсний дараа явуулсан тодорхой үйл ажиллагааны талаар Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад тайлагнахыг уриалж байна.

Үүнтэй адилаар аялал жуулчлалын бусад оролцогч талууд ч мөн жуулчдыг хамгаалах олон улсын дүрмийг баримталж, жуулчидтай байгуулсан гэрээндээ холбогдох зөвлөмж, зарчмыг аль болох тусгаснаар жуулчид төрөл бүрийн аяллын үйлчилгээг итгэлтэйгээр захиалах үндэс болох юм.

²¹⁹ INTERNATIONAL CODE FOR THE PROTECTION OF TOURISTS, Adopted by the Resolution A/RES/732(XXIV) of the General Assembly of UNWTO at its twenty-fourth session, <https://www.e-unwto.org/doi/epdf/10.18111/9789284423361>

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ /Тодорхойлолт ба тодруулгууд/**А. Тодорхойлолт**

Тодорхой зүйлд өөрөөр заагаагүй бол уг дүрмийн хүрээнд дараах нэр томъёог доор дурдсан утгаар хэрэглэнэ:

1. "Үндсэн харьяаллын улс" гэж жуулчин нь тухай улсын харьяалалтай, эсхүл зайлшгүй, онцгой нөхцөл байдал, онц байдлын үед тухайн жуулчны үндсэн болон байнгын оршин сууж буй улсыг хэлнэ.
2. "Онц байдал" гэдэг нь хүлээн авагч улсын хяналтаас гадуурх байгалийн болон хүний үйлдлээс үл хамааралтай томоохон хэмжээний тусламж шаардлагатай болсон ер бусын, онцгой эсвэл урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдлыг хэлнэ.
3. "Экскурст аялагч" гэдэг нь оршин суудаг ердийн орчин бус, аяллын гол зорьсон газарт хүрэхдээ хонох шаардлагагүй аялж байгаа хүнийг хэлнэ.
4. "Хүлээн авагч улс" гэж зайлсхийх боломжгүй, онцгой нөхцөл байдал, онц байдал үүссэн, эсхүл түүний үр дагавар нь тохиогоод байгаа гишүүн улсыг хэлнэ.
5. "Аялал жуулчлалын үйлчилгээ" гэж жуулчдад үзүүлэх дор дурдсан үйлчилгээний аль нэгийг дан болон хосолсон хэлбэрээр үзүүлэхийг хэлнэ.
 - i. Орон сууцны зориулалтаас бусад орон сууцны үйлчилгээ;
 - ii. Тээврийн үйлчилгээ;
 - iii. Багц аяллын зохион байгуулалт, жижиглэн худалдаа, зуучлалын болон бусад захиалгын үйлчилгээ;
 - iv. Аялал, үйл ажиллагаа, үзвэр үйлчилгээ, тойрон аялал, арга хэмжээ;
 - v. Жуулчдад үзүүлэх бусад үйлчилгээ.
6. "Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчлах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулах үүрэг хүлээсэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийг (хувийн болон төрийн өмчийнхөөс үл хамааран) хэлнэ.
7. "Жуулчин" гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэг жилээс бага хугацааг гол зорьж буй газарт хүрэхдээ зарцуулан тухайн улс эсвэл очсон газартаа байнгын оршин суугч болох эсвэл ажиллахаас бусад бизнес, амралт зугаалгын болон өөр хувийн зорилгоор аялж буй хүнийг хэлнэ.
8. "Зайлсхийх боломжгүй, онц нөхцөл байдал" гэж тухайн нөхцөл байдал үүсгэсэн талын хяналтаас гарсан бөгөөд бүхий л боломжит арга хэмжээ авсан ч зайлсхийх боломжгүй болсон үр дагаврыг хэлнэ.

В. Тодруулга

Тодорхой зүйлд өөрөөр заагаагүй бол уг дүрмийн хүрээнд дараах тодруулгыг хэрэглэнэ.

1. Энэ дүрмийн хүрээнд "Маргаан хянан шийдвэрлэх бусад арга" гэдэг нь аялал жуулчлалын болон жуулчны тухай гомдлыг төрийн болон хувийн хэвшлийн аль нэг талт маргаан хянан шийдвэрлэх байгууллагын туслалцаатайгаар шүүхээс гадуур шийдвэрлэх зохицуулалтыг хэлнэ. Маргаан хянан шийдвэрлэх бусад аргуудад омбудсмэн(аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа төрийн байгууллагын эсрэг иргэдийн гомдлыг шалгахгаар томилогдсон албан тушаалтан), эвлэрэл, зуучлал ба заавал дагаж биелүүлэх болон заавал дагаж биелүүлэх албагүй хэрэглэгчийн арбитр зэрэг ордог ба зөвхөн дээрх зүйлсээр хязгаарлагдахгүй юм.
2. Энэхүү дүрмийн хүрээнд "бизнесийн хэрэглэгч" гэсэн нэр томъёо нь жуулчдад аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх зорилгоор эсвэл үзүүлэх явцад онлайн

- аялал жуулчлалын платформ ашигладаг аливаа аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчийг хэлнэ.
3. Энэхүү дүрмийн хүрээнд "дижитал аялал жуулчлалын үйлчилгээ" гэсэн ойлголт нь мэдээллийн нийгмийн үйлчилгээ, аялал жуулчлалын үйлчилгээтэй холбоотой зуулчлалыг оролцуулан үйлчилгээ хүлээн авагчийн хүсэлтээр, алсаас, цахим хэрэгслээр үзүүлж буй аялал жуулчлалын аливаа үйлчилгээг хэлнэ.
 4. Энэхүү дүрмийн хүрээнд "дижитал аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч" гэсэн нэр томъёо нь дижитал хэрэгслээр жуулчдад аялал жуулчлалын үйлчилгээг бүрдүүлж, худалдах, сурталчлах болон үйлчилгээг нийлүүлэх үүрэг хүлээсэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
 5. Энэхүү дүрмийн хүрээнд "зуучлагч" гэдэг нь гуравдагч этгээдээс нийлүүлсэн аялал жуулчлалын үйлчилгээ эсвэл зохион байгуулагчийн нийлүүлсэн багцыг худалдах, худалдахаар санал болгож буй зохион байгуулагчаас бусад аливаа хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
 6. Энэхүү дүрмийн хүрээнд "ялгаварлан гадуурхахгүй байх" гэсэн аливаа ойлголт нь НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр хүлээн зөвшөөрөгдсөн тэгш эрх, ялгаварлан гадуурхахгүй байх ерөнхий зарчимд нийцүүлэгдэн тайлбарлагдахын зэрэгцээ үүнд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйл, ОУХБ-ын 1112 тоот Ялгаварлан гадуурхах тухай конвенцын 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтууд хамаарах бөгөөд зөвхөн дээрх заалтуудаар хязгаарлагдахгүй.
 7. Энэхүү дүрмийн хүрээнд "маргааныг онлайн аар шийдвэрлэх" гэсэн нэр томъёо нь уг хэсгийн 1-р зүйлд заасны дагуу аялал жуулчлалын болон жуулчдын гомдлыг шийдвэрлэхэд Мэдээлэл Харилцаа Холбооны Техник болон интернэтийг ашиглан хялбаршуулах, хурдасгах маргааныг шийдвэрлэх өөр хэлбэрийг хэлнэ.
 8. Энэхүү дүрмийн хүрээнд "онлайн аялал жуулчлалын платформ" гэдэг нь хамтарсан эдийн засгийн вэбсайтууд, контент хуваалцах вэбсайтууд, олон нийтийн сүлжээнүүд, апп дэлгүүрүүд, онлайн зах зээлүүд, онлайн аялал жуулчлалын болон орон сууцны вэбсайтууд зэрэг аливаа хостинг үйлчилгээг хэлнэ. Энэхүү үйлчилгээ нь жуулчин эсвэл бизнес эрхлэгчийн хүсэлтээр хийгдэх ба аялал жуулчлалын дээрх үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хадгалж эсвэл түгээдэг.
 9. Энэ дүрмийн хүрээнд "зохион байгуулагч" гэсэн нэр томъёо нь ашиг олох зорилгоор бус ховор тохиолдолд шууд болон өөр хүнээр дамжуулан, эсвэл өөр хүнтэй хамтрах замаар аяллын багц үйлчилгээг зохион байгуулж, худалдах түнийг санал болгож буй аливаа хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
 10. Энэхүү дүрмийн хүрээнд "оператор" гэсэн нэр томъёо нь жуулчдад аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх зорилгоор буюу үйлчилгээний явцад онлайн аялал жуулчлалын платформ ажиллуулдаг аливаа хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
 11. Энэ дүрмийн хүрээнд "түрээсийн үйлчилгээ" гэсэн нэр томъёо нь автомашин, моторт тээврийн хэрэгсэл, унадаг дугуй эсвэл жуулчны зугаа цэнгээний хэрэгсэл зэргийг түрээслэх үйл ажиллагаа бөгөөд дараах агуулга нь зөвхөн дээр дурдсан зүйлсээр хязгаарлагдахгүй.
 12. Энэхүү дүрмийн хүрээнд болон тус бүлгийн А хэсэгт тодорхойлсончлон "аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч" гэсэн нэр томъёо нь аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчээр хууль ёсны бүртгэлтэй аль эсвэл улс орон бүрийн аялал жуулчлалын үйлчилгээг зохицуулах эрх зүйн зохицуулалтын дагуу эрх бүхий байгууллагуудаар хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

13. Энэхүү дүрмийн хүрээнд болон тус бүлгийн А хэсэгт тодорхойлсон "жуулчин" гэх нэр томъёо Экскурст аялагч гэсэн утгыг давхар илэрхийлнэ.
14. Энэхүү дүрмийн хүрээнд "тээврийн үйлчилгээ" гэдэг нэр томъёо нь төмөр зам, авто зам, ус, агаарын болон сансрын зорчигч тээврийн үйлчилгээ, түүнчлэн тус улсын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээнд заасан бусад зорчигч тээврийн үйлчилгээг багтаасан ойлголт бөгөөд зөвхөн дээр дурдсан зүйлсээр хязгаарлагдахгүй.
15. Энэхүү дүрмийн хүрээнд "зайлсхийх боломжгүй, онц нөхцөл байдал" гэдэгт дараах зүйлс багтана. Үүнд аялж байгаа газар эсвэл түүний ойр орчимд иргэний эмх замбараагүй байдал болон терроризм гэх мэт аюулгүй байдлын ноцтой асуудлууд үүсэх мөн урьдчилан таамаглагдаагүй ноцтой өвчний дэгдэлт зэрэг хүний эрүүл мэндэд учирч болзошгүй томоохон эрсдэлүүд мөн үер, газар хөдлөлт, цаг агаарын нөхцөл байдал зэрэг байгалийн гамшигт үзэгдэл нь талуудын хяналтаас гарж, аялал жуулчлалын үйлчилгээний гэрээнд заасны дагуу зорьсон газар руугаа аюулгүй зорчих боломжгүй хэмжээнд очих зэрэг багтана. Түүнчлэн тухайн улсын нэгдэн орсон олон улсын холбогдох гэрээнд заасан бусад нөхцөлүүд үүнд багтах ба тус ойлголт нь дээр дурдсан жишээнүүдээр үл хязгаарлагдана.
16. Энэхүү дүрмийн хүрээнд "ваучер" гэдэг нь аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч нь жуулчдад мөнгөн нөхөн олговор олгохын оронд санал болгодог урьдчилан төлсөн купон, бэлгийн карт, аяллын чек эсвэл үнэгүй тасалбар зэргийг хэлэх ба зөвхөн дараах зүйлсээр хязгаарлагдаагүй ойлголт юм.
17. Энэхүү дүрмийн хүрээнд "эмзэг бүлгийн жуулчид" хэмээх агуулгад хөдөлгөөний бэрхшээлтэй, хөгжлийн бэрхшээлтэй, нэвтрэх тусгай шаардлага бүхий жуулчид болон насанд хүрээгүй эсвэл өндөр настай аялагчдыг хамааруулах бөгөөд зөвхөн дээрх зүйлсээр үл хязгаарлагдах ойлголт юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ *Онц байдлын үед олон улсын жуулчдад үзүүлэх тусламж/*

I ХЭСЭГ

ЗАРЧИМ

1. Уялдаа холбоо:

Олон улсын жуулчдад онц байдлын үед үзүүлэх тусламжийн талаарх дэлхий нийтийн нийтлэг арга барилыг бий болгож, хэрэгжүүлэх бодлого, практикийг уялдуулах шаардлагатай бөгөөд ингэснээр олон улсын бүх жуулчид яс үндэс, эх орон, очих газар, арьс, өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрөлт эсвэл бусад байдал, болон аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчийн харьяа улс орон зэргээс үл хамааран тэгш эрхтэйгээр зохих хамгаалалтыг хүртэх болно.

2. Тэнцвэр:

Хүсэж буй болон хүрч болохуйц үр дүнгийн хоорондох шударга, тэгш тэнцвэрийг олох хэрэгцээ шаардлага байна. Онц байдлын өмнө, онц байдлын үед болон онц байдлын дараа бий болж буй үүрэг хариуцлагын хуваарилалтад аялал жуулчлалын бүх оролцогч талууд болох олон улсын жуулчид өөрсдөө, жуулчны үндсэн харьяаллын улс мөн хүлээн авагч улс зэргийн байр суурь, боломжит чадавхыг онцгой анхаарах ёстой ба эмзэг бүлгийн жуулчдын онцлог хэрэгцээ зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

3. Хамтын ажиллагаа ба зохицуулалт:

Онц байдлын үед олон улсын жуулчдад туслах зорилгоор олон улсын хамтын ажиллагаа, зохицуулалтыг үндэсний болон олон улсын түвшинд, түүнчлэн улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллагууд хоорондын олон улсын хамтын ажиллагаа, зохицуулалтыг сайжруулах, бэхжүүлэх шаардлагатай байна.

4. Хариуцлага:

i. Төрийн эрх бүхий байгууллага болон аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдийн үүрэг бол онц байдлын үед олон улсын жуулчдад тусламж үзүүлэх юм. Үүнд жуулчдад хялбар хүртээмжтэй, цаг тухайд нь, бодитой, үнэн зөв, хамааралтай мэдээллийг ойлгомжтой, ил тод, бүрэн байдлаар хүргэх мөн түүнчлэн аюулгүй байдал, аюулгүй байдлын арга хэмжээ, ослоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдал зэргээр хангах нь уг агуулгад багтах бөгөөд зөвхөн дараах зүйлсээр хязгаарлагдахгүй. Мэдээллийн агуулга, арга хэлбэрийг хүлээн авагч орны эрх баригчидтай зөвшилцсөний үндсэн дээр хувь хүний нууцыг хүндэтгэж, хувийн мэдээллийг хамгаалах болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хүргэх ёстой. Ийм мэдээлэл нь нөхцөл байдлын хүнд байдалтай хатуу пропорционал байх ёстой бөгөөд онц байдал үүссэн газарзүйн бүс нутагт мэдээллийн зарим зүйлс хязгаарлагдах нь байдаг.

ii. Олон улсын жуулчид зочлохоор бэлдэж буй улс орныхоо онцлогтой танилцах эсвэл аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн мэдээллийг дагаж мөрдөх үүрэгтэй. Олон улсын жуулчид өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа гадуур аялал хийхдээ эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн талаар аль болох мэдээлэлтэй байж, хямралын үед төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон эрүүл мэнд, аюулгүй байдлын протоколуудыг дагаж мөрдөх, аялал жуулчлалын зохих даатгалд хамрагдах замаар эдгээр эрсдэлийг багасгах тал дээр арга хэмжээ авах хэрэгтэй.

5. Хүртээмжтэй байдал:

Эмзэг бүлгийн жуулчид бусад хүмүүстэй адил тэгш эрхтэйгээр, ямар ч ялгаварлалгүйгээр аялах эрхтэй. Зарим тусгай хэрэгцээтэй жуулчид онц байдлын үед бусдаас сул дорой эсвэл илүү эмзэг байж болзошгүй тул төрийн эрх баригчид болон аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдээс нэмэлт баталгаа авахыг эрэлхийлэх төлөвтэй байдаг. Онц байдлын үед тэдгээр хүмүүсийг нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын арга хэмжээ, аяллын шинэчлэлт, шийдвэр гаргалт, үндсэн үйлчилгээний хүртээмж, хүртээмжийн талаарх мэдээлэл зэргээс орхигдуулж болохгүй. Тэдний нөхцөл байдлын талаарх мэдээлэл, харилцаа холбоо хүртээмжтэй бус байвал энэ нь тэднийг нэмэлт эрсдэлд оруулж болзошгүй юм. Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч болон орон нутгийн удирдлагууд олон улсын жуулчдын аюулгүй байдлыг зохих ёсоор харгалзан үзсэний үндсэн дээр аливаа саад тотгорыг арилгах хэрэгтэй.

6. Тодорхой, баттай байдал

Олон улсын жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчид өөрсдийн эрх, тэднээс юу хүлээгдэж байгаа болохыг тодорхой мэдэж, тухайн шаардлагыг биелүүлэх хангалттай цаг хугацаатай байх шаардлагатай.

7. Эрсдэлд чиглэсэн хандлага:

Эрсдэлд чиглэсэн зохицуулалтын арга барилтай байх, тодорхой байх хэрэгцээ болон маш сайн тодорхойлсон зорилтуудтай байж тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, пропорционал байх зарчмуудыг хүндэтгэн үзсэний дүнд онц байдлын үед шууд хариу үйлдэл үзүүлэх.

II ХЭСЭГ

ЗӨВЛӨМЖ

Гишүүн улсууд I хэсэгт заасан зарчмуудын дагуу дараах шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой.

A. Урьдчилан сэргийлэх

1. Онцгой байдлын үед шуурхай арга хэмжээг хөнгөвчлөх зорилгоор хямралын эсрэг байнгын, мэргэжлийн, үр ашигтай, үр дүнтэй үйлчилгээг бий болгох;
2. Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч, дипломат консулын алба болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага зэрэг нь олон улсын жуулчдын тодорхой нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг харгалзан зохион байгуулах механизмыг багтаасан онц байдлын тусгай хөтөлбөр, онцгой байдлын төлөвлөгөө, протоколыг бий болгох;
3. Энэ хэсгийн 2 дахь хэсэгт дурдсан онц байдлын төлөвлөгөө, протоколыг хэрэгжүүлэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, зохицуулах үүрэгтэй болон онц байдлын үед олон улсын жуулчдад тусламж үзүүлэх орон нутгийн мөн үндэсний түвшинд зохих эрх бүхий байгууллага, байгууллагыг томилох, аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчид, дипломат консулын алба болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага, олон улсын жуулчдад зориулсан холбоо барих, мэдээллийн төвийг бий болгох;
4. Онц байдлын үед олон улсын жуулчдад, ялангуяа эмзэг бүлгийн жуулчдад үзүүлэх тусламжийн талаар аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдэд чиглэсэн мэдээлэл, сургалт, харилцааны материалыг тогтмол боловсруулж, шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ. Ийм мэдээлэл, харилцааны материалыг аль болох олон хэл дээр өөр формат болон бусад хүртээмжтэй биет болон цахим хэрэглүүр (жишээлбэл, Брайл хадмал, видео гэх мэт) ашиглан, уншихад хялбар, ойлгомжтой хэлээр гаргах ёстой. Ингэснээр олон улсын жуулчдад зохих зааварчилгааг хүлээн авах, тэдгээрийг зөв ойлгох боломжийг олгох юм;
5. Онц байдлын үед олон улсын жуулчдыг нийтээр нь хамруулах зорилгоор жуулчдын гэрээний дагуу хүртээмжтэй, шударга аяллын даатгалын тогтолцоо болон баталгааны системүүдийг хөгжүүлэх, ашиглахыг дэмжих хэрэгтэй ба үүнд цар тахлын үеийн жуулчны тасалбарын зардал болон цуцлалтын хураамж, эмчилгээ, хорио цээрийн дэглэм, эх оронд нь буцаах зэрэг тусламжийн зардлууд багтах ба зөвхөн дараах зүйлсээр хязгаарлагдахгүй.
6. Онц байдлын үед тухайн нутаг дэвсгэрт нь санхүүгийн хүндрэлтэй байгаа аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх санхүүгийн схемийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх; болон;
7. Онц байдлын үед аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч нь олон улсын жуулчидтай харилцахдаа захиргааны ачааллыг аль болох багасгах, журмыг хялбарчлах талаар зохих арга хэмжээ авах;

B. Мэдээлэл

1. Улс орон бүрийн харилцаа холбооны хэрэгслийг харгалзан хамгийн сүүлийн үеийн мэдээллээр хангах. Уг мэдээлэлд хилийн шугам, аяллын цэг хүрэх эсвэл тэндээс хөдлөх боломжит тээврийн хэрэгсэл, зорчих хязгаарлалт, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал, аюулгүй байдлын арга хэмжээ, түүнчлэн олон улсын жуулчдад зориулсан бусад бодит мэдээлэл багтах ба дараах зүйлсээр үл хязгаарлагдана. Дээрх мэдээллүүдийг эрх бүхий байгууллагаар дамжуулан албан ёсны вэбсайт болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслийн платформ дээр

аль болох олон хэлээр хүргэх ёстой. Цаашлаад дараах мэдээллүүд нь аялал жуулчлал, тээвэрлэлтийн мэргэжилтнүүд, хэрэглэгчийн агентлагууд, үндсэн тээврийн үйлчилгээ үзүүлэгч болон нийгмийн эрүүл мэндийн дэд бүтцээр дамжуулан хүргэгдэнэ;

2. Олон улсын жуулчдад онц байдлын нөхцөл байдалд хүргэж болзошгүй эрсдэлээс сэрэмжлүүлэх зорилгоор бүрэн ажиллагаатай хил дамнасан, сайн дурын үндсэн дээр зөвшөөрөгдсөн, харилцан ажиллах боломжтой холбоо барих программуудыг хувийн мэдээллийг хамгаалах болон холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглахыг дэмжих;
3. Онц байдлын талаар мэдээлэл түгээхдээ "Аялал жуулчлалын талаарх зөвлөгөө, арга хэмжээний мэдээлэлд газарзүйн тэмдэглэгээ, огноо, цагийг ашиглах зөвлөмж"-ийн дагуу хүргэх;

С. Тусламж

Хүлээн авагч орны хувьд:

1. Зохицуулсан систем, журам, зохицуулалтаар дамжуулан аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох хууль тогтоомжоор тогтоосон хязгаарын хүрээнд, зайлсхийх боломжгүй, онц нөхцөл байдлын үеийн олон улсын жуулчдад хугацаа алдалгүй зохих тусалцаа үзүүлэх, тусламжаар хангах боломжтой эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх тусламжид
 - i. Аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээ, орон нутгийн засаг захиргааны болон консулын тусламжийн талаар боломжит мэдээллээр хангах;
 - ii. Шаардлагатай бол олон улсын жуулчдад зайны харилцаа тогтооход нь туслах болон тэдэнд өөр зохицуулалтыг олоход туслах;
 - iii. Олон улсын жуулчдыг гэрээгээр тохиролцсоны дагуу буцаах боломжгүй тохиолдолд шаардлагатай хоол, унд, байр хүртэл тээвэрлэх зардлыг гаргаж, хэд хэдэн хоногийн байрыг хүлээн авагч улс хариуцах бөгөөд холбогдох журмын дагуу нөхөн төлбөр нэхэмжлэхэд хохирол учруулахгүйгээр нэхэмжлэлийг барагдуулах;
 - iv. Олон улсын жуулчдын эрх зүйн байдал болон эдлэх эрхийг тодорхой болгоход нь туслах үүднээс жуулчдыг хэрэглэгчийн агентлагууд, хүлээн авагч улсад байгаа эрх баригчидтай холбоо тогтооход нь туслах;
2. Байрны үйлчилгээ үзүүлэгчдэд урьдчилсан байдлаар шаардлагатай мэдээлэл, харилцаа холбооны сувгаар дамжуулан зохих ёсоор хүргэсэн эсэхийг баталгаажуулж, зайлсхийх боломжгүй болон онц нөхцөл байдлын үед хүлээн авагч улсын холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, дараах мэдээллийг боломжоороо хангана;
 - i. "Хувийн мэдээллийг хамгаалах" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд олон улсын жуулчдын биеийн байдал, эрүүл мэндийн байдал, байршлын талаарх боломжит мэдээлэл;
 - ii. Онц нөхцөл байдал нь үйлчилгээ үзүүлэгчээс орон сууцны үйлчилгээ үзүүлэхэд хэрхэн нөлөөлж байгаа тухай мэдээлэл;
 - iii. Тусламж хэрхэн үзүүлэх боломжтой талаарх мэдээлэл;
 - iv. Олон улсын жуулчдын эрүүл мэнд, сайн сайхан байдлын талаарх боломжит мэдээлэл;
 - v. Олон улсын жуулчидтай хэрхэн холбогдож болох талаар болон тэднийг яаж аливаа хүндрэл, онц байдал, аюулаас холдуулан, нутаг буцаах зэрэг мэдээлэл;

3. Зайлсхийх боломжгүй, онцгой нөхцөл байдал, онц байдлын үед байрны үйлчилгээ үзүүлэгч нь ёс зүйтэй байж, олон улсын жуулчдын нэмж хоноглох өрөөний үнийг нэмэгдүүлэхгүй байхын баталгаажуулах;
4. Зайлсхийх боломжгүй, онцгой нөхцөл байдал, онц байдлын үед олон улсын жуулчид өөрсдийн байрлаж буй газарт очих боломжгүй байдалд хүрсэн эсвэл орон сууцны үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болж, цуцлалтын төлбөрийг төлөхгүй байгаа эсэхийг баталгаажуулах;
5. Онцгой байдлын үед аврах үйлчилгээ, харилцаа холбооны үйлчилгээ, түр хамгаалах байр, шаардлагатай хоол хүнс, виз болон бусад зохих зөвшөөрөл, тээвэрлэлт, үндсэн эм, эмнэлгийн яаралтай тусламжийг аль болох хангана.
6. Онцгой байдлын үед хүлээн авагч улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүйгээр бусад улсын иргэдэд захиргааны санкц/шийтгэл, торгууль ногдуулахаас татгалзах. Үүнийг аялал жуулчлалын хязгаарлалтын улмаас зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн, нутаг дэвсгэрээсээ гарч чадахгүй байгаа жуулчинд хамааруулан ойлгоно. Ийм онц байдлын улмаас саатсан нэмэлт хугацааг жуулчны дараагийн визний мэдүүлэг боловсруулалтад тооцох ёсгүй.
7. Онцгой байдлын үед, олон улсын жуулчны амь нас, эрүүл мэнд, хувийн бүрэн бүтэн байдал шууд аюулд өртөх үед зохицуулалттай нүүлгэн шилжүүлэх, онцгой байдлын болон аюулгүй байдлын ажилтнуудаар хангах, эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг шаардлагатай нэмэлт үйл ажиллагааны арга хэмжээг боломжит байдлаар хэрэгжүүлэх.

Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд:

8. Зайлсхийх боломжгүй, онцгой нөхцөл байдал, онц байдлын үед хүлээн авагч улсын эрх баригчидтай нэн даруй холбоо тогтоох хэрэгтэй бөгөөд тэдгээр нь ч мөн олон улсын жуулчдад үзүүлэх тусламжийг зохих ёсоор зохицуулахын тулд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчид, тэдгээрийн орон нутгийн төлөөлөгчид эсвэл орон нутгийн агентлагуудтай шууд, тодорхой харилцааны сувгийг идэвхжүүлэх ёстой.

D. Эх оронд нь буцаах

Хүлээн авагч болон үндсэн харьяаллын улсын хувьд:

1. Дараах мэдээллийг холбогдох дипломат болон консулын эрх бүхий байгууллагад аль болох боломжийн хугацаанд дамжуулах;
 - i. Онц байдлын ерөнхий нөхцөл байдал;
 - ii. Онц байдалд өртсөн газарзүйн бүсүүд;
 - iii. Онц байдалд өртсөн бүс нутагт дахь олон улсын жуулчдын тоо, харьяалал бүхий улс орнуудын байдал;
 - iv. Олон улсын жуулчдад тусламж үзүүлэхэд шаардагдах хувийн мэдээлэл;
 - v. Олон улсын жуулчдын эрүүл мэндийн байдал, байршлын болон ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл;
 - vi. Хохирогчдын мэдээлэл;
 - vii. Хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээ болон;
 - viii. Шаардлагатай бол хувийн мэдээллийг хамгаалах болон холбогдох бусад ууль тогтоомжийн дагуух бусад мэдээлэл;
2. Олон улсын жуулчдыг дамжин өнгөрөх, эх оронд нь буцаах зэрэг шаардлагатай үйл ажиллагааны арга хэмжээг хөнгөвчлөхөд гуравдагч орнуудтай сайн санааны хүрээнд хамтран ажиллана.

Хүлээн авагч орны хувьд:

3. Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчтэй хийсэн эсвэл аялал жуулчлалын даатгалд тусгагдсан жуулчны гэрээ байсан ч холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр нэхэмжлэхэд хохирол учруулахгүйгээр тухайн улсын иргэдийн нэгэн адил олон улсын жуулчдыг эх оронд нь буцаах талаар шаардлагатай арга хэмжээ авах;
4. Зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс хэтрүүлэн оршин суусан болон хилээр дамжин гарах журам гэх зэрэг визний шаардлага эсвэл бусад зохих зөвшөөрөл дээр зааварчилгаа өгөх.
5. Онцгой байдлын үед тухайн жуулчдын эх орноос илгээсэн аливаа албан тушаалтан, эмнэлгийн болон техникийн ажилтнууд, тэдгээрийн тоног төхөөрөмжийг шаардлагатай тохиолдолд өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, оршин суух, нүүлгэн шилжүүлэхэд шуурхай туслалцаа үзүүлэн, уг үйл ажиллагааг хөнгөвчлөхийн тулд чадах бүхнээ хийх. Ийм тусламж нь олон улсын жуулчдад хэрэгтэй байгаа тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах зүйлд түр зуурын виз эсвэл ажиллах зөвшөөрөл олгох, нэвтрэх шаардлагыг хөнгөвчлөх гэх мэт урьдчилсан зөвшөөрлийг аль болох хурдан олгох зэрэг багтана. Энэхүү үйл явц нь уг үйл ажиллагааг газар нутаг дээрээ зохион явуулж буй улсын үндэсний хууль тогтоомж, практик дээр суурилна.

Жуулчны үндсэн харьяаллын улсын хувьд:

6. Олон улсын жуулчдыг эх оронд нь буцаах зэрэг шаардлагатай үйл ажиллагаануудыг хөнгөвчлөх чиглэлээр хамтран ажиллана;
7. Өөрийн орны иргэд болон тэдний гэр бүлийн гишүүдийг хүлээн авагч улс эсвэл гуравдагч орноос эх орондоо буцаж ирэхэд нь дэмжлэг үзүүлж, шаардлагатай бол цааш дамжин өнгөрөх нотлох баримтыг бүрдүүлж өгнө. Түүнчлэн оршин суух зөвшөөрөлтэй гуравдагч орны иргэд болон харьяалагдах улсдаа буцаж байгаа тэдний асран хамгаалагчид уг ойлголтод хамаарна.

Гуравдагч орнуудын хувьд:

8. Хувийн мэдээллийг хамгаалах болон холбогдох хууль тогтоомжийн дагуу орон нутгийн аюулгүй байдал, аюулгүй байдлын арга хэмжээ, орон нутгийн засаг захиргаа, консулын тусламж, түүнчлэн олон улсын жуулчдын биеийн байдал, эрүүл мэндийн байдал, байршлын талаарх мэдээлэл зэргийг хүлээн авагч орон болон жуулчдын үндсэн харьяаллын улсад аль болох хурдан мэдэгдэх;
9. Олон улсын жуулчдыг цааш хүргэх, эх оронд нь буцаах зэрэг шаардлагатай үйл ажиллагааг хөнгөвчлөхөд сайн санааны үүднээс хамтран ажиллах; болон
10. Олон улсын жуулчдын эх орноос илгээсэн аливаа албан тушаалтан, эмнэлгийн болон техникийн ажилтнууд, тоног төхөөрөмжийг нутаг дэвсгэрийнхээ хүрээнд дамжин өнгөрөх, тээвэрлэхэд шуурхай туслалцаа үзүүлж, уг ажлыг хөнгөвчлөхийн тулд нөөц бололцоогоо дайчлан хамтран ажиллах.

**БАЙГАЛИЙН ХИЙ, МЕТАН ХИЙ ХАЙХ, ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОН
УЛСЫН ТУРШЛАГА: ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН БА СТАНДАРТ**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Г.Алтан-Оч (Ph.D.),
С.Золжаргал, Б.Баянмөнх, Б.Батцэцэг*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

Нэг. БАЙГАЛИЙН ХИЙ, МЕТАН ХИЙ ОЛБОРЛОДОГ УЛС ОРНУУД

1.1 Олон улсын байгууллага

1.2 Дэлхийн метан хийн ялгаруулалт

Хоёр. БАЙГАЛИЙН ХИЙ ХАЙХ, ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН
ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙЛСАН ШААРДЛАГА, СТАНДАРТ

2.1 Байгалийн хийн химийн бүтэц ба геологийн тархац

2.2 Байгалийн хийн гэрээний эрх зүй

2.3 Хайгуул

2.4 Олборлолт

2.5 Стандарт ба баталгаажуулах байгууллага

2.6 Эрх зүйн зохицуулалтын чиг хандлага

Гурав. БАЙГАЛИЙН ХИЙ, МЕТАН ХИЙ ХАЙХ, ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮН
БА БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

3.1 Байгалийн хий

3.2 Байгалийн хий олборлолт

3.3 Өрөмдлөг, олборлолтын нөлөө

3.4 Байгалийн хий, метаныг хайх болон олборлох

Дөрөв. БАЙГАЛИЙН ХИЙ ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ СӨРӨГ НӨЛӨӨ

4.1 Байгалийн хийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

УДИРТГАЛ

“Байгалийн хий, метан хий хайх, олборлох үйл ажиллагааны олон улсын туршлага: зохицуулалтын орчин ба стандарт” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэлээ.

Судалгааны хамрах хүрээ: Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу сэдвийн хүрээнд дараах асуудлуудыг хамруулан судаллаа. Үүнд:

- газрын хий, метан хий олборлодог улс орнуудын талаарх мэдээлэл лавлагаа;
- улс орнуудын газрын хий, метан хий хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин, хуулиар тусгайлан стандарт, шаардлага тогтоосон эсэх мэдээлэл;
- газрын хий, метан хий хайх, олборлох үйл ажиллагааны хүн ба байгаль орчинд үзүүлэх нөлөө;
- газрын хий, метан хий олборлох үйл ажиллагааны эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөө.

Түлхүүр үг: *Байгалийн хий, метан хий, байгалийн хий олборлох, метан хий үйлдвэрлэх*

Keywords: *Natural gas, methane gas, natural gas extraction, methane gas extraction*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Байгалийн хийн зонхилох хувийг метан (70-90%) бүрдүүлэх ба этан, пропан, бутан багавтар хэмжээтэй (0-20%), нүүрстөрөгчийн давхар исэл (0-8%), азот (0-5%), хүхэрлэг устөрөгч (0-5%) өчүүхэн хэмжээтэй байдаг бол гели, аргон, неон, ксенон маш бага хэмжээтэй тус тус агуулагдаж байдаг байна.

Байгалийн хийг ихэвчлэн газрын гадаргад хэрхэн байрласан байдлаар нь ангилдаг. *Ердийн* байгалийн хий нь томоохон хагарал болон чулуулаг давхраа хоорондын орон зайд байрладаг. Тэгвэл *ердийн бус* байгалийн хий нь занар, хайрга (элсэрхэг чулуу) буюу бусад төрлийн тунамал чулуулаг бүрэлдэх явцад үүссэн нүх сүвэнд агуулагддаг байна. Тиймээс ч занарын хий буюу нягт хий гэж нэрлэдэг. Түүнчлэн, *нөхцөлдсөн* байгалийн хий нь газрын тосны ордод хамт байдаг байна. Нүүрсний давхаргын метан нь нүүрсний ордод байдаг бас нэгэн төрлийн байгалийн хий юм.

Байгалийн хий нь чулуужсан түлштэй харьцуулахад байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бохирдол харьцангуй багатай байна. Байгалийн хийг шатаах явцад газрын тос, нүүрснээс хамаагүй бага хүлэмжийн хий ялгаруулдаг. Гэхдээ энэ нь байгаль орчинд ээлтэй гэсэн ойлголт биш бөгөөд сөрөг нөлөө ч байдаг.

Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэр нь орчин үеийн эдийн засагт хамгийн өндөр цэвэр ашиг авчирдаг, үнэ цэн бүхий салбар юм. Энэ салбар нь ажлын байрны аюулгүй байдал, хөрөнгийн удирдлага, байгууламжийн тордолт (техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ) болон хүрээлэн буй орчин, хууль эрх зүйн зохицуулалт гэх мэт хоорондын олон сорилттой тулгарч байна.

ISO стандартуудыг дагаж мөрдөх нь газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн үйл ажиллагааг ашиг орлоготой байх, үр ашигтай байх нөхцөлийг бүрдүүлж байдаг байна. Газрын тос ба байгалийн хийн салбар дахь баталгаажуулах байгууллагын цогц аудитын үйлчилгээ нь тухайн салбарт мөрдөх стандарт нөхцөлийг бүрдүүлэх, хангуулахад чухал үр нөлөөтэй.

Газрын тос, байгалийн хийн хууль, эрх зүйн зохицуулалтын онцлогыг бүхэлд нь авч үзвэл, тухайн улс орны уул уурхайн салбар, тэр дундаа байгалийн хийн салбарын хөгжлийн түүхэн үйл явц, уламжлалт зохицуулалт болон хамаарал бүхий хууль тогтоомжуудын онцлогоос шалтгаалан зохицуулалтын горим нь өргөн хүрээг хамарсан нарийвчилсан зохицуулалттай, эсхүл товчхон ерөнхий хуультай боловч хэрэгжүүлэх хүрээнд дагалдан гарсан төрөл бүрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актаар журамласан байх 2 янзын чиг хандлага ажиглагдаж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд эрчим хүчний компаниуд нь засгийн газраас олгож буй ашигт малтмалын эрхийн төлөө ямагт өрсөлдөж байдаг бөгөөд ингэхдээ концессын гэрээ буюу бүтээгдэхүүн хуваах гэрээний аль нэгийг сонгодог байна. Концессын гэрээ байгуулсан тохиолдолд, хайж олсон газрын тос болон байгалийн хий нь үйлдвэрлэгчийн өмч болдог байна. Харин бүтээгдэхүүн хуваах гэрээний тухайд, засгийн газар нь өмчийн эзнээр үлдэж, оролцооны хувь хүртдэг байна.

Газрын тос ба байгалийн хийн хайгуул, олборлолт явуулахдаа тухайн орон нутаг хийгээд бүс нутгийн байгаль орчин, нийгмийн бусад асуудлууд, оршин суугчид болон олон нийтэд үзүүлж болзошгүй сөрөг үр дагавар, нөлөөллүүдийг урьдчилан тооцсон байх шаардлагатай. Тухайлбал, ОХУ-ын хууль тогтоомжоор энэ асуудлыг нарийвчлан зохицуулсан байна. Энэ асуудал ялангуяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд холбооны улсын хэлбэртэй улс орнуудын хувьд чухал байдаг нь судалгаанаас харагдаж байна. Учир нь холбооны улсын хувьд газрын тос, байгалийн хийн нөөцийн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон асуудлыг тухайн муж улс, эсхүл орон нутгийн засаг захиргааны эрхийн хүрээнд шийдвэрлэн зохицуулах зарчим үйлчилдэг байна.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ) занарын хийг гаргаж авсанаар эрчим хүчний салбарын түүхэнд хамгийн том ололт амжилт олж, байгалийн хий импортлогч орноос дэлхийн тэргүүлэх үйлдвэрлэгч орон болон дэвшиж, улмаар экспортын хэмжээгээ эрчимтэй нэмэгдүүлсээр байна. АНУ-ын хувьд байгалийн хийн асар их нөөцтэй бөгөөд дор хаяж 60 ба түүнээс дээш жил ашиглах байгалийн хийн нөөцтэй гэсэн тооцоо байдаг байна. Тус улс нь байгалийн хийн олборлолтоос гадна Канад, Мексикээс байгалийн хийг хоолойгоор импортолдог.

Орос Улс нь дэлхийн хамгийн их байгалийн хийн нөөцтэй улс бөгөөд бусад улсаас илүү байгалийн хийг экспортолдог байна. Мөн автомашины хэрэглээний хийг дэмждэг улсын нэг бөгөөд зарим тээврийн хэрэгслийг байгалийн хийгээр цэнэглэх зорилгоор үйлдвэрлэдэг байна.

Нөөцийн хувьд Орос Улсын дараа хоёрт ордог Иран нь байгалийн хийн багахан хэсгийг ашиглаж байгаа бөгөөд ирээдүйд их хэмжээний хийг нийлүүлэх боломжтой цөөн тооны орнуудын нэг болно хэмээн үздэг.

Хятад улс нь байгалийн хийн олборлолтоор дэлхийд дөрөвдүгээр байрт жагсаж байна. Сүүлийн жилүүдэд Хятад улсын засгийн газар агаарын бохирдлыг бууруулж, утааг бууруулах зорилтот түвшиндээ хүрэхийн тулд эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор нүүрснээс байгалийн хий рүү шилжих ажлыг эрчимжүүлсэн. Сүүлийн 10 жилийн хугацаанд Хятад улсад байгалийн хийн олборлолт бараг хоёр дахин нэмэгдсэн ч Хятад улс хэрэгцээнийхээ тал орчим хувийг импортоор хангадаг хэвээр байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү)

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

Нэг. БАЙГАЛИЙН ХИЙ, МЕТАН ХИЙ ОЛБОРЛОДОГ УЛС ОРНУУД

Байгалийн хий нь дэлхийн гадаргын доор үүсдэг байгалийн гаралтай нүүрсустөрөгчийн хий ба нөхөн сэргээгдэхгүй чулуужсан түлш юм. Байгалийн хийг халаалт, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглахаас гадна автомашины түлш болон хуванцар үйлдвэрлэхэд ч ашиглана. Байгалийн хий нь түүхий нефтийн ордуудтай зэрэгцэн үүсэх ба нүүрсний давхаргын метан нь нүүрсний ордуудад байдаг байгалийн хийн өөрчлөлт юм.

Дэлхийд одоогоор Орос улс нь хамгийн их байгалийн хийн нөөцтэй бөгөөд бусад улсаас илүү байгалийн хийг экспортолдог. Мөн автомашины хэрэглээний хийг дэмждэг улсын нэг бөгөөд зарим тээврийн хэрэгслийг байгалийн хийгээр цэнэглэх зорилгоор үйлдвэрлэдэг байна.

Иран нь байгалийн хийн нөөцөөр Орос улсын дараа хоёрт ордог. Одоогоор нөөцийнхөө багахан хэсгийг ашиглаж байгаа нь ирээдүйд их хэмжээний байгалийн хийг нийлүүлэх боломжтой цөөхөн орны нэг болно хэмээн үздэг байна.

Катар нь дэлхийн байгалийн нөөцийн 13 гаруй хувийг эзэмшдэг. Тус улсын нөөцийн ихэнх хэсэг нь далайн эрэг дээрх хойд хэсэгтээ байдаг. Байгалийн хийн экспортоо өргөжүүлж, шингэрүүлсэн хийн дэлхийн тэргүүлэгч экспортлогчийн байр сууриа сэргээхийн тулд хойд хэсгийнхээ өрөмдлөгийн өргөтгөлөө хийж эхэлсэн байна.

АНУ-ын хувьд байгалийн хийн асар их нөөцтэй бөгөөд хамгийн том нь Техас, Оклахама, Луйзиана мужуудад байдаг. АНУ дор хаяж 60 ба түүнээс дээш жил ашиглах байгалийн хийн нөөцтэй гэсэн тооцоо байдаг байна. Тус улс нь байгалийн хийн олборлолтоос гадна Канад, Мексикээс байгалийн хийг хоолойгоор импортолдог.

Саудын Араб нь байгалийн хийн нөөцөөрөө дэлхийд тавдугаарт ордог ба ихэнх нь Персийн буланд байрладаг. Дэлхийн хамгийн том түүхий нефтийн экспортлогчийн хувьд Саудын Араб нь байгалийн хийг экспортлох болон, газрын тосоор ажилладаг эрчим хүчнийхээ 70 хувийг байгалийн хий, 30 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гаргахаар төлөвлөж байна.²²⁰

Хүснэгт 1. Байгалийн хий олборлодог улс орнууд (2023 он)

Зэрэглэл	Улс	2020 оны үйлдвэрлэл (тэрбум куб метр)	2020 оны хэрэглээ (тэрбум куб метр)
75	Шинэ Зеланд		4.60
74	Финланд		2
73	Сингапур		12.60
72	Хонг Конг		4.90
71	Швейцар		3.20
70	Австри		8.50
69	Израиль		11.30
68	Беларусь		17.90
67	Унгар		10.20
66	Португал		6
65	Папуа Шинэ Гвиней		
64	Грек		5.70

²²⁰ Байгалийн хий улсаар <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>

63	Чех		8.50
62	Швед		1.10
61	Бельги		17
60	Эквадор		0.50
59	Чили		6.10
58	Тайвань		24.90
57	Марокко		0.80
56	Испани		32.40
55	Өмнөд Солонгос		56.60
54	Өмнөд Африк		4.10
53	Франц		40.70
52	Турк		46.40
51	Филиппин		3.80
50	Япон		104.40
49	Йемен	0.10	
48	Дани	1.40	
47	Сири	3	
46	Польш	3.90	21.60
45	Итали	3.90	67.70
44	Герман	4.50	86.50
43	Румын	8.70	11.30
42	Вьетнам	8.70	8.70
41	Ирак	10.50	20.80
40	Перу	12.10	7.10
39	Бруней	12.60	
38	Ливи	13.30	
37	Колумби	13.30	13.90
36	Болив	14.40	
35	Кувейт	15	20.60
34	Бахрейн	16.40	
33	Мьянмар	17.70	
32	Венесуэл	18.80	18.80
31	Украин	19	29.30
30	Нидерланд	20	36.60
29	Энэтхэг	23.80	59.60
28	Бразил	23.90	32.10
27	Бангладеш	24.70	30.40
26	Азербайжан	25.80	11.90
25	Тринидад Тобаго	29.50	15.10
24	Мексик	30.10	86.30
23	Пакистан	30.60	41.20
22	Казакстан	31.70	16.60
21	Тайланд	32.70	46.90
20	Оман	36.90	25.90
19	Аргентин	38.30	43.90
18	Их Британи	39.50	72.50
17	Узбекистан	47.10	43
16	Нигери	49.40	
15	Арабын нэгдсэн Эмират улс	55.40	69.60
14	Египет	58.50	57.80

13	Туркменистан	59	31.30
12	Индонез	63.20	41.50
11	Малайз	73.20	38.20
10	Алжир	81.50	43.10
9	Норвег	111.50	4.40
8	Саудын Араб	112.10	112.10
7	Австрали	142.50	40.90
6	Канад	171.30	112.60
5	Катар	171.30	35
4	Хятад	194	330.60
3	Иран	250.80	233.10
2	Орос	638.50	411.10
1	АНУ	914.60	832

Эх сурвалж: <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>

1.1 Олон улсын байгууллага

ОПЕК²²¹ (Organization of the Petroleum Exporting Countries (OPEC)) буюу нефть экспортлогч орнуудын байгууллага нь 1960 оны 09 сард Исламын Бүгд Найрамдах Иран, Ирак, Кувейт, Саудын Араб, Венесуэл зэрэг таван орон гэрээ байгуулснаар Иракийн нийслэл Багдад хотод байгуулагдсан. Тус байгууллагын эрхэм зорилго нь газрын тос үйлдвэрлэгчдийн шударга, тогтвортой үнийг баримтлахын тулд гишүүн орнуудын газрын тосны бодлогыг зах зээлийн эдийн засагтай уялдуулж, нэгтгэх явдал бөгөөд, хэрэглэгч улс орнуудад үр ашигтай, хэмнэлттэй тогтмол эрэлт нийлүүлэлттэй байдлыг тогтворжуулах, уг салбарт хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй, шударгаар татах юм. ОПЕК-ийг байгуулсан нь газрын тос олборлогч орнуудын хамтын ажиллагаа, бусад олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах замаар гишүүн орнуудынхаа нефтийн бодлогыг зохицуулах, газрын тосны зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилттой.

ОПЕК-ийн дүрэмд, Бага хурлын гишүүнээр элсэх өргөдлийг хүлээн авсан улсуудыг үүсгэн байгуулагч болон бүрэн эрхт гишүүн гэж ялгадаг. ОПЕК-ийн Нарийн бичгийн дарга нарын газар буюу гүйцэтгэх байгууллага гэж байх бөгөөд Австри Улсын Вена хотод байрладаг. Тус газар нь бага хурлаас гарсан бүх шийдвэрийн хэрэгжилтийг хариуцаж, Удирдах зөвлөлийн хурлаас гаргасан бүх шийдвэрийг хэрэгжүүлнэ. Мөн судалгааны ажил хийдэг бөгөөд судалгааны үр дүн нь удирдлагын шийдвэрт голлон нөлөөлдөг байна. Нарийн бичгийн дарга нарын газар нь Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий нарийн бичгийн даргын ажлын алба, хуулийн алба, судалгааны алба, туслах үйлчилгээний албаас бүрдэнэ. Судалгааны хэлтэс нь Мэдээллийн үйлчилгээ, Газрын тосны судалгаа, Эрчим хүчний судалгааны хэсгүүдээс бүрдэнэ. Туслах үйлчилгээний хэлтэс нь Олон нийттэй харилцах, мэдээлэл, санхүү, хүний нөөц, мэдээллийн технологийн үйлчилгээнүүдийг гүйцэтгэнэ.

Одоогоор тус байгууллагад 13 гишүүн орон байна.

Хүснэгт 2. Гишүүн орнуудын үзүүлэлт (2021 он)

Улсын нэр	Тив	Гишүүнээр элссэн он сар	Байгалийн хийн батлагдсан нөөц (тэрбум куб.м)	Зах зээлд нийлүүлэгдсэн байгалийн хийн үйлдвэрлэл (сая куб.м)	Байгалийн хийн экспорт (сая куб.м)

²²¹ Organization of the Petroleum Exporting Countries https://www.opec.org/opec_web/en/about_us/25.htm

1	Алжир	Африк	1969.7	4,504	105,043	54,759
2	Ангол	Африк	2007.1	301	8820	5,084
3	Конго	Африк	2018.6	284	415	
4	Эквадор	Өмнөд Америк	1963-93 2017 эргэж элссэн	39	7,047	4,694
5	Габон	Африк	1975-95 2016 эргэж элссэн	26	454	-
6	Иран	Ойрхи Дорнод	1960.9	33,988	257,119	18,425
7	Ирак	Ойрхи Дорнод	1993.9	3,714	9,586	-
8	Кувейт	Ойрхи Дорнод	1960.9	1,784	12,728	-
9	Ливи	Африк	1962.12	1505	24,244	8000
10	Нигери	Африк	1971.7	5,848	48,572	38,464
11	Саудын Араб	Ойрхи Дорнод	1960.9	8507	120,485	-
12	Арабын Нэгдсэн Эмират	Ойрхи Дорнод	1967.11	8200	54,485	7,849
13	Венесуэл	Өмнөд Америк	1960.9	5541	23,720	-

Эх сурвалж: https://www.opec.org/opec_web/en/about_us/25.htm

Дэлхийн метан, эрчим хүчний амлалт (Global Methane Pledge Energy Pathway (GMP))²²²

Дэлхийн дулаарлаас шалтгаалан, дэлхийн эрчим хүчний салбарыг нүүрстөрөгчөөс ангижруулахаас гадна метан хийн ялгаруулалтыг хурдан бууруулах ёстой байна. АНУ, Европын Холбоо болон дэлхийн 100 гаруй улсууд 2030 он гэхэд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй метан хийн ялгаруулалтыг 2020 оны түвшингээс 30-аас доошгүй хувиар бууруулах зорилгоор Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн 26 дахь бага хурал (COP26)²²³-аар Дэлхийн метан, эрчим хүчний амлалтыг (GMP)-г эхлүүлсэн. Египет, Косово, Молдова, Оман, Катар, Сент Люсиа, Тринидад Тобаго, Узбекистан зэрэг орнуудыг нэмснээр дэлхийн метан хийн ялгарлын тал хувь, дэлхийн эдийн засгийн бараг дөрөвний гурвыг төлөөлж буй 120 улс орон тус амлалтад нэгдсэн байна.

Газрын тос, байгалийн хийн салбар дахь метан хийн ялгаруулалтыг бууруулах нь дэлхийн метан амлалтын зорилтод хүрэхэд чухал ач холбогдолтой. 2021 онд дэлхийн хэмжээнд 250 тэрбум метр гаруй байгалийн хийг шатааж алдсан нь дэлхийн гурав дахь том хий үйлдвэрлэгчийн жилийн олборлолтын хэмжээнээс давсан байна. Газрын тос, байгалийн хийн салбарт метан хийн ялгаруулалтыг бууруулах нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авах, дэлхийн хүн амын эрүүл мэндийн хувьд ашиг тустай. Эрчим хүчний арга хэмжээ нь дэлхийн метан хийн амлалтыг хэрэгжүүлэх чухал алхам бөгөөд өнөөдөр байгаа метаны нөлөөллийг бууруулах хамгийн хурдан бөгөөд хамгийн хэмнэлттэй шийдлүүдийг нэвтрүүлэх ажлыг хурдасгахаар байна. Оролцогч

²²² Global Methane Pledge Energy Pathway (GMP) https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP_22_3793
²²³ COP26 <https://www.globalmethanepledge.org/>

орнууд шинэ техник, санхүүгийн эх үүсвэрээр хангах, эсвэл дотоодын төсөл, бодлогын арга хэмжээг сайжруулах замаар дэмжих үүрэг хүлээдэг.

Дэлхийн хий үйлдвэрлэгчид метан хийн ялгарлыг бууруулах, цэвэр, аюулгүй хийгээр хангах чиглэлээр төсөл боловсруулж, бодлогоо бэхжүүлэх томоохон шинэ амлалтуудыг өгсөн. Үүнд:

- **Мексик** нь АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн техникийн дэмжлэгтэйгээр 2024 он гэхэд хийн хайгуул, олборлолт, боловсруулалтын үйл явцад бусад улс орнуудтай нэгдэж газрын тос, байгалийн хийн салбар дахь шатаах болон метан хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө боловсруулна.
- **Аргентин** нь 2030 он хүртэл Уур амьсгалын эсрэг үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөгөө Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн 27 дахь бага хурал (COP27)²²⁴-д танилцуулах үүрэг хүлээсэн бөгөөд үүнд газрын тос, байгалийн хийн салбараас ялгарах метан хийн ялгаруулалтыг хязгаарлах, гал асаах, агааржуулах зэрэгт хяналтыг чангатгах, сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэх зэрэг тодорхой арга хэмжээ авахыг багтаасан.
- **Нигери** нь газрын тос, байгалийн хийн салбарт метан хийн ялгаруулалтыг зохицуулсан Африкийн анхны улс болсон.
- **Канад улс** 2030 он гэхэд газрын тос, байгалийн хийн метан хийг 2012 оны түвшингээс дор хаяж 75 хувиар бууруулах амлалтад тулгуурлан метан хийн үндэсний стратегийг боловсруулсан.
- **Малайзын** газрын тосны үндэсний компани ПЕТРОНАС нь 2025 он гэхэд метан хийн ялгарлыг 50 хувиар бууруулах зорилтоо зарласан.
- **Египет** нь газрын тос, байгалийн хийн салбарын дэлхийн метаны амлалтад нэгдсэн бөгөөд энэ нь Египетийн метан хийг бууруулах, эрчим хүчийг өргөжүүлэхэд нөөц, дэмжлэг үзүүлэх амлалт юм.
- **Колумби улс** нь газрын тос, байгалийн хийн салбараасаа метан хийн ялгаруулалтыг зохицуулсан Өмнөд Америкийн анхны орон болжээ.
- **Египет, Израил, Европын Холбоо (ЕХ)** нь байгалийн хийн гурван талт хэлэлцээр байгуулж, метан хийн алдагдлыг бууруулах, тухайлбал, агаараас алдагдах, шатаахыг багасгах шинэ технологи, боломжуудыг судлах хүсэлтэй байгаагаа мэдэгдэв.
- **ЕХ болон Японы Засгийн газар** нь газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэл, хэрэглээнээс метан хийн ялгаралтыг бууруулах, үүнд олон улсын зохих хяналт-шинжилгээ стандартыг дэмжихэд хөрөнгө оруулалт хийх замаар дэмжих.
- **АНУ** нь ЕХ-ны Эрчим хүчний зөвлөлөөр дамжуулан нүүрсустөрөгчийг нийлүүлэгчдийн метаны ялгаруулалтын мөчлөгт дүн шинжилгээ хийх, амлалтаа дахин нотолсон.
- **ХБНГУ** нь Дэлхийн банкны хийн түлшний шаталтыг бууруулах түншлэлд оролцохоо тус тус мэдэгдсэн.

Байгалийн хийн олон улсын үзүүлэлт:

Хүснэгт 3. Байгалийн хийн хамгийн том нөөцтэй 10 улс (2020 он)²²⁵

²²⁴ COP27 <https://cop27.eg/#/>

²²⁵ Байгалийн хийн хамгийн том нөөцтэй 10 улс 2020 <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>

	Улсын нэр	2020 оны нөөц (шоо метр)	2020 оны нөөц (куб фут)	Дэлхийн нөөцийн %
1	Орос	37.4 их наяд	1320.5 их наяд	19.9%
2	Иран	32.1 их наяд	1133.6 их наяд	17.1%
3	Катар	24.7 их наяд	871.1 их наяд	13.1%
4	Туркменистан	13.6 их наяд	480.3 их наяд	7.2%
5	АНУ	12.6 их наяд	445.6 их наяд	6.7%
6	Хятад	8.4 их наяд	296.6 их наяд	4.5%
7	Венесуэл	6.3 их наяд	221.1 их наяд	3.3%
8	Саудын Араб	6.0 их наяд	212.6 их наяд	3.2%
9	Арабын нэгдсэн Эмират улс	5.9 их наяд	209.7 их наяд	3.2%
10	Нигери	5.5 их наяд	193.3 их наяд	2.9%

Хамгийн их байгалийн хий олборлодог 10 улс (куб метр, 2021 он)²²⁶

1. АНУ-Үйлдвэрлэл: 934.2 тэрбум: АНУ бол дэлхийн хамгийн том байгалийн хийн үйлдвэрлэгч бөгөөд дэлхийн нийт байгалийн хийн үйлдвэрлэлийн бараг дөрөвний нэгийг бүрдүүлдэг. Тус улс нь байгалийн хийн томоохон үйлдвэрлэгчээс гадна хамгийн том хэрэглэгчид тооцогддог.
2. Орос-Үйлдвэрлэл: 701.7 тэрбум: Дэлхийн хамгийн том байгалийн хийн экспортлогч, үйлдвэрлэгчийн хувьд Орос улс нь манай гараг дээрх хамгийн том байгалийн хийн нөөцийг эзэмшдэг. Тус улсын төрийн өмчит Газпром групп нь дэлхийн байгалийн хийн нөөцийн 16.3 хувийг эзэмшдэг байна.
3. Иран-Үйлдвэрлэл: 256.7 тэрбум: Иран нь дэлхийн нийт байгалийн хийн үйлдвэрлэлийн 6.4 хувийг бүрдүүлдэг гурав дахь том орон юм. Байгалийн хийн нөөцөөрөө хоёрдугаарт ордог. Гэвч дэд бүтцийн хувьд нэлээд хоцрогдмол байна.
4. Хятад-Үйлдвэрлэл: 209.2 тэрбум: Сүүлийн жилүүдэд Хятад улсын засгийн газар агаарын бохирдлыг бууруулж, утааны зорилтот түвшинд хүрэхийн тулд эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор нүүрснээс байгалийн хий рүү шилжих ажлыг эрчимжүүлж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд байгалийн хийн олборлолт бараг хоёр дахин нэмэгдсэн ч Хятад улс хэрэгцээнийхээ тал орчим хувийг импортоор хангадаг хэвээр байна.
5. Катар-Үйлдвэрлэл: 177.0 тэрбум: Катар бол байгалийн хийн тав дахь том үйлдвэрлэгч бөгөөд дэлхийн гурав дахь том батлагдсан байгалийн хийн нөөцтэй.
6. Канад-Үйлдвэрлэл: 172.3 тэрбум: Канад нь байгалийн хийн батлагдсан нөөцтэй бөгөөд Баруун Канадын сав газар нь байгалийн хийн үйлдвэрлэлийн ихэнх эх үүсвэр юм. Ньюфаундленд, Нова Скотиа, Арктикийн бүс, Номхон далайн эрэг орчмын талбайнууд байгалийн хийн ихээхэн нөөцтэй. Канад бол зөвхөн дамжуулах хоолойд тулгуурладаг байгалийн хийн шилдэг экспортлогч бөгөөд АНУ-ын худалдааны цорын ганц түнш юм.
7. Австрали-Үйлдвэрлэл: 147.2 тэрбум: 2009 оноос хойш Австрали улс 100 гаруй тэрбум шоо метр байгалийн хий олборлосон байна. Сүүлийн 10 жилийн

²²⁶ Хамгийн их байгалийн хий олборлодог 10 улс 2021 <https://investingnews.com/top-natural-gas-producers/>

- хугацаанд хэд хэдэн шинэ үйлдвэрлэлийн байгууламжууд ашиглалтад орсноор Австралийн байгалийн хийн экспортын хэмжээ асар хурдацтай өссөн байна.
8. Саудын Араб-Үйлдвэрлэл: 117.3 тэрбум: Байгалийн хийн олборлолтоороо наймдугаарт ордог Саудын Арабын үйлдвэрлэл сүүлийн хэдэн арван жилийн байгалийн хийн үйлдвэрлэлийн хамгийн дээд түвшинг харуулсаар байна. Энэхүү үйлдвэрлэлийн өсөлт нь байгалийн хийн бие даасан цооногуудын бүтээн байгуулалт нэмэгдсэнтэй холбоотой юм. 2021 онд төрийн мэдлийн Saudi Aramco нь Саудын Арабын хамгийн том уламжлалт бус байгалийн хийн орд болох Персийн булангийн ойролцоо орших Жафура ордыг ашиглахаар төлөвлөж буй эрчим хүчний компаниудтай гэрээ байгуулжээ. Одоогийн байдлаар тус улс байгалийн хийн үйлдвэрлэлээ экспортолдоггүй. Гэсэн хэдий ч Саудын Арабын засгийн газар 2030 он гэхэд байгалийн хийн экспортоо эхлүүлэхээр төлөвлөж байна.
 9. Норвег -Үйлдвэрлэл: 114.3 тэрбум: Норвеги бол дэлхийн 9 дэх том байгалийн хий үйлдвэрлэгч, гурав дахь том байгалийн хий экспортлогч орон юм. Норвегийн байгалийн хийн компаниуд хөршүүдийнхээ эрэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн бөгөөд тооцоогоор тус улс 2022 онд 122 тэрбум куб метр байгалийн хий олборлох боломжтой бөгөөд энэ нь түүхэн дээд амжилт болох юм.
 10. Алжир-Үйлдвэрлэл: 100.8 тэрбум: Байгалийн хий олборлодог эхний 10 орны тоонд Алжир орсон байна. 2021 онд тус улсын олборлолт өмнөх оныхоос 24 орчим хувиар нэмэгдэж, анх удаагаа 100 гаруй тэрбум куб метр болсон байна. Алжир нь дэлхийд 5 дахь том экспортын хүчин чадалтай бөгөөд 2021 онд экспорт нь 2020 оныхоос 28 гаруй хувиар өссөн байна. 2021 онд тус улс Европын байгалийн хийн хэрэгцээний 11 орчим хувийг хангасан.

Байгалийн хий хамгийн их хэрэглэдэг 10 улс (куб метр, 2020 он)²²⁷

1. АНУ - 832 тэрбум
2. Орос - 411.1 тэрбум
3. Хятад - 330.6 тэрбум
4. Иран - 233.1 тэрбум
5. Канад - 112.6 тэрбум
6. Саудын Араб - 112.1 тэрбум
7. Япон - 104.4 тэрбум
8. Герман - 86.5 тэрбум
9. Мексик - 86.3 тэрбум
10. Их Британи - 72.5 тэрбум

1.2 Дэлхийн метан хийн ялгаруулалт


Метан хийн ялгаралтыг хурдан бөгөөд тогтвортой бууруулах нь дэлхийн дундаж температурын өсөлтийг хязгаарлахад хүрэх боломжтой бөгөөд зайлшгүй шаардлагатай арга хэмжээ юм. Уур амьсгалын өөрчлөлт нь өнөөдрийн байдлаар агаар мандалд метан хийн агууламж аль ч цаг үеийнхээс хамгийн өндөр байгаа бөгөөд өнөөг хүртэл ажиглагдсан дэлхийн дулаарлын 30 орчим хувьд метан хий нөлөөлсөн байна.

2021 онд дэлхийн эрчим хүчний салбар агаар мандалд 135 сая тонн метаны ялгаруулалтанд нөлөөлсөн гэж тооцоолж байна. Эрчим хүчний салбар нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нийт метаны ялгаруулалтын 40 орчим хувийг эзэлдэг бөгөөд


²²⁷ Байгалийн хий хамгийн их хэрэглэдэг 10 улс <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>

хөдөө аж ахуйн дараа хоёрдугаарт ордог. Эрчим хүчнээс үүдэлтэй 135 сая тонн метаны ялгаралтын 42 сая тонн нь нүүрсний уурхайн метан, 41 сая тонн нь газрын тос, 39 сая тонн нь байгалийн хий олборлох, боловсруулах, тээвэрлэх, 9 сая тонн нь биоэнерги (ихэвчлэн мод боловсруулах үед) бүрэн бус шаталтаас үүдэлтэй байна.

Зураг 1. 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаралтын эх үүсвэр²²⁸




Зураг 2. 2021 онд дэлхийн хэмжээнд хүний үйл ажиллагаанаас алдагдсан метан хий²²⁹




²²⁸ 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаралтын эх үүсвэр <https://www.iea.org/data-and-statistics/charts/sources-of-methane-emissions-2021>

²²⁹ 2021 онд дэлхийн хэмжээнд хүний үйл ажиллагаанаас алдагдсан метан хий <https://www.iea.org/reports/global-methane-tracker-2022/overview>

Зураг 3. 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаруулалтаараа тэргүүлсэн орнууд²³⁰



Зураг 4. 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаруулалт бүс нутгаар²³¹



²³⁰ 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаруулалтаараа тэргүүлсэн орнууд / <https://www.iea.org/reports/global-methane-tracker-2022/overview>

²³¹ 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаруулалт бүс нутгаар <https://www.iea.org/data-and-statistics/charts/global-energy-related-methane-emissions-by-region-reported-to-the-unfccc-and-estimates-from-the-iea-2021>

Хоёр. БАЙГАЛИЙН ХИЙ ХАЙХ, ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙЛСАН СТАНДАРТ, ШААРДЛАГА

Дэлхийн хэмжээнд байгалийн хийн үйлдвэрлэл 5% өсөж, 2021 онд 4.04 их наяд м³ хэмжээнд хүрсэн байна. Орос улс одоогоор байгалийн хий үйлдвэрлэсэн хэмжээгээр дэлхийд хоёрдугаарт жагсаж байгаа бол уг түлшийг экспортод гаргасан хэмжээгээр тэргүүлж байна.²³²

2.1 Байгалийн хийн химийн бүтэц ба геологийн тархац

Байгалийн хийн зонхилох хувийг метан (70-90%) бүрдүүлэх ба этан, пропан, бутан багавтар хэмжээтэй (0-20%), нүүрстөрөгчийн давхар исэл (0-8%), азот (0-5%), хүхэрлэг устөрөгч (0-5%) өчүүхэн хэмжээтэй байдаг бол гели, аргон, неон, ксенон маш бага хэмжээтэй тус тус агуулагдсан байдаг байна.²³³

Байгалийн хийг газрын гадаргад хэрхэн байрласан байдлаар нь ихэвчлэн ангилдаг байна. *Ердийн*²³⁴ байгалийн хий нь томоохон хагарал болон чулуулаг давхраа хоорондын орон зайд байрладаг байна. Тэгвэл *ердийн бус*²³⁵ байгалийн хий нь занар, хайрга (элсэрхэг чулуу) буюу бусад төрлийн тунамал чулуулаг бүрэлдэх явцад үүссэн нүх сүвэнд агуулагддаг байна. Тиймээс ч занарын хий буюу нягт хий гэж нэрлэдэг. Эцэст нь, *нөхцөлдсөн*²³⁶ байгалийн хий нь газрын тосны ордод хамт байдаг байна. Нүүрсний давхаргын метан нь нүүрсний ордод байдаг бас нэгэн төрлийн байгалийн хий юм.

Мөн *хуурай* (цэвэр метан) буюу *нойтон* (бутан зэрэг бусад нүүрс устөрөгч агуулсан) гэж ангилдаг байна. Нойтон хийг тээвэрлэхийн өмнө бусад нүүрс устөрөгч болон бусад тунадаснаас нь ялгаж цэвэршүүлэх шаардлагатай байдаг байна. Ингэж ялгаж авсан бүтээгдэхүүнийг тусад нь борлуулан ашиг олох боломжтой юм.²³⁷

2.2 Байгалийн хийн гэрээний эрх зүй

Америкийн Нэгдсэн Улс (АНУ) занарын хийг гаргаж авсанаар эрчим хүчний салбарын түүхэнд хамгийн том ололт амжилт олж, байгалийн хий импортлогч орноос дэлхийн тэргүүлэх үйлдвэрлэгч орон болон дэвшиж, улмаар экспортын хэмжээгээ эрчимтэй нэмэгдүүлсээр байна.

Эрчим хүчний компаниуд нь засгийн газраас олгож буй ашигт малтмалын эрхийн төлөө өрсөлдөж байдаг байна. Ингэхдээ концессын гэрээ буюу бүтээгдэхүүн хуваах гэрээний аль нэгийг сонгодог байна. Концессын гэрээ байгуулсан тохиолдолд, хайж олсон газрын тос болон байгалийн хий нь үйлдвэрлэгчийн өмч болдог байна. Харин бүтээгдэхүүн хуваах гэрээний тухайд, засгийн газар нь өмчийн эзнээр үлдэж, оролцооны хувь хүртдэг байна.

2.3 Хайгуул

Хайгуул нь өндөр эрсдэлтэй, үндсэндээ хамтарсан хөрөнгө оруулалтын сан санхүүжүүлэх боломжтой байдаг учир өндөр зардалтай үйл ажиллагаа юм.

²³² Газрын тос, байгалийн хийн хөрөнгө оруулалт-OIL AND GAS INVESTING-англиар <https://investingnews.com/top-natural-gas-producers/>

²³³ Байгалийн хий-Natural Gas-англиар <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>

²³⁴ conventional-англиар

²³⁵ unconventional-англиар

²³⁶ associated-англиар

²³⁷ Конгрессын номын сан, Газрын тос ба хийн салбар: Судлаачийн гарын авлага, Урсгалын эх: Үйлдвэрлэл ба олборлолт-Library of Congress, Oil and Gas Industry: A Research Guide, Upstream: Production and Exploration-англиар <https://guides.loc.gov/oil-and-gas-industry/upstream>

Чичирхийллийн шинжилгээний арга хэрэглэн хуурай цооног (хатсан худаг)-ийн өрөмдлөг хийж бүтэлгүйтсэн хайгуулын өртөг гэхэд нэг ордын хувьд 5-20 сая ам. доллар, зарим тохиолдолд түүнээс ч их гарах магадлал бий. Гэсэн хэдий ч хэрэв ордын хайгуул амжилттай болж, газрын тос болон байгалийн хийн олборлолт үр ашигтай болвол хайгуулын зардлыг төвөггүй нөхөх бөгөөд энэхүү зардал нь үйлдвэрлэлийн бусад өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц бага байдаг байна.

Баталгаат нөөц гэж газрын тос болон байгалийн хийн ордыг одоогоор хэрэглэж байгаа технологийг ашиглан тодорхой цаг хугацааны туршид эдийн засгийн хувьд үр ашигтай үйлдвэрлэл явуулах боломжийг илэрхийлдэг хэмжүүр юм. Баталгаат нөөцийн таамаглалыг тогтмол дахин үнэлгээ хийсний үндсэн дээр түрээсийн үргэлжлэх хугацааны туршид байнга шинэчлэн тогтоож байдаг байна. Технологийн дэвшил нь энэхүү таамаглалд хүчтэй үр нөлөө үзүүлдэг байна. Технологиос гадна үнэ болон одоо байгаа дэд бүтэц нь мөн нөөцийн таамаглалд нөлөөлдөг байна.

2.4 Олборлолт

Газрын тос болон байгалийн хийн олборлолт (үйлдвэрлэл) нь үнэтэй тоног төхөөрөмж, өндөр боловсролтой мэргэшсэн ажиллах хүч шаардлагатай учир хамгийн их хөрөнгө оруулалт шаарддаг аж үйлдвэрийн салбарын нэг юм. Газрын тос болон байгалийн хийн төрөл, ордын геологийн тогтоцоос шалтгаалан өрөмдлөгийн аргыг сонгодог байна.

Офшор өрөмдлөгийн байгууламжийн хувьд, цооногуудыг талбар болгон бүлэглэх ба хүнд газрын тосны нэг цооногт хагас акр²³⁸ газар ноогдох бол байгалийн хийн хувьд 80 акр газар оногддог байна. Цооногийн бүлгүүд нь өөр хоорондоо нүүрстөрөгчийн ган (техникийн алмаз) хоолойгоор холбогдсон байх ба газрын тос болон байгалийн хийг химийн урвалд оруулах, халаах зориулалтын үйлдвэрлэх болон боловсруулах байгууламжид дамжуулдаг байна. Зах зээлийн нөхцөл байдалд тохируулан оншор үйлдвэрлэгч нь өрмийн машиныг офшортой харьцуулахад илүү хялбар нээж, хаах боломжтой байдаг байна.

Офшор өрөмдлөгийн байгууламжийн хувьд, суурин (ёроолыг нь бэхэлсэн) буюу хөдөлгөөнт (зангууны тусламжтай урсаж гулгахаас хамгаалсан) ганц тавцан (платформ) ашигладаг байна. Офшор өрөмдлөг нь оншороос, суурин өрмийн машин нь хөдөлгөөнтөөсөө тус тус илүү үнэтэй байдаг байна. Ихэнх үйлдвэрлэлийн байгууламжууд нь офшор өрмийн машины ойролцоо эрэг дээр байрладаг байна.

Цохих буюу усаар цохиулах²³⁹ техник нь өндөр даралттай шингэн ашиглан газрын тос болон байгалийн хийг геологийн тогтоцоос нь шахаж гаргах арга юм. Энэхүү технологийг 1940-өөд онд анх нээсэн боловч 1990-ээд онд л эдийн хувьд үр ашигтай болсон байна. Цохих технологийг эхлээд нүүрсний давхаргын цооног, нягт элсэрхэг тогтоц болон занарын тогтоцоос хий олборлоход ашигласан бол улмаар өмнө нь хүрэх боломжгүй байсан өрмийн цооногоос газрын тос гаргаж авахад хэрэглэдэг болсон байна. Ердийн ордын нөөц багассан тул өдгөө Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын шинэ газрын тосны цооногийн 90%-д нь усаар цохиулах технологийг ашиглаж байна.

2.5 Стандарт ба баталгаажуулах байгууллага

Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэр нь хамгийн чухал бөгөөд орчин үеийн эдийн засагт хамгийн өндөр цэвэр ашгийн үнэ цэн бүхий салбар юм. Энэ салбар нь ажлын байрны аюулгүй байдал, хөрөнгийн удирдлага, байгууламжийн тордолт (техник, тоног

²³⁸ 1 акр=4 047 м²

²³⁹ hydraulic fracturing-англиар

төхөөрөмжийн засвар үйлчилгээ) болон хүрээлэн буй орчин, хууль эрх зүйн зохицуулалт хоорондын олон сорилттой тулгардаг байна.²⁴⁰

ISO-стандартууд нь газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн үйл ажиллагааг ашиг орлоготой байх, үр ашигтай байх нөхцөлийг бүрдүүлж байдаг байна. National Quality Assurance Ltd. (NQA) нь газрын тос ба байгалийн хийн салбар дахь баталгаажуулах байгууллага юм. Түүний цогц аудитын үйлчилгээ нь газрын тос ба байгалийн хийн салбарын байгууллагад шаардагдах стандартын нөхцөлийг бүрдүүлэх, хангуулах чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэр нь тос, хий болон ижил төстэй бүтээгдэхүүн боловсруулах бөгөөд доорх 3 чиглэлтэй:

1. **Урсгалын эх:**²⁴¹ Байгалийн хий буюу түүхий нефтийн талбарыг хайж илрүүлэх, ашигт малтмалыг цооног гарган өрөмдлөг хийж олборлох;
2. **Урсгалын дунд:**²⁴² Хий, тосыг баяжуулах (цэвэршүүлэх), тээвэрлэх, хадгалах болон боловсруулах;
3. **Урсгалын адаг:**²⁴³ Түүхий эдийг шүүх (ялгах), маркетинг, бүтээгдэхүүнийг худалдааны сувгаар хэрэглэгчид түгээх.

Газрын тос ба байгалийн хийнээс гаргаж авдаг голлох бүтээгдэхүүн:

- Дизель түлш
- Бензин
- Керосин
- Мазут (шингэн шатахуун)
- Байгалийн хий
- Асфальт (цардмал)
- Шингэн хийн шатахуун (LPG)
- Халаалтын тос
- Тосолгооны материал
- Онгоцны түлш
- Нефть химийн бүтээгдэхүүн

Эдгээр бүтээгдэхүүнийг бордоо, хуванцар, эм болон уусгагч зэрэг бараа таваар боловсруулахад шууд буюу үндсэн материал болгон хэрэглэдэг байна.

Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн орчин үеийн чиглэл тренд:

- Аж ахуйн нэгжийн өсөлтийг хангах зорилгоор дэд бүтцийг сайжруулахад анхаарах;
- Хүрээлэн буй орчны нөлөөг бууруулах зорилгоор тогтвортой практик нэвтрүүлэх;
- Аюултай бүсийг шинжлэн судлах зорилгоор нэмэлт болон хийсвэр орчин бүрдүүлэх төхөөрөмж бүтээх.

Газрын тос ба байгалийн хийн салбарын стандартын баталгаажуулалт хийхэд NQA байгууллагын баримталдаг стандартууд:

²⁴⁰ Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн стандартууд-OIL & GAS INDUSTRY STANDARDS-англиар <https://www.nqa.com/en-gb/certification/sectors/oil-gas>

²⁴¹ Upstream-англиар

²⁴² Midstream-англиар

²⁴³ Downstream-англиар

- **ISO 9001:** Чанарын удирдлагын системийн олон улсын стандарт. Энэ стандартыг чанарын хяналт, байгууллагын зохион байгуулалт, удирдлагын бүтцийг сайжруулахад ашигладаг байна.
- **ISO 14001:** Хүрээлэн буй орчны удирдлагын системийн стандарт. Энэ системийг ажлын байрны хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг хянах, нийцтэй эрх зүйн орчин бүрдүүлэх, экологийн үр нөлөөг багасгахад ашигладаг байна.
- **ISO 50001:** Байгууллагын эрчим хүчний удирдлагын хүрээнд хүрээлэн буй орчны стандарт. Байгууллагын эрчим хүчний хэрэглээг оновчтой, үр ашигтай болгоход зориулагдсан.
- **ISO 45001:** Мэргэжлийн эрүүл ахуй, аюулгүй байдлын гол стандарт. Ажлын байран дахь ажилтны эрүүл мэнд, аз жаргалтай байдалд муугаар нөлөөлөх үзүүлэлтийг хянаж бууруулсанаар осол, гэмтэл, хохирол гарах магадлалыг бууруулах зорилготой.
- **ISO 27001:** Мэдээллийг нууцлан²⁴⁴, бэлэн байдалтай²⁴⁵, эрх зүйн хувьд нийцлэг²⁴⁶ байдалтай хадгалах. Энэ нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын системийн олон улсын стандарт юм. Уг стандартыг баталгаажуулах нь дээрэм тонуул, хулгай, кибер довтолгоо зэрэг аюулгүй байдлын заналыг бууруулах болно. Гэхдээ энэхүү стандарт нь Өгөгдөл хамгаалах ерөнхий зохицуулалтын журмыг хамаарахгүй болно.
- **PAS 2060:** Саармаг нүүрстөрөгчийн тухай цорын ганц олон улсын стандарт. Энэхүү стандарт нь ISO 14001 стандартын үндсэн дээр хэрэгждэг байна.
- **ISO 55001:** Хөрөнгийн удирдлагын стандарт. Өндөр өртөгтэй буюу олон тооны хөрөнгөтэй аж ахуйн нэгжүүд энэхүү стандартад тусгасан удирдлагын зарчмыг хэрэгжүүлдэг байна. Эрсдэлийг бууруулах, өсөлтийн боломжийг илэрхийлэх үр дүнгийн бичвэр үйлдэх зорилготой хөрөнгийн удирдлагын систем юм.
- **ISO 37001:** Хээл хахуулийн эсрэг удирдлагын системийн олон улсын стандарт. Байгууллага хээл хахууль авах, өгөхийг тогтоох, шийдвэрлэх болон урьдчилан сэргийлэх зорилготой. ISO 9001 стандартын зарим хэмжүүрийг ашигласны үндсэн дээр хэрэгждэг байна.
- **ISO 22301:** Тасралтгүй бизнесийн үйл ажиллагааны удирдлагын системийн олон улсын стандарт. Онц байдлын дараа бизнесийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан осол, гамшигаас нөхөн сэргээх, хариу үйлдэл хийх, бэлтгэл хангах зорилготой. Мөн дээрх хөндлөнгийн нөлөөнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад чиглэнэ.

ISO 20815:2018 Нефть, нефть хими болон байгалийн хийн аж үйлдвэр-Үйлдвэрлэлийн итгэмжлэл²⁴⁷ ба найдвартай ажиллагааны удирдлагын стандарт.²⁴⁸ Уг баримт бичигт нефть, нефть хими болон байгалийн хийн нөөц (ашигт малтмал)-ийг хайж өрөмдөх, олборлох, боловсруулах болон тээвэрлэхтэй холбогдох систем болон ажилбарын²⁴⁹ хүрээнд үйлдвэрлэлийн итгэмжлэлийн үзэл баримтлалыг тусгасан байна. Стандартад урсгалын эх (усан доорхыг оруулаад), урсгалын дунд болон урсгалын адгийн байгууламж, нефть хими болон түүнтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг багтаасан

²⁴⁴ confidential-англиар

²⁴⁵ available-англиар

²⁴⁶ compliant-англиар

²⁴⁷ assurance-англиар

²⁴⁸ ISO 20815:2018 Нефть, нефть хими болон байгалийн хийн аж үйлдвэр-Үйлдвэрлэлийн итгэмжлэл ба найдвартай ажиллагааны удирдлага-ISO 20815:2018 Petroleum, petrochemical and natural gas industries — Production assurance and reliability management-англиар <https://www.iso.org/standard/69983.html>

²⁴⁹ operation-англиар

байна. Ингэхдээ газрын тос ба байгалийн хийн үйлдвэрлэл, боловсруулалт болон түүнтэй холбоотой үйл ажиллагааны үйлдвэрлэлийн итгэмжлэлд голлон төвлөрөх ба бүрэлдэхүүн хэсгийн найдвартай ажиллагаа, тордолт (засвар үйлчилгээ)-ын дүн шинжилгээг хамарсан байна. Үйлдвэрлэлийн итгэмжлэл нь зөвхөн нүүрс устөрөгчийн үйлдвэрлэлээр хязгаарлагдахгүй, харин ч өрөмдлөг, дамжуулах хоолойн суурилуулалт, усан доорх ажилбар зэрэг болон эдгээртэй холбоотой үйл ажиллагааг хамардаг байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага/ОУХБ²⁵⁰ (International Labour Organisation/ILO)-ын баримталдаг стандарт болох суурь гэрээ хэлэлцээр, гэрээ хэлэлцээр болон зөвлөмжийн хүрээнд байгалийн хийд холбогдох “R160 Тэнгисийн тавцангийн ажлын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн зөвлөмж” (R160 Occupational Safety and Health (Dock Work) Recommendation) гэсэн нэртэй ганц зөвлөмжийг 1979 онд батлан мөрдүүлж байдаг юм байна.

Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн салбарт ашиглаж буй ISO-стандартуудын бүрэн жагсаалтын схемийг хавсаргав.²⁵¹

2.6 Эрх зүйн зохицуулалтын чиг хандлага²⁵²

Газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолттой холбоотой хууль, эрх зүйн орчин, холбогдох хууль тогтоомжуудыг харьцуулан судлахад, хуульчилсан арга, хэлбэр нь улс орон бүрт янз бүр байх ба агуулга, зохицуулалтууд нь ихээхэн ялгаатай байна. Эдгээрийг эрх зүйн тогтолцоо болон зохицуулалт талаас нь дараах байдлаар ангилан авч үзэж болох юм. Үүнд:

- Тухайн хууль тогтоомжоор бүхэлд нь нарийвчлан зохицуулсан, тогтмол агуулга бүхий хатуу зохицуулалттай **/fixed content system or freezing provisions/** тогтолцоо;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хүрээнд хэлэлцээр явуулах гэрээнд суурилсан эрх зүйн тогтолцоо **/agreement system/**, эсхүл шууд хэлэлцэн тохиролцох хэлэлцээр **/direct negotiating/**-ийн арга;
- Гэрээ, эрх зүйн дээр дурдсан хоёр төрлийн тогтолцоонд хоёуланд нь суурилж, тэдгээрийн аль аль нөхцөлүүдийг харгалзан үзэх завсрын агуулга бүхий уян хатан эрх зүйн тогтолцоо **/flexible content system/** буюу холимог эрх зүйн тогтолцоо **/hybrid system/**.

1/ Тогтмол агуулга бүхий хатуу зохицуулалттай эрх зүйн тогтолцоо—энэ нь тухайн орны үндэсний хэмжээнд үйлчлэх хууль тогтоомжид тухайн гэрээнд оролцогч талуудын эрх үүргийг нарийвчлан тусгаж өгдгөөрөө онцлогтой. Ийм төрлийн хууль тогтоомжийн хэлбэрийг Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Канад, Австрали, Латин америкийн орнууд, Дани, Франц, Герман, Нидерланд, Их Британи-Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ), Норвег зэрэг орнууд хэрэглэдэг байна.

Энэ хэлбэр нь газрын тосны хайгуул, олборлолттой холбоотой бүх төрлийн гэрээний нөхцөлүүдийг салбар хуульдаа тусгасан бөгөөд зарим нэг нөхцөлийг тусгайлан

²⁵⁰ Олон улсын хөдөлмөрийн стандартууд-International Labour Standards-*англиар*

<https://www.ilo.org/inform/online-information-resources/research-guides/economic-and-social-sectors/energy-mining/oil-gas-production/lang--en/index.htm>

²⁵¹ Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн салбарт ашиглаж буй ISO-стандартууд-ISO Standards for use in the oil & gas industry-*англиар*

[https://committee.iso.org/files/live/sites/tc67/files/ISO%20Standards%20for%20use%20in%20oil%20%26%20gas%20industry%20\(A3%20Poster\).pdf](https://committee.iso.org/files/live/sites/tc67/files/ISO%20Standards%20for%20use%20in%20oil%20%26%20gas%20industry%20(A3%20Poster).pdf)

²⁵² Г.Алтан-Оч, Д.Халиун СТ-21/236 “Газрын тосны харилцааны эрх зүйн зохицуулалт, бусад орнуудын туршлага” 2021

журамладаг байна. Энэхүү тогтолцоо нь хайгуул, олборлолтын гэрээнд оролцогч талуудад адил тэгш нөхцөлүүдийг бүрдүүлдгээрээ давуу талтай. Хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын тогтмол агуулгатай хатуу хэлбэрийг газрын тосны салбартаа баримтлах нь бусад компаниудыг татан оролцуулахад бэрхшээл үүсгэдэг уян хатан бус нөхцөлтэй, эсхүл хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд доогуур үнийн жишиг баримтлахыг тулган хүлээлгэх хандлагатай байдаг зэрэг сул талтай гэж үздэг байна.

Хуулийн энэхүү тогтолцоо нь хөгжиж буй орнуудад хувьд тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа компанийн газрын тосны үйл ажиллагаа, түүнтэй холбоотой татварын эрх зүйн орчинг тогтвортой байлгах, гэрээ хэлэлцээрийн эрх зүйн орчныг тодорхой болгодог давуу талтай.

2/ Гэрээнд суурилсан эрх зүйн тогтолцоо—энэ нь хөрөнгө оруулагч тал олборлолт явуулах оронтой бие даасан, тусгайлсан гэрээний онцгой нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцох явдал юм. Гэхдээ гэрээний агуулга нь ерөнхий, эсхүл үйл ажиллагааны үе шат бүхэнд гэрээний нөхцөлүүд нь нийцэж үйлчлэх шаардлагатай тул учир дутагдалтай байдаг. Ийм хэлбэрийн эрх зүйн зохицуулалттай үед гол төлөв тухайн орны Засгийн газар, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий байгууллага үйл ажиллагааныхаа хүрээнд газрын тосны гэрээ хэлэлцээр байгуулахад оролцдог.

Ингэхдээ бүтээгдэхүүн хуваах, тусгай зөвшөөрөл олгоход үйлчилж буй уламжлалт нөхцөлүүд, тухайн эрх зүйн зохицуулалтын зохих шалгуур болох стандарт гэрээний нөхцөлүүд, эсхүл тусгай зөвшөөрлийн шаардлага болон нөхцөлүүдийг гэрээ байгуулахдаа ашигладаг байна. Түүнчлэн газрын тосны компаниудтай гэрээ байгуулахдаа төсөвт нөлөөлөх хүчин зүйлийн үйлчлэлийг нэмэгдүүлэхгүй тогтвортой байлгах талаар хэлэлцэн тохиролцож, энэ хүрээнд тухайн орны Засгийн газрын зүгээс тодорхой амлалт, үүрэг авах боломжтой боловч нэгэнт тохиролцож гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа уг гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь хүндрэлтэй байх сөрөг талтай. Өөрөөр хэлбэл, гэрээгээр тохиролцож амлалт авах нь гэрээнд заасан татварын үйлчлэх орчинд ямар нэг өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн орны эдлэх эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарласан байдаг.

3/ Гэрээний уян хатан эрх зүйн тогтолцоо—энэ нь дээр дурдсан хоёр эрх зүйн тогтолцооны хосолмол хувилбар юм. Өөрөөр хэлбэл, ашигт малтмал эзэмшигч орон холбогдох хууль тогтоомжоор эрх зүйн зохицуулалтын горим журмыг нарийвчлан тогтоохын зэрэгцээ тодорхой зарим нөхцөлүүдийг онцгойлон авч үзэж, бие даасан зохицуулалт хийх эрх эдэлдгээрээ онцлогтой.

Газрын тос олборлуулагч эзэн орны хувьд тусгай зөвшөөрлийн нөхцөлүүдийг тодорхойлох, тухайн ашигт малтмалын олборлолтын талаар гэрээ хэлэлцээр хийх, нөөцийг үнэ хаялцуулан өрсөлдөөний журмаар шийдвэрлэх суурь нөхцөл болгон ашиглах, гэрээний загварын төсөл бэлтгэх, шаардлагатай бол гэрээний нөхцөлүүдэд өөрчлөлт оруулах боломжтой байх зэрэг уян хатан гэрээний эрх зүйн тогтолцоог хүлээн зөвшөөрдөг байна.

Түүнчлэн, газрын тосны эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг авч үзвэл, ашигт малтмал, газрын тосны өмчлөлийн харилцаанаас хамааруулан *эрдэс баялгийн төрийн өмчлөлд байх үе дэх эрх зүйн зохицуулалт, хайгуулаар илрүүлж, нөөц тогтоохын өмнөх үе буюу эрдэс баялгийн өмчлөгч тодорхой бус байх үеийн эрх зүйн зохицуулалт*, мөн зарим улс орны шашны номлолд тусгасан *Исламын бүсэд баримтлах эрх зүйн чиг хандлага* зэрэг хандлагуудыг тодорхойлж болох юм:

- Эрдэс баялаг төрийн буюу улсын өмчлөлд байх ухагдахуунд суурилсан хуулийн тогтолцоо **/Domianial Law System/**-ны онцлог нь эрдэс баялгийн нөөцийн хайгуул,

олборлолтын үйл ажиллагааг газар нутаг дээрээ явуулж байгаа тухайн муж улсын хувьд энэхүү үйл ажиллагаанд улсын зүгээс тавих шаардлага, баримтлах нөхцөлүүд, эрдэс баялгийн зүйлийг өмчлөх тогтолцоо нь тогтсон хэв загвартай, тогтвортой стандартчлагдсан байдаг байна. Энэ тогтолцооны сонгодог жишээ нь АНУ юм. Мөн түүнчлэн Зүүн европын орнууд, Мексик, Чили, Бразил, Аргентин зэрэг орнууд нь энэ чиглэлээр өөрийн гэсэн практик туршлага хуримтлуулсан бөгөөд төрийн зүгээс эрдэс баялгийн салбарт давамгайл эрхтэй оролцдог тул газрын тосны үйл ажиллагаа, ялангуяа техникийн болон санхүүгийн чиглэлээр туслан гүйцэтгэх ажил, үйлчилгээнд хувийн салбарын оролцоог хязгаарладаг байна.

- Хайгуулаар илрүүлж, нөөц тогтоохын өмнөх үеийн эрдэс баялгийн өмчлөгч тодорхой бус байх ухагдахуунд суурилсан хуулийн тогтолцоо **/Regalian system/**-ны үндсэн зарчим ашигт малтмалын тогтоосон нөөц хөрөнгийг өмчлөх эрх нь бүрэн олгогдоогүй, өмчлөгч нь тодорхойгүй байх үед төрийн зүгээс эрдэс баялгийн нөөцийг эзэмших, ашиглалт явуулах эрх, чиг үүргийг тодорхойлсон тусгайлсан горимыг үндсэн хоёр аргаар тогтоож өгдөг.
 - Тухайн муж болон улс нь ашиглалт явуулах том хэмжээний эрдэс баялгийн ордод тэрхүү эрдэс баялгийг хэн түрүүлж хайгуул хийж илрүүлэн нөөц тогтоосон байна, тэр этгээдэд өмчлөх эрх олгож, ашиглалт явуулах баталгаа өгдөг байна. Төрийн зүгээс ийнхүү хайгуул хийж, олж тогтоосон нөөцийг олборлох эрхийг хэрхэн олгох, ямар журмаар ашиглуулах нөхцөлийг урьдчилан тодорхойлсон байдаг. Эрдэс баялгийн нөөцийг олж илрүүлэх болон түүний дараа төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны горимыг ийнхүү тогтоох нь хайгуулын үе шатанд болон түүний дараа олборлох эрх эзэмшигчийг шилж сонгох үйл ажиллагаанд төрийн зүгээс давуу эрхтэй оролцох байдлыг хязгаарладгаараа онцлогтой.
 - Төрийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх горим болон түүний эрх зүйн зохицуулалтын механизмуудыг хуулиар тогтоож, аль оновчтойг нь хэрэглэх эрх мэдэлтэй байх зарчим байна. Үүнийг төрийн “бие даасан эрх хэмжээ” гэж нэрлэх бөгөөд жишээ нь, газрын тосны хайгуулын шатанд төрийн эрх бүхий байгууллагын зүгээс хайгуулын ажлыг гүйцэтгэх эрх авсан этгээдийн үйл ажиллагааны явц байдалд хяналт тавих, ашиглалт явуулах, байгалийн эрдэс баялгийн нөөцийг аль болох бүрэн хэмжээнд тогтооход нь дэмжлэг үзүүлэх зэргээр оролцдог байна.
- Исламын бүсэд баримтлах чиг хандлага **/The Islamic perspectives/**. Энэ бүсийн орнуудад бизнес, худалдаа-арилжааг дэмжих болон гэрээ хэлэлцээрт чөлөөтэй оролцох, газар болон хөдлөх хөрөнгийн хувийн өмчийн эрхийг хамгаалахыг дэмжсэн агуулгыг баримталдаг хуулийн зохицуулалттай. Коран судрын агуулгад гэрээ бол улсын, хувийн салбар, албан тушаалтнуудыг оролцуулаад гэрээнд оролцогч талуудын аль алиныг төлөөлөх, талуудын харилцан итгэл хүлээсэн байх үзэл санааг агуулсан байхыг тусгасан байдаг. Ашигт малтмалын өмчлөлийн эрх зүйн харилцаанд шариадын хууль-номлолыг үндэс болгодог байна.

Дэлхийн ихэнх улс орны хувьд байгалийн баялаг, ашигт малтмалын нөөцийг тухайн улсын нэрийн өмнөөс өмчлөгч этгээд хэн байх, хэрхэн өмчлүүлэх, түүгээр дамжуулан ашигт малтмалыг олборлуулах, ашиглуулах, хуульчлан тогтоосон горимыг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд хариуцлага тооцох, ашигт малтмал ашиглах эрхийг нь дуусгавар болгох, шилжүүлэх, ашигт малтмалын нөөцийг ашиглах этгээдээс ашигт малтмал ашигласны төлбөрийг улсын орлогод авах, уг орлогын удирдлагыг хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг Үндсэн хуулиараа зохицуулсан байдаг байна.

Нийт 152 орны Үндсэн хуулийн хүрээнд энэ чиглэлээр хийсэн харьцуулсан судалгаанаас үзэхэд:

- Хуучин социалист орнууд, мөн Энэтхэг, Мексик, Перу, Габон зэрэг зах зээлийн эдийн засагт шилжсэн орнуудын хувьд тодорхой нэр төрлийн эрдэс баялгийн нөөцийг улсын өмчлөл, мэдэлд байлгах харилцааг Үндсэн хуулиараа хуульчлан тогтоосон байдаг. Харин ашигт малтмалын тодорхой төрлүүдийг улсын өмчлөлд үе уламжлан байлгах асуудлыг салбар хуулиуд болон гүйцэтгэх засаглалын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг, тогтоол шийдвэрээр зохицуулсан байдаг байна.
- Зарим эрдэс баялгийн нөөцийг өмчлүүлэх эрхийг Үндсэн хуульдаа хүлээн зөвшөөрсөн байна. Хэрэв хувийн өмчлөлд байгаа ашигт малтмалын нөөцийг улсын өмчлөл, мэдэлд шилжүүлэн авсан бол түүний төлөө нөхөн олговор олгож байх тухай ерөнхий нөхцөлийг судалгаанд хамрагдсан 152 орны 93 улс нь Үндсэн хуульдаа тусгасан байна.

Эрдсийн салбарт гэрээ байгуулах хоёр үндсэн арга байдаг: *хоёр талын хэлэлцээр, сонгон шалгаруулалт*. Хэлэлцээрийн үед гадаадын компани нь хайх, олборлох, эрдсийг экспортлох концессыг авахын төлөө тухайн улсын засгийн газарт хандаж хэлэлцээрт ордог байна. Компанийн зүгээс засгийн газарт тодорхой хэмжээний роялти төлбөр хийснээр гэрээг авдаг уламжлал тогтсон аж. Ийм гэрээ нь хэтэрхий нэг талыг барьсан, компанид илүү ашигтай байдаг байна. Учир нь компани эрдэс баялаг болон үйлдвэрлэлийн түвшнийг бүрэн хянах боломжтой, өргөн эрхтэй байдаг. Энэхүү тэнцүү бус байдал нь засгийн газарт мэдээлэл дутмаг байх, мөн эрэл хайгуул явуулах санхүүжилт олоход бэрхшээлтэй байдлаас үүдэлтэй юм.

Гурав. БАЙГАЛИЙН ХИЙ, МЕТАН ХИЙ ХАЙХ, ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮН БА БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ


3.1 Байгалийн хий

Байгалийн хий нь чулуужсан түлштэй харьцуулахад байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бохирдол харьцангуй багатай байна.²⁵³ Байгалийн хийг шатаах явцад газрын тос, нүүрснээс хамаагүй бага хүлэмжийн хий ялгаруулдаг. Гэхдээ энэ нь байгаль орчинд ээлтэй гэсэн ойлголт биш бөгөөд дараах байдлаар тодорхой хэмжээнд нөлөөлж байдаг.

²⁵³ Байгалийн хийн олборлолт байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл <https://group.met.com/en/mind-the-future/mindthefuture/natural-gas-environmental-impact>

Зураг 5. Байгалийн хийн төрөл, нөөц

Schematic geology of natural gas resources




Source: Adapted from United States Geological Survey factsheet 0113-01 (public domain)

3.2 Байгалийн хий олборлолт


Байгалийн хийг олборлохдоо босоо болон хэвтээ цооног өрөмдөж олборлодог байна.²⁵⁴ Ихэнх тохиолдолд босоо цооноогоор дамжуулан олборлодог бол зарим тохиолдолд байгалийн хий нь занар болон бусад төрлийн чулуулгийн тогтцод хуримтлагдсан байдаг тул чулуулаг тогтцыг буталж чулуулгаас байгалийн хийг гаргаж соруулж авдаг байна. Энэ үйл явцыг гидравлик хугарал эсвэл фракинг гэж нэрлэдэг бөгөөд заримдаа уламжлалт бус олборлолт гэж нэрлэдэг. Олборлолтын дараа байгалийн хийг ихэвчлэн жижиг хоолойгоор дамжуулан үйлдвэрүүдэд боловсруулдаг. Тухайн боловсруулах үйлдвэрт байгалийн хийг төрөл бүрийн нүүрс ус төрөгч болон шингэнийг цэвэр байгалийн хийнээс нь салгаж "хуурай байгалийн хий" үүсгэдэг. Мөн байгалийн хийн алдагдлыг илрүүлэхийн тулд үнэрт бодис гэж нэрлэгддэг химийн бодисуудыг байгалийн хийд нэмдэг байна. Зарим байгалийн хий нь боловсруулалт хийлгүйгээр дамжуулах хоолойн тээвэрлэлтийн стандартыг хангахуйц хуурай байдаг. Хуурай байгалийн хийг далд агуулах эсвэл түгээх компаниуд руу хоолойгоор дамжуулж, дараа нь хэрэглэгчдэд хүргэдэг. Нүүрсний давхаргын метаныг нүүрс олборлохоос өмнө эсвэл олборлох явцад нүүрсний нөөцөөс гаргаж, ямар нэгэн тодорхой боловсруулалт хийлгүйгээр байгалийн хий дамжуулах хоолойд нэмж болно.

²⁵⁴ Байгалийн хий олборлолт - <https://www.linquip.com/blog/is-natural-gas-a-fossil-fuel/>

Зураг 6. Хэтээ өрөмдлөг буюу уламжлалт бус олборлолт



Зураг 7. Байгалийн хийн олборлолт, үйлдвэрт боловсруулах явц



3.3 Өрөмдлөг, олборлолтын нөлөө

Байгалийн хийг олборлох цооног буюу худаг өрөмдөх нь ан амьтан, газрын ашиглалтад сөргөөр нөлөөлдөг. Энэ нь тухайн байгалийн экосистемд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Амьтадын нүүдлийн хэв маягийг эвдэж, гол мөрөн, горхийг бохирдуулж, шороон элэгдэл, бохирдуулагч бодисууд нь байгалийн хийн олборлолтын сөрөг үр дагавар юм. Гидравлик хагарал нь газар хөдлөлтийг үүсгэж, тухайн газар нутгийн усны эх үүсвэрт сөргөөр нөлөөлдөг байна.

Тээвэр:

Олборлож гаргаж авсан хийг байгалийн хийн цахилгаан станц руу зөөвөрлөх дэд бүтцийг бий болгох нь мөн л бохирдуулах үйл явц юм. Дамжуулах хоолой нь амьдрах орчны хуваагдал үүсгэж, байгалийн талаас нь авч үзвэл гол хэсгүүдийг хөндлөн огтолж болно. Хоолойноос хий гоожих нь газрын доорх усны түвшинд мөн газрын гадарга дээрх усны нөөцөд болон хүрээлэн буй орчны томоохон асуудал үүсгэдэг.

Шатаах ба хэрэглээ:

Байгалийн хий нь илүү цэвэрхэн шатдаг тул байгальд хамгийн ээлтэй чулуужсан түлш юм. Цахилгаан станцуудад байгалийн хий нь ердийн газрын тос эсвэл нүүрсээр

ажилладаг цахилгаан станцуудаас 50-60 хувиар бага нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂) ялгаруулдаг байна. Мөн амьдралын мөчлөг багатай хүлэмжийн хийг агаар мандалд ялгаруулдаг. Гэсэн хэдий ч шаталт нь метан ялгаруулж, агаарын чанарыг бууруулдаг юм.

Байгалийн хийг бүрдүүлэгч гол элемент нь *метан* юм. Метан нь органик бодис ялзрах явцад үүсдэг байна. Ургамал, амьтны үлдэгдэл нүүрс болон хувирч буй нүүрсжих процесст нүүрсний метан хий үүсдэг. Метан нь дэлхий дээрх янз бүрийн геологийн бүтцээс илэрдэг. Нүүрсний давхаргын үеүдэд оршин буй метаныг нүүрсний давхаргын метан гэж нэрлэдэг. Энэ нь нүүрснээс ялгарч буй нэг төрлийн байгалийн хий юм. Метан нь хүлэмжийн хий болох карбондиоксид буюу нүүрсхүчлийн хий CO₂-оос 21 дахин илүү дулаан ялгаруулах хүчтэй юм. Метан нь маш бага тоо хэмжээтэй боловч нүүрс хүчлийн хийн дараа орох хоёрдогч хүлэмжийн хийг бүрдүүлэгч хий юм.

Нүүрс олборлолт болон хүмүүсийн бусад уйл ажиллагаа тухайлбал хог хаягдал, мал аж ахуй, байгалийн хий олборлох, тээвэрлэх систем зэргээс метан ялгардаг байна. Метан нь ашиглаагүй тохиолдолд хаягдаж буй эрчим хүч юм. Мөн энэ нь дэлбэрэмтгий хий бөгөөд хүчилтөрөгчтэй харьцангуй бага 5-15 хувийн харьцаатай холилдсон нөхцөлд дэлбэрэх, тэсрэх аюулд хургэнэ. Метан, агаарын эзлэхүүний харьцаа 1:10 байвал хамгийн хүчтэй тэсэрнэ. Хэрвээ нүүрсний уурхайн гүнд метаны хуримтлал үүссэн үед ямарваа нэг ноцоолт өгвөл асар их аюул гамшигт хүргэх тэсрэлт болдог байна. Иймээс нүүрсний уурхайд метаны зөвшөөрөх хэмжээнээс илүү хуримтлал үүссэн тохиолдолд түүний хэмжээг багасгах, арилгах арга хэмжээг авдаг байна. Метан нь уурхайд нүүрсийг бутлан, олборлох явцад нүүрсний давхаргаас чөлөөлөгддөг бөгөөд энэ нь нүүрсний ил болон далд уурхайн аль алинд үүсэж байдаг. Мөн нүүрсийг хадгалах, боловсруулах, тээвэрлэх явцад ч түүнээс метан ялгарч байдаг байна. Тиймээс нүүрсний уурхайн олборлолт хийхээс өмнө түүнд агуулагдах байгалийн хий буюу метаны олборлолт хийх нь эдийн засгийн хувьд болон байгаль орчинд сайнаар нөлөөлөх ашигтай байна.

3.4 Байгалийн хий, метаныг хайх болон олборлох

Метан хийг газар доорх ордуудаар дамжуулан олборлодог. Метан хийн орд газрыг илрүүлэхийн тулд янз бүрийн системийг ашигладаг байна. Хамгийн түгээмэл ашиглагддаг арга бол жижиг дэлбэрэлтээр хиймэл газар хөдлөлтийг дараалан үүсгэх явдал юм. Эдгээр газар хөдлөлтүүд нь газар хөдлөлтийн долгион хөрсний чулуулаг руу хүрч, гадаргуу дээр тусаж буцаж эргэх хугацааг хэмжих юм. Тус чичирхийллийн долгион нь шингэн болон хийн ордуудын хэсэгт цохилт өгөхөд хэлбэлзлийг тусгай багажаар тэмдэглэж орд газрыг илрүүлдэг байна. Метаныг олборлоход дамжуулах хоолойгоор дамжуулж эсвэл цилиндрт шингэрүүлсэн хий хэлбэрээр нэвтрүүлдэг байна. Үүнийг хөлөг онгоцоор эсвэл том хэмжээний газрын тосны цистерн гэх мэт техник ашиглан их хэмжээгээр тээвэрлэх боломжтой юм.

Газрын гадаргууд нөлөөлөх

Метаны олборлолтын явцад газрын гадаргуугийн бүрхүүлд өөрчлөлт орох, аливаа хөдөлгөөнөөс үүсэх чимээ шуугианы түвшин нэмэгддэг байна. Чичирхийллийн судалгааны үед хийгдэж буй тэсэлгээг хэт өнгөц, гүехэн, гүн биш нүхэнд хийснээс газрын гадаргуугийн байдалд өөрчлөлт орно. Геологийн туршилтын үед ялангуяа хайгуулын цооног өрөмдөх явцад өрөмдлөгийн талбайд олон тооны салаа зам, харгуй гарах, барилга байгууламж барих, авто тээврийн хөдөлгөөн, өрөмдлөгийн үйл ажиллагаанаас үүсэх тоос шороо, бохир агаарын ялгарал, өрмийн шингэн, шаврын холимогоос учруулах хөнөөл, мөн гадна асгасан гүний давхаргын ус, нефть нь газрын гадаргууд сөргөөр нөлөөлдөг байна. Зам барих, чичирхийллийн судалгаа болон хайгуулын цооногийг өрөмдөхдөө буруу байрлуулах, буруу зохион байгуулах нь ургамалын нөөц, экосистем,

байгал орчинд сөрөг нөлөө үзүүлдэг байна. Гэсэн хэдий ч байгалийн хий, метаны олборлох уурхай нь нүүрсний ил болон далд уурхайтай харьцуулахад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь харьцангуй бага байна.

Байгаль орчинд нөлөөлөл

Метан нь олон төрлийн хэрэглээнд нийтлэг байдлаар аюулгүй гэж тооцогддог бөгөөд байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөө үзүүлдэг, эрсдэлгүй эрчим хүчний эх үүсвэр юм. Метан нь байгаль орчинд үзүүлэх нөлөөг үл харгалзан маш цэвэр шатдаг бөгөөд бусад чулуужсан түлшнээс хамаагүй бага хэмжээний нүүрстөрөгчийн давхар ислийг үүсгэдэг юм.²⁵⁵ Нүүрстөрөгч нь хүлэмжийн хийг бүрдүүлэгч гол хий бөгөөд түүний араас метан ордог байна. Метаны нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт нь бусад чулуужсан түлшнээс хамаагүй бага түвшинд байдаг ч метаны молекул нь дэлхийн агаар мандалд дулааныг барихад 25 дахин илүү байдаг байна.

Метан нь усанд маш сайн уусдаг тул үйлдвэрлэлийн эх үүсвэрээс эсвэл мөнх цэвдэг, гүний орд зэрэг байгалийн усан санд амархан уусдаг. Ууссаны дараа ус эсвэл хөрсний гадаргуугаас ууршиж, агаар мандалд орж нарны цацрагийг шингээж, халаах нөлөө үзүүлдэг байна. Мөн энэ хий нь хаягдал материал задрах явцад нянгийн үйл ажиллагаанаас их хэмжээгээр үүсдэг. Эх сурвалжаас үл хамааран метаны байгаль орчинд үзүүлэх нөлөө хэвээр байна.

Агаар, цаг уурт нөлөөлөл

Дэлхийн дулаарал нь дэлхийн агаар мандлын температурын өсөлтөөс шалтгаалж байна. Дэлхий дээр нүүрстөрөгчийн давхар ислийн (CO₂) дараа орох хоёр дахь том хүлэмжийн хий бол метан юм. Гэсэн хэдий ч метан нь дэлхийг дулаацуулахад илүү их үүрэг гүйцэтгэдэг байна. Агаарт метан ялгарахдаа хэд хэдэн аюултай урвалд ордог. Метан нь исэлдүүлэх замаар агаар мандлыг орхиж, усны уур, нүүрстөрөгчийн давхар ислийг үүсгэдэг байна. Тиймээс метан нь дэлхийн дулааралд шууд төдийгүй нүүрстөрөгчийн давхар ислийг ялгаруулах замаар шууд бусаар нөлөөлдөг. Мөн метан нь озоны давхарга үүсэхэд нөлөөлж, агаарын чанарыг бууруулж, амьтдын эрүүл мэндийн янз бүрийн асуудал, хүний дутуу үхэл, үр тарианы ургац буурахад хүргэдэг байна. Метан нь агаар мандалд дунджаар 10 жил тогтдог бол нүүрстөрөгчийн давхар исэл нь агаар мандалд 300-1000 жил үлддэг байна. Метан нь богино хугацаанд агаарт үлддэг ч дэлхийн дулааралд нөлөөлөл нөлөө нь өндөр байна.

Метан хийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Метан хийн хордлого нь концентрац өндөр байвал хүн, амьтны эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй юм. Метан нь техникийн хувьд хоргүй бөгөөд бага түвшинд амь насанд аюул учруулахгүй ч хүчилтөрөгчийг нүүлгэн шилжүүлж, амьсгал боогдоход хүргэдэг.²⁵⁶ Энэ нь хийн алдагдал, уусгах хий илрээгүй битүү орон зайд ажиллаж байгаа нөхцөлд онцгой эрсдэлтэй байдаг.

Хүний биед их хэмжээний метаны хордлого нь дотор муухайрах, толгой өвдөх, амьсгал давчдах, цээжээр өвдөх, хэл яриа алдагдах, ой санамж муудах, сэтгэх чадвар муудах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Харамсалтай нь эдгээр шинж тэмдгүүд нь арга хэмжээ

²⁵⁵ Метаны олборлолт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл-<https://www.bridgerphotonics.com/blog/how-does-methane-affect-environment>

²⁵⁶ Метаны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл-<https://www.qedenv.com/en-us/markets-solutions/oil-and-gas/commercial-gas-leak-detection/what-are-the-dangers-of-methane-gas/>

авахаас өмнө хэсэг хугацаанд анзаарагдахгүй байж, ноцтой гэмтэл, заримдаа үхэлд хүргэдэг.

Урт хугацааны метан хийн хордлогын улмаас хүмүүс дараахь үр дагаварт хүрж болзошгүй юм. Үүнд:

- Зүрх судас, амьсгалын замын болон мэдрэлийн тогтолцооны асуудлууд;
- Эпилепси, уушгины хатгалгаа, клаустрофоби, зүрхний эмгэгийн хөгжил;
- Санах ой алдагдах, сэтгэлийн хямрал.

Хүмүүст үзүүлэх удаан хугацааны үр нөлөө нь бусад хүчин зүйлсийн өртөлтийн төрөл, үргэлжлэх хугацаа зэргээс хамаарч өөр өөр байдаг.

Дөрөв. БАЙГАЛИЙН ХИЙ ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЗЭРЭГ СӨРӨГ НӨЛӨӨ

2020 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар дэлхийн нийт батлагдсан байгалийн хийн нөөц 7,257 их наяд шоо фут (Tcf) гэсэн тооцоо гарсан. Сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхий нийтийн байгалийн хийн хэрэглээ нэмэгдэж 2021 оны байдлаар дэлхийн хэмжээнд байгалийн хийн хэрэглээ ойролцоогоор 4.04 их наяд шоо метр болоод байна. Үүнээс хэрэглээний өсөлтөөр Ази, Номхон далайн орнууд жилд 5.2%-ийн тэргүүлж байна.

Байгалийн хий нь дэлхийн түлшний үндсэн эх үүсвэрийн хувьд дэлхийн эдийн засгийг тодорхойлогч хүчин зүйлийн нэг. Тиймээс НҮБ-аас дэлхийн хүн ам 2030 онд 8.5 тэрбум, 2050 онд 9.7 тэрбум дайна гэсэн тооцооллын үндсэн дээр дэлхийн эрчим хүчний хэрэглээ хэрэгцээ 2050 он гэхэд 2020 оны түвшинтэй харьцуулбал даруй 50% нэмэгдэх төлөвтэй гэж үзэж байна. Дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувийг дангаараа газрын тосны салбар бүрдүүлдэг учраас газрын тос, байгалийн хий нь улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөдөлгөгч хүч болоод байна.

4.1 Байгалийн хийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө

Хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө

2019 оны байдлаар дэлхийн хэмжээнд газрын тосны салбарт 8 сая, байгалийн хийн салбарт 3,9 сая ажилчид ажиллаж байна гэж Олон улсын хөдөлмөрийн байгууллага (International Labour Organization)²⁵⁷-ийн 2022 оны газрын тос, байгалийн хийн ирээдүйн төлөв олон улсын хурал дээр мэдэгдсэн. Байгалийн хийн үйлдвэрлэлээс олох эдийн засгийн үр өгөөжийг түшиглэн зохистой хөдөлмөр эрхлэлт, дотоодын аж ахуйн нэгжүүдэд шинээр ажлын байр бий болгох, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, чулуужсан нүүрсний хэрэглээг бууруулах зэрэг олон зорилтын хүрээнд мөн Парисын гэрээний зорилтуудтай уялдуулан шинэ макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхийг улс орнуудад уриалж байна. Тус байгууллагын судалгаагаар 2030 онд тогтвортой эрчим хүчний эх үүсвэрт шилжсэнээр газрын тос, байгалийн хий боловсруулах үйлдвэрүүдийн ажлын байр 1.6 саяар буурна гэж тооцоолсон байна. Байгалийн хийн салбарын хөдөлмөр эрхлэлтийн тусгайлсан хууль дутмаг байгаагаас зарим улсад байгалийн хий олборлолт, боловсруулалт хийх үеийн хөдөлмөрийн нөхцөл, ажилчдын эрх ашиг маш ихээр зөрчигдөж байгааг харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллагсдын эрх

²⁵⁷ International Labour Organization https://www.ilo.org/sector/Resources/publications/WCMS_859846/lang-en/index.htm

ашиг, хөдөлмөрийн нөхцөл байдалд хууль эрх зүйн орчин, хөдөлмөрлөх нөхцөлөөр эрх тэгш хангах шаардлагатай гэж ОУХБ-аас мэдэгдэж байна.

2020 оны байдлаар дэлхийн хэмжээнд газрын тос, байгалийн хийн олборлолт, боловсруулалтад 511 тэрбум ам долларын хөрөнгө оруулалт зарцуулсан нь энэ салбарын олборлолт, боловсруулалт, үйлдвэрлэл нь өндөр технологи, мэргэшсэн ажиллах хүч, ихээхэн хөрөнгө оруулалт шаарддаг болохыг харуулж байна. Тиймээс сүүлийн үеийн шинэ технологид суурилсан дижиталчилсан үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд байгалийн хийн үйлдвэрлэл, боловсруулах үйл ажиллагаанд хөдөлмөрлөх олон хүчин зүйлийг хэмнэх үүднээс робот, электрон хэрэгслийг ашиглаж эхлээд байна.

Төр хувийн хэвшлийн түншлэл

Газрын тос, байгалийн хийн салбарт хувийн, төрийн, төрийн өмчийн хязгаарлагдмал болон үндэстэн дамнасан томоохон аж ахуйн нэгжүүд зонхилдог. Энэ нь төр хувийн хэвшил хамтарч дотоодын нийт бүтээгдэхүүнийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байна. Тухайлбал, Мексик Улс газрын тосны үйлдвэрлэлээ үндэсний баялаг гэж үзэн төрийн мэдэлд авснаар олон тооны төрийн өмчит компаниуд байгуулагдаж тэдний хувьцааг бусад улс орнууд ихээр худалдан авах болсон.

Эрчим хүчний эх үүсвэр

ОУХБ-ын нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулах, хязгаарлах үндэсний стратегийн нэг хэсэг болгон эрчим хүчний шилжилт буюу чулуужсан нүүрснээс нүүрстөрөгчийн хийгүй эрчим хүч рүү шилжүүлэх, мөн сэргээгдэх эрчим хүч болох ногоон эрчим хүчний эх үүсвэрт шилжихийг гишүүн орнууддаа уриалж байна.

Байгалийн хий нь нарны болон салхины эрчим хүчний үүсвэр буурахад нөөцийг хурдан хугацаанд нөхөж, гэнэтийн эрэл хэрэгцээнд эрчим хүчийг түргэн хугацаанд нөхөж, сэргээгдэх эрчим хүчийг дэмжихэд тусалдаг байна.

Мөн усан цахилгаан станцад доголдол гарах хур тунадас багатай үед байгалийн хий нь цахилгаан эрчим хүчийг найдвартай хангаж нөхөж чаддаг байна.

Эдийн засгийн үр ашигтай нөлөө

Байгалийн хийн үйлдвэрлэл, тээвэрлэлт, хэрэглээг нэмэгдүүлэх нь улс орны эдийн засагт цаашлаад дотоодын нийт бүтээгдэхүүнд маш их нөлөө үзүүлнэ. Хийн үйлдвэрлэлийг дотооддоо үйлдвэрлэснээр:

- Эрчим хүчний тогтвортой эх үүсвэр болсноор эрчим хүчний үнэ буурч инфляц буурна;
- Уул уурхайн олборлолт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн боловсруулах зэрэг олон үйлдвэрүүд байгалийн хийг эрчим хүчний үндсэн эх үүсвэрээ болгон үйлдвэрлэл явуулах;
- Аж үйлдвэрүүд нэмэгдсэнээр ажлын байр нэмэгдэх, жижиг дунд үйлдвэрлэл хөгжих;
- Эрчим хүчний эх үүсвэрээс гадна хөдөө аж ахуйн олон салбарын тоног төхөөрөмжид байгалийн хийг хэрэглэж байгаа нь жижиг дунд аж үйлдвэрлэл эрхлэгчдэд үр ашигтай;
- Хийн түлшний хэрэглээ ихэссэнээр ачаа тээвэр, тээвэрлэлтийн зардал буурч, бараа бүтээгдэхүүний үнэ буурах;
- Цахилгаан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл үйлдвэрлэгдсэнээр үргүй зардал багасах зэрэг ач холбогдолтой байна.

АНУ нь газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлдэг улс юм. 2022 оны байдлаар байгалийн хийн үйлдвэрлэл нь 4%-р (өдөрт 4.9 тэрбум шоо фут, дунджаар 119 Bcf/d) өссөн үзүүлэлттэй байна.

- *Эрчим хүч* – Байгалийн хий нь эрчим хүчний 80%-ийг хангадаг;
- *Ажлын байр* – Газрын тос, байгалийн хийн салбар нь 12.3 сая ажлын байр бий болгох;
- *Дэд бүтэц* – 2012-2025 оны газрын тос байгалийн хийн салбарын үйлдвэрлэлээс сургууль, эмнэлэг, олон нийтийн үйлчилгээний байгууллагын дэд бүтэц, засвар үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх;
- *Гэр бүлийн төсөвт хэмнэлт үзүүлэх* – газрын тос, байгалийн хийн олборлолт нь АНУ-ын иргэдэд ойролцоогоор 203 тэрбум доллар (4 ам бүлтэй гэр бүлд 2500 доллар) хэмнэх;
- *Худалдааны алдагдал* – 2019 онтой харьцуулахад байгалийн хийн үйлдвэрлэснээр худалдааны алдагдал 305 доллароор бага;
- *Байгалийн хийн нийлүүлэлт* – Байгалийн хийн нийлүүлэлтээс шалтгаалан эрчим хүчний зардлыг бууруулснаар хувийн хэвшлийнхэнд төрөөс үзүүлэх том дэмжлэг болох;
- *Эрчим хүчний үнийн бууралт* – АНУ нь эрчим хүчнийхээ 4/1-ийг үйлдвэрлэлд зарцуулдаг учраас эрчим хүчний үнийн бууралт нь үйлдвэрлэлийн салбарт 630,000 ажлын байранд дэмжлэг үзүүлэх;
- *Байгалийн хийн үнэ нөөцийн хүртээмжтэй байдал* – Байгалийн хийн үнэ тогтвортой, нөөц хүртээмжтэй байх нь олон шинэ үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийн шинээр ажлын байр бий болгох явдал нь эдийн засагт ихээхэн дэмжлэг үзүүлж байна.

Байгалийн хийн үйлдвэрлэл нэмэгдсэнээр бордоо, химийн бодис, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж илүү олон ажлын байр бий болж байна. Мөн хямд тогтвортой байгалийн хийн эрчим хүчний үүсвэрээр үйлдвэрлэгчид ажлын байраа хадгалж үлдэх, түлшний доголдлоос болж барилга байгууламж барих, нүүлгэн шилжүүлэлт гэх мэт асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж байна. Тухайлбал, Техас, Пенсильвани мужуудад байгалийн хийн нөлөөгөөр сүүлийн нэг жилд 200 мянга гаруй ажлын байр шинээр бий болж, 5.46 сая ам. долларын шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Ингэснээр татварын орлогод ч хувь нэмрээ оруулдаг. Америкт дизель түлшээр явдаг 8 сая хүнд даацын машиныг хийн түлшээр сольсноор ачаа тээвэр, тээврийн зардал буурч худалдааны салбарт эерэг өөрчлөлт гарч байна.

Эдийн засгийн сөрөг нөлөө


Байгалийн хий нь бус нутгаас хамааралтай бүтээгдэхүүн учраас нөөц баялаг ихтэй улс орнуудын нөөц, үйлдвэрлэл, боловсруулалт, тээвэрлэлтийн шударга бус өрсөлдөөн, эрэлт нийлүүлэлтээс шалтгаалах дэлхийн зах зээлийн хийн үнэ зэргээс шалтгаалан зарим орны эдийн засагт хараат байдал үүсгэдэг. Тухайлбал, байгалийн хийн томоохон экспортлогч Оросын Холбооны Улс (ОХУ)²⁵⁸ нь сүүлийн жилүүдэд байгалийн хийн экспортын зах зээлээ тэлж, тэр дундаа шингэрүүлсэн байгалийн хий (LNG) экспортолж байна. 2020 онд байгалийн хийн 78% нь Европ, 11% нь Ази, 11% нь бусад улс руу экспортолсон байна. Байгалийн хийн орлого нь 2021 онд төлөвлөгөөгөө 51.3%-р даван биелүүлж, нийт 9.1 их наяд рубль буюу 119 тэрбум долларт хүрсэн байна. Европын хувьд ОХУ-ын байгалийн хийн салбар нь газрын тосны салбараас илүү геополитикийн ач холбогдолтой юм. Тус улсын экспортын хамгийн том зах зээл болох Европ руу байгалийн

²⁵⁸ The Role of Russian Natural Gas <https://crsreports.congress.gov/product/pdf/IN/IN11900>

хийн ихэнх хэсгийг дамжуулах хоолойгоор дамжуулж Европын байгалийн хийн нийлүүлэлтийн уян хатан байдлыг хязгаарладаг. Европын зарим улсууд ОХУ-ын байгалийн хийн импортоос бүрэн хамааралтай байдаг бөгөөд ОХУ нь байгалийн хийн үнэ болон нийлүүлэлтээ хэрэглэгч орнуудтай харилцах харилцаандаа ашиглах, гэрээний хэлэлцээрт хөшүүрэг болгох явдал байдаг.

Зураг 8. 2020-2040 он хүртэлх ОХУ-ын байгалийн шингэрүүлсэн хийн дамжуулах гэрээ

Figure I. Russian Natural Gas Contracts



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Байгалийн хий улсаар <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>
- Organization of the Petroleum Exporting Countries https://www.opec.org/opec_web/en/about_us/25.htm
- Global Methane Pledge Energy Pathway (GMP) https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP_22_3793
- COP26 <https://www.globalmethanepledge.org/>
- COP27 <https://cop27.eg/#/>
- Байгалийн хийн хамгийн том нөөцтэй 10 улс 2020 <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>
- Хамгийн их байгалийн хий олборлодог 10 улс 2021 <https://investingnews.com/top-natural-gas-producers/>
- Байгалийн хий хамгийн их хэрэглэдэг 10 улс <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>
- 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаралтын эх үүсвэр <https://www.iea.org/data-and-statistics/charts/sources-of-methane-emissions-2021>
- 2021 онд дэлхийн хэмжээнд хүний үйл ажиллагаанаас алдагдсан метан хий <https://www.iea.org/reports/global-methane-tracker-2022/overview>
- 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаруулалтаараа тэргүүлсэн орнууд / <https://www.iea.org/reports/global-methane-tracker-2022/overview>
- 2021 онд дэлхийн хэмжээнд метан хийн ялгаруулалт бүс нутгаар <https://www.iea.org/data-and-statistics/charts/global-energy-related-methane-emissions-by-region-reported-to-the-unfccc-and-estimates-from-the-iea-2021>
- Газрын тос, байгалийн хийн хөрөнгө оруулалт-OIL AND GAS INVESTING-*англиар* <https://investingnews.com/top-natural-gas-producers/>
- Конгрессын номын сан, Газрын тос ба хийн салбар: Судлаачийн гарын авлага, Урсгалын эх: Үйлдвэрлэл ба олборлолт-Library of Congress, Oil and Gas Industry: A Research Guide, Upstream: Production and Exploration-*англиар* <https://guides.loc.gov/oil-and-gas-industry/upstream>
- Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн салбарт ашиглаж буй ISO-стандартууд-ISO Standards for use in the oil & gas industry-*англиар*
- Байгалийн хий-Natural Gas-*англиар* <https://worldpopulationreview.com/country-rankings/natural-gas-by-country>
- Газрын тос ба байгалийн хийн аж үйлдвэрийн стандартууд-OIL & GAS INDUSTRY STANDARDS-*англиар* <https://www.nqa.com/en-gb/certification/sectors/oil-gas>
- ISO 20815:2018 Нефть, нефть хими болон байгалийн хийн аж үйлдвэр-Үйлдвэрлэлийн итгэмжлэл ба найдвартай ажиллагааны удирдлага-ISO 20815:2018 Petroleum, petrochemical and natural gas industries — Production assurance and reliability management-*англиар* <https://www.iso.org/standard/69983.html>
- Олон улсын хөдөлмөрийн стандартууд-International Labour Standards-*англиар* <https://www.ilo.org/inform/online-information-resources/research-guides/economic-and-social-sectors/energy-mining/oil-gas-production/lang--en/index.htm>
- Г.Алтан-Оч, Д.Халиун СТ-21/236 “Газрын тосны харилцааны эрх зүйн зохицуулалт, бусад орнуудын туршлага” 2021
- ISO Standards for use in the oil & gas industry-*англиар* [https://committee.iso.org/files/live/sites/tc67/files/ISO%20Standards%20for%20use%20in%20oil%20%26%20gas%20industry%20\(A3%20Poster\).pdf](https://committee.iso.org/files/live/sites/tc67/files/ISO%20Standards%20for%20use%20in%20oil%20%26%20gas%20industry%20(A3%20Poster).pdf)
- Байгалийн хийн олборлолт байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл-<https://group.met.com/en/mind-the-fyouture/mindthefyouture/natural-gas-environmental-impact>
- Байгалийн хий олборлолт - <https://www.linquip.com/blog/is-natural-gas-a-fossil-fuel/>

- Метаны олборлолт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл-
<https://www.bridgerphotonics.com/blog/how-does-methane-affect-environment>
- Метаны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл-<https://www.qedenv.com/en-us/markets-solutions/oil-and-gas/commercial-gas-leak-detection/what-are-the-dangers-of-methane-gas/>
- The future of work in the oil and gas industry 2022
https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_dialogue/---sector/documents/publication/wcms_859846.pdf
- International Labour Organization
https://www.ilo.org/sector/Resources/publications/WCMS_859846/lang--en/index.htm
- Advantages&Disadvantages of natural Gas <https://environmental-conscience.com/natural-gas-pros-cons/>
- Statistical Review of World Energy 2021
<https://www.bp.com/content/dam/bp/business-sites/en/global/corporate/pdfs/energy-economics/statistical-review/bp-stats-review-2021-full-report.pdf>
- The Role of Russian Natural Gas
<https://crsreports.congress.gov/product/pdf/IN/IN11900>

**МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ХҮНСНИЙ НОГООНЫ ДОТООДЫН
ХЭРЭГЦЭЭ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗООРЬ, АГУУЛАХЫН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

Ц.Норовдондог (Ph.D.), О.Билгүүтэй

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

1. Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногооны дотоодын жилийн хэрэгцээ
2. Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний экспорт
3. Монгол Улсын импортын хүнсний ногоо
4. Ногоо, хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахын мэдээлэл
5. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

ХАВСРАЛТ

Мах, махан бүтээгдэхүүний экспорт, мян.тн /нэр төрлөөр/

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн судалгааны захиалгын дагуу “Мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногооны дотоодын хэрэгцээ, хүнсний бүтээгдэхүүний зорь, агуулахын талаарх мэдээлэл, лавлагаа”-г Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж буй асуудлуудтай холбогдуулан захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын хэмжээнд мах, махан бүтээгдэхүүний экспорт, хүнсний ногооны импорт, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зорь, агуулахын хангамжийн талаар судлах.

Хамрах хүрээ:

1. Монгол Улсын хэмжээнд мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногооны дотоодын жилийн хэрэгцээ;
2. Монгол Улсын хэмжээнд мах, махан бүтээгдэхүүний экспорт;
3. Монгол Улсын импортын хүнсний ногоо;
4. Монгол Улсын хэмжээнд мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, хүнсний бүтээгдэхүүний зорь, агуулахын мэдээлэл;
5. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар өнгөрсөн хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудын хүрээнд мэдээллийг цуглуулсан болно.

Дээрх мэдээлэл лавлагааг Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик мэдээлэл, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам, Гаалийн ерөнхий газраас гаргасан статистик мэдээллүүд болон холбогдох цахим сайтуудын мэдээлэлд тулгуурлан бэлтгэв.

Түлхүүр үг: *Мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногооны дотоодын хэрэгцээ, хүнсний зорь агуулах.*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Үндэсний Статистикийн Хорооноос 2021 онд гаргасан “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд” судалгааны тайланд дурдсанаар Монгол Улсын хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой **хэрэгцээ 2021 оны** байдлаар улсын хэмжээнд жилд нийтдээ **мах, махан бүтээгдэхүүн 186.0 мянган тонн, хүнсний ногоо 254.6 мянган тонн** байхаар тооцсон.²⁵⁹

Үүнээс 2021 онд улсын хэмжээнд дотооддоо **512.4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 121.7 мянган тонн хүнсний ногоо** үйлдвэрлэсэн байна.

Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээний дотоодын үйлдвэрлэлийн хангамжийг авч үзвэл, сүүгээр 100.0 хувь, төмсөөр 99.9 хувь, гурилаар 98.7 хувь, мах, махан бүтээгдэхүүнээр 95.4 хувь, хүнсний ногоогоор 61.6 хувийг тус тус хангасан байна.

Монгол Улсын мал сүргийн тоо сүүлийн 5 жил дунджаар 3.8 хувиар өсөж, 2022 онд **71.3 саяд** хүрсэн. Үүний 15 сая толгой мал буюу дунджаар 20 хувийг нь хүнсэнд хэрэглэж, эдийн засгийн эргэлтэнд оруулдаг байна. Аймаг, орон нутгаас ирүүлсэн судалгаагаар 2022-2023 онд хүн амын хэрэгцээнд 12.8 сая толгой мал буюу **387.9 мян.тн мах нийлүүлж**, нийт мал сүргийн 9.1 хувь буюу **186.0 мянган тонн махыг** экспортлох боломжтой гэсэн байна.

Хүнсний хангамжийн эх үүсвэрийн тухайд Монгол Улсын гол нэрийн 16 хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг 2020 оны байдлаар авч үзвэл **57.9 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 42.1 хувийг импортоор** тус тус хангасан нь өмнөх оноос 0.6 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Олон улсын практикт хүнсний хангамжийн баталгаат байдлыг “хүнсний бие даасан байдал”-ын итгэлцүүрээр, өөрөөр хэлбэл, хэрэглэсэн нийт гол нэрийн бүтээгдэхүүний хэмжээнд импортын эзлэх хувийн жингээр авч үздэг бөгөөд манайд импортын хангамж 40 хувиас илүү байгаа учраас “хүнсний бие даасан байдал” алдагдсан хэмээх ангилалд багтсан байна. Импортоор төрлөөр авч үзвэл, төрөл бүрийн будаа, ургамлын тос, загас-100.0 хувь шувууны мах- 96.5 хувь, жимс, жимсгэнэ- 96.4 хувь байгаа нь хүнсний бүтээгдэхүүн импортод хамгийн өндөр хувийг эзэлж байна.²⁶⁰

Монгол Улсын хэмжээнд төмс, хүнсний ногооны зоорь, агуулах **7300** байх ба нийт багтаамж нь **253.8 мянган тонн** байна. Үүнээс 5100 нь нүхэн зоорь (60.4 мянган тонн багтаамжтай), 2100 нь энгийн зоорь (128.8 мянган тонны багтаамжтай), 59 нь механикжсан агуулах (66.1 мянган тонн багтаамжтай) байна.

Үүнээс Улаанбаатар хотод нийт 84 мянган тонн багтаамжтай 100 гаруй зоорь, агуулах ашиглагдаж байгаагийн 60.1 мянган тонн нь механикжсан агуулах байгаа юм.²⁶¹

Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд дараах стратегийн томоохон зорилт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол малын махны ач тусыг олон улсад сурталчлан таниулж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлэх (“АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого),
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг

²⁵⁹ Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд 2021 он. Монгол улсын үндэсний статистикийн хороо.

²⁶⁰ АУДИТ: Монгол Улсын гол нэрийн хүнсний импорт нийтлэл (2022)

²⁶¹ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам: Агуулах, зоорь, элеватор, үтрэмийн хангамж, ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн А.Бямбадорж (Нийтлэл)2022,

- орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих
(*Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр*)
- Импортлогч улсын холбогдох яам, мэргэжлийн газруудтай мал экспортлох гэрээ, хэлцэл хийж, орон нутгийн байгууллагуудыг бодлого, зохицуулалтаар дэмжих
(*Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2017 оны 318 дугаар тогтоол*)
 - Сүүний урамшуулалтай ижил үндэслэлээр нөөцийн мах бэлтгэлд урамшуулал, хүүгийн хөнгөлөлтийн татаас олгох (*Хүнсний тухай хуулийн 8-р зүйлд заасан мах бэлтгэлийн урамшуулал*)
 - “Монгол экспорт хөтөлбөр” (Засгийн газраас 2018-2022 онд хэрэгжүүлсэн) зэрэг үйл ажиллагаануудыг дурдаж болохоор байна.²⁶²

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.)

²⁶² Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн яам, салбарын бодлого, <https://www.mofa.gov.mn/branch/huns/616fa65373bc4a5fc70f2225>

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

МОНГОЛ УЛСЫН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН, ХҮНСНИЙ НОГООНЫ ДОТООДЫН ЖИЛИЙН ХЭРЭГЦЭЭ


Хүнсний хангамжийг улсын хэмжээнд тодорхойлоходоо тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулна.

Жишсэн хүн ам гэж насны бүлэг тус бүрийн хүний тоог шилжүүлэх итгэлцүүр ашиглан ижил түвшний дундаж хүнд шилжүүлэн тооцсон хүн амыг ойлгоно.

Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ гэж жишсэн хүний хоногийн хэрэгцээг (зөвлөмж хэмжээг) 365 хоногоор үржүүлсэнтэй тэнцүү хэмжээг ойлгоно.²⁶³

Монгол Улсын хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой **хэрэгцээг 2021 оны** байдлаар улсын хэмжээнд жилд **мах, махан бүтээгдэхүүн 186.0 мянган тонн**, сүү 156.7 мянган тонн, сүүн бүтээгдэхүүн 176.2 мянган тонн, гурил 97.9 мянган тонн, гурилан бүтээгдэхүүн 176.2 мянган тонн, будаа 49.0 мянган тонн, сахар, чихрийн зүйл 32.3 мянган тонн, төмс 117.5 мянган тонн, **хүнсний ногоо 254.6 мянган тонн**, буурцагт ургамал 39.2 мянган тонн, жимс, жимсгэнэ 195.8 мянган тонн, өндөг 19.6 мянган тонн, ургамлын тос 22.5 мянган тонн, цөцгийн тос 9.8 мянган тонн байхаар тооцоолсон байна.²⁶⁴

Зураг 1. Жишсэн хүн амын хүнсний хэрэгцээ мянган тонн



Жишсэн хүн амын хүнсний бүтээгдэхүүний **малын махны** жилийн хэрэгцээ 2020 онд 115.2 мянган тонн байсан бол 2021 онд **117.5 мянган тонн** болон нэмэгдсэн байна. Харин хүнсний ногооны хувьд 2020 онд 249.6 мянган тонн байсан бол 2021 онд **254.6 мянган тонн** болон өссөн байна.

²⁶³ Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал.

²⁶⁴ Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд 2021.

Хүснэгт. 1 Жишсэн хүн амын хүнсний хэрэгцээ

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ	Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ				
		2017	2018	2019	2020	2021*
	килограмм	мянган тонн				
Мах, махан бүтээгдэхүүн	69.4	176.2	178.7	179.2	182.4	186.0
Малын мах	43.8	111.3	112.9	113.2	115.2	117.5
Загас	11.0	27.8	28.2	28.3	28.8	29.4
Шувууны мах	14.6	37.1	37.6	37.7	38.4	39.2
Сүү	58.4	148.4	150.5	150.9	153.6	156.7
Сүүн бүтээгдэхүүн	65.7	166.9	169.3	169.7	172.8	176.2
Гурил, гурилан бүтээгдэхүүн	102.2	259.7	263.4	264.0	268.8	274.2
Гурил	36.5	92.7	94.1	94.3	96.0	97.9
Гурилан бүтээгдэхүүн	65.7	166.9	169.3	169.7	172.8	176.2
Төрөл бүрийн будаа	18.3	46.4	47.0	47.1	48.0	49.0
Төмс	43.8	111.3	112.9	113.2	115.2	117.5
Хүнсний ногоо	94.9	241.1	244.6	245.2	249.6	254.6
Буурцагт ургамал	14.6	37.1	37.6	37.7	38.4	39.2
Жимс, жимсгэнэ	73.0	185.5	188.1	188.6	192.0	195.8
Өндөг	7.3	18.5	18.8	18.9	19.2	19.6
Ургамлын тос	8.4	21.3	21.6	21.7	22.1	22.5
Цэцгийн тос	3.7	9.3	9.4	9.4	9.6	9.8
Сахар, чихрийн зүйл	12.0	30.6	31.0	31.1	31.7	32.3

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

1.1 ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Дотоодод 2021 онд улсын хэмжээнд 705.0 мянган тонн сүү, **512.4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн**, 218.2 мянган тонн гурил, гурилан бүтээгдэхүүн, 182.6 мянган тонн төмс, **121.7 мянган тонн хүнсний ногоо**, 118.5 мянган тонн сахар, чихрийн зүйл, 10.4 мянган тонн өндөг, 2.4 мянган тонн жимс, жимсгэнэ, 0.3 мянган тонн цэцгийн тос, 0.3 мянган тонн ургамлын тос үйлдвэрлэсэн байна.²⁶⁵

Хүснэгт. 2 Дотоодын хүнсний үйлдвэрлэл, биет хэмжээгээр, тонн

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	2020		2021*		Өсөлт, бууралт, % Дотоодын үйлдвэрлэл
	Дотоодын үйлдвэрлэл	Экспорт	Дотоодын үйлдвэрлэл	Экспорт	
Мах, махан бүтээгдэхүүн	744 261.8	20 664.6	512 424.3	9 857.3	-31.1
Малын мах	743 689.4	20 630.9	512 178.5	9 857.3	-31.1
Загас	33.7	33.7	0.0	0.0	-
Шувууны мах	538.7	0.0	245.8	0.0	-54.4
Сүү	776 293.8	0.0	704 974.4	0.0	-9.2
Сүүн бүтээгдэхүүн	82 708.4	481.0	84 479.7	339.6	2.1
Гурил, гурилан бүтээгдэхүүн	235 292.8	20.3	218 158.7	12.0	-7.3

²⁶⁵ Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд 2021 он.

Төрөл бүрийн будаа	0.0	0.0	0.0	0.0	-
Төмс	244 261.6	0.0	182 638.2	0.0	-25.2
Хүнсний ногоо	121 235.2	84.0	121 743.4	0.0	0.4
Буурцагт ургамал	36.4	0.0	50.5	0.0	38.6
Жимс, жимсгэнэ	1 665.4	33.6	2 421.7	25.4	45.4
Өндөг	8 482.5	0.0	10 356.9	0.0	22.1
Ургамлын тос	17.2	0.0	307.5	0.0	17.9'
Цөцгийн тос	250.2	0.3	256.6	0.1	2.6
Сахар, чихрийн зүйл	126 606.4	37.5	118 457.7	8.0	-6.4

Эх үүсвэр: ҮСХ, ГЕГ, * Урьдчилсан гүйцэтгэл, ' дахин их

¹Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн тооцоонд 2015 оны суурьт шилжсэнээс сүү, махны тооцоог засварласан. Махны үйлдвэрлэлд дайвар бүтээгдэхүүнийг нэмсэн.

Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн сүүгээр 100.0 хувь, төмсөөр 99.9 хувь, гурилаар 98.7 хувь, мах, махан бүтээгдэхүүнээр 95.4 хувь, хүнсний ногоогоор 61.6 хувийг хангаж байна. Манай улс 2021 оны нийт хүнсний бараа бүтээгдэхүүний импорт 963 сая америк доллар байгаа бөгөөд 57.3 хувийг Европын орнууд, үүнээс 35.8 хувийг ОХУ бүрдүүлжээ.

2021 онд шоколад ба какао агуулсан хүнсний зүйлийн 89.1 хувийг, усан үзмийн дарсны 82.2 хувийг, чихрийн зүйлсийн 80.9 хувийг, жимс, жимсгэнийн 50.1 хувийг Европын орнуудаас импортоор авчээ. ОХУ нь улаан буудай, өндөг, ургамлын тос, маргарин, гахайн мах зэрэг бүтээгдэхүүний импортод дунджаар 92 хувийг бүрдүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ


Монгол Улсын мал сүргийн тоо сүүлийн 5 жил дунджаар 3.8 хувиар өсөж, 2022 онд 71.3 саяд хүрсэн. Үүний 15 сая толгой мал буюу дунджаар 20 хувийг нь хүнсэнд хэрэглэж, эдийн засгийн эргэлтэд оруулдаг байна.

Аймаг, орон нутгаас ирүүлсэн судалгаагаар 2022-2023 онд хүн амын хэрэгцээнд 12.8 сая толгой мал буюу **387.9 мян.тн махыг нийлүүлж**, нийт мал сүргийн 9.1 хувь буюу **186.0 мянган тонн мах** экспортлох боломжтой гэжээ.²⁶⁶

Монгол Улс КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн улмаас өмнөх хоёр жилд 129 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолж байсан бол цар тахлын хязгаарлалт, тэвэр логистикийн хүндрэл, эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалан энэ хэмжээ 45 хувиар буурч **2020 онд 38.8 мянган тонн, 2021 онд 21.8 мянган тонн, 2022 онд 16.0 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг** 43 аж ахуйн нэгж 10 улсад экспортолжээ.

²⁶⁶ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Зураг 2. Мах, махан бүтээгдэхүүний экспорт



Коронавируст халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны 06 дугаар сараас эхлэн БНХАУ мах, махан бүтээгдэхүүний экспортыг хязгаарласан боловч Монгол Улсын Гадаад харилцааны яам БНХАУ-ын эрх бүхий байгууллагатай олон удаагийн яриа, хэлцэл хийсний дүнд БНХАУ-ын Гаалийн ерөнхий газартай “Нэмэлт гэрчилгээ”-ний загварыг тохирчээ. Үүний үр дүнд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн экспорт сэргэж, Гаалийн ерөнхий газрын мэдээгээр 2023 оны эхний сард 0.9 мянган тонн адууны мах, 0.8 мянган тонн дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн, нийт 1.7 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортолсон байна. Цаашид мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гуравдагч орны зах зээлд шинээр нэвтрэх зорилгоор Ойрх Дорнод болон Зүүн Өмнөд Азийн улсын зах зээлийг судалж, мах, махан бүтээгдэхүүн экспортолж нөхцөлийг тохирох чиглэлээр ажиллаж байгаа ба 2022 онд 5 улсад 3.9 мянган тонн хонь, ямааны мах экспортолжээ.

МОНГОЛ УЛСЫН ИМПОРТЫН ХҮНСНИЙ НОГОО

Хүнсний үйлдвэрлэлийн салбар

Монгол Улсын *Засгийн газрын тухай хуулиар* Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн *сайдын эрхлэх асуудлын хүрээнд* хамаарах чиг үүрэгт хүн амын хүнсний хангамжийн бодлого, хүнсний аюулгүй байдлын асуудал харьяалагддаг.

УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан *Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого-д* хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, **импортыг орлох хүнсний үйлдвэрлэлийг** дэмжих зорилтуудыг дэвшүүлсэн.

Түүнчлэн *ХХААХУ-ийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө* нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг салбарын түвшинд нарийвчлан тусгаж, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна. Тус стратеги төлөвлөгөөнд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг

оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, **импортыг орлох**, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.


Хүнсний хангамжийн эх үүсвэрийн тухайд Монгол Улсын гол нэрийн 16 хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг 2020 онд **дотоодын үйлдвэрлэлээр 57.9 хувийг, импортоор 42.1 хувийг** тус тус хангасан нь өмнөх оноос 0.6 нэгж хувиар буурсан байна.

Гол нэрийн 6 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа боловч **импортын хамаарал 42.1 хувь** буюу хүнсний бие даасан байдал алдагдсан хэвээрээ байгаагийн илрэл юм.

Олон улсын практикт хүнсний хангамжийн баталгаат байдлыг “хүнсний бие даасан байдал”-ын итгэлцүүрээр, өөрөөр хэлбэл хэрэглэсэн нийт гол нэрийн бүтээгдэхүүний хэмжээнд импортын эзлэх хувийн жингээр дараах 3 түвшинд үнэлдэг байна. Тухайлбал:

- Импорт 10-20 хувь “хүнсний бие даасан байдал” хангагдсан;
- Импорт 25-30 хувь бол “хүнсний бие даасан байдал” эрсдэлтэй;
- Импорт 40-хувиас илүү бол “хүнсний бие даасан байдал” алдагдсан гэж үнэлдэг.


Зураг 3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын хамаарал (2020 оноор)



Эх сурвалж: Үндэсний аудитын газар

Импортоор төрөл бүрийн будаа, ургамлын тос, загасыг 100.0, шувууны махны 96.5, жимс, жимсгэнийн 96.4, цэцгийн тосны 51.4, өндөгний 49, сүүн бүтээгдэхүүний 39.1, хүнсний ногооны 39.3, гурилан бүтээгдэхүүний 35.2, сахар, чихрийн зүйлсийн 34.4 хувийг тус тус хангаснаас үзэхэд манай улсын гол нэрийн 16 бүтээгдэхүүний импортын хамаарлын түвшин 42.1 хувь буюу “хүнсний бие даасан байдал” алдагдсан ангилалд байна.

Зураг 4. Хүнсний импортын гол нэрийн бүтээгдэхүүн



Эх сурвалж: Үндэсний аудитын газар

ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ИМПОРТЛОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хүнсний түүхий эд болон бүтээгдэхүүн импортлох эрх зүйн харилцааг Хүнсний тухай хууль болон олон улсын Женевийн конвенцод тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд зохицуулж байна. Үүнд:

- Женевийн конвенц: "Чанарын шаардлагын хяналт" гэж ачаа нь холбогдох хууль тогтоомж, журмаар тогтоосон олон улсын болон үндэсний чанарын наад захын үзүүлэлтийг хангасан байх;
- Хүнсний тухай хууль: "Хүнсний чанар" гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний стандарт, техникийн зохицуулалтын болон хэрэглээний шаардлага хангасан байх;
- Боомтын хяналт шалгалтын бүсэд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, экспорт, импортын хүнсний түүхийн эд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, холбогдох хууль тогтоомж, олон улс, бүс нутаг, үндэсний стандартын үзүүлэлт, шаардлагыг хангуулах.

Хүснэгт 3. Баримт бичгийн хяналт

№	Шаардлагатай баримт бичгийн жагсаалт	Хуулийн заалт	Шаардлага
"Хүнсний тухай" хуулийн 11 дүгээр зүйл. Хүнс экспортлох, импортлоход тавигдах шаардлага			
1	Улсын бүртгэлийн гэрчилгээтэй, хуулийн этгээд байх	11.1.Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортолж, импортлоно.	Иргэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлохгүй.
2	Худалдааны гэрээ	11.2.1.Экспортлогч улсын үйлдвэртэй шууд, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай	Худалдааны гэрээнд тоо, ширхэг үнийн дүн байхаас гадна бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа, сав баглаа боодлын стандартын шаардлага, тээвэрлэлтийн горим баримтлах, тээврийн хэрэгслийн

		худалдааны гэрээ байгуулсан байх;	ариун цэвэр, тээвэрлэлтийн үеийн тэмдэглэл бүртгэлийн талаар тусгасан байх
3	Чанар, стандарт, зохистой дадал, удирлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан баримт. (НАССР, GMP, GHP, ISO)	11.2.2.Импортлох хүнс нь зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан байх;	Олон улсын стандартчиллын байгууллага ISO 2200:2018: Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (ISO 22000) нь хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд үйл ажиллагаа явуулдаг аливаа хуулийн этгээдийн хүнсний аюулгүй байдлыг ханган, хүнсний аюулгүй байдлын агуулуудыг хянаж, улмаар зах зээлд нийлүүлэх хүнс аюулгүй, найдвартай гэдгийг баталж, тасралтгүй сайжруулалтыг нэвтрүүлэхэд чиглэгдэнэ.
4	Бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа баримт бичиг, шошгод мэдээлэх	11.2.2.Импортлох хүнсний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байх;	Монгол улсын хилээр нэвтрүүлэх үед хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байх ёстой. Жишээ нь: Үйлдвэрлэгдсэн хугацаа 2018 Дуусах хугацаа 2021 Импортоор орж ирэхдээ 2 жилийн хүчинтэй хугацаатай байна гэсэн үг.
5	Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан тээврийн хэрэгслийн баримт.	11.2.4.Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;	Авто тээврийн хэрэгслийн техникийн ерөнхий шаардлага хангасан /MNS 4598:2020/ халуун, хүйтнийг тохируулах боломжтой зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх.
6	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд бүртгүүлсэн байна.	11.3.Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн байх;	Бүртгүүлээгүй бол импортлохыг хориглоно
“Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 13 дугаар зүйл. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн			
7	Экспортлогч улс, үйлдвэрлэгчээс хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийсэн шинжилгээний дүн	13.2.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага хангасан байна.	Шинжилгээний дүн нь Монгол Улс, олон улсын стандарт, техникийн зохицуулалттай нийцэж байх

НОГОО, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗООРЬ, АГУУЛАХЫН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хэмжээнд нийт 253.8 мянган тонн багтаамж бүхий төмс, хүнсний ногооны 7300 зоорь, агуулах байна. Үүнээс 60.4 мянган тонн багтаамж бүхий 5100 нүхэн зоорь, 128.8 мянган тонны багтаамж бүхий энгийн зоорь 2100, 66.1 мянган тонн багтаамж бүхий 59 ширхэг механикжсан агуулах байна. Үүнээс Улаанбаатар хотод нийт 84 мянган тонн багтаамж бүхий 100 гаруй зоорь, агуулах ашиглагдаж байгаагийн 60.1 мянган тонн нь механикжсан агуулах байгаа юм.

Улаанбаатар хот орчмын төмс, хүнсний ногооны зоорийн түрээс одоогийн байдлаар сард 30-100 мянган төгрөгийн үнэтэй байна. Нийт зоорийн 60 хувь нь чанарын сайн үзүүлэлттэй, 40 хувь нь чанарын дундаас доогуур үнэлгээтэй байна. Манай улс хүнсний ногооны хувьд дотоодын үйлдвэрлэлээс 55-60 хувийг хангаж бусад хувийг импортоор авч байна.

Төмс, хүнсний ногооны хангамж, ашиглалтын байдлын бүртгэл судалгааг захиргааны статистик мэдээлэл цуглуулах арга хэмжээний хүрээнд нийслэл болон орон нутгаас авдаг байна. Хураан авсан ургацаа нөөцлөх боломжтой боловч хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдэх, хүн амын хэрэглээ өсөж байгаатай холбогдуулан Монгол Улсад нэмэлтээр 55 мянган тонн буюу нийт 309 мянган тонны багтаамжтай агуулах, зоорь шаардлагатай байна.

2022-2025 онд агуулах зоорийн хангамжийг нийслэл болон 21 аймагт 500-2500 тонны 55 мянган тонн багтаамжтай иж бүрэн механикжсан агуулахыг байгуулахаар “Хүнсний хангамж аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” төлөвлөгөөнд оруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнээс 2022-2023 онд Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын 10.2 сая еврогын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийслэл болон зургаан аймагт нийт 8000 тонн багтаамжтай иж бүрэн механикжсан агуулахыг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.²⁶⁷

“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр

“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийг Монголбанкны Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын хамтарсан санамж бичгийн дагуу Монголбанк, ХХААЯ хоорондын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-166/А/24 дугаар хамтарсан тушаалаар 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан. Үүний дагуу Монголбанк, банк хооронд хөтөлбөрийн зээлийн гэрээг 2013 оны 11 дүгээр сард байгуулж, санхүүжилт олгож эхэлсэн.

Дээрх хөтөлбөрийг зоорь, агуулахын тоо хэмжээг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн.

ХХААЯ-наас энэхүү хөтөлбөрт хамрагдах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, Монголбанкнаас банкаар дамжуулан санхүүжилт олгох зарчмаар хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Ингэхдээ Монголбанк банкт байгуулсан хөтөлбөрийн зээлийн гэрээний дагуу банк жилийн 0.89%-ийн хүүтэй эх үүсвэрийг авч, хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжид жилийн 3.8%-ийн хүүтэй дамжуулан зээл олгосон.

²⁶⁷ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Агуулах, зоорь, элеватор, үтрэмийн хангамж, 2022.08.22 <https://news.zindaa.mn/4aq>

Хүснэгт 4. Хөтөлбөрийн хүрээнд тавьсан зорилт


	/мянган тонн/		
	Хөтөлбөр хэрэгжиж эхлэх үе	Хөтөлбөр хэрэгжиж дуусах үе	Өөрчлөлт
Нийт улсын зоорийн багтаамж	174	259	85
Шинэ технологи бүхий автомажсан зоорь	23	106	83
Нойтон махны нийлүүлэлт /2-7 дугаар сард/	7	8	1
Махны үйлдвэрлэл	220	248	28
Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах	16	54	38

“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш санхүүжилт олгогдсон бөгөөд эргэн төлөх хуваарийн дагуу хөтөлбөрийн зээл хэвийн буцаан төлөгдсөн байна. Хөтөлбөрийн хүрээнд нийт 66 аж ахуйн нэгжид 7 банкаар дамжуулан 137.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.²⁶⁸

Хүнсний ногоо, (тариалан) эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 1590 аж ахуй нэгж газар тариалан хүнсний ногооны аж ахуй эрхэлдэг бүртгэлтэй байна.²⁶⁹

Зураг 5. 2014-2022 оны хүнсний ногоо, тариалан эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагын тоо.




Хүнсний ногоо, газар тариалангийн бүтээгдэхүүний нийлүүлэлт өндөр аймгууд болох Орхон, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгуудын хүнсний ногоо, тариалан эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагын тоо 2014-2022 оны хооронд дараах байдлаар бүртгэгдсэн байна.

²⁶⁸ “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийн тайлан

²⁶⁹ Үндэсний статистикийн хороо https://www.1212.mn/mn/statistic/statcate/573069/table-view/DT_NSO_1002_014V1

Зураг 6. Орхон, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгуудын хүнсний ногоо, тариалан эрхэлдэг аж ахуй нэгж байгууллага



МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Мал аж ахуйн салбарт бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх, мэргэжлийн үйлчилгээг төгөлдөршүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжээс хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх, мах, махан бүтэгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх тал дээр төвлөрөн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Хөгжлийн загвар нь уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурингийн орчимд бүсчилэн хөгжүүлэх, нөөцийг тогтвортой, зохистой ашиглах, ногоон эдийн засгийн чиг баримжааг дэмжихэд суурилна.

Дээрх зорилтуудын хүрээнд мал аж ахуйн салбарт мах, махан бүтэгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх тал дээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

1. “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Мал аж ахуй салбар:

- Уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурин орчимд бүсчлэн хөгжүүлж, нөөцийг тогтвортой, зохистой ашиглан, ногоон эдийн засгийн чиг баримжаатай мал аж ахуйг хөгжүүлнэ.
- Малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний чадавхыг сайжруулж, явуулын үйлчилгээг олон улсын жишигт хүргэх, малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлнэ.²⁷⁰

2. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээ

- Хот, суурин газрын ойролцоо, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, махны чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой, сүүний чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой үхрийн аж ахуй, махны болон нарийн ноост хонины үржлийн цөм сүргийн аж ахуйг бий болгох, өндөр ашиг шимт малын

²⁷⁰ <https://www.mofa.gov.mn/branch/maa/6141573c5cc6bd3bf76ae267>

үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил селекцийн ажилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, холбогдох санхүүжилтийг төсөвт тусгах;

Бусад:

- Монгол малын махны ач тусыг олон улсад сурталчлан таниулж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

3. “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

4. Засгийн газрын тогтоол

Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2017 оны 318 дугаар тогтоол/

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.27 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:²⁷¹

1. Мал сүргийн тоо толгойн өсөлт, бэлчээрийн даац, хадлан, тэжээлийн хүрэлцээ хангамжтай уялдуулан таваарын зориулалттайгаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор малын гоц халдварт өвчин гараагүй аймаг, сумдаас үржлийн бус эр хонь, ямааны 20 хүртэл хувийг экспортлохыг зөвшөөрөх.
2. Импортлогч улсын холбогдох яам, мэргэжлийн газруудтай мал экспортлох гэрээ, хэлцэл хийж, орон нутгийн байгууллагуудыг бодлого, зохицуулалтаар дэмжих,
3. Импортлогч улсын мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн малыг хорио цээрийн тусгаарлагдсан бүс, байгууламжаар дамжуулан мал эмнэлгийн хяналтын дор үзлэг, шинжилгээнд хамруулж, мал бордох үйлчилгээг үзүүлж экспортлох арга хэмжээг зохион байгуулах.

5. Мах бэлтгэлийн урамшуулал

Хүнсний тухай хуулийн 8-р зүйлд заасан буюу сүүний урамшуулалтай ижил үндэслэлээр нөөцийн мах бэлтгэлд урамшуулал, хүүгийн хөнгөлөлтийн татаас олгож ирсэн байна.

Нөөцийн мах бэлтгэлд зориулан 2013 онд 11.4 тэрбум төгрөг, 2014 онд 9.5 тэрбум төгрөг, 2016 онд 14.5 тэрбум төгрөгийн урамшууллыг аж ахуйн нэгжүүдэд олгосон ба 2015 онд урамшуулалд зардал төсөвлөөгүй байна. Түүнчлэн 2017 оноос урамшууллыг зогсоож оронд нь мах бэлтгэлд зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлт буюу татаас олгож иржээ. Мах бэлтгэлд олгосон зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2017-2020 онуудад жилд дунджаар 3.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Мах бэлтгэлийн урамшууллын зорилго нь нөөцийн махны нийлүүлэлт, хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа ба махны нийлүүлэлтийн үнэ, ханшийн хэлбэлзэлтэй хэрхэн холбогдох нь тодорхойгүй байна. Төсвийн тухай хуулийн 1-р хавсралтад тусгагдсан хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтэд “Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны хэрэглээг нэмэгдүүлэх /мянган тонн/” гэж тусгасан байдаг. Энэ нь мах бэлтгэлийн

²⁷¹ <https://legalinfo.mn/mn/detail/13067>

урамшууллын үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт байж болох боловч нэг талаас бэлтгэсэн мах нь “Үйлдвэрлэлийн аргаар” боловсруулсан эсэх, мөн урамшуулалд хамрагдаж бэлтгэсэн эсэхийг тодорхойлоход хүндрэлтэй болно. Тиймээс мах бэлтгэлийн урамшууллын зорилго, үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг илүү тодорхой, хэмжигдэхүйц болгож журманд тусгах нь зүйтэй хэмээн үзэж байсан байна.

6. “Монгол экспорт” хөтөлбөр

Уг хөтөлбөрийг Засгийн газраас 2018 онд баталсан ба 2018 оноос 2022 оны хооронд хэрэгжсэн байна. Монгол экспорт хөтөлбөрийн зорилгууд:

- Хөтөлбөрийн зорилго нь үйлдвэрлэл, экспортын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх замаар уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад оршино.
- Ноос ноолуур, арьс шир, мах болон сүүн бүтээгдэхүүн, чацаргана, зөгийн бал, уламжлалт эм, эмийн түүхий эд зэрэг бүтээгдэхүүний стандартыг Европын болон олон улсын стандартад нийцүүлэх.
- Ноос, ноолуур, арьс шир, мах болон сүүн бүтээгдэхүүн, чацаргана, зөгийн бал, уламжлалт эм, эмийн бүтээгдэхүүн зэрэг экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний шинжилгээ, сорилтын лабораторийн чадавхыг олон улсын жишигт хүргэх, энэ чиглэлийн лаборатори байгуулах, тохирлын гэрчилгээ олгох үйл ажиллагааг бүх түвшинд дэмжих.

Мах, махан бүтээгдэхүүний экспорт, мян.тн /нэр төрлөөр/

/*Гаалийн ерөнхий газрын мэдээлэл/

№	Бүтээгдэхүүн	2016		2017		2018		2019		2020	
		ТОО ХЭМЖЭЭ, МЯН.ТН	МӨНГӨН ДҮН, МЯН.АМ.ДОЛ	ТОО ХЭМЖЭЭ, МЯН.ТН	МӨНГӨН ДҮН, МЯН.АМ.ДОЛ	ТОО ХЭМЖЭЭ, МЯН.ТН	МӨНГӨН ДҮН, МЯН.АМ.ДОЛ	ТОО ХЭМЖЭЭ, МЯН.ТН	МӨНГӨН ДҮН, МЯН.АМ.ДОЛ	ТОО ХЭМЖЭЭ, МЯН.ТН	МӨНГӨН ДҮН, МЯН.АМ.ДОЛ
1	Адууны мах	8.0	14392.6	26.1	44529.2	32.2	64974	30.8	57688.6	17.6	33048
2	Үхрийн мах	0.7	1592.3	0.6	1643.3	1.1	3306.2	0	0	0	0
3	Хонь, ямааны түүхий мах	0.2	361.5	2.6	60701	6.2	15567.7	7	24164.6	1.8	4828.3
4	Дулааны аргаар боловруулсан мах	0.5	1550.9	2.8	8501.7	29.3	79038.6	18.4	50311.9	19.4	54756
НИЙТ		9.3	17897.3	32.1	115375.2	68.8	162886.5	56.2	132165.1	38.8	92632.3

Мах, махан бүтээгдэхүүний 2016-2021 онуудын экспортын мэдээ (Ямааны мах)

он	барааны код	барааны нэр	хүлээн авагч улс	ТОО ХЭМЖЭЭ, ТОНН	ҮНИЙН ДҮН, МЯН.\$
2016	020450	Ямааны мах			
2017	020450	Ямааны мах	БНХАУ	110.2	159.6
2018	020450	Ямааны мах	БНХАУ	24.0	68.5
	020450	Ямааны мах	Вьетнам	1,244.8	2,158.5
	020450	Ямааны мах	Хонконг	187.9	416.1
2019	020450	Ямааны мах	БНАСАУ	814.9	1,792.6
	020450	Ямааны мах	БНХАУ	95.0	332.7
	020450	Ямааны мах	Вьетнам	242.0	467.3
2020	020450	Ямааны мах	Вьетнам	790.4	1,597.0
	020450	Ямааны мах	Хонконг	470.5	1,042.0

2021 эхний 10 сар	020450	Ямааны мах	БНХАУ	95.0	268.0
	020450	Ямааны мах	Вьетнам	73.0	226.3
	020450	Ямааны мах	Хонконг	487.0	966.8
2016-2021.10 дүн				4,634.6	9,495.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээлэл

Мах, махан бүтээгдэхүүний 2016-2021 онуудын экспортын мэдээ (Үхрийн мах)

он	барааны код	барааны нэр	хүлээн авагч улс	тоо хэмжээ, тонн	үнийн дүн, мян.\$
2016	0201.0202	Үхрийн мах	ОХУ	560.0	1,376.2
	0201	Үхрийн мах	БНХАУ	135.1	216.1
2017	0201	Үхрийн мах	ОХУ	600.0	1,643.3
	0201	Үхрийн мах	БНХАУ	0.1	0.7
2018	0201	Үхрийн мах	ОХУ	762.6	2,437.6
	0201	Үхрийн мах	Вьетнам	136.0	332.2
	0201	Үхрийн мах	Узбекистан	136.0	326.6
	0201 0202	Үхрийн мах	Казахстан	60.0	161.0
2019	0201 0202	Үхрийн мах	БНАСАУ	19.5	48.8
	0201 0202	Үхрийн мах			
2021 эхний 10 сар	0201 0202	Үхрийн мах			
	2016-2021.10 дүн				2,409.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээлэл

Мах, махан бүтээгдэхүүний 2016-2021 онуудын экспортын мэдээ (Адууны мах)

он	барааны код	барааны нэр	хүлээн авагч улс	ТОО хэмжээ, ТОНН	ҮНИЙН ДҮН, мян.\$
2016	0205	Адууны мах	БНХАУ	6,118.5	10,532.1
	0205	Адууны мах	ОХУ	1,853.3	3,842.0
	0205	Адууны мах	Казахстан	11.0	12.1
	0205	Адууны мах	Япон	0.8	6.4
2017	0205	Адууны мах	БНХАУ	23,422.8	38,194.7
	0205	Адууны мах	ОХУ	2,198.0	5,145.6
	0205	Адууны мах	Казахстан	497.5	1,187.1
	0205	Адууны мах	Япон	0.4	1.8
2018	0205	Адууны мах	БНХАУ	29,446.0	58,649.2
	0205	Адууны мах	ОХУ	2,066.2	4,665.7
	0205	Адууны мах	Казахстан	688.6	1,659.1
	0205	Адууны мах	БНХАУ	30,350.0	56,565.8
2019	0205	Адууны мах	ОХУ	280.0	701.9
	0205	Адууны мах	Казахстан	203.5	405.2
	0205	Адууны мах	Япон	1.4	15.7
	0205	Адууны мах	БНХАУ	17,148.0	32,121.6
2020	0205	Адууны мах	Казахстан	419.8	925.9
	0205	Адууны мах	БНХАУ	6,925.0	14,434.0
2021 эхний 10 сар	0205	Адууны мах	Казахстан	100.0	152.0
	0205	Адууны мах	Япон	0.0	0.0
2016-2021.10 дүн				121,730.7	229,217.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээлэл

Мах, махан бүтээгдэхүүний 2016-2021 онуудын экспортын мэдээ (Малын дайвар бүтээгдэхүүн)

ОН	барааны код	барааны нэр	хүлээн авагч улс	тоо хэмжээ, ТОНН	ҮНИЙН ДҮН, МЯН. \$
2016	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Япон	5.5	57.8
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	БНХАУ	2.9	1.3
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Хонконг	0.1	0.2
2017	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	БНХАУ	46.3	27.8
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Вьетнам	40.0	20.0
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	ОХУ	20.0	26.0
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Казахстан	12.5	7.6
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Япон	6.5	69.8
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	БНСУ	1.2	21.4
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Арабын Нэгдсэн Эмират Улс	0.8	3.8
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Хонконг	0.6	12.9
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Вьетнам	1,503.4	1,905.6
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Хонконг	111.0	166.5
2018	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Киргизстан	8.6	43.2
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Япон	6.3	62.4
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Узбекстан	2.0	2.0
2019	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Вьетнам	1,371.4	1,444.5
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	БНАСАУ	983.5	1,064.5
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	БНХАУ	3.0	0.4
2020	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Хонконг	713.4	667.1
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Вьетнам	387.5	460.1
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	БНАСАУ	100.0	130.0
2021 эхний 10 сар	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Хонконг	1,020.3	821.6
	0206	Малын дайвар бүтээгдэхүүн	Турк Улс	20.0	10.0
2016-2021.10 дүн				6,366.7	7,026.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээлэл

Мах, махан бүтээгдэхүүний 2016-2021 онуудын экспортын мэдээ (Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн)

он	барааны код	барааны нэр	хүлээн авагч улс	ТОО хэмжээ, ТОНН	ҮНИЙН ДҮН, МЯН.\$
2016	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	БНХАУ	17.0	74.2
2016	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	ОХУ	6.0	19.8
2016	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	Япон	0.0	0.0
2017	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	БНХАУ	18.2	170.1
2017	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	ОХУ	10.8	55.7
2017	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	БНСУ	0.4	6.1
2017	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	Япон	0.1	1.5
2018	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	БНХАУ	12.5	98.8
2018	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	ОХУ	6.0	29.5
2018	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	Япон	0.2	3.0
2019	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	БНХАУ	25.0	125.0
2019	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	ОХУ	6.4	37.5
2019	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	Арабын Нэгдсэн Эмиррат Улс	0.1	1.3
2020	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	БНХАУ	75.0	375.0
2020	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	ОХУ	5.4	28.1
2021 эхний 10 сар	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	ОХУ	1.6	7.6
2021 эхний 10 сар	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	ОХУ	1.5	7.0
2021 эхний 10 сар	0210	Утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүн	ОХУ	1.5	7.0
2016-2021.10 дүн				187.6	1,047.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээлэл

Мах, махан бүтээгдэхүүний 2016-2021 онуудын экспортын мэдээ (Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн)

Он	барааны код	барааны нэр	хүлээн авагч улс	тоо хэмжээ, ТОНН	ҮНИЙН ДҮН, мян.\$
2016	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	БНХАУ	353.8	1,325.7
	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	ОХУ	83.0	225.1
2017	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	БНХАУ	2,536.4	7,739.4
	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	ОХУ	294.3	762.3
2018	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	БНСУ	0.0	0.0
	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	БНХАУ	28,988.6	78,396.4
2019	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	ОХУ	233.6	642.2
	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	БНХАУ	18,411.7	50,042.7
2020	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	ОХУ	89.3	268.8
	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	Япон	0.0	0.4
2021 эхний 10 сар	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	БНХАУ	21,165.5	60,188.9
	1602	Боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн	ОХУ	15.9	53.5
				72,172.2	199,645.6
2016-2021.10 дүн					

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд 2021 он (Үндэсний статистикийн хороо)
https://www2.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_976_L32&type=sectorbook
- Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийн тайлан 2016
https://www.mongolbank.mn/file/files/documents/pricestability/day_news/2016/20160615_food_report.pdf
- Махны нийлүүлэлтийн тогтолцоо судалгааны тайлан 2022 (хөдөө аж ахуйн бирж)
- ОХУ-д адууны мах экспортлох
- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ
- Махны экспорт гурван жил дарааллан буурчээ 2022 <https://gogo.mn/r/xdw3j>
- Мах, махан бүтээгдэхүүний экспортын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуулгын хариуг сонсов (2023)
<https://www.mnb.mn/i/282844>
- Мах хөтөлбөр батлах тухай <https://legalinfo.mn/mn/detail/11591>
- Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай <https://legalinfo.mn/mn/detail/13067>
- Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам (Бодлого)
<https://www.mofa.gov.mn/branch/maa/6141573c5cc6bd3bf76ae267>
- Махны экспортын тухай (Мэргэжлийн хяналтын ерөнхий газар)
<http://home.inspection.gov.mn/news/258/single/759>

